



БОРЖИГИН БИЛГИЙН СУДАР

2014 ОН

Боржигин билгийн судар
Зохиолч:Б.Энхтөр

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

НОМ МЯЛААХ СУҮТЭЙ ХАДАГ

Хүмүүний амьдралын их утга учрын нэгээхэн хэсэг нь өөрийнхөө мөрөөдөл, хүсэл дэврэл, сэтгэлийнхээ чөлөөт эдлэнд зоргоороо хөлбөрч, өөрийн санасан бодсон зүйлээ хэний ч шахалт шаардлагагүйгээр хийж бүтээн, бусдын бүтээлийн толинд өөрийгөө харьцуулан тольдон, суралцан, сургамжлах үедээ мэдсэн сурсан зүйлээ бусдад харамгүй хүртээн, мөнхүү санаж сэрж ухааран, магадгүй өөрийн хийж бүтээсэн, хийж бүтээж буй тэрхүү энгийнээс эхлээд аугаа зүйлдээ сэтгэл хангалуун байж гэмээ нь аз жаргал, эрх чөлөө, хувь хүмүүний дотоод тусгаар тогтнол гэгч нь тэр бөлгөө хэмээн эгэл уран бүтээл миний бие бодном. Магадгүй хэн нэгэн сэцэн ухаантан эсхүл бусдыг үгүйсгэгч нь миний энэхүү бодолтой санаа үл нийцэх аваас эрхэм уншигч авхай таныг хүндэтгэн түмэнтээ наманчлан толгой дохин хүлцэл өчих ину. Хүний нийгмийн хөгжлийн явцад гүн ухаантнууд болоод их сод хүмүүн төрөн, тухайн цаг үедээ цойлон гарч ирэн байгалийн унаган авьяас билиг, өөрийн хүсэл зориг, ухаан, сэтгэл зүтгэлээрээ ахуй хийгээд удирдахуйн мөн оюуны эгнэшгүй сод бүтээлийг туурвин, мөнхийн баялгийг бүтэж ирсэн хийгээд бүтээх нь буй.

Нөгөөтэйгүүр энэ орчлонд цогцлоон буй болгосон бүх баялгын ихэнхийг энгийн эгэл жирийн хүмүүс түүхийн бүхий л цаг үед бүтээж ирсэн нь хэн ч маргашгүй билээ. Тиймээс эглээс агуужим бүхэн эхтэй. Монгол улсын отгон аймагт суурьшин амьдарч, ажиллаж хөдөлмөрлөн улс, эх орон, суугуул сайхан нутгийнхаа хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтанд өөрийн хувь нэмрээ оруулахын зэрэгцээ ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл Монголын зохиолчдын эвлэлийн Говьсүмбэр аймаг дахь утга зохиолын салбарын уран бүтээлчид ч оюуны их бүтээн байгуулалтанд бие сэтгэлийг чилээн байж өөрсдийн гэх билиг ухаарлын мөнгөн долгисыг нэмэн буйдаа хангалуун байдаг билээ. Энэ онд манай аймгийн утга зохиолын салбарын үүсэж хөгжсөний 20 жилийн ой тохиож байна. Их ойдоо бэлэг барин эрхэм уншигч таны өмнө дэлгэж буй хамтын уран бүтээлийн түүврээрээ ойн халуун мэндийг хүргэж, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. Сүм дагшин сэтгэлд тань сүүтэй хадагаа өргөн барьлаа. Шимтэн хүртэхийг эрхэм таны сэтгэлийн таашаал мэдэх авай.

Номын цагаан буян ашид дэлгэрэх болтугай

Салбарын Удирдах зөвлөлийн дарга Ду.Батмэнд

СУДАРТ ӨРГӨХ ҮГ..

Оюун санааны гоо зүйгүй хүмүүний хөгжлийг тоймломгүй. Сэтгэлийг хөглөхяруу үгсийн элч нь тэнгэрийн өгөгдөл бүхий хүмүүс юм. Тэднийг яруу найрагчид, зохиолчид гэдэг. Үгийн урлаачдыг дээдлэн хүндлэх, эс тоохын бурангуйлал альч цаг үед оршиж байсан ч эгшиглэнт шүлэг, уянгат дуугүйгээр амьдрал аль чүед байсангүй. Хэн бүр ойлгодоггүй араншинтай эдгээр билигт хүмүүс маань эхорон, ард түмнээсээ урвасан түүх үгүй аж. Өөр олон жишээг үл нуршихын сац “Монголын нууц товчоо”-г хэн бидэнд хүргэж ирсэн билээ гэдгээс ойлгомжтой. Энэ бүхнийг өгүүлэхүйн тайлал нь Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдэлүүсэн байгуулагдаад хорин жилийн ойтойгоо тохиож буй баярт мөч ажаам.

Тэртээ 1994.11.09-ны өдөр МЗЭ-ийн гишүүд болох Р.Батжаргал, Ж.Дансранжав, Гүн.Төмөр нар аймгийнхаа Утга зохиолын тулгын чулууг тавьж галыг бадраажээ. Уран зохиолд элэгтэй анхны арван дөрвөн хүн гишүүнээр элсч Говьсүмбэрийн гэх зохиолчид Монголын их утга зохиолд хаяглагдах болсон байна. Утга зохиолын нэгдлийн анхны даргаар яруу найрагч Р.Батжаргал сонгогдож, эдүгээг хүртэл Ш.Батнасан, Б.Бат-Өлзий, Д.Батмэнд, М.Батбаясгалан, Б.Энхтөр гээд сонгогдож, ажиллаж, бүтээж иржээ. Хэн бүхэн нь өөрийн цаг үедээ оюуны гал голомтоо өөднө татаж ажиллаж байсан нь түүх юм. Монголчууд бид эртнээс бичиг соёлдоо хүндэтгэлтэй ханддаг уламжлалтай.

Үе үеийн аймаг орон нутгийн удирдлагууд Утга зохиолын нэгдлийн санаачилсан ажлыг дэмжин сайшааж, туслаж, хамтран ажиллаж ирсэн баялаг хуудастай билээ. Үүний жишээ бол “Боржигидай сэцэн” яруу найргийн наадмыг уламжлал болгон явуулдаг болсон, “Найргийн зөн”, “Найргийн яргуй” хүүхдийн яруу найргийн наадмыг зохиодог болсон гэх мэт. “Боржигидай сэцэн” наадмыг зохиоход Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн байсан, одоо “Боржигин” чуулгын даргаар ажиллаж буй МУСТА Ц.Сүхбаатар идэвхийлэн хөөцөлддөг байсныг, залуустаа зориулсан үйл ажиллагааг маань дэмжиж хайрын шүлгийн “Вансэмбэрүү” наадмыг Уул уурхайн жишиг Политехник коллежийн захирал Г.Энхбат сургуулийнхаа нэрэмжит болгон ивээн тэтгэж ирсэнийг, аймгийн Ардчилсан намын дарга байхдаа Л.Одсэр Утга зохиолын нэгдлийн тамга, тэмдэг, баримт бичгийг шинээр улсын бүртгэлд бүртгүүлэхэд хувиасаа туслаж байсныг мартах учиргүй. Хувь хүмүүс, аж ахуйн нэгж байгууллагууд туслаж, дэмжиж байсан дурсгалт баримтууд манай салбарын сан хөмрөгт хүндэт байрыг эзлэн хадгалагдаж байдаг юм. Энэ хугацаанд Утга зохиолын нэгдэл маань өргөжин салбар болон тэлжээ. Уран бүтээлийн олз арвин байсныг нь дан утга зохиолын бүтээл гэхэд тавь гаруй хэвлэгдсэн нь бахархам тоо юм. Утга зохиол гэдэг бол хүний сэтгэлийг хөгжүүлэх үйлс байдаг болохоор баригдам харагдах зүйлгүй ч магад мянган жилийн дараа ч тэдний бүтээсэн дуу эгшиглэж, найраг уянгалж байдаг нь туйлын үнэн бөлгөө.

2010 оноос МЗЭ-ийн шинэ дүрмээр аймгуудын Утга зохиолын нэгдлийг салбар болж өргөжүүлэхэд зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орж салбарын хөгжлийн асуудлыг Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл шийддэг болсон юм. Энэ хугацаанд Б.Энхтөр, Ду.Батмэнд нар Удирдах зөвлөлийн даргаар, гүйцэтгэх захиралаар М.Батбаясгалан, Б.Энхтөр нар Удирдах зөвлөлийн гишүүнээр Б.Мөнх-Өлзий, У.Баярмаа, Б.Баттулга, Т.Эрдэнэбаатар, Б.Аасүрэн, С.Отгончимэд, хяналтын зөвлөлийн гишүүдээр Н.Дөш, Н.Баттөмөр, Х.Чулуунбаатар нар ажиллаж иржээ. Салбарын Удирдах зөвлөлийн

хэрэгжүүлжирсэн зөв бодлогын үрээр МЗЭ-ийн 15-р их хурлаар Улсын тэргүүний салбараартодорч, мөн ондоо аймгийн тэргүүний төрийн бус байгууллагаар шалгарсанны бид бүхний хамтын хичээнгүй ажиллагааны үр дүн байв.

“Боржигидайсэцэн” наадмаа улсын хэмжээнд шударгаар зохион байгуулах санаачлага гарганажилласаны үр дүн гарч одоо Монгол улс даяараа мэддэг, найрагчид бүхэн шүлгээсойхыг хүсдэг хүсүүштэй наадам болж. Салбарын маань гишүүд өөр өөрсдийнажилладаг салбарынхаа шилдэг ажилтан, тэргүүлэгч нар байдаг нь бахархууштай.МУСТА зургаан хүн, Эрүүл мэндийн тэргүүний ажилтан хоёр хүн, Хоршооллынтэргүүний ажилтан нэг хүн, Үйлдвэрчний эвлэлийн тэргүүний ажилтан нэгхүн, БХамгаалахын болон БХТН-ийн тэргүүний ажилтан нэг хүн, Ардын болон Боловсролын тэргүүний ажилтан дөрвөн хүн байдаг нь үүнийг батлах бус уу.Хорин жилийн хугацаанд Утга зохиолын салбарт Ж.Дансранжав, Л.Содномдорж нар “Утга зохиолын төлөө” хүндэт шагнал, Р.Батжаргал МЗЭ-ийн шагнал, Б.Мөнх-Өлзий, Б.Энхтөр нар “Г.Сэр-Одын нэрэмжит шагнал”аар шагнагдсан нь чамлам тоо биш бөгөөд салбарын найрагчид маань Улс болон бүсийн чанартайутга зохиолын наадмуудад амжилттай оролцож аймаг орон нутгийнхаа нэрийггаргаж ирсэн амжилт бүтээл дүүрэн он жилүүд байлаа. Монголын Их утгазохиолд Говьсүмбэрийн гэж овоглогдох болсон зуун зуунд үл нурах оюун ухаанысуваргын барилгачид, эрхэм уран бүтээлчиддээ хорин жилийн баярын мэндхүргэхийн ялдамд оюун билгийн авшиг онгодтой байж ирж буй жилүүдэд сударномын дээдээ ард түмэндээ хишиглэж явахын өлзий дэмбэрэлийг ерөөе. Ном дормөргөмүү.

Салбарын гүйцэтгэх захирал Баатарын Энхтөр

ЯРУУ НАЙРАГ



Рэгчаагийн БАТЖАРГАЛ

МЗЭ-ийн Шагналт яруу найрагч

1946 онд Дундговь аймгийн Дэрэн сумын нутагт төрсөн.

Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийг үүсгэн байгуулагч. УБДС-ийг Монгол хэл-уранзохиолын багш мэргэжлээр төгссөн.

Тэрээр “Өвөөгийн эрдэм” “Хүслийн өргөл” “Шүлгэн эрих” “Араншингийн салхи” “Чанад совин” “Гоё амраг” “Тэнгэрийн санаа” “Алаг дэвтэр1” “Миний шүлгүүд” “Алаг дэвтэр 2” “Бурхад уулзах цаг”, “Тийм биз” яруу найргийн номууд хэвлүүлжээ “Чанад совин” “Гоё амраг” номуудаараа МЗЭ-ийн шагналт хүртжээ.

“Боржигидай сэцэн”, “Боржигин Угтаал” наадмын тэргүүн шагналтай.

ЗҮРХНИЙ АТИРАА

Хөсөр үгс хөвчирч

Хөв их цэнгэл бөхөхөд

Зүг чиг алдардаг

Хөөр агсал шингэрч

Хөхөөн дуу эзгүйрэхэд

Зүүд совин сарнидаг

Хөлгөн заяа бөртөлж

Хөмсөг ончрон зангирахад

Зүрх минь атирдаг

2014-1-3

ЭРХ ЧӨЛӨӨ

Тэсрэлт хийгээд омогшлыг бүтээх

Тэрсэл минь аагшиж

Эрчис билэг омголон байдаг

Тэнэгийн дотор амгалан гэх

Тэсгэл хийгээд хүлцэхүйн үүдэнд

Эзэн заяа бүрэн байдаг

Тэнгэр л мэднэ дээ бусдад падгүй

Тэнүүлчийн сэтгэлд

Эрх чөлөө бүтэн байдаг

2014-1-14

х х х

Харамлахгүй явж тэвчихгүй

Хайр гэж байдаг

Шаналал тээгээд өвгөрдөг

Халуун энгэрт ноцсон

Түймэр гэж байдаг

Шалихгүйн зуур бөхчихдөг

Өнчин зүрх өмөлзөвч

Өөрийгөө л гэх орчлонд

Өрөөлийг гээхгүй гээд яах вэ

2014-1-16

ДЭРЭН

Суунаг хөх зэрэглээгээр

Сувдрах нулимсаа арчиж

Сургаар жаргадаг нутаг минь

Зүүгээр баруугаар хошуулсан

Зүрхэндээ шархтай хүмүүс

Зүүдэндээ эдгэдэг өлгий минь

Дэгдээхэй нас сөдлөхөд

Дэлхийн чинээгээр дэвэрч

Дэгдээд ирдэг Дэрэн минь

2014-1-18

ШУВУУНЫ МӨР 4

Уулын намар

Улаалзганын туяа шувуудын жавжинд

Цус шиг гэрэлтэнэ

Жирийн бишид

Жижигхэн чиний нүднээс алдуурах гэгээн дусал

Жимс аагилна

Хач үлгэсэн

Харих цагийн диваажинд чив чимээгүй

Хайр нялхарна

ШУВУУНЫ МӨР 64

х х х

Эрвээхэйн нүдлүүрт

Энхэрхэн гоо бодол цугларна

Эхнэр эзгүй

х х х

Эр зөгийн

Этгээд сонин үхэл намайг сэрхийлгэхэд

Эмзэглэл чихэлдэнэ

х х х

Хортой мөөгөнд

Хортой ялаа үхэдхийн унаад сарвалзана

Хортой хортой

х х х

Чи юундаа

Чихэр гаажар чимхэж зовооно

Чишш чимээгүй

х х х

Үг чилээрхэхэд

Үйл буцалж ташлын тасам тасравч

Үүрд үгүй

х х х

Энэ орчлон

Эрх нь дэндүү тэнэг юм

Эм зөн

х х х

Сормуусандаа эрхлэх

Согоон цочир харц энхэрхэндээ

Солонго ээдүүлнэ

х х х

Сормуус дөллөхөд

Согтож мэдэх шандал буцалгана

Солиотой ертөнц дөө

2014-6-6

ҮЙЛИЙН ҮР

(суварган ест)

Хайртай хайртай гэхэд

Хан хорвоо халбилздаг

Үглэхийн дайтайд үймэрч

Үгийн хялуу хурцлахад

Үйл өртөс үрчилздэг

Алив тэр яах вэ

Амьдрал юм хойно

Үйлийн үр яах вэ

Үхэл биш юм хойно

2014-3-13

(суварган ест)

Смэн өвс шарлангуй

Сүмийн туурь гаслангуй

Элэрийн чөтгөртэй хэлэлцэж

Энд би хүйт залгилж

Энгэрээ бээртэл зогсном

Тэрсэл үгсийг сүлжиж

Тэнгэрийн өвөгтэй хуучилнам

Тэнд би хүйт залгилж

Тэрлэгээ жиндтэл зогсном

2013-11-3

МӨРӨӨ РӨӨ АСНАМ

(газель дүрст шүлэг)

Бийлэг элбэгт хутгалдаж

Бирдийн шаналал царайчилсангүй

Бий үгүйд бишүүрхэж

Бишдийн мөрд тээгэлсэнгүй

Мөчөө гөө өгөхгүй ноцном

Мөрөөрөө аснам

Билэгт үгийг хэлэлцэж

Би зул шиг гэрэлтээгүй ч

Харанхуйд шатнам

Жаргал минь

МИНИЙ АРАНШИН

(газель дүрст шүлэг)

Аяс аяс салхины үзүүр амсан

Алтан дусал навчис газардана

Авир төрх санахын их заяа түшиж

Амин мэт төгөлдөрт унана

Түүний зан

Тэнгэрийн зөн юмаа

Үүрд үгүйн хашлагыг зад тийрч

Үйлийн хөх дөлөөр авалцах нь

Миний араншин юмаа

Жаргал минь

НУТАГ

Таан шимсэн салхи дэвс дэвс дэгддэг

Тарнтай хонгор аялгуу дэрсний толгой задалдаг

Талибуун дэлгэр нутгаа санахгүй байхын аргагүй

Дөрвөн цагийн нуруунд шувууд сөдөө шилэмдэн тухалдаг

Дөмөн хатир хүлгийн шандас сульдааж туулдаг

Дөлгөөн цэнхэр талдаа хоргодохгүй байх аргагүй

Өндөр өндөр уулыг давлаа гэвч санагдсан

Өвгөдийн шаргал нөмөр сэтгэлийн хайланд идээшсэн

Өр зүрхний нутагтаа ирэхгүй байхын аргагүй

XXX

Зүүдний тохиол нүдэн бүрдийн асгал

Зүг чиг минь нүүдэлч удмын гэгээхэн охин чи

Зүүрмэг үүрийн зүс тунгалаг аялгуусан

Зүрхний минь энтэй орчлонгийн явдлыг сэрээж

Зүхэлгүй ариухан жаргалд хутгалдахад эвчхэн

Зүрийн мэт цоомгор зүүсгэлгүй эгшиглэн сэн

Сормуус туяарах нүд харц зүйн зүтгүйтэхэд

Согтох халаг солонголог биеийг гайхуулаад

Сод авиа дуун алдалт дураар уянгалнам

ГУРВАН ЗУРАГ

Эрэмгий хурдан хүлгэдийн зул задрах омогт

Эрчит дөрвөн туурайн сул асгарах цахилд

Эрийн хийморь хөтлөөтэй цэцэг зайчилж салхилна

Эрээн асар цахалтал аварга хүчитнүүд дугтралцаж

Эрвээхэй мяндсан зодогны уран шаглаас хуйлран

Эртэй зартайн аархал тахимаа аваад таахалзана

Эвэр нумны татал эрхий нөжиртөл аагьж

Эрчит сүмбэн сум эрмэг зурхайд баагьж

Эгшиг туна уухай тэнгэр цоргиж шаагина

ЧОНО

Хий үзэгдэл мэт сар хайчлан дайжих

Хилэнц нүглийг үүрэх алт мэт нэгэн амь

Хийсэн ч хийгээгүй гүтгэх хөх чоно хөндөлдөв

Модод чөлөөчлөн улалзах улаан нүд түүнийх

Мохож цуцашүй эрэмгий улайрах омог түүнийх

Мохрол амсахгүй агсам учрал зориг түүнийх

Хийморь сэргээх дон ад хөлөглөсөн эрсийг

Хилэн хар шөнө совин шилгээн төөрүүлж

Хий үзэгдэл мэт галт сороо сэгсрэн дайжив

АМЬДРАЛ

Үхэлд хүртэл гоё очихыг гайхуулах

Үзүүргүй сэтгэлийн бөхийг яана

Үзэсгэлэн гэдэг тэр ажээ

Ханьдаа гэвч харамлаж эрхлэх

Хас цэнгэлийн уриныг яана

Хайр гэдэг тэр ажээ

Энэ чинь энгэр ээллэгч бясалгал юм

Эр сур тасдам омог юм

Эмтэрч үл дуусах домог юм

ИЖИЙДЭЭ

Ирэх шувуудын дуу маргаашийн совинд хутгалдана

Ижийнхээ мөртэй хондонд сэтгэлээ сэгсрэвч хоргодно

Их л холдож цөхөж дээ үр харам үгүйлнэ

Илбийн саадган зэрэглээ яргуйт талаар хөөрцөглөнө

Ил цагаахан гунил тэнгэрийн хэлээр хөвөлзөнө

Ийм ойрхон үлдэж дээ ижий тарни эгшиглэнэ

Альхан зүгийн ямба бол далд уянга сэдрэх юм

Амирлах гоо ертөнцийн нарны хэлийг зүйгээд

Алхам тоолон мөргөө тэнгэрийн сахиус ижийдээ



Жалбуугийн ДАНСРАНЖАВ

МЗЭ-ийн гишүүн, “Утга зохиолын төлөө” хүндэт шагналт яруу найрагч 1932-2012

1932 онд Дорноговь аймгийн Сайхан дулаан суманд төржээ. Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийг үүсгэн байгуулагч. МУИС-ийг төгссөн. 1961 оноос МЗЭ-ийн “Утга зохиол урлаг” сонины нарийн бичгийн дарга, Ховд Говь-Алтай аймаг хариуцсан зохиолчдын хорооны төлөөлөгчөөр ажиллаж байв. 1952 оноос уран бүтээлээ туурвиж эхэлсэн бөгөөд уран бүтээлээ төв орон нутгийн хэвлэлүүдэд хэвлүүлж иржээ. Дууны шүлгүүд бичсэнээс “Эх орноо магтан дууля” дуу нь олонд түгж “Тал нутгийн хүний дуу” нь Дорноговьчуудын сүлд дууболжээ. Тэрээр МЗЭ-ийн 80 жилийн ойгоор “Утга зохиолын төлөө” шагнал хүртжээ. 1957 онд “Юу сайхан хөдөлмөр сайхан” 1961 онд “Тал нутгийн дуу” 1962 онд “Залуу хосындуу” мөн “Уургач” өгүүллэгүүд, 1963 онд “Ах дүү хоёр” 1972 онд “Итгэлийн од” 1996 онд “Нас дагасан найраг” номууд хэвлүүлжээ.

САРУУЛ ТАЛАА ХАРАХАД

Саруул талаа харахад

Санааны үзүүр сэвэлзэнэ

Унаган нутгийн агаараар

Уушиг дүүрэн амьсгална

Төрсөн нутгаас холдох

Төөрсөн адил бодогдоно

Өссөн нутгийн салхинд

Өмссөн хувцас өнгөжнө

Уудам нутгаа харахад

Ухаан санаа баясна

Багын явдал дурсагдаж

Байгаад баймаар санагдана

Улсын ажлыг бодож

Алсын замд мордоно

Уулзахын ерөөл тавьж

Аав ээждээ ёслоно

1961 он

ГАЛУУ ШУВУУНЫ ДУУ

Галуу шувууны ганганасан дуу

Газарт, тэнгэрт хадаж байна

Хайрт хүүхний хангинасан хоолой

Хаданд, ууланд цууриалж байна

Намар боллоо, буцъя гэж

Усны шувууд ганганаж байна

Нандин хуримаа хийе гэж

Учирсан хонгор дуулж байна

Агаарын олон жигүүртэн шувууны

Аяллын замд сайныг ерөөе

Хайрлаж тэтгэсэн хонгор хүүтэйгээ

Ханилж суугаад сайхан жаргая

1961 он

АРД ТҮМНИЙ УХААН

Ивэлж үрээн цатгадаг

Амьтан хүний ёсон буюу

Эвэлж үйлсээн бүтээдэг

Ард түмний ухаан буюу

САЙХАН САРУУЛ ХОЁР

Сайхан бүхэн хэнд ч

Нар сар шиг туяарна

Саруул бүхэн хэзээ ч

Навч цэцэг шиг дэлгэрнэ

БУЛГАН ГОЛЫН УРСГАЛ

Бургасан өтгөн шугуйг

Эрэг дээгүүрээ ирийлгэсэн

Буман цагаан гэрийг

Ширэг дээгүүрээ ярайлгасан

Булган голын урсгал

Долгио цацлан шидэлнэ

Буцах хүний дотор

Дурсгал болон шигдэнэ

Тариан сайхан ургацыг

Билчир дагуугаа найгасан

Тарган түмэн сүргийг

Билчээр дагуугаа налайлгасан

Булган голын урсгал

Долгио цацлан шидэлнэ

Буцах хүний дотор

Дурсгал болон шигдэнэ

Тосгон болсон төвийг

Мандал дундаа эгнүүлсэн

Торгууд ардын аялгууг

Халгил дундаа эгшиглэсэн

Булган голын урсгал

Долгио цацлан шидэлнэ

Буцах хүний дотор

Дурсгал болон шигдэнэ

Ховд.Булган сум. 1961.09.25.

ХОЁР УХААНЫ ЯЛГАА

Бодол эргэц үүлэл сайтай хүний

Бор ухаан "хар "-дагт үй юм билээ

Болгоомж , хашир муутай хүний

"Боловсон " ухаан ч газарддаг юм билээ

ЯСНЫ ДУРГУЙ

Ховолж тал засах гэдэг

Ховсоргон занд би ясны дург үй

"Хувилж " нэр олох гэдэг

Хувилгаан дүрд би ёсны дург үй

ОХИД БЭР НАРТАА

Цай ч үгүй царай ч үгүй суух нь

Айл айлын авгайн адаг болдог юм

Най ч үгүй, нааш ч үгүй зөрүүдлэх нь

Үйл үйлийн эцэст алдаа болдог юм

Чи бол миний

Зүрхний туяа

Зүүдний уяа

Чи бол миний

Мөрөөдлийн зүг

Мөнхийн шүлэг

Энэ бол

Гал шиг халуун

Ган шиг хатуу үг

Энэ бол

Чин сэтгэл

Гүн итгэл

Чи бол миний

Найрын уянга

Хайрын уяа

Чи бол миний

Салшгүй хань

Сольшгүй хонгор

Энэ бол

Чамаас өөр хүн

Надаас сонсохгүй үг

Энэ бол

Надаас өөр хүн

Чамд хэлэхгүй үг

1961 он

ИЛРЭЛ ЭЛБЭРЭЛ ХОЁР

Хүний алдааг сонсмогц зэмлэх нь

Дээрэнг үйн ааштайн илрэл буюу

Түүний учрыг ойлгохыг эрхэмлэх нь

Энэрэнг үй ухааны элбэрэл буюу

ИТГЭЛ АЛДРАХУЙ

Хүнд чи хуурамч "загнавал "

Өрөөлийн итгэлийг хуй салхи шиг алдана

Хүн чамд худлаа хэлбэл

Өөрийн итгэлийг ороо морь шиг хулжаана

СҮҮЛДЭЭ МӨРТЭЙ НАЙРАГЧ

Шүлэг гэдэг ямар шүлс биш дээ

Шүүдрийн мөнг өн дусал болохоос !

Шүлэгч гэдэг ямар сүг биш дээ

Сүүлдээ мөртэй найрагч болохоос !

АМИН ДЭНЧИН

Эх орон гэдэг хүнд

Эцэг өвг өдөөс заяасан өлгий

Эгэл ганц ширхэг чулуу нь ч

Эзэн бидний амин дэнчин

Өлзий буянтай ардын дуу

Өлсс өн цагт ардын дуу сонсоход

Өл залгах шиг болдог юм билээ

Өөрөө дуулж чаддагт үй хэдий ч

Өлзий буяныг нь хүртдэг юм билээ

АЧ НАРТАА ӨГӨХ БЭЛЭГ

Миний амьдран суудаг газар

-Чойр

Миний амгалан байдаг үе -нойр

Миний ажиглан хардаг зай -ойр

Миний ач нартаа өгөх бэлэг

-хайр

ДӨРВӨН ЕРТӨНЦ

Хүн гэдэг өөрөө ерт өнц

Хүүхэд гэдэг өсв өр ерт өнц

Хүүхэн гэдэг өвөрм өц ерт өнц

Хөгшид гэдэг өвг өрс өн ерт өнц

МӨНХИЙН ДӨРВӨН ҮНЭНЧ

Сүүж харцагандаа салшг үй үнэнч

Сүвээ хавиргандаа сольшг үй үнэнч

Сүүл ууцандаа тээрг үй үнэнч

Сүүдэр эзэндээ цээрг үй үнэнч

ДӨРВӨН ДАМПУУ

Алмайрч суудаг ажилг үй дампуу

Архинд "сунадаг" амьдралгүй дампуу

Ахмадын үг авдаггүй

ажиггүй дампуу

Айл гэр болдоггүй

арчаагүй дам пуу

ХҮН

Тэвчиж чадвал хүн ухаантай "амьтан "

Тэсэрч "дэлбэрвэл " хүн тэнэг "амьтан "

"Нэвчиж дааварлах " оюун ухаанаа

Нээж чадваас хүн гайхамшигт төрөлхтөн

ХҮРЭЭТ БААТАР

Тэнүүн сайхан говь минь

Тэмээн сүргийн нутаг юм

Тэмээн түмэн сүрэг минь

Тэнүүн говийн чимэг юм

Говийн чимэг тэмээдээ

Гойд маллагч олон юм

Гойд маллагчдын дундаас

Гоц нэг нь Хүрээт юм

Хүн бүхэн малладаггүй

Хүрэн улаан тэмээдийг

Хүч тарган байлгадаг

ХАГАЦАШГҮЙ ХАНЬ МИНЬ

Хагацашгүй хань минь чи

Хар хүн минийхээ Сарангуа

Хайрт үрсийнхээ Нарангуа

Хамаг хүүхнүүдээс Содонгуа

Халуун найргийн минь Одонгуа

Хагацашгүй хань минь чи

1969 он

НАЙРАГЧ БАЙХЫГ ХҮСНЭ

Ядуу найрагч биш

Яруу найрагч байхыг хүснэ

Яруу найрагчдаа

Даруу найрагч байхыг бодно

Бичсэн зүйлээ ямарыг

Би өөрөө хэлэхгүй

Олигтой олиггүйн алиныг

Олон түмэн шүүнэ

Шүүмж үг дуулаад

Шүүрс алдагч би бишээ

Мандах алдаршихын төлөө

Магтаал горилогч би бишээ

Ард түмнийхээ дуунд

Ая нэмэхийг хүснэ

Алд биеийнхээ идэрт

Ажилч байхыг бодно

Ядуу найрагч биш

Яруу наөйрагч байхыг хүснэ

Яруу найрагчдаа

Даруу найрагч байхыг бодно

1963 он

ЗҮРХ МИНЬ

Зүрх минь чулуу биш

Зүрх минь хатуу биш

Улаахан зүрх минь

Уяхан зүрх минь

Уулаас өрөвчхөн

Угаас эмзэгхэн

Харлаагүй

Хатаагүй

Хүрэн зүрх миинь

Бүрэн зүрх минь

Хэзээний туяхан

Хэдийний уяхан

Хүний зовлонг

Тэгш хуваалцана

Хүн ч сэтгэлээ

Тэрүүнд хувилна

1965,1968

ХЭЛЭЭЧ ДЭЭ ХАЙРТ МИНЬ

Хайрт чамайг хажууд ирэхээр

Хаврын цэцэг дэлгэрэх шиг болох юм

Надаас чамайг холдоод явчихаар

Намрын цэцэг гундах шиг болох юм

Хэн хэндээ чи бид хоёр

Хэдийд хаврын цэцэг болох вэ

Хэлээч дээ хайрт минь хэлээч

Үзэсгэлэнт чамайг дэргэд ирэхээр

Өнгийн солонго татах шиг болох юм

Үеийн чамайг босоод явахаар

Өнөөх солонго арилах шиг болох юм

Хэн хэндээ чи бид хоёр

Хэдийд өнгийн солонго болох вэ

Хэлээч дээ хайрт минь хэлээч

Манайд чамайг ороод ирэхээр

Мандах наран гарах шиг болох юм

Удахгүй тэгээд яваад өгөхөөр

Ургах наран шингэх шиг болох юм

Хэн хэндээ чи бид хоёр

Хэдийд мөнхийн наран болох вэ

Хэлээч дээ хайрт минь хэлээч

1962 он

АЛАГ ЦЭЦЭГ ДЭЛГЭРНЭ

Аглаг хээрийн бэлчээрт

Алаг цэцэг дэлгэрнэ

Аавын хүүгийн цээжинд

Амраг сэтгэл төрнө

Алаг цэцэг дэлгэрсэн

Аглаг хээр үзэмжтэй

Амраг сэтгэл төрсөн

Аавын хүү баяртай

Ээрэм хөндийн бэлчээрт

Эрээн цэцэг дэлгэрнэ

Ээжийн охины зүрхэнд

Энгүй хайр оргилно

Эрээн цэцэг дэлгэрсэн

Ээрэм хөндий үзэмжтэй

Энгүй хайр оргилсон

Ээжийн охин баяртай



Гүндсамбуугийн ТӨМӨР

МЗЭ-ийн гишүүн Яруу найрагч 1921-1997

1921 оны 6-р сарын 15 нд Дундговь аймгийн Луус суманд төржээ. Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийг үүсгэн байгуулагч. Намын Дээд сургуулийг төгссөн. Олон олон дууны шүлэг бичсэнээс “Нутгийн бараа” “Ертөнцийн сайхан ээж” “Шингэн лимбийн эгшиг” зэрэг дуунууд нь олонд түгсэн байна. Тэрээр Говьсүмбэр аймагт Утга зохиолын нэгдэл байгуулахад оролцож залуу уран бүтээлчдэд үг сургаалиа хайрлан тэдний уран бүтээлийн өсөлт хөгжилтөд чамгүй хувь нэмэр оруулжээ.

Шивээ говь суманд аж төрж байхдаа “Наран ордын эзэд” яруу найргийн ном бичсэн байна.

Г.Төмөр 1972 онд “Талын нар” 1980 онд “Талын од” шүлгийн номуудаа хэвлүүлжээ.

ЕРТӨНЦИЙН САЙХАН ЭЭЖ

Эх Долгорын дурсгалд

Өлийн халзан давааг

Өгсөж уруудаж гэлдрэхдээ

Үр гэсэн намайгаа

Үүрч дүүрсэн ээж минь

Ээжий минь ээжий минь

Ертөнцийн сайхан ижий минь

Бүүвэйн шингэн дуу нь

Чихэнд дандаа дуулдана

Бүлээн цагаан сүү нь

Тагнайд дандаа амтагдана

Ээжий минь ээжий минь

Ертөнцийн сайхан ижий минь

Миний сайхан ээжий

Ертөнцийн сайхан хүн

Миний ээжийн сэтгэл

Сүүн цагаан сэтгэл

Ээжий минь ээжий минь

Ертөнцийн сайхан ээжий минь

Молцог цагаан элсээр

Хэрэн хэсэн явахдаа

Монгол нутгийн хөрсөнд

Мөрөө үлдээсэн ижий минь

Ээжий минь ээжий минь

Ертөнцийн сайхан ээжий минь

Миний ээжийн хайр

Ерийн хүний сэтгэл

Ээжий минь ээжий минь

Ертөнцийн сайхан ээжий минь

НАМРЫН ТАЛААС ТЭМЭЭ ТУУНА

Налайж идээшсэн тэмээдээ

Намрын талаас цуглуулахад
Олойрт цагаан шөнө
Оддоо бас цуглуулав
Тэнгэр хаялдсан одод
Тэмээн тавхайд гялалзан
Тэнд энд үсэрч
Талын тэртээ рүү шидэгдэв

ТЭНГЭРИЙН ТАЛ НЬ ГОВЬ

Хаяа нь үгүй говь
Хараа сунган цэлийв
Хадган цэнхэр говьд
Хавтгай нэг үзэгдэв
Дүүгүүрийн чулуу ойх шиг
Дүүлж яваа нь харагдав
Зуур хоногийн газар
Зурвас тоос хадав
Хаяа нь үгүй тэнгэрт
Хавтгайн бараа тасрав
Тэнгэрийн тал нь говь байдгийг
Тэгэхэд би мэдэв

ЦАГААН ГЭРТЭЭ БУЦАВ

Униар суусан тал
Усан шүүдрээ шилгээн
Үүрийн цагаан гэгээнд

Үзэсгэлэн бүхнээ дэлгэв

Тэлмэн цэнхэр нуур

Тэнүүн талдаа мэлтийж

Тэмээтэй усчин би

Тэр нуур луу хандав

Тэнгэр бас надтай

Тэлмэн нууранд ирж

Нуур тэнгэр хоёрт

Нүүрээ би тольдов

Тэлмэн цэнхэр нууранд

Тэнгэрийн нар мандав

Хурмастын тэр нарнаас

Хутгаж би амжив

Авсан тэр нараа

Аган тэмээндээ тэгнээд

Цайдам талыг туулан

Цагаан гэртээ буцав

ЗУН

Талын нар

Талибуун сайхан

Шингэхдээ

Ширхэг таана болгонд

Шижир гэрэл нь уусна

Уусаж шингэсэн нар

Ургаж дээшээ

Мандахдаа

Таанын үндэс хөлжүүлэн

Талын зун болж найгана

САЙХАН ХАНГАЙН НАМАР

Үүлсийн дунд

Уулс дүнхэлзэн

Хөвчийн зулайд

Үүлс тунана

Үзүүрт модонд нь

Үүлс сэмрэн

Алтлаг навсаас нь

Алдуурч унана

Саяны навчсаас

Санчиганд унасан нь

Сайхан хангайн

Намар нь байлаа

ТАЛЫН ХҮН БИ ТАЛААСАА УРГАНА

Талын хүн би

Талынхаа хөрснөөс

Таана шигээ үндэслэнэ

Өөдлөх нарны гэрлийг

Өлмий дороо гишгэн

Хонгор талаасаа

Хоёр гараараа

Мөчирлөн ургана

Зүүн гараараа

Зүйлийн тариа найгуулан

Баруун гараараа

Барилгын өрлөг

дээшлэн ургана

Талын хүн би

Талынхаа хөрснөөс

Таана шигээ ургана

ХАВАР

Тал нутгийн минь элгэн дээгүүр

Хаврын урь цэнхэртээд ирлээ

Та бидний алган дээр

Хадаг дэлгэн бариад ирлээ

Настан олны минь хайр ерөөл

Хацар нүүр төөнөөд ирлээ

Нарны шим гэрэл гэгээ

Хаврын аясаар уртсаад ирлээ



Лувсандогвын ПУНЦАГСҮРЭН

1944- 2008

Л.Пунцагсүрэн 1944 онд Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт төрсөн . Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн анхны гишүүн.Тэрээр бага наснаасаа яруу найргийг бүтээх их үйлсэд зүрх сэтгэлээ өгч туурвисаар “Миний араншин” “Хуур дагасан аялгуу” “Хээтэй араншин “Ташуу араншин” зэрэг яруу найргийн номуудаа хэвлүүлж уншигч олны хүртээл болгожээ.

“Боржигидай сэцэн” наадмын тэргүүн шагналт.

БОРЖИГИН

Өвснийх нь явдал тэлмэн жороо

Өвг өдийнх нь үг бурхан сургаал

Дуун түрлэг хуур дагасан аялгуу

Дугана сүм хуучины дурсгал

Домогт боржигины

Аргалы нь утаа аргалынх

Тэнгэр зүстэй адууных нь салхи

Эрийн хийморьтой

Энэ л хошуу нутагт

Ренчингийн Чойном төрсөн

Эрт галавын мэргэдийн дүр тодорсон

Буурал түүх дэлхийн тасархай

Бурхад уулзах диваажингийн орон

Ногт зангидах өвг өдийн төрх

Ноцсон гал бурхан сүнстэй боржигины

Зүрхний мөнгөн агсаргаанд нь

Зүүдний бодол мансуурна

Манхан шаргал асгарт нь

Манжуурын толгод ч атаархана аа ...

МИНИЙ ОМГОРХОЛ

Хур шимэн үндэс аргадах

Хувь тавилан өвс өн дуун

Хувьсах цагийн зүрхэн цохилсон

Хуучирын аялгуу зөөлөн эгшиглэн

Он жил үүдийн урсгалд үл автсан

Оморхол дэвэрлэлийн халуун нулимс

Одод зүсэлсэн тэнгэрийн зүүд

Оршихуй эс оршихуйн гэгээн гуниг

Хүмүүн заяаны хууч домог

Хөг нь тасрааг үй хуучирын эгшиг

Хирэгсүүр чулуу дээдсийн дурсгал

Хэрлэнгийн урсгал миний оморхол

ХҮЛЭЭНЭ ДЭЭ, ХҮЛЭЭНЭ ЧАМАЙГАА

Зүйтэйхэн төрс өн чамайгаа

Сэтгэлдээ аргадаж хүлээлээ

Зүүн уулын хэцийг

Сэтэртэл нь харуулдаж хүлээлээ

Багын хайртай чамайгаа

Санан мөрөөсөж хүлээлээ

Баруун уулын хөтөлд

Сар өөөдт өл хүлээлээ

Дурлал хайрын их бурхан чамайгаа

Даанчиг их хүлээлээ дээ

Дундуурхан чиг устай голоо

Далай болтол нь үерл үүлж хүлээлээ дээ

Хүлээсэндээ хүлээнэ чамайгаа

Хүнийх биш минийх болтол нь

Хүлээнэ дээ хүлээнэ

ГЭРЭЛТ САРНЫ ДОР.,

Гэрэлт сарны дор

Шүлэг шигээ алхалхад

Гэнэ гэнэхэн гэгэлзэх

Шөнийн тэнгэр гуниг авчирна

Ижий минь хаа нэгтээ

Уйлах дуу нь сонстож

Энгэр норгох

Усархаг бороо мэт нулимастай үзэгдэнэ

М өрөөсөл юундаа хөтл өгд өн

Тэр зүг рүү

Мөөмөн сартай үдшээр

Тэрлэгээ тайчиж гүймээр бодогдоно

Гуниг зулсан шөнийн тэнгэрээс

Гуйх л юм

Шүлэг ижий хо ёр минь баймаар санагдана

НАМАЙГ ИЖИЙ МИНЬ ТОСНО

Намайг ижий минь тосно

Намхан намхан толгодынхоо бэлд айсуй тосно

Үрээ зүүдэлж сэрсэн

Ижий минь намайг тосно

Үйлээ сүлдэлж аргадсан

Үг нь хүртэл амдаж тосно

Хүлэг зүслэж хурайлсан

Сүүн ижий минь тосно

Шүлэг сөгн өж нярайлсан

Сүлд хийморь нь ч тосно

Үнэнийг зүслэж аминчилсан

Буянтай ижий минь намайг тосно

Үхлийг ч цэглэж наминчилсан

Бурхантай ижий минь айсуй тосно ...

НУТГИЙН УУЛ

Хүний их нас

Толгодын өвөг эцэг шиг

Хүглэгэр хүглэгэр уулс

Тоо тоймгүй олоон

Тэнүүхэн бэлд нь хөллөж боссон

Миний нутгийм нэгэн уул

Тэр их уулсын дунд

Мэлмэрэх нулимсанд торолзоно гэхээс

Хариг цаг хавраар гүйсэн хүлэг шиг

Халуун зүрхний гунигаа зайчилан

Нулимстай сэтгэлийн хураа огшоож

Нутгийнхаа уулан дээр

Бороо болон

Цайрч нэг буухсан

Бодлынхоо хураар

Цангаагий нь бас тайлахсан

МОНГОЛ

Монгол гэж

Дорно өрний

Өргөрөг уртрагийн туйл

Домог хэлхсэн

Өнө эртний дууль

Монгол гэж

Дээдсийнхээ хүчинд

Дээлтэйгээ үлдсэн

Хорвоод ганцхан

Хосгүй дурсгал

Монгол гэж

Дэлхийн тавцанд

Дээшээгээ асах

Ураг төрлийн хэлхээтэй

Улаан галын урсгал

Монгол гэж

Цагаан сүлдээ тахисан

Цацал мөнгөн гялбаа

Хүрэл илдээ атгасан

Хүннү сүннүгийн улбаа

Монгол гэж

Нүгэлт мичин жилийг

Нүдээрээ үзсэн ч

Буянаа бараагүй Бурхад.

АМИН ГОО

Чамайг ирнэ гэхээс

Царцанга өвлийн жавар уясаж

Бараан гуниг зүүднээс хулжиж

Баруун уулын хэц холын одод руу явчихлаа

Намайг бодно гэхээс

Насны минь гал нараар гэрэлтэж

Бороо цайрах алс тэнгэрийн хаяа

Бор талын зоо сэргээд явчихлаа

Чи бидэн хоёр уулзана гэхээс

Чимээгүй дүнсийх бодлын манан нимгэрч

Элс нургилах ингэ буйлах

Ишиг тонгочих янзага нойрсох

Говийн нарыг тулгандаа аргамжиж

Чагтагандаа уях шиг

Голомт дулаацуулсан хайраа

Чамтайгаэ хуваалцана амин гоо минь

ИЖИЙГЭЭ САНАНА

Санана даа санана

Ижийгээ санана

Санахын хармаар нялхарч

Эрхлэн санана

Харцанд нь

Хайр гэрэлтэх

Халуун тагнайд

Уураг амтагдах

Ижийгээ санана

Санана даа санана

Санчигных нь мөнгөлгөөс

Сүү үнэрлэж санана

Саалынх нь зэлэн дээр

Шүлэг шиг гэрэлтэж санана

Хайрхан уулс нуур усаа

Шувууд үгүйлэн элдэг шиг

Халуун цээжнийхээ хөмөгт

Ижийгээ би санана

БИ ГЭЖ

Говийн хөх найрагч

Говьсүмбэрийн хөөрүү шүлэгч

Үгүйдээ үгүй би чинь

Үйл заяаныхаа тавилангаар

Үүрээ зассан шувуудын

Өндөг аргадаж бүүвэйлсэн

Халтар говийн хань

Хайлаасны халирсан мөчир

Халуун гангын урсгал

Хатуугийн хатуу загийн амь

Үгүйдээ үгүй би чинь

Үйл заяаныхаа тавилангаар

Чойроо цоллон

Сүмбэрээ сүлдлэх

Шүлгэн дуутай

Говийн хөх найрагч

Говьсүмбэрийн хөөрүү шүлэгч.

БУЙ БИЕЭРЭЭ БИ

Буй биеэрээ би

Буйдан хөх орчлонгийн

Өнгө зүсийг хүлсэн

Өвс ногоо

Гэрэлт дэлхий дүүрэн

Гэгээн гуниг дарсан

Гээг үс шигээ их

Өвс ногоо

Эгэл даруухан ч

Омог бардам

Идэр нас шигээ

Өвс ногоо

Энхрийлэм дотно

Охидын үнсэлтийг

Эрхсэж ноолсон

Өвс ногоо

Хайрлаж явсан

Хардуулж үзсэн

Эрэн цаг минь

Өвс ногоо

Хаа холын

Их хэтээс ирэх захиа

Эрхтий уулын шүлгүүд минь

Өвс ногоо

Бодол бодолдоо сүлдсэн

Бор борхон толгодоо зулсан

Борог өвсөн шивнээ шигээ

Өвс ногоо

Жаргалтайн дэлгэр

Өнө холын дуртгал

Жанжин Чойрын

Өвс ногоо

1999.10.16

ШҮЛЭГ ШИГЭЭ...

Шүдэнз асаахын дайтай

Зурсхийгээд өнгөрөх

Амьдрал ахархандаа хатуурхавч

Шүлэг шигээ би

Зуун зууны дараах

Амьдын сайхан диваажиндаа гэрэлтэнэ.

БИ ТЭС ХӨНДЛӨН ХӨХ ЭР

Эрхэтий хайрханыхаа

Чулуунаас гоёсон цул хөндлөн

Ижий бурханыхаа

Цуснаас амилсан ил хөндлөн

Иймдээ л би

Тэс хөндлөн хөх эр

Ирж буцахын туйлыг

Тэнцүүлж үүрсэн ил хөндлөн үр

Сар наран цалгилсан

Тэнгэрийн дайтай тэс хөндлөн

Салхи шуурга цалалсан

Газрын зурлагатзй гал хөндлөн

Хэлэх үг минь ч хатуу

Хад чулуу мэт хөндлөн

Хэрлэн Туулын

Хатан ус шигээ хөндлөн

Долоон бурхад руу бодлоо нисгэж туйлсан их хөндлөн

Домгийн сайхан хүслээн жаргааж дуулсан хөндлөн

Ирж буцахын туйл

Зөөлөнг хатуутай нь аргадсан хөндлөн

Ижийгээ санахдаа

Зүрхэндээ нулимстай хөндлөн

Иймдээ л би тэс хөндлөн хөх эр

Эрин зууныхаа их салхийг

Тэвэрч уярсан ил хөндлөн үрээ...

2002.05 10



Нацагийн ДӨШ

Ган боржигин овогт Нацагийн Дөш 1949 онд Дорноговь амгийн Өргөн сумын "Өргөө толгой" гэдэг газар төрсөн.

Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн анхны гишүү н. БХДээд сургуулийг төгссөн.

"Тэнгэрийн цоморлин" яруу найраг, дурсамжийн ном хэвлүүлжээ. МУ-ын БХ яамны болон БХТНийгэмлэгийн "Тэргүү ний ажилтан". "Утгын сүү эгшиглэн" наадмын дэд байрны шагналт.

ӨРГӨӨ ТОЛГОЙ

Морь буусан шагай шиг

Молцог жаахан мөөмөн толгой

Хүүгээ хүлээсэн эх шиг

Хүдэнт талынхаа дунд бөртийнө

Зүссэн хуруудын шомбон шиг

Зүмбэр талын бөмбөн толгой

Ээжээ хүлээсэн хүү шиг

Эрээн талынхаа уудамд торолзоно

Учрал хүлээлт ээлжилдэг орчлонд

Уяхан ээждээ үр нь хайртай

Уртын холыг туулаад очиход

Уулзан золгоход уяралын нулимстай

Тахилын мөнгөн цөгц шиг

Талын борхон толгой минь

Эртнээс заяатай миний л нутгаа

Элэгнээс бадамласан зул ч юм уудаа

Өөдөс бяцхан ачийн минь

Өхөөрдөж өрсөн тоглоом шиг

Өр зүрхний амин шүтээн

Өргөө толгой –Миний нутаг аа

2009.02.15. Сайн-Шанд.

АРСЛАН УУЛС

Сүрлэг шар арсланг билэгдэн

Сүлдэлж залсан аймаг

Зурхайн төлгөнд буусан

Зураг шиг тод

Шар арслан уулс

Тангадын мэргэн зурхайчдын төлгөнд

Таван зуун жилийн өмнө буусан

Тал нутгийн гурван чандмань эрдэнэ

Тахил сүлдэт арслан уулс

2000.02.02. Чойр.

ТЭНГЭРИЙН ЦОМОРЛИН

Төрийн соёмбот туг намирсан
Төв цэнгэлдэхийн дэвжээний голд
Туурайт хүлгийн шандас сорьсон
Түмэн хурсан Яармагийн саруул дэнжид
Түргэний голын хээрийн буулт дадлагын талбайд
Туул голын хөвөөнд байрлах морин тойруулгад
Хангай говь хосолсон монгол орны нутаг бүрт
Хаана ч бол хаана
Авьяас чадмаг шүхэрчид
Асарлан буухын гайхамшигийг үзүүлдэг
Дүүлэн дүүлэн нисэх нь
Бүргэдийн зоригтой
Дуулан дуулан буух нь
Гургалдайн хоолойтой
Эргэлдэн эвхэрч агаарт бүжиглэх нь
Хараацайн уран жигүүртэй
Энгүй тэнгэрийн мандлаас
Цахлай шиг чөлөөтөөр нисдэг
Тэнгэрийн цоморлин шүхэрчид
Тэвчээр зоригийн бахдал

1999.12.19. Улаанбаатар

ХОНИН ГҮРВЭЛ

Бударгана, хөмүүлтэй энгэрээр

Хонин гүрвэл гүйнэ

Бөндгөр хөөрхөн гэдсээ

Цүндэгнүүлэн алсыг харна

Бутны цаадах жалганаас

Гэнэт хүүхдүүд ирлээ

Бултаж амиа аврахаар

Хөөрхий гүрвэл зугтав

Алдлан хөөсөн хүүхдүүдээс

Айсандаа багтарч

Амьсгал нь давхцсан гүрвэл

Амиа хамгаалах арга эрэв

Эцсийн мөчид эрсэлсэн гүрвэл

Эрээн сүүлээ тастаад зугтав

Эргэлдэн мушгирах сүүлэнд хууртаад

Эцсэн гүрвэлийг хүүхдүүд мартав

Аюул нөмөрвөөс аврах сэжмийг

Амьтан бүрт хорвоо заяажээ

2008.08.05. Сайн-Шанд

ГОВИЙН НАМАР

Айл айлын яндангаас суунаглах

Аргалын босоо цэнхэр утаа

Аядуухан налгар намрын өдөр

Алтан говьд минь ирсэнийг зарлана

Хөхүүртээ исэх намрын сэнгэнэсэн айрагнаас

Хээр талын үнэр сэнхийж тос амтагдана

Хот айлын зэлнээс хангинатал янцгаах унаганы дуу

Хүүхэд насны минь хөгжилтэй дурсамжийг сэргээнэ

Гэрийн сүүдэрт дэлгэсэн ингэний ааруул

Тавиур дүүрэн тос нэвчүүлж элээ эргэлдүүлнэ

Гэрэвшсэн харцаараа айлын шинэхэн бэр

Тогоо тавихын зуур дэргэдэх залуусыг шилбүүрдэнэ

Жонжин тэшүүлэх ингэн тэмээний бөхөн завсраар

Жирэлзэн өнгөрөх цагаан загнуудын орой шаргалтан туяарна

Жин үдийн аниргүйн дунд ижий говь минь

Жиргэн донгодох голио, царцааны царгианд зүүрмэглэнэ

Толгодын энгэрт үдшийн бүрийд цагаан хяруу мөнхөрч

Хот дүүрэн налайх хонин сүрэг амгалан хивнэ

Тоонын гэрлүүд тас харанхуйд алсаас тодрохдоо

Харь гарагийн элч тавган хөлгүүдээр эргэлдэн нисэх мэт ээ

2010.09.20. Баянжаргалан

МИНИЙ ЭХ ОРОН

Угжсан ингэний сүү минь миний эжий орон

Ууж дассан цулхирын цай минь миний эжий орон

Уралдаж тоглосон

Наймангийн тал минь миний эжий орон

Хурдны морь унасан балчир нас минь миний эвий орон

Хултай айраг сөгнөсөн идэр нас минь миний эвий орон

Хурдан буу мөрөвчилсөн цэрэг нас минь миний эвий орон

Тоонот бор гэр минь миний өлгий орон

Төрсөн бүлээн хонд минь миний өлгий орон

Төгссөн буянт сургууль минь миний өлгий орон

Амраг хайрт минь миний хайрын орон

Алаг хонгор үрс минь миний хайрын орон

Алиа хөөрхөн ач зээ минь миний хайрын орон

Төрийн алтан соёмбот туг минь миний эх орон

Төрсөн нутаг Дорноговь минь миний эх орон

Төрөлх Монгол улс минь миний эх орон

ХОРВООГИЙН ЖАМ

Эрвээхий шиг хөөрхөн төрсөн бүсгүй

Эвдэрсэн араг шиг болдог

Хангайн буга шиг сайхан эр

Хавчаахай нум шиг болдог

2009.06.05. Чойр.

БОРЖИГИНЫ ЭГШИГЛЭН

Найргийн ажнай хурдаа авч чинад совинг

Нас дагасан найраг, миний шүлгүүдээр

Нар аргамжсан нутагт араншингийн салхиар

Найргийн зургаан татлага, тэнгэрийн санааг мэлмэрүүлнэ

Алаг заяа, миний араншинтай

Амраг шүлгүүдийг бурхад унших завгүй ээ

Алаг дэвтэрүүд, хэлд орж хөл дээрээ боссон нутагт минь

Агуу их бурхад уулзах цагт, боржигины эгшиглэн уянгална

Бусдаас өөр чамдаа, хуур дагасан аялгуутай дэлгэрэхийн чулууг бэлэглээд

Өөр өнцгийн нүд, морьт сүмбэр аялгуунд уярч сувдан шигтгээ унагасан

Би залуудаа гоё амрагаа хайрлаж энхрийлэхдээ

Өргөст цас, хээтэй араншинд хүргэлгүйгээр шүлгэн эрхээр гижигдсэн

Цэнхэрлэн эгшиглэх боржигин нутагт минь

Цэрэг амьдралын минь мөрдөст аялгуу эгшиглэнэ

Амьд цаасан дээр жаргалтай нутгийн наадам хөгжөөд

Алтан ургийн өвгөд, эмгэд, нарны ордын эзэн лугаа жаргана

2010.07.24. Чойр.

ДУРСАМЖИЙН ДЭВТРЭЭС

Нандигнан хадгалсан дурсамжийн дэвтрээ нээхэд

Найз нөхдийн минь багын сайхан дүрүүд мэндчилнэ

Нэг л мэдэхэд бид уулзалдалгүй дөчин таван жил

Нэрнээсээ бусдыг бараг мартах дөхлөө гэж үү

Тахианы шинэхэн байрны анхны зочид нь

Техникумын дадлагын оюутан залуус байлаа

Тархиа өвтдөл дээвэр цоортол мөргөлдсөн

Танхилхан залуу насны хөгжилтэй дурсамжууд мартагдахгүй ээ

Зүссэн болрын гялтганасан талст лугаа

Зоргол хайрхан орой нарны туяанд шижиртэнэ

Залуу насныхаа гэгээн цэлмэг өдрүүдийг минь

Зүггүйтэж явсан бидний зүрхний бичээс байжээ

Халтартаж шарласан дурсамжийн дэвтрээс

Хорин хоёр хөвгүүдийн гэгээлэг мөрөөдөл мэдрэгдэнэ

Харвасан сум шиг өнгөрсөн дөчин таван жилээ

Хоёр зууныг дамнасан түүх болон мөнхөрчээ

Өсөн нэмэгдсээр он жилүүд юутай хурдан өнгөрнө вэ?

Өтлөж хөгширсөн хойно эрхэм андуудынхаа дурсамжийг

Өнгийн харах тэрхэн мөчид өнөөдрийн учрал

Өнгөрсөн дурсгалт жилүүдийн гантиг хөшөө болно

2013.09.10 Улаанбаатар

ЦЭРГИЙН ДАРГЫН ГЭРГИЙ

Эр нөхрийнхөө

Цэрэг амьдралын жамыг дагаж

Эгэл боргилхондоо

Цэнгэлт олноос буйдхан залуу насаа гээсэн

Аль тааралдсан ажлыг

Би би гээд хийж ирсэн чи минь

Армитай амьдралаа холбосон

Бие сэтгэлийн тэнхээтэй бүсгүй минь

Давхар давхар ачаа үүрч

Амьдралыг хамт туулалцсан хань минь

Даамай сайхан сэтгэлээрээ

Ариун голомтоо түшсэн гэргий минь

Ойн зэрлэг согоо шиг

Тунсаг жавхаатай төрсөн чи минь

Онгон хилийн зурвас дээр

Тушаалгүй зогсоо жинхэнэ цэрэг ээ

ТЭД БАЯН

Хүмүүс цэргийн дарга нарыг

Баян л гэдэг юм

Холцруутаж боргошсон олон хүүхэдтэйгээ

Тэд баян

Хатуужил, тэвчээр, хатан зоригоороо

Тэд баян

Хайрт эх орныхоо төлөө дусаасан хөлс, цусаараа

Тэд баян

Ард түмнээ хайрлах сэтгэлээрээ

Тэд хамгийн баян



Цэвэлийн ДУЛАМЖАВ

Бага Боржигин овогт Ц.Дуламжав 1947 онд Дорноговь аймгийн Дэлгэрэх суманд төрсөн. Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн анхны гишүүн.

МУ-ын Соёлын “Тэргүүний ажилтан”. “Утгын сүү эгшиглэн” наадмын дэд байрны шагналт.

ЗАХИАС

Хүслээр жиг үүрлэн сэтгэлээр баян яв хүү минь

Хүний хүүг мөрөөдөн уясч инээмсэглэж яв охин минь

Хатууг зөөлн өөр бодож хатамжтай яв үрс минь

Хайрыг ухаанаар тосож жаргаж явцгаа та минь

Хүслээр жиг үүрлэн сэтгэлийн галдаа шатаж яв охид минь

Хүндэт алдраа хүн бүхэнд дуурсуулж яв хүү минь

Хүйтэн халууныг ажралг үй давж явцгаа таминь

Хүсэлтэйг эдэлж хясалтайг бяцалж баярлаж амьдарцгаа

1995

х х х

Айлхан аашинд минь хайлаад чи согтуу

Аньсага нүдэнд чинь багтаад би согтуу

Энхрий биенд минь хүрч ядаад чи ядуу

Ээжийн чинь дэргэд хүсэл хумиу би ядруу

Уяхан аашинд минь уяраад чи согтуу

Ухаантай харцанд чинь багтаад би согтуу

Учралын гэгээ цалгиад чи ядуу

Ус голыхноос чинь бэргээд би

Ядруу

XXX

Зүүрмэглэх цагт зүүдэлж сэрээд горьг үй нь

Зүс гэгээн амьдралд чамдаа хайрг үй байж чадахг үй нь

Хүслээ тэглэх гэсэн чинь чамайг бодоод горьг үй нь

Хүнийх ч гэсэн чамайгаа хүлээхг үй байж чадахг үй нь

Уужуу тайвуу байя даа гэхнээ горьгүй нь

Ухаарлын учиг сэмрээд байж сууж болохг үй нь

Ургаж хагдрах гунигаа цэцэг өөрөө эдэлдэг

Уйлж дуулах жаргалаа хүү өөрөө

Мэдэрдэг

ХҮСЭЛ ХЯСАЛ

Дуулах уйлах ч хүсэл хясал

Дурлах өших ч хүсэл хясал

Ер өөх хараах ч хүсэл хясал

Ерт өнц өөрөө хүсэл хясал

Танилцах салах ч хүсэл хясал

Таалах баалах ч хүсэл хясал

Үхэх төрөх ч хүсэл хясал

Үнэндээ энэ орчлон хүсэл хясал

х х х

Мандах гэж шингэдэг

Нар шиг ээж минь

Ургах гэж ганддаг

Цэцэг шиг ээж минь

Уярах гэж бүрддэг

Дуу шиг ээж минь

Уй хөгл өсөн насанд

Дулаахан ээж минь

ХҮНИЙХ БОЛОХООР ХЭЦҮҮ

Хайртай хайртай л гэнэ

Хаяа холдоо хэц үү

Холдохын аргаг үй чи минь

Хүнийх болохоор хэц үү

Сайн хүн сайн хүн л гэнэ

Санахаас хэтрэхг үй хэц үү

Салахын аргаг үй чи минь

Хүнийх болохоор хэц үү

Байгаа байгаа л гэнэ

Барьж болохг үй нь хэцүү

Байгаа үгүй хо ёрыг

Би мэдэхг үй нь хэц үү

Үзэгдэнэ үзэгдэнэ гэнэ

Үнэрлэж болохг үй нь хэц үү

Үгүй байгаа хо ёрыг

Би мэдэхг үй нь хэц үү

НОЙР ХУЛЖСАН ШӨНӨ

Нойр хулжсан шөнө

Бадаг шүлэгтэй хуримлаж

Нохой минь манаачийн үүрэгтэй

Баавгай шиг зүүрмэглэнэ

Гэнэт сэртэсхийсэн нохой

Холыг чимээлж хөв хөв

Гэрт дөтл өн ойртох

Хөлийн чимээ тов тов

х х х

Үүлэн чөлөөний нар хурцхан

Үеийн чиний хайр халуухан

Үүрд чамтай учран ханилахгүй ч

Өр зүрхэндээ шатаж явъя даа

Өглөө өглөөний нар хурцхан

Өхөөрдөм чиний хайр халуухан

Хайрт чамтайгаа учран жаргахгүй ч

Халуун зүрхэндээ шатаж явъя даа

АЙЛЫН ААВ

Айлын аавын ааш нь даруу

Алаг нүдний ирмээ нь учиртай

Алхаа гишгээ нь намбалаг намуун

Аядуу зөөлөн дуу нь уянгалаг

Айлын аавын инээх нь дажгүй

Алаг нүдээ ирмэн байж

Аа би мэдээгүй шүү гэж

Аяглах нь хүртэл ялдамхан

Хааяа тулгарах харц нь үг

Хайраа нуусан цээж нь гал

Нарны эртэд уулзаагүй гаслан

Насны идэд учраагүй хяслан

х х х

Үг үгрүүгээ урсана

Үерлэнэ үү үймэрнэ үү би мэдэхгүй

Сэтгэл сэтгэл рүүгээ тэмүүлнэ

Сэргэх нь үү сэгсрэгдэх нь үү би мэдэхгүй

Хайр хайр руугаа урсана

Ханилна уу хагацна уу би мэдэхгүй

Халуун халуун руугаа тэмүүлнэ

Харин чи ганцхан минийх шүү

ГАНЦААРДАЛ

Үүлэн чөлөөний хооронд

Саран ганцаардана

Өнчин дэрний нойронд

Би ганцаардана

Үүр шөнийн сэлгээнд

Цолмон ганцаардана

Үйл заяаны хайранд

Зүрх ганцаардана

ЧАМАЙГ МАРТЪЯ

Хүлээгээд хүлээгээд ирээгүй чамайг

Хүнийх гэж бодож мартъя

Хүүхэд багынх шиг дэврүүн сэтгэлээ

Хүрэн зүрхнээсээ үргээж мартъя

Хараад хараад ирээгүй чамайг

Хайргүй шүү гэж бодож мартъя

Хос зам ширтсэн харцаа

Хажуу тийш нь хориглож мартъя

Сэтгэл итгэл хоёрын холбоог

Сэмлэн байж сэмхэн мартъя

Надад ирээгүй сэтгэлийн жолоог

Насаараа дугтчин байж мартъя

ЧИНИЙ МИНЬ ДҮР

Бодол бодлын гүнд

Босоо үлдсэн чи минь

Борхон зүрхний тольтод

Бодогдоод байх чинь юу вэ

Санан санан дурсахад

Санаа алдмаар ариухан

Сайхан чиний минь хайр

Сар мэлтийх шиг тунгалаг

Уяран уяран бодоход

Урьхан дүр чинь тодроод

Уяхан төрсөн чинийхээ

Ухааныг эсгэн суумаараа

НАЙМАН НАСТАЙ ХЭЭР

Найман настай хээрийгээ

Найр наадамд унал уудаа

Намбалаг төрсөн чамтайгаа

Нартын элгэнд жаргах уу даа

Шанхан дэлтэй хээрийгээ

Шандын булгаас услах уу даа

Шийдсэн хоёр сэтгэлийг

Санааны зоргоор залах уу даа

Дөрвөн настай хээрийгээ

Дөрөлжийн булгаас услах уу даа

Дөмөөрөө байгаа сэтгэлийг

Дөнгөж байгаад дасгах уу даа

УЛ МӨР

Сайхан чи минь сайн хардаа

Санааширлын бие тэмдэг болж

Санчиганд унасан хяруу хэзээнийх вэ

Санааны уг дахь эрэгцүүлэл хэдийнийх вэ

Гуйгаад мөнхөрдөггүй

Орчлонгийнжамаар

Гундаж ч явсан мандаж ч явсан

Гуниг баярын их ул мөр

Гурви сорви шиг байгаа нь энэ шүү дээ

ОД ОЙЧТОЛ ГУНИХСАН

Амрагийн хооронд давчидсан

Алаг зүрх минь хөөрхий

Амраглаж чадахгүй тарчилсанаас

Асарлах тэнгэрт сар болмоороо

Эчнээ дотроо ганихарсан

Элэг зүрх минь хөөрхий

Энхрийлүүлж чадахгүй явснаас

Энгэр цармын эрвээхэй болмоороо

Хайранд умбалгүй хорвоод

Хатаж гундаж байснаас

Халиун ягаан цэцэг болж

Хад хагсаж од ойчтол гунихсан

ХАЛУУН МӨРӨӨДӨЛ

Хамгийн анхны дулаан өдөр

Хавар багтаад ирдэггүй юм

Хааяа тохиох бүлээн харцанд

Ханийн жаргал байдаггүй юм

Хажуугийн хүнд үг алдахгүй

Хархан нүд чинь ярих илбэтэй

Хамаг сэтгэлдээ өчиг үлдээлгүй

Харцан дээрээ бичих эрдэмтэй

Харах дугам сэтгэл татсан

Халуун зүрхний хүчит соронзон

Ханийн заяатай хүний орчлонд

Хайрын тахилгатай онгон тэргүүн

Дурлалын тухай хамгийн сайхан

Дууг хамтран зохиох юмсан

Дуулим хорвоод ханийн жаргалаар

Дуундаа л шингээд үлдэх юмсан



Цэвэгдоогийн ГАЛДБАДРАХ

1958-1997

Цэвэгдоогийн Галбадрах нь 1958 онд одоогийн Говьсүмбэр аймгийн цагаан толгой хэмээх газарт Цэвэгдоогийн отгон хүү болон төрсөн. Бага насандаа эцэг эх, ах эгчийн гар дээр өссөн, 1966 онд Говьсүмбэр аймгийн 1 дүгээр дунд сургуульд элсэн орж, 1975-1976 онд Дорноговь аймгийн Сайншандад 10 дугаар ангиа төгсөж. 1976 ондоо ЦИС-д элсэн орж 1980 онд Улс төрийн мэргэжилээр төгссөн. 1992-1995 онд Говьсүмбэр аймгийн цэргийн хэлтэст ахлах офицероор ажиллаж байхдаа Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн анхны гишүүн болж “Найргийн ажнай” хамтын бүтээлд шүлгүүд нь хэвлэгджээ. 1996 онд БХЯ-ны сургалтын төвд Соёл олон нийтийн зааварлагч, 1997 онд БЦДБЧ-д жагсаал ангид Боловсон хүчний Даргын үүрэгт ажлыг гүйцэтгэж байгаад гэнэтийн ослоор мөнх бусыг үзсэн.

ӨВГӨД МИНЬ

Боржигин овогт аавдаа

Малынхаа захаас хөндийрч бийр янтай түшээгүй

Манант их талаасаа билгүүн сэтгэл хулжаагүй

Хонх дамар аясуулан бурханы оронд залраагүй

Хошуу алгасан амьдарсан ч ус нутгаа мартаагүй өвгөд минь

Төө хархан гэээгтэй төрийн хар хүн явсан юм

Төвхөн агаад даруухан жирийн хүмүүс байсан юм

Засаг төрийнхөө буянд ядуугийн зовлонг гэтэлгэж

Замбуулингийн энэхэн хавцгайд тэгш жаргалыг эдэлсэн юм

Зулай зулайгаа гишгэсэн үрсийнхээ хожмыг бодож

Заяа буяныг даатгаж төрийн сүлдэндээ залбирсан юм

Нартын жаргалыг эдлэх хувьтай төрсөн буурлууд минь

Насны хяруу унасан ч тулх нь хэвээрээ буурлууд минь

Оройн дээд эрдэнэ төрийн сүлдээ огоорооггүй

Ороо бусгаа амьдралд ноён нуруу нь хотойгоогүй

Орчлонгийн эрээн бараанд сэтгэл алдран гонсойгоогүй

Орчилт энэ хорвоод ганцхан заяах буурлууд минь

Алс хэтийг тунгаах ид шидийн ухаан

Алдаа оноог тэгшлэх сургаалийн алтан сан

Атгаг харам санаагүй цэвэр ариун сэтгэл

Алаг энэ дэлхийд амьдралын шударга үнэн

Намайг чамайг гэсээр хээр хоносон саран

Намжаа дэлхийг ундаалах хурын дараах наран

МАЛГАЙ

Асаж мандахын гэгээ сүмбэр оройтой бүтээсэн

Ашид амирлахын ухаан очир сампин зангидсан

Амгалан мөнхийн билэгдэл дөрвөн талаар хүрээлсэн

Ариун галын дөл бадман залаа намируулсан

Хамба торгон гадартай халх жанжин малгай

Хан тэргүүндээ дээдэлдэг хийморь сүлдийн манлай

Буруу харсан сав гээд бусдад өгдөггүй жамтай ч

Буянтай ард түмний минь өнө мөнхийн соёл

ХҮН

Аз жаргал бялхсан арван буяны суудал

Амьдрал тэмцэл дундах үнэн худлын заадал

Ачлал энэрэлээр сүлсэн хүндлэл хайрын зүйдэл

Атаа жөтөө холилдсон арван харын гүйдэл

ДЭЭЛ

Дэгжиж өөдлөхийг билэгдэж энгэр захыг босгосон

Дэлгэр буяныг бодож дотоод хормой оруулсан

Төвшин жаргалыг эдлэг гэж эмжиж хажиж урласан

Төлөв дарууг эрхэмлэн товчилж, бүсэлж заншсан

Цагийн хатууд өмсдөг цувцаа нэхий дээл

Цэнгэл наадамд гоёдог торго дурдан тэрлэг

Цагаан сэтгэлтэй ардын минь цэмцгэр нэгэн гоёл

Цаг цагийн саалтанд гээгдээ нь үгүй гоёл



Сүрэнгийн ОТГОНЧИМЭД

Боржигин зурхайч овогт Сүрэнгийн Отгончимэд 1953 онд Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг Дунд баян гэдэг газарт төржээ. АУДС-ийг Эрүүл ахуйч их эмчээр төгссөн. Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн анхны гишүүн. “Есөн зоосны мэрэг”, “Эвтэй амьдрахын нууц”, “Алганы хээ-Амьдралын үндэс”, “Дэлгэрэхийн чулуу” , “Мэлмий ба зурхай” номнуудыг бүтээжээ. МУ-ын Эрүүл мэндийн “Тэргүүний ажилтан”.

Эргэж төрсөн хань минь

Эрхэлж ирсэн ач хүү минь

ХАЙРТ ХАНЬ ЦООЖДОО ЗОРИУЛАВ.

Чамайгаа алс холын хонгор нутагт

Чарлаж нялхарч үр минь болон ирсэнийг мэдлээ

Харахад хань ижлий минь дүр тодорч

Хайрлах сэтгэл цээж огшооном

Хаа холд төрсөн чамайгаа ирсэнийг хараад

Хаана ч байсан андуурахгүй гэдгээ мэдлээ

Хацар, хамар, хүзүү бүхэн нь чамайг дуурайж

Халхын нутагтаа ирсэнийг мэдлээ

Их шаргалтах талд ганцхан цэцэг үлддэг шиг

Их хүмүүн орчлонд хүү болон төрснийг мэдлээ

Хонгор нутгийн эгэлхэн бүсгүйд үр болон заяаж

Эвий миний хүүгийн хүү юм гэдгийг мэдлээ

ЭНХРИЙ ХӨӨРХӨН АЧ СОНОРТОО

Эвий хөөрхөн ач минь

Эмээгээ дагаад уйлаад байх юм

Ижлээ дагаад тонгочих унага шиг

Эгэлгүй цовоо бүжих юм

Цэцэглэж яваа оюундаа

Цэнгэж тоглохсон гэдэг биз

Цээжиндээ аавын минь ээж гэж

Сэтгэлдээ хайрлан бодоо биз

Аньсага чийглэн гоморхож

Алтан сувд юунд унаганам

Аавын минь ээж гэж

Балчирхан сэтгэлдээ хайрлаа биз

Иймхэн балчраасаа эмээгээ мэддэг нь

Эжийгийн саруул ухаан шингэснийх биз

Ижлээ мэдэн тонгочих нь

Эцгийн холч ухаан удамшсанийх биз

2013 он

СОНОРХОНДОО

Арав хоноогүй байхдаа

Алаг нүдэн юм чинь

Арван найм хүрвэл

Аяа миний охин солонгорно доо

Мөөмөө тавиад намайг онцлон харлаа

Мөн ч хөөрхөн гэдгээ гайхуулан ширтлээ

Үнсэх гээд тонгойход минь

Үнсүүлэх гээд бэр минь өслөө

Хүүхдээсээ эрх миний бэр

Хүний дээд ээж байгаасай

Хүн болж төрсөн ач охин минь

Хүслийн дээд нь биелж байгаасай

Зэмлэл

Аавыгаа зөнгөөрөө мэдэрч

Ажилд нь явуулахгүй уйлдаг

Алиа бяцхан үр минь

Аав болон ач төрүүлж өглөө

Ач минь аавыгаа алга болохоор

Адилхан тамираа шавхан уйлах юм

Аяны шувууд хүртэл өндгөө хамгаалдаг болохоор

Аав болсон үр минь юунд ачийг минь чарлуулна вэ?

Үр ачаа хайрлах сэтгэл

Нар ихэдвэл өвчин болдог

Хайрыг мэдрэхгүй бол хагацал болдог

Хань үрээс хагацвал зовлон болдог

Хайрлан байж айл жаргалтай

Бүсгүй хүний хайранд

Бүлтгэр үр чинь жаргана

Бүлтэй, бүстэй эр хүний ухаанд

Бэр болсон бүсгүй хүн жаргана

Хоёр

Алс холоос авчирсан эрдмээ

Архинаас өгчвөл хэцүү яа

Алсаал авчирсан богцоо

Алмайрч байгаад алдчихвал хэцүү еэ

Ойн хүрэн баавгай шиг өвөлжин унтсан

Ойн шугуй шиг согтуу найгавал хэцүү еэ

Ойрын хүндээ халамжгүй амиа хичээсэн

Олон түмэнд ач тусгүй

Архичин болчихвол хэцүү еэ

Гурав.

Бүсгүй минь бүлтгэр үрийн ээж минь

Бүүвэйн дуугаар үрээ гэрээ ариул

Үрээ хайрладаг шиг хүүг минь хайрла

Үндэстэй нөхөдтэй нь аялгуухан хайрла даа

Уур бухимдлаар үрээ гэрээ бүү дүүргэ

Ухаан тэвчээр хоёроор бүхнийг дийлнэ

Ухааны ураар мэтгэн шагладаг бэр бол

Уужим сэтгэлээр хүүг минь хайрлаж амьдар даа

Нөхөдтэй нь цуг хайрлахгүй юм бол

Нөхөр чинь гэртээ тогтохгүй ээ

Дүү нартай нь цуг хайрлахгүй юм бол

Дэндүү хэцүү үед хэн ч туслахгүй ээ

Хайр халгисан түм бужигнасан айлыг сайхан айл гэнэ

Хэн ч орохгүй цэмцгэр цайгүй айлыг

Ямар сайхан айл гэх вэ?

Орж ирсэн хүний хөл шагалзан

Олон түмэнгүй айл бол ямар сайхан айл байх вэ?

Хорвоод хоёулханаа жаргадаг хосоороо амьдардаг ч

Тойрсон олны тусламжгүй тун ч хол явахгүй ээ

ОЛОН УЛСАД ТАРСАН ЭРЧҮҮДЭЭ

Олон улсад тарсан эрчүүд минь гэртээ ирцгээ

Олон жил харуулдсан ээж чинь эмгэн болох нь ээ

Орхиод явсан гэргий хүүхдүүд чинь

Олон жил харлаа одоо боллоо

Адуун сүргээ бэлчээдэг

Атар сайхан нутгийг чинь

Алтыг нь устай нь устгаж

Ангалзсан том техникээр тоноод дууслаа

Алив эрчүүд минь нутагтаа ир

Алс холын нутагт үзсэн харсанаа үзүүл

Аавыгаа орлож гэртээ үлдсэн хүүдээ харуул

Ангаж цангасан сэтгэлийг нь амраа гэргийнхээ

Эрчүүд нь эзгүй айлыг ямар айл гэх вэ?

Эр нөхөр нь эзгүй бүсгүйн ачаа хичнээн их вэ?

Эзгүй хээр тал нутагт чинь хэн хамаагүй суух нь

Элдэв газрын харийнхан нутагт чинь эзэн суух нь

Ган хөлгөөр эрдэнийг чинь зөөж байна

Газар газрыг чинь сэндийчлэн ухаж байна

Гал халуун эхнэрт чинь нөхөр болох нь байна

Ганц үрийн чинь аав болох нь байна

Алив эрчүүд минь гэртээ ирцгээ

Ангаж цангасан ажилсаг эхнэрээ амраа

Алтан нутагтаа эзэн сууцгаа

Усны шувууд хүртэл төрсөн нутгаа зорьж

Жилдээ нэг ирдэг байхад

Уугуул нутгын ухаант хүн байтлаа

Жилдээ нэг ирэхгүй байж яаж болох вэ?

Чамайг ирэхэд нутгийн чинь салхи угтаж мэднэ

Нутаг гэх газаргүй болсон байж мэднэ

Эхнэр хүүхэд чинь угтаж мэднэ

Ээж чинь харин байхгүй байж мэднэ

Төрийн нуруу тэгшлэх эрчүүд минь

Төмөр хүлгийн эзэд минь

Түмэн олны хүндэтгэл хүлээж

Төрсөн нутагтаа эргэж ирцгээ

Баялаг дүүрэн нутгаа эртнээс харамлаж ирсэн юм

Тал дүүрэн таван хошуу мал бэлчээж

Тансаг эрдэнээ хадгалж ирсэн юм

Та нар харин хайрлахгүй хаяад явж болно уу

Хэн хамаагүй эзэмших нутаг биш гэдгийг харуул

Хэн хамаагүй худалдчих эзгүй юм гэж бүү сана

Ард түмэн байхад улс сөнөдөггүй

Аав нь байхад айлын голомт бөхдөггүй юм

2013 он

ГАЛ ШАР НУТАГ

Алс хол явахад минь ээ хө

Тааны үнэр ханхалсан

Гал шар нутаг

Аян яваад ирэхэд минь ээ хө

Алаг цэцэг нь дэлгэрсэн

Гал шар нутаг

Хулангийн сүрэг хуйлран байдаг

Хурдан морьдоороо гайхуулсан

Гал шар нутаг

Холын холд суугаа уяачдын зүүдэнд

Хоногшин байдаг

Гал шарын хурдууд

Монгол түмэнд алдар нь цуурайтсан

Молор эрдэнийн сүрэгтэй

Гал шарын нутаг

Морины уяан дээр нялхаасаа өссөн

Монгол эрсийн шүтээн

Гал шар нутаг

Хараа сунгахад нүд цуцахаар

Ханагар уудам талдаа уралдаж өссөн

Гал шарын уяачид

Халх монголын бахархал болсон

Хаа ч алдартай

Гал шарын хурдууд

МИНИЙ ХАЙРТАЙ ХҮҮ

Үнэртэхэд эхийн цагаан сүү

Үлгэхэд өлгий дүүрэн хайр

Уйллаа ч өмөлзөх нь өхөөрдөм

Уурлалаа ч эвийлэн эвийлэн аргадмаар

Өлгийдөхөд энгэр дүүрэн хайр

Өвөртлөхөд өвөр дүүрэн мишээл

Өрвийлгөж сэрвийлгэмээр сэглэгэр

Ганганах нь гайхам уяхан уянга

Дэрвэх нь дэгдээхэйн хөнгөн жигүүр

Ганг ч уяраах хөөрхөн амьтан

Гандааж гундаахгүй ганц хүслэн

Инээх нь шүдгүй мөртөө ход ход

Үнэгчлэх нь сэрэхгүй мөртөө үрчиг үрчиг

Хөхөх нь цадиггүй гуд гуд

Нэвглэх нь жудаггүй год год

ЦАС

Үйлийн хайчаар эсгээгүй

Үүлэн хээтэй цэнхэр торго

Нарны илчээр гоо урласан

Намрын цас мөсөн эмжээртэй

Торгон мяндас хөвөлзөх шиг

Тоононоос сувд унах шиг

Торго урласан сэмбэгэр цас

Тогтуун цагаан өвлийн жавхаа



Ширчингийн БАТНАСАН

Дуутан овогт Ш.Батнасан 1959 онд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд төрсөн. 1975 онд Багшийн сургууль төгссөн.

Соёлын ажилтан мэргэжилтэй. Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн анхны гишүүн. Яруу найргийн “ Найргийн зургаан татлага”, судалгааны “Зурсан зурлага” “Хорлол ба хариулга” ном хэвлүүлж “ Могой газрынхаа өнгөөрөө”, “ Хормой дэвсэн хонгорхон нас” жүжгүүд бичжээ. “Боржигидай сэцэн” наадмын тэргүүн шагналт. МУ-ын Соёлын “Тэргүүний ажилтан”

ОРЧЛОН НАДААР ДУТАЖ ТААРНА

Тэнгэр мөрлөсөн амьдралд өөрийн зайгаа эзэгнэсэн

Тэлмэн жороо зуунуудын алдааг тойрох гэж мэрийсэн

Тэргэл саран дор өөрийгөө хэвлэж жаргасан

Тэнэг цэцэн хоёрын хоргой сүлжээс болохоор

Орчлон надаар дутаж таарна

Дээлтэй бурхадынхаа үлдээсэн эх орноороо гоёсон

Дэлхийд уралдуулах морьдоо онгодын хурандаа сойсон

Дээдэс буурлуудынхаа дэргэд дэггүй, зүггүй тархи

Дэвэргэн залуусын хажууд амьдралын нэвтэрхий толь болохоор

Орчлон надаар дутаж таарна

Он цагийн урсгал аниргүйхэн надаар өвгөрдөг

Од эрхэсийн таталцал намайг өдөж харвадаг

Оцол сансарын залуус насыг минь гуйж золгодог

Оорцог толгодоо түшсэн өвгөдөө орлож ухааждаг болохоор

Орчлон надаар дутаж таарна

Эрэвгэр дэрэвгэр эрээн нууранд үдлэхдээ

Эр хонгор сэтгэл минь энхэр зөөлөн эгшигтэй

Эр цэргийн тангарагаа батлах дуудлага гардахдаа

Эрмэг зоримог цустай эсгий туургатаны удам болохоор

Орчлон надаар дутаж таарна

Занданы үнэртэй санчиг нь танан өнгөөр туяарсан ч

Замбуулинд ганцхан ханьдаа хайрын хан хүү нь болохоор

Заяа тавилангийн минь шагнал бидэн хоёрын эрдэнэ

Жаахан бор үрсдээ өндөр Жанрайсаг болохоор

Орчлон надаар дутаж таарна

Хуурын алтан аялгууг хүмүүсийн сэтгэлд эгшиглүүлдэг

Худал үнэний дэнсэн дээр дүүжин даажин тоглодог

Хоёр зууныг дамнуулж найргаа сөгнөх хувьтай

Хожмын угтах ирээдүй шүлгээр минь дурсах ерөөлтэй болохоор

Орчлон надаар дутаж таарна

ӨВГӨН ЧУЛУУ

Цэнгийн мөнгөн бороогоор цэцгийн дэлбээг сэвэгнүүлж

Цэнхэр дурдан алчуурыг хайрын захиатай халааслаж

Гуулин хөгжмийн аялгуунд

“ Гурван марал” гудайтал бүжиглэж

Гуниж гутрахыг мэдэхгүй гурвалжин чулуу явлаа

Ааш бааштай орчлонгийн алтан дагнаасыг дагаагүй дээ

Амьдрал чиний оргил өөд өөрийн бодлоор тэмүүлсэн дээ

Дөрвөн зүгтэй орчлонгийн дөрвөлжин хэвэнд хашигдаж

Дөрөөн дээрээ ухаажсан дөрвөлжин чулуу боллоо

Эз азын даалуунаас өдөр хоногуудыг хожсон

Эр бор харцагын шуранхайн аясаар эмтэрсэн

Өндөр тэнгэрийн хаалга руу өөрийгөө элээж алхсан

Өрөөлийн мандааж зулын тос шиг дундарсан

Өндөг шиг мөлийсэн, өвгөрсөн, өнхрүүлж тогломоор эгдүүтэй ч

Голдоо ирмэгтэй эр чулуу,

Дотроо бодолтой өвгөн чулуу

ОЦОЛ САНСАР

Халхын уудам талыг

Харамлаж ургасан харуул уул

Хаа ч явсан сэтгэлд уяатай

Хиад Боржигины чандмань уул

Онгод найрагт минь уянга нэмсэн

Олон үеийнхний шүтээн уул

Од сар наранд ойрхон

Огторгуйн адистай Оцол сансар

ЕСИЙН ХҮРД

Алтан төрийнхөө хойморт

Есөн цагаан сүлдтэй

Амьд бурхаддаа өргөдөг

Есөн цагаан бэлгэтэй

Арслан төрдөг наадам нь

Есөн босоо даваатай

Ардаг догшин өвөл нь ч

Есөн есийн араншинтай

Арван хуруунаас минь хүртэл

Есийн хүрд уяатай

Би хөх Монголын удам аа

Нэгэн ес нь ес

Хоёр ес нь арван найм

Гурван ес нь хорин долоо

Дөрвөн ес нь гучин зургаа

Таван ес нь дөчин тав

Зургаан ес нь тавин дөрөв

Долоон ес нь жаран гурав

Найман ес нь далан хоёр

Есөн ес нь наян нэг

Арван есийн ер

х х х

Би чулуу

Чулуу чулуудаа

Эр чулуу

Элтэрч, эмтэрч үзсэн

Элэгдэж яваа өвгөн чулуу

МОНГОЛ ЗУРХАЙН ТАТЛАГА

Уярал цөхрөлийн нулимс угаасан усны минь халгиа

Урсан өнгөрөх он жилүүд нүгэл буяны минь харгиа

Уярач ээнэгшсэн бүхэндээ хайрын мөнгөн боргио

Удам судрын хэлхээндээ хүн урсгалын цалгиа

Би ус-Ус аа

Дэлхий ээжээ хөхөж үндэс яргаж салаалсан

Дээшээ тэнгэрт залбирч дээлэн дотроо ургасан

Зусар золбин үгсэнд итгэлээ цавчуулж хоргодовч

Зурс хийгээд өнгөрөх шүдэнзний ганц ширхэг

Би мод-Мод оо

Наран тунгалаг эх орныхоо голомтыг сахин дүрэлзсэн

Наран гоо дагинасад дурлаж дурлуулж хөлчүүрсэн

Наран сарны орчилд найргаар агсарч сагсуурсан

Нартаас буцахдаа хүртэл өрөөлийн зүрхэнд гэрэлтэх

Би гал- гал аа

Тэнгэрийн тамгатай төрсөн ч газар амьтай амьдрах

Тэртээд одсон өвгөдийнхөө өвөр дээр нь өтлөх

Тэнгэрт суудлаа олсон ч газарт ясаа орхих

Төрсөн нутгийнхаа хэвлийд эргээд шингэх тавилантай

Би шороо- шороо

Амьдрал чиний дөшин дээр он цагаар давтуулсан

Асар басар араншинд алгадуулж ухаажиж хатуужсан

Атгахан зүрхэндээ эх орноо ард түмэнтэй нь тээсэн

Алтан ургийн сахиустай амьд илд бамбай

Би төмөр- төмөр өө

Таван мах бодь миний тавилан заяаны тойрог

Ташуу нүүхээс минь харамласан монгол зурхайн татлага

х х х

Салаад явсан ч мартамгүй

Өтөл насыг умартсан

Санаанд уяатай үзэсгэлэн

Зүүдэнд хүртэл ээрэх юм

х х х

Хорвоогоос нүүхдээ та минь

Зүрхэнд ирж мөнхөрлөө

Хожмын хүмүүс дурсаг гэж

Чулуу уйлуулж үлдээлээ

XXX

Сайн яваагийн тэмдэг

Үсэнд чинь бий ээжээ

Санан дурсах бичлэг

Зүрхэнд минь бий ээжээ

МАТАДЫН ХУДАГ

Матадын худаг модон таглаатай

Магнай ташим сувдан устай

Мартахын аргагүй олон жимтэй

Манхан дундах талын нүдэн

Түнэр харанхуйд саамширч хонодог

Түүчээ тогорууд шүлсдээгүй усан

Түүх хадгалсан сумны шархтай

Төрөлх нутгийн минь амин эрдэнэ

Хатан зоригтнууд цусаараа үнэлж

Харамлаж үлдсэн хатан ус

Хамаг олны минь заяаг түшилцсэн

Халхын талын газрын сүү

Матадын худаг

х х х

Салаад явсан ч мартамгүй

Өтөл насыг умартсан

Санаанд уяатай үзэсгэлэн

Зүүдэнд хүртэл ээрэх юм

х х х

Хорвоогоос нүүхдээ та минь

Зүрхэнд ирж мөнхөрлөө

Хожмын хүмүүс дурсаг гэж

Чулуу уйлуулж үлдээлээ

х х х

Сарны цэгээн туяа

Гэгээхэн бодолтой бидэрлэнэ

Санаа сэтгэл үймүүлсэн

Бараахан давалгаанд бүдчинэ

Саахалтын санагдах он жилүүд

Нэг л мэдэхэд нисчихэж дээ

Саатай торго шиг нас минь

Самбай болтлоо сэмэрчихэж дээ

АРГАГҮЙ

Уйлах тоолон нулимс минь бүлээн байдаг аргагүй

Уярал цөхрөл хоёр сэтгэлийн сэмрэл юм чинь

Уйлах тоолонд нулимс минь бүлээн байдаг аргагүй

Хайрын мэлмий нь сүүдэртсэн ч анддаа баярлахаас аргагүй

Хүнлэг сэтгэлийг минь хуурайдавч намайг хөрөө шиг хурцалдаг

Хайрын мэлмий нь сүүдэртсэн ч анддаа баярлахаас аргагүй

Хаяа сахьсан нохой ярдаг байдаг аргагүй

Хайрлаж тэжээсэн эзнийхээ хармын сэтгэл юм чинь

Хаяа сахьсан нохой ярдаг байдаг аргагүй

Надад итгэсэн бүхнийг гэрэлтүүлж явахаас аргагүй

Нар шиг гийгүүлж чадахгүй ч хүж шиг уугьж дуустлаа

Надад итгэсэн бүхнийг гэрэлтүүлж явахаас аргагүй



Дамдины БАТЧУЛУУН

Дорноговь аймгийн Алтанширээ сумын “Чулуунгишгэр” хэмээх газар төржээ.

АУИСургуулийг хүний их эмч мэргэжлээр төгссөн.

Дорноговь аймгийн “Хурмаст тэнгэр” төвийн анхны гишүүн Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн анхны гишүүн.

“Алтан бийр”, “Билгийн далай” наадмын шагналт.

МУ-ын Эрүүл мэндийн “Тэргүүний ажилтан”

Цурам нойрыг минь хасаж

Урам хайрласан шүлэг минь

Цучил болон хатаагдаж

Хурам ч бөхөлгүй асаасай

ШҮЛГЭН ЦАЦАЛ

Марал мичидээ өнжөөж

Малчны дуугаа хурайлсан

“Малх”ын их талаар

Мэлмий юугаа тэлсэн

Ширээж хатаасан “чулуу” нь

Шидийг олж шилэрдэг

“Шивээ”гийн их говиор

Өлмий юугаа жийсэн

Жаран жарны тэртээгээс

Залбирч шүтэж ирсэн

“Жанжин Чойр”ын ууландаа

Жаргалын есөн цацлаа өргөө

Сүү өргүүлэн мялаалгаж

Сүүдэр юугаа үргээлгэсэн

“Сүмбэр” их ууландаа

Шүлгийн есөн цацлаа өргөө

Олон зууны тэртээгээс

Онцолж биширч ирсэн

“Оцол сансар” ууландаа

Онгод найргийнхаа дээжийг өргөө

Хурай, хурай, хурай

2014 он

НУТГИЙН БОРОО

Газрын зөөлөн бараадсан бүгээн голдуу адуу

Гантай жилийн хөрсөнд туурай цөмчин бүдчинэ

Газар үнэрлэн тургилна ганц шанд руу цувна

Харганын сахалд бүдэрсэн хамхаг чилээрхэх агшинд

Харгуйн бүдэг зөргөөр улбаа тоос манарна

Харагдах бараагүй алсарна хачин гэмээр аниргүйднэ

Хагссан суулгын бүслүүр огшиж үлдсэн оромд

Харшсан ингэний буйлаа шингэж ядан мэнэрнэ

Хаяа нь үгүй тэртээд зэрэглээтнэ харин энэтээд хоосорно

Бүрдэн усандаа хоргодож говь захалсан адуу

Бүтэн бээрээс анирдаж самсаа бүрээдэн шуухирна

Хүрдэн хадандаа залбирч хурмастын дагинасыг аргадна

Толгод дамжин ингэ тэшүүлнэ том том бороон дусал дусална

Тооройн бяцхан төгөлд

Тогорууд бүжиг цамнана

2011 он

ӨРХИЙН ЭМЧ

/Өрхийн эмч нараа өмөөрч бичсэн шүлэг/

Өрхийн эмч-Хүний эмч

Өр нимгэн – Монгол эмч ээ

Өвдөхийн хорлол эмгэг бүхнээс сэргийлдэг

Өөдлөхийн эхлэл эрүүл бүгдийг хамгаалдаг

Өөр хэнд ч заяагаагүй эрхэм үйлсийн эзэн

Өөрөөсөө илүү бусдыг хайрлагч эрдэнэт хүмүүний дээд

Өрхийн эмч – хүний эмч

Өргөсөн тангарагтаа –үнэнч эмч ээ

Өр зээл хоёр сүлэлдэн бас сүлбэлдэн байдаг

Өвчин эмгэг хоёр холилдон бас хоршилдон байдаг

Өнгө алагласан энэ л орчлонд өгсөж бас уруудаж амьдрахдаа

Өндөр хэргэм горилж өрхөө орхиж яваагүй

Өглөг барьцанд шунаж өвчтөнөө мартаж үзээгүй

Өрхийн эмч – өрөвч хүн

Өөчлөх юмгүй – эгэл хүн

Яаруу давчуу дуудлагандаа явган голдуу явдаг ч

Бороо цасны алинд ч бохирч сөхөрч үзээгүй

Халцарсан гутлаа өмсөхдөө ч харшиж ер цухалдаагүй

Хашааны банхарт хөөгдөхдөө ч халширч ер шантраагүй

Өрхийн эмч – эрэлхэг хүн

Өр нэхдэггүй – цэрэг хүн

Өрхийн эмч, хүндтэй хүн өвөө эмээ нарт үнэтэй хүн

Эх хүүхдэд ээлтэй хүн ээж аавд итгэлтэй хүн

Эгэл түмэндээ эмч хүн энэ зуундаа алдартай хүн

Эх орондоо бол харин иргэн хүн

Өрхийн эмч – хүний эмч ээ

Өр зөөлөн – Монгол эмч ээ

2013 он

“ИХ ТООНЫ ЭЗЭД БУЮУ ЭНЭ ЗУУНЫ ХӨТӨЧ”

Статистикийнхэнд зориулсан шагналт шүлэг/

Тооцохуй ухааныхан гэдэг

Тоолж барамгүй сантай

Том айлын үр сад

Төрийн сангийнхан гэдэг

Төөлж барамгүй түүхтэй

Төр түшсэн эзэд ээ

Эдийн засгийнхан гэдэг

Эрт холын домогтой

Их хөгжлийн хөтөч өө

Эзэн Чингис хаан

Эр хоёр загалынхаа

Дэл сүүлийг үргээж

Дэргэдэх хэвгүүлдээ өгөхдөө

Дэлхийг донсолгосон цэргийнхээ

Дэг жаягийг тогтоох

Дээж их тоог

Дээдэлж эндээс олсон юм гэдэг ээ

Есөн хөлт их цагаан туг

Ертөнцөд ингэж мэндэлсэн юм гэдэг

Ер бусын шидээр хийморь лундааг сэргээсэн

Есийн тооны түүх ч

Ер нь ингэж эхэлсэн юм гэдэг ээ

Аянд одсон ханийнхаа ирэх өдрийг хүлээж

Эргэх цагийн өнгөнд

Аргалд явах болгондоо түүж ирсэн чулуу нь араганд багтахaa болиход

Айлын бүсгүй үр тооцохуйн ухаанд нэвтэрч тоолж сурсан юм гэдэг ээ

Сая живaa тоо ч нэгээр дутдаг гэгийг

Сар жилийн хугацаа ч хормоор дутдаг хэгийг

Цаас хэрэглэхгүй тэмдэглэж цаг алдалгүй тооцдог

Цахим тоолуурын эринд ч цааши хөгжлийг нь хөтөлсөн

Эдийн засгийнхан гэдэг энэ үеийнхнийг хөтлөх

Их тооны эзэд ээ ирэх мянганыг ч туулах

Их хөгжлийн хөтөч өө

“ШҮЛГЭН ШИВШЛЭГ”

/ Багш нарт зориулсан шагналт шүлэг/

...Болгоо багш минь та болгоо

Болох бас болохгүйн энэ л орчлонд

Босоо бас сууж явахыг сануулсан таныгаа

Ухаарал бас эгээрлийн цагаан дэнсээр

Урьд нь бас хойно нь дэнслэхийг сургасан таныгаа

Наран жаргаж сүүдэр хүүшлэх үдшийн цагаар

Номын дуугаа өндөрлөж гэрийн зүг явахад чинь

Айдсыг үргээх шившлэг болон хувилж

Ар хормойн нугалаасанд чинь асаад одог ээ шүлэг минь

Наран гийж сүүдэр огших энхийн өглөө

Номын заллага авч сургуулийн зүг яарахад чинь

Итгэл хайрлах хийморь болон хувилж

Энгэр хормойн нугалаасанд чинь эргээд эргээд ирэг ээ шүлэг минь

Шүлэг минь ингэж шившлэг болон хувираг

Багш минь та болгоо

Шүлэгч нь харин сүүдрээ тээн эндээ үлдэг

Багш минь та болгоо

Оршихуй орчихуй хоёр
Солигдон байдаг хорвоод
Огоорохуй эгээрэхүй хоёр
Эрэгцэн байдаг ёс байх юм
Үлдэхүй үрэгдэхүй хоёр
Ээлжлэн байдаг орчлонд
Үгүйрэхүй хоосрохуй хоёр
Зэрэгцэн байдаг ёсон байх юм
Өөдлөхүй уруудахуй хоёр
Өрсөлдөн байдаг хорвоод
Өрөвдөхүй өширхуй хоёр
Зэрэгцэн байдаг ёсон байх юм
Эвлэрэхүй эвдэхүй хоёр
Ээлжлэн байдаг орчлонд
Энэрэхүй инчдэхүй хоёр
Эрэгцэн байх ёсон байх юм

ХӨӨРХИЙ

Аргамжаатай морио хазаарлаж суралгүй
Аав эжий болно гэдэг
Юу л бол доо хөөрхий
Өлгийн дуугаа сурч ч амжилгүй
Өвөө эмээ болно гэдэг
Юу л бол доо хөөрхий
Дөчтэйдээ биш дөрөвтэйдээ галзуу сархад

Дөнгөж амсан гэдэг

Юу л бол доо хөөрхий

Тавьтайдаа биш тавтайдаа

Тамхилна гэдэг

Юу л бол доо хөөрхий

ЭНЭРЭХҮЙГ ИНЧДЭХҮЙ

Ботгоо эндүүлсэн ингэний гунганаа

Борхон говьдоо уусаж амжаагүй байхад

Борвий нь дагасан цагаан сүү

Боргионд шингэлгүй улаан болдог

Юусан билээ

Ханий нь ад үзсэн хадмын хахир дуу

Хамар хашаанд шингэж амжаагүй байхад

Хармын сэтгэлээр цалгиасан зэлгээн бор цай

Хатаж амжилгүй хар болдог билээ

Юуныхсан билээ

Үүрээ эвдүүлсэн өлөгчин чонын гийнаа

Үүрийн харанхуйд уусаж амжаагүй байхад

Өргөстэй бутанд дэлэнгээ хага татаад

Өөрөө өндөлзөн сорж хэвтдэг нь

Юуных вэ?

Хаягдаад үлдсэн үрийнх нь дуу

Харанхуй хонгиод замхраагүй байхад

Орхиод одсон эхийнх нь бие

Ондоо хүний өвөрт орсон байдаг

Юуныхсан бэ?



Мөрдоржийн БАТБАЯСГАЛАН

МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын төвд 1974 оны 6-р сарын 26 нд төрсөн. Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн анхны гишүүн. УЗНА-ны Дээд сургуулийг төгссөн.

“Морьт Сүмбэр аялгуу”, “Морьд үнэртсэн бороо”, “Энхжин зүрхний ерөөлтэй нутаг” номоо хэвлүүлжээ. “Боржигидай сэцэн” наадмын таван удаагийн Тэргүүн шагналт. “Есөн намрын зээргэнэ” наадмын тусгай шагналт. МУ-ын Соёлын “Тэргүүний ажилтан”, МУ-ын хошой өргөмжлөлт ерөөлч, магтаалч.

ХҮН ЧАНАРЫН ӨВӨЛЖӨӨ

Төв халхын эгшиглэнт найрагч Ж.Баяржаргалд

Тэнгэрийн цээлд бүргэд шувуу элин халих уулс ариун заллагатай

Газрын судас гүнж булаг үнэгчлэн мишээх ундарга дундрахгүй заяатай

Далд баяслын элбэг заяа хурга ишиг адил хөгнөөстэй

Далайн шуурга нэвтэлж үл барам дуулга дулаахан хаяатай

Морьтой эргэх шиг зорих зам нь сүү ерөөл бялхам болоод

Монгол төв халхын нутаг дуу өлзий өмөг түшигтэй

Янзага цогих шиг салхи нь сар цалгиулан эртний домог сөгнөсөн

Омог бардам халил нь уянга хуур халзан зүстэй

Эхийн сэтгэл гэрэлтсэн

Хүн чанарын өвөлжөө тийш.,

Тэнгийн ачаа дааж ядсан ертөнц хувь тавилан

Жингийн цуваа мэт хөвөрсөөр л байна даа

ЗОХИСТ БАДРАНГУЙ

Зохист бадрангуй эгшиглэнт нүд чинь тунгалагшаад

Зовлонг мартуулаад ямархан уяралтай

Мөнх саруул мөрөөр нь тэврэхэд амраг сэтгэл эгшиглээд

Мөн ч энхрий дотно уярал эгшиг сүлэгдэнэ

Их санасан сэтгэлийн манан сүлэх

Ижий минь бүүвэйн дуу аялах шиг бүсгүй юм чи

Гайхамшигтай цас хайлсан олон хаврын өдрүүдэд

Ганцхан чи минь сэтгэлийн тулганд бадамлана

Зохист бадрангуй эгшилэнт нүд чинь тунгалагшаад

Зовлонг мартуулаад ямархан уяралтай

ХАС ТҮҮХ

Яруу найрагч Х.Чулуунбаатар агаадаа

НЭГ

Оюун санааны гэрэвт суварга

Боржигин билгийн судрыг

Олонд хэн адислуулсан юм бэ?

Зотол хайрхан уулын солонгот аялгуу морьд үүрсэх шиг болоод

Хотол чуулган хавар цагийн бороо зүрхнээ шивэрнэ

Тэмүүлэл хүслийн бамбарыг өдөөн цацруулж

Тэнхлэгээ бүтэн эргэх дэлхийн түүхийг

Алгандаа бөмбөрүүлэх сүлд ах минь

Гартаам увдист чулуу, газар усныхаа төлөө

Ганцаараа шаналал тээсэн гунигт өдрүүдийг чинь дурсмааргүй байна

Гарьд шувуу мэт омог төгөлдөрийг чинь л дуулмаар байна

Саран зүгийн тэнгэр оддын мэлмий юуг тунгалагшуулж

Салхины үзүүр шүлгийг минь илбэнэ

ХОЁР

Хэрвээ та эх орноо гэдэггүй бол

Хэний тухай би гэрэлт аялгуу дуулах бол

Эмзэглэл хайр нь хүн бүхэнд түгээмэл бус

Элбэг торгон заяагий нь хаана, хэн мөнхлөх бол..,

Хүн төрөлхтний суу билгийн орон зай уудам талбарт

Хүн чулуу мэт, хас түүхийг туурвигч хишигт хүмүүн

Цасан дундуур омог оргилуулан

Цацаж бадран дүрэлзсээр л..,

Мөнх цаст тэргүүн уулсын оргил мэт

Мөнхрөхийн ид шидийг хүртэх болно

Мөнгөн сар шиг мэлтийх болно..,

ҮЛЭМЖ ИХ БОДЛЫН ЧИМЭЭ

Үлэмж төгс, судар орчлонг бүтээгч сэтгэл гүн худгийн дор усан мэт ундрахын хүслэнд гэгэлзээд

Үүлэн хүлэг эгшиглэн

салхитай намрын тэнгэр цэнхэрхэн тунгалаг гэрэлтэнэ

Дэрс нь хүртэл чуулан бүүвэйн дуу аялаад

сарны тэнгис давалгаа аргадан

Дэврэн асарлах омголон зүрхийг оддын зүг хуур мэт хөглөнө

Утгын омогшил, оюунбилиг сэтгэлийн сүү цэцэг болж зүлгэн дээр солонгороод

Урсах он цагийн зөн мэдрэхгүй уяхан агаад бодлын туульстай амраглана

Баруун Чойрын Баясхулан гэрэлт ерөөлч шүлэгчийг

Есөн зүйлийн эмт ургамалыг вансэмбэрүү мэт ихэрлүүлэн цэцэглүүлж

Ертөнц хувь тавиланг нэгэн намраар эгшиглүүлэх болно

Үзэсгэлэнт цаглашгүй туурвигч эртний бичээчийн алтан өдний амьсгал тасрахгүй

Үелзэн яруусах тарнилаг шувуудын алс жигүүр дорнын тэнгэрт цуцахгүй

Наран зүг найраг салхитай жигүүрээ дэвж омогшино би

Морин зүс номын хийморьтой жаргал үүрсээж домогшино би

БОДЛЫН ЧОНО

Яруу найрагч Б.Энхтөрд

“Оюун билгийн оргил уулсад омогшин улих бодлын чоно

буюу чи..,” өврийн дэвтрээс

Ардын яруу найргийн ертөнц

цаглашгүй болоод уудам юм

Амь булаалдан шатаж

он жилтэй дөрөө харшуулан дотносно

Алтанхан судар адислана

Мөнгөн чиг бийр түшнэ

Өвс цэцгэн дундаас хором бүр

өөдөө тэмүүлж

Өнө мөнх тэнгэрийн цээлд

гүн шаргал цэнхэртэнэ

Алтан хараацайн далавчин завсраар

нисч буй хязгааргүй үргэлжлэл

Асар хөх хурмастын авч давхисан

хувилгаан салхи чи

Зоргол хайрхан уулын шил дээр тунарах

тэргэл уянга сарны туяа

Хэрээ хадны минь цохио өөд мацах

Хэдэн муу шоргоолжны санаа алдалтыг

хөмсөг зангидан өрөвдөх

Ертөнцийн ер бусын мөнхөд

үргэлжлэх нууцыг

“Өөр өнцгөөс” нээхийг хүсэмжлэх

Ерөөлийн хадаг сэмрэхгүй

Судар номын тэнгэр юм

Оюунт хүмүүн төрөлхтөний

сэтгэлгээний гүнгэрваанд

Гүн од эрхсийн тусгал

үр бодол тань солонгорох

Омголон эгшиглэнт бодлын чоно

Огторгуйн дорно нутагтай

Ардын яруу найргийн ертөнц

цаглашгүй болоод уужим юм

Амь булаалдан шатаж,
он жилтэй дөрөө харшуулан дотносно
Алтанхан судар адислаж
Мөнгөн чиг бийр түшихийн
Учир билиг очир мэт ээ..,

АЛСЫН ЦЭНХЭР АЯЗ БУЮУ ЗӨӨЛӨН СЭТГЭЛ

Яруу найрагч Б.Бат-Өлзийд

НЭГ

Сүүдэр нь сүү
Их газрын чулуун элгэнд
цэцэг дэвтээх уянгын хур
Бодлын тань хананы үдээр тасрахгүй
Цээжний агсал үүлших зовлон нэг юм
Ариун сэтгэлд ардын итгэл өрөмтөөд
Агаар тэнгэрт солонгорон гэрэлтэх
Сүсэг бишрэлд залбирнам
Алсын цэнхэр аяз
дорно тийш харцанд чинь
Адуут хийморьт
эрхсийн шувуу нисэх мэт
хөмсөг тэнийнэ
Сүүдэр нь сүү
Их газрын чулууны элгэнд
цэцэг дэврээх уянгын хур та

Сүлдэн тахилгат

Чойрын богд уулсын тэнгэрт

Уянга цацраах ашид наран

Зүрхний тань галын дөл бөхөхгүй

Зүсрэн борооших номын

хур жаргал нэг юм

Алтны өнгө итгэлд сэтгэл шижиртээд

Ариун газарт хөрлөн хунгарлах

талын цас зүмбэрлэнэ

Алсын цэнхэр аяз

дорно тийш харцанд чинь

Авьяас хойморт ухаантаны

Тэнгис давалгаалах мэт

шуугиан хөөсрөнө

Сүлдэн тахилгат

Чойрын богд уулсын тэнгэрт

Уянга цацраах ашид наран та

ДӨМӨГ ДҮҮРЭН

Яруу найрагч Ш.Батнасанд

Далай уянгалан давалгаална

Дагшин эгшиглэнт эгц босоо

Уулсын хяр дээр

манан хонох мэт

зүрх хөлөргөн

Уярал ухаарлын татлагаар

дэлхийг тэнчээлнэ

Аргагүй тунгалаг шүлгүүдээ

Алгандаа нуусан

Атаа хорсол минь...

Гүйж буй хүлгийн зүс гундахгүй

Уйлж буй харцанд нь

нулимс тогтохгүй

Цаг хугацааны эргүүлэгт

улдаж хоцроогүй

Цас, усны гэрэлт аялгуу минь

Бөмбөлзтөл жороолох

морин сэтгэлийг тань

Бүүвэйн дуу мэт үгүйлэхийн учир...

Далай уянгалан давалгаална

Догшин эгшиглэнт эгц босоо

Далай уянгалан давалгаалсаар л...

САРНЫ УЯНГА

Цэцэн тунгалаг Боржигины салхи

агсал морьдын дэлнээс сэнгэнээд

Цөн түрэх алсын цуурай

адуут талын цээжинд

хөндүүрлэн жингэнэнэ

Мөлүү бодлын элэг эмтрэн

бүдэрч тааны цэцгэс уйдан

Мөнгөн өвсний лимбэдэх аялгуунд

амраг булгийн харц тунгалагшина

Голын хөвөөнөө омголон бодлын

торгон тар тоосорч

сувдан утга бөнжигнөнө

Галын илчнээ амгалан

сэтгэлийн бороо цас бидэрлэн

сарны уянга бөмбөрнө

АНИР ЗӨӨЛӨН МӨНГӨН ЗҮҮД

Эгшиглэнт мөрөн уянга урин

хаврын үүр гэгээрэхүй

Эрмэгхэн бодол зүрхэнд баяр

жаргал солонгорно

Сэтгэлийн дэрвэх асарт

дуртгалын наран мандахад

Итгэлийн дэлгэр зүгээс

аялгуут цагаан үүлс нүүнэ

Анир зөөлөн мөнгөн зүүд

марал гудайтал эгшиглэхүй

Айсуй зөн молор совин

манхан халзан замаар эрвэлзэнэ

Гэгээн алсад зорин тэмүүлэх

бодлын цагаан шувуудыг

Гунигийн сүүдэргүй учрал баяр

гэрэлт хязгааргүйд бүүвэйлнэ

УУЛСЫН ОРОЙ ГЭРЭЛТЭЖ

АМТЛАГ ЦАС СОЛОНГОРНО

Уулсын орой гэрэлтэж амтлаг

цас солонгорно

Уймраа хөх бодол галд түлэгдээд

үнс болно

Уяран хайлах сэтгэл

хаврын цас мэт тарлантаад

Ухаангүй тэмүүлсэн амраг

хайр зовлон болно

Алтанхан шаргал намрын навчис

Алаг үүлсийн хөдөө

салхинд хийсээд

Асар дээд замбуулингийн

сэтгэл үймэрнэ

Уулсын орой гэрэлтэж

амтлаг цас солонгорно



Дамбын БАТЦООЖ

Боржигин овогт Дамбын Батцож Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын “Сацын шар хоолой” гэдэг газар 1929 онд төрсөн. МУИС-ийг төгссөн. Дундговь аймгийн

Утга зохиолын нэгдлийг үүсгэн байгуулалцсан анхны гишүүний нэгэн. Говьсүмбэр аймгийн Утга зохиолын салбарын өндөр настан гишүүн. “Түүдгийн дөл” шүлгийн түүвэр 1961 онд Дундговь аймгийн “Улаан туг” сонины газрын хэвлэх үйлдвэрт хэвлэгдэн гарснаар тэрээр 1966 онд “Лимбийн эгшиг”, “Уран зохиолын цоморлиг”, “Сургууль багш нараа дурсахуй”, 2009 онд “Хэлд орж хөл дээрээ боссон нутаг”, “Боржигин хошууны тухай товч түүх” зэрэг бүтээл хэвлүүлжээ.

Ардын боловсролын “Тэргүүний ажилтан”

ИХ БАГА ЦЭГЭЭНИЙ ГОВЬ

Дэлгэрхэн намрын цагтаа

Дэнж толгодоор нь айлууд налайгаад

Дэндүү чиг амгалан нутаг юм уу даа

Миний Цэгээн говь

Талын өнгө нь намартаа дуниартаад

Таанын үнэр нь хамар шахираагаад

Тансагхан ч юм уу даа

Миний Цэгээн говь

Айраг идээ нь амсар дүүрэн бялхаад

Алагхан цэцэг нь эх нутгаа гоёод

Ариухан ч юм уу даа

Миний Цэгээн говь

Дээр хөх тэнгэр нь агарлаад

Дэргэдүүр хөдөө тал нь амраад

Дэндүү чиг уудам юм уу даа

Миний эх орон

Их, бага Цэгээний говь

ОТОРЫН ТАЛ

Малхын их тал

Адуугаар дүүрч хийморлино

Манай нутгийн адуучид

Тэнд л нэг жаргаж өвөлжинө

Оторчин залуус уурга суналзуулж давхилдана

Омголон морьдын туурай

цас манаргаж пижигнэнэ

Хаврыг хүлээсэн хүүхнүүд

Ханцуйн дотроо хоног тоолно

Отороос адуу ирэхийг хүлээж

Амрагийн дуу хүүхнүүд аялна

1977

СЭТГЭЛ ГЭГЭЛЗЭЭД...

Хойд ухаагийн зэрэглээ нь

Хойно хойноосоо бөмбөрнө

Хонгор ээжийн минь сургаал

Холдох тутмаа бодогдоно

Урд толгодын зэрэглээ нь

Униар дундаа жирэлзэнэ

Ухаант ээжий минь хайр

Удах тусмаа санагдана...

Тэрэгтийн талд

ХАРЬД ОЧСОН БЭРИЙН ДУУ

Боржигин хошуу нутагаа саналаа гээд ч яахав дээ

Босоо буурлынхаа зоонд дөрөөлөх л юм чинь дээ би

Борхон зүрхээ догдоллоо гээд ч яахав дээ

Босгуул бэр би чинь болж л яваа юм чинь дээ

Жанжин Чойрын уулаа харах л гэж зүтгэнэ дээ

Жаахан миний сэтгэл харьж л байж амарна даа

Заяа тавилан хоёртоо итгэж л яваа болохоор

Залбирал буян үйлдэх ч гээд яахав дээ

Энэхэн нутгаа алсхан гээд ч яахав дээ

Ээж л аав хоёртоо золгож л байж жаргана даа

Эрхтийн цэнхэр уулаа холхон ч гээд яахав дээ

Энгэрийн нь дулаан өвөлжөөнд хүрээд л очих юм чинь дээ

ХҮСЭЛ

Хүний амьдрал гэдэг

Туйлгүй богино ч гэсэн

Хүн олныхоо төлөө

Хүчээ зориулбал урт юм

1959 он

ҮҮЛЭН ЦЭНХЭР ГОВЬ МИНЬ

Өвгөд дээдсээс бишрэлтэй

Өмнийн цэнхэр говио хө

Өнөө бидний хөгжүүлэх

Өгөөж баян нутгаа хө

Уул нурууд нь сүмбэрлээд

Үзэсгэлэнт баян говио

Учран золгох түмэн нь

Найрсагаар угтдаг говио хө

Хаяа нь үгүй говь

Хараа сунган цэлийгээд

Халтар хүрэн тэмээд нь

Нарны гэрэл гишиглээд

Газар тэнгэрийн савслагаар

Хулан зээр нь дүүлээд

Гадаад их далай ц

алгилж байна уу гэлтэй

Их говийн зэрэглээ

илбэ шидээ гайхуулна

Есөн эрдэнийн баялагтай

Өмнийн их говио

Ерөөлөөр заяасан бидний

Өнийн жаргал нутгаа хө

Буурал түүхийн шаштартай

Буянт баялаг нутгаа

Бурхан гуйсан ч өгөхгүйгээ

Бударганат говийнхон мэднээ хө

х х х

Төрсөн нутгийн барааг

Харах тусам баясана

Төрүүлсэн эхийн хайрыг

Санах тутам яарна

1960

х х х

Хүй олны минь өмөг түшиг

Асар тэнгэр мэт уужим аа

Хүний эхийн хайр сэтгэл

Алтан дэлхий мэт өргөн өө

1960 он

БОРЖИГИН НУТГИЙН УНАГА

Боржигин нутгийн унага нь

Босоо дөрвөн туурайтайдаа

Болох л хүний үр нь

Энэ нутгийн алдрай юу даа

Өндөр бүүрэгтэй эмээл нь

Хүлгийн зоондоо таараа юу даа

Өсөх л багын нутаг минь

Хүүгийн сэтгэлийн уяа юу даа

Малахын их тал нь

Мал сүргийн минь бэлчээрдээ

Манай нутгийн алдар нь

Боржигин вангийн хошуу даа

ЭГШИГ

Шанзны эгшиг сонсохуй

Намуун аяс гуниглана

Шарх авсан зүрх

Шаналж алсран бодлогоширно

Цээжинд гэгэлзсэн ардын дуу

Чимээ тасарсан аргагүй амраг

Дассан сэтгэл хэдий хумигдсан ч

Даамай аялгуунд дахин сэргэнэм

х х х

Ширүүн борооны хур

Цонхны цаана шир ширхийнэ

Шил гэгээвчийн дор

Мөнгөн дусал шит шит гэнэ

Ногоон цэцэрлэгийн мод

Найган найган бөхөлзөнө

Норсон цэцгийн дэлбээ

Ганхан ганхан дохиозоно

Аадар борооны чимээг

Чагнан чагнан байхдаа

Амрагаа мөрөөдсөн хүү

Ширтэн ширтэн сууна

1958 он

БУУРЛЫН СУРГААЛ

Булгийн ус хадны ёроолоос ундарна

Буцаж эргэхгүй урсана

Буурлын үг ханхар цээжнээс урсана

Буцаад эргэхгүй надад шингэнэ

“Хүйтэн шанд”-ын булаг

Хүнийг эрүүлжүүлэх аршаан гэнэ

Хүндэт өвгийн минь ярьсан домог

Хүч өгөх бас нэгэн аршаан

1999 он

БУЛАГ

Асга байцын ёроолоос

Урсч гарсан булаг байна

Аагим зуны халуунд

Хүйтэн байдаг булаг байна

Хурга ишиг ундлуулан

Хоржигнож урссан булаг байна

Хуйвт шилбүүр бариад

Хүүхэд тоглосон булаг байна

1957 он

ЧИ МИНЬ Л БАЯСНА

Нүүдлийн шувууд айлчилж

Уяхан дуугаа ганганана

Гүйдлийн горхи хоржигнож

Гоёхон чимээгээр хосолно

Явсан амраг ирээгүй

Сэтгэлд гуниг төрүүлнэ

Бичсэн захиа хариугүй

Итгэлд төвөг учруулна

Алсаас ирэх чамайг

Би мөрөөдөн сууна

Амдаад золгох цагт

Чи намайг баясгана

Хайр баяр тэгэхэд

Тэнийлгэж оволзоно

Найр хурим маань тэгээд

Гэр дүүрэн түрхэрнэ

1960 он

ЦЭГЭЭН НУУР

Цэгээн нуурын мандал

Тэнгэр тольдон мэлтийнэ

Цэнгэг тунгалаг ус

Бэдэр татан долгиотно

Миний төрсөн нутаг

Цэгээний уудам хөндий

Мянган бээрийн цаанаас

Цэнхэрлэн санагдах сайхнаа

Зулай төөнөсөн халуунд

Сэрүү татан амьсгална

Зүлэг ногоон хөвөөгөөр нь

Мал сүрэг идээшилнэ

Эцэг өвгөдийн алдартай

Их бага Цэгээний нуур

Эрдэнэт нарны гэрэлд

Мөнхий туяагаар гялалзана

1960 он

МӨРӨӨДӨЛ

Энэ оройн тэнгэр дор

Өргөн мөрний эрэг дээр

Цорын ганцаар би зогсоод

Цохлох амрагаа мөрөөдөж байхад

Долгионт мөрний усанд

Сарны туяа тусаж

Дотно янагийн царай

Миний дэргэд гэрэлтэх шиг

Цохилох зүрхний лугшилтыг
Мөрний долгиотой зүйрлэе
Цоргих дурлалынхаа чадлыг
Түүний урсгалтай адилтгая
Хүсэл мөрөөдлийн эцэст
Учрал амьдрал байдаг юм
Сартай үдшийн энэ бодол
Нартай өдрийн жаргал болог

1955 он

ҮДЭШ

Нуурын мөс гялтайж
Сарны гэрэлд туяарна
Тойрмын зах бараалж
Сондуул дэрс сүүдэртэнэ
Суурийн сүрэг налайж
Бууцны үнэр хэнхэлнэ
Айлын гэр цэмцийж
Дэнгийн гэрэл тодорно

1960 он

ХАЙР

Будан дунд хөхөртөх нь
Манай нутгийн уулсаа
Бодол дунд тодрох нь
Магад чиний минь дүр ээ

Унаган хүлгийн хүслийг
Ижил сүрэг нь татах юм
Ууган хайрын дөлийг
Энхрий чи минь булаах юм
Ижилдээ нийлсэн цагтаа
Сарних нь үгүй хүлэг дээ
Үгий нь сонссон хойноо
Хувирах нь үгүй хайр даа

1959 он

АМРАГТАА

Чин зүрхний дурлалаар
Амьдралаа бид холбосон
Гүн сэтгэлийн хайраар
Бие биедээ ижилдсэн
Амраг хайртай чи минь
Гар даллан үдсэн
Алсад суугаа би чинь
Ганц мөч мартаагүй
Үргэлжийн хайр гэдэг
Мөнхийн аршаан юм
Үнэнч дурлал гэдэг
Түүний охь юм



Намсрайн БАТТӨМӨР

МҮЧЗХолбооны гишүүн зохиолч Баатарборжигин овогт Намсрайн Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутаг “Цагаан- уул” гэдэг газар төрсөн. Морин жилтэй. Химибиологийн багш мэргэжилтэй.

МУ-ын Ардын боловсролын “Тэргүүний ажилтан”. “Утгын сүү эгшиглэн” наадмын тэргүүн шагналт.

АКРОСТИХ

Бузгай зугаатай яриа нь

Бусдад хүрэхдээ наран

Асаж, шатаж, дүрэлзэвч

Аргалын шаргал гал шүү, харин

Туурга тусгаар Монголдоо

Тулсан голомт нь Боржигин

Түргэн сэтгэж, хурдан хэлэх нь

Төрөлхөөс заяасан араншин

Өвгөдийнхөө хол ч ухаанд биширмүү

Өвдөг сөхөрч ёсолж хүндэтгэмүү

Мөрөөдөл хүслийн гэгээн бадралыг

Мөр шад холбон бүтээхийг хүсмүү

Өнхрөх биш мөнхрөх тэмцлийн талбарт

Өөд нь хаясан дөрвөн бэрх шиг босмуу

Равжаа хутагтын билэг авьяасанд сүсэглэм үү

Рашааны ундрага шиг ном эрдэмд мөргөм үү

ЖАРАН НАС

Цагийн зайтай орчлонг

Цагаан мөртэй туулаад учирсан

Жаран нас жаргалтай нас

Жамаараа золгосон түшээ нас

“Найгал гол”ыг аяланхан сууж

Нанчидад даврахгүй –намбалаг нас

Нартын өнгийг ухаарч таньсан

Наргианд дэврэхгүй –нуруутай нас

Тавийг үдсэн тавьтартай нас

Далыг угтах босго нас

Гурван үеэ үзсэн гуниггүй нас

Гуч жичээ эрхлүүлэх эрхэм нас

Тэнхлэгт хорвоог дэнслэх нас

Тэвчээр алдаж донслохгүй нас

Дээдэлж өргүүлдэг - өвөө нас, эмээ нас

Тэтгэвэрт гарсан ч тэнхлүүн нас

Жаран нас —наран нас

Жамын аяс —санчигны цас

Гэгээлэг амьдралын хадагтай нас

Гэнэн нь арилсан жудагтай нас

ГСА-ийн УТГ ЗОХИОЛЫН

НЭГДЛИЙНХЭНД

Яруу найргийн Боржигидай

Ингэ ботголох шиг өнжмөл

Яггүй хэдэн шүлэгч нар нь

Хавтгайн буур шиг ормол

Задгай шүлгийн мөрүүд нь

Зүү ороосон маягтай

Залуу хөгшин ялгаагүй

Зуу татах аягтай

Хавар өвлийн улиралд

Савхи нэхий дээлтэй

Халимаг гэзэгээ ургуулбал

Сэтэртэй адуу шиг дэлтэй

“БОРЖИГИДАЙ СЭЦЭН”

цомын өчил

Нялхаасаа авахуулаад

Тунчиг сүрхий даллагатай

Нялгаас гаралтай

Пунцагсүрэнгийнд заллагатай

Бодлогын хэлтсийн түшмэл

Сүхээ даргаас хамааралтай

Боржигидай мэргэний наадам

Сүйхээ дутсан гачлантай

2005

ТЭТГЭВЭРИЙН БАГШИЙН АРАНШИН

Олон зочид айлчилахад

Жагсааж оруулахаар санаархана

Оройн хоолны дараагаар

Дэвтэрээ засмаар үгүйлэгдэнэ

Үдийн мэдээнээс урьтаж

Үзүүлэн хийхээр яарна

Өглөөний цайгаа уучихаад

Цүнхээ шүүрч будилна

Цагийн сэрүүлэг дуугархад

Хичээлийн хонхтой андуурна

Дэлгүүрийн шилэн хоргоноос

Улаан балыг шохоорно

Дэргэдээ зогссон хүүхдийг

Уншуулж үзмээр санагдана

Багийн хуралд суухдаа

Баруун гараа өргөнө

Багачуудын дуулахыг сонсоод

Баярын нулимастай өмөлзөнө

Арван сарын нэгэнд

Ахмадын өргөөнөө яарах

Захирал эрхлэгч нараасаа

Заллага урилга горьдох

Хаврын сар гарахаар

Хонхны баяр зүүдлэх

Есөн сарын нэгэнд

Зүрх дүүрэн баяртай

Ертөнцөд гэгээн мөртэй

Багшийн сэтгэл сургуульдаа

ОЮУТНЫ ГУДАМЖНААС ОЛСОН ШҮЛЭГ

Очих газар дөтөлсөн

Зорчих замын хажууханд

Оюутан охидын цоглог инээд

Орчны чимээг даран цангинав

Охидын инээдийг сонсохуй

Он цагийн уртад элэрсэн

Оюутан ахуйгаа санагалзав

Одтой насаа дурсав

Бор тархины нэгээхэн хэсгээс

Бодол дурсамж амилав аа

Инээд алдаад л сугадан хөтлөлцдөг

Их дотноссон

Ичинхорлоогоо гэнэтхэн үгүйлэв ээ

Магадгүй, охидууд өчигдрийг

дурсамж болгон

Маргаашийг угтахдаа өнөөдрийг

үдэж байгаа нь энэ

Хөөр баясал, хөгжөөн дүүрэн

Хөхүүн баяртай инээж байгаа нь тэр

Хүсэл хясал зэрэгцсэн

Хүний орчлонгийн жамыг

Бүрэн дүүрэн ухаарахгүй байгаа

Бүүр түүрхэн ч төсөөлөхгүй байгаа

Ирээдүйд мөрөөдлөөр хөтөлж

Их л гоёхон дурсамж сэргээсэн

Ийм л цовоо цоглог инээд

Ингэж л цангинаж байгаасай. Инээд..,

2014.02.28.

Молцог зүрхэнд булгилах халуун цус

Морьт минь

Монголоороо бахархах омгорхол

нэмдэг Морьт минь

Наадам хийж, морьдоо уралдуулахад

Өндөлзөн байж тоосонд нь даруулдаг

Морьт минь

Нутгийн сор охид, хөвгүүдээ

сайн явахад

Өмөлзөн байж гийнгоолдог

Морьт минь ээ

Хойморын ухаа болгож шүтмээр

Морьт минь

Хийморийн овоо гэж тахимаар

Морьт минь

Дамдин бурханы зүрхэн тарнийг

сүслэн байж уншъя

Дагшин онгод, судрын авшиг шившиг

гуйж залбиръя

Дандаа наадмын хүлэг,

найргийн ажнайг уралдуулж

Даяар олон Угтуулынхандаа шүтээн нь

байгаарай, Морьт минь

2014.05.03 Говь-Угтаал

ХИЙМОРИЙН УХАА-МОРЬТ МИНЬ

Монгол хүний бахархал

Морины домог хичнээн бэ?

Тодруулагтун

Монгол хүний хийморь

Морины нэртэй газар хэд вэ?

Тоологтун

Төрийн сүлдэндээ морио,

Монгол улс минь залсан

Төрөлх нутгийн толгодоо Морьт гэж

Угтаалынхан минь нэрлэсэн

“Адуун цэг” ээ Адаацаг

“Агтны уул” аа Дарви хэмээсэн

Ардынхаа ухаанд бишрэлтэй

Хөглөгөр Алтайн Хөх морьттой

Хөлгөн түүхийн улбаа ижил

Морьт минь

Хан Хэнтийн Мөнгөн морьттой

Хаа ч дуурсагдах нэр нэг

Морьт минь

Нийслэлийн хоймор -Шарга морьттой

Нийтийн домог нь адилхан

Морьт минь



Бямбадоржийн БАТ-ӨЛЗИЙ

Таван гучид овогт Б.Бат- Өлзий

1967онд Дундговь аймгийн

Мандалговь суманд төрсөн.

Хүүхдийн их эмч мэргэжилтэй.

Эрүүл мэндийн “Тэргүүний
ажилтан”

Өссөн нутгийн минь хүйс

Өвөг дээдсийн минь шүтээн

Өнө эртний түүхийг

Өвөртөө хадгалсан уул

Суугаантын урд дэнж дээр

Суугаа нойрссон баатар

Сумын бяцхан төвийг

Сугандаа хавчуулсан баатар

Хүн бүхний сэтгэлийг

Хүрэн зүрхний орой

Хүүхэд бүхний анх

Хэлд ордог шившээ

Хажуугаар нь явахад

Дагаад байгаа юм шиг

Хажуугаас нь холдоход

Даллаад байгаа юм шиг

Ахуй нутгийн минь

ЧУЛУУН ХААЛГА

Амьдралын минь замын

ЧУЛУУН ЦАЦАЛ.

1990 он. Гурвансайхан сум.

НАМАР

Навчис нарны өнгөтэй шувууд болж

Намайг орхин нисэх цагийг

Намар гэж тэнгэр надад шивнэлээ

Шувууд далавчтай навчис болж

Шулганан ганганан өмнө зүг хийсэхийг

Намар гэж үүлс надад шивнэлээ

Хөөрхөн бүсгүйд учир шалтаггүй

Хөнгөн гуниг төрөх цагийг

Намар гэж ус надад шивнэлээ

2005-11-16

Навч бүхэн мөчрөөсөө

Өөр өөрийнхөөрөө хагацдаг

Намар оройн нэг л өдөр

Өвсөнд, усанд унадаг

Унахдаа ч бас өөрийнхөөрөө

Уйлах нь уйлж инээх нь инээдэг

Зугтах нь зугтаж

хөөгдөх нь хөөгддөг

Зураг тавилангаа л

хэн ч сөрдөггүй

2000-10-05

ХЭРВЭЭ

Хэрвээ сайхан дуу эгшиглэхгүй бол

Нартай өдөрч бүрхэг

Хэрвээ сайхан бүсгүй алхахгүй бол

Зун цаг ч хүйтэн

Хэрвээ хүүхэд инээхгүй бол

Хөгшин хүн шиг санагдана

Хэрвээ хань минь үнсэхгүй бол

Харь хүн шиг санагдана

Хэрвээ сайхан яриа өрнөхгүй бол

Анд нөхөд ч дайсан шиг

Хэрвээ сайн шүлэг уншихгүй бол

Хамгийн тансаг дарс ч амтгүй

2009-2-3

х х х

Ертөнцийн хаа нэгтээ

Яруу найрагч

Ер бусын мөрүүдээ хэлхсэн

Ерийн нэг орой

Ер бусын мөрүүдээс нь

Хундага дарс ханхалж

Ерийн нэг бүсгүйн

Гоо сайхан гэрэлтэнэ

Ер бусын мөрүүдээс нь

Хаврын үдэш чийгтэж

Ерийн нэгэн хосын

Халуун хайр харагдана

1998 Чойр

МЭЛТИЙСЭН ГУНИГ

Намуухан хөгжмийн эгшигэнд

Даруухан бүсгүй бодлогоширч

Хархан нүднийх нь харцанд

Хайрын сэтгэл нь мэлтэгнэх

Дурлал шиг,

дурлалын шүлэг шиг

Дуу шиг, дуулах шиг

Намуухан хөгжим, даруухан

бүсгүй

Намрын шөнө, арван тавны сар

Мэлтийсэн цагаан гуниг

Миний зүрх рүү шагайна

1994-02-24

ГАЗРЫН ДИВААЖИН

Ингэ нь уярахдаа нулимс унагадаг

Ижий минь өрөвдөхдөө дагаад уйлдаг

Ботго нь төрөнгүүтээ бодолд унадаг

Аав минь гайхахдаа

хорвоог эргэцүүлдэг

Хэлгүй хүн – тэмээ

Бөхгүй тэмээ – хүн хоёр

Бие биенээ үүрч өдийг хүрсэн

Би чи дээ хүрч хамт дуулахаа шахсан

Хүн мал хоёр нь амь нэгтэй

Хүүхэд төл хоёр нь тоглоом ижилтэй

Хүслийн шунал зовлонг мэдэхгүй

Газрын диваажин говь мину

1994-01-12

х х х

Өмсөж болдог шүлэг бичихсэн

Ганцхан чамдаа урлах юмсан

Харахад ганган хээнцэр биш

Хачин даруухан, эгэлхэн

Өөр хэн ч урлахгүй

Өөр хэнд ч байхгүй

Үнэ цэнийг нь тогтоох болмжгүй

Үнгэгдэж хуучран хаягдахгүй

Өмсөж болдог шүлэг урлахсан

Ганхан чамайгаа гоёхсон

1991-09-13

х х х

Нүдэнд үл үзэгдэх амьтан

Зүүднээ амилан суниаж

Чихэнд үл сонсогдох

Яруухан аялгуу эгшиглүүлэхэд

Минийүл мэдэх

Анхилхан үнэр тархан

Чиний биеийг, нимгэхээн

Торго мэт ороохуйд

Чи надад үнсүүлсэн мэт

Жаргалтайхан инээвхийлнэ ...

Чи бид хоёр тэврэлдэнхэн

Нам гүмд нойрсоном

Чиний миний мэдэхгүй ертөнц

Бидэн хоёрыг гайханхан...

2012 – 09 - 13

Чихэнд үл сонсогдох

Нүдэнд үл харагдах

Чимээгүй цагаан гэмшлийг

Үл ухаарнам бид

Духаараа тойруу харсан

Нүдээрээ зөөлөн учирласан

Дуугүй цагаан гэмшлийг

Үл ухаарнам бид

Үзэгдэл бүхнийг бид

Гүйцэд үл ухаарнам

Үнэн шударгыг бид

Хараад ч үл танинам

1994-04 сар

Цугларсан уйтгар гэмээр

Шар навчсыг гишгэлэн

Цувныхаа захыг босгон

Намрын гудамжаар алхална

Цухалдсан үгс гэмээр

Жихүүн салхийг сөрөн

Цувраа моддын дундаас

Шүлэг хайх шиг алхална

Ахиад л намар

яасан ч хурдан юм

Хүсээгүй болохоор

тэр биз дээ

Хавар болтол харин удах

байхдаа

Хүлээж байгаа болохоор

тэр биздээ хөөрхий

1994-09-16

Шүлэг уншиж олсон жаргалаа

Ганцхан чамтай хуваалцмаар

Шүлэг мэдэхгүй чамд

Чихэр болгоод өгчихмөөр

Амандаа жаргалтай хүлхэн

Алаг цаасыг нь гартаа имрээд

Амтархан байхыг чинь хараад

Аятайхан нэг шүлэг биччихвэл...

2013 – 08 - 24

Шүлгийн мөрүүдээн хоньчлон хариулж

Өөрөө өөрийгөө дурандана

Шүүгч, үзэгчгүйн жаргал эдэлж

Өөрөө өөртөө алга ташина

Цаана нь гарах төгсгөл үгүй

Бүхий л хорвоогоор аялана

Цаг хугацаанаас ангид

Гав ганцаараа инээмсэглэнэ

2012 - 12 – 29

ЦАГ МӨНХИЙН ТАЛ НУТАГ

Дээгүүр нүүгч үүлс нь

өвгөдийн минь сүнс юм

Доогуур өнгөрөгч

нутгаа эргэн тольдох нь тэр юм

Дэргэдүүр сэвэлзэх салхи нь

тэдний өгүүлэх түүх юм

Дэргэдээс нь үлдэх нутгаа

илбэн таалах нь тэр юм

Хажууд сүмбэрлэх уулс нь

харьж одсон цаг хугацаа юм

Хажуугаар нь урсах биднийг

өрөвдөн хардаг юм

Гүнээс ундрах ус нь

далайн түлхэлт юм

Гүнээд ургах үндэс нь

ширэнгэн ойн навчис юм

Өглөө мандах нар нь

чинад орчлонгийн харц юм

Өглөө бүхэн бидэнд

дурлан ирдэг юм

Үдэш гэрэлтэх сар нь

бишэд ертөнцийн гэгээ юм

Үдэш бүхэн бидэнд

яаранхан ирдэг юм

Домог хөлөлсөн

Буурал боржигины тал нь

Долоон Бурхан одны

алтан сэнтий юм

Тост Боржигины буурал тал нь

Тоост орчлонгийн

мөнхийн өлгий юмаа

2013 – 09 – 20

Чамайгаа санахад

Бодол

Дөнгөж төрсөн хүүхэд шиг

Нялхарна

Чамайгаа санахад

Бодол

Дөнгөж орсон бороо шиг

Чийгтэнэ

Чамайгаа санахад

Бодол

Дөнгөж ногтлуулсан унага шиг

Цовхчино

Чамайгаа санахад

Бодол

Дөнгөж дэлбээлсэн цэцэг шиг

Гэрэлтэнэ

Чамайгаа санахад

Бодол

Дөнгөж орсон цас шиг

Цавцайна

Чамайгаа санахад

Бодол

Ахин ахин нярайлж

Чамдаа дахин дахин дурлана аа

2012. 11. 29

Би шүлэг бичнэ

Атаархах зүйл үгүй болоход

Би шүлэг бичнэ

Анзаарах зүйл элбэг болоход

Би шүлэг бичнэ

Өмчлөх зүйл үгүй болоход

Би шүлэг бичнэ

Өмөлзөх зүйл элбэг болоход

Би шүлэг бичнэ

Сайхан зүйл ховор болоход

Би шүлэг бичнэ

Саар зүйл элбэг болоход

Би шүлэг бичнэ

Хорвоод ирсэнээ үл гайхахад

Би шүлэг бичнэ

Хорвоогоос буцахдаа үл хоргодоход

Би шүлэг бичнэ

2012. 11.17



Батаагийн БАТТУЛГА

Таргад овогт Б.Баттулга 1969 онд Увс аймгийн Наранбулаг сумын “Хар үзүүрийн ихэр” гэдэг газар төрсөн. Багш сэтгүүлч мэргэжилтэй. 1997 онд хайрын шүлгийн “Цагаан уул” 2008 онд “Үлэмжийн чанар яруу найргийн наадмын тусгай байрын шагналтай.

Тэрээр 2003 онд “Урлагийн тэнгэртэй залуу нас” 2007 онд “Аавыгаа аргадсан аялгуу” тайлан тоглолт хийж, 2003 онд “Нар аргамжсан нутаг” яруу найргийн ном хэвлүүлжээ.

Үйлдвэрчний эвлэлийн “Тэргүүний ажилтан”.

ЦЭЭЖНИЙ МОРЬД

Цэлгэр талынхаа салхин сэвшээтэй зэрэглээнд

Цэнхэр тэнгрийнхээ хураар амилсан цэцгэнд

Цэц хурд чадал сорьсон

Цээжний морьд хол тасарчээ

Хуй салхитай уралдсан цээжний морьдын барианд

Хол саахалтын зайтай дараачийн ажнай дөхлөө

Эрдэнийн сайхан биенд нь эрүүл хөлс чийхарч

Эрчит дөрвөн туурайнаас нь замын тоос бослоо

Ээрэм талын цээлэнд толгой хаялан давхиж

Элгэн толгодын энгэрийг нар зөв эргэхэд

Сая, цээжний морьдыг гүйцэж явна

Санаа цэлмэтэл унасан хүүхэд нь гийнгоолж айсуй

Барианы газар морьдын тоосоор дүүрэн

Баранзад хадаг шиг тэнгэрийн дор хурдны тэнгэр уужуу

Барианд ойртохуй аман хүзүү зэрэгцэн айсуй

Баярласан түмний минь наадмын манлай хурдны түрүү эрэгцэж явна,

Бас уралдаж явна,уралцаж явна би

2000-03-04.

АДУУ АЙРАГ ХОЁР

Аясын зөөлөн салхи хацар илбэн сэrvэгнэхүй

Аальхан зантай бүсгүй инээд алдаад тормолздог оо

Агтны шандаст уяа майхан тойроод бараалахуй

Алсаас ирсэн бүсгүй айраг сөгнөөд угтдагаа

Сайхан бүхнээ тээсэн монгол наадмын ширвээнд

Салхитай уралдаж түрүүлсэн хурдны тэнгэр уужуу

Сүргийн манлай азарга уяан дээрээ үүрсэхүй

Саяхан танилцсан бүсгүй харц шидээд холддог оо,

Туурайт хурдан шандсаараа

дэлхийн талыг тойрсон

Туг шиг бадамлаж явсан миний дээдсийн хүлгүүд

Амгалан цагийн тэнгэр дор аясын салхитай уралдаж

Агтны тоостой хөрсөндөө хурдны шандас соригоо

Эр хүн агт хоёр алт шиг хэрэгтэй

Эрхт төр оршихуй эх орон дор хэрэг болох ажгуу.

х х х

Зүрхэн дундуур минь урссан

Нарангийн гол

Зүүдэн дундуур минь үелсэн булгийн эхэн

Зүсээ тольдон гоёсон

Нарангийн боргио

Бүсээ тайлж холдсон охин заяа

ДҮҮМЭДХЭН МИНЬ ЭЭ

Ханилж чадаагүй ч харамлаж явья даа

Харцнаас чинь уяатай явах жаргал юм даа

Босго даваад алхах богинохон шөнийн жаргал

Бодлоо хувааж жаргах залуу насны алдаа юу

Навчис хүртэл уйлах шиг намрын усан бороо

Намайг чамтай учруулсан цэн цэнгийн салхи

Нүүдэл үгүй үүл нь бороо шиврүүлэн арилахад

Нүцгэн толгодын энгэрт жаргалтай байснаа мартахгүй

Хавар хаврын шувууд далавч дэлгэн ганганана

Хадамд очсон чамайг хуурын аялгуутай үдлээ

Хайлган сэтгэлийн чинь найран дээр бодлоо эгшээж суухдаа

Хархан нүдний чинь талимаанд уяатай байснаа мартахгүй

Зүсэр зүсэрхэн бороо дээвэр норгоод өнгөрнө

Зүүдэнд ирсэн шувуу үүрээр нисээд явчихна

Амьдрал хэмээх тулганд залуу нас буцална

Арван хаврын салхи аанай л биднийг элээнэ

Гуныж үзээгүй царайг чинь жингийн цуваа элээнэ

Гутраа нь үгүй сэтгэлийг чинь ардын дуу аргадна

Ангирын гурван нууранд дэгдээхэйгээ дагуулсаар ниснэ

Амьдрал чи бидэн хоёрыг аргадаж байгаа нь энэ

2000- 07- 03



Батцоожийн БАЯРЦЭНГЭЛ

Цоож боржигин овогт Б.Баярцэнгэл 1964 онд Дундговь аймгийн Мандалговь суманд төрсөн. Москвагийн Залуучуудын Хөдөлгөөний дээд сургууль төгссөн. Хэвлэл мэдээллийн “Тэргүүний ажилтан” “Боржигидай сэцэн” наадмын тусгай шагналт.

ЦАГААН ЗАЙ

Түүхийн алтан хүрд өөрийн жамаар эргэнэ

Түүхт өвөг дээдсийн цадиг намтар оршино

Эзэн Богд Чингисийн үр удмын шаштир

Эрхэт Монгол түмний баринтагласан судар

Омог догшин баатруудын он цагийн хэлхээс

Онгод яруу бичээчдийн онч мэргэн сургаал

Очир дарь хувилгаадын их хөлгөн судар

Онголж тахисан бурхадын ариун алтан мутар

Зуун зуунаар хэлхсэн түүхийн алтан товчоонд

Зуурдын үйлийн лайтай цагаан зай үүсчээ

Золигт гарган цаазлахыг цаанаас зурж өгчээ

Зовлон үүрүүлэх зөн совин татжээ

Хилэн хар хөшиг нүдний нь өмнүүр татагдаж

Хүйтэн бууны амыг шилний нь араас тулгаж

Үнэгэн харанхуй шөнөөр үрээ үнсэж ч чадаагүй

Үүд хойморын зайнаас ханиа харж ч амжаагүй

Эрдэм ном төгс эх оронч хөвгүүдийг

Элдэв хэрэгт тулган энд тэндгүй буудав

Зовж үлдсэн бүлийг үр удмаар нь устгаж

Золибон ноходын адилаар жалганд булав

Хийгээгүй хэргийн төлөө хэлмэгдүүлэн гүтгэж

Харийн хууль цааз дор хамж аваад одов

Зуун зуунаар хэлхсэн түүхийн алтан товчоонд

Зуурдын үйлийн лайтай цагаан зай үүсчээ

Найман зууны тэртээгээс түүхээ бичиглэж ирэхдээ ч

Намхан морьдоо унаад дэлхийн дайдад хүрэхдээ ч

Бусдын зааварт оролгүй туган дороо нэгдэж

Буурал дэлхийн талыг захирч явсан бишсэн үү

Бид чинь

2008- 09 - 19

ХҮРЭЭ НОГООН

Гантай халуун улиралд тэнд л зуншлага байдаг

Ганганах шувуудын намраар тэнд л сөлтэй байдаг

Жавар жиндүүлэх өвлөөр тэнд л өнтэй байдаг

Жатга ороолгох хавраар тэнд л нөмөртэй байдаг

Ангир шувуудын чуулал амгалан нууранд жаргадаг

Аниргүй үдшийн сэрүүнд амраг хосууд зугаалдаг

Тургилах адуун чимээнд айлын бүсгүй сэрдэг

Тонгочих унаганы янцгааг гэрийн эзэн зүүдэлдэг

Домог түүхийн нугачаанд

“Хүрээ ногоон” хувираагүй

Долоон бурхан ододтой шөнөжин наадавч уйдаагүй

Эзэн Чингисийн баатрууд үдлээд явсан түүхтэй

Энгүй их талын минь Баян бүрд нутаг аа

2009- 12-9

СЭТГЭЛИЙН ХУР

Гүйгүүл хурдан морь

гүйгээд иржээ сүрэгтээ

Гүн шөнийн түнэрт намайг олжээ хайр минь

Царай царайгаа хараагүй ч харсан мэт танил

Царцанги шөнийн хөшүүнийг гэсгээх мэт бүлээн

Бүлээн тэр орчинд бүгдийг мартаа хоёул

Нар гийсэн өглөө дэлхий баярлан хөөрөх

Нас хэвийснээ мэдэхээр сэтгэл зүрх огших

Хурдан гүйгүүл морьд шиг явж одсон он жилүүд

Хурлаад одсон бороо шиг бидэн хоёрын амьдрал

Шанх задгай гэзэгт чинь буурал сор суужээ

Шанага даахгүй гар минь зүгийг зөв заажээ

Шөнийн одод тэнгэрийн заадаст чуулжээ

Шивнэх үг харин сэтгэлийн хурыг буулгажээ

2005- 03- 12



Дуламсүрэнгийн БАТМЭНД

МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Ду. Батмэнд 1961 онд Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг “Гэээг” гэдэг газар төрсөн. Загвар зохион бүтээгч, дизайнер мэргэжилтэй. “Бурхад завгүй”, “Сүүтэй итгэлд бийрээ дүрж” яруу найргийн ном хэвлүүлжээ. МУ-ын Соёлын “Тэргүүний ажилтан”.

СЭТГЭЛЭЭ АЖМУУ

Сэтгэлээ ихээр цэнгүүлж гоодох тусам

Сэрлийн арсалн дөлөнд гэрэлт омогшил ноцохыг ажмуу

Сэтгэлээ ихээр цэнгүүлж гоодох тусам

Эгшиг танан сүмэн үндэс өөдөө сэтгэхийг ажмуу

Сэтгэлээ ихээр цэнгүүлж гоодох тусам

Төгөлдөр хэвлийд ертөнц ер бусаар сэрэхийг ажмуу

Сэтгэлээ ихээр цэнгүүлж гоодох тусам

Гувай хатан цэцгийн үлэмж мөрөөсөл төрүүлэхийг ажмуу

Сэтгэлээ цэнгүүлж гоодох тусам

Эгэлээс агуужим эхтэйг сэхээрсэн уулга алдалтыг ажмуу

Сэтгэлээ ихээр цэнгүүлж гоодох тусам

Лам шувуу түүчээлж яргуйн зүүд сэмлэхийг ажмуу

Сэтгэлээ ихээр цэнгүүлж гоодох тусам

Эгшиглэнт янжилхамын авшиг гүр цэнгэл эдлүүлэхийг ажмуу

Сэтгэлээ ихээр цэнгүүлж гоодох тусам

Эл гүнгэрваанд ямархан тунгалаг ай цогцолдогийг ажмуу

2014.05.31.

ОРЧЛОН ХАЧИН ИХ ЧИМЭЭ

Арга билиг амин аргамж

Алаг заяа алтан хоргомж

Оноо алдаа хувьсал суудал

Он цагийн буурал буудал

Орчлон хаан их чимээ

Орог үүлс, манан будан

Одон мичид биелгээ долгис

Охин сарны гэгээн тэшил

Онгод цалигийн задгай асгал

Орчлон хатан их чимээ

Өвс ногоо хагдрах ургах

Өтгөс нялхас буцах ирэх

Сэрэмж алдрам бодь сэтгэл

Сэрэхүйн чанад дотоод аялгуу

Орчлон хачин их чимээ...,

ТОЛЬ

Тал засахгүй

Тал харагдуулахгүй

Тун тогтмол

Тунгалаг гадаргуу

Цэмцгэр эр ч бай

Цэлхэгэр эм ч бай

Баян ч бай

Бэлгүй ч бай

Би бол би

Чи бол чи

Чин үнэн

Чигч шударга

Ямар харагдана

Яг тийм

Ян хатуу..,

Инээхэд чинь инээж

Уурлахад чинь урагдахгүй

Ийм л байна даа..,

2014.06.21.

САРНЫ ЕРТӨНЦӨД

Сайхан юм аа

Сарны ертөнцөд

Саатан морилоод ирлээ

Санаа бодол гэрлээр цэлмээд ирлээ

Сайхан юм аа

Даруухан юм, сарны шүлэгчид

Дарс тулгаж үзлээ

Амсах л төдий юм

Агсрал биш

Шүлэг нь уясал юм

Зөөлөн мэдрэмж, гэгээрэл юм

Гэгээн тунгалаг ертөнц тэнд байна

Гэрлийн хэлээр ярих юм

Садан төрөл шиг дотно юм

Сарны сонет намуухан эгшиглэх юм

Санаа бодол амирлангуй диваажин юм

Халдах дайсан, булаалдах шунал алга

Хараал зүхэл, гуйлга зовлон алга

Шүлэгчид нь гэрлээр амьсгалах юм

Гэрлэн биетэй ертөнц юм

Гэгээн сэрэлтэй ертөнц юм..,

ГЭГЭЭН СЭРЛИЙН МЭДРЭХҮЙ

1.

Үес үесхэн сэтгэл гэгэлзэхэд

Үзэж туучсан замаа сэхээрч

Үлэмж нандинг дээжлэн дурсмаараа

Өнгө зохирол сэтгэлээс гэгээ цацраан

Өөрийгөө тоон гоодож, сар асгартал

Өөнтөгч нэгний сэтгэл рүү өнгийж үзмээрээ

2.

Хааяа хааяахан итгэл алдрахад

Хатуу зөөлөнг сөргүүлж билүүдмээрээ

Ховорхон заяаны алаг төөрөгт эвлэрч

Халуун зэмлэлд шартаж тархиа гашилгаад

Хожуу ухааралд хатсан өрөө зөөллөж

Хайрлах сэтгэлээр өөрийгөө аргадмаараа

3.

Гэнэ гэнэхэн бодол зангирахад

Гэгээн зүгийн цагаан салхиар

Гунигаа аргадан арчиж алхмаараа

Гэрэл сүүдэр ханьсах орон зайд

Гэм зэм ноёлож халдамгүй

Гэгээн сэрлийн мэдрэхүйд уусаж ариусмаараа

2009.08.13

СУГАРЧ ҮЛДЭХ ГУНИГ

Гунигт ээрэгдэн алхахуйяа

Гутлын уланд гишгэгдэх

Ганц нэг чулуу булгиж ёврох нь

Гашуун бодлын хаялага мэт ээ

Гэгэлгэн бодлоо сэмлэн үлээхүйеэ

Гэгээн сайхныг хүлхэж алхаагаа ширүүсгэхэд

Гүйгүүл салхин хажуугаар гуниг сугалж одох нь

Гэгээн хүслийн цацлага мэтээ

Гэрэлтэнтосох харгуй цэлийхүйеэ

Гэм зэмээр боолчлох гэж юунд ээрнэв ээ

Ганц хором ч үнэтэй байнаа

Голт зүрхэнд зай алгаа

Гүйж чамаас холдье доо

Гуниг чи замаа боддоо

НАДААС АНГИД ЮМ ҮГҮЙ

Шим дагшин учрал хөвөрнө

Шүүдэр ариун уянга хөвнө

Шүлэг торгон ухаарал хөглөнө

Шүтээн хөлгөн урсгал хөтлөнө

Насны чагтага ашид хийморьлог

Лагшин тунгалаг өнөд гэгээлэг

Нарны ийм илч гэрэлтэйд

Надаас ангид юм үгүй

Сансрын хүрдэн чөлөөгүй орчино

Санаа цайлах залбирал оршооно

Сувдан сондор бодол ончирно

Сул асгарах цалиг оргилно

Сэтгэлийн диваажин аниргүйд сүлдлэг

Сэрэхүйн нээлхий чанад сүнслэг

Сарны ийм өнгөлөг ахуйд

Санаанаас ангид юм үгүй

Цаг хугацаа намайг гээтэл

Надаас ангид юм ер үгүй

2010.04.26.

ХАЧИН ЮМ ШҮҮ

Хачин юм шүү..,

Хааяа ингэж бодогдох

Хал, бал, харш хундага тулгаад

Хэн нэгнийг алсуур

Хайрлах, үзэх ядах хоёр

Халуун зүрхэнд минь

Халз тулаан хийнэ

Алинд нь хүлцэхээ мэдэхгүй

Ацан шалаанд унаж мэгдэх

Цоожны нүхээр шагайж

Цоо ширтэх тэр харц..,

Цочих анираа залгиж

Цаанаа нууцлагыг онгичих

Ардаа нүдгүй дүлий чих

Миний зүрх рүү нэг өнгийж

Мэгдээг минь ангуучлаасай гэж

Хааяа ингэж бодогдох

Хачин юм шүү..,

СЭРЭХҮЙН ХҮРД

Бурхан мэлмийт билиг оюуны шимээс

Бусдад хүртээж яваг хэмээн

Ханш эртийн болор дусал сэржимдэж

Хаан дагшин хураар онгодын зөн шивэрнэ

Гоо даль цэцэглэх сэтгэмжит нялх сэрэхүй

Илбийн чөлөөнд хөлбөрөг хэмээн

Гүн амгаланд сэтгэл ураглахыг мөрөөсөн

Гүнж төгөлдөр өнгөөр амраг зөн шивнэнэ

Ялмын модны навчис зулгарах анираас

Ямхын төдий сэдэл аваг хэмээн

Инагш чинагшлахуйн мөнгөн зөрөгт хажваас

Ирвэгнэх долгисоор шигшрэг зөн шилбэлзэнэ

Хар цагаан дөрөө харшихын зүйр эсгэж

Цаглашгүйн цавагт хүлхэг хэмээн

Цалин гилбэлгээ санчиганд зөөж

Хаш хялмаагаар насны зөн шилгээнэ

Сэнтий хутагт хүмүүн үлэмж тунгалагт оршихуй

Сэлгэмж гэгээн хүрд үргэлж тунамалд орчихуй

БУРХАД ЧИМЭЭЛЭХҮЙ

Цаглашгүйн орны бодь чанар

Цалиг дэврээх цахим эрчис

Бодлын зэлэнд хэлбэргүй бүжих

Өнгийн өдөн чуулбарыг үргээнэ

Чимэгт арвис аялгуу тодоостод

Чихнээ бус зүрхэнд асгарна

Бишид холын бичил чимээ

Билиг хөглөх торгон анир

Сонгодог зүгээс бурхад чимээлэхүй,,,

Сунтаг аравнайт анир хөгсөнө

Сэтгэлийн зэлэнд хүлэг үүрсэхүй

Тэнгэрлэг найрагч түүнийг хэлмэрчилнэ

СҮҮТЭЙ ИТГЭЛД БИЙРЭЭ ДҮРЖ...

1

Газар тамгалж үлдээх хос мөр он цагийнх

Ганц олдсон хувь заяаны хэмжээс бурхных

Гал цустай аагаар бууриа шийрлэж

Оюун билгийн хязгааргүйд талбих

Орон зайд өөрийн эзэгнэлээ тэлнэ

Гэрэл сүүдрийн дайр юу ч байсан

Гарцаагүй гэтлээд л өнгөрнөм за

Цаглашгүй жамын өтлөөх занганд

Нитгэрч гээгдэх ганц навч байг хамаагүй

Цадиг хутагын алинд ч бай

Жаргахын бөөн хүсэл байнаа

2

Хувь багадаж хүсэл ахадмаар

Хуульгүй төөргийн нажидтай ханьсаж

Хийж бүтээхийн бурхан хүрдэнд бүжихдээ

Атаа тэнгэрийн чимх тээг

Алинд ч ончрохгүй , хойшоо бай

Заамны товчоо тасартал задгай омгорхлоор

Замд хөндөлсөх задын чулууг бутартал

Зад туучаад өнгөрнөм за

Замлин таны дансанд амь бөх цагт

Залгих цаг хугацааны эрлэг дор гунихгүй ээ

3

Өсгөлүүн хүслийн зараалд тэмүүлэхдээ

Өөрийгөө өөш хаяж эрлэгийн ам тослохгүй

Од зурж хувьстал хэн барыдах юм бэ?

Онгодын цалгих их хуйлшрал орчоож

Он цагийн эзэгнэлээ оршоож чаднам за

Ямба чухаг сүрээ диваажинд залрааж

Ялгуун сүлд минь хожид бадамлахад

Яруу найрагч сүнс дахин нярайлтал

Сүүтэй итгэлд бийрээ дүрж туурвисаар

Сүн шүлгээ зүйж шинэ өлгий зэхнэм зэ,

ЦАГ ХУГАЦАА

Агшинг зурах мөнгөн зэрэглээнд

Алдааг чимэх дурсамжаа зүүнэм

Цэцгэсийн бодлоор гэгээг тэмтэрч

Цаг хугацаа дуусчихвий гэхээс яарнам

Цааш сураггүй алдрахаас амжиж

Цаг хугацааны үнсэлтэнд зорогоороо эрхлэж

Цаасан дээр үсгийн тиг битүү өрж

Цагаан өнгийг цоохор болгон утга сийльюу

НАМАР БҮХЭН ГУНИГ БИШ

Аяа. Намар бүхэн хөнгөн гуниг биш юм

Ай , Хайр ихэрлэх, найр дэгжээх уянга юм

Зэгс алтрах салхин зөн юм

Зэл алсрах шувууд зүг юм

Сарних бодлын үймээн навчис юм

Санаандгуй санаа алдалт тайвшрал юм

Духанд дааварлах хөлс нулимс биш

Дутуу ухаарал харин хожмын гэмшил

Нарны эрчис гогцоорч сүүн сөлөө

Наргил моддод юүлэх ижий хишиг

Дурлах тусам шүлэг минь яруусах

Дурдан намрын өдрүүд дэндүү өглөг

Наадмын морьдын тэнгэр зурах тоос

Наранд солонгорох босоо уран татлага

Аяа, намар бүхэн хөнгөн гуниг биш юм

Ай, найраг сүлэх, айраг бүлэх чимээ юм

2011.10.21.

ҮЙЛТЭЙ ХОРВОО

Хүн хүнээ түшиж жаргана

Хүсэл хясалаар хэмлэж тамлана

Хүн хүнээ бараадаж амьсана

Хүн хүнээсээ дөлж айлсана

Өглөг сэтгэлтэн бурхны тиг дотор

Өөрийгөө бусдын төлөө золино

Хэнэггүй нэгэн цагийн салхинд

Хэрмэл хамхуул шиг зүгээ алдана

Зальжин нь инээж байгаад

Үнэнийг олох завдалгүй залгиж орхино

Зусарч нь зугаа элээж

Зуйраад зуларч одно

Хүмүүс хайр түгээж амьдарна

Хүмүүс гай тарьж адарна

Үйлтэй нажтай хорвоод

Гэрэл сүүдэр сүлэлдэнэ...



Сосорын АМАРБАТ

Сугир овогт Сосорын Амарбат 1952- оны 2- сарын 12 нд Өмнөговь аймгийн Номгон сумын 3- р багт “Цонжийн бууц” гэдэг газар төрсөн. Малын их эмч мэргэжилтэй. Хөдөө аж ахуйн “Тэргүүний ажилтан”

БОРЖИГИН НУТГИЙН МАГТААЛ

Зээ

Бодончор ахаас өвлөж ирсэн

Боржигин нутгаа магтая хө

Чингэс хаанаас уламжилж ирсэн

Цэцэн вангийн уугуул нутаг юм хө

Хэнтий ханы онго шүтлэгт

Хэрлэн Тоонын овоо эндурт

Долоон болдог-ийн мөнх харуулт

Дайчин эрсийн өлгий нутаг юм

Хүннү сүннүгийн цаад үеэс

Хөх монголын төв нутаг юм

Хамаг монголын удам гарвалт

Ханлиг угсаатны нутаг юм хө

Бурхан хулдуунаас холгүй юм

Буурал Хэрлэнгээс урдхан юм

Баян эрхтийгээс тодхон юм

Оцол Сансар нь алдартай юм

Төв халхад нутагтай юм

Тэв дэлхийд алдартай юм

Төмөр замаар холбоотой юм

Төгс төгөлдөр харилцаатай юм

Баругшин замаар давхидаг байна

Баруун зүүнгүй хүрдэг байна

Агаараас буух талбайтай юм

Арддаа нүүх нутагтай юм

Модун шаньюу гаас эхтэй юм

Монгол заншил хадгалаастай юм

Морин дэл дээр өсдөг байна

Мохошгүй зоригтны орон юм

Бөө мөргөл заншилтай юм

Баглааш, сэргэ шүтлэгтэй юм

Боловсрол гэгээрлийн төвтэй юм

Боржигин наадмын дэгтэй юм

Зээр хуйларсан талтай юм

Зэрэглээ татсан говьтой юм

Зэрэгцээ босоо уулстай юм

Зэрлэг ангийн нутагтай юм

Тэрэгт, Малахын тал уудам юм

Тэмээн жингийн шар замтай юм

Түрэг, Хиргисийн хөшөөтэй юм

Түмэн үеийн түүхтэй юм

Гурван Сүмбэртээ шидтэй юм

Дөрвөн Баяндаа эрдэнэстэй юм

Говь тал хосолсон юм

Галав эртийн тогтоцтой юм

Цавчил өндөр уулстай юм

Цастын орноос гэгээрэлтэй юм

Цанид, Чойрын номтой юм

Цагаан дарь эхийн шүтээнтэй юм

Богино хөлт адуутай юм

Боржигин угшил нь хурдтай юм

Мөнгөлөг Сүмбэр хоньтой юм

Мөрөөдөл хүслийн өнтэй юм

Аглаг уудам нутагтай юм

Арвин баялаг эрдэнэстэй юм

Ард олон нь жаргалтай юм

Ашид мөнхийн бэлгэтэй юм

Зээ

Оцол Сансарын оройгоос

Өлзийт толгойн өврөөс

Өнөөгийн боржигин нутгийн

Өөдлөх ирээдүйг харваас

Хуучин ёсны өв уламжлалаар

Хошуу нутаг нь тэлэх юм

Хүрээ суурин нь хөгжих юм

Хүний төлөө нийгэм байх юм

Цахим мэдээ, эрдэм оюунаар

Цаг хугацааг товчлон

Эрчим мэдээлэл худалдаж

Эрэн зуундаа алдар түгэх юм

Цаасан мөнгө алт гэлтгүй

Цанид Чойрын ухаанд нэвтэрч

Наран саран шингэхгүй

Найман зүгтээ алдарших юм

Хуурай замын уулзвар

Хурдат онгоцны буудал

Хүчит тэрэгний зогсоол

Худалдаа арилжааны төв болох юм

Билэг чанар гэгээрэлд хүрч

Бүтэх, эвдрэх шүтэн барилдсаар

Боржигин Сүмбэр тэргүүлсээр

Бүх монголын гэгээн Сүмбэр юм

Оцол Сансар өөдөө өөдөө

Онгод хийморь дээшээ дээшээ

Олон амьтан жаргаг жаргаг

Хурай хурай хурай хурай

Ум а ма ри ва ти суха,

Ум нама ши ва яа

2005 он



Балдангийн ТУУЛ

1964-2010

Жолоо овогт Балдан Туул 1964 онд Дорноговь аймгийн Замын –Үүд суманд төрсөн. Мал зүйч мэргэжилтэй. Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн гишүүн байсан. “Боржигидай сэцэн”, “Эрдмийн цагаан лавай”, “Нутгийн аялгуу” зэрэг найргийн наадмуудад оролцож тусгай шагнал хүртэж байсан авьяаслаг найрагч эмэгтэй байв.

БИ ЭМЭЭ

Төрүүлж өсгөсөн

Торомгор үрс минь

Тулгын гурван чулуу шиг

Та гурвыгаа л гэж

Зүрхэндээ байнга санагалзаж

Зүүдлэн сэрэх бүхийдээ

Бодоогүй санаагүй өдөр гэж

Богино амьдралын минь энэ мөчид

Бодлоос салсан өдөр гэж үгүй

Цагийн жамаар

Та гурав минь

Тэвэрт минь дүүрэн

Том эрчүүл болцгоож

Ээж нь ч гэсэн

Эргэж буй насны жамаар

Нас намба суусан

Намбалаг эмээ болсоон

Хайр шингэсэн бүүвэйн дуугаар

Хайртай ачаа өсгөж бойжуулсан

Халуун үнэт сургаалтай

Хачирхах юмгүй би эмээ

Эцэг эхийн залгамж удмыг үлдээ битгий тасал

Эд хөрөнгө зохистой үлдээ хэрэггүйг бүү цуглуул

Эргэж төрөхгүй ч нэр алдар үр удам чинь бий

Энэ ганцдаа эргэж бүү хоргод буяныг бод

Бурхан бодьсатваа туслахгүй ч өглөг буяныг хичээ

Бумбатай рашаан амьдруулахгүй ч түүнийг хичээ

Буруу үйлийг тэвч бодь сэтгэлийг барь

Буурал хорвоогийн жамаас бултахгүй зуу наслахыг бод

УХААРАЛ

Энхэл донхолтой орчлонд

Ижий минь ижий минь

Эвийлж энхрийлсэн

Их хайрыг чинь яахин мартах

Урлагийн тэнгэр Янжинлхам

Ухаарч амжаагүй сэтгэлд минь

Ухаарлын эгшиг хангинуулсан

Ухаант дарь эх минь та сонсоо

Хан хорвоод мөнх бусыг үзэхэд

Хөлөө хучуулах үртэй хүн юм би

Ханат гэрийн минь голомтыг залгах

Хорвоод би удамтай хүн юм

ТӨРСӨН НУТАГ

Дуудах нэр

Дуурсах алдрын эхлэл

Бахархах хувьтай

Элэнц хуланцын минь өлгий

Эцэг дээдсийн минь нутаг

Эрэмгий зоригт

Эх оронч хөвгүүдийн

Өсч өндийсөн

Өгөөмөр баян нутаг аа

Би таныг

Бодь сэтгэлдээ сүслэн

Цайныхаа дээжийг өргөж

Цагийн саалтыг туулдаг аа

Төрсөн нутаг минь

Төгөлдөр их хайр минь



Лувсаншаравын СОДНОМДОРЖ

МЗЭ-ийн гишүүн Хөвсгөл аймгийн Галт сумын “Тэмээн хүзүүвч” гэдэг газар 1948 онд төрсөн. МУИС- ийн Монгол хэлний ангийг төгссөн. Москвад Комсомолын дээд сургуулийн дээд курсыг тус тус дүүргэсэн. “Нутгийн минь нэр Айраг”, “Шүлгэн шившлэг”, “Боржигин уянга”, “Аравнайн эгшиг” зэрэг утга зохиолын бүтээлүүд хэвлүүлсэн. “Цэнхэр Боржигин”, “Нарны заллагатай Айраг” уран бүтээлийн тайлан тоглолтуудаа хийжээ.

“Үлэмжийн чанар” тэргүүн байр 2008 он, “Алтан бийр” яруу найргийн наадмын дэд байрны шагналт. “Ард түмний гавьяат” цолтой, МУ-ын Соёлын “Тэргүүний ажилтан”, МУ-н Ардын боловсролын “Тэргүүний ажилтан”, “Утга зохиолын төлөө” хүндэт шагнал 2011 он

ЧОЙРЫН БОГД УУЛ

Чойрын богд уул

Үүлэн дунд халамцана

Чойрын номын

Ид шидэнд уярч

Чоно хүртэл халирна

Буяны туульс урсгасан

Бурхан ухаантай өвгөдийн

Алдрыг зарлан

Алтан салхиар

Аргадуулан дүнхийнэ

Агуу юм чинь

Багаас эхэлдэг

Бага юм чинь том болдог

Чойрын богд уул

Хайрын богд уул

Хайрын богд уул

Чойрын богд уул

2010-05-15 Чойрын уулнаа

САНСАР УУЛЫН САЛХИ

Сансар уулын салхи

Сар нарны даллагатай

Саатан тухлах ахуйд

Сайн явахын заллагатай

Сансар уулын салхи

Сайны ерөөлийн элчтэй

Хамаг бүхнийг ариулсан

Хацар шүргэх чимэгтэй

Сансар уулын салхи

Өнгө өнгийн хөгтэй

Санаанд онгод хуруулсан

Өвөрмөц нэгэн аястай

Сансар уулын салхи

Амьсгал сэлбэж хурдална

Сайхан шүлэг бодолж

Аялгуу найрагт хурцална

2010-02-11

ЦЭНХЭР БОРЖИГИН

Үелээ мянган толгод зэрэглээнд сүүмэлзэн нуугдах

Үүлэн хөх тэнгэр хураа тэтгэж газрын үндэс дээшлэх

Атан тэмээний буйлааныг салхи илбэн эгшиг цацлаах

Ардын дууны шуранхайгаар аргадуулан уярах

Цээж дүүрэн цэвэр агаар цалгиасан

Цэнхэр боржигин- миний нутаг

Өнгийн чулуу бүхэн нь аялгуу найрагт тээж амилсан

Өндөр өвөг дээдэс нь домог хуучлан жаргаасан

Уртын дууны аялгуу нь нар саатуулан аргамжсан

Уужим талынхаа цараандаа цэнхэр уянгатай боржигин минь

Цэнхэр униар хөшиглөсөн их талыг харахуйд

Цээжинд шүлэг ховсдон ирж урсах

Аялгуу найргийн мөр бүхэнд жигдэрч

Агсам цэнхэр хүлэг шүлэг дэрвээн нисгэх

Хүн бүхний жаргалын өлгий

Хүслийн цэнхэр Боржигин мину

Намтар түүхээ улбаалсан өндөр дээд жаягтай

Найр найрнаас уламжилсан агуу их дэгтэй

Боржигин уртын дуу нь газар түгэн т энгэрт цацагдах

Болоогүй удсан найр нь өдөр хугаслан жигдрэх

Цэлмэг агаарт хуурын эгшиг түгж

Цэцэн билэгт түмний сонорыг мялаана

Дуучин Зэвгээгийн уянгат хоолой шиг

Дууны түрлэгт цацагдан уран зэрэглээнд уусна

Хуурын татлага бүхэн нь хөх талаа сэргээсэн

Хурдан морины гийнгоо их талаа тайтгаруулсан

Уугаад дундрашгүй айраг их талын минь заяа

Уралдуулаад баршгүй хүлгүүд энэ боржигины хаяа

Боржигин хийцтэй эмээлээ доргитол янцгаах

Босоо дэлтэй хүлгүүдийн хийморь лундаа тэгш

Намрын дунд сарын арван долооын өдөр шиг

Найр жигдрэх үед авьяасын тэнгэр задгай

Цэц билиг тэгширсэн буянт ухаант түмэнтэй

Цэвэр Монголоо уламжилсан домогт удмын боржигиндоо

Цэцэг амилсан талаасаа шүлэг шүүрэн босохуй

Цэнхэр боржигин чамайгаа юугаар ч би солихгүй

Энгүүн жаргал тэгширсэн нутагт минь өштөн халдах гэвэл

Эгэлхэн биеэрээ дэнчин тавьж газар шороондоо уусна

БОРЖИГИНЫ БОР ТОЛГОД

Хуйлрах салхи оргилыг нь аргадан

Арван гурав эргэнэ

Хурдан удмын унага даага янцгааж

Дуугаар нь толгод хөглөгдөнө

Дээрээс нь нар аргадаж илчээ шингээн ээнэ

Доороос нь таана хэнзэлж эгэл толгодоо чимнэ

Танан цагаан чулууд наранд гялтаганах нь

Талын толгодын нэрийг тэр л холоос дуурсгана

Буй орчинд нь хөх зэрэглээ мяралзах нь

Бор толгой минь цэнхэр өнгөөр газар хучина

Шиврээ зөөлөн бороонд толгод дэвтэн баясна

Шинэхэн татсан солонгонд

Толгод уясан долоон өнгөнд уусна

Их талын минь сүр буяны заяаны үр

Ээрэм талыг минь тайтгаруулах

Боржигины бор толгод

НУТГИЙН БОР ӨВГӨД

Жаргал хайрласан

нутгийнхаа агаар амьсгалж

Жаргаж яваа нутгийн бор өвгөд

Зуусан ганс, зүүсэн хутга нь сүрлэг

Барьсан хөөрөг, ярьсан яриа нь найраг

Хурдан морьдоо ярихад нь магнай нь тэнийдэг

Хултай айргаа уухлаар сэтгэл нь хөглөгддөг

Буянт малаа сүлдлэн дээдэлж

Бурханаасаа өөрцгүй шүтэн биширдэг

Алсын бараа харсаар нүдний нь хараа холч

Амьдрал туулсан гэгээн ухаан нь голч

Нөмөр нөөлөг буян заяатай

Нутгийн минь бор өвгөд

Уртын дуугаар дуугаа хийсэн

Унасан мориороо хийморио сэргээсэн

Ерөөлийн үгээр бэлгээ болгож

Өрөөл бусдад сургаал хайрласан

Харахад тэрлэгэн дээлтэй ачтангууд

Хайрлахад тэмдгээ зүүгээгүй алдартангууд

Уншъя гэвэл амьдралын ухаан мэдрэгдэх

Уудалъя гэвэл агуу их жаяг нь мөнхлөгдөх

Далай олны халуун хайраар хүлүүлсэн юм шиг

Даруу гэхэд дэндүү даруу

Найраг амилуулж айраг амтлуулсан

Нутгийн минь хэдэн морь өвгөд минь

МЯДАГМААТАЙ НААДАМ

Нар сарны хослол шаргал өнгөөр туяарч

Найман шаргал агт наадам зарлан үүрсч

Цагаан эрээний хослолоор наадмын гоёл тодорч

Царайлаг бүсгүйчүүдийн дотроос

Мядагмаа минь туяарч

Мядагмаатай наадмыг

Мартаж яахан чадах вэ

Эрээн ланзан асрын өмнүүр хослон холхиж

Эр эм хоёрын хос бөгж шүргэлцэж

Холоо газраас ирсэн бидэн хоёр
Хос мөнгөн бөгжөө гоёж нэг жаргав
Сул асгасан гэзэг тахим даван урсч
Сувдан сайхан даруулга нь гоёл болон сацарч
Гоёж ирсэн бүсгүйчүүдийн дотроос
Гойд сайхан нь Мядагмаа минь байлаа
Сонин содон бүхнийг гэгээн сонороороо мялааж
Соёолон морьдын тоосонд хийморио нэг сэргэж
Алаг цэцгэн дэнж дээр хосоороо суун жаргаж
Амьдын хором агшнаа төрийн наадмаа мялаалаа
Цээлхэн сайхан засуулчдын хоолойн цараа эгшиглэхүй
Цэцэг хүртэл амьсан дэлбээ юугаа нээлээ
Цэцэн билэгт мэргэдийнхээ цэц оюуны уухайд
Цэнгэн инээн баясч уухайн түрлэг өргөлцлөө
Засуулаа ханаруулсан бөхчүүдийн хүч мэхэнд биширч
Захыг нь мушгих дээлийг нь өмнөө тавин суухуй
Улаан хүрэн өмсгөлтэй аймгийн заан залуу
Удаж төдөлгүй давчхаад
төрийнхөө туганд адислалаа
Нутаг нутгийн бүсгүйчүүд дотроос
Түмнээс хөөрхөн нь Мядагмаа байлаа
Мянга түмэн хүмүүс чуулсан
Мядагмаатай наадам сайхан боллоо

ХАНИА ХАЙРЛА ЭРЧҮҮДЭЭ

Ингэний буйлаанд хөхний нь сүү элбэгших

Ижий заяатай гэгээн сэтгэлтэй

Амьдралд алдахад сэтгэлээ ивж түшдэг

Арай дорой уруу явбал үсний нь буурал нэмэгддэг

Тогоотой сүүнд сэтгэл нь цуг буцалдаг

Тоонот гэрийнхээ галыг мандаахдаа итгэл нь өөдөө бадардаг

Гэр амьтай эм заяатай

Гэргийгээ хайрлацгаа эрчүүдээ

Оройтож ирэхэд халуун хоолыг нь хөргөчих вий гэж зовнидог

Орчлонд ганцхан эрчүүдээ бурханчлан шүтдэг

Хааяа нэг халамцуу очвол яамайдаа гэж бэлэгшээдэг

Ханийн тэнгэр миний нөхөр гэж сэтгэлдээ баринтагладаг

Ажил нь ихэдсэн ч ахуйгаа өөд нь татах гэж мэрийдэг

Амраг нөхрөө хол явсан ч дээжийг нь тавин ерөөдөг

Дотоод сэтгэл нь сүүгээр оргилсон

Гадаад төрхөнд нь хайр гэрэлтсэн

Хаанаас ч ирээд олдохгүй

Ханиа хайрла эрчүүдээ

Гунхсан сайхан бие нь яван явсаар та нарын төлөө бөхийлөө

Гурваар сүлжсэн гэзгийг нь насны намрын хяруу уналаа

Алт мөнгө зүүдэг хуруунууд нь амьдралын нугачаанд элэгдлээ

Алаг сайхан нүдний нь цог дөл буурлаа

Ээ хэний төлөө ингэвээ

Эрчүүд та нарын төлөө

Хүүхдээ бүүвэйлж өсгөсөн бүүвэйн дуу нь сааралтлаа

Хүний орчлонгийн жамаар буурал хорвоог элээж явна

Халамж тавь эрчүүдээ

Ханиа хайрла эрчүүдээ

Нас нь залуу ч залуугаас нь хайрла

Намба суусан нас тогтсон ч сэтгэлээ өгч хайрла

Хичээл нас руу явж байвал бүр илүү хайрла

Хэний ч ялгалгүй та нарын хань шүү дээ

Цайны давс нь дутуу бол сайхан гэж урам өг

Царай дарсан уруу бол хөөрхөн гэж нэг үнэрлэж үнс

Ядарч зүдэрсэн харагдвал амардаа гэж сэтгэлээ өг

Яруу найргийн охин тэнгэр

Янжинлхам бурхан шиг тахин шүт

Халамж тавь эрчүүдээ

Ханийгаа хайрлацгаа эрхэмүүдээ

2008-11 - cap



Уяатын БАЯРМАА

Уяатын Баярмаа нь 1972 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. Боловсрол дээд. “Боржигидай сэцэн” наадмын Тэргүүн шагналт, “Боржигидай сэцэн” наадмын гутгаар байрны шагналт.

ХУНДАГА ДАРС ӨРГӨӨ

Нойр хугаслан сэрээсний чинь төлөө

Надад ирэхдээ цуваа тайлдгийн чинь төлөө

Сэрэхэд хамтдаа байдаггүйн чинь төлөө

Сэтгэлээс ангид амьдардгийн чинь төлөө

Магадгүй

Надад ирчихээд дуу аялахгүй бол яах юм

Аяархан сэрээж нүдэн дээр минь үнсвэл яах юм

Сэтгэл дотор суудлаа засчихаад

Түүндээ очихгүй бол яах юм

Эрхэмсэг бардам

Их зантайг минь мэдчихвэл яах юм

Өргөсөн дарсаа

Өлмийд чинь дусаая

Өөрийн тань өмнө

Далай болог

Хундага дарс өргөө

х х х

Зүүдний үүдээр шагалзах хэрэггүй

Эрхэм ээ

Зүгээр л хажуугаар зөрж од

Зүйрлээд хэлчихмээр жишээ алга

Цорын ганц болохоор чинь

Хэлж чадахгүй нь

Тог тог тогшихоор чинь

Би сэрчих гээд байна

Хэрэггүй

Зөвхөн зүрхний тайзнаа

Жүжиглэ

Дайсан минь

х х х

Шувууд буцаад л

Даллахад минь гунганалдаад л

Хавар ирэхдээ

Намайг лав таниана байлгүй

Зэллээд нисэхдээ

Жигүүрээрээ намайг далласан

Гараас нь атган мэндлэхийг хүсэхдээ

Би хойноос нь ниссэн

Зөндөө удчихаад ирэхэд

Залуу болчихсон байгаарай

Чамдаа дахиад

Дурлахаас айхгүй гээд

Яг тийм

Би далавчлан нисээд

Гар барин учирнаа

дараа жилийн хавраар

ХЭРЛЭН ГОЛ

Үнэр анхил талын цэцгийн амтыг уусгаж

Үрэл мөнгөн оддын сувдан гэгээг тольдон

Үзэмж алтанхан нарны буман цацрагийг наадуулсан

Үзэмж гоо охьюу

үзэсгэлэнт Хэрлэн минь урсана

Бүжин зэрэглээ эрхлэх цээлхэн талыг хээлэн

Бөгтөр цэнхэр тэнгэрийн өнгө гоод талиман

Бөртөн бодол хулжааж дөлгөөн тунгалаг мяралзсан

Бодь амгалангийн хайлан буурал Хэрлэн тунарна

ӨРГӨСТЭЙ ЦАС

Ганцхан шаргал навч

Захан дээр минь буулаа

Хүзүүг минь үнсэж таалсан

Зөөлхөн байсан өргөстэй мөртөө

Зүрхний агшин гэж

Яг ийм байдаг даа

Өргөстэй навчис шиг

Зөндөө жаргалаа булаалгачихаад

Цоорхой навч шиг

Гэхдээ

Харамсах юмгүйдээ

Он жилүүд минь

Одоо би

Өргөстэй цас орохыг үзмээр байна

х х х

Зөрж өнгөрөхдөө

Зүрхний чинь чимээг сонсчихсон

Хачин булгилаад цовхчиж байсан

Гар дээр минь та инээд асгачихаад

Юу ч болоогүй юм шиг

Ажин түжин

Зүгээр л хажуугаар сэвхийгээд

Зөрж одсон

Ингэхийг чинь би

Эргэж хараагүй

Харах ч хэрэггүй

Та намайг мэдчихсэн болохоор

Сэтгэлийн тань диваажин

Үүдээ дэлгэчихсэн

Яг одоо

Та над руу харж байгаа

х х х

Зэллээд ниссэн шувуудын хойноос

Жигтэйхэн их гуниглаад хоцорсон

Нууцлан байдаг орь ганц хүслийг

Нуусан чигт нь ниссэн болохоор чинь

Буцаад ирээсэй гэдэг

Булгилах зүрхэн айзамд бүжье

Бүлээн хушуугаа дэвсээд

Наддаа эрхэл дээ

Тэгээд

Тэнгэрт үнэрхэн

Нууцыг минь шивнээч

Би мэдмээр байна

Мэдчихвэл

Өөрөөсөө бас нуумаар байна

х х х

Чамайг би зуръя

Нарийхан бийрээр

Ирж явааг чинь

Инээж байгаагаар

Амандаа зүрхээ зуугаад

Нүв нүцгэнээр

Нүднээс чинь

Нулимс биш

Хайр усаж байгаагаар

Хоёр зүрхтэй

Чамайг би зуръя

х х х

Зүрхний асарт

Зүү шивж тоглоё

Зүгээр л

Зүүдэнд минь хүрээд ир

Сэтгэлийн талд

Зүү эрж наадъя

Сэмхэн нуугдаад

Ороод ир

Хайрын төгөлд

Зүү ургуулж эрхлэе

Бушуухан надад

Яваад ир

Харин

Зүрхээ гээж

Зүсээ хувиргаад

Хов хоосон

Хүрээд ир

Дурлал минь

Хүсэлгүй зэвхий царайт минь

Надаас бүү ай

х х х

Гудамжны гэрэл бүхэн

Ганцхан над дээр тусаад

Сонжиж байх шиг

Ичгүүргүй

Бодлыг минь мэдчихвий

Түүний тухай

дуулж байна гэж

Хурдхан алхъя

Дараагийн гэрэл хүртэл

х х х

Он жилүүдийг хамтдаа элээгээгүй юм шиг

Анх учраад догдлохдоо зүрхээ эсгээгүй юм шиг

Зүүдний чинь зайцаар би шагалзаагүй юм шиг

Зүрхний чинь арын хаалгаар хөл тавьсан юм шиг

Хайр нь чамайг мартанаа

Амархан шүү дээ

Хээнцэрлэж гоёоод тольдоогүй юм шиг

Хэрэг болгож солиогүй юм шиг

Хоёр дэр зэхээгүй юм шиг

Хушуунд чинь зүүгдээд эрхлээгүй юм шиг

Хайр нь чамайг мартанаа

Хялбархан шүү дээ

Хойтон хаврыг угтахгүй гэж

Холоо оччихоод ирэхгүй гэж

Хүслээ дагаад шулуухан алхаарай гэж

Хайр нь чамайгаа мартанаа

Харин мартах гэдэг

Хаа орчлонд ямар байдгийг

Зөвхөн өөрөөр чинь заалгаад

Зүгээр л мартаж орхё

Амархан биз

х х х

Гэнэт сэрчихлээ

Зүрхний хаалга угз татан орж ирэхээр чинь

Намайг яагаад амраадаггүй юм бэ

Тэр намар

Зүрхний хаалгыг савж одсон өдөр дөө

х х х

Таны явснаас хойш

Хэдэн хавартай учирсан

Таны хөтөлдөг гар

Савхин бээлий угладаг болсон

Та үүнийг мэдэхгүй

Таныг явсан хавар өргөстэй яргуй ургаж

Түүнд бүдэрч унахдаа би

Бээлийгээ сольчихсон



Маамын МӨНХЗАЯА

Боржигин овогт М. Мөнхзаяа Дундговь аймгийн Говьугтаал сумын төвд 1966 –онд төрсөн. Цахилгааны инженер. Хоршооллын “Тэргүүний ажилтан” Оюутны яруу найргийн наадмын тусгай байрны шагналт.

УГТААЛ НУТАГ МИНЬ

Санчиг нь бууралтсан хөвгүүний

Сэтгэл зүрхэнд нь уяатай

Сүүний үнэртэй цэцгэн тал

Саранд ойрхон Угтаал нутаг минь

Амьдралын жигүүр алсад одсон

Аав ээжийн үрсийн аргамжаа

Азай буурал өвгөдийн

Мөнх нойрссон өргөө

Зүүдэндээ шөнө болгон очсон

Замбуулинд ганцхан миний нутаг Угтаал

Зуун зуун жил өнгөрсөн ч биднийг хүлээнэ

Зүрхэн сүмбэр уултай

Зэрэглээт Их газрын чулуутай

Ирсэн бүхнийг зочилдог

Унд сайтай бүсгүйчүүлтэй

Уртын дуу аялаж

Ардаг хүлгийн зоонд дарцагласан

Эрмэг хүдэр эрстэй

Хаа ч явсан сэтгэлийн соронзон

Хүүхэд ахуйн дурсамж дүүрэн

Хүйн холбоотой амин нутаг

Насны эцэст ясыг минь хадгалах

Наран доорхи алтан өлгий

Миний нутаг Угтаал

2004.10.26.

ЦУНАМИ

Далайн ус агаарт үүл болон босч

Дэлхийн газарт чихэр шиг уусч

Нүд ирмэхийн зуур орчлон хөмөрч

Нойрмог далай догшин авирлана

Усан уул тэнгэр баганадан

Замын бүхнээ залгин сүйтгэн

Цунами чи гамшиг дэгдээн

Зуун зуун мянган хүнийг диваажинд хүргэв

Эргэх дэлхийн түүхэнд ганц л гарсан

Эрдэнэт хүний амийг

Эд хөрөнгөтэй нь эхнэр хүүхэд ахан дүүстэй нь

Эрлэгийн оронд бөөнөөр нь залсан

Зуун зуун жил өнгөрсөн ч

Цунами чи түүх болон яригдана

Мянга мянган жил өнгөрсөн ч

Цунами чи усан хөшөө болон сүндэрлэнэ

МӨРӨӨДӨЛ

Бодол оюуны үзүүрт хөвөрч байдаг мөрөөдөл

Болно бүтнэ гэж хүсэж хүлээсэн мөрөөдөл

Бяцхан хөвгүүд, охид, өвгөд, хөгшдийн

Буриад, халх, хятад, орос

Америк, куба хүн бүхнийг хөтөлж явдаг мөрөөдөл

Хүйн холбоо амин сүнстэй мөрөөдөл

Хэзээ ч орхиж болохгүй

Хүрэх л ёстой мөрөөдөл

Хүрч чадаагүй бол

Хойч үедээ өвлүүлэх ёстой мөрөөдөл

Мөрөөдөл мөрөөдөл мөрөөдөл

Мөнгөн шүүдэр тэнгэрээс буулгаж

Мөнхөд залуу байлгаж д иваажинд хүргэх

Мянга мянган мөрөөдөл

ХААЛГА

Хүн бүхний орж гардаг хаалга

Хүмүүний амьдрал буцалж байдаг хаалга

Хятад, монгол, орос, герман хийцийн хаалга

Хаана л бол хаалга онгойж хаагдана

Эрдэнэсийн зүйл ч цаана нь байна

Эрх ямбатай нь ч цаана нь байна

Хэрэгтэн ялтан ч цаана нь байна

Хэрүүл, маргаан ч цаана нь харагдана

Эсгий үүднээс өвгэй

Эрин зуунд ч бидэнтэй байх

Хөгжил дэвшилийн нүүр царай

Хөлд ороод алхаж гарсан хаалга

Хаалга хаалга хаалга

ЭЭЖ МИНЬ

Унасан навчис салхинд тэнэх шиг

Ухаан богино балчирхан насанд

Урмаар ухаан хайрласан ээж минь

Уужим гэхэд дэндүү уяхан миний ээж

Харанхуй шөнө хар дарахад

Хөлсийг минь арчиж сэрээсэн

Хайраараа үргэлж намайг хайрласан

Халамжийн дээдийг ханьдаа үрсдээ өгсөн ээж минь

Нас нь ахиж намхан болсон ээж минь

Намайгаа үргэлж нялхаар бодсон

Нартад наддаа ганцхан ээж минь

Нандингаас нандин бурхан тэнгэр

ЭЛСНИЙ НҮҮДЭЛ

Эргэх тоолондоо дэлхий хөгширч
Элсний нүүдэл газар авсаар
Сахарын цөл африкийн элс хормой тэлж
Саран дээрх ертөнц ойртсоор
Хүн төрөлхтөн бүгдээрээ
Хөдлөхгүй бол горьгүй нь
Хөрс шороо газар нутгаа
Хайрлахгүй юм бол хорвоод амьдраад яах юм бэ?
Цөлжилт сөнөлтийн шуурга
Шөнө өдөргүй оволзсоор
Сөөг бутны өмнө элсэн хунгар
Сэтгэлд багтахгүй их нүүдэл айсуй хүмүүсээ
Ногоон төгөл говьдоо ургуулъя
Наашлах аюулыг сөрөн зогсьё
Намираа хурыг нутагтаа буулган
Назгайрч суулгүй бүгдээрээ хөдөлмөрлөө

АЯНААС ИРЭХЭД

Хонин зэрэглээ хөлөөр намирч
Хөхүүн салхи хацар долооход
Хонгор чи минь сэтгэлд туяарч
Ханийн жаргалд намайг дуудна
Холын аянаас чамдаа яаран

Хоймрын уяанд дөрөө мулталхад

Хүлэг морь минь ижлээ санан үүрсэхэд

Хань минь чи хайрын мишээлтэй угтана

Тоонот гэрийнхээ босго алхахад

Тогоотой цайны ааг хамар цоргин

Туулсан замын ядаргаа тайлахад

Тормогор үр минь үнэгчлэн унтана

Гэрийн эзэн суудал тухлахад

Гэргий чи минь цайгаа барина

Гэнэн хонгор үр минь ааваа танин тэмүүлэхэд

Галынхаа дэргэд чи минь мишээнэ



Баатарын ААСҮРЭН

Яруу найрагч Баатарын Аасүрэн 1979 онд Дундговь аймагт төрсөн. “Бэрс” дээд сургуулийг сэтгүүлч мэргэжлээр төгссөн. Хүүхдийн яруу найргийн “Хүрэл тулга” наадамд амжилттай оролцож байжээ. 2009 онд анхны номоо “Бусдаас өөр чамд” нэртэйгээр хэвлүүлж уншигчдын хүртээл болгосон юм.

ИХЭЭ ГАЗРЫН ЧУЛУУ

Ихээ газрын чулуу

Тэнгэрийнх гэдгээ нотолж

Ирнэ гээд явсан хүүгээ

Газарт сөгдөж хүлээдэг юм

Ихээ газрын чулуу

Ийм гэдгээ баталж

Ингэний гунганаатай толгодоо энгэртээ энхрийлж

Сүүмэлздэг юм.

Ид борооноор өдийд

Будан хүдэнгээ дуудчихаад

Ирэх бүхнийг угтан

Торолзож л байгаадаа

Би л үүнийг мэднэ

Ихээ газрын чулуу

Их холынх бишээ

Энгэрийг минь налаад хэвтвэл

Агь ганга нь надаас л хан хийнэ

Ихээ газрын чулуу их холынх бишээ

Энхэр бодлыг минь зурж жаахан байсаныг минь батална

Ихээ газрын чулууны охин юм би.

ШАМБАЛ

Зөөлөн элсний чимээ

Зөн совин дагуулж

Хүслийн уулруу мацуулна

Зөндөөн шаргал гунигаа

Зөрүүлэн байж дамжлаад

Зүр гурын үүдээр орж

Зүг чигээ дэнслүүлнэ

Савчин савчин жингэнэх

Сарны чимээтэй хонхонд

Санаа хүслээ өлгөж

Салаа мөчрөө даатгана.

х х х

Хүүгийн минь мэндэлсэн өдөр

Хүрээд иржээ өнөөдөр

Хүслийн цалгиа нялххан цагийн

Хүүгээ амлуулсан гэгээхэн мөчийн

Цээж нэвчсэн ариухан сүү минь

Сар нарыг хагасалж

Ижийгээ бүтэн болгосон

Шанх санчигийг минь гоёж

Бүсгүй болгосон хүү минь

Хүрэх өдрийн учиг

Хөх талын эзэн

Миний муухай үр

Хүү минь

ЗҮҮДЭЛСЭН ШИГ...

Зүүдэлсэн шиг

Хэн нэгэн номыг минь

бариад зад загнаасай

Зүүдэлсэн шиг

Хэн нэгэнд

“ Үс минь бүдүүн..” гээд л

Сэмээрхэн уншаасай

Зүүдэлсэн шиг

Хөдөө хээр даарч дараа нь

жигтэйхэн их халууцаасай

Зүүдэлсэн шиг

Хөхрөгч уулын тэргүүнд

хөлөөрөө мацаж гараасай

Зүүдэлсэн шиг л ...

х х х

Ийм урт замын өмнө зогсоно

Инж бэлгийг юугаар хэмжих

Ийм их хайрын өмнө зогсоно

Ирэх өдрүүдийг

дүүргэх гэж шанална

Хайраар туулах энэ өдрүүдээ

Хань гэж зөөлхөн нэрлэнэ

Хажууд нь цэцэглэх

цаг хугацааг

Үр гэж аяархан нэрлэнэ

Нэрийн дор би

сөгдөж амьдарна

Нэхэлдтэй амьдын амь зүйж

Нээрээ тэд минь бүгдээр

Намайг бүтэн болгоно

ХУДАЛЧ

Алхаж дөнгөж хөлд орж буй

Алаг ертөнц минь

Усаар тань өөрийгөө

Угааж л сууна даа

Өршөө

Гүйгээд ирэхийн цагт тань

Гүйцэж очоод

Гээзгийг тань норгон

Гялалзтал нь самнаж өгнөө

Итгэ.

х х х

Цүнхэнд минь шүлгийн ном алга

Би юу уншиж яваа юм бол

Зүрхэнд минь шүлгийн мөр алга

Би хаагуур яваад байгаа юм бол

Шинэ он шинэ шүлэг

Шивнэсэн үг шинэхэн амраг

За тиймээ би бүгдийг зөвшөөрье

Захаасаа аваад намайг бүгд дага

Замын тань чулууг түүж өгье

Захьж бас нэгийг хэлье

Заяа золын халууныг над шиг эдэл

ХӨДӨЛГӨӨН

Өвөөгийн минь араар

Аав ороод нуугдчихсан

Аавын минь араар

Энэ ертөнц орчихсон

Эмтрэхдээ би

Эрэг дагаж гүйсэн

Гүйсээр би өвөөд дөхөж очсон

Өвөөгийн цаана аав

Бас л гүйж явсан

Аавын өмнөх орчлон

Миний өмнө ирчихсэн

Гүйж явсаан

Бид ер нь бүгдээрээ

Битүү хорвоотой гэжүү...

х х х

Сэтгэл бороотойг хэн хэлдэг юм бол

Мэдмээр байна

Өхөөр минь

Сэмхэн нүцэглээд өөрийгөө тольдсныг

Сэрмээр байна уу

Өөрөө мэд

х х х

Ирээдүйг тээсэн хүүхнүүд

Ийм олон байхад

Ингэтлээ юунд гуниглах вэ ер нь

Маргааш нөгөөдөр магад түүний маргааш

Хүмүнээс хүмүн төрж буйг мэдэрч байгаа цагт

Хүүшилж нүүж хөндийгөө юунд голох вэ , ер нь

Үр бүхэн минийх гэж бардаж сур

Баян байгаа минь энэ

Үндэс бүхнийг мөнхийнх гэж итгэ

Дүүрэн байгаа минь энэ

х х х

Нар зөвийн шалтаг

Надад олон байна

Хүүтэй ижий үхэхгүйн шалтаг

Хүслээ гэж тэмүүлсний шалтаг

Хүний л төлөө шаналсны шалтаг

Хүрэх газраа мэдэхийн шалтаг

Үнэндээ надад орлон

шалтгаан байна

Үргэлж асахын шалтаг

Үүдээ тайлахын шалтаг

Зөв энгэртэй дээл

Зүйж өмсөхийн шалтаг

Зөн цэнгийн хорвоод

Зөв бодохын шалтаг

Нар зөвийн шалтгаан

Надаар дүүрэн байна

ТЭНД... БАС ЭНД

Жаахан уйдангуй

бүдэг өнгөнүүд

Жаргал гэсэн тод бичгүүд

Нүүрээр дүүрэн

нээлттэй цонхнууд

Нэг л содон ганц бүсгүй

Тэнд

Бичигдэхээ хүлээсэн

бодлын тасархайнууд

Биежхээс айсан

бүлээн мэдрэмжүүд

Энд

Зүрхээр минь хатгасан

Зөн өвдөлт

Зүггүйтэж тогломоор

Хачин ертөнц

Бас

Усаар дүүрсэн

Наймын хувин

Утгагдаж сандарсан

Миний авьяас.



Дашдондовын МӨНХБАТ

1973 онд Дундговь аймгийн Баянжаргалн суманд төрсөн. Шашны дээд сургууль төгссөн. “Боржигидай сэцэн” наадмын Тэргүүн шагналт.

БАЙЖ МЭДНЭ

Хоол эрээд гудманд гүйх

хатингар гөлгийг битгий чулууд

Хонгор жаахан үр чинь болж

заяаж мэднэ

Хос хосоороо нисэх хунг

салгаж битгий нисгэ

Хожим нь чамайг жаргаах

хань чинь байж магад

Тэргэнд хөллөөд зүтгэх

гулзгай атаа битгий жанч

Тэнгэр уул шиг түшигтэй

аав чинь байж болно

Тэргэл саран дор нутгаа гүйх

байдсыг битгий чөдөрлө

Тэвэрч өсгөсөн ижий тань байж мэднэ

Уулын хөх цэцэд уйлах

чононд битгий муу сана

Урьдаас чинь итгэл алдаагүй

анд тань байж магад

Урамдан зогсоо

халтар халиун бугыг битгий цочоо

Ухаант сургаалаа айлдсан

өвөө тань байж мэднэ

Нүхэндээ орсон тарваганд

урхи битгий тавь

Нөж цус нэгтэй садан тань байж болно

Нүүдлийн ачаанд буух

болжморийг битгий үргээ

Нүгэл аврах гээд тарина унших

эмээ тань байж магад хүмүүсээ

ХҮРЭН ДУХ

Эрт галавын аврага амьтдын

диваажин болсон орон минь

Их далайн хөвөөг чимсэн

агуу баян арал минь

Энгүй их талын төгсгөл уул минь

Элсэн их говийн

тэргүүн хайрхан минь

Энгэрээс тань урсах

булаг болгон нь рашаан

Эргэнд тань ургасан бүхэн эм

Эгц хясаа ганга тань уран барилга

Элгэн хүрэн толгод тань

буурал түүхийн гэрч

Өвгөд дээдэс догшин хэмээн

оройд нь гаргадаггүй

Өөрийг тань ил оршихуйд

нэрийг тань хэлдэггүй

Өнчин гурван хайлаас тань

хэн ч гар хүрдэггүй

Өвгөн буурал хайлаас тань

хэн ч гар хүрдэггүй

Өвгөн буурал хүрэн дух минь ээ

Миний нутгийн нэгэн гайхамшиг

Мэндийн цэнхэр хадаг шиг

говийн минь оргил

Нэр нь хүртэл тэргүүн магнай

ИХ ЦАГААН ГЭГЭЭ

Авдрын өмнө ханхайх аавтайгаа

Золгох гэлээ золгосонгүй

Аагтай шаргал цайгаа

самрах ижийдээ

Үнсүүлэх гэлээ үнссэнгүй

Аргамаг хүрэн азаргаа

Сүргээс нь гурийллаа янцгаасангүй

Агь таана ханхалсан бор толгоддоо

Хөрвөөлөө үнэртсэнгүй

Их харуусал зүрхэнд тунархуйд

Их цагаан гэгээн дундуур

Би ганцаар гэлдэрнэм

Уулсынхаа оройд нартай

Уралдан гараад

Хашгирлаа цуурайтсангүй

Урсгал дөлгөөн Хэрлэндээ

Умбаж шумбалаа норсонгүй

Учирсан жаахан амрагаа

Саран ичээж үнслээ догдолсонгүй

Уруул дэвсээд амаа тосоод

Охиноо тэвэрлээ эрхэлсэнгүй

Их цагаан гэгээн дундуур

Би ганцаараа гэлдэрнэм

Найрын дугараанд дөхөж

Аяллаа хуурдаж түрсэнгүй

Нанчид зооглон агсам тавилаа

Хэн ч намайг хайхарсангүй

Наадмын зүлэг ногоон дэвжээнд

Дэвээд гарлаа

нэрийг минь дуудсангүй

Найргийн охин тэнгэр дор

Шүлгээ хайллаа хэн ч сонссонгүй

Их цагаан гэгээн дундуур

Би ганцаар гэлдэрнэм

Таних бүхэнтэйгээ

толгой мэхийн мэндэллээ

Хариу хэн ч мэндэлсэнгүй

Танихгүй болгонтой

үг сөрж яриа өдлөө

Хэн нэг нь ч дуугарсангүй

Тоос татсан их зам тосож зогслоо

Юу ч үзэгдсэнгүй

Тогорууны дэгдээхэйг барьж нооллоо

Эх нь өмөөрсөнгүй

Их цагаан гэгээн дундуур

Би ганцаар гэлдэрнэм

Их үхлийн өмнө

Миний эзэгнэх орчлон гэж...

Бямбасүрэнгийн МАЙНБАЯР

Бямбасүрэнгийн Майнбаяр нь 1969 онд Сүхбаатар аймгийн Баруун- урт хотод төрсөн. Анагаах ухааны коллеж төгсжээ.

САЛХИНЫ ИЛБЭЭ

Эвийлэн илбэх чиний минь гар шиг

Бүлээхэн салхи намайг илбэхэд

Энхрий чамайгаа би үгүйлэхэд

Битүүхэн дотроо санаж суулаа

Салхи минь чи намайг

Дахин дахин илбээч

Сайхан түүнийг минь

Санагдтал илбээч

Уяран хайлах чиний минь гар шиг

Урьхан салхи намайг илбэхэд

Унаган багын чамайгаа үгүйлээд

Хайлан нялхарч дурсаж суулаа

Салхи минь чи намайг

Дахин дахин илбээч

Унаган багын түүнийг минь

Бодогдтол илбээч

Янаглан үнсэх чиний минь уруул шиг

Ягаахан дэлбээгээ цэцэгс дэлгээд

Амраг чамайгаа би үгүйлээд

Аньсагаа гийгүүлэн санаж суулаа

Салхи минь чи намайг

Дахин дахин илбээч

Амраг түүнийг минь

Нялхартал илбээч

2008—5-23

ХЭРЛЭН

Наран ургах зүг рүү

Найраг түрэн урсан

Налгар монгол орон минь

Нанчид өргөх Хэрлэн

Найраг шүлгийн тэнгэрт минь

Онгод хайрлах Хэрлэн

Найрал сайхан дуунд минь

Түрлэг нэмэх Хэрлэн

Үлэмжийн сайхан орондоо

Үзэмж нэмсэн Хэрлэн

Үүлэн хөх тэнгэртээ

Өнгө нийлсэн Хэрлэн

2006-5-23

УЧРАЛ

Хаврын нэгэн сэвэлзүүр салхитай өдөр

Харц минь анх мөргөлдсөн бил үү

Харьж ирээд бодож суухнаа

Хачин сонин санагдаж билээ

Зөн билгийн совин татаад

Зүрх сэтгэлд нэгийг шивнээд

Чиний дүр нүдний өмнүүр

Жирэлзээд өнгөрөх шиг санагдаж билээ

2004-5-16

х х х

Дуулимд намайг уйлж явахад

Дуугаараа чи уярааж явсан

Дурлал хайрын гэгээн тэнгэр минь

Дуу хүрэхгүй алсад суугаа даа

Хорвоод намайг гуниж явахад

Хоёрхон үгээр сэргээж чадсан

Хосгүй хайрын эзэн чи минь

Холын холд суугаа даа

Ганцаар би гуниглан дуулаад

Газрын холоос чамайгаа үгүйлээд

Яралзтал сайхан инээсээр чи минь

Яг одоо хүрээд ирээч дээ

2007- 2-25



Мөнхбаярын ХҮРЭЛБААТАР

Догшин Боржигин овогт Мөнхбаярын Хүрэлбаатар 1966- 3-28 –нд Дундговь аймгийн Баянжаргалан сумын “Аргатай” гэдэг газар төрсөн. 1 Эм зүйч мэргэжилтэй Эм зүйн ухааны магистер. Анагаах ухааны дээд сургуулийн залуу уран бүтээлчдийн нэгдлийн шилдэг шүлгийн уралдаанд оролцож байсан. Эрүүл мэндийн “Тэргүүний ажилтан”

ЖАРГАЛТАЙ НУТГИЙН НААДАМ

Гангийн улаан дэвсгэр дээр

Нутгийн олны нүүдэл дээр

Эрхт боржигины цээжин дээр

Их догшний зүрхэн дээр

Жаргалтай нутгийн наадам

Дэлгэр монглд зарлагдав аа

Баян буурал түүхийн

Наян жилийн ойн дээр

Буян хурсан түмнийхээ

Хандивийн халуун итгэл дээр

Жаргалтай нутгийн наадам

Даяар олныг даллав аа

Алтан туурт хүлгүүд

Авто хөлөглөн морилов

Аяны дэгжин асрууд

Сум тойрон дэвэлзэв

Жаргалтай нутгийн наадам

Хийморийн тоосыг өлгийдөв өө

Иртэй бяртай хүчтэнүүд

Талбай дүүрэн цэнгэв

Цамтай хууртай залуус

Өдөржин шөнөжин наадав

Жаргалтай нутгийн наадам

Боржигон дуундаа уярав аа

Хан хурмаст баярлаж

Хувилгаан үүлс нь мэлмэрэв

Хатан дэлхий дэлэгнэж

Хялман тоос нь бадамлав

Жаргалтай нутгийн наадам

Ган тайлж өндөрлөв өө

2005 –8-3

х х х

Айраг үнэртсэн талын агаар

Аавын гэр шиг дотно агаар

Цээж зайлсан өглөөний агаар

Сэтгэл цадсан миний агаар

x x x

Сар хурайлсан намрын үдэш

Сархад дэвэрсэн найрын үдэш

Сайхан хосын хайрын үдэш

Санаанаа гарамгүй тэр үдэш

x x x

Үүл нүүсэн хөхөмдөг тал

Үлгэр хүүрнэсэн тахимдуу тал

Салхи хүүгсэн цайдам тал

Санаа алдарсан найргийн тал

x x x

Найр найрын дээд наадам мөн сайхнаа

Насны ганц ханиа олох мөн сайхнаа

Хайр хайрын дээд ээж минь мөн сайхнаа

Халуун сургаал үгийг нь сонсох мөн

сайхнаа

АДИЛБИШИД

Ховд нутгийн Адилаа

Хонгор жаахан Адилаа

Сар гарахаар ниснэ

Саахалт буугаад уулзана

Зээл байвал авна

Зэрэгцэж суугаад ярина

Нутаг нь хол боловч

Сэтгэл нь ойрхон Адилаа

Д.ОЮУНЧИМЭГТ

Бүжинэ гэж ч бүжинэ дээ

Бүгдийн өмнө гунхана даа

Шинжлэнэ ч гэж шинжлэнэ дээ

Шинэ хуучингүй шалгана даа

Халхын сайхан Хандармаа

Хаа байна Оюун аа

Халуун сэтгэл бүлээн хайраа

Хайртай мэргэжилдээ зориулсан юм аа

х х х

Болзоондоо хоцорсон бор халзан галуу

Бодолдоо дарагдан ганц хоёр гишгэнэ

Буурлын үгнээс зөрсөн босоо нэгэн залуу

Бошгот төрийн өмнө өршөөл горилон эргэнэ

Д.АЛТАНТУЯАД

Мэргэжлийн хяналтын Алтантуяа

Мэдээж бидний Амин уяа

Энхтайваны Амрагтуяа

Эмзүйч Ариухантуяа

БААСАНЦЭРЭНД

Нөмрөг уул нь нөөлөгтэй дээ хө

Нөхөр Бааска нь суурьшилтай даа хө

Ангийн нөхдөөс алслагдсандаа хө

Амар мэндийн солиогүйдээ хө

Одоо ингээд гарлаадаа хө

Оройхон та нартайгаа уулзана даа

Орчлон хорвоо оройгүй шүү дээ хө

Одоо ч гэсэн мисс шүү дээ хө

БАЯРМААД

Дундговийн дугуй цагаан

Дорноговийн унаган боловоо

Ар шандын агаар таарч

Амьдарал тэгширч жин нэмэв ээ

Хүүхэд нас алсран одож

Ачын дуу хачин ойртов оо

Хур хөрөнгө бяд сууж

Зоо тэнийх цаг ирэв ээ

Батнасангийн ШҮРЭНЧИМЭГ

Дуутан овогт Б.Шүрэнчимэг 1986 онд төрсөн. Эдийн засагч мэргэжилтэй. 2006-онд Дархан хотод ТИС-ийн нэрэмжит “Хорол-эрдэнэ” шүлгийн наадамд дэд байр 2008- онд ХААИС-ийн нэрэмжит наадмын дэд байрын шагнал хүртсэн.

ЧОЙРЫН БОГД УУЛ

Чойрын богд уул нь

Чонын хийморьтой уулаа

Очсон бүхнийг ивээн хайрласан

Орчлонд ганцхан миний уул

Өргөн сайхан талынхаа

Оргил нь болж өндийсөн

Өөдрөг олон түмнийхээ

Онгодыг бадраан мялаасан

Чойрын ганцхан богд нь

Чойртоо ээлтэй уул

Ирсэн бүхнийг ивээн хайрласан

Илбийн цэнхэр уул

Мэндийн торгон хадаг шиг

Миний цэнхэр уул

Нүүдлийн мянган шувуудын

Нүдэн баримжаат уул

Чойрын уудам талдаа

Чингисийн цэнхэр зэрэглээндээ

Эцэг төрөө тахисан уул

ЧАДАХГҮЙ ЮМ

Чамд би хайртай гэж

хэлж би чадахгүй юм

Чангаас чанга тэврээд

үнсэж би чадахгүй юм

Тэгсэн мөртлөө мартаж би чадахгүй юм

Тэр их хайрыг чинь

үгүйлэхгүй байж чадахгүй юм

Уурлаж байхдаа загнаж би чадахгүй юм

Унтаж байхдаа зүүдлэхгүй байж

чадахгүй юм

Аашлаж байхад чинь

аргадаж би чадахгүй юм

Архидаж байхад чинь

болиулж би чадахгүй юм

Дэндүү хатуу загнахад чинь

гомдож би чадахгүй юм

Дэргэдээс чинь явах гэвч

даанч би чадахгүй юм

Чамд би хайртай болохоор

Чамаас би холдож чадахгүй юм

Чиний дэргэд байгаа болохоор

Чамайг би мартаж чадахгүй юм

х х х

Эрдэнэт биеийг минь өсгөх гэж

энэхэн биеэ зовоосон

Энхрий сайхан ээжийнхээ

элбэрэлийг би мартахгүй

х х х

Хайрын цэгээн яргуй

хамгийн түрүүнд дэлбээлдэг ч

Хайрын уяхан сэтгэл

хамгийн түрүүнд сэвтдэг

2004-10-4

АНХНЫ ХАЙР МИНЬ

Хөөрүү насны минь энэхэн сэтгэлд

Хөврөн нүүгээд өнгөрсөн

Хүсэл сэтгэлийн минь үзүүрт

Харваж ирээд буцсан

Гэнэн сэтгэлийн минь хөг болсон

Гэрэлтэй насны минь чимэг болсон

Гэнэн томоогүй насны минь

Ганцхан тохиох анхны хайр минь ээ

Хорвоотой бүрэн танилцаж амжаагүй

Хонгор охин миний сэтгэлд

Агшин зуур үдлээд буцсан

Алсын шувуудын цуваа шиг

Дэрвүүн насны минь энэхэн үзүүрт

Днгийн эрвээхэй мэт эргэлдээд

Дэндээ шатан дуусах шиг

Дэндүү гэнэн анхны минь хайр аа

2003-06 сар

ЗУН ЧИ ЮУТАЙ ГАЙХАЛТАЙ

Өвлийн улирал дуусаж

Өнгөт цагаан цас хайлж

Өнчин зүрхэнд тээсэн гуниг

Өвөлтэй хамт сарних шиг

Аяа зун чи юутай гайхалтай

Алтан гургалдай донгодож

Алаг зүрхэнд тээсэн гуниг

Арилан одлоо ч

Сэрүүн салхи сэвэлзэх тоогоор

Сэтгэл хааяа сэм сэмхэни шимширч

Шиврээ бороо шиврэх тоогоор

Шимшрэх зүрх нэгийг шивнэх шиг

Аяа зун чи юутай гайхалтай



Баатарын ЭНХТӨР

Монголын Зохиолчдын Эвлэлийн гишүүн, Г.Сэр-Одын нэрэмжит шагналт зохиолч, яруу найрагч Төв аймгийн Зуунмод хотноо 1973 онд төрсөн. Боловсрол дээд “Өөр өнцгийн нүд”, “Оршихуйн Дорно.., Равжаа”, “Мөнх цэнхэрлэх Сүмбэр нутаг”, “Цаг хугацаанаас ангид.., диваажинд учиртал”, “Уруул шүрэн жүнз”, “Орон зайн гишгэгдэл” яруу найргийн, “Амьд цаас” үргэлжилсэн үгийн, “Эрх нас” хүүхдийн ном, “Стихи.., Роса сердца” яруу найраг, орчуулгын бүтээлүүдээ хэвлүүлжээ.

“Вансэмбэрүү наадмын Тэргүүн байр, Дархан-Уул аймгийн “Алтан өд” наадмын Дэд байр, “Борхойн цом” наадмын Дэд байр, “Санахын огторгуй” наадмын Дэд байр, “Эх орон–Оюунсанаа” наадмын гутгаар байр, “Ган үзэг” наадмын тусгай байрын шагналт.

ГАЛ ЭТЭЛСЭН ХӨХ ЧУЛУУ

Алмаазан ус буман жил өрөмдөн урсавч

цоолж зүрхэнд минь хүрээгүй

Агсал он цаг өрөвтөлж илүүрдэн довтловч

зоригийг минь бөхөөгөөгүй

Дүрэлзэх нүүдэлч ертөнцийн галыг биеэрээ туулж бэхэжсэн

Дөллөх ян халууныг тэсэж амьдрахын хат утгыг олсон

Би гал этэлсэн хөх чулуу

Би хал үзсэн бөх чулуу

Галав эрин солигдохын ай дивангарт би байсан

Газар буцалж туйл өөрчлөгдөхийн тэртээд би байсан

Монгол хуваагдахын эмгэнэлд цусанд нэвчиж би байсан

Мандан бадарч омогшиход тосонд мэлтийж би байсан

Би талын хөх чулуу

Би танил хөх чулуу

Бүл багачуул наадахад гэр барьж тоглуулсан наадгай билээ

Буурал өтгөст дэр ивж нойрсуулсан тахилгат суварга билээ

Улсынхаа манаанд хил болж зогссон сөхрөөгүй андгай билээ

Учрах амрагт болзоо болж тоссон цөхрөөгүй сэнтий билээ

Би буйрны хөх чулуу

Би буйгаараа хөх чулуу

Туулай харайлган чулуудах хүүхдийг инээлгэн баясгаж

Нар үзэлгүй түмэн жил голд живсэн би

Тусгаар тогтнол ямар үнэтэйг хэлэх гэж

Нэрээ арилгалгүй мянган жил монголоо тэвэрсэн би

Би аарцны хөх чулуу

Би амьд хөх чулуу

Нарны гэрэлт урсалыг шимэхдээ цэцгэсийн үндсэнд

дулаанаа өгдөг

Найраг сөгнөсөн орчлонг танихдаа сэтгэлийн аглагт

уясч зөөлөрдөг

Гэтлэх хийгээд гээгдэхийн сүүдэрт жамыг эмтэрч ухаардаг

Гэрэл болоод харанхуйн асури увдист шалтгааныг таньдаг

Би шүлэг хөх чулуу

Би шүтээн хөх чулуу

Хорвоогийн буурал судрыг элгэндээ бичиглэн хадгалж

Хан уулсын оргилыг сөөм өндөрсгөсөн итгэл би

Тэнгэрийн өвгөн бүргэд эцсийнхээ хүчээр харвахад

Сүүлчийнх нь шунгалтыг тосдог эр зоригийн хязгаар би

Би гал этэлсэн хөх чулуу

Би хал үзсэн бөх чулуу

БИЛИГТ ЗҮРХНИЙ МӨР

Мөрөөслийн вишнү наран

уянга эгшиглэн манддаг зүг бий

Мөчид винай амьдралд

амтлаад дундалдаггүй нандин үг бий

Өвөртөлж дуусахгүй хүсэл минь

ханд дагинас зүүдтэй

Өөрийг минь хүргэх намрын хязгаар

бадам мөнхийн шүлэгтэй

Нулимс гэдэг сэтгэлийн гүйдэл

нирванаар тунгалагшиж урсдаг билээ

Нялхарч л жаргах үнэний бөөрөнд

хорвоо тэнцүүгүй алаг билээ

Хасбуу ташлан орчлонгийн

утгын гоо үзэсгэлэнд амьсаж

Халуун зоргоороо дүрэлзэн
гэгээн шүлэгч омогшиж амьдарна
Цанхуй цэцгэсийн бунд дэлбээ
хавар бүрийг хээнцэрлэн гоодоход
Цаглашгүйн адистат жамын
агшин хүрдийг бийрээр үрслэнэ
Энгэсэгт цэцгэсийн уран хүйсэнд
яруу шүлэгчид дурласаар л байна
Энгийн бүхний төгөлдөр эгшиглэнг
үгийн шүүдрээр урласаар л байна
Цаг бууралтахыг гоёж
амьдрах ариуныг ургуулж нээдэг
Цаашлах үнэтэй нүцгэн жимд
зүрхний ганц үнэнийг дэлгэдэг
Эрлийн түмэн жим дор
с увдан учрал үйлийн хишиг мөн өө
Эгнэгт бүхэн төгсгөлтэй
дурсамжит сэтгэлийн бүлээн мөн өө
Гэсрийн хурдаар дөрөөлөх
эш амьны алтан төлөөснөө
Гэрэлт чимэг хайраа чандманалсан
билигт зүрхний мөр үлдэнэ ээ

МЗЭ-ийн шагналт яруу найрагч агсан

П.Бөхбат ахдаа зориулмой

“БАЯНМОНГОЛ”

Одоо мөдхөн

“Борооны тарни” эхлэнэ

Орчлонд бүх юм шинээр дэлгэрнэ

Шүлэг тань хүртэл

шинээр уншигдаж

Нулимс минь урсахдаа

шинээр урсана

Яруу найрагчийн зүрхийг

гайхсаар л байна уу? хорвоо

Ямар гэгээн явдагийг

замлин мэдэв үү?

Хагацалд цадаагүй хорвоогоос

Хашгирч би асуумаар байна!

Эмнэлэгийн орон дээр

дэргэд минь өнгөрсөн саятан эр

Ихийн их хөрөнгөө барж

амжаагүй хөөрхий

Алт амлаж, эмч бурхан хоёроос

Ахиухан нас, амьдрах хоног

гуйж байсан

Амьдрах сайхаан...,

Дэндүү сайхан

Гэвч,

Баянмонгол гэж

Бадрангуй хэлсэн

Сүүлчийн тань үгийг

Сүлд тэнгэр өршөө

Яруу найрагчийн зүрх

Яаж зогсдогийг орчлон харав уу?

Одоо мөдхөн

“Борооны тарни” эхлэнэ

Орчлонд бүх юм шинээр дэлгэрнэ

Шүлэг тань хүртэл

шинээр уншигдаж

Нулимс минь урсахдаа

шинээр урсана, ах аа

AABA

Зодолдож өсөхдөө

Зодуулчихаад ирэхэд минь

Ах нараас харамлаагүй

Зоргоороо эрхлэхэд минь

Алт байтугайг ч харамлаагүй

Зорилгоо олохгүй тэнэхэд минь

Амьдралын буулганаас харамлаагүй

Танхайрч гэмээ нь

Тэлээдэхдээ харамлаагүй

Тангараг өргөхөд минь

Эх орноосоо харамлаагүй

Тулаанд эрсдсэн ч

Амийг минь харамлахгүй

Миний муу хөх аав

Тамхи үнэртүүлэн үнсэхэд тань, ааваа

Тандаа эрхлэх сэтгэл бүтэн болдог

Сахал тань сэргэжүүлж

хацар хатгахад тань, ааваа

Санасан элэг дэвтэж

Самсаа эрхгүй шархирдаг

Миний муу хөх аав

Өрлөг түүхээн

Өвөг үндсээн

Орчлонгоос харамладаг

Өлгий буйр

Өнөр Монголоо

Өвөртөөн харамладаг

Өсөх ач, үнэгчлэх зээгээ

Эжий, ааваас нь ч харамладаг

Өөрийг минь харин

Бор сархад, жудаггүй явахаас харамладаг

Тамхи үнэртүүлэн үнсэхэд тань, ааваа

Тандаа эрхлэх сэтгэл бүтэн болдог

Сахал тань сэргэжүүлж

хацар хатгахад тань, ааваа

Санасан элэг дэвтэж

Самсаа эрхгүй шархирдаг

Хөх орчлонгийн

Хөх судар

Хөөрхий муу

Хөх аав минь

Хөхрөгчийн доорхи хорвоод

Хүүгээсээ юугаа ч харамлаагүй

2014.04.01.

П.Батхуягтаа зориулмой..

СЭТГЭЛ БҮТЭЭГЧ

Хүн чанар мөстлөгийн

эрин үеийг хайлуулахаар

Хүрээ хөвүүний зүрхний нар под под дуслана

Зүүний сүвэгчээр нар шургаж

харанхуйд багтдаг

Зөнгөөрөө эргэх хорвоо

гэрлийн зүг нүүдэллэж амьдардаг

Хүмүүний бүтээсэн нар шүлэг юм

Хүн чанарын сэтгэл бүтээгч нь

яруу найрагч юм

Эрвээхэйн зүүдийг тайлж

харцны томьёоллыг задлаж

Хэзээ ч үхэхгүй үгсийг

тэнгэрийн санаанаас тэрлэдэг юм

Хүн чанарын мөстлөгийн

эрин үеийг хайлуулахаар

Хүрээ хөвүүний зүрхний нар под под дуслана

Хүмүүн төрөлхтөнг

гэрэлд дөхүүлсэний төлөөсөнд

Хөөрхий дөө, өөрийгөө л шатааж

аз жаргал олдог юм

2014 он

Яруу найрагч, нутгийн ах Ц.Дашдамбадаа зориулмой..

ТЭНГЭРИЙН СЭТГЭЛ

Цаг хугацаа элээж үл хүрэх

Тэнгэрийн сэтгэл

Цалиг онгодын билгээр

Яруу орчлонг гэрэлтүүлнэм

Чинагш одох үйлийн

алтан судрын өргөөнд

Зоргол хайрханыхаа өнгөтэй

Утгын гоод биширнэм

Үзтэл хорвоо

өөрийн зөнгөөр нүүдлэвч

Үзэсгэлэнт шүлгэс гэдэг

нарны садан юм аа

Үндэс нэгтэй амьдралын

Ургах, унахын төөрөгт

Өлгий нэгтэй нутаг нь

Бүлээн Өнжүүл юм аа

Цаг хугацаа элээж үл хүрэх

Тэнгэрийн сэтгэл

Цалиг онгодын билигт

Миний л ах юм аа

2014.04.04.

ХААЛГА

Бухан хүзүүт

Буурал уулыг

Будан иднэ

Бурхан ширтэнэ

Цасны уянга

Цаглахуйг сүлжинэ

Цаашаа явсан мөр чимээгүй

Амьдрах арвин амтай

Авсаны хаалга ганцтай

Духыг минь хэн хээлнэ

2014.01.02.

СТЕПЬ

Родная степь, дорогая

Широка, как душа материнская

Как будто ты поешь для меня

Всякую колыбельную

Бархатный ветер степи

Поет мне своей песни

Родная моя степь, бесконечная

Широка, как книга интересная

Как будто ты читаешь мне

Каждое утро интересную сказку

Блуждающий ветер степи

Шепчут мне своей стихи

Родная моя степь дорогая

Широка, как ум аксакала

Как будто ты советуешь мне

Каждое утро мудрые советы

Рыскающий ветер степи

Вливает мне своей силы

Родная степь, дорогая

Широка, как бесконечной мечты

Как будто ты даришь мне

Каждое утро светлую надежду

А шустрый ветер степи

Дарит мне радость и смех

УЛИРАЛ

Цусны амь

Сүү...

Зөгийний хэвлийд

Цэцэг..

Тогоруун дуу хагархад

Унаганы тоосонд

Зун босно

Царцаан царгиа

Цагийг ноёлно

Даашинзгүй модод гэрэлтэнэ

2014.01.03.



Загдсүрэнгийн БИЛЭГБАЯР

Харчин овогт Загдсүрэнгийн Билэгбаяр 1988 оны 10-р сарын 30 нд Говьсүмбэр аймгийн төвд төрсөн Сүмбэр сумын 10 –н жилийн дунд сургуулийг дүүргэжээ.

“Зүрхээн би чамд..” яруу найргийн номоо хэвлүүлсэн. “Боржигидай сэцэн” наадмын Гутгаар байрны хошой болон тусгай байрны шагналт.

СЭТГЭЛИЙН МИНЬ ТАЛД

Сэтгэлийн минь талд зун болж байна

Сэрүүхэн зүүдэнд цэцгэс ургаж

Сэвэлзэх салхи нь зүрх шүргээд

Сэмээрхэн бодолд минь солонго татаад

Сэтгэлийн талд бороо орж байна

Салхинд бодол минь дайгдаж ирэхэд

Санах юм.., Чамайг байдгийг

Сартай цуг ханьсаж хоноход чинь

Саваагүйтэж, бодол чинь хүрэх юм

Сэтгэлийн минь талд зун болж байна

Налгар намрын өдрүүдийг

Надтай хамт туулах гэж

Наран зүгээс

Нутгийн минь салхи үнэртлээ

Надтай ижил

Намхан бор толгод минь

Намайг санаж дуудлаа

Зүлгэнд нь ижий нар шингээд

Зөөлхөн байдаг юм

Зулайд нь хүртэл цас тогтохгүй

Зунаараа байдаг юм

Гээгэн дээр минь нар тусч наадаад

Дээлэн дотор цэцэг ургаж цаашлаад

Гэнэн бодолдоо од тоолж зүүдлээд

Дэнжийн толгоддоо солонго хөөж гүйсэн

Балчирхан насны багахан жаргал минь

Бараадаж тосдог уулын минь тэнд бий

Бага насаа дурсахаар тандаа би очно

Бадаг шүлгээ эвлүүлж тандаа би зорино

2013

Салхи, шуурга, цас, бороо

Сар, нар, сар, өдрүүд

Сараачих мэт өнгөрсөөр

Хөшигтэй цонхны доор

Хөөрхөн болжмор, буурал хөгшид

Хөөрөлдсөөр, хөхрөлдсөөр

Хөгжилтэй байгаа даа

Сараалжин торон сэтгэлд

Сайхан эрх чөлөө минь

Сартайд болзсон дурсамж минь

Саатсаар..., саатуулагдсаар...,

2013 он

Бодлыг минь шоолж

модод инээв

Бодол минь бодлоосоо

ичиж чимх инээв

Болзоогүй хайрын төлөө

зүрхээ догдлуулж

Бодлоороо шүхэр дэлгэж

Бороонд алхав...,

2013 он

ӨМНӨ ЧИНЬ...

Чимээгүй уруулын өнгөөр

өөрийгөө будаж

Чиний өмнүүр алхмаар...,

Чихэрлэг нандин үгсийг

Чихэндээ зүүж гоёмоор

Өмнө чинь бүгдийг тайчиж
Өөрийгөө гайхуулж баясмаар
Өлмийгөөрөө зөөлхөн гижигдэж
Өвөрт чинь шургаж эрхэлмээр тийм л.,
Дурлал хайр тийш гэж
Дур хүсэл ийм гэж
Зааж өгөөч надад
Зав байна уу.,?

2013 он

ТАВИЛАН

Эрчүүдийн сэтгэлд ..,би
Эдгэшгүй нэгэн сорви
Энхэд дуурсагдах шүлэг
Эвлэшгүй дурлалын
мөрөөдөл
Эхлэлгүй хэрнээ
төгсгөл болж үлдэнэ
Чинийхээ сэтгэлд би.,
Чимж сондорлосон эрдэнэ
Чинадын эрх аялгуу
Чихэр хүлхүүлсэн амттан
Чиггүй дураараа
салхин болж үлдэнэ
..., Хайртынхаа сэтгэлд би

Хамт ассан гал

Хатан тунамал итгэл

Харам дүүрэн хайр

Ханашгүй гэгээн жаргал

болж үлдэнэ

2010-11-02

ЭХНЭР

Эхнэр гэх..,

Эм заяаны бахархал уу?

Эр сэтгэлийн талархал уу?

Эвтэйхэн нэртэй шорон уу?

Надад заримдаа..,

Намтрыг минь цуулах аянга

Найргийг минь дарах элс

Намайг дааруулах цас

Энэ тавилан надад..,

Хормой зуурах үр

Хоёр ч алхахгүй мэдлэг

Хотгор доторхи жаргал

Энэ нэр надаас..,

Эрдэм сурах хүслийг минь

Эрх чөлөөт сэтгэлийг минь

Эргэж олдошгүй насыг минь

ЭГНЭГТ АВЧ ОДСОН

ЭЭЖ МИНЬ

Тоотойхон хоногийн урсгалдаа

Тогтоод л байгаарай ижий минь

Томоогүй хэдэн үрсээ

Тэврээд л үнсээрэй ижий минь

Хаяахан нэг зочилход минь

Гундуу битгий учираасай

Хачин их санадагийг минь

Ганцхан та л мэднэ дээ

Зөвийн гэгээт орчлонг

Зөндөөн урт болгоод

Зөвхөн таныхаа дэргэд

Зөрж эргэхгүй амьдрахсан даа

2011-01-29

ЗӨН ҮГ

Саналаа! таныг би сая

Санаандгүй нэг таарахсан гэж

Саваагүйтэж нэг залгахсан гэж

Сайн байна уу? гэж

бичихсэн гээд

Сэтгэлдээ цэцэг ургуулж саналаа

Өөр зүгт яваа шүү дээ гэж

Өрөөл бусдын тангараг шүү дээ гэж

Өчнөөн санасан ч ирэхгүй дээ гэж

Өрөвдөх сэтгэлгүй ангуучин гэж

Өөрийгөө би хуурлаа

Уучлалаар төгсгөөд орхи гэж

Уйлах сэтгэлээ гамна гэж

Урвах итгэлээ хөвчил гэж

Удах тусам нь хайрла гэж

Удган сэтгэл минь зэмлэлээ.

2010-09-29

ДУЛААН БОДОЛ

Үгүйлнэ дээ!гээд үнсэхэд чинь

Үсээн би норгочихсон

Үгээн би мартчихсан

Үнэндээ би иччихсэн

Санана даа гээд салахад чинь

Сайхныг би умартчихсан

Санаанаасаа би уравчихсан

Санаа алдан зогсчихсон

Баяртай гээд явахад чинь

Баахан гуниг үерлүүлсэн

Бадаг шүлгээн эвлүүлсэн

Барааг чинь тасартал харсан!

2010-он

ОНГОД

Дэндүү догшин үгтэй

найргийн бөө онгод

Дэлт цанхал аргамаг шиг

цээжин дотор цовхчино

Дэндүү гэгээн үгтэй

найргийн сүү онгод

Дэрэн дээр ивлэж

шөнөжин сул асгарна

Хатуугаас хатуу үгтэй

найргийн гал онгод

Хатан сэтгэл дэлсэж

дээшээ огшиж цоргино

Хачин этгээд үгтэй

найргийн зөн онгод

Хайлган зүрхийг минь савчуулж

гаргах шахан дэлсэнэ

2010-06-15

XXX

Зүрхээн би чамд

Зүйж оёод өгье

Дахиад чи уралгүй

Дандаа гамнаж яваарай

XXX

Энгүй дотнохон ярианд

Ижилсэнэ...
Би үгүйлнэ...
Ирэх цаг мөчүүдийг
Эрэгдэнэ...
Би зогсоох гэж
Дандаа хэлэх үгэнд
Дасна...
Би мөрөөднө...
Дагаж урсах өдрүүдийг
Даллана...
Би элээх гэж...
Булиглан цохилох зүрхэнд
Лугшина...
Би орох гэж...
Буцан одох цаг хугацааг
Буруутгана...
Би хайрлах гэж

2010-07-30

ЗҮРХНИЙ ХОСМОЛЖИН

Зүрх Зүүд
Зүрхээ Зүүдээ
Зүрхнээсээ Зүүднээсээ
Зүрхэндээ Зүүдэндээ
Зүүчихлээ Зүйчихлээ

Харцанд чинь хайр гийхээ больж

Хаашаа ширтсэн юм бол

Харин надад нулимс зохихоо больж

Хаана ууссан юм бол?

Дуу нь чих илбэхээ больж

Дууссан юм болов уу?

Духанд минь уруул хүрэхээ больж

Дутсан юм болов уу?

Утсанд минь зурвас ирэхээ больж

Уйдсан юм болов уу?

Уруулд минь салхи хоргодох болж

Уулзах ч юм болов уу?

Дэргэд минь чи тогтохоо больж

Ханасан ч юм болов уу?

Дэвтэрт минь зай үлдэхээ больж

Хаягдсан ч юм болов уу?

2010-09-12

Онгод хөлөглөсөн найрагч

Орчлонгийн гүнд одохдоо

Орхиж үлдээх зүйл нь

Оюуны суварган бүтээл

Охор богинохон насандаа

Овойлгох зүйл үгүй ч

Он жил бүдгэрхэд

Орчлонд үлдэх мөртэй

Орох үүд, гарах хаалга нь

Ондоо мөртлөө төстэй

Орог саарал орчлонд

Ондоо зүйл хэрэггүй

Онгодоо үйж

Орчлонг ундаалья



Гэнийдоогийн АЛТАНЧИМЭГ

Боржигин овогт Гэнийдоогийн Алтанчимэг 1970- оны 5- сарын 16 нд Өмнөговь аймгийн Манлай сумын төвд төрсөн. Тогооч мэргэжилтэй.

НУУЦ

Нэр нь хүртэл нууц болохоор

Нээрээ л нуух юм их юм аа

Ээжид нь золгож болохгүй

Эхнэрт нь харагдаж болохгүй

Энхрий үрст нь үзэгдэж болохгүй

Эр хүн өөртэй чинь хааяа л учрах

Энхэн мөч бас л нууц

Үг хэл минь нууц

Үйл хөдлөл минь нууц

Үгүйлж санах минь нууц

Үнсүүлж салах минь нууц

Уйлж дуулах минь нууц

Уярч хайрлах минь нууц

Уулзаж зогсох минь нууц

Учрал жаргал минь бүр нууц аа

Хэдийд ирэхийг чинь хүлээе

Хэдэн үг хэлэхийг чинь сонсоё

Хайрлуулж ганц тэврүүлээд

Хацар дээрээ үнсүүлж үлдэх юмсан

Хайрт гэж хэлэхгүй нь магад

Хань гэж дуудахгүй нь ч лав

Гэхдээ л таныг хүлээе ээ

Баярласан сэтгэлээ дарж ядан байна

Байж ядсан хүслээ хорьж тогтоон байна

Басхүү олонтаа дуугарах хүсэл үгүй

Байтлаа дахин дахин хармаар

Царайг чинь мартах аргагүй

Санааг чинь мэдэх аргагүй

Цадигаа алдаж таныг царайчлана

Чадалаа мэдэхгүй таныг л бараачлана

2009

х х х

Зах хязгааргүй бодолд дарагдаад

Заримдаа би зовлонтой ч жаргалтай

Үй түмэн бодолд дарагдаад гуниглаж

суухад минь

Үүлтэй тэнгэрээс хур ороод угаачихдаг бол

Үйлээ үзэж тэр бүхнийг

Үзэн ядаж зовохгүй л байх байсан

2009

х х х

Нууцхан урсах нулимс чимээгүй

Нуугаад байхад хацар л норчих юм

Нүгэл туучих энэ орчлонд

Нүд минь ганцаар гэрч юм уу

х х х

Сөхрөх цөхрөх хоёр хүнд ирдэг ч

Сөхөрч гуйхгүй, цөхөрч гүйцэхгүй

Сэмэрч уйлсан ч

Цөмөрч ойчихгүй

х х х

Чамайг бага багаар санах гэж

Сэм сэмээр мартах гэж би амьдрана

х х х

Чамд хэлэхгүй үгийг чи битгий сонс

Чамайг бодохгүй биш бодно

Гэвч бас л үл хэлнэ

Чиний сайхан бүхнийг

Санах,бас муухайг үл мартах

Чамайг өрөвдөнө,бас өширнө

Чамд уурлана, бас уучлана

Би хавар ургасан доройхон яргуй

Хатсан хөрсний ядуухан яргуй

Ханш нээхэд өрсөж дэлбээлсэн яргуй

Би хаврын хаварт

хамт л шингэх яргуй

Би яргуй дэлгэрэх цагаар төрсөн

Би яльгүй ихэмсэг дүрээр өссөн

Би яахын аргагүй эмэгтэй хүн

Би яалтч байхгүй гэнэн бүсгүй

2008- 5- 16

х х х

Би өөрийгөө биш байхыг

Хармааргүй байна

Би өөрийнхөө бие сэтгэлийн

Боол нь баймаар байна


Би зүгээр л нэг амьдармаар байна

Бие сэтгэлээ жаргааж

нэг адармаар байна

Байн байн баясаж амьдармаар байна

Барьж тавьж бас итгэж жаргамаар байна



Банзрагчийн БАЯРМӨНХ

Боржигин овогт Банзрагчийн Баярмөнх 1980 онд Баянхонгор аймгийн Баянхонгор суманд төрсөн. Хөгжимчин мэргэжилтэй. “Боржигидай сэцэн” наадмын Гутгаар байрны, “Вансэмбэрүү” наадмын тусгай байрны шагналт.

МЯНГАН ЖИЛИЙН ӨМНӨХ МИНИЙ ХОЙД НАС

Оршил нь биш байсан

Ургаж буй түүнтэй

Хээрийн салхиар исгэрэн хүүрнэх

Урьд хожидын тэр үлгэр

Шөнө гэгч байгаагүй тэнд

Өглөө гэдэгт сэрж үзээгүй гэнэ

Өдөр гэж төсөөлөхөд хэцүү

Үдшийн завсарт өгүүлэх домогт гардаг

Урсгал усны төгсгөлд дуслах

Мянган жилийн өмнөх

Миний хойд нас

XXX

Би чиний хүсээд ирэхгүй

жаргал чинь байя

Би чиний зүхээд холдохгүй

зовлон чинь байя

Би чиний буцаад олдохгүй

хайр чинь байя

Би чиний бухимдаад дийлэхгүй

уур чинь байя

Би чамд үүл шиг үзэгдэж

салхи шиг хийсье

Би чамд үлгэр шиг оршиж

зүүд шиг замхаръя

Би чамд сэтгэл шиг шингэж

зүхэл шиг хөөгдье

Би чамд чөтгөр шиг ойр

Бурхан шиг хол байя...

XXX

Уучлаарай энд амьдрал байсан юм

Удалгүй мөхөл болсон

Яг энд байсан юм

Яагаад тэгсэнийг хэн ч мэдэхгүй

Тэгээд тэд зугтсан

Тэнд хэнч үлдээгүй

Надаас өөр бусад нь

Нам гүмхэнд уусан одсон

Эргээд ирэх байхаа

Эндээ л байж байя

Хэзээ ч мандаагүй нарны

Туяаг унттал хүлээж л байя

XXX

Битгий ойлго

Би хүсэж байна

Хэн ч анзаараагүй

Бүгд инээдэг

Би дотроо уйлдаг

Үзэн ядах

Хайрладаг түүнийг...

Орчлонгоос зугтаадаг

Хорвоо жижигхэн

Тэр бас хөөрхөн

XXX

Холын хол тэр дурлалд

Би дурласан

Хожим учрахгүй ч

Дандаа зүүдлэдэг

Царайг нь хараагүй ч

Цаанаа л хөөрхөн

Цаашаа явахдаа

Эргэн эргэн харсан

Хэзээ нэгэн цагт заавал ирнээ

Гэж хэлчихээд...

Хүлээнээ хүлээнэ гээд

“Хоршоо Дэрэм”ийг чинь

Сонссоор суугаа шүү би

XXX

Нулимсан бороонд норсон болжмор

Үүрээ олохгүй сандран чичрэнэ

Нурсан сэтгэлд дарагдсан бодол

Амилах гэж ядан өндөлзөнө

Бороо татарч гунигийн нар ээхэд

Болжмор үүрээ мартан

өөрийг даган ниснэ

Нурсан сэтгэл, норсон үүр тэр үед

Бүлээцэх гэж бядан уйлагнана

Ниссэн болжмор эргэж ирэхгүй ч

Цаг хугацаа жамаараа эргэнэ

Сэтгэл үүр хоёрт нэг л өглөө

Өөр нэгний зүүд нисэн ирж жаргана

Үүрээ орхисон болжмор

Өвлийн жавартай мөргөлдөн

доош унахад

Тоссон мөс орхисон үүрнээс хатууг

Унасан хойноо ч үл мэднэ

САРЫГ ХАЙГААД...

Уйтгар дүүрэн шөнө

Сарыг хайгаад олсонгүй

Уйлаад унагасан нулимс

Шүүдрийг хайгаад олсонгүй

Сар шүүдэр хоёр

Чамтай байсныг мэдсэнгүй

Саваагүй нэгэн тэнгэр

Чам дээр унагасаныг мэдсэнгүй

Чиний гэзгэнд сар унажээ

ДУРЛАЛ ШИГ...

Дурлал шиг арз

Зураг шиг инээдтэй

Зовлон шиг ходоод руу

Зүсэх шиг орно

Зүүд шиг бодол

Зэрэглээ шиг дуниартан

Уйтгар шиг хундаганд

Дуу шиг дүүрнэ

2010-он

ЗАМЫН ЭЦСЭЭС БУЦЛАА...

Явах замын эцэс...

Эндээс би буцлаа

Явган мөлхөх яаруу хорвоо

Надаас зуурч чирэгдэнэ

Урд урьдахын шинэ зам

Ухарч гиюүрхэд уйтгар нүүрлэнэ

Удаан хүссэн мөрөөдөл

Уулын цаагуур шингэхэд

Ард үлдсэн үйл

Намайг хараад гэгэлзэнэ

2011-01-05

~~ТҮҮНИЙ ХАЖУУД БИ~~

Төөрсөн тэр улбар манан

Үзэгдэх төдий орчлонгийн

Ёроолгүй ангалд

Түүний хажууд бүх юмс

Тод агаад цэлмэг

Алс холын тэр цөхрөл

Түүний хажууд би...

2010-07-06

XXX

Уучлаарай энд амьдрал байсан юм

Удалгүй мөхөл болсон

Яг энд байсан юм

Яагаад тэгсэнийг хэн ч мэдэхгүй

XXX

Тэгээд тэд зугтсан

Тэнд хэнч үлдээгүй

Надаас өөр бусад нь

Нам гүмхэнд уусан одсон

XXX

Эргээд ирэх байхаа

Эндээ л байж байя

Хэзээ ч мандаагүй нарны

Туяаг унттал хүлээж л байя

XXX

Сэтгэл гэгэлзэх тэрхэн агшинд

Чи бодолд ургана

Сэтгэл огших торгон мөчид

Чи зүрхэнд бадамлана

Ай бүсгүй минь...,

Бүлээн цусаар минь гүйнэ

Ай бүсгүй минь...,

Бүх биенд минь шингэнэ

Бүсгүй ертөнц дундаас

Ганцхан чи

Сэтгэлд цацарч

Зүрхний зайд оршино

XXX

Бутран малгайлах шүхэр цасан

Гунигийн дуутай зөөлөн газардахдаа

Сэтгэлд нэгийг шивнэнэ

Буцааж болохгүй түмэн алдаа

Буурал хорвоогийн цээжинд

Өнгөрсөн цаг дээр тоологдоно

Гашуунаар

XXX

Будран хаялах цагаахан цасан

Жаргалыг эрэн жавартай газардахдаа

Надад нэгийг өгүүлнэ

Эргээд ирэхгүй тэрхэн амьдрал

Энэхэн шөнийн зүүдэнд ирэх нь

Ирээдүй цаг дээр тоологдоно

Жаргалтайгаар

XXX

Бүчин лавсах эмзэгхэн цасан

Бүлээн хацар дээр унан урсахдаа

Надаас нэгийг нэхэн уйлна

Буруу зөвийг эс ялгах миний л амраг

Бусдын дунд инээмсэглэн алхах нь

Одоо цаг дээр тоологдоно

Гунигтайгаар

XXX

Тэр жилүүдийн амьдрал

даан ч богинохон байж

Тэнд эдэлсэн жаргал

дэндүү амттай байж

Тэвэрч өнгөрүүлсэн шөнүүд

хэтэрхий цөөхөн байж

Тэнгэрт мандсан нар

чиний хайраас хүйтэн байж

Чихэнд хөгжим чанга сонсогдох нь

хэн нэгний жаргал

Сэтгэлд эгшиг нь зөөлөн урсахуй

миний тамлал

Үзэн ядалт буцлах нь

хэнийх ч биш

Үргэлж өөрийгөө зүхэх

минийх биш

Чамайг хайрлах нь

хүнийх биш

Чимээгүй надад эрхлэх чинь

чөтгөрийнх юм

Чи зүрхэнд орших чинь

хараалынх юм

Чихэнд чийртэй инээмсэглэх чинь

шуламынх юм

Чамайг би эдлэх нь

тавилан юм

XXX

Ихэр хоёр голын урсгал

Эцэг уулын энгэрт

Зэрэглэн урсах лугаа

Ээжийн минь

салаа хархан гэзэг

Идэр залуу насанд нь

Аавын минь энгэрт

Аясын салхиар

Эрхлэн байсан биз

XXX

Нар мандахаараа мандана

Би сэрдэгээрээ сэрнэ

Цаг явдагаараа явна

Би шаналадагаараа шаналана



Ганбатын БОЛОРСУВД

Боржигин овогт Ганбатын Болорсувд 1988 онд Төв аймгийн Баян суманд төрсөн . Бүрэн дунд боловсролтой.

ЧАМААСАА АСУУЯ

Би чамайг хүлээсээр...

Бие сэтгэлээрээ шаналсаар

Орчлонгийн одод бүхнээс

Он цагийн тоолол бүхнээс асууя

Гараасаа хөтлөлцөн явсан

Гэгээлэг орчлонгоос асууя

Гэрт минь хүргэж буцдаг

Гэрэлгүй гудамжнаас би асууя

Дурсгаж өгсөн зурагнаас чинь асууя

Дурлалдаа шатсан зүрхнээсээ асууя

Дахин учраагүй чамаасаа асууя

Одоо чи минь хаана явна

Орчлонг туулах хайр минь хаачив

БОЛЗОО

Энэ зун ингээд салъя

Ирэх зун эргээд уулзъя гэж

Энүүхэндээ чи бид хоёр

Эвлүүхэн болзоо тавьсан

Тавьсан болзоо минь чиний төрсөн өдөр

Тогтоож авсан гэж найдъя

Чимээ сураггүй их л удлаа

Чи минь намайг мартаагүй гэж

Найдъя

ХАЙР

Чи миний амин хайр

Чин зүрхний нандин хайр

Амьдралд миний анхны хайр

Ахин олдохгүй ариухан хайр

Энэ биений эхний хайр

Эмзэг зүрхний эцсийн хайр

Хайр хайрын дээд болсон

Хонгор чи минь миний хайр

ХОРВОО

Амьдрал гэдэг хатуу юм

Амьдрах гэдэг жаргал юм

Хүн амьдралд алдаж энддэг ч

Хэзээ нэг өдөр жаргадаг

Ядуу байлаа гээд гутарч болохгүй

Яахав дээ энэ бодот амьдрал

Арчаагүй замаар явлаа ч

Амьдралыг чи үзэн ядаж болохгүй

Анхны хайр чинь бүтээгүй ч

Ахиад чамд жинхэнэ хайр ирнэ

Би энэ амьдралдаа гутрахгүй

Бүтэхгүй ч гэсэн

энэ амьдралдаа хайртай

Бүлээхэн зүрхнийхээ эрч хүчээр

Оюун ухаандаа

шүлэг тэрлэх дуртай

Яахав дээ би чаддаггүй ч гэлээ

Яруу найрагаараа тайтгарч

Үзэг цаас нийлүүлж

Үйлтэй энэ амьдралын

Үнэнийг бичих дуртай

СОЛИЛЦОО

Амьдралд хөл тавьж

охин минь мэндэлсэн юм

Амьдрал үнэхээр хатуу болохоор

Ахыг минь зөрүүлээд аваад одсон

Нэг нь ирж жаргал бэлэглэхэд

Нөгөө нь бурхан боллоо

XXX

Хайрт хүү Сэргэлэнбатдаа

Сайхан хайрын бурхан

Ээж аавын эрдэнэ

Романтик хайрын илч

Гэгээлэг хайрын

Эзэн болсон үр минь

Лааны гэрлийн гэгээ минь

Эмээ өвөөгийн

Насыг уртасгаж

Баяр нэмж байгаа

Алдрай үр чамайгаа

Төрийн тэргүүн

болоорой гэж ерөөе

XXX

Нүдээрээ чи намайг хайсан

Нүүдлийн шувууд шиг чи ирсэн

Хайраараа би чамайг дуудсан

Хаврын шувууд шиг чи ирсэн

Шувууд буцахаас хайр буцахгүй

Шүүдрийн усанд

сэтгэл хоргоддог шүү



Бямбадоржийн МӨНХ-ӨЛЗИЙ

Г.Сэр-Одын нэрэмжит шагналт яруу найрагч Таван гучид овогт Бямбадоржийн Мөнх-Өлзий нь Дундговь аймгийн Гурвансайхан суманд 1978 онд төрсөн.

Дүрслэх Урлагийн дээд сургуулийг зураачаар төгссөн. “Гүнж өнгө” яруу найргийн номоо хэвлүүлсэн бөгөөд “Хайрцаг” драмын жүжигээ тайзнаа толилуулжээ. “Боржигидай сэцэн” наадмын Дэд байрны шагналт. МУ-ын Соёлын “Тэргүүний ажилтан”, Үйлдвэрчний эвлэлийн Соёлын “Тэргүүний ажилтан”

ӨДНӨӨС ХӨНГӨН БОДЛУУД

Өднөөс хөнгөн бодлууд сэтгэлдээ хөвүүлээд

Өөрөө би чулуунаас хүнд

Өнгөнөөс тод хорвоод гэрэлтэж асаад

Өөр ертөнцийн тухай сүүдэртэй бодолд автана

Аяар аяархан бүйвээн дуунд уяраад

Амандаа жаргал хүлхэж нялхарсан

Өд шиг хөнгөн биетэй

Чулуу мэт бодол болдоггүй байхдаа

Өнгөт хорвоогийн гэрэл сүүдрийг

ялгадгүй байхдаа

Өөрийнхөө ээжийг л таньдаг байж дээ

ВААРТАЙ ЦЭЦЭГ

Өвөл даарч мэдэхгүй өнгөөрөө

Өвс болж өтлөхгүй мөнхөөрөө

Хааяа нэг гуниглан дэлбээгээ сэгсэрдэг ч

Хаад ихэс шиг халамжаар хучаастай

Хотын чимэг ваартай цэцэг

Цонхоор ширтээд

Холын зочид будрах цасанд

Шохоорхол шивнэнэ

БИД ОЛУУЛАА

Хананы цаана хамаг хэрэг мандана

Хана бас тэгтэл чихтэй гэнэ

Хананы цаана муухай, бас

муухайгаас нуугдана

Хана бас тэгтэл нүдтэй болчихсон

Дулаахан бас хүйтэн

Дуу нэвтэрдгүй бас нэвт дуулддаг

Гэрэлтдэг шилэн бөгөөд гэгээ сайн ордог

Гэмт хэрэгтэнийг чандалсан харанхуй

Мянга мянган ханаар салж одоод

Одоо бид өөрсдийгөө олуулаа гэдэгт итгэнэ.

ШИНЭ ЖҮЖИГ

Шидэт ундаагаар цатгалдсан

Шилэн савнууд гоёлоо гайхуулцгаан

Ширээн дээр ордны

шадрууд болж эгнээд

Шинэхэн тавигдах

жүжгийн тухай маргалдана.

ХҮН ТӨРХ

Алтан нөмрөгтэй адуу байхад

Амгай зуусан хүмүүн байна.

Халхамж оромжинд халууцаж байхад

Хааны ордонд даарах нь ч байна.

Сэтгэл түүгээд бөгтийн бөгтийн бөртөлзөхийг

Сэрүүн зүүдлэгчид ядуу гэнэ

Бодол тэгээд богшин богшин огшихыг

Боломж хайгчид бядуу гэж боорлоно

Агаар ус адилхан хүртэвч

Араншин төрлөө алс гэж арцалдана

Би үгүй хоёрын дундуур

Бие биенээ элэглэнэ бидний хүн төрлхтөн

ЧОЙРЫН БОГД ХАЙРХАН

Тэнгэрээс газарт шивнэсэн ном

Газраас тэнгэрт шившсэн нум

Талаас хойморт дээдэлсэн сүм

Хоймроос хийморьт түгээх сум

Нар зөв эргэсэн дөрвөн улирал

Нас зөв мөргөсөн дөрвөн бэрх

Галав эртийн дөрвөн цаг

Газар тэнгэрийн дөрвөн хүчтэн

Тамгатны орой арслан уул

Тахилгатны орой гарьд уул

Хүчийг бэлгэдэгч барс уул

Лусыг эзэгнэгч луу уул

Болж бүтэхийн ерөөл дэлгэсэн

Богд дөрвөн хүчтэн

Боржигин нутгийн шүтээн

Босоо дөрвөн хүчтэн уул

Үүлэнд үнсүүлсэн уулын

хийморь цагаан оргил

Үерийн их ус болон

уралдан урсах цагт

Тал нутаг танихгүй

цэцэгсээр дүүрээд

Таньдаг байсан чамаас би төөрнө.

Тэр үед тэнгэрт ойрхон байсан

цасан сэтгэл

Гэссэндээ гэмшин

гэрэлт зүсээ алдахад

Цэцэгсийн цэвэр ичэмтгий

чимэг алдарч

Цэнгэлийн нас богинохон

болохыг дуулна.

ЗУЛ БАДАМЛАНА

Наранд шаргалтах өвсний ширхэг болгоны тэргүүнд

Найраг дууны өнгөтэй гэрэлт зул цацрана

Насан залуу сэтгэлтэй зүрх бүхний цохилоонд

Нандин хайрыг дуудсан гэгээн хүсэл бадамлана.

Бадамлах зүрхэнд ассан гэрэлт аялгуун чимээ

Бардам зүстэй бүсгүйн гэнэн сэтгэлд шивнэхэд

Өнгө баян хорвоо өөр хоорондоо сүлэгдээд

Өлзий утсаар угалзран өнийн зүгийг чимэглэнэ

Наранд шаргалтах өвсний ширхэг болгоны тэргүүнд

Найраг дууны өнгөтэй гэрэлт зул цацрана.

2011 он

ШИЛИЙН БОГД

Морин туурай шиг

Шилийн богд уул

Монгол нутгийн хийморь

Шинийн гурваны сар

Сайн үйлийн гэгээ

Саар муугийн гэсгээл

Савдагтай догшин уул

Салхитай өндөр хайрхан

Зовсон ардыг өмгөөлсөн

Зоригтон эрсийн өргөө

Эх орон монголынхоо

Эрдэнэ, хил шил уул

Халдсан дайсанд хатуу

Халуун сэтгэлтэнд зөөлөн

Хадган дээр залсан

Хавирган сар, нар, гал уул

Гадагшаа хурцалсан

Ган хушуутай гарьд уул

Дотогшоо дэлгэгдсэн

Домогтой ембүү уул

Мандах нарны туяанд

Жануйн малгай шиг гэрэлтэж

Мандах төрийн сүлдэнд

Жаргалын далбаа шиг цоролзож

Мал сүрэг адуугаа

Мартуулаагүй хэрэм уул

Манай өвөг дээдсийн

Манжаас хамгаалсан шилийн уул

Ширүүн түргэн эрсийн

Овог болсон шилийн уул

Шийд муутай ноёдын

Бодол үймүүлсэн богд уул

Омогтныг огшуулаагүй

Оройтныг богшуулаагүй

Харийн ноёдод хажиг

Халхын хаалга хар суварга уул

2008.

БААТРУУДЫН СҮНС

Өглөөхөн өргөн тэнгэрийг туулаад ирсэн

Харийн үнэртэй салхинд

морьд уруудаад зогсчихож

Өвлийн жаврийг цуучин дүүгэлдэх

хар цагаан үүлс

Хааяа нэг шинэ хурын

үнэр сэнгэнүүлээд өнгөрөх нь

Баруун хойш одсон баатрууд

Хэц хэнгэргээн дэлдээд

дэргэтэл эргээд иржээ

Өглөө өргөн тэнгэрийг туулаад ирсэн

Харийн үнэртэй салхи

Өвсний нөмөрт хөлдсөн нялх ногоодын

сүнсийг тээгээд иржээ.

ЦАСНААР

Цаснаар ганц хүн алхана

Цагаан дээр зурсан хар цэг болохоор

Цаглашгүй эрх чөлөөтэй алхана

Атаатай амьдардаг адил төрөлтөнгүүд нь

Харагдахгүй болохоор

Ариусаж байна гэж андуурна

Алаг эрээнд аргасан нүд нь

Амарсан болохоор азтай

Цаснаар ганц хүн алхана

2008

ХАЙРХАН УУЛ

Тэнгэрээс газарт шивнэсэн ном

Газраас тэнгэрт шившсэн нум

Талаас хойморт дээдэлсэн сүм

Хоймроос хийморь түгээх сум

Нар зөв эргэсэн дөрвөн улирал

Нас зөв мөргөсөн дөрвөн бэрх

Галав эртийн дөрвөн цаг

Газар тэнгэрийн дөрвөн хүчтэн

Тамгатны орой гарьд уул

Тахилгатын орой арслан уул

Хүчийг бэлгэдэгч барс уул

Лусыг эзэгнэгч луу уул

Болж бүтэхийн ерөөл дэлгэсэн

Богд дөрвөн хүчтэн

Боржигин нутгийн шүтээн

Босоо дөрвөн хүчтэн уул

xxx

Дурлалы дуу боловсорч

бүүвэйн дуу төрөхөд

Гиюүрэхийн зовлонг элээж

даврахын шаналан босно

Дундуурхан гунигтай мөчийг

дуугаараа үргээж

Нялх үр гижигдэх мэт өнгө орно



Төмөртөгогийн ЭРДЭНЭБААТАР

Яруу овогт Төмөртөгогийн Эрдэнэбаатар Төв аймгийн Баян суманд 1977 онд төрсөн. Төмөр замчин. “Үнэр”, “Хадан ой” яруу найраг, “Айлгах аавтай арслангийн зулзага 1,2” хүүхдийн шүлгийн номоо хэвлүүлсэн. Төмөр замчдын “Ган үзэг” яруу найргийн наадмын Тэргүүн өргөмжлөлт.

БИД ХОЁРЫН

Бид хоёрын

Бие биендээ хэлдэг хайрын үгэнд

Балчир ногоон дэлхий

Будлихгүй эргэж байдаг юм хайраа

Цалгилах их далайн дэргэд чамтай хамт суугаад

Цангаж үзмээр байна нүдэн минь

Бид хоёрын

Бие биендээ хэлдэг хайрын үгэнд

Огтор цагаан шөнөтэй

Орчлон урт насалдаг юм хайраа

Цаг хугацааны цаанаас эргэх

Цайрах бороонд үнэгчлэж үзмээр байна сэтгэл минь

Бид хоёрын

Бие биендээ хэлдэг хайрын үгэнд

Уулсруу санаа алдсан

Удган модны мөчир нахиалдаг юм хайраа

Тэнгэрийн бодол унших

Тэнэмэл салхинд хашгирмаар байна хорвоо минь

Бид хоёрын

Бие биендээ хэлдэг хайрын үгэнд

Надад цагаан тунирхсан

Нарны сэвх арилдаг юм хайраа

Аз жаргалын үзүүрээс атгаж

Аархахдаа тэнгис дээгүүр харайж үзмээр байна

совин минь

Бид хоёрын

Бие биендээ хэлдэг хайрын үгэнд

Тогоруун дуугаар үдүүлсэн

Төөрөлдсөн он жилүүдийн ааш нялхардаг юм хайраа

Танил биш хувь заяагаа

Тэвдэж зогсохыг хармааргүй байна өчигдөр минь

АЛАГ ХАВ

Аз жаргалаас гинжлүүлсэн

Алаг зүстэй хав

Нойтон зүүдээ эргэхдээ

Нарны утсаар нэхсэн хивс нөмөрнө

Сүүлээрээ айдсаа аргадаж

Сүүдэртэйгээ сүүж булаацалдан

Сүрэг өдрүүдийг үднэ

Хонхны инээх дуугаар

Хоноглох зочинг танина

Эзэндээ илгэн шаахай дөхүүлж

Элгэнд нь эрхэлж шагнуулна

Хоймрын бурхад бухимдуулсан

Хонгор ятганы гиншилтийг

Халбаган чихнээсээ сэгсэрч

Хорвоогийн шөнийг барна

Нүцгэн нүгэл ширтэн

Нүдээ дасгасан хав

Ноёны өргөө рүү ноцох

Ноолох салхи үгүйлнэ

ЗАГАСЧИН

Замаг ширэлдсэн нуур

Загасчны дэгээ үмхэнэ

Зүхэлээ утсан өгөөшнөөс

Загас хавч хавчигнан

Зүүдэнд агнасан загас

Зуухны бөөрөнд эрхэлнэ

Үүргэлх загасчны дэгээ

Үдшийн сар гогодно

НАМАР

Тураг бор гөрөөс

Тунимхай сэтгэлдээ хөтлөгдөн

Тугалган сарны зүг

Туулайн жимээр цогино

Нахиагүй цантай мөчрөөр

Нар өдсөн мод

Намбагүй намар царайчлан

Навчсаараа гунигаа хөнгөлнө

Удган хөх тогоруу

Уулын хяраар тэнүүчлэхдээ

Уртаар санаа алдан

Уул цөмөлмөөр гишгэлнэ

Хээлэндээ тээсэн согоог

Хэвтрийн өвснүүд тохуурхан

Тугалынхан хөлд үрэгдэх

Танил төөргөөсөө цочино

Охидын инээд рүү тонгойх

Оддоор цоохортсон тэнгэр

Орчлонгоос намар буцахыг

Овоггүй цэцгэнд л дуулгана

ЧАМД

Чиний өргөс орсон орон зайг

Мойног хуруу зөөлөн гунигаар чичлэн

Өдөөр эрхлүүлэх шинэхэн амрагаа

орчлонгийн мухраас эрэв

Чамд би тунихдаа

Чиний эмзэглэл дуслуулж одсон

зээрэн зөргөөр

Тугалган од хөндүүрлэн ширтэх бүрэг үдэш

Сэтгэлдээ эвлүүлсэн гэрлээр

цаг хугацааны өнцөг

Булан бүрийг тэмтрэв

Чамд би тунихдаа

Өндгөн сартайд дэвүүрээ нөхсөн

цагаан эрвээхий

Мөлхөө уруулын янзаган толбоор

зайгүй бөгжлөн

Ураг барилцсан тэнгэрийн солонгыг

бачимдахдаа хөвлөө

Чамд би тунихдаа

Чиний үнэгэн харцаар хоосолсон

эвэр хундагаар

Нарны булгаас хутган гэнэн бодлоор үерлэх

эрхэмсэг бүсгүйн инээдтэй тулган

Самуун салхи аяны богцондоо дүүргэн

шөнө уртыг гайхав

Чамд би тунихдаа

Хэнзхэн учралд торойсоор бүдэгрэх

хуримын өдрөө

Чиний гоёлын үгээр нэвширтэл будаад

Сүүдэр нь хөлд тээглэгдэх үхэр чулууг

хагацлаар хагалав

Чамд би тунихдаа

Хатгуураа даахгүй хэдгэнэд

тавиланг нь үүрүүлж

Холтос нимгэрсэн өмрөх модны үзүүр лүү

Хөхүүл шаргачин ховсдсон

шивэгчин шумуулаар дөхүүллээ

Чамд би тунихдаа

Багахангай. 2010-он

ӨВГӨН ЗАМЧИН

Нарны гэрэл гулгаж ханаагүй харгуйг

Насаараа манасан өвгөн замчин

Галуун хүзүүт царил мөрлөн

Ган цагираг домнон зангидна

Цэнхэр зэрэглээнд яарсан өвгөн

Цэцэг зүүдэлсэн нойроо ивэлгэж

Намбагүй хөх униартай

Найргийн талыг сэрээнэ

Далавчаа даахгүй бүргэдийн

Дэвүүр харцандаа өтөлж

Давж чадаагүй уулсынхаа

Нөмгөн бодлыг уншина

Толгод чичрээсэн зэвхий салхинд

Тоорцоггүй мөртлөө өвөл аргадна

Гоё эгшигээс бүрдсэн

Горхины явган харгиа

Өвгөн замчинг бараадан

Өвөр дээгүүр нь урсана

Угтаж олон өнгөрөх

Уулын хормой ачсан

Уухилах галт тэргийг

Зогсоох хүсэлгүй

Өвгөн замчин

Зоос ташуурдан

Өтлөх эрхгүй

ХҮРЭЛ ХӨШӨӨ

Зурмал цэцэгтэй

Зун

Зулзага зүлэг нь ширэлдсэн

Цөөвөр салхинд эрхлэх

Цогших хүрэл хөшөө

Мөргөх тэнгэрийн сүмд

Мөшгөх сүүдрээ таньсан

Мөргөлчин хөвгүүнээр

Мартагдсан он жилийн дарааллаас

Манантай хуудсаа сөхүүлэн

Гэрлээр хуурах оддыг

Гэрийнхээ туурьд хөглөрүүлсэн

Зоримог залуу насруугаа

Зогсоо энэ л өдрүүдээ

Зүүдээрээ зөөхөөр зэхэвч

Цагаан зам татуулан

Өвс чулуу чирсэн

Цамнах хүрэл хөшөөний

Цутгамал царайг зэврүүлж

Болор үдшийн болзоонд

Бодолоо таалцах амрагууд

Бурхан өдрүүдийн урсгалд

Богших сэтгэлээ

хоничлон хариулахад

Хөшүүн хүрэл хөшөө

Хөлийнхөө мөрийг эрнэ

2011-04-25

БҮСГҮЙ ЧАМААР

Гэрэлт уруулаар

Гижиг урсгах

Бүсгүй чамаар

Хоногшсон өдрүүдээ

Үүр цайлган

Хувь зохиолд

Чамайг зурах

Зав гаргая

Орон зай

Гуниглах сэлүүхэн

Орчлонд чамд

Сэтгэлээ дэвсье

Хуримын бөгжөө

Хуруунаас чөлөөлж

Хоноцынхоо ширээн дээр

Хайраараа аргамжиж

Гээзэг задалсанаа

Нарнаас нууж

Гэрлүүгээ зүглэхдээ

Өчигдөрөө сугавчил

2011-он



Хишигийн ЧУЛУУНБААТАР

Хатагин овогт Хишигийн Чулуунбаатар нь 1959 онд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд төрсөн. Боловсрол дээд. Үйлдвэрчний эвлэлийн “Тэргүүний ажилтан”

НУТГИЙН ХҮН

Тосон Боржигин нутгийнхаа

Тоосон дунд нь өссөн

Тормолзсон алаг нүдтэний

Хайран дунд жаргасан

Би нутгийн хүн

Оцол Сансар уулынхаа

Оройг нь харж мөргөсөн

Олон түмэн ардынхаа

Итгэлийг нь дааж амьдарсан

Би нутгийн хүн

Дархан Сүмбэр, Далан түрүүнийхээ

Хормойг нь тойрч нутгалсан

Давхиулсан олон морьдынхоо

Уяа сойлгыг нь тааруулсан

Би нутгийн хүн

Чойрын Богд уулынхаа

Хийморь лундааг өргөсөн

Цогчин дуган сүмийнхээ

Суурийг нь сахиж үлдсэн

Би нутгийн хүн

БИ ТҮҮХ

Эргэх энэ дэлхийдээ

ирж яваа минь түүх

Эрх тусгаар Монголдоо төрж

мэндэлсэн минь түүх

Ээж бурхантайгаа

амьдарч байсан минь түүх

Эхнэр шүтээн дарь эхтэйгээ

эрхэлж байсан минь түүх

Энхрий бяцхан хүүхдүүдтэйгээ

хөтлөлцөж явсан минь түүх

Эрхэм олон нөхөдтэйгээ

найрлаж суусан минь түүх

Эмнэлэгийн хатуу орон дээр

үхэж байсан минь түүх

Эрлэгээс зөвшөөрөл аваад

сэхэж байсан минь түүх

Эх оронч Дашбалбартайгаа
нэгдэж байсан минь түүх
Элэнцээс үлдсэн газар шороогоо

харамлаж байсан минь түүх

Эх орноо худалдсан ноёдыг

айлгаж явсан минь түүх

Элгэн олноо өмөөрч

эмтэрч байсан минь түүх

Эх орноо хамгаалж

тэмцэж явсан минь түүх

Энэ олон түүхийг минь

сүнс минь аваад явна

Эрлэгт очоод харин

эрхэмсэг дээгүүр амьдарна

Энэ замбуулин тивээ

эргэж тойрч амьдарна

Эх Монгол орноо манаж

хамгаалж амьдарна

Элгэн олон түмнээ ивээж

тэтгэж амьдраад

Эргэх энэ дэлхийдээ бас эргээд ирнэ

Энэ л бяцхан түүхээ

эргэж ирээд үргэлжлүүлнэ

НУТГИЙНХАНДАА

Хардал бэйс, Егүзэрийн унаганууд нь

Харайн тоглож давхисан

Хатигины талаа бүү зовоо

Харь элэгтэнгүүдийг дээгүүрээ гишгүүлдэггүй

Хатан Чоно голоо битгий ширгээ

Егүзэр эрдэнэ мэргэн хутагтын

Ерөөл тавьсан тал шүү тэр тал

Есөн эрдэнийн орныг минь

Ертөнцөд хамгаалж урсдаг гол юм шүү

Домогт шилийн сайн эрчүүд нь

Довтолгож явсан тал шүү тэр тал

Дархан Монгол орныг минь

Давхар хамгаалж урсдаг гол шүү

Дайсан бүгдийн хар хорыг дарж

Түмэн олондоо тусалдаг байсан

Дамдин бишрэлт дүвчин хувилгааны

Тарнидаж үлээсэн шороо шүү тэр хөрс

Зотол хан, Цагаан овоогоо эмзэглүүлж

Чоно гол, Уртын голоо зовоож

Зоосны нүхээр та бүгд харвал

Зовлонгийн далайд унахдаа адилаа

Хайрлаж хамгаалж харин чадвал

Халзан ширээт хувилгаан ламын сүнс баярлаж

Хаан Тэмүүжин хурмастаас ивээж

Хамаг бүгдээрээ жаргах болноо,

Миний нутгийнхан

Хурай хурай хурай

Булганд хоносон 3 өдөр буюу Дөш хурандаа-д зориулав.

“БОРЖИГИН ЭРЭЭН АСАР”

Боржигиноос ирсэн хүүхдүүдийг өлгийдөж оносон

Булган нутгийн илчийг цацрааж боссон

Буурал боржигидийн түүхийг өгүүлж хоносон

Босоо хийморьтой боржигин нутгийн эрээн асар

Ардын хатан баатар вангийн нутагт ирсэн

Арван найман аймгийн арслан барууд болсон

Армийн бэлтгэл ахлах офицеруудыг айлгаж хоносон

Босоо хийморьтой боржигин нутгийн эрээн асар

Будант хангайн гавьяат дуучныг уярааж дуулуулсан

Булган Эрдэнэтийн алдартнуудыг цуглуулж авчирсан

Боржигин наадмыг мэдрүүлж хоносон

Босоо хийморьтой боржигин нутгийн эрээн асар

Элэнц хуланцынхаа суурийг эзэлж

Эрэлхэг хэвтүүлүүдээр өөрсдийгөө хүрээлүүлж

Эзэн богд Чингис хааныхаа сүрийг үзүүлсэн

Босоо хийморьтой боржигин нутгийн эрээн асар

Хатагин овогтнуудаар тулгуураа хийж

Хос тугнуудаар гангарч ялгарсан

Хорин нэгдүгээр зууны жинхэнэ монгол төрх

Босоо хийморьтой боржигин нутгийн эрээн асар

Хурдан морины гийнгоон дээр эрээн асар

Хурц сумны үзүүр дээр эрээн асар

Хүчит бөхийн цолон дээр эрээн асар

Хөх Монголын наадмууд бүгд эрээн асар

Замбуулин тивд би монгол гэж уртын дуу минь цуурайтна

Замбуулинд би монгол гэж морин хуур минь хүнгэнэнэ

Замбуулин тивд би монгол гэж өргөө цагаан гэрүүд яралзана

Замбуулин тивд би ч бас монгол гэж

Боржигин эрээн асар намиран уухайлна

2013.08.04.

“ХАС” Чука анд нь.

МӨНХХАЙРХАН

Шилийн богдын төрсөн дүү

Шивээт талын ноён оргил

Шинийн нэгэнд хийморь бэлэглэдэг

Шидэт хувилгаан сүрлэг хайрхан

Хүрийн ногоо хань ижилтэй

Хурмаст тэнгэр онгон сахиустай

Хаан төрийн түшиг тулгуур

Харуул зангиар тодорч тогтсон

Хан Чойрын богдын лүндэнгээр

Хамаг амьтаныг хамгаалж тэмцсэн

Хариас ирсэн дайсныг

Хиар цохьсон түүхтэй

Боржигин нутгийн

Босоо хар толгой

Буурал түүхт

Мөнх цагаан толгой

НАМАР

Над дээр унасан навчийг

Намар гэж хэлнэм

Надаар тоглосон хайрыг

Намар гэж хэлнэм

Найранд дуулсан дууг

Намар гэж хэлнэм

Надаас холдсон бүхнийг

Намар гэж хэлнэм

Нартад амьдарсан үеийг

Намар гэж хэлнэм

Надаас мөнхөд үлдэх

цаг хугацааг

Намар гэж хэлнэм

ХАРИЙНХАН ЯАХ ГЭЖ ТУСАЛДАГ ЮМ БЭ

Буурал дээдсээ хүндэлдэггүй

Бурхан шүтээнээ дээдэлдэггүй

Болчимгүй нэгэн болгох гэж

Харийнхан бидэнд тусалдаг

Хаан түүхээ мэдэхгүй

Хатан эх байгалиа танихгүй

Харанхуй бүдүүлэг болгох гэж

Харийнхан бидэнд тусалдаг

Харамлаж хайрлах газаргүй

Хамгаалж зогсох хилгүй

Харь хэлээр ойлгуулах гэж

Харийнхан бидэнд тусалдаг

Билиг танхай оюуныг минь

Бичиг үсгээ мэддэггүй

Бурангүй нэгэн болгох гэж

Харийнхан бидэнд тусалдаг

Өрөнд барьцаалан ядууруулж

Өвчинд баригдан шаналуулж

Өндийх чадалгүй болгож

Өөрийн нутаг болгох гэж

Харийнхан бидэнд тусалдаг

Энэ биеийг минь доройтуулж

Идээ хоолыг минь булааж

Ирээдүй үеийг минь эзэгнэх гэж

Харийнхан бидэнд тусалдаг

Аврал эрэх төргүй

Алхах гишгэх газаргүй

Амыгүй албатууд болгох гэж

Харийнхан бидэнд тусалдаг

Харийнханд битгий итгэ

П.БӨХБАТДАА ДУРСАМЖ

Алиахан багын хүүхэд насандаа

Айл саахалт үерхэж явахдаа

Анд маань түмэнд байнга

Алдарт Чойрын богдоороо

бахархаж явсан

Араатны хаан тэнгэрлэг

Арслан та болоорой уул минь

Амьтны хийморьлог сүлд

Азарган чоно нь би болно хүү нь гээд

Орой болтол теннисны вандан дээр

Омгорхон аархаж тоглож явахдаа

Ойр ойрхон, тойр тойр гэж

Одод онгон сахиусандаа

Тангараглаж байжээ чи минь

Алтан дэлхийд

Равжаагаас өөр нам хэрэггүй надад

Амиа тасартал найрагтайгаа явна би

Ардчиллаас өөр үзэл бодол

хэрэггүй надад

Ардчилагч нараас илүү

тэмцэж чадна би гэж

Боржигины бор толгод дундаа

Бурханлаг билиг танхай оюунаар

Бодлын таринаа тодхон уншаад

Бороогоо оруулсаар яваад өгсөн

Багахан түүхэн энэхэн үедээ

Бахархаж найзыгаа дурссаар

Балгасанд ургасан бут шиг

Барайж бүгдээрээ үлдсэн бид

Зуун зууны дараагаар

Зураг тавилангийн эрхээр

Зуурдын биш үүрдийн найзууд болж

Жаран жарныг туулах болно анд минь



Даваадоржийн РЕНЖИН

1942-2013

Харнууд овогт Даваадоржийн Ренжин 1942 онд Дундговь аймгийн Өндөршил сумын “Тасын долоод” гэдэг газар төржээ. “Би залуудаа” яруу найргийн ном бүтээжээ.

МИНИЙ ӨЛГИЙ ГОВЬ

Галав дамжин шаргалтсан их говийн өнгө

Газар болгондоо жаргалтай ирэх цагийн хуанли

Гаргуун ухаант мэргэдтэй говь шанхын хутаг

Галбираас модноос цэцэгс амилах алтан дуулгат өлгий

Түмэн зууныг элээсэн тэнгэр нь цэлмэг миний говь

Түүхийн хуудсанд шаралж үлдсэн төгөл

тоорын шугуйт говь

Түүж хураасан мөнгөн шүүдрээрээ түрхэж хурайлсан говь

Төгсгөлгүй хорвоогийн далайд тэмцэж хөвсөн

цорын ганц говь

Говийн тэнгэртээ гололж татсан өнгийн солонго

Газрын тэнгэртээ ургаж нахиалсан өнчин шүлэг

Гайхуулж дэлгэх номын ариун шашдир

Галба шанхаар овоглосон өмнийн цэнхэр говь миний өлгий

2009

ИХ ГАЗРЫН ЧУЛУУ

Ижий болсон нутгийн минь хойморт

манан татаж цэнхэртэх

Их газар уулын хийморь болсон

сүрлэг өндөр хайрхан

Ирэх гийчдийн амарыг асуусан

холын холоос санагдах

Ирсэн зочиндоо дэлгэх

мэндийн цэнхэр хадаг

Их газрын чулуу

Идэр залуу насны хүслийг татах

уулын мөнгөн чулуу

Ирэх зууны эхийг тайлсан

мэлмий чилээх их чулуу

Ирээдүй хойчийн сэтгэлийг мялааж

мэндийг илтгэсэн сүрлэг чулуу

Ирэх өвөлийн аясийг таах

шившлэгт хайрхан

Их газрын чулуу

Идэр аврага Хур харцагийн мэндэлж

өссөн өлгий чулуу

Ижий хайрыг орлох ивэлсэн

сүүний үнэртэй чулуу

Их сүрээрээ дэлхийд данстай

мөнхийн үзмэр чулуу

Ирвэс шилүүс дүүлэлдсэн

хадан өндөр чулуу

Ирсэн буцсан зочидийн зам сүлжин

зурайсан ханан их чулуу

Ирүүлж буцаасан сүүн цацалаан

сөгнөж хадгалсан

Үүр гэгээрэх мөнгөн туяатай нутгийн чулуу

Үүл баганадсан сүрлэг хадан уул

нутгийн чулуу

Их газрын чулуу

2006-4-23

МИНИЙ НУТАГАА

Сүүний үнэртэй агаараар нь амьсгалж

Сүүлний тостой толгодоор нь аргадуулж

Сүүдэрт талын уулсаар нь тэврүүлж

Шүүдэр асгам цэцэгсийн үнэрт өссөн

миний нутаг аа

Ээжийн энгэрээс унахдаа мэдэрсэн

Эцгийн хайраас өвлөхдөө тухалсан

Эрийн цээнд хүрэхдээ эрхэлсэн

Элсэн шаргалтах хөрс шороондоо

ээнэгшсэн миний нутаг аа

Тоост орчлонгийн тосон энгэр

Тойрогт амьдаралын тодхон бэлэг

Тохомын чинээ газарт нь ч гэсэн

Тоолж барахааргүй эрдэнэсийн сан миний нутагаа

МОНГОЛ ЭР ХҮН ЖАРГАЛТАЙ

Уул шиг нөмөртэй хонгор сайхан

Уулзаад мэндлэхэд итгэж уярмаар

Учраад танилцахад ханийн түшигтэй

Ухаант ард монгол эр хүн жаргалтай

Уян зөөлөн энгэрт нь салхи саатаагүй

Уужим тэнүүн өргөөнд нь жавар хоргодоогүй

Ухаан тэлэм бодолд нь хир суугаагүй

Урьтаж, бардаж дугарч яваагүй

Дуулсан дуунд нь хэцийн жавар бүлээсч байдаг

Дугарсан дуунд нь хээрийн боохой айн сүрддэг

Дуулим тал нутагтаа эзэн нь болж заяагдсан

Дуундаа жаргаж явдаг нь

монгол эр хүн байдагаа

Дайн тулаан тэмцэлд дийлж явсан өдөртэй

Дархан нутаг орноо

дээдэлж хамгаалсан түүхтэй

Даян дэлхийн цомогт

дээлтэйгээ гарсан зурагтай

ХОРВОО

Хорвоо уудам ч зүү орох зайгүй тавилан

Хорвоо уйлуулдагч дуулуулдаг мянган шүлэгтэй

Хорвоо урт ч дандаа жаргал байгаагүй гачлан

Хорвоо үргэлж гэрэлтэй ч бас харанхуй байдаг

Хорвоо тэр аяараа үнэн мөр

Хорвоо тэр чигээрээ тамын тогоо

Хорвоог туулах зам олон хязгааргүй

Хорвоог туулахад сэтгэлийн тэнхээ хэрэгтэй гарцаагүй

Хорвоод ирэхэд итгэлийн зул асаалттай мөнх

Хорвоог туулахад ижийн сүү замчилах нь үнэн

Хорвоо тэмцэж тэнцэх зовлон биш жаргал

Хорвоо тэнцвэргүй хүнд ачаа биш үүрэг

Хорвоо нинжин сэтгэлийн халуун хайр

Хорвоо нэгэн насны жаргал зовлон

Хорвоо гашуун байсан ч хүний төөрөг

Хорвоо гарах гарцгүй хүний ертөнц

Хорвоод хүн болгон жаргал амсдаг

Хорвоог элээж байгаа нь хүн бидний төөрөг

2008-3-5

ХҮЙ ДАРСАН ЧУЛУУТАЙ ЭНГЭР МИНЬ

Бодол сэтгэл татан хайрлагдсан

Бор борхон толгод дундаас

Босоо цагаан хиймороор адисалсан

Борхон энгэрт хаваржаа манайх байдагсан

Тэр л энгэрт миний хүй дарсан чулуутай

Тэр л хавьд миний хөлд орсон мөртэй

Тэгээд л тэр хаваржаат энгэрээ

Тээх сэтгэлдээ хайралж явдаг

Тэндэхийн уул толгод наддаа

Тэмтэрч мэдрэх судас болж цохилдог

Тэр л энгэрт хүй дарсан чулуу минь би

Тэр л хавьд өрж тоглосон тоглоом минь бий

Сүүмэлзэн цэнхэртэх уулс нь зэрэглээтсэн

Сүүдэртэн хүглийх хайлаас нь цуварсан

Сүрэглэн яралзах зээрийн сүрэг цахилсан

Сүүгээ өргөсөн өмнийн цэнхэр говьд

Хүй дарсан чулуутай энгэр минь бий

Хүн явсан нэртэй сураг минь бий

2008-5-24

Далай их буян

монгол эр хүн жаргалтай

Бурхад таалсан

номин эрдэнийн орондоо

Будан татсан

хорвоогийн уртыг элээж

Буян заяа тэгш

үйлийн манлайд

Бууж сөхрөөгүй

монгол эр хүн жаргалтай

Хөхөмдөг дэлхийдээ

хүү нь болж төрөхдөө

Хөрст газар шороонд нь

хөлөө тавьж адислан

Хүний жаргал зовлон туулж

элээж хатуужсан

Хүүгээ гэж

үнэг хайчилж зүүдэлсэн

Монгол эр хүн жаргалтай

2006-3-8



Гончигийн ГАНХУЯГ

МҮЧЗХолбооны гишүүн яруу найрагч Алагийнхан овогт Гончигийн Ганхуяг нь морь жилтэй Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутагт төрсөн. Малчин.

БОРЖИГНЬХОН

Дэлтэй гал намхан жижиг морьдоороо

Дэлхийн талыг тойрч орон гүрнийг хураасан

Дээд тэнгэрээс заяат Бөртэ -Чинуагийн удам

Дэндүү омголондоо ижилгүй хүчирхэг овгийнхон

Наран замбуутэвд гүрэн улсаа байгуулж

Найман зовхис дөрвөн зүгт хүн зоноор хүрээлүүлчихээд

Найгал алтан завьяа дүүрэн мэлтрэх дугараатай

Найрлаж буусан боржигонууд бидний алтан ургийнхан

“Эрхэм төр”-ийн цуу татсан гурав гурван түрлэгтэй

Эрэмбэ дараа ёс дэглэмтэй боржигин найр

Эрдэнийн хасбуу тамгатай хүмүүн бэлчээр харилцаж

Эрхт төрийн албыг эндэлгүй залгуулж ирсэн
Эрдэм ухаан төгс боржигин удмын түшмэлүүд
Эргэж ирэхээргүй одовч нутагтаа л шингэдэг
Эзний торгон цэргийн аман хишигт удмынхан
Эрхэм төрт ёсны хүлээн авалт үйлчилгээнийхэн
Эрхтэн дархтаны бие хамгаалалтын хэвгүүл албаныхан
Эд бүхэн нийлээд энэ цагийн боржигныхон
Өндөр гэгээн богдыг Төвдөөс залсан ачтан
Өвгөн ноён Цэрэнсандивынхаа гайхам ухаанд биширдэг
Өөрийн хошууны ард иргэдийн дагаж мөрдөх хууль нь
Өнөөг хүртэл бидэнд өвлөж үлдсэн зангилаа
Дээрхийн наадмын тоосноос
ноёны хар азаргууд сугарсан
Дэнж хотолзуулсан бөхчүүлээ
Чүлтэм аварга магнайлсан
Дээдсийн дотоод албанд Майдар зайсан шадарласан
Дэд сайдын сэнтийд Гомбосүрэн ноён заларсан
Тоонот цагаан гэрийнхээ сүлдэн хоймороо шүтээнтэй
Тортогт хөх асар уулан дээрээ тахилгатай
Торгон дээлийн мөрөнд малын буян тостой

ЭРХЭМ ТАНД

Сэлүүн цэнхэр нутагтаа
гал голомтоо үргэлжлүүлмээр
Сэмэрч туулах хорвоогоос

дугуу бүхнээ гүйцээмээр

Сэтгэлийн тань сайханд

уусан шингэж хайлмаар

Сэрмийсэн нүдний чинь харцанд

хоргодож согтмоор

Хүний хүн ч гэлээ хайрлаж нэг таалмаар

Хүрэн зүрхнийхээ эрхээр

дотносон сууж ширтмээр

Хүсэл сэтгэлийнхээ хөгөөр

хоолой нийлүүлэн дуулмаар

Хүүхэн заяанд чинь биширч

сүслэн дээдэлж явмаар

Толгой бууралч гэлээ дурлаж бас үзмээр

Тормогор жаахан чамд ээнэгшиж

ойртож дасмаар

Тоостой энэ замбуулинд

жаргаж зовж явсных

Тоотой үлдсэн насаа

дэмий бас өнгөрөөмөөргүй

Нас ахисан ч гэлээ хайрлаж бас үзмээр

Намба төвшин чамд нялхарч бас эрхэлмээр

Нартай сартай орчлонд

дээрдэж дордож явсных

Нандин сайхнаас үлдсэнээ

өөрт чинь зоиулмаар

Ахин бас нэг галзуу юм шиг дурламаар

Алаг хөөрхөн үрстэй нь

тойрон сууж шуугилдмаар

Алман сартай хорвоод алдаж онож явсных

Арван наймт шиг яадаг юм

хөл алдаж сэвэлзмээр

Тавь гарсан ч гэлээ дурлаж бас үзмээр

Тансаг ариун бүхнийг тань

илж таалж үнсмээр

Тавьтаргүй залуу нас минь

орхиод одсон ч гэлээ

Танхил сайхан дүрийг чинь

шөнөжин зүүдлээд жаргамаараа

АЛАГИЙНХАН ГЭЖ

Агуу түүхт боржигины

асут долоон овгийнхон

Алдар суут ловонгийнхны

эрхэмсэг дээд өвгийнхөн

Асаж дүрэлзсэн сэтгэлтэй

тэнгэрлэг омголон ургийнхан

Алаг тэмдгээрээ ялгарах

тэнхээлэг амгалан удмынхан

Амьд домог болсон

хоймор налайсан буурлуудтай

Амгалан дагшингийн орон

бурхны олон хуваргуудтай

Ахиж дээшлэх суудалтай

төрийн эрхэм түшээдтэй

Амьдрал тэмцэлд хатуужсан

хүдэр боргил эрчүүдтэй

Алагийнхан

Ашид өөдлөн дэлгэрэх

наран гэрэлтэй Алагийнхан

Лянхуа суудалд залрах

саран туяатай Алагийнхан

Ааг омог бадарсан

Одны гялбаатай Алагийнхан

Гайхамшигт заяанд үргэлжлэх

хүмүүний золбоотой

Алагийнхан

ӨЛГИЙ НУТАГ

Уран хөх бүрдийнхээ ангир ганганах

Удамт түмэн сүргийнхээ

агь сэнгэнэх бэлчээр

Утгат орчлонг багтаасан морин хуурын эгшиг

Ухаан санааг цэлмээсэн

Мөнх-Очир гуайн шуранхай

Унаган хүлгийнхээ зоонд

дарцаглаж явсан тал

Уруул чичигнэх айрагны хамар сэнхийх үнэр

Удгалан цохилох зүрхэнд

үүрд тээгдсэн дурсамж

Учрал хагацалтай хорвоог

ухааран байж сийрэгжвээ

Туулж эдэлсэн амьдрал энэ минийхээ

Дэлгэр цэнхэр боржигины тос даасан хоймор

Эр биеийн минь хөрвөжсөн

торгон хөлтрөгт өргөө

Эх орноо таньж хөл тавьсан газар

Эгэл наддаа эх орон минь эхэлсэн үнэн

Эргэж ирэхгүй одохдоо ч

тайван орших өлгий нутаг

АЯА-ГААРАА БИ ГОЁДОГ

Тост боржигины нутагт

үдэлж буусан хун

Тоонот цагаан гэрт минь

гэрэл цацруулсан дагина

Тойрч болдоггүй зовлонг

хувааж эдэлсэн буянтан

Тольт зүрхний цохилтыг

хос болгосон шидтэн

Хэлтийх бүр засдаг

энэрэнгүй нинжин сэтгэлт

Хэний ч дэргэд гайхуулмаар

авралын гэгээн дарь эх

Хэлтгий заяанд хэлгийрэхэд

тосож авсан торомгорхон

Хэрсүү аядуу ухаанаар

татаж авсан бурхан ээж

Ахимаг насанд учирсан

Аяа-гаараа би гоёдог

х х х

Бодончар мунхагаас гарвальтай

Эртний дээдсийн үргэлжлэл

Богд Чингэсээс угсаатай

Гучин хоёр хаадын удам

Боржигин цэцэн вангийн

Бодлого ухаан төгөлдөр

Өвгөн бээлтний эзэмшил

Тоост замбуулингийн наранд ойрхон

Энхжингийн өвөр

Тост боржигины буян хурсан

Мөнхжингийн хоймор

Тоотой насанд минь заяасан

Амгалангийн дагшин нутаг

Тойруулгат мөнгөн өргөөндөө цэнгэх

Жаргалангийн өлгий

Боржигин нутаг

х х х

Сул чулуу нь шаргисан

намхан бор толгод минь

Хал суулгаж

миний өвдөг шалбалсан талбар

Цэл залуу насандаа эрдэм ном сурахаар

Хол замд үдсэн сүүн цацал нутаг минь

Бал бурмын цэцгэс өнгө алаглах цагаар

Тал нутгийн зун ёстой нэг диваажин

Зол баяр бялхсан манай сумын наадам

Жил жилийн ойдоо

сүр жавхаатай нижигнэвээ

Нэл алтан саатай ижил дээлээр ихэрлэж

Цул мөнгөн хэрэглэлтэй

хос мориор гангарсан

Гил хархан үснээс нь

салхи үнэртсэн чамдаа

Хөл алдан дурлаж жигүүрлэж явсан нас

Цал буурал эцгийнхээ удам судрыг дагаж

Гал голомт асааж өрх гэрээ үүсгэн

Мал адууны дэргэд хусан уурга суналзуулж

Дөл бадрааж явсан залуу халуун үеээ

Хул шаргал намрын

салхин зүсээр санагалзаад байна

Дэл суман хүлгээрээ

дэлхийг тойром омогшоод байна

БАЯН ТАЛ

Нүдний үзүүрт цэлийх

Уудам дэлгэр тал

Нүүдлийн шувууд цуцах

Униарт өргөн тал

Нүүдэлчин боржигидын

Хүлгийг сорьсон тал

Нүнжиг дээжээ хайрласан

Миний нутгийн тал

Босоо төрсөн унага нь

Сөхчилгүй тэнцдэг тал

Бодол цолмон хүрэн л

Цуцалгүй туулдаг тал

Босон суун шулганах

Болжморын жиргээтэй тал

Богдын торгон үүд

Оёоргүй цэнхэр тэнгэртэй

Хаяа нийлсэн тал

Орог саарал зэрэглээ

Мяралзан жирвэлдэг тал

Омголон хангал зээр

Хуйларч давхидаг тал

Отроор ирсэн адуу

Оорцог Сансарын хоорондох

Тэрэгтийн шаргал тал

Оросын ганган тосгон

Сүндэрлэж боссон тал

Онгорхой Должингийн

ороо цоохрууд

Ойлж цойлсон тал

Олон ястан цугларсан

Говьсүмбэрийн Баянтал

2001 он



Пүрэвийн БӨХБАТ

1963-2013

МЗЭ-ийн Шагналт яруу найрагч, “Мөнгөн үеийн” төлөөлөл Пүрэвийн Бөхбат нь 1963 онд Төв аймгийн Эрдэнэ суманд төржээ. Сүмбэр сумын 10- жилийг төгссөн. ЗХУ-ын Краснодарийн Нисэхийн сургууль, УБДС-ийг тус тус дүүргэжээ. Монголын Утга зохиолын “мөнгөн үе”ийн төлөөлөл бөгөөд Говьсүмбэрийн сургуулийг төгссөн сурагчдаас төрсөн анхны МЗЭ-ийн шагналтан юм. “Санахын огторгуй”, “Зуны амраг”, “Борооны тарни” яруу найргийн “Таван зүг”, “Үйлийн үрийн цоорхой”, “Алтан гавал” үргэлжилсэн үгийн зохиол туурвижээ. “Үлэмжийн чанар” наадмын Тэргүүн байр, “Вансэмбэрүү” наадмын Тэргүүн байр, “Алтан бийр” наадмын Тэргүүн байр, “Монгол цэрэг” наадмын Дэд байр, “Боржигидай сэцэн” наадмын хошой Дэд байрны шагналт.

МАЛХЫН ТАЛ ДЭЭР МЭЛТИЙХ ХАЛХЫН ХӨХ ТЭНГЭР

Молор сүнстэйгээ дор хаяж гурвын дайтай, би

Молиго өмхүүлсэн гэвэл шалга, амандаа сайн тоол

Миний нутагт санаархсан харь түмэд юу ч биш

Морь сүүдэртэйгээ дор хаяж арвын чинээ, би

Мордох дөрөөний бөх, бидний зоригийг туршиж үз

Монголын хойморт санаархсан буман тосгод юу ч биш

Мандах нарнаас эрийн хийморь авахаар, бид хэд

Малхын талд мянга мянгаар үржихийг тэнгэр гэрчилнэ

Манай голомтонд санаархсан хот живаа юу ч биш

Элэнц хуланцаасаа монгол эр ганцын чинээ байгаагүй

Энэрэнгүй нь ихэдсэн миний дээдсийн сэлэмний өшөөг

Энэ монгол гурван зуун жил ийш тийш нь яг төллөө

Малхын талд өвөлжих цасан шуурга галзуу догшин

Малхын талд хаваржих шороон шуурга бүгд догшин

Малхын тал дээр мэлтийх халхын тэнгэр бүхнээс догшин

НАМАЙГ ИРЭХЭД

Нартын толгой эргүүлсэн нанчид, нанчилдаан

Нажид зовлон, ужид садар, араар тавих гээд

Надад зохиосон ганц нүгэл үнэндээ байгаагүй

Намайг ирэхэд энэ дэлхийнхэн зэхчихсэн байсан

Найман зовхис тустай арван цагаан буян

Нарны тарни, цайны дээж өргөх гээд

Надад зохиосон ганц буян үнэндээ байгаагүй

Намайг төрөхөд энэ хорвоогийнхон бэлдчихсэн байсан

Баян хүний бэлэн үлдээсэн хөрөнгөн дээр туйлах шиг

Баруун гар, зүүн хөлөө хэзээ дүрснийг мэдэхгүй

Барцад минь миний баялаг, байнгын лам багш минь

Басган болж төрөөгүй минь олз, хойд настай минь аз

Муу муухайг минь живтэл цагаан сүү дусаа

Мундаг сайныг минь дэвэртэл ариун сэржим өргө

Хэвтээ цагаанд хувирах дон тусаагүй байхад

Хэзээ ч өөрийг хийхгүйг бурханаас гуйж, шүлэг маанилах..

ЧОЙРЫН ТОЙРОМ

НЭГ:

Чойр-Чойр, ойр-ойр

Ойр, ойрхон –тойр, тойр

Богд төгөлдөр Чойрын уул

Бодь сад номын буурь

Айлын ганц боржигины

Ахуй нийслэл жанжин Чойр

Хашлага сум зоох аав

Хасаа шагай, оноо уухай

Хаш хөөрөг алга дүүрэн

Халхын гангацуул эмээл хөндлөн

Элчит наран эгдүү дотно

Элсэн шуурга эрдүү сэргэлэн

Хатаж ургадаг бутны цэцэг

Хайр сэтгэл шиг санагддаг

Таана нь миний талийгаач авгынх

Хөмүүл нь хөөрхий

хөдөөлүүлсэн нагацынх

Овоо нь одоо миний өвөө

Очиж золгох нутгийн хөгшид

Чойр-Чойр, ойр-ойр

Ойр, ойрхон –тойр, тойр

ХОЁР:

Арга билгийн дэлгэрэнгүй эх

Алтан, мөнгөн хоёр боть

Анхны дурлалын хацар ноорог

Ангийн чимэг хөөрхөн Зулаа

Биндэрьяа эрдэнийн бэмбээ хөх

Бие тэгш чи арван зургаатай

Би гэх аавын сайхан цээж

Биеийн хүчин үнэлэх нас чацуу

Халуун насны хүүхэнсэх тэмдэг

Хавар сарын өндгөн эс

Өдөр шөнийн цагаан зөн совин

Өнгө энхэр чи дурлалын төлөө

Зүлэг хар хөмсөг духдуулсан

Зүг наашаа зөнч харц

Зүүдний зураач уран сормуус

Зүрхний ятгач хунгийн инээд

Ононгийн цэнхэр зэрэглээ эмжсэн

Жонон багын элсэн далай

Чойр-Чойр, ойр-ойр

Ойр, ойрхон –тойр, тойр

ГУРАВ:

Нар бид гурав хамгаас эртээс сэрдэгсэн

Сар бид гурав сансраас сүүлд унтдагсан

Өвс бид гурав өвөр дээрээ суудагсан

Элс бид гурав энгэр түрийндээ өссөн

Улиас бид гурав нэг газар уулздагсан

Улс амьтнаас хэн хэнийгээ нуудагсан

Онгод бид гурав шөнөжин шүлэг уншдагсан

Од бид гурав тэнгэрийн гадуур зугаалдагсан

Зүлэг хар хөмсөгтөн минь совингоороо

Зүүд яасан олон зурсан зураачхан минь

Зүрхний ятгач инээдтэн минь хөгөөрөө

Зөн билэгт юутай их нөлөөлөгчхөн минь

Хавар бид гурав хар нялхаараа байсан сан

Хайр бид гурав хамгаас ойр байсан сан

Уймрах сэтгэл ямар нойтогнуур юм бэ

Уярах одоо яасан үнэнч эмчилгээ вэ

ДӨРӨВ:

Бүлтгэр гүрвэл нь

Бүл нэмж амь оршдог

Бурханы шар цэцэг

Бутны мөчирт дэлгэрдэг

Элсэн дээр хөл тавимагц

Эргэж би хөвгүүн болдог

Эхнэр хацартай үеийнмаад

Энхрий аргагүй охид болдог

Уртаа багш, улаан гитартайгаа

Улаа бутарч ихэр болдог

Охидын ааль нүдээр дамжиж

Одон болж зүрхийг шагнана

Ой тойнд танай цонх гэрэлтэнэ

Оддын дороос

Чойрын гэрэл босно

Ойр тойрноос

Чойрын Богд түшинэ

Ойр ойрхон, тойр тойр...

ТАВ:

Булан тойроход бага нас ойрхон

Бултаж гүйгээд зүүдэнд ойрхон

Өдөр шөнөгүй сансар ойрхон

Өндөг цагаан сэтгэл ойрхон

Өндөр худаг номхон далайд ойрхон

Өртөө вокзал Улаанбаатарт ойрхон

Дэлгүүр, найз дайлахад ойрхон

Дэмбээ найр, намрын нар ойрхон

Дээл малгай хадаг золгоход ойрхон

Дээр үе, ижий аав минь ойрхон

Зургаан байшин

долоон бурханд ойрхон

Зулай дээр зуны тэнгэр ойрхон

Оцол Сансар минь одонд ойрхон

Орой болохоор саранд ойрхон

Өсгөсөн өндөр дов минь

Өндийлгөсөн өв дош минь

Дэнхийлгэсэн дэлгээ дэнж минь

Дэвтэрлэсэн шүлгүүд минь

Ойрын сүнстэй минь ойрхон

Чойрын богдтой эх орон минь

Ойр- ойрхон, Чойр- Чойроороо

Ойрдоо ойртож тойрох минь ээ

ОРОСМАА

Даашинзаараа нэг сагасан

Давстай талхны хөрөнгө

Энгэрээрээ дүүрэн мээмэнд

Эрчүүд чихэлдэх нь архины мухлаг шиг

Ай Оросмаа

Тосгоноороо багтсан уруултай чинь

Толгойныхоо хундагыг тулгамаараа

Сэрэл давслах сэргэлэн орос хулмас

Сэтгэлийн талаар

таанан бүлээн амьсгаатайяа

Ай Оросмаа

Намхан пийшин шиг пүнхийсэн

Номхон далай шиг цэлхийсэн

Охин шиг гэрлээгүй,

ЭМГЭН ШИГ БЭЛЭВСЭН

Ойн чөлөөн дэх өнчин гацаа

Ай Оросмаа

Нартад одоо чамтай

ханилъя гэх нь үгүй ч

Нааш ир! гэх

халангар эрчүүд мундахгүй

Залуудаа чи хуялын тоогоо гүйцээ

Замдаа үнсэлцэнэ гэж

маньд ганцыг үлдээ

Ай Оросмаа

ХҮН ЧАНАРЫН АКАДЕМИ

НЭГ:

Адууны хумс шиг үнгэгдсэн

Алд дэвсгэр даавуун дээрээ

Шар арьстан би бээр

Шархны халуунтай нэгэн шиг

Шаргалжуутад хэвтсэн мэт

Шартаж усан эм баримой

Луу дарсны эрдмээр

Лүү муугаа дармой

Сэтгэл уяхнаар хөгжиж

Сэмж элгээ цочоомой

Муу санаагаа гэж

Муухар сэдлээс холдмой

Ерийн дүрсээс салж

Ертөнцийн зовоосыг мартмой

Над шиг цайлган хүн

Нартад одоо алга байна

ХОЁР:

Сонгодог театрын чих шиг

Сонсдог бүхэн манайд бий

Үзэгдэлт билгийг сайшаадаг

Үздэг нүд хойморт минь бий

Үгсийн дээдсээр цэнгэхдээ

Үнэн совинг бурханчилдаг

Сархад дээжээ магнайлж өргөдөг

Савдаг хайрхан говьд бий

Үгийн бурхад манайд

Үсгийн дарааллаар биш

Хорвоогийн эрэмбээр

Хоймор дүүргэн тойромлон

Хормойгоо дэвсэж суухдаа

Ховор үгээ сархаддаа

Ховс хийморь дүүргэж

Хүн чанарын академи болсон

Дивангарын энэ нанчдыг

Диваажингийн шид болгодог

ГУРАВ:

Галт зэвсэг бэлэглэх нь битгий хэл

Гартаа барьж дадаагүй бид

Гаргасан номныхоо дийлэнхийг

Гарын үсгээ зурж бэлэглэдэг бид

Үйлийн савдагууд энд тэндгүй

Үсэгт номоо одон шиг гардуулдаг

Ном төрсөн алтан агшнаас

Нойргүй угаалга амжиж эхэлдэг

Мялаах сайхан дэмбэрэлийг

Мянган бурхад ойшоодог

Хүн чанарын академи болсон

Хүндэт номын дээшээ буян дээрээ

Дурсах андын овог нэрийг сийлж

Дурайтал гарын үсгээ зурж бариад

Дуулахаас илүүтэй шүлэг уншиж

Дуусдаггүй сархдаа

пуужин шиг зоодог

Цөмийн зэвсгийн харвагч минь

Цөхөрч гацна гэж хэзээ ч үгүй

Хүн бүхэн хүн чанараар бялхаж

Хүйтэн харц хивсэн доор нуугдаж

Яг одоо, Янжинлхам бурхан

Ялалтын буудлага зарлаж байна

Хүн чанарын академид
Хүрээлэн баярлагчдыг суралцуулна
Онц хэн сурах вэ, бүгдээрээ шүү
Олиггүйтэж хэн муу сурах вэ,
ганц ч үгүй
За ашгүй санаа амарлаа
Залаг муухайд завсар орлоо
Хүүртэй энэ хорвоод хөөш гэм
Хүн чанарыг бурхан гэж тунхаглая

ЧОЙРЫН УУЛЫН ЧОНО

/ Нэгэн үеийн эрчүүлдээ/

НЭГ:

Талын сансарлаг зэрэглээгээр
Тасын дүүлэлтээр ниснэм
Уулын хавцал агуйгаар
Усны амьтан шиг сэлнэм
Сэмбэн цагаан цаснаар
Сэвсийж сэргэлэн болном
Цэлдэн нойтон борооноор
Цэмбийж өлдөн хөнгөрнөм
Цовдолмоор шороо шуурганаар
Цоорхой ухаж, нөмөр үүсгэн давшнам
Эр зориг шилбэлздэггүй гэдгий
Энд тэндгүй элс шиг цацнам

Сүүдэр чөдөртэй халуунаар

Сүнстэйгээ хамт хөлөрнөм

Шүд нь эв нэгдэлтэй ярсхийнэ

Шүлс нь эрх чөлөөтэй гоожисхийнэ

Эсэн мэндийн алтан ланчинтай

Эр зоригийн түмэн лүндэнтэй

Чойрын Богдын суман чоно

Ойрдын биш Боржигин чоно оо

ХОЁР:

Дорны сарыг

Хоншоортоо өлгөж

Долоон бурханыг

Сүүлэндээ гогдож

Өглөөний нарыг

Өвчүүндээ зүүж

Үдший бүрийг

Өлмийдөө зулж

Довтолж явах

Давшиж урагшлах

Дарс дэрс цочихдоо

Дах болохоон мэдэхгүй

Дарга энэ амьтан

Цэрэг явах лайгүй ч

Улаан хувьсгал шиг араатанлаг

Ухарч чаддаггүй амьтан

Урд, хойд насны

Уншлага мэддэг ламтан

ГУРАВ:

Элсэн сайрыг шиншихээр

Эрдэм сурагч бэлтрэг болдог

Эвгэй шаазгай шиг гичий

Элдэв аашт онгон болдог

Эр зоригондоо элэг бариулж

Энэ нутагтаа дайсан болдог

Намнах санаатай анчны

Насыг уртасгаж өгдөг

Найз цэцэн хар бууны

Найдварыг устгаж өгдөг

Жамсран бурхан шиг догшин

Жанжин Чойрын мөнгөн чоно

Агсам зэрэглээ задалдаг

Анчийн туслах дуранд

Алд хүрэхгүй сүүл нь

Аварга луу шиг дэвдэг

Араа соёо, улаан гол нь

Асмал түймрээс урт дөлтэй

Чөмгөөн дундалж

яаж амьдардагийг

Чөтгөр авхайданд багшилдаг

Буянаа яаж арвитгадгийг

Бурханы жаягаар сургадаг

Жамсран бурхан шиг догшин

Жанжин Чойрын

азарган чоно оо

ЗАЯА ТӨӨРГИЙН СҮГ ЗУРАГ

Хувь тавилангаа би

сэтгэл хөдлөлөөр шагнадаг

Хувь төөргөө

би хайр дурлалаар шагнадаг

Хувь заяагаа би

үүрийн шүлгээрээ мялаадаг

Хувь тохиогоо би

ижийнхээ шаналангаар хамгаалдаг

Хувь онгодоо би

Ноён хутагтын сүлдээр догшроодог

Хувь хийморио би

талын салхиар намируулдаг

Хувь тэнгэрээ би

толгодын зулайгаас босгодог

Хувь тангарагаа би

сүнснийхээ нөмөрт шившдэг

Хувь заяагаа би

зүрхэн дотроо боолчилно

Хувь төөрөгөө би гар дороо зарцална

Хувь замаа би

хөл дороо дайвалзуулна

Хувь тохиогоо зулай дээрээ тахина

Хувь тавилангаа би адаг сүүлд днь

Хөх мөнх тэнгэрийн

гүн рүү чулуудчихна

БИ РАВЖААГИЙН НАМЫНХ

Яруу найргаас өөр нам надад байхгүй

Янзыг минь үзэж хэзээ ч хэрэггүй

Өтөлж намссан

номхон бор харандаатайгаа

Өглөөний наранд хатаасан

цагаан цамцтайгаа

Зүд зүд тарчлаасан

зүүд тамын ёртойгоо

Гуд гуд тоолсон

гучин хоёр цэнхэр лонхтойгоо

Гунихад совиншсон

алтан шар амрагтайгаа

Цээжин дотор цэнэгших

нэмэх хасах онгодтойгоо

Цэгцэрийн талыг манах

аавын хөшөөний чулуутайгаа

Чөмөг дундлах

чөдрийн хэдэн зовлонтойгоо

Чөтгөр шавилсан

шүлгийн бурхан багштайгаа

Гань гань гандуулсан

уудам талын салхитайгаа

Гариг гаригийн төөрөг

ганц цагаан мэнгэтэйгээ

Үхэл хэзээ ч цөмлөхгүй

ихрийн өрөөсөн сүнстэйгээ

Үйл хойчийг бүтээдэг

хэл бие сэтгэлтэйгээ

Би Равжаагийн

яруу найргийн намынх

Билэг танхай шүлгийн

мөнхийн намынх

Надаас үлдсэнийг намд минь тушаа

Намтар, нанчид, амраг амьдынх аа

Найланхайталгүй

чанга дуугаар дуудъя

Найраг, сүнс хоёр хойд насных аа

Ноорогт шургасан

өглөөний болжморын жиргээтэйгээ

Нойтон бэхний бүжиг

худам монголтойгоо

Янтай бийр, ном шогол,

сандал ширээтэйгээ

Яах л аргагүй,

Би – Равжаагийн намынх



Пүрэвдоржийн НАРАНХҮҮ

Мухлай овогт Пүрэвдоржийн Наранхүү 1985 онд Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд төрсөн. “Их засаг” их сургуулийг дүүргэсэн.

Тус сургуулийн Урлагийн наадмаас “Шилдэг яруу найрагч”ийн өргөмжлөл, алтан медаль хүртэж байсан.

АМЬ УРАГ

Булгийн ус нь булиглан ориглоно

Бурханаас эхтэй цалиглан ундарна

Голын ус нь голдирлоороо урсана

Галын цучилаар ноцон урсана.

Амьдралын далай

Ангаж, цангасаар дүнсийнэ

Алагхан бөөрөлдий

Аясаараа эргэлдэнэ

Далдын чанадаас гэгээхэн аялгуу

Даруухан хорвоод зөнгөөрөө уянгална

Дусалхан амьтай дуугүйхэн цутгалан

Дундаршгүй заяаны хүүрнэлийг нэмэрлэнэ

Эцгээс ундаргатай

Эжий урсгалтай

Энэрэлийн цутгалантай

Эгшиглэн их далайд

Мөнхөд аялахаар тэмүүлэн хөвнө

Мөрөөдөлд умбан намуухан нойрсоно

Ханий минь хэвлийд бойжиж буй үрдээ зориулав

2013 он

Идтэй насны бяр

Цагаа эрж

Арай гэж намайг олтол

Ирж биш

Буцаж яваа нар

Орой дээрээс тусч

Ирт амьдралын минь

Мөн мэт

Үнэн яс

Итгэл эмтэлж

Тархи хугасалж

Толгойноос цухуйна

Идэр насны ахмадуудадаа зориулав

2011 он

УРЛАН

Итгэл гэдэг шавраар

Эвлүүлэн байж өрсөн

Эгшиг аялгуу дүрстэй

Энгийн нэгэн баримал

Эвгүйхэн барьвал

хэлбэр нь алдагдаж

Эс тоовол хэрэг нь алдагдаж

Эгшин төдийд л бутран унадаг

Эмзэгхэн агаад нандин

эгэлгүй тэр бүтээл

Эрхэс орчлонгийн учигт

Эвлэлдэн байж бүтэвч

Энэ л ертөнцийн элдэвт

Элэгдэн байж ховхорно.

Хөөрхий зайлуул.

Хэн үүнийг бүтээсэн юм гэж

Хүнээс чи бүү асуу

Хэнд итгэх ёстой вэ? гэж

Харин өөрөөсөө асуу

Гэлээ ч яахав гэрлээс бүү нуу

Гэрэл сүүдэр нь

таарсан өөр нэгэн бүтээл

Гэрэлт орчлонд өөрөө

гялалзан төрөх байлгүй

Тэнгэр дуугарч үүлс хуралдаад
Хэнгэрэг мэт агаарт сүржигнээд
Тэнүүн талын уулс догдлоод
Оргилд нь шоволзох овоодын
Өндөлзөөнд хөвөлзөх
Өвс нь сэрвэлзээд
Салхиар найгах өвс нь биесээ алгадаад
Салам согтуу тэнгэрийн хаяа хотолзоод
Сүү чинэрсэн энгэрийн сарьдаг чичрээд
Санаа амьдлаг чимээнд сүнс хоргодох
Гүн нөмөртэй агуйнд
Үерлэсэн бороо аянгатай урсана
Их үйлсийн дараа амарсан
Байгалийн өвөрт цэцэгс инээнэ
Ижилгүй дассан сэтгэлтэй
Тэнгэрийн нүд онгойж нар гарна



Эрдэнэсүрэнгийн БЯМБАСҮРЭН

Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 1987-10-03-нд төрсөн. Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулийг дүүргэсэн. “Хүрэл тулга 2003”наадмын гутгаар байр, “Хүрэл тулга 2005”оны наадмын Тэргүүн байрны шагналтай

ИЖИЙ МИНЬ

Нарны шаргал туяаг угтаж цайгаа сүлсээр

Намайг хүний зэрэгт хүргэх гэсээр ижий минь

Залуу насаа элээсэн

Ахуй биеийнхээ элтэс намайгаа

дэлхийн энтэй холбох гэж

Аяганд хурах нулимсаа

тэвчиж залгисаар ижий минь

Анхил биеэ элээсэн

Буй орчлонгоос алслахуйн ирмэгт тулахуйд

Булбарай насыг минь

бурхдаас харамлахдаа ижий минь

Бүлээн цусаа хугасалсан.

Үрсийнхээ нулимсаар хөрстийг

умдаалахгүй гэсэндээ бүсээ чангалж

Өнчирлийн шархыг ганцаараа үүрсээр ижий минь

Нуруугаа бөхийлгөсөн

Шимтэй бүхний хэлтэрхийг өөрөөсөө харамлаж

Ширээний ард насаараа

цатгалан суусаар ижий минь

Шүдээ элээсэн

Гэлээ ч

Элээж, хугасалсан бүхнээсээ

өр нэхдэггүй ижийн минь

Эгнэгт үл элэх энгүй сүүн сэтгэл

Ивлэх тоолондоо хайраар асгарч

үрсээ ундаалдаг аа

Өтөлж дээ гэж халаглах тоолонд минь үгүйсгэдэг

Өөдрөг гэгээн тэмүүлэл нь

үргэлж залуугаараа урагшилдаг аа.

БУРХАН ААВДАА

Аав минь таныгаа үр чинь

Ямар их санана вэ?

Ар давах хүлгийн жолоог атгасан ч

Амьдрал мөрний хатуу хүтүүг

Ажралгүй туулах ухааны хат суусан ч

Аавдаа нэг эрхэлмээр санагдах юм аа

Зүрхний минь гүнд бүтэн үлдсэн

таны минь дүр

Зүүдлээд сэрэхэд замхарчихвий гэхдээ

Сэтгэлдээ өдөр бүр зурдаг аа.

Хорвоогийн жам, он цагийн урсгалд түүртэн

Хонгор үр нь таныгаа үл огоорох вий гэхдээ

Шүлгэндээ мөнхөлдөг өө

Тэнгэр бурхдын орноос түшдэгт тань итгэж

Тэнүүхэн алхална аа үр нь.

Тэнгэрлэг үйлсээр минь

бахархдагт сүслэхдээ

Зөвийг үйлднэ ээ үр нь

Зүрхэнд минь илч нэмдэгт тань бишрэхдээ

Хайраа бусдаас үл харамлана аа үр нь

Зөвхөн таны л охин болсон

хувь тавилангаараа бахархахдаа

Нэрийг тань бүтэн авч явна үр нь

СЭТГЭЛИЙН МИНЬ ҮНЭН

Зүрхийг чинь булаах гэж эргэлдэх

согоон цэцэгс шиг охидоос

Зөвхөн намайг л гэж

сэтгэлийн үүдээ чи дэлгэсэн

Зөрж өнгөрөхөд чинь тусах

ааль ялдам харц бүхнээс

Зөвхөн минийхд л чи

замагт нуурын загас шиг ээнэгшсэн

Үй олноороо салаалах

хүний харгуйгаас

Үүрд минийх л байх гэж

амьдралын аянд мордсон

Үймсэн олны хөлөнд

амар алдруузай гэхдээ

Үнэнчийн итгэлээ илчлэн

хайрын тангарагаа өргөсөн

Чамдаа би яг одоо сэтгэлээ илчлэе

Чанадын чанад дахь

чин хүслээ дэлгэн байж хэлье

Гунигийн мананг чинь яран мандах

Наран би байхыг

Гудайсан талаас чинь түших

Тулгуур нь би байхыг

Инээд цалгиан догдлуулах

Аз жаргал чинь би байхыг

Энэ орчлонд хоргодох утга учир чинь

Би л байхыг хүснэм

Энэ л чиний сэтгэлийн чин үнэн

ХАНЬДАА ЭРХЭЛЖ ХЭЛЭХ ШҮЛЭГ

Хүслээр минь хайрлах гэж

Хүнээр дутахад ханьсах гэж

Ядрахад минь асрах гэж

Ягтахад минь дэмнэх гэж

Гарыг минь дулаацуулах гэж

Гэрийг минь дүүргэх гэж

Сэтгэлийн минь галыг өрдөх гэж

Сэмхэн гунигийг минь үргээх гэж

Уйлуулахгүй гэж

Удаан гэгч нь хамт байна гэж

Ганцаардуулахгүй гэж

Гараас минь тавихгүй гэж

Хавар шиг аашийг минь уучлах гэж

Хайруу хатуурхлыг минь даах гэж

Гэж... гэж... гэж... надтай гэрлэсэн болохоор

Гэнэдэж учирсан тавилан мэт бүү аашлаарай

Бүсгүй сэтгэлийг минь

цэцэгчин мэт арчлаарай

Бүтэн заяанд минь дурлаж

дүүрэн амьдраарай.

АДИЛХАН ЗҮЙЛ НЬ ЮУ ВЭ?

/Хайрт охин Н. Ситадаа зориулан өхөөрдөж бичсэн шүлэг/

Шувуу хүнтэй огтхон ч адилгүй

Шовх хошуу, хос далавч

Модны мөчир шиг арзгар сарвуу

Моодгор сүүл, өд сөд

Ангирын дэгдээхэйг бяцхан охинтой

Адилтгаж ерөөс болохгүй л баймаар

Хаанаас нь ч харсан биеэр жижиг

Хачин сонин зүс нь алаг

Гэтэл хүмүүс бяцхан үрээ

Алаг үр, ангирын дэгдээхэй минь гэж

Энхрийлэн хайрлах юм

Эвийлэн дуудах юм

Гайхаж эмээгээс асуувал

Ганцхан хариулт бий гэлээ.

Янз янзаар ганганах дуу нь

Ялгахын аргагүй ижил гэлээ

БОДЛЫН ХЭЛХЭЭС

Гал цэцэг нарнаас тасран агшинаа дэлбээлэх шиг

Ганц нэг дусал үүлнээс унаж хур даллах шиг

Хэн нэгэн цөлийн шуурганаас эсэн мэнд ирэх шиг

Хэзээ ч төсөөлөөгүй цаг хугацаа зүрхэнд хөврөхүй...

XXX

Чиний тухай бодол

Сэтгэлд аргамжаатай

Чиний тухай зүүд

Нойрноос аргамжаатай

Аргамжаа алдуурч

бодол зүүднээс алслаасай

Аяа энэ сүүлчийх байгаасай

Мөхөөгүй итгэл бүхнийг

зүрхнээс минь аваад яваач

XXX

Зүрхний минь тэнгэр

үүлээ даахгүй бороошиж байна

Зүүн өмнөөс наран мандаж,

солонго татахыг

Зөнгөөрөө хүлээнэ

Гэвч

Хайрын дууг амьдрал юм шиг

итгэсэн цаг хугацаанаас

Хайртыгаа би олж үл чадна

Хайрлах уу? Эс хайрлах уу?

XXX

Авахаасаа эмээж, алдахаасаа зүрхшээх

Цаг хугацааны дарангуйлал

Алаг зүрхний орон зайг тарчлаахуй

Би чамтай бас чамгүй байхыг хүснэ

Жингийн тавган дээр дэнжигнэх мэт

Сэтгэлийн хос туйл

Хэн хэндээ үл дийлдэм аяглахуй

Бодол минь ихэрлэж нэг,

салаалж нэг хөвөрнө

Хэлхээ сувдан нулимсаа энгэртээ эгшээн

Хээрийн салхиар үг дайх гэнэхэн хүслээр

Хэзээд би чамайг үгүйлдэг

Бүгд үгүйсгэх харанхуйн шаналанг

бүхий л хүчээрээ яран байж

Би чамруу зүрхээ уран тэмүүлнэм.

XXX

Яах ёстой вэ? Бурхан минь хэлээч.

Яадаг юм бэ? өөрөө учраа ол гэвэл чинь

Чөтгөрийн үгийг

Чимээгүй дагалаа шүү.

XXX

Зөөлөн хаялах цасан ширхэг

алган дээр минь буухад

Зүрхэнд халуун халуун илч төөнөх шиг

Яг л ийм цаснаар чиний гараас хөтлөн

Хэмжээлшгүй баяраар бялханхан алхдагсан

Хөвсгөр цасны ширхэг бүрт шингэсэн чиний инээд

Хөрөөгүй гэлтэй

Алган дээр минь буух энэ цас

Дулаахан байна яг л тэр үеийнх шиг.

XXX

Дэгжин хээнцэр залуусын

Дээгүүр шидлэх харцнаас

Сэтгэлийнх нь үнэнийг таних гэж

Сэргэлэн цовоо бүсгүйчүүд

Сэмрэхийг умартан тэмүүлнэ...

XXX

Амархан дассан сэтгэлээ

Арай яарчихав уу? гэж сэрэмжлэвч

Яадаг юм бэ энэ чинь залуу нас

Яруухан учралгүй бол ямар ч утгагүй гэж

Далдын чанадаас жолоо булаахуй нь

Тархи зүрх хоёрын нэгдсэн дайралт аж...

XXX

Ганц дусал нулимс

Аягаа халин урслаа

Гадагшаа бус

Дотогшоогоо...

МӨРӨӨДӨЛ БИЕЛДЭГ

Зүсэрч орсон бороо

өглөөний нарнаар татарч

Зөрөг замын хонхорт тогтож

ул мөрөө үлдээжээ

Тойрч өнгөрөх хүмүүс,

дайрч өнгөрөх машин

Тоймгүй олон хараалын үгс

Зүү мэт түүнийг шивлээ

Ай тэнгэрээс буухдаа

ариухан хур байсан ч

Аргагүй энд тогтохдоо

шалбааг болон булингартлаа гэж

Хувь заяандаа гомдсон

хурын ус уйлж

Хөгшин намагтай ханьсан

газрын хөрсөнд шингэхдээ

Золоор олдсон хувь тавилангаа

Зольж орхив гэхдээ

Зовлонт биеийнхээ ганц дуслыг

Заяат тэнгэрлүүгээ илгээлээ.

Өөрийг нь орлосон

тэр дусал сүнсийг нь тээсээр

Өргөн мөрний дээрээс

бороо болон асгарлаа

Эцсээ хүртэл тэмцсэн

зүтгэлийнхээ ачаар

Эхэлж алдсан алдаагаа

ахин үл давтаж

Ижий мөрний усанд

долгио нэгээр нэмлээ

Мөрөөдөл биелдэг ажгуу.

XXX

Өвөлжин хураасан нулимсаа задгайлж

Өдөржин уйлж өнжлөө тэнгэр

Өөр нэг өдөр би ч ялгаагүй

Өрөөлөөс нуусан гунигаа тайлж

Өнөөх дуслуудтай нь

ханьсах л байх даа

Хорвоо гэж...



Сахьяагийн БУЛГАН

Жолоо овогт Сахьяагийн Булган 1996 онд Дорноговь аймгийн Сүмбэр суманд төрсөн. МУИС-ийг Хуульч мэргэжлээр төгссөн.

“Чам шиг хавар..,” яруу найргийн номоо хэвлүүлжээ. Говьсүмбэр аймгийн “Цагаан Уул”наадмын Тэргүүн байрны шагналт.

ХАНЬДАА

Хань минь. Тэр минь.

Хавраар ирж намраар буцах тогорууд шиг

Хачин хэврэг, үнэгүй дурлалууд дунд

Халширч явахад минь ассан зул минь.

Ижийн минь оронд цай аягалж

Ирэх жилүүдийн хөргийг хамтдаа зурж

Их багын илүү дутууг имэрч хэмжиж

Идэр цагийн ирийг минь хурцлах хань минь.

Хавт Хасарын удмыг хэвлийдээ тээж

Хатан заяагаа чимсэн ижий гоо минь

Хангайн энгэрт үндэслэж талд ургасан

Харахаас ялдам, үнэр тунсаг хайтан минь.

Мөнхийн анирт энэхэн тал нутагтаа

Мөчир навч нь тэнгэрт тултал тэгш ургах

Мөр дор нь мөрөөдөмтгий үрс шулганаж, мөргөлчид тайвшрах

Мөлж элэх нь ч шимтэй мөнгөн модод болон ургана аа.

Хоёулаа.Хань минь.

ТАНДАА

2011-10-26,12:51

Амин судсыг чинь сэмлэн байж ирсэн үр чинь

Алдрай насаа гээлгүй үүрд нялхаараа байх шиг

Асаж дүрэлзсэн хайрыг тань ааш аяг шиг бодож

Ачлал гээчийг үзүүлж амжаагүй хүүгээ өршөө.

Ээж минь

Хүү нь өсөж, дээл минь багадаж

Хүслийн залгамж нэрийг тань өргөж

Хүж орчлонгын энүүхэн жамд

Хүн зул болж таныхаа л төлөө бадамлана аа.

Ээж ээ

Хорвоогийн анхны рашаан болсон уураг тань

Хоолойд минь одоо ч амин дусал болон үлдэж

Хоногын уртад зовлон даах тэнхээ өгч

Хол ойрын аянд сэтгэлийг минь дэвтээж яваа шүү.

Ээж ээ

ИЖИЙН МИНЬ ХАЙР ГАЗАР ШИНГЭЭГҮЙ

Өргөст навчис хуйсагнан тэртээ алсрах намраар
Өнчин сэтгэлийг жиндээж хяруу мөнгөрөх цагаар
Өтөл тогоруун дуутай бүүдэг тэнгэрийн дор
Өнө оршихгүй жамыг зүхэж явна аа. Хүү нь
Энэ л өдрийг ирэхгүй юм шиг бодож
Эрхэмсэг өдрүүдийг эгэлд тооцож
Эцсийн нар жаргадаггүйд итгэж
Ээжийнхээ дэргэд танхи явж ээ. Үр нь
Эцгийн яс, эхийн махаар бүрдсэн билээ л бидэн
Эргээд ач хардаггүй билээ л тэд минь
Эргэх цагийн гудиггүй салхинд гандаж
Элсэн сэмрэх шиг асарч явж дээ нас нь.
Таны минь
Ижийн минь хайр газарт шингээгүй
Их бодлын зүрхэн чинадад минь
Эр заяаны тэнхлэг ахад минь
Ээл бүлээн хонгорхон дүү нарт минь үлдсэн шүү.
Ээж ээ...,
XXX
Хаврын шөнө...
Согтуу салхин хашаа налан
гуйвж одоход
Солгой саран хаа хамаагүй гуниг дуулж

Солиорсон одод хажуу нэгнээ хэмлэн харваж

Сохор нохой бусдын яс эрэн төөрнө.

АЙ ДАА МИНИЙ ЗАЛУУ НАС

Ай даа миний залуу нас

Хүрэн тасын хийморь даль

Андуу жаргалд дэндүү умбасан

Хүлээх завгүй омголон үе

Нүгэлтэй нөхөрлөн наргиж цалгиж

Нүцгэн орчлонг умартан мансуурч

Шүлэглэж,салгалаж, хөлчүүрхэн алхаж

Шөнийн буг, өдрийн бурхан төрхөлж

Халуухан жаргал бүлээхэн нулимсыг

Ханаж цадалгүй амталж явсан одтой нас

Хайрын сайхан, бүсгүйн ялдамыг

Харамлаж , өмчилж явсан оргилуун цус

ДУЛААХАН

2011-3-29,12:32

Цагийн саалтанд гундсан сэтгэлийг минь

Цаанаа л дулаахан нэгэн сэргээнэ

Цадиг муутайхан налиг дурлал бус

Цагаахан бөгөөд бүлээхэн амьсгал урсна

Дүр, сэтгэлийг нь цөөхөн мэдэрсэн ч

Дүрлэгэр нүдэн чамайг цөхрөлтгүй эрнэ

Дүн цагаахан өвлийн дулаахан дурлал

Дүүмэдхэн түүнийг би дууланхан, дууданхан дулаарнам.

ЧАМ ШИГ ХАВАР

2011-5-17,01:44

Чиний уруул шиг

Чийг ханхийж

Чилийсэн шөнүүд

Чимээгүй уясаад л..,

Чам шиг уяхан хавар

Чамаас л түрүүлж ирэх юм

Миний нүд шиг

Мишээл тодроод

Мэлийсэн нар

Мэндэлж угтаад л..,

Чам шиг худалч бороонд

Чамайг л бодон норох юм

Түүний нас шиг

Түүх эргэж

Түмэн модод

Түүхий гөлгөлөөд л..,

Чам шиг уйдамхай хавар

Чамаар л дутуу эргэх юм..,

xxx

Гуйгаад мөнхөрдөггүй орчлонгийн жамаар

Гурвалсан морь шиг тэмүүлэх цагийн аясаар

Гурын жим шиг хорвоогийн нарийхан замаар

Гурамсан сур шиг чангахан насаа үрж л явна

МАРТАХЫН АРГАГҮЙ

2010-10-12,09:57

1

Мартахын аргагүй миний л амраг нь

Марал цагаахан шөнийн уянга нь л билээ л

Манант цэнхэрхэн нугын уясал нь л билээ л

Магтаал багахан шүлгийн уярал нь л билээ л

Мартахын л аргагүй миний л амраг нь

Санахгүй байхын аргагүй миний л амраг нь

Салхин сайвар намрын гуниг нь л билээ л

Саран бүүдийсэн тэнгэрийн од нь л билээ л

Самсаа шархируулсан хагацалын дурсамж нь л билээ л

Санахгүй л байхын аргагүй миний л амраг нь

2

Тэргэл сар шиг миний л зүрхэнд мандсан

Тэр л нэгэн бүсгүйг хэний ч охиноор орлуулахгүй

Тэнэглэл дүүрэн орчлонд тэнэж би төөрлөө ч

Тэнгэрийн доор мөнхрөх хайраа бөхөөхгүй

Ганц л олдсон эрдэнээ гараасаа унагаж гээсэн тэр үеээ

Галав эрин юүлтэл, гантиг чулуун доор ортлоо зүхнэм

Галын бурхад далласан чамайгаа гэрийн бурхан болгож чадаагүй тэр хугацааг

Газар эргэж, тэнгэр нуртал голт борхон зүрхэндээ шигтгэнэм.

Би бий үгүйн орчлонд чамаараан дандаа дутдаг

Билэг төгсхөн зүүдэндээ битүүхэн жаргаж хонодог

Биелж босоогүй амьдралаа мөрөөдөлдөө чимдэг

Билгүүн гоо чинийхээ замыг засан залбирдаг аа.

Зул зулхан цэцэгс шүүдэрт өглөө жиндэн мэндэлж

Зургаа долоон сарын наран жаргахаа мартан нозоорч

Зураг зургын өнгө шиг охид солонгорон алдан гунхаж

Зуур зуурхан сэвших салхин найргийн дугараанд согтож

Зурвас зурвасхан ганганах шувууд тэнгэрээ чимэн дээшлэж

Зууны зууны залгаа намар нь миний л сэтгэлд ирж ээ..,

ХАЙРТАЙ

2010-9-2, 02:56

Өгсөж уруудах замбууд ОЮУН билиг төгсхөн төрж

Өнгө алагхан хорвоогын нандин

ЭРДЭНЭ минь хэмээгдсэн

Өлзийт учралаар учирсан ЧАМДАА л өгсөн итгэлээрээ

Өдөр өдрийг угтаж үдэж БИ чинь явах л тэрхэн үедээ

Өрөөл бусдад хэлэх учиргүй ХАЙРТАЙ гэдэг үгийг

Өглөө бүрийн нарнаар дамжуулж нэгэн шивнэдэг ШҮҮ

Буян нүгэл орчилдсон зэвхий саарал хорвоод

Буугаад мордох зэрвэсхэн үедээ бүлээн хайраа ивэлгэж

Буцааж нэхэхгүй өглөгч зангаар бүгдэд харамгүй түгээж

Будант орчлонгийн өнгийг цагаан сүүгээрээ сүлэхээр

Бүсгүй танхи заяанд Бурханы зараалаар ирсэн

Бүрэг ичимхий дүртэй Монголжингоод би хайртай

ЗЭРЭГЛЭЭ

2010-9-8,08:49

Зээрийн зоо шиг халиухан намрын сардаа

Ээлийн гоо бүсгүй зүүд исгэн наадна

Рид хувилгааны сод бүтээл гэлтэй

Эгэл сэтгэлийн үзүүр ороон наадна.

Гуниг зурах шувуудын дуу наран зүг алсрахад

Лимбэн цагаан аялгуутай хослон наадна.

Энхэр ялдам бүлээхэн санаашрал урсган

Эзгүй дурлалын оч зурсхийлгэн наадна аа...

xxx

Саалийн үнэртэй ижийн минь тэрлэг шиг

Сар хоргодсон талынхаа үүрээр адуундаа эртлэн мордох

Сайхаан

Саам исэх чимээтэй саахалт айлынхаараа буугаад

Салхи шиг омголон хангалын дөрөө амраагаад мордох

Сайхаан



Баттулгын БАТГЭРЭЛ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 1994-08- 26-нд төрсөн. МУИС-ийн Нийгмийн Шинжлэх ухааны Их сургуулийг Олон улсын сэтгүүлчээр төгссөн. “Уран жиргээ” улсын наадмын Гутгаар болон тусгай байрны шагналт, “Хүрэл тулга” наадмын Дэд болон гутгаар байрны шагналт. UBS ТВ-ээс зохиогддог “Орших уу..эс орших уу” уралдааны шилдэг 15”д шалгарч байсан. “Үнэн нүцгэрэх цагт” яруу найргийн номоо хэвлүүлжээ.

БИ ХҮСНЭ

Хорз шиг амьдралд би гашуун байхыг хүснэ

Хорвоог согтоож чамайг жаргаамаар

Бурам шиг амьдралд би чихэр шиг байхыг хүснэ

Бусдаас харамлаж өөрийгөө чамд л амтлуулмаар

Шунал минь хэтэрсэн ч даварсан ч

Шуурга шиг бүхнийг өөрийн болгодог замтай

Тачаал минь бөхсөн ч мохсон ч

Тааралдсан бүхнээ гал шиг асаадаг жамтай

Миний гуйлт чамд тушаал шиг байж

Би чамайг эзэрхмээр бас эзэмдмээр байна

Миний хүсэл чамд зарлиг шиг байж

Бие сэтгэлийг чинь би өөрийнх байлгамаар байна

Амьдралд би унаж сөхөрлөө гэж уйлахгүй

Алдаа буруугаас айж алхам ухрах бодолгүй

Тиймээс би хүссэнээ амьдралаас гуйхгүй

Тээж ирсэн жаргалаа бусдаас харамлахгүй

Угаас амьдрал хүссэнээр минь эргэдэг болохоор

Уйдаж залхах, гуйж гувших цаг надад байхгүй

Хоёр биш нэг л амьдрах учраас

Хойшлуулалгүй хүссэнээрээ л хайрла

Амраг минь надтай хамт алхал

Аз жаргалтай амьдралын шуналт амтыг мэдэр

ҮНЭН ХАЙР

Уруулын чинь нууцлаг амтыг мэдэрч

Ухаангүй болтлоо чиний үнэрт мансуурч

Үснийхээ үзүүрийг чамаар илбүүлж

Үүрд чинийх болж би амьдрахыг хүснэ

Харц чинь хүйтэн мөс шиг

намайг хайрсан ч би даардаггүй

Хуруу чинь гар руу минь тэмүүлж

цог шиг түлсэн ч би өвддөггүй

Холын холоос ч чамайг надруу

ширтэж байгааг би мэдэрдэг

Хажууд минь ирэх өдрийг л хүлээн

би чамруу тэмүүлдэг

Нэг л өдөр нартай борооноор

чи над дээр ирнэ

Нэг өдөр гал шиг дүрэлзэх

цээжиндээ чи намайг тэвэрнэ

Тэр л өдрийг хүлээж би зуун зууныг элээнэ

Тэр л өдрийг хүлээж би зун өвлийг гэтлэнэ

Чамайг л хүлээж би

бусдаас өөрийгөө харамлана

Чамайг л хүлээж би

өөрийгөө өөрөөсөө харамлана

ГУНИГ МИНЬ НАМАЙГ БҮҮ ОРХИ

Гуниг минь намайг бүү орхи

Ганцаараа үлдмээргүй тийм үед

намайг ол

Гуниг минь нарнаас бүү нуугд

Гэрэлд ч гэсэн уйлж болох

тийм таашаалыг мэдэр

Гуниг минь бусдаас бүү зугт

Гүнзгий их шаналандаа

нүцгэлж байгааг чинь тэд хараг

Бүх л зүйлийг чиний нулимсаар

мэдэрч мансуурах шунал байна

Бүтэн байгаагаа чиний нүдээр харж

тайвшрах хүсэл байна

Гуниг минь намайг бүү орхи

Хэтэрхий төгс ертөнцөөс нуугдах

харанхуй өрөө минь

Хэзээний л нэг танилууд ши

г хаалгаа нээгээд зогс

НҮД ЧИНЬ ХАРАВЧ...

Нүд чинь харавч

Харахын хүслэнд чинь

цэг үгүй тэвчиж сур

Ам чинь идэвч

Цадахын хүслэнд чинь

таслал үгүй өлсөж сур

Гар чинь ававч

Шунахын хүслэнд чинь

эцэс үгүй өгч сур

Хөл чинь хурдлавч

Явахын хүслэнд чинь

үргэлжлэл үгүй хүчилж сур

Хязгааргүйн орчлонд

Хана үгүй ч хаалга буй

Хаагаад нээж сур

Нээснээ хааж сур

ҮНЭН НҮЦГЭРЭХ ЦАГТ

Уруулаа зүсэх үед цус гарна

Яагаад үг биш цус гэж

Нүүрээ угаахад будаг урсана

Яагаад инээд биш будаг гэж

Өөрийгөө тайчаад тольруу ширтэнэ

Яагаад энэ би биш чи гэж

Хаа нэгтэй бурхан буруу зураг зурж

Хаа нэгтэй сайхан үлгэр буруу төгсөж

Хаа нэгтэй жаргал зовлонд дийлдэж

Хаа сайгүй үнэн нүцгэрээд

Цөхрөлд дарагдсан модод

навчаа сэгсэрч нүцгэрээд

Цурхирч уйлсан нүднүүд

нулимсаа ууж нүцгэрээд

Цээжинд байсан зүрх

судсаа тасалж нүцгэрээд

Үнэн гэдэг донгоос болж

бүх л зүйл нүцгэрээд

Гэхдээ би гаж донтон

Харцан дээр минь нүцгэлэх

үнэнг харах дуртай

Алган дээр минь тайчих

үнэнг тэврэх дуртай

Үнэн намайг галзууруулж

Өөрийн эрхгүй би түүний энгэрийг тэмтчдэг

Үнэн намайг өдөөж

Өөрийн мэдэлгүй би түүнийг тайчдаг

Үнэн нүцгэрэх цагт

Үг минь урнаар

Гар минь зөөлнөөр

Зүрх минь хурднаар

Түүнийг мэдрэх дуртай

Тэнэг байсныг минь үнэн мэднэ

ТӨГС БАЙХ ГЭЖ

Орчлонгийн үнэнээс зугтаж

төгс байх гэсээр

Би үхэлд зам тавьж

хаалган дээр нь ирчихэж

Амьдралын сайхныг харалгүй

төгс байх гэсээр

Би төгсгөлд цэг тавих гэж

яардаг болчихож

Зөвхөн үнэн үг хэлэх гэж хичээгээд

Зөрж өнгөрөх бүхэнд

зөв байхыг тушаах гээд

Хэмнэл тасарсан хөггүй хийл шиг

Хуучирч үрчийсэн өнгөгүй даавуу шиг

Хэтэрхий үхмэл мэдрэмж

Хэрэггүй төгс шунал...

Баригдсан хаагдсан сэтгэлээ

төгс дэлгэх гэж

Бадарсан бадмалсан зүрхээ

төгс харуулах гэж

Өөрийгөө хүлж амьсгалсаар

би өнөөдөр

Зовлон ч үгүй жаргал ч үгүй

хагарсан шаазан болж

Зориг ч үгүй айдас ч үгүй

үхмэл бие цогцос болсон

Төгс зүйл өөрөө төгсгөл байдаг

Гэхдээ би эхлэл баймаар байна

Алдаа оноотой амьдралд

Алдах зүйл үгүй эхлэл баймаар байна

Өнөөдрөөс би

төгс зовогчийг булшилж

Өөрийгөө шинээр төрүүллээ

эхлэл нь байг

ХАА НЭГТЭЭ

Бодлоос асгарсан үгэн салхи хаа нэгтээ

Борооны цуван дээрх дусал шиг тогтон

Тэнгэрийн мандал дахь

солонго руу тэмүүлэн

Энгэрээс зууран халихыг хүснэ

Хаа нэгтэйх төгс төгөлдөрийг

Хаанаас ч юм тэнүүчлэн хайж

Хаа нэгтэйх аз жаргал руу

Хязгааргүй ихээр шунан тэмүүлж

Ховсын хүчинд ухаан алдана

Хоёр алхана... тэгээд зогсоно

Хаа нэгтэйх зөөлөн исгэрээ

Хаа нэгтэйх нялуун сүрчиг

Хоёр алхана... дахиад зогсоно

Хаана ч хамаагүй намайг хүлээх

Хаа нэгтэйх төгс амьдралруу

Хэд алхана... нисэхийг хүснэ.

Бүжихүй

Санаа алдам сайхан харцанд чинь

донтчихоод

Саран авхайгаас нуун байж

хальтхан харчихаад

Сураг хүлээн суудалдаа тогтохгүй үсчээд

Солиорсон мэт бүжмээр байна хайрт минь

Уруулд чинь дөхөх гэж

Урагшаа алхан

Гараас чинь атгах гэж

Газраас хөөрсөөр

Тэнгэрийн нарнаас утас шүүрсэн мэт

Тэвэрт чинь шигдэн дүүлмээр байна

Чи бидний харцны үзүүр

нэг аяс дээр эгшиглэж

Чи бидний сэтгэлийн хэмнэл

нэг чавхдас дээр тоглож

Бэлхүүсийг минь чангахан тэвэрч

Биеийг минь халуун гараараа ил

Би чамд захирагдан хэмнэл дагая

Бирд шиг хүсэлд чинь гал нэмж

Би чиний амьсгал дээр бүжихүй агаар байя

Би чиний судсан дээр

эргэлдэхүй цусан байя

ХОРЬЖ ЧАДАХГҮЙ ХОРИН НАСЫГ..

Хавартай тэврэлдэж, үнсэлцэж

Хар гэзэгээ салхинд намируулан

Энгэрээ задгайлж гангарах

Хорин насыг хорьж болдоггүй юм

Хүүхэд шиг эрхэлж хэлээн зажилаад

Хүүхэн шиг аальгүйтэж уруулаан будах

Хэтэрхий хөнгөн хорин насыг

Боль гэсэн ч үгэнд ордоггүй юм

Торго дурданд нүдээ унагаж

Толь шилэнд нүүрээ наасан

Тэнэг гэнэн энэ насыг чинь

Зэмлэлээ гээд ч арганд ордоггүй юм

Одоо болно орхи түүнийг

Нимгэн банзалтай жиндэж хөрсөн ч

Нүдээн гартал гоёж гоодсон ч

Бүү зандар тэрнийг минь

Богинохон ирээд хурдхан одчихно



Цэвэгмидийн ОЮУНЦЭЦЭГ

МҮЧЗХ-ний гишүүн Одоогийн Говьсүмбэр аймгийн нутагт /Түшээт хан аймгийн боржигон цэцэн вангийн хошуу, Дундговь аймгийн Чойр суманд/ 1960 онд төрсөн. МУИС-ийг МХУЗ-ын багш, хэл судлаач мэргэжлээр төгссөн. 1996 оны Данзанравжаагийн наадмын Тусгай шагналт, “Миний нутаг” яруу найргийн Тэргүүн шагналт. “Хайр гуниг бодрол” яруу найргийн түүвэр, “Танд цуглуулсан амтат бал” сургалт танин мэдэхүйн эмхэтгэл хэвлүүлжээ.

Сүмбэрийн 10 жилийн анхны төгсөгч, анхны яруу найрагчдын нэг АБТА, МУСТА магистр багш маань одоо Багануур дүүргийн “Боловсрол” цогцолборт ажиллаж амьдарч байна.

ОГООРООД Ч ЯАХ ЮМ

Гэгэлгэн бодол өлмий товшин сэтгэлд бүжиж

Нэхэл хайрын их л урсгал сэтгэлд үерлэж

Гэгээн уянга намайг цаламдан чамд тушааж

Нэлэнхүй орчлон тэр аяараа инээж байх юм.

Сэргэлэн бодол уянга дуутай өнгө хоршиж

Сэмхэн намайг гэнэхэн уярлаар хайлуулж орхих юм

Тэрхэн зуурын жаргал гэрэлтсэн их хайраар

Тэвэр дүүртэл хэнийг ч гэмээнэ хайрлам санагдах юм.

Хөлчүү сэтгэл, хөөрхөн ааль хөвсөлзөн байж

Хөнгөхөн болоод өнгөхөн хорвоод жаргаагаад авах юм

Хүний орчлонг мөнхийн юм шиг эндүү бодож

Хүрэн зүрхээ хүний юм шиг зовоогоод ч яах юм.

Оргилуун дарс бид хоёрын сагахын зуурхан

Ондоо хэн нэгэн чамтай тэрслэхийн зуурхан

Оддыг буулгаж, цэцгийг тэнгэрт ургуулаад ч яах юм.

Огт оргүй хоосон чанарыг харин огоороод ч яах юм

ТИТМЭЭР ГОЁСОН БИЧИГ МИНЬ

Агуу ихийн утгыг шингээсэн

А-үсгийн титмээр, номынхоо

хуудсыг эхлүүлдэг

Өвөг дээдсийнхээ өлмийд сөгдье.

Өнөд бишрэн шүтье.

Агудам –дэлхийн цээжинд

Агула-ын ихийг сүндэрлүүлсэн

Алаг хорвоогийн энгээр

Агучлал-ын ухааныг сүсэглүүлсэн

Абу-ийн гэрийн хойморт

Амар амгаланг хурайлсан

Андгай тангаргын ёсонд

Андын журумыг тунхагласан

“А”-Агуу ихийн утгатай

Алтан ургийн үсэг минь ээ.

Эхэ- ихийн утгыг ч

Дүрсээр ялган урладаг

Эндүү ташаа болохыг ч

Эгшгийн нийлэмжээр ялгадаг.

Ацаг шүдний зөрөөгөөр

Аюулын харанга ч дэлдэх

Эндүүрч андуурч бичимгүй

Эцгээс минь захиастай

бичиг минь ээ

“Э”- Эх орныг минь багтаасан

Эрдэнийн хэлхээ үсэг минь ээ.

Тэнгэр тэтгэж хайрласан

Титмээр гоёсон бичиг минь ээ

Оюуныг минь цэлмээсэн

Онгодын цагаан хүлэг минь ээ

Орших олшрохыг билэгдсэн

Орчлонгийн оёоргүй билэг минь ээ

Өндөр заяаг минь түшилцсэн

Өлмий бат хийморь минь ээ

Өсөх өрнөхийн шившлэгтэй

Өөрийн биений минь зурлага минь ээ

“Ө,Ү,О,У”-Өнгөрсөн одоог бичиглэсэн

Өнөд мөнхийн үсэг минь ээ

Наашаа сэтгэлтэй бүхнийг

Инагш дандаа дуудсан

Ямагт мөнхийн хайрыг

Янаг амрагаар мөнхөлсөн

Язгуурын тэнгэр заяаг минь

Яруу найргаар шүлэглэсэн

Ятгын аялгуутай эгшиг минь

Яахын аргагүй “Уянга” минь ээ

Тэнгэр тэтгэж хайрласан

Титмээр гоёсон бичиг минь

Үүх түүхийг минь таниулсан

Үнэний “хэлмэрч” бичиг минь ээ

Үр хойчийг минь гэгээрүүлсэн

Үргэлжийн хүндэт “элч” минь ээ

Мянган үе дамжсан

Мартагдашгүй “ өв соёл” минь ээ

Морин дэл дээр хөвөрсөн

Мөнхийн хөх “судар” минь ээ

Эзэн Чингисийн зарлигдсан

Их цааз хууль минь ээ

Эртний мэргэдийн цэцэлсэн

Эрчилсэн “ их ухаан” минь ээ

Дээшээ заяат Монголоо дуурсгах

Дэлхийд гайхагдсан бичиг минь ээ

Дэргэдийн дайсан ч халдамгүй

Дархан хилийн дээс минь ээ

Тэнгэр тэтгэж хайрласан

Титмээр гоёсон бичиг минь ээ

“ИХ НАЙРАГЧ ЧОЙНОМ” ДУУЛАЛ ШҮЛЭГ

“Сайн хүний үр

Сүүт гүүний унага”

/хэмээхийн учир/

Нэг.Уянгын эхлэл.

Баянбулаг, Бор –Ухаагийн хондонд

Буян хурсан Гэлэгренчин ламынд

Чойрын номын уншлага дунд

Чойном найрагч төрсөн юм билээ.

Хийдийн зурхайч литэч лам

Хилс их барианы үед

Гав гинжээр эрхээ солиод

Гяндан шоронд орсон юм гэнэ лээ.

Эцгийнх нь нэрээр бүрэн овоглох

Эрх, зүрх байгаагүй эх

Энхрий үрээ сүүдэр дайрахаас

Элгэндээ тэврэн халхалсан юм билээ.

Хоёр.Уянгын өрнөл

Айл хот саахалтынхан

Алиа бяцхан Чойном хүүгийн

Цагийн зүү болон

Чаг Чаг Чаг Чаг савлан эргэлдэхийг

Цаас аван таталган зурахыг

Цахилан ,товшин бүжихийг

Цангинатал дуулж ,ерөөл хэлэхийг

Цээжнээсээ цэцлэн шүлэглэхийг харан

Гэр дүүрэн инээлдэн баясч

Гэгэлзэнхэн хөгждөг байсан гэдэг

Гарын ур гаргаж сийлсэн

Гайхам урланг нь биширсэн гэдэг.

Гараасаа хөтөлж хүн болгосон

Гангар цагаан эх нь

СССР улсад Рабфак-т суралцаж

Сэхээтний боловсрол эзэмшсэн юм билээ.

Гоёхон сайхан Рэгзэн эгч шиг

Ганган хүүхэн болохсон гэсэн

Гандсан дээлтэй, сайртай охид

Гаднаа саравчлан үлдсэн гэнэ лээ.

Саруул ухаантай аавын “Нуган”

Санаа цайлган ээжийн “Алдрай”

Чухаг гурван эрдэнийн хэлхээ

Чойном найрагчийн намтрын хуудас аа.

Гурав.Уянгын тайлал

Чойном- Үерхлээр бялхсан

“Зүрх”-ээ инээлгэж

Үнэнээр амьсгалсан

“Шударга”-аа тунхаглаж

Үхлээс айгаагүй “Зориг”-

оороо хатуужсан

“Үзэл”-д төөрөөгүй

“Найрагч” байсан юм

Чойном- Магнагт умбаагүй

эгэлхэн боргил

Маргаашийг зөгнөсөн

ардачлалын түүчээ

“Магтаалын зуун”-д тал засаж

Малгай тавьж хоноглоогүй

“Найрагч” байсан юм.

Чойном- Айдас нөмөргөсөн “хулчгар” жарны

Ам хагалсан

“Улс төрийн хэрэгтэн”

Хэлэхүйг сөнөөсөн

“Нийгэм журамтан”-ы

Сэрэхүйг сэрээсэн

“Найрагч” байсан юм.

Чойном- Эцгийнхээ хайрласан нэрээр

“Номон судар байсан юм.

Эхийнхээ хайлсан хайрын охиор

“Оргилсон булаг” байсан юм.

Чойном- Өрөөлийг хурцалсан шад шүлгээрээ

“Очилсон цахиур байсан юм.

Өнөө ч бидний онгодыг асаасан

“Өнө мөнхийн бамбар” юм аа.



Гэндэняримпэлийн МАЙХАНТ

Гэндэняримпэлийн Майхант 1942 онд Дорноговь аймгийн Даланжаргалн сумын Цохио хэмээх газар төрсөн. Соёл урлагийн газарт бүжигчин, жүжигчин, жолоочийн ажлыг хийж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан.

УЯНГЫН ҮДЭШ

Нугас нуугин долгио бидэрлээд

Нуур ариухан дөлгөөхөн

Навчис нь намуухан шивнэх

Уянга цагаан хус модны дор

Орь залуу хонгорхон хоёр

Уярал хайранд умбан

Уруулын баланд мансуурна

Аяа дурлал хайрын гэрч

Дугариг цагаан сарны дор

Хос залуусыг учруулж

Хорвоогийн цэнгэлд бүүвэйлсэн

Уянгын үдэш намрын үдэш ээ

Уулс зүүрмэглэн шувууд нойрсоод

Хорвоо аниргүй амгалан

Цэцгэс хонин жороо салхины аясаар

Танго бүжин цэнгэл нэмээд

Хаа нэгтээ баян хуур намуухан эгшиглэхэд

Хайрын халуун шивнээ

Зүрхэн дундуур үерлэнэ

Аяа олон тансаг учралын гэрч

Од хариулсан сарны дор

Хос залуусыг учруулж

Хорвоогийн цэнгэлд бүүвэйлсэн

Намрын үдэш, уянгын үдэш ээ

НАМАР

Хайлгийн цагийн тос даасан

Хангайн царманд буга дуудсан

Архад хөхүүрт айраг шаагисан

Яруухан хосууд яарч хүлээдэг

Яншивын арван долоон айсуй намар аа

ХҮЛЭГ

Одод очих хорвоогийн

Анир намуун үдэш

Янзган цоохор адрагатай

Адуун сүргийн захаас

Гүйгүүл шунхлай хүлэг

Газар үнэрлэж хөрвөөгөөд

Дөмөлзтөл янцгаасаар холдоход

Хашгай дөрвөн туурайнаас нь

Оч бадрах гайхамшиг

МИНИЙ БАГА НАС

Өрх цоорхой бор гэр

Нэхий манцуй хялгасан живх

Авсан ээжийн шивнэсэн нэр

Ган тулга галын илч

Иргэн хонины тураг сүүл

Ээдэж хувирдаггүй ээжийн хайр

Ухнаас ойчоод уйлаагүй цүрдгэр

Хуйвтай шилбүүр “Шувуун саарал”

Хурганы бэлчээр “Сүнжидмаагийн нутаг”

Хусам, тараг ходоодын баясгалан

Дааган хүлэг, даавуу цүнх

“А”-аас эхэлсэн алсын харгуй

Охин шоглосон дүрсгүй тархи

Айлын эгчийн алганы амт

ДУУЧИН БҮСГҮЙД

Шиврээ намираа аалиараа

Зүрхэнд уянга шивнэсэн

Хаанах нутгийн бүсгүй

Ханьсахын жаргалыг дуулна вэ?

Ай хө

Хайрын чинь сэтгэ

л хөвөлзөөд байна уу даа

Цэнгүүхэн сэтгэлийг хөгжөөсөн

Халгин жороо харцтай яа

Хун цэнгийн ганганаатай

Тунгалаг нуурын хөвөөнд

Зэ хө

Хайр амтлан хамтдаа дуулахсан

НУТАГ

Нумлан татсан солонгоны

Тунамал долоон өнгөтэй

Үйл мэтгэн тормолзох

Үзэсгэлэн гоогийн талимаатай

Үүрийн тунгалаг туяаг

Өрхөн дээгүүрээ цайлгаад

Өлмий дороос нь нар мандсан

Миний сайхан нутаг

Хамгаас үнэтэй энэ нутгаа байхад

Харийн газар ясаа тавихгүй би

АРИУСАХУЙ

Өлзий цагаан үүлсийн дор

Амар амгалан хөвчийн гүнд

Анис анхилах агаар ариун

Өгөөмөр энэ орчлон

Хөч аялгуут

шувуудын жиргээнд

Атгаг буртаг товрог болоод

Яруу уран сэтгэмж төрвөө

ЭНХРИЙМАА

Эрэвгэр нүдэн Энхриймаа

Манай айлын дунд охин

Нартад мэндэлсэн

“Үлэмжийн чанар”

Намайг сорьсон ялдам бүсгүй

Улсын начин хүдэр залуугийн

Ухаа хонгор

уяан дээр эрэгцэнэ

Учиртайхан инээд

хаяагаар цалгихад

Урагшгүй би

өөрийгөө өрөвдөнө

ЗУН

Үүл цуучин аянга нүргэлээд

Үер бууж дэлхий дэлгэнэсэн

Дэлгэр зун цэцгэн хээтэй

Ширээ нуурын сэрүүн дэнжид

Сэргэлэн багачуудын

Ум-Ра-Зай цалгиад

Налгар зун наадмаа хүлээдэг

Ундаассан бурхад

болзоонд яарсан

Уянгын халилтай зун

Хайрын..,Хайрын эгшиглэн

ОМОГШИЛ

Этүгэн эх, их түүх

Эх хэл, эртний соёл

Омогшиж бахархах үндсээ

Хан тэнгэрийн тамгатай

Хаш цагаан ястан та бид

Өрцөө цөмөртөл өмгөөлөхгүй юм бол

Би монгол хэмээн цээжээ яахин дэлдэх



Цэдэнхүүгийн ЦОГБАДРАА

Түшээ гүний хошууны Боршиг овогтой Цэдэнхүүгийн Цогбадраа 1948 онд малчны гэр бүлд төрж өсөн торнисон. 1965 оноос тус смын төвд худаг усны засварын мастер, гэрлийн моторчин, мужаан зэрэг ажил хийж байгаад 2002онд өндөр насны тэтгэвэрт гарсан. Одоо Говьсүмбэр аймагт амьдарч байгаа.

ААВ ЭЭЖ ХОЁР МИНЬ

Алдаатай оноотой хорвоод

Ахиж мандахгүй наран саран

Алаг үрс бид нарыгаа

Алтан хэвлийгээсээ төрүүлсэн

Будантай манантай тэнгэрт

Буцаж ирэхгүй халин одсон

Буурал хорвоогийн жам ёсоор

Бурхан оронд явсан аав ээж минь

Эрээнтэй бараантай энэ орчлонд

Эргэж ирэхгүй заларсан

хоёр бурхан минь

Эгч дүү бид нартаа

Энэ насан олдох хос бурхан

Хөрст дэлхийд үлдсэн үр биднийгээ

Харж байдаг бол бурхад минь

Хаана явж байгааг үзэж байдаг бол

Мөнх нойрссон аав ээж хоёрт минь

Мөнгөн сар нартай тэнгэрээс

Мөч болгонд ажиж байдаг бол

Мөрөөрөө л амьдарч байна даа бид

Ачит төр засгийн ивээл дор

Ард олон түмнийхээ түшиг тулгуурт

Алаг үр ач зээ нарынхаа халамжинд

Амьдарч л явна даа бид нар чинь

Өвчин зовлонгүй эрүүл саруул

Өгөл авалгүй сэтгэл тайван

Өмсөх хувцастай мөр бүтэн

Өтөлсөнөөс өөр өөрчлөлтгүй

Сар нарны гэрэл туссан

Сайнтай муутай энэ орчлонд

Сайхан амьдарч байна даа бид

Санаагаа зовоолгүй тайван нойрсоорой

Аав ээж минь

ЧОЙРЫН БОГД

Үзэмж сор нь гялалзсан

Чойрын богд уул

Үүлтэй тэнгэрийг баганадсан

чандмань эрдэний хайрхан

Газрын холоос бараа нь харагдах

суварган цэнхэр уулс

Галав эртнээс нэр нь адаршсан

сударт өндөр хайрхан

Эртний алдартай энэ уулаа

Эндхийн ард түмэн бүгдээрээ

Эрт дээр үеэс шүтэн биширч

Энх амгалан амьдарцгаан

Өвгөн буурал энэ хайрхандаа

Өчнөөн жил нутаглан дасаж

Өнөр олноороо эрүүл мэнд

Өнөтэй сайхан нутаглаж

Жилийн дөрвөн аль улиралд

Жирмийн шугуй шиг өндөр өвстэй

Жалга судгандаа нөмөр дулаан

Жавар салхинд даарахгүй ордог

Нутаглаж байгаа амьтан бүхэнд

Нуур ус өвс ургамал нь

Нуга жалг тал хөндий ялгаагүй

Нарийн өвс бут мод ургасан

Малчин олон ард түмэнд

Маш тохиромжтой нутаг болохоор

Малаа таргалуулж тухлан суухад

Малтай айл бүрийн тавтай нутаг

Өвөл зунгүй малаа бэлчээж

Өвөр аргүй тойрон бууцгааж

Өгөөжтэй энэ уулынхаа хормойд

Өвгөрч хөгширтлөө энд байгаа

Азай буурлууд бүгдээрээ

Асга хадтай нөмөр дулаан

Алтан дэлхий өгөөжит хайрхандаа

Айраг сүүнийхээ дээжийг өргөж

Байгалиас заяасан энэ ууландаа

Багаасаа эхэлж нутаглаж дассан

Буурал толгойт өвгөд хөгшид

Байнга шүтэн биширдэг

буянтай хайрхан

ААВЫН МӨНГӨН АЯГА

Аавын мөнгөн аяганд

Айраг дүүргээд өглөө ээж

Аав түүнийгээ уучаад

Адуундаа мордоод давхилаа

Ээжийн чанасан

цайны дээжийг

Энэ л аяганд хийдэг юм

Элбэг хээрээрээ мордсон

аав минь

Эрчит зэлэндээ

унагаа уяад ирлээ

Завьяа модтой мөнгөн аяганд

Самарч уудалсан

цайгаа хийлээ ээж

Загал мориороо мордсон

аав чинь

Залсан адуугаа

хураагаад ирлээ

Цалин мөнгөн аяганд нь

Цацал айраг дүүрэн байна

Цал буурал аав минь

Цангаагаа тайлан ууж сууна

Хаш мөнгөн аяганд нь

Хайр дүүргээд ээж барьлаа

Халуун сэтгэлийн ууранд нь

Ханхар гэр

тэр аяараа дулаацлаа

АЛАГ АЗАРГА

Асгат өндөр уулын

Араар эмжсэн хормойд

Аглаг ногоон талын

Атар сайхан бэлчээрт

Алаг хээрлэг азаргатай

Адуун олон сүрэг

Аагим халуун наранд

Арав таваараа бөөгнөрч

Түмэн ялаа бужигнахад

Сүүл шарван тургина

Тарга хүчээ гүйцсэн

Сүрэг адуу тогтоно

Бут товцог дотроос

Болжмор гэнэт үргэлээ

Хээрийн намуун тэнгэрээс

Хэрээ дуугарах сонсогдлоо

Алсаас гарсан тэр чимээг

Алаг азарга сонсоод

Адуугаа бөөгнүүлж хураагаад

Анхаарал татсан тэр зүгээс

Араатан чоно гарч ирэхийг

Алаг азарга олж хараад

Адуугаа ахин нэг тойроод

Болжмороо үргэсэн тэр газраас

Боохой гараад айсуйг

Бараа харсан алаг азарга

Бахим дөрвөн туулайгаараа

Гал бутартал газар цавчилж

Галзуу юм шиг дороо эргэлдэж

Ганган хөөрхөн хамраараа

Газар манартал тургиж

Ижил олон сүргээ

Ирэх дайснаас хамгаалах

Иртэй дөрвөн туурайгаа

Их тулаанд бэлдээд

Хөх чоныг хүрээд ирэхэд

Хээрлэг азарга ч угтаад очлоо

БИ МАРТАХГҮЙ

Хүн болж эхлээд

Хөлд орж газар гишгэхдээ

Хөрс шороонд нь мөрөө гаргасан

Хүрэлдийн булангаа

Би мартахгүй

Өсөх залуу насаараа нутаглаж

Өчнөөн жил энд амьдарч

Өвс усаар нь мал хүнгүй усалж

Өдийг хүртэл нутаглаж ирсэнээ

Би мартахгүй

Хар хүрэн тэмээн сүргээ

Ханан хэцийн өргөн хярд нь

Хариулж маллаж явсанаа

Хадуу чулуугаар нь тоглож өссөнөө

Би мартахгүй

Хувхай саарал чоно ч

Хурд мэдэн зугтаалаа

Хул морьтой адуучин ч

Хуй салхи шиг хөөгөөд одлоо

Адуучин эрийн хул морь

Араатан хөх чоныг

Амархан гүйцэж аваад

Ард нь тулж очтол

Аргагүй гүйцэгдсэн боохой

Амай ангайн эргэх гэтэл

Адуучны тэнзэн ташуур

Агирсан хамарт нь буулаа

Хөвчийн хөх чоныг

Хөөгөөд номносон болохоор

Хөдөөгийн энэ сайхан бэлчээр

Хөндлөнгийн аюулгүй болгож

Атар сайхан нутаг нь

Айх аюулгүй болсон болохоор

Ард олон малчид

Амгалан тайван малаа адгуулж

Өргөн хангайн нутагтаа

Өнөөг хүртэл тааваараа

Өвөлжиж, хаваржиж, зунжиж

Өнтэй сайхан намаржиж

Жилийн дөрвөн улиралд

Жавартай хүйтэн болсон ч

Жигтэйхэн халуун байсан ч

Жаргалтай сайхан а

мьдарцгааж байна

Хэлэлцээтэй юм шиг уулзаад

Хэлхээтэй юм шиг тэмцэлдэх

Онгон хээрийн энэ бэлчээрт

Орог саарал аюулт чононоос

Олон ижил сүргээ хамгаалах

Онцгой ширүүн тулалдаанд

Согоо хоёр чихээ алаг азарга

Сортойж байсныг хулмайж дайрлаа

Соотон чихтэй саарал чоно

Соёо шүдээ арзайлгаж үсэрлээ

Энэ хоёр ингэж тулалдсаар

Эр чадал авхаалж самбаагаа

Эрэлхэг зориг хүч чадлаа

Эцэж цуцатлаа тэмцэлдэн

Аль аль ядарлаа

Асгарах цус нь ч гоожицгоолоо

Адуун сүрэг нь харин тэднийг

Ажиглаж харж зогсохдоо

Даага унаганаасаа аваад

Давжаа жижиг болгоноо

Дундаа хийж тойроод

Дайтаж тулалдахыг харж зогсоно

Уулын саарал чоно ч

Урдаа таарсан болгоноос

Урж сэтэлж хазсаар

Улайран дайрсаар байлаа

Алаг азарга харин бас

Аль таарсан газарт нь

Арьсыг өмөртөл цавчилж

Ар өвөргүй зөрөн өшиглөж

Амь өрссөн энэ тулалдаанд

Алалдаж тэмцэж байтал

Ард нь гэнэт хүн дугарч

Адууны эзэн давхин ирлээ



Ганбаатарын БАТБАЯР

Ганбаатар овогтой Батбаяр 1988 онд Дорноговь аймгийн Сүмбэр суманд төрсөн. Төмөрзамын Дээд сургуулийг төгсжээ.

ДУРЛАЛ

Бүүдгэр сартай нэгэн орой

Бүхэл шөнөжин нойр минь хулжлаа

Бүтэлэгүй болсон хайрынхаа тухай

Бүтэн шөнөжин бодлогоширон хонолоо

Дурлал хайрын сайхныг мэдрээд

Дутах зүйлгүй сайхан байжээ

Дурлал хайраа чамаар хөглүүлж

Дэндүү их жаргалтай явжээ

Орчлон дээр чамаас өөр

эрдэнэ байхгүй юм шиг санаж

Омогшиж би дэндүү бардам явжээ

Оргилсон их хүсэлдээ автан

Өөрийгөө ч мартан би чамайг л гэдэг байж

Гэрэлт наран бидэнд ав адилхан туссаар байхад

Гэнэтхэн намайг яагаад үүлэн сүүдэр дайрав

Гайхамшгт сайхан хайрыг минь

Гэгэлзсэн гунигаар юунд солив

Мөрөөдөл хүслээ биелүүлэх гээд

Мөн ч удаан тэссэн юмсан

Ганцхан олдох хайр минь гэж

Хэнээс ч илүү итгэсэн юмсан

Өнөөдөр тэгтэл миний сэтгэл

Өнчирч хоцрон ганцаар шаналлаа ч

Өөр хүнтэй болсоныг чинь сонсоод

Өнгөцхөн дурлал байсныг нь би мэдэрсэн

Намрын шөнийн жаргал минь

Зовлон авч ирэх байсан юм гэж үү

Надад өгсөн бүхэн чинь бүгд

хуурамч байсан юм гэж үү

Чин сэтгэлийн минь хайрыг олж харахгүй

Чиний сэтгэл минь тийм сохор байсан юм гэж үү

Чанга хатуу үгээр намайг гомдоосон ч

Чамд өгсөн хайр минь дундраагүй

Зүрхэнд шивнэсэн хайрын үгс минь

Зүгээр л хийсээд явчихсан юм гэж үү

Яасан богинохон дурлав вэ?

Яасан хэцүү амьдрал вэ?

ААВДАА

Энэ хорвоод хүн болж төрснөөс хойш

Эргэцүүлж би олон зүйлийг бодсон

Энх тунх энэ амьдралдаа би

Эргэж буцалтгүй бахархалтай явнам

Эрээнтэй бараантай энэ орчлонд

Эгэлхэн нэгэн гэр бүлийн итгэл болж

Эцгийн голомтыг залгах

Их хүү нь болсондоо би баярладаг

Алхам бүрийг минь надад заагаагүй ч

Амьдралын ухааныг мэдрүүлсэн

Аавыг би хүндэлдэг

Элдвээр үглэж загнадаг ч

Дэндүү уяхан сэтгэлтэй эжийдээ би хайртай

Хосгүй хайраар биднийг ивээгч

Ховорхон заяах бурханаа би

Хэнээс ч илүү хүндэлж

хэнээс ч илүү дээдэлж

Хэнээс ч илүүгээр хайрлаж хэнээс ч

илүүгээр баярладаг

Баярладаг би айдаг

Бахархдаг ч би хэлж чаддаггүй

Бодол болон ганцаар суухдаа л

Би та хоёртоо хайртай шүү гэж

дотроо шивнэдэг

Эртлэн босож цайг нь чанаж өгөөгүй ч

Итгэлийг нь алдаж сэтгэлийг нь

сэвтээх вий гэж айдаг

Үглэж загнаж зандрахаас нь бишээ

Үнсүүлж зэмлүүлэх хүнгүй

болчих вий гэж айдаг

ЗҮҮД

Шөнө дунд би сэрэв

Сэтгэл минь ихээр догдолсон байв

Гэрийн гадаа чимээ гарч

Гайхамшигт зүүдийг минь

таслаж орхив

Гэгэлзсэн сэтгэлээ чагнан байж

Гэрэлт сайхан зүүдээ санав

Цэвэрхэн царайтай нэгэн бүсгүй

Цээжийг минь налан

дэргэд минь суух юм

Танхилхан дуутай тэр бүсгүйн

Нэрийг нь би өөрөө

мэдэхгүй байх юм

Тэврүүлж надтай байгаа болохоор

Тэнгэрээс заяасан

хань минь бололтой

Зөөлөн үсийг нь илбэн суухдаа би

Зүйрлэшгүй их жаргалтай байх юм

Зүүд тасалдаж би сэрэв

Зүрх минь тэгээд догдолсон байж

Үргэлжлүүлж би зүүдээ үзэхээр

Нүдээ анин чимээгүй хэвтэв

Нэрийг нь мэдэхгүй бүсгүйгээ

Дахин би зүүдэлсэнгүй

Хайран боловч сайхан зүүдийг

Хэзээ ч би мартахгүй ээ

Зүүдэндээ харсан тэр бүсгүйгээ

Заавал би хайж олно оо

АНДУУД

Сурагч багын танхил насандаа

Санаандгүй учралаар бид найзууд болсон

Сэтгэл зүрхээрээ санаа нийлж

Сэлүүрт завинд бид хамтдаа суусан

Зөнгөөр давалгаалах амьдралын далайд

Зөөлнөөр сэлүүрдэн бид хөвлөө

Давалгаа ихтэй амьдрал дунд

Дандаа бид хамт байлаа

Хүслээр жигүүрлэсэн энэ гэгээн амьдралд

Хэнийгээ ч марталгүй бид хамт явсан

Хайраас хагацаж сэтгэл нь шаналах үе

Хэн хэндээ бид түшиг болж явсан

Ганцаардаж нэгнийгээ уйлахад нь

Гунихарч хамт байлаа бид

Гэгээн орчлонд нас нэмэхэд нь

Улирч хамт байлаа бид

Тоглоом наадмын үед ч

Хөгжилдөж хамт байлаа бид

Торгон агшин тааралдахад

Баярлаж хамт байлаа бид

Омголон залуу насандаа бид

Оргилсон хүслээр дүүрэн амьдарна аа

Орчлон дээр бид хэнийгээ ч гээлгүй

Онцолж нэгнээ хүндэлж явна аа

Дэлхий сүйрч завь минь хөмрөхгүй л бол

Дэврүүн их нөхөрлөл минь хэвээрээ

Хөлгүй цэнхэр амьдралын далайг

Хамтдаа бид сэтгэл зүрхээрээ туулна аа

Хөөрсөн сэтгэлдээ би автан

Хэдэн мөр шүлэг бичлээ

Хэдэн сайхан андаараа би

Хаана ч явсан бахархаж амьдарна аа

XXX

Сар мэлмэрч салхи сэвэлзэж

Санаа бодлыг минь гэгэлзүүлж байна

Бодох тусам улам ихээр санаж

Булиглах зүрх минь догдлон цохилно

Уулзах өдрөө тоолон хүлээж

Учирах цагаа болзмоор санагдана

Хүлээсэн сэтгэлийн цангааг тайлж

Хамтдаа хөтлөлцөөд алхах юмсан

Цаг мөч бүхэн бодлоос гарахгүй

Цаанаа л нэг үгүйлээд байх юм

Зүс царай чинь сэтгэлд тодхон ч

Зүүд нойронд минь үзэгдэхгүй юм аа

Холдох мөчгүй хамтдаа байж

Хөөрхөн царайг чинь ширтэн сууж

Хорвоод хоёулаа амьдрах юм сан

ХАЙРЫН ДУУ

Үүрэглэх шөнийн гэрэлт одод

Өр зүрхийг минь уяртал дуулна

Үнэнч ариухан миний сэтгэлийг

Өөрийн эрхгүй догдлуулж дуулна

Хацрыг чинь үнсээд

харцыг чинь ширтээд

Хайрын өдрөөр чамайгаа тэврээд

Хайртай гэдгээ зөөлөн шивнэж

Хагацахгүй гэдгээ чамдаа амлая

Гэрэлт оддын гайхамшигт гялбаа

Гэгэлзсэн сэтгэлийг минь

хөөргөж орхилоо

Хөөрсөн сэтгэлийн цагаахан итгэлээр

Хайрын сайхныг би мэдэрч сууна

Хацрыг чинь үнсээд

харцыг чинь ширтээд

Хайрын өдрөөр чамайгаа тэврээд

Хайртай гэдгээ зөөлөн шивнэж

Хагацахгүй гэдгээ чамдаа амлая

Намуухан шөнийн аниргүй дунд

Намайг эзэмдсэн сэтгэлийн дуунд

Найган бүжих моддын дунд

Намайг хөглөсөн хайрын дуунд

Хацрыг чинь үнсээд

харцыг чинь ширтээд

Хайрын өдрөөр чамайгаа тэврээд

Хайртай гэдгээ зөөлөн шивнэж

Хагацахгүй гэдгээ чамдаа амлая

XXX

Дэрхийн нисэх шувууд адил

Дэггүй хайрыг минь үргээж чи явлаа

Дэндүү уяхан сэтгэлд минь

Дэвтэшгүй их шаналал үлдээлээ

Хайрт чамайг нисэн одоход

Хоолой зангирч сэтгэл гороолоход

Сэтгэлийн цангааг тайлах гэж

Сэм сэмхэн би хэн нэгнийг хүлээнэ

2008.11.14.

Сарны мөнгөн туяан доор

Сайхан түүнтэйгээ тэврэлдэн зогсохдоо

Хайраар гэрэлтсэн орчлонд

Хамгаас жаргалтайгаа би мэдрэнэ

Одод чуулсан мөнгөн үдшээр

Оргилон ундрах хайрын сэтгэлээ

Сайхан цэцгэс дэлбээгээ нээх адил

Сэмхэн шивнэж хэлэх би дуртай

Гараа зөрүүлж чамайгаа тэвэрхэд

Газраас хөндийрч тэнгэрт нисэх шиг

Гайхамшигт ягаахан уруулыг чинь үнсэхээр

Гэрэлт орчлонгоос тасран одох шиг

Энэ хорвоод жаргалыг би амслаа

Энэ орчлонд хайрыг би мэдэрлээ

XXX

Тэнгэрт анивчих оддыг би ширтэн хэвтэнэ

Тэртээ холоос над руу нүд ирмэх шиг санагдана

Тэдэн шиг агуу их хайрыг би хүснэ

Тэрүүхэн тэрэндээ би чамайг л ганцхан үгү

Сэтгэлийн жигүүр итгэлийн гэрэл залуу насанд

Сэрэхгүй үргэлжлэх зүүд шиг амьдралд

Зүйрлэшгүй олон учрал тохиол дунд

Зүрх сэтгэл минь дэврэн дэврэн булгилаж явлаа

Өнөөдөр харин миний сэтгэл

Өөрчлөгдөн солигдон эсрэгээр эргэж

Өөгүй сайхан залуу насандаа

Өр зүрх минь шархалж явна

Хоёр нүд минь нулимсаар уйлж

Хосгүй сэтгэл минь чамаар уйлж

Хөөрхий бодол минь чамаар уйлж

Хагацсан зүрх минь цусаар уйлж байна

Орой унтах гээд хэвтэх болгондоо

Оноо алдаагаа дурсан бодно

Одтой шөнөөр ганцаар суухдаа

Онцолж ганцхан чамайг л бодох юм

Олон сар өдөр өнгөрсөн ч гэлээ

Оюун санаанаас гарахгүй байх юм

Ондоо хүнийг сэтгэлдээ тээсэн ч

Орлож чамайг чадахгүй байх юм

Үргэлж чамайг санан мөрөөдөж

Үнэнч сэтгэлээ өрөвдөн харуусаж

Өөрийн эрхгүй сэтгэл минь шанална

Дасаж, хагацаж, уйлж, ухаарч

Даанч их зүйлийг

залуу насандаа би мэдэрч

Дуулж, дурлаж, дэвэрч, цалгин

Дэндүү ихээр бардамнаж ч явлаа..гэвч

Өнөөдрийг хүртэлх энэ амьдралдаа би

Өнчирч, ганцаардаж, шаналаж явсан ч

Өөр хүний өвөрт ороод явахыг чинь

Өөрийн нүдээр харна гэж

төсөөлсөнгүй явлаа

Гайтай тэр жихүүн орой

Ганцаардсан сэтгэлээ бүр ихээр мэдэрч

Галзуурч бачууран зүрх минь шатавч

Ганцхан чамайг л бодож би тэсэн суусан

Санасанаар болдоггүй хорвоо дээр

Салаа зам олон байх юм аа

Хүслээр болдоггүй хорвоо дээр

Хүний амьдрал гэж хэцүү юм аа

2009.05.05.

ҮРГЭЛЖИЛСЭН ҮГИЙН БҮТЭЭЛ



Гунгаанамжилын Зоригт

Боржигин овогт Гунгаанамжилын Зоригт нь 1960 онд Дорноговь аймгийн Иххэт сумын Борнуруу гэдэг газар төрсөн. МУИС-ийг философич, нийгмийн ухааны багш мэргэжлээр дүүргэсэн. Сэлэнгэ аймагт зарласан утга зохиогдсон яруу найргийн наадамд 2001 онд Тэргүүн байр, Дархан – Уул аймагт 2006 зохиогдсон үргэлжилсэн үгийн наадмын Дэд байрны шагналтай.

ЖҮЖИГ

Говийн уран зэрэглээнд

Гурван гэр чандмална

Гурван гэрийн гадаа

Арван хүүхэд тоглоно

Эсгий гэрийнхээ хаяанд

Чулуун гэрээ барина

Эцгийн голомтынхоо дэргэд

Эрхэлж наадан жаргана

Ногоон торгон тайзан дээр

Найруулагч олонтой жүжиг эхэлнэ

Зохиогч нь бүгдээрээ энэ жүжигт

Зовлон жаргал бүгд байна

Мянгат малчин Мятав

Маадгар гээч нь алхана

Туслах малчин Тулгаа

Тун ч дурамжхан гэлдрэнэ

Үнээ малаа саадаггүй юм уу гээд

Өнөөх Мятавын эхнэр зандрана

Тулгаагийн гэргий Дулмаа

Хувингаа шүүрэн гарна

Засаг дарга Баадай

Цагаан тэрэгтэй давхина

Түмэн олонтойгоо уулзаж

Төрийн бодлого хэрэгжүүлнэ

Амараа Бурмаа хоёр

Айл гэр болж тоглоно

Аав ээжийн хооронд

Аминчхан яриа өрнөнө

Хэдэн малаа өсгөнө гэнэ

Хэцүү өвлийг давна гэнэ

Хэдэн хүүхдээ сургана гэнэ

Хэнээс ч дутахгүй амьдрана гэнэ

Арван хүүхдийн тоглоом

Амьдралыг дуурайсан жүжиг байна

Оногдсон дүрдээ хуурамж тоглох

Олиггүй жүжигчин алга байна

Хүүхдийн энэ жүжгийн

Хөшиг нь хэзээч хаагдахгүй

Хөдөөгийн энэ театрын

Үүд нь үргэлж нээлттэй

Говийн уран зэрэглээнд

Гурван гэр чандмална

Гурван гэрийн гадаа

Арван хүүхэд тоглоно

Эсгий гэрийнхээ хаяанд

Чулуун гэрээ барина

Эцгийн голомтынхоо дэргэд

Эрхэлж наадан жаргана

Шивээговь. 2013.

Г.ЗОРИГТ “ХОНВЕНЦ”

Сэлэнгэ аймагт зохиогдсон наадмын Тэргүүн байрны шагналт.

Өвгөн Бүргэдийн ач дэгдээхий тэгш сууж чадахгүй эмзэглэн байгааг ангийн багш Тагтаанзаарлаа. Шавь дэгдээхийгээ дуудав. Хонгыг нь үзвэл улаан гүвдрүү болжээ. Тагтаа багш “Нялх амьтныг яаж ингэж болох вэ?” гурр гурр хэмээн зөөлөн дуугарсаар нийгмийн ажилтан Хөхөөд мэдэгдэв. Нийгмийн ажилтан Хөхөөгийн нүдэнд нулимс цийлэгнэнэ. Гүг гүүг, гүг гүүггэж уяхнаар донгодон дэгдээхийн толгойг илбэн энхрийлнэ. Сурвалжилж бас хэн ингэснийг тогтоов. Аймшигт явдлыг захирал Шар шувууд илтгэлээ. Дэлхийн дэгдээхийнүүдийн эрхийн конвенцийг ноцтой зөрчсөн этгээдийг дуудуулахаар Хараацай жижүүрийг нисгэв. Хэрэг ингэж манджээ. Хэдэн жилийн өмнө Бүргэдийн хүү ахиухан хоол олохоор Солонгосыг зорин нисчээ. Гэхдээ гаргасан ганц өндөгөө аав, ээждээ орхисон аж. Өвгөн, эмгэн хоёр өндөгийг хальстай байхаас нь хамаг муугаас хаацайлан халуун элгэндээ дарж өсгөв. Хайр халамжаар дутаасангүй. Ашгүй өндөг дэгдээхий болж арван нас хүрлээ.

Азай буурлууд ачаа үнэнч, шударга, өндөртнисдэг шувуу болгохыг хүснэ. Сургамжилна. Харин ачид нь сайн шувуу болох шинж огт үгүй. Бүргэдүүд хараал хэлэх нь байтугай бие биенээ “Чи” гэж дуудаж үзээгүй. Ийм байтал энхрий ачнь элдэв муухай хараалыг эрээ цээргүй урсгана. Шувуунаас биш шулмаснаас гарах араншинголонтаа үзүүлнэ. Юунаас болоод ингээд байгааг бүргэдүүд олсонгүй. Дэмий л шувууд хараалхэлдэггүй юм. Тэнгэрт хараал хэлвэл хан хурмаст хилэгнэж, газарт ингэвэл лус савдаг дошгирдог юм гэж ахин дахин хэлээд тусыг олсонгүй. Өчигдөр орой өвгөний цухал ихэд хүрчээ. Ач нь телевизийн өмнө бондойн сууж нэгэн киног шимтэн үзэж суулаа. Өнөөх кинонд нь нүүр өөдцус үсэрмээр аллага хядлага гарах аж. Хажуугаар нь хачин муухай хараалын үгсийг хашгична. Бүргэд гадаадын кино орчуулагч олон хэл мэддэг мэргэн Тотьнуудад гомдон суулаа. Ээ халагминь. Эх хэлэндээ хөрвүүлэхдээ энэ муухай хараалуудыг арай зөөлрүүлчихэж болдоггүй л юмбайхдаа гэж. Гэтэл эмгэн нь “Өөр юм үз ээ. Миний хүү. Муухай кино байна” гээд удирдлагыгшүүрэн авч сувгийг солилоо.

Гэнэтхэн ач нь “ Гичий минь ээ. Би энэ киног үзмээр байна” гэж хашгирах нь тэр. Өвгөн Бүргэд өчүүхэн ачаа шүүрэн авлаа. Өмдийг нь шувт татан өөхөн цагаанхонгыг нь гаргав. Далавч юугаа дэлгэн таван салаа боовны амтыг үзүүллээ. Бас “Бай чи. Байчи” гэж уухчина. Харин ач нь “Байя байя” гэхийн оронд “Дэгдээхийнүүдийн эрхийг хамгаалах конвенц байдаг юм шүү. Дараа нь та нар үүнийхээ хариуг амсана даа” гэж хараал, нулимсхоёртоо хахаж цацан чарлана. Бүргэд сургууль руу нисч явахдаа “Ач маань хэрэг тарьсан юм болов уу?. Гайгүй л баймаар юм. Муу эцгийн хүчит далавчаар хэд алгадуулсан байхад овоо олонсар чих зөөлөн хөл хөнгөн явдагсан” гэж бага насаа дурсав. Бүргэдийн бүтэл нь хазайсан өдөр ажээ. Сургуулийн хаалгаар орохын даваан дээр нэгэн болжморийн дэгдээхий шидсэн чулуу шиг нисэн ирж цээж руу мөргөөд хүчиндээ саван уналаа. Тэр маш ууртай дэгдээхий ажээ. Саарьбяцхан сарвуугаараа харагдсан бүхнийг базлан, даарьт борхон хошуугаа тааралдсан болгондирлэнгээ “Муу насны доройтол ясны сийрэгжил замаас зайлахгүй яасан юм бэ?” гэв. Бүргэдийн толгой эргэж дотор нь харанхуйлна.

Харин энэ үгийг хошин шогийнхон хэмээх хэдэн алагшаазгайнууд амьтан инээлгэх гэж тайзан дээр шагширалдан байсныг бүүр түүрхэн санав. Настан бүргэд болжморийн дэгдээхий хоёрын тал талаас баахан дэгдээхийнүүд шаван “Яасан бэ?. Юуболсон бэ?. Чиний эрхийг яаж зөрчсөн бэ?” хэмээн шулганалдана. Нийгмийн ажилтан Хөхөө ирж нөгөөх уурт болжморийн дэгдээхийг “Чанга унасан уу? Гэмтээгүй биз! Чөлөөтэй нисэхэрх чинь зөрчигдсөнд уучлаарай” гэх мэтээр аргадан явууллаа. Харин Бүргэдэд хандан “ Даяндэлхийн дэгдээхийний эрхийн конвенцийг дахин дахин зөрчлөө та. Захирлын өрөөнд очоорой” гэж зэмлэнгүй донгодлоо. Өвгөн Бүргэдэд явах байтугай дуугарах ч тэнхэл байсангүй. Дотроо лихэд гомджээ. Тэдэнд. Өглөөн нарны тунгалаг туяанд хөхөөний уянгалаг донгодоон, болжморийн сэргэлэн жиргээнд сэтгэл баясч яваагүй гэж үү? Хүчтэй шударгыг минь магтан дуулдаг байсан биш үү! Гэтэл одоо яаж донгодож, жиргэдэг болчихдог нь энэ вэ? Бас идэх тариа будааг нь огтоно, зурамнаас цэвэрлэн насан туршид нь хооллосон биш бил үү? гэж. Цаашид Бүргэдийн бүх тамир тасран сөхрөн унахад цагаан нөмрөгт Хун эмч тариа залган авч одлоо. Өвгөн Бүргэдтүүнээс хойш огт ниссэнгүй. Өдөр болгон өндөрт нисч ихийг үздэг байснаа больж үүрэндээ лөөвийж сууна. Ач хүү нь ялсан баатрын дүртэй энд тэндгүй хараал хэлэн чавхдана. Телевизээр улсыг удирдагч Хангарьдууд юугаа булаацалдсан юм бэ? Бүү мэд. Увайгүй муухай үгсээр биесээ хараан хэмлэлдэх ажээ. Бүргэдийн зөвхөн нүд нь л гялалзана.

Хүчит хоёр сарвуугаараа тулгармодоо тас атган сууна. Гэнэт. Хонвенц...,Хонвенц..., хэмээн хоолой нь хоржигнон их дуун гаргантэнгэрт халин одлоо. Эргэж хэзээ бууж ирэхийг нь хэн ч эс мэднэ.

2006 он.Дархан хот.

“ДАНКО”

Би Дорноговийн хүн. Насаараа нутагтаа амьдарсан. Нэг л мэдэхэд их сургууль төгсөөд хоринтаван жил болчихож. Ангийнхан маань уулзая гэж урилга илгээжээ. Хот орлоо. Ганаагийндирлээ. Үүдийг нь тогшлоо. Хаалганы цаана “Данко оо Үүд !!!” гэсэн Ундармаагийн цангинасандуу тод дуулдлаа. Түүнийг сонсонгуут миний тархинд оюутан цагийн нэгэн хөгжилтэй дурсамжаянга цахилгаан мэт гэрэл сацруулан орж ирлээ. Зүрх минь ч баяр жаргалаар дүүрэн будгиллаа.Би тэсэлгүй пис хийтэл инээд алдав. Данкогийн тухай бодох болгондоо дандаа ингэдэг билээ.Уг нь Данко бол Израгель гэдэг эмгэний ярьсан нэгэн үлгэрийн баатрын нэр билээ. Бидний багадтэр зохиолыг хүүхэд бүхэн мэддэгсэн. Утга нь: Нэгэн омгийнхон балар шугуйд төөрнө. Нар үлхарагдана. Тас харанхуй. Тэд хэд хоног шугуйгаас гарч үл чадна. Хүүхдүүд уйлж, хөгшид ёолно.Хүмүүс зовж гаслана. Гэтэл Данко хэмээх залуу чээжээ хага яран зүрхээ суга татан дээр өргөжхүмүүсийг дагуулан замчилна. Учир нь түүний зүрхнээс асар хурц гэрэл цацран гийнэ.Данкогдаган явсаар омгийнхон нь цагаан талд гарна. Гал түлнэ. Дулаацна Бүгд амьд гарсандаа баярлантойрон бүжиглэнэ. Харин галын дэргэд гэрэл сацруулан цовхчин байсан Данкогийн зүрхэн дээрхэн нэгэн нь анзааралгүй гишгэчихэв гэж төгсдөгсөн. Хүүхэд байхдаа их харамсдагсан.Ийм лгайхамшигт үлгэрийн баатарын нэрийг миний найз хүртсэн хүн дээ. Хүртэх хүртэхдээ бүр ГоёУндармаагаас шүү. Уг нь түүнийг Гавал Ганаа гэдэг байсан юм. Гавал гэдэг нь хоч огт бишбөгөөд түүний өргөмжлөл нэр. Яагаад гэвэл тэр улсын тооны гурдан удаагийн аварга билээ.Би цэргээс халагдаж ирээд их сургуульд эргэн суралцахдаа Ундармаа Ганаа хоёртой нэг ангиболлоо. Тооны анги. Ганаатай бүр нэг тасагт орлоо. Аз таарсан юм.

Ганаа нэг өдөр “Би олон улсынуралдаанд бэлтгэж байгаа. Багш нэг л хүнтэй хамт бай гэсэн. Тохитойгоор нь тантай хамт байя”гэж билээ. Цэргийн гурван жил тооноос хөндийрсэн надад бөөн завшаан байлгүй яахав. Тэгээдч хоёулахнаа шүү. Уухайн тас зөвшөөрөв. Ганаа бид хоёр хагас жил сайхан амьдрал. Ганаагаасби мөн ч их юм сурсан. Ганцхан би ч биш. Дээд дамжааныхан хүртэл тоогоо заалгаж бодуулдагбайв. Ганаа огт төвөгшөөдөггүй байлаа. Хэн ч орж ирсэн “За одоохон” л гэнэ.Ундармааг бол бүрч уриалагахан хүлээж авна. Хэдэн цагаар ч хамаагүй инээж хөхрөлдөн хичээлээ хийдэг байлаа.Бид гурав. Гэвч энэ байдал удаан үргэлжлээгүй юм. Хавар болох тусам манай Ганаагийн аашараншин хачин болов. Тэр дурланихжээ. Бүр Гоё Ундармаад. Ундармааг гүйцэх царайлаг охиних сургуульд ховорхон.Түүний бие болоод царай зүс тэгш зохицжээ. Нуруу нь өндөр болооднарийхан. Үс нь хар болоод урт. Царай нь цагаан болоод цаанаа л үзэсгэлэнтэй. Уран тунгалагхоолойтой, ухааны цараань дотроос нь гэрэлтэн байдаг тийм л гоо бүсгүй байв. Тэр Сэлэнгийннохин. Их мөрний хөвөөнд өссөн болохоороо ийм үзэсгэлэнтэй байдаг юм болов уу? гэж хааяа бибоддогсон. Түүнд мөн ч олон хөвгүүн дурлаж өлмийд нь сөгдөн үхнэ, хатна гэж айлгаж байжбилээ. Харин Ундармаа хэн яаж ч хайр зарласан үл тоон хэнд ч үл зөвшөөрөн гунхалзан алхсаарл...Их сургуулийн оюутнуудын дунд дурлалын гурвалжин, дөрвөлжин заримдаа тойрог

хүртэлүүссээр. Харин манай Ганаа тоогоо ч хүртэл бодохоо байв. Зарим нэг хичээл асуух гээд ирсэнхүүхдийг адайр ааш гарган явуулна. “Ийм юм мэдэхгүй байж их сургуульд яаж орсон юм бэ?” гэж нэг охиныг, Гавал Ганаа гэж дуудсан нэгэн хөвгүүнийг “Толгойны яс уу? Би” гэж хөөлөө. Тэр Ундармаад хэд хэд захиа өгөөд зөвшөөрч өөрийг нь тоохгүй байгаагийн хариуг бусдаас авчбайх шиг санагдана. Эвгүй гэдэг нь. Манай тасгаар хүн орж ирэхээ болилоо.

Ганаа ч орон дээрээ буруу харан хэвтээд босохоо болив. Хааяа нэг хэнгэнэтэл санаа алдах нь л сонсогдоно. Надтай чүл дуугарна. Би багш нарт худлаа хэлсээр залхлаа. Аргаа ядаад Ганаагийн өмнөөс “Азийн цагаандагина Улаанбаатрын Ангийн цагаан гүнж Ундармаа минь сайн уу?” гэж эхлээд хамаг байдагуюун ухаанаа шавхан нэгэн захиа бичиж Ундармаад аваачиж өгвөл “Гавал Ганаа тоо бодохоо болиод шүлэг бичвэл таарна” гэж даапаалав. Ганаа ганцхан өдөр л өөр хүн болов. Бүтэн сайнөдөр байсан юм. Өглөө эрт юм хяхтнах чимээнээр сэрэн харвал Ганаа хоолны том хар хутгаабилүүдэн хурцалж суух юм. Өмнө нь нэг бөөрөнхий мод улаан будаг байна. Шөнжин зорсон бололтой шалаар дүүрэн үртэс холтос. Би сандран орноосоо огло үсрэн бослоо. Гэтэл Ганаа тачигнатал хөхрөв. Би ч дотроо ухаан мэдрэл нь муудаж гэж бодов

.-Чи юу хийж байгаа юм бэ? намайг асуувал тэр хэнэгч үгүй:

-Зүрх гэв.

Би: -Юун зүрх вэ? гэвэл Ганаа:

-Та удахгүй учрыг нь мэднэ. гэв

. - Чи юу хийх гээд байгаа юм бэ? гэвэл \Би дотроо маш их айж байв.

Учир нь тэр юу ч хийж мэдэх зоримог хүн билээ.\

-Ах минь Бүү ай. Би хүнийг болоод өөрийгээ егүүтгэх тэнэг хүн биш.

Зүгээр тоглох гэсэн юм. гэв. Би жаал тайвшран цайгаа уулаа. Тэр хооронд Ганаа нөгөө зүрхээ зорж дуусган будаж эхлэв. Будаг нь цусан улаан аж. Би гайхан харж суутал Ганаа зүрхээ гялгар цаасанд нойтноор нь боож хар хутгатайгаа хамт энгэрийнхээ халаасанд хийгээд намайг “Явъя” хэмээн толгой дохин гарлаа. Би түүний юу хийх гэж байгааг нь мэдэхгүй ч сониучирхан дагаж явав.

Ундармаагийн тасагт орлоо. Хаврын шалгалт дөхсөн тул Ундармаа нэгэн охинтой хичээлээ давтан сууна. Ганаа шууд л Ундармаагийн өмнө очоод:

-Чи надад хайртай юу? гэв Нөгөөдөх нь:

-Хайргүй ээ гэв. Ганаа:

-Тэгвэл надад үхэхээс өөр зам алга. Үнэнч дурлалынхаа төлөө чиний гар дээр зүрхээ сугалж тавъя. Ундармаа:

-Өө ямар хямдхан амь бэ? Аль вэ? гээд гараа тослоо.Ганаа:

. Хар хутгаа гарган ирж хачин муухай орилж буруу харан чээжээ ярах мэт гялгар цаасыг зүсэн шинэхэн улаан будагт зүрхийг Ундармаагийн гар дээр тавьж орхив. Ундармаагийн гар нуль улаан болсон нь нөж цус нөж атгасан мэт. Түүний цасан цагаан царай бүр зэвхий цайж юу ч дуугарч чадалгүй орон дээрээ гулжийн уналаа. Модон зүрх Ундармаагийн гар дээрээс унаж шалан дээгүүр точигнон өнхрөв. Би сандчин Ганаагийн зүрх бишээ хуурамч зүрх, гавалын зүрх бишээ модон зүрх гэж үглэн Ундармааг сэхээж ядлаа. Нөгөө охин зүрхний эзэн хоёр бараа сураггүй алга болжээ. Ундармаа нэг сэргэснээ ширээн дээрх ув улаан зүрхийг хараад нэг ч үг дуугарахын завдалгуйдахин муужрав.

СҮНСНИЙ ТАРЧЛААН

Бор Зана шар Самба хоёр арван жилийн сурагч байхдаа холбоотой хомоол шиг салдаггүй найзуудбайлаа. Аль алийгаа өмөөрөөд арслан шиг биш юм гэхэд гөлөг шиг хуцахад бэлэн байдаг байв. Самба математикийн хичээлд ангидаа толгой цохино. Зана түүний далбаанд дагаж шогшсоор нэг мэдэхэд хичээлдээ мэдэгдэхүйцээр сайжирсан байв. Харин 10-р анги төгсдөг жил өөрсдөө ч мэдэхгүйгээр аажим аажмаар холдсоор үерхэл нь тасарчээ. Тэдний ангийн хамгийн царайлаг нь Бүтэмж гэж нүдээрээ инээсэн цовоо охин байлаа.

Хацрынх нь туяанд хаврын цомирлох цэцэгсийн нөнгө дарагдаж харцных нь усгалд хавийн залуус унаж тусаж цээлийн загас шиг умбаж шумбажөнжихөөр хөөрхөн бүсгүй болов. Зана Бүтэмжийг эхнэр болгов. Ангийнх нь хамгийн хөөрхөн бүсгүй Занад өврөө нээсэн гэхэд зэргэд ангийнхан зэрмийтэл гайхаж өөрийнх нь ангийн хөвгүүд өврөө сэмхэн тэмтэрсэн гэдэг. Тэгээд тэд дээд сургууль төгсөж нутагтаа ирэн алба хашижамьдралын нугачааг нэгжин хэлхээтэй дэгдээхэй шиг хэдэн хүүхдээ өсгөж иржээ. Яггүй сайнбагш гэж эцэг эхчүүд Заныг магтана. Зана ч хичээл дээр юу зааж дараа нь давтлагад юу хэлэхбашрыг аль хэдийн тооцсон байлаа. Шар Самба эдийн засагч болоод сумандаа ажиллахаар ирэхдээ хангай нутгийн зэрэмгэр цагаан бүсгүйг эхнэрээ болгоод ирсэн нь хөдөө газрын залуусын хөл харц хоёрыг соронзон гүрд татагдах төмрийн үртэс мэт хуйлруулж байлаа. Олоонжилийн хойно Занын сэтгэлд хаг хаясан цөлх бодол өнжөөд байдаг болов.

Би яагаад Бүтэмжийн анхны эр хүн байж болоогүй юм гэж гаслахад тэр азтай эрд атаархаж цусаар уйлмаар болдог байлаа. Тэгээд нэг хэлтгий хэвгий гэнэ урсаж гижиг ассан өдөр үг зөрж ам мурийх хооронд чиямар охин цусаа шингээж онгон биеэ өгсөн биш “Муу гичий” гэж агсраад Бүтэмжийг нуснулимстай нь хольчихжээ. Эмзэг сэтгэл сэмлэх үгийн хорз үйлийн гашууныг амсаж Бүтэмжгомдолдоо горолзсоор нүгэлт орчлонгийн золиос хүлхэж холын хүний хоргой харц хоргодохооргүй ойрын хүний овжин харц олзолхооргүй нүднээс гарчээ. Үхсэн амьдын ялгаа нь ингэж арилжүүлгэртэн цөхнө. Энэ үеэс Зана улам өөнтөгч атаархуу болжээ. Түүгээр бүү хэл Бүтэмжийн анхны хүн энэ Самба байх гэж дотор хорсоно. Тиймдээ Самбын хийсэн бүхэн өөрөөс нь илтдавуу санагдаж бачимдуулна. Уг нь тэр мөч Занын бодсноор биш жам ёсоороо нэгэн өдөрсанаандгүй учирсан байж. Бүтэмжийн хувьд түүнийг мартаж эс чадна. Эр хүнийг харахааричингүйрэл тогшоож хамаг бие нь жирвэх тунгалаг нас. Тэдний амнаас унах үг чих алтдан өнгөрөхдөө эрээ цээрийг шатаачих мэт халуун. Тэгсэн мөртөө өөдөөс нь сэм хармаар. Харцунагасандаа зүрх амаараа цухалзмаар бадрангуй. Алийгаа мэдэхгүй ангарайтах арван зургаатай түүний сормуусны гэрэлд өрөвхийж согтуугийн эрхэнд тэлчлэхдээ үг өдөн сүүмийтэл ширтэх заан Балдан гэгч зантгар эр болжмор барих харцага мэт сарвалзуулан чирч хүч түрэмгийлэн үхэрхадны булан түшүүлж ноолж байгаад чимхчихсэн хэрэг. Уйлах завдалгүй ёолох адгалгүй болоод өнгөрсний хойноос харамсах баярлах алин болохыг мэдэхгүй жаахан охин нэгэн зуур хөндүүрлэвчигижиг нь асаад байх шиг халуу дүүгэхэд шөрмөс хонгоо чидийтэл чангалан агдаад хадны завсарорж нууцгайгаар сэмхэн үзмээр санагдавч үл мэдэгхэн чийгтэхэд тэмтэрвэл тэр нь өнгөтэй байсанд балмагдаж өөрөө өөрөөсөө ичин баахан уйлжээ. Зана тэр нэг өдөр химийн

багш охиныг долооvroopoо доёлж дуудаад шатны булан бараадан хялмалзаад чиний тэр кабинетийн чиньолон бодисод золбин нохой цааш харуулчих хор байдаг уу гэж асуужээ. Багш дэмий юм асуух юм Сургуулийн газар энэ олон хүүхдүүд дунд яалаа гэж хортой бодис хадгалах юм гээд цаадсанааг мэдчихэв үү гэмээр ширэв татаад ангидаа орчихжээ. Зана “Олно доо” гэж заналтайгааршивнэн эргэснээс хойш эрсээр яваад хор олжээ. Түүнийгээ Самбад амсуулах таатай цагийг Тасгийн охин нь ашгүй эмч дууджээ. Настай эмч ирлээ. Болсон явдлын учрыг сайнойлгоогүй бололтой. “Хоол ундгүй, өдөр шөнөгүй уншиж давтахаар ингэдэг байхгүй юу” Эмнэлэгт аваачиж тамиржуулна” гээд Ундармааг түргэний тэргээрээ авч одлоо. Хэргийн эзэн байрандаа ирж хоносонгүй. Харин маргааш өглөө эрт хаанаас олсон юмбүү мэд тавин төгрөг барьчихсан гэмшингүй амьтан орж ирээд “Та Ундармааг эргэчихгүй юу” гэж намайг царайчлан гуйлаа. Би өгсөн мөнгөнд нь нилээд амттан, хоол унд аваад Ундармаадээр бэргэсээр очив. Ундармаа харин юу ч болоогүй юм шиг инээмсэглэн гарч ирлээ. Намайг “Баатар ахминь юун их юм авчраа вэ? Хэдийдээ Монте Кристо гүн болчихоо вэ?” гэж дамшиглалаа. Би:

- Ганаа өгч явуулсан юм. гэвэл

—Цаад мангар чинь юу хийж байна вэ? гэв Би:

—Хичээлдээ явсан. гэлээ Тэр:

- Ашгүй дээ гэснээ их л уян зөөлнөөр Үдээс хойш миний гадуур хувцасыг аваад ир гэж хэлээрэй. Одоо тэр энэ унадаг тусдаг болсон хүнээ яахыгаа өөрөө мэднэ биз. Би ч түүнийг зовоох байхдаа гэж билээ. Би үгийг нь гүйцээлгүй Ганаад энэ тухай хэлэхээр эргэн гүйлээ. Ундармаа араас” Би ч гэсэн Данкод хайртай” гэж цангинууллаа. Гавал Ганаа минь ийнхүү Данко болсон юм. Ганаа гэрийнхээ үүдийг онгойлголоо. Бид гурвыг тэврэлдэн учирхуйд Данкогийн мөнөөхөн улаан зүрх шилэн хоргоноос гэрэл сацруулан байвай. яах бол яаж таталдах бол хоёр өсгийгөөрөө ногоороод цувахыг харахсан гэхээс хөх инээд цээжийг нь хөшнө. Үнэхээр үхлийн хүчтэй эд билээ Нохойн идүүрт хийхэд цэхэр хүрээ татаж байсан гэж бодож амжив. Самба ч төдөлгүй явлаа. Түргэн эдгээрэй гэх Самбын ерөөл манж зоог шиг нялгадаж сэр сэрсхийн голыг нь мөслөв. Самбыг гарсны дараа мартсанаа санах мэт тасынсарвуу шиг эцэнгэр үе нь овойж товойсон хэрзгэр гараа сунган элдэв зүйл эрээн мяраан юмчихсэн жижиг хайрцаг татаж авчраад онгичиж байтал цаас нь шарласан жижиг боодолтой юмтааралдав Аа энэ гэж амандаа үглээд түүнийг олзуурхан авч чичирсэн гараар дэлгэж үзэх гэж байгаад ороороо нэг тараачихав. Ээ салгалмар гэж дуу алдсанаа пүргэх цагаан бодисыг хам хумхамж цаастай нь галд хийчихлээ. Тэгээд гэмгүй царайлан орондоо атиран хэвтэв. Амандаа хортой могой өөрөө хорддоггүй нь бусдад зориулдагтаа ажээ. Гэтэл Занын хувьд нүдэнд өргөстөрөхуй нүглийн чихээс чигжрээд шатрын хөлөг шиг алаг амьдралд нүүргүй хүү шиг эрдэж явсан түүний сүнс авсны ирмэгт торж ядан тарчилж Самбад хор биш өөртөө үхэл зэхжээ. Тэр өдөртөө Зана ертөнцийн мөнх бусыг үзэв. Задлан шинжилгээ хийгээд хүчтэй хоронд хордсон байна гэсэн дүгнэлт гарчээ. Заныг өнгөрдөг өдөр тэднийхээр ганцхан Самба орсон гэнэ гэсэн ёрын золбин яриа сумын төвөөр тэнүүчлэв.

Энэ яриаг дэвэргэсэн хүн Хас-Очир байв.

СҮҮДРИЙН ЗОРГОДОС

Дорлигийг шоронгоос ирсний дараахан Долгор хүүхэн дуудуулжээ. Нутгийн тохь томоотой хүнирээч гэж хэл өгүүлсэнд Дорлиг ацан шаланд унав. Нутаг нугаараа баян цатгалан гэж хүндэлдэгалдар нэртэй тохьтой томоотой хүн ир гэж байхад нэг муу шоронгийн хулгайч бултаад хаа хүрэхвэ Гэхдээ ямар гавьяа байгуулаад ирсэн биш тэр бүү хэл өөрийнх нь гэр орныг талчихаад галдажшатаачихаад шоронд явсан хүнийг дуудуулдаг нь сэжигтэй санагдаад Улаан нүүрээрээ улалзахгүймэрт унасан юм шиг халгаж халширна. Долгорыг их баян гэгцгээнэ. Өөрөө сүрхий хүнболохоор талийгаач нөхрийхөө олж цуглуулсныг бусдын гараар үрүүлэхгүй гэсэндээ өдийхүртэл ганцаараа яваа юм гэж зарим нь өөнтөглөнө. Долгор аймгийн эмнэлэгт хэвтээд ганц охиннь гэртээ үлдсэн байв. Долгор газар дээр ганц охиноо гэж эрвийх дэрвийхээ илүүчилж, элдэвухаанаа зарж зааж яваа хүн өөрийнх нь хувьд хүсэл ивлэвч нааш гэх хүнгүй болсон өдрөөснасны хэц дээр гарснаа ухаарч мөнх аж үгүйг гаслан хорвоог элээх элэхийн хооронд туучижяваа нэгэн. Эх нь эмнэлгээс гараад сумын төвд шуудангаар маргааш ирэх учир охин нь тосож авахаар оройн нар ханын толгой амсахад хос морьтой морджээ. Нутаг нугынхан охиных ньийнхүү эршүүд гүжирмэг, морь унаанд барагийн муу эрийг дагуулахгүй сайныг мэдэхээс бүсгүй нандин уяхан зөөлхөнийг гадарладаггүй байлаа. Энэ мөчийг үлий сахих сар шиг анаж байсанДорлиг бүрий болохыг тэсэж ядан хүлээсээр тэднийд буужээ.

Айлд очиж буй хүний дүрээрхоолойгоо засаж “Нохой хорио” гэвч чимээгүй. Морио тушаад дөхөж очвол гэр нь цоожтой.Хүлээсэн цаг мөч ингэж ирдэг байжээ гэж баярласандаа арай л зуун гүвээ давтал гуугчижхашгирсангүй эргэн тойрноо гүйлгэн харж сэрэмжлээд цоожийг мулт татаж гэрт нь орлоо. Эмхцэгцтэй цэвэр цэмцгэр, харахаас халуун дулаан угтахад ёстой нэг диваажинд байгаа юм шигтарвалзлаа. Хоймрын авдрыг онгойлгож үзтэл зангилсан гар орчихом хонхор ёроолтой галуунхүзүүт морин шилтэй хар архи гарч ирэв. Их эртний эд ажээ. Бөглөөг бүлт цохитол арааны шүлсасгарам хар архины эхүүн охь гэр дүүрэв. Эгээ л орон гэртээ байгаа юм шиг тухлан мөнгөнаяганд мэлтэлзтэл дүүргээд хөнтөрчихөв.

Хоолойгоор нь тос шиг гулсаад залгисны дараа амаарнь дүүрэн амтлаг хар шүлс тунахад алдаад асгачих вий гэсэн шиг шуналтайгаар гудхийтэлзалгив. Шүлс нь хүртэл архины ааг амттай байлаа. Тэгээд Дорлиг улам ашлан сууж барьжэрсээр улирсан хэрэг. Бусдад буруу санасан энэ байдалдаа өөрөө чөдөрлөгдөж айлд ороод аягацай тухтай уучихаж чадахгүй сэжиглэж авгайгаа өглөө цай аягалахад энэ яачих бол гэж сэрдэнмөрөн дээгүүр нь өнгийдөг болжээ.

Тэр өдрөөс химийн багш годгор хөх охинд муу санажмуруй бодож хор сураглаж явсан гэж ам алдуузай гэхдээ шахмал бурманд хавчуулаадүмхүүлчихмээр бодогдоно. Эс тэгвэл ажил бүтэхгүй болсон мэт өөртөө агдана. Чонын хоргэдгийг олж авсан ч буух эзэн буцах хаягаа өөрөө заагаад өгчихлөө гэж болчимгүйдээ харамсанбиеэ зүхнэ. Тэгсгээд хорны тухай мартагджээ. Зана том охиноо нас бие гүйцэж бүсгүй галбирцогцлох бүр эхтэйгээ адилхан нүд сормуус болсон харцаар эрхлэх тусам хохь туулсан башраарогьж, албин чинь золбин гичийгээ дууриагаад яагаа ч үгүй байж огли татуулж охин биеээ гээхбий гэж харамлан орох гарах орой үдэшгүй цагдана. Харин хүргэнтэй болсон өдөр сэтгэлийнсэв арилж хэсэгтээ амрав. Тэгээд нэг өдөр хүргэнээ дуудаж их дотно аминчханаар “Цаадах чиньчамтай учрахдаа бүтэн байсан

уу” гэж учир битүүлэг юм асуужээ. Хүргэн нь хэсэг гайхснааинээвхийлээд өнгөрчээ.

Насны эцэс ээрэхэд цусных нь эргэлт буруу эргэсэн юм шиг адарч явсанөөнтөгч эр цун ясныхаа химийг шимж хэвтэрт оржээ. Харгасан бүхэндээ хараал ивж “Тэр мууяадаг юм” гэж нулимж явснаа үгүйлэх тэнхэлгүй хэд хоносны эцэст голд нь гэрэл харвасан мөчүхлийн өмнөх тайвшрал байжээ. Энэ нь ухаантайд эрэгцүүлэх мулгууд эргүүтэх цөвийн цагбилээ. Занын хувьд өөрт таалагдаагүй бүхэнд адарч чадарч байдаг хөг өнгөрчээ. Үхлийг аргадахгэсэн шиг нулимс нь цийлж нүднийх нь аяга дүүрэх шиг болно. Хэзээ би хэний төлөө гэж дусалнулимс унагаж байлаа гэхэд санаанд торох юм алга. Утсан улаан амьныхаа төлөө уйлах янзтайгэж бодоод зовхио эрхийгээрээ тэмтэртэл хув хуурай байв. Тийм байлгүй дээ гэж ганцаарааүглээд бараан орчлонд багтарч ядна. Хэвтэрт орсноос хойш чих нь дүлий дүмбэ мэт болж эрүүбилүүдэх юмгүйдээ дотор нь хорсоно. Тэр хэн хүний сайн сайхныг үзэн яддаг байлаа.

Энэ ньөөрийн сэхүүн бардам зангаас болдог биз. Ямар сайндаа ангийнхаа онц сурдаг сурагчдыгхарахаар нүд нь хорсоно. Харин тааруухан сурдаг сурагчийг бол зад загнаад өөрийгөө баахангайхуулаад орхино. Үүн шиг жаргал байсангүй. Тэднийг урагшгүй тэнэг мангараар нь дуудаадёстой нэг бах тав нь ханаж тэнгэрийн суудал эзлэх мэт бардам дүүрэн эрдэм нь амаараа сагажбайх шиг эрхэмсэг байдагсан. Энэ явдал аажимдаа цээжинд нь өлөгчин чоно мэт үүрлэж сайняваа сайхан яваа гэх хүний сураг сонсуут би түүнээс юугаараа дутуу юм гэсэн эгзэг эдэрч шархор буцлан бушуухан мартахгүй бол шаналж тарчилна. Самбыг Санхүү эдийн засгийн тэргүүнийажилтан болсноос хойш түүнтэй дуугарч чадахаа больжээ. Тиймдээ Зана бусдын тухай хар үгхов живд бол баланд шунах зөгий мэт дурлаж хушуу билүүднэ. Бусдын аманд орчих шахануралдаж ярихдаа уургын морь гэсэн үг. Заримдаа үүнийг хэн хэнд ярья даа гэж нойргүй хононо.Нөхрийн тухай муу үг цуглуулж гаажилна. Түүний энэ аяг занг мэдэх хүмүүс үхсэн хүн гэжнэрлэнэ. Үхсэн хүн явж байна. Үхсэн хүн тааралдлаа гэгцгээнэ. Үхээр мэт загнасанддаа үхдэл мэтхарагдсан нь тэр биз Учир нь үхдэлийн нүд нулимсгүй бас инээдэггүй.

Муу үг бүхнээр цэр ньцээжиндээ тагжирч, сүүдэр тодын орчлонд бараан бүхнийг шимж тамшаалж, хорсолдоо гашлан,мунан гадасны толгой бяцартал араагаа зууж, мунхагийн галд тос нэмнэ. Эдэлсэндээ сэтгэл эсцадахын хөх дөл шуналаар буцалж харцы нь хурцална. Эхнэртээ итгэж амжаагүй насны харамсалгашуу оргино. Тэр өдөр Самба багын найз Занынд орлоо. Самба нэгд Занын биеийг асуухаарнөгөөтэйгүүр Бүтэмжийн сэтгэлийг бодож хэд гурван үг солихоор тэднийхээр оров. Хэвтрийнхүн ганцаараа байлаа. Зана сүүлийн арав хоног хэн нэгнийг алж байна гэж зүүдэлжээ Түүнийхамгийн сүүлчийнх энэ Самба очиж очиж манайд ирдэг сайн ёр биш дээ гэж ширвээдэв. Сайндаанамайг эргэх гэж ирээч үү үгүй ч үү үхэх болж уу гэж шиншилж яваа биз гэхээс үйлийн хорвоодүхэх ч багадахаар бачимдав. Самбыг мэнд мэдэж аяга цай амсах зуур аяганд нь хор хийчихвэлтавьсаар шил архиа дуустал уужээ. Дотор нь халж ходоод нь ирвэгнээд толгой нь жааханманалзахад балтаар цохиулсан ч буцамгүй зориг орж нүднийх нь гал дүрэлзэн асах шиг болов.Дорлиг авдар савыг онгичин хайш яйш тарааж өөрт хэрэгтэй гэснээ өвөртөлсөөр байв.

Хэдхичнээн юм авснаа мэдсэнгүй. Нэг мэдэхэд өвөр түрий нь даагдамгүй хүнд болжээ. Гадагш гарчмөрөө баллах ухаанаар гэрий нь галдчихаад мориндоо мордох гэтэл өврөөрөө

дүүрэн эд бараачихсэндээ ч юм уу эсвэл уусан архиндаа халамцаад тэгсэн үү эмээл дээгүүрээ давж ойчоодбайв. Номхон хээр морь нь галын нөөлгөнд омоорон хамраа тачигнуулан цахлавч эзнээ иймсалга өвчин тусаад тэлчилж байгаад гайхах мэт зогссоор авай. Шөнө дундын түнэр харанхуйд Дорлиг мориндоо мордож эс чадаад түймрийн халуун уулга элчинд нозоорон архиндаа цохигдожнам унтаад үүрээр сэрж мордоод шогшчихжээ. Долгор охин хоёр маргааш нь иртэл гэр орон ньшатчихсан бүлээн нурам утгжээ. Ойр хавийнхан Долгор хүүхний гэр хайлчихжээ гэгцгээн санаазовцгоон сэтгэлийн дэм өгөхөөр ихэнх нь цуглаж ирцгээв. Долгор гэрийнхээ шатсан нурмыгжаал хутгаж үзсэнээ манайх бүрэн шатаагүй юм байнаа хүн шатаачихаж гээд цагдаад алдсаносолдсоноо бүртгүүлжээ. Баг хонхроороо сэтгэл гаргаж нэг гэр овойлгож туслах санаатай тавгурван төгрөг нийлүүлж байх зуур Долгор суурин ороод байшингаасаа цоо шинэ таван ханатгарган хүүхдүүдээ гэр барилцаад өгөөрэй гэжээ.

Цугларсан хүмүүс гайхсан харцаар бие биенээцоргиж чимээгүйхэн хоорондоо дохиж ирмэлцээд гэрийг нь зөөж барьж өгөх зуур Долгор ч гавшав шалавлан гал өрдөж цай буцалгаад дээжээ өргөж байв. Гэр барилцсан хорь гаруй хүнийгоруулж цайлав. Авдар саваа байрлуулаад хоймрын авдраа нээж арван хуруундаа шүүлэг татахалтан бэлзэгүүдээ авч тусгай хайрцагт хийгээд ээлжийн арван бэлзэг гаргаж зүүв. Баруун хойдталын авдраа нээж нижгээд мөнгөн аяга гарган хүмүүст цай барихад нэгийн зэрэг дутаг. Зүүнхойд талын улаан авдраа нээвэл тохой тохой хэртэй давхарлаж хив хадагт ороосон мөнгөн аягачигжээстэй байлаа. Тэндээс аяга авч гүйцээв. Долгорт тусална гэж хэд гурван төгрөг цуглуулжбайсан хүмүүс ичих шиг болж дуугүйхэн тарцгаажээ. Тэр өдрөөс Долгор ийм баян тиймцатгалан гэгцгээж баахан шагшраад тэр их мөнгө хөрөнгөтэй байж машин авч унавал яадаг юмгэж шордоцгоов. Үүнийг мэдсэн юм шиг Долгор унаатай болох гэнэ гэсэн яриа тархлаа. Гэхдээ Долгор нутаг усныхан нүүж сууж байхад нэмэр тустай юм трактор олж авах юмсан гэж байнагэгцгээв. Айл нүүлгэж буулгавал ганц нэг төлөг шүдлэнгийн хожоотой юм гэж Долгорынбодсоныг хэн ч анзаарсангүй.

Гэр шатсан дуулиан бүр намдсан хойно хулгайч нь баригджээ.Залгаа нутгийн Дорлиг гэж залуу энэ хэрэгт сэрдэгдэв. Тэрээр хот орж барааны зах барааданхулгайн эд зүйлээ борлуулж яваад баригджээ. Арван алтан бэлзгээ алга хийчихээд хорин мөнгөнаягаа увуулж цувуулж зарахад хэн ч сэжиглэсэнгүй. Харин алтан ёроолтой гурван мөнгөн аягабайсныг гэнэдэж гаргаад баригджээ. “Алдсан юмыг чинь оллоо ирж ав” гэж Долгорт хэл ирэхэдхулгай хар мөртэй би авахгүй улсын орлого болгочихоорой гэсэн гэх. Дорлиг хийсэн хэргийнхээтөлөө ялаа эдлээд ирж байгаа нь энэ. Гэтэл Долгор хүүхэн ирж уулз гэж хэлүүлсэн байдаг.Халуухан нь халуухан л явдал байлаа. Дорлиг халгаж хулгасаар хэд өнжөөд тэднийд буув.Долгор түүнийг юу ч болоогүй юм шиг хүлээж аваад нутаг ус нуур ногооны тухай яриад өөхболсон дал дөрвөн өндөр чанаж орныхоо хөндийгөөс жингэр жунгар харшуулан нэг шил юмгаргаж сөгнөв. Долгорын нөхөр торгон Дорж гэж цагтаа цалгиж шилийн сайн эрийн шийрхатаан алдаршиж явсан нэгэн. Аавын босгоор алхсан нь харин ганцхан гэх. Тэрээр хонь төхөөрчгурил зутагнах хэдэн гозгор борц цуулбарлаж өлгөчихөөд бусдыг бүгдийг чанаж нэг амиаридчихнэ. Ингэхдээ өлссөн боохой шиг загнаж шаант богтос зэрэг булчин махыг азарган цагааншүдээрээ хөндлөн тас тас хазаж бахтайгаар шажигнуулан зажилна. Энэ нь махны шим шүлтийгмагад нэг авч байх шиг таашаал асгана. Тэгээд ус ууж өвс иддэг юм шиг сар шахам хоолидэхгүй явна. Наян зургаан бодын хэрэгтэй сэжигтнээр баригдаад аймгийн шоронд

очсоншөнөдөө оргочихжээ. Торгон Доржийг алдчихсан тухай яриа тарж айл хотлоороо зэнзийрхэнавдар саваа цоожилдог болов. Гэвч түүний сураг дуулдахаас бараа харагдахгүй сар шахам болооднэг өглөө өөрөө мөрдөнгийн хаалга сахиад сууж байжээ. Дарагддаггүй чөтгөр мэт баригддаггүй Доржийг өөрөө ирсэнд олзуурхахаасаа аргаа ядаад ирлээ гэж чангалав.

Энэ хооронд Доржоройдоо ганц тагш хоол идэж өдөржин хоосон гэдсээ зайлж давхиад бүр сүүлдээ аяга долоохтөдийд цаддаг болоод очжээ. Иймдээ нарсанд суухад хоолоор ходоод хонхолзож өчиг алдахааргүй болсон байжээ. Гэвч түүнд тулгах ял их, гулгуулж гулсуулсан бодын тоо олон тул наян зургаагаасарав гаруйг аргагүй эрхэнд хүлээгээд ял авсан гэдэг. Тэгээд Мөнгөнморьтын хорих ангид ачигдажхангай газар давирхай нэвчсэн хар модтой хоёр жил ноцолджээ. Эр эзгүй эхнэр хүний энгэрхумиу явах зовлонг эдэлж цөхөхийн дээдээр цөхөж яваа Долгор хэл сураг улаалсаар долоонхөтөлгөө морьтой нөхрийнхөө ял эдэлж байгаа тэр хангай нутгийг зорьжээ. Хэд хоног тэгш талих цайдмыг туулж явсаар сүүлдээ уул нь өндөршиж ус нь элбэгшээд ирэв. Арван хэд хоногийнбаяны жолоо сааж их сүрлэг модтой хайрхны хадах энгэр хунхад баруун Бүрхийн гол гэж хундагандмэлтрэх сархад шиг тунгалаг голын хөвөөнд чигжээд буучихсан жижигхэн сууринд очлоо. Мөнгөнморьт сум гэгч энэ ажээ. Цэнхэр хадаг шиг намиатаж тэнгэр үйсэн голын хөвөөнд сүүнийүүлдрийн бололтой олон цэлэлзсэн үнээнүүд ширэг зүлгийг шир шир зулгааж идэшлэнэ. Сумынтөвийн баруун урд голын тохойрсон гүн цүнхээлд гүрвэл шиг хэдэн чардгар нүцгэн хүүхэдшумбаж тоглоно.

Өөрийнх нь өссөн төрсөн говьд жинхэнэ чандмань эрдэнийн үнэтэй дусалдуслаар хэмнэж хэрэглэдэг ус энэ нутагт ийм элбэгт гайхан бас сүрдэж хоцров. Сүрдэхийн учир нь Долгор шагайгаар татсан усанд ч хөл алдаж мэдэх билээ. Хорих ангийн дарга даамалтайуулзаж учир явдлаа тоочвол тэд тийм ч хатуу хүтүү аашгай хүмүүс биш бололтой. Доржийнсургийг гаргав. Сумаас зүүн хойш хөндөлсөх модтой өндрийг даваад өртөө илүү газарт Борхоньтын хэсэг гэж бий гэнэ. Тэнд ял эдэлж байгаа гэлээ. Унаа морьдоо Бүрхийн хөвөөнд хэсэгамраагаад ангийн даргаас нөхөртэйгөө уулзах зөвшөөрлийн бичиг шийтгүүлж аваад тэр хэсэгдээр нь дэргүүлээд буучихав. Зөөлөн харгилах уулын голын хөвөөнд тэнгэр сүлбэсэн сүрлэгмоддын шил дарж барьсан хэдэн дүнзэн байшин байх нь Бор хоньтын хэсэг ажээ. Энэ олонмодыг хөрөөдөөд хөрөөдөөд унагадаг юм байх даа гэсэн шүү говийн хүний бодлоор алмайрангайхтал тийм биш ажээ. Уулынхаа униар хохсон уйтан хөх амыг өгсөөд тэр их түнэр ойд модбэлддэг бөгөөд машин тэрэг явах зам нь бэрх, хэлтгий хазгай ихтэйгээс том том моддыг унагажзамын налууд ивүүр хийн зассан газар хүртэл байдаг гэнэ.

Тэнд машины дөрвөн дугуй зарим ньгазарт хүрэлгүй явдаг гэсэн үг. Хэсгийн дарга гэж нэг их мөрдөс чимэг болсон цэмцгэр тэвхгэрзалуу ялтан Доржид эргэлт ирж гэж хэл явуулснаар хагас өдөр хүлээсний эцэст торгон Доржазарган цагаан шүдээ яралзуулан инээсээр ирсэн боловч даргынхаа өмнө номхон зогсчихооднааш зүглэдэггүй Энэ нь Долгорт өнгөрсөн хоёр жилээс урт юм шиг санагдав. Ялтан Доржэргэлтэндээ гэхэд тамтгаа цайж яадгаа алдсан салбархай ял хувцасаас нь аргуун давирхайханхалсан зөвхөн нүд шүд хоёр нь гялалзах Дорж догдлолоо дарж ядавч дэндүү тайвнаар “Сайнявж ирэв үү” гээд зөөлөн инээмсэглэж түрүүлээд хамгийн зүүн урд талын зайдуухан барьсанжижигхэн дүнзэн байшин чиглэв. Энэ байшин Доржийн маань байр юм байх даа Хэдүүлээ байдагюм бол гэж бодох зуур үүдэнд нь тулчихлаа.

Гэтэл эргэлтийн байр юм санажээ. Өөрөөс ньтүрүүлж ирсэн нэг эмгэн хүүтэйгээ уулзаад идээ будаа болчихсон сууж байв. Тэр хоёрыг ормогцнөгөө эмгэний хөл хөнгөрч “Ээж нь одоо явлаа Дараа ирэмз Миний хүү ажлаа сайн хийгээрэй”гээд залуу хосод зай гаргаж өгөх гэсэн мэт ум хумгүй гарч одов. Долгор хангай нутгийн жамаарморьдоо аргамжлаа. Хахаж үхдэггүй л юм бол морины идэш дэндүү элбэг газар ажээ. Дэргэдүүртөв тодорхой өгзөг ташаа тэргүүтэн тэвхийгээд цээж нь тэгшрэн, хүзүү хоолой нь гадилын зүсээргэрэлтээд өлөн бугын зуулт амссан мэт бие нь жирвээд байж сууж чадахгүй болоход дороохавьчаад суудлаа засав. Долгор хүүхэн бас сархадыг чамгүй тогтоох ажээ. “Сайн эрийн хуйхявсан юм” гэж талийгаач нөхрөө дурсан сэтгэлээ онгойлгож дуулж, уйлж амьдралын хээтэйхуартайг шагшиж бас хэдэрлэж, амьдрахын эрээн бараан ээдрээг эвхэж хөвж байх шиг загнаадбайн байн хөндийгөө суйлж нэмж бөглөө мулталсаар суухад зовхинд нь алдас тэмтэчсэнсүүдрийн зоргодос тэнүүчилэн хөх дөлөөр жирвэнэ. Дорлигийн болгоомж ингэж цавчирсанбайж болох юм. Долгор ухаантай хүн мөрөө олж гишгэвэл шорон ямарч муу эрийг хоолоо олжидэхээр болгодог газар даа гэж ариун бодол асгана.

Дорлиг аягатай сархад гардах тоолондоо “Айдаа” гэж дуу алдан архи Цоомоо хоёрын алинд нь тамшааж согтож байгаагаа ялгахгүй үүлгэртэжсуув. Шөнө дүл болтол дайлуулж цайлуулж шоронд орсноосоо хойш амсаагүй нарсны харшаагарч, нарны итгэл зузаарам аз жаргалтай хүндлэл хүлээж хүн заяаны эрхмийг эрэгцээхдээЦоомоогийн хүсэл булаалдах гэрэлт харцтай хааяа шөргөн гал шиг тулгарна. Хазахын заяа үгүйч харахын заяанд ээнэгшиж хүслийн хязгааргүйд асаж шатах шиг агдахад согтож байна даагэсэн цөлх бодол цээжинд нь чихэлдэв. Тэгээд морь харахаар гарах гэж тэлчлэхэд нь Цоомоотүшиж байсан санагдана. Үүр тэмдгэрэхэд сэрсэн Дорлигийн дотор архины аагинд хатаж адсагашир шиг аргахад босож гантай уснаас шанагаар хутган гуд гуд залгилаад бачууран хахаж цацажхэсэг болоод дотор нь сүв орох шиг сэрүү татахад гайхаж хоцров.

Тэр Цоомоогийн халуунөврөөс сая босож ирсэндээ итгэж ядан нүүр ам, нүд чихээ хүртэл угзчиж үзэвч үнэн байлаа.Амьдын зол атгах эмзэг хязгаарт гайхах балмагдах зэрэгцэвч гал атгасан юм шиг халуун үнэнийгэрч болсон тэр гэрэлт өглөө Цоомоогийн өврөөс өндийхдөө насаараа согтуу явах үйлийн үрийгүрэлцэн ганцын заяаг төвшлөх эр хүний хувь төгөлдөрт хутгалдаж өөрөө өөрийгөө хулгайлсанцагийн хашлагад гаслан галын бурханд хадаг тавих зориг зүрх нь тэгширэн уяандаа дасах нохойшиг хувь тавилантайгаа эвлэрэх үлдлээ

АЛИМ ИДЭХҮЙ

Намар орой юм даг. Сумын шар дэлгүүрт алим ирж, лангуу нь улаа бутарч, худалдагч эгч ягаа бутраад, том багагүй тийш гүйдэлт б болов. Дэлгүүрийн үүд хором амрах завгүй чахрана.

Жилдээ ганц үзэгддэг алимнаас илүү амттан сумын дэлгүүрт үгүй. Би тооны хичээлийн гэрийн даалгавараа хийхээр номоо эргүүлж суутал манай ангийн “охин” Баяраа орж ирэнгүүт “Хөөе Сэлэнгээ, Хоёулаа сумын дэлгүүр орж, алим авч идье” гэв. Баяраагийн “Охин” хоч нь надад дэндүү жульдаж сонсогддог. Харин “Зөнгөр, аавын нударга, аавын цээж” гэвэл дүйцмээр. Боржигин цэцэн вангийн хошууны таван толгой баяны нэгний отгон хүү. Ганц ах нь цэргээс халагдаж рээд, шинэ унаатай энд тэндгүй дүнгэнүүлж байсан цаг.

-Ирэх намар аав надад ахынхаас илүү ув улаан өнгөтэй тос нь ханхалсан ИЖ-ПЛАНЕТА авч өгнө гэсэн гээд есөн сарын нэгэнд сургууль дээр ирэв. Намайг зуслангаас ирэхэд, Баяраа ВТ янжуур зууж, урт нударга хаяад, дэгэлсэн орос хромыг гармуушиглачихсан, саарал бүрх малгайны хэвийг өөрчилж, ковбой хэлбэрт оруулчихаад ар шилэн дээрээ хаячихсан ганган дэгжиний нийлбэр болсон эр ирж билээ. Ахтай байх ямар сайхан юм бэ гэж өөрийн эрхгүй бодогдуулав. Мань эр суга өсөж, би “байрандаа” хоцорсон мэт санагдах тул барилдаж хүчээ сорьё гэхэд үл зөвшөөрнө. нь Тэрэлжийн гол гэж ёроолд нь алдсан үлбэн гэрэлтэм тунгалаг элбэг устай гол хад алгадан цовхчих нь хүн малын диваажин байхаар газар ажээ. Дорж ял хувцасаа тайчихад түүний булчин ер бишээр зангиран бадируун цээж нь гэрэлтэж улам чийрэг зузаан болсон шиг санагдав. Эцэж ядартлаа хар модтой ноцолдсон гэхэд сульдсан шинж ер үгүй эрчис билэг төгс цагийнхаа янзаар санагалзахын зөн тэмтчих эр ханхал гижиг асааж сэрэл оргитол тэнүүчилнэ. Нүд бүхэнсохорчихсон юм шиг нүглийн халхавчийг мартаж нүцгэн биеээрээ элгэнд нь наалдахад чимхээдавах шиг чим чим хийж догшин сэрэл галзуурна. Энэ цаг анхны учралынх шиг амттайхныгсэдрээж бусад цагийн жаргал бүхнийг мартуулах халуухан байлаа. Дорж эрх чөлөөнийхэлтэрхийг олзуурхан эдэлж эхнэртэйгээ гурав хоног эрхлээд яландаа явав. Долгор тэр өдөртөөбуцаж нэг их хэргээ бүтсэн юм шиг эд эс бүхнээрээ халуу шатаж буцалсаар хэд хоногийн дараанутагтаа иржээ. Тэгээд энэ охиноо төрүүлсэн гэдэг. Доржтойгоо хэдэн жил ханилахад олдоогүйэрдэнэ, хувь заяа түшиж бие нь нялхран хангайн тэр дагшин дүүрэнд олдсон ганц охинообурхны хишиг гэж өвөр дээрээ бөөцийлөн өлгийн дуугаар аргадан өсгөжээ. Охин төрсөн баяртмөчийн дараахан нэгэн гунигт мэдээ зүрхийг нь мэсэлсэн нь хоригдол Дорж осолдсон байлаа.Бор хоньтын мод цагаалах зам харгуй шавар шавхай, намаг ус туучсаар амныхаа адаг хүртэлүргэлжлэх авч уул өөдөө машин техник гарч чадахгүй тул хоригдлууд унагасан модоо хайнагаарбулхайддаг байлаа. Булхай чирсэн хайнаг тээр дээрээс уруудахдаа тэнгэрийн амьтан шиг сүртэйнүд нь улаан цагаанаар эргэлдэж буулгандаа тэнцэж ядан тэвхдэж тэхэлзээд, алдалсан гар шигаварга том эвэр нь тачигнаж хажуугийн модонд харгаад туурай нь шажигнаад буучихна.

Мал мэддэг монгол хүний омог зоригийг чухам нэг асаана. Дорж гурвуулаа хөхрөх хөвчийн шилдарваад хайнагтай мод цагаалж, цавчсан ормоос нь эсгэлэн шүүс дусагнам нойтон модоорзангидсан уулын оромжиндоо тав хонож байлаа. Алтан зоргодос шиг одод шингэрэн үүртэмдгэрч сүүмэг цэгээн туяа оромжны цонхоор шургаж ядаж байтал хайнагнууд нь

хуйхранориллодож уяагаа тасдуулав. Юу болов хэмээн ухасхийсэн Дорж гараад чив чимээгүй Нөгөөхоёр нь хойноос нь шагайвал үүрийн бүдэн баданг халхлах мэт хөвчийн хөглөгөр хүрэн баавгай Доржийг хөндлөн зуугаад моддын чөлөөгөөр таахалзан далд орж байлаа. Хорхойтсон баавгайд хоригдол бариулсан цуу голоор нэг тарж нутгийн сайн анчид цугларан мөр мөшгөв. Олон улдааг боож үргээсний эцэст гуравдах хоног дээрээ Мөнхжаргалантын арын хөх шугуйд нөгөөбаавгайтай анчид уулзжээ.

Баавгай аль хэдийн хоригдлыг идэж зөвхөн баруун гарыг нь зуужявснаа газар булж байгаатай таарчээ. Амтшаад ахиж хүнд хүрүүзэй гэхдээ хөөцөлдөж байж баавгайг намнажээ. Түүнийг цэц хараа жигдэрсэн нутгийн хашир сайн анчин амин газар нь буудахад эгдүүцэн хэдэрлэх, эрэмшин хүрхрэх нь хөвч хөвхөлзтөл доргион тэр хавийн бүхмодод суман үндсээ сулартал ганхаж шилгээн анчдын унаа морьд зуун жилийн өвгөн улиаснынавчис зулартал үүрсээд шээс алдсан гэгцгээдэг юм. Ингээд Долгор өөдсийн чинээ охинтойгооүлдсэн ажээ. Сар жил улиран өнгөрсөөр охин нь нүд сормуус болсон сайхан бүсгүй болсонд нутгийн залуус санаархавч түүний гоо үзэсгэлэнд бал тусаж эхийнх нь авир аашаас халгаад халддаггүй байлаа. Түүнийг Цолмонжаргал гэнэ Хүмүүс Цоомоо гэж дуудна. Нутгийн залуус Цоомоог замын жолоочоос харамлаж нэг л өдөр тоостой замын тостой жолооч дагуулаад явчихбайх гэж харамлан өвдгөө илж өврөө тэмтэрцгээнэ. Бараг манаж хонох нь холгүй аяглана. Дорлиг Долгор хүүхнийд ирсэн даруйдаа Цоомоог сонжин харав. Тэгээд мөнгөн аягатай сархад мэлтэгнүүлэн гардаад амандаа хүргэхдээ Цоомоог хулгайн нүдээр ширтэв. Түүний уясам зөөлөн ааль илбэ шидийн мэт зэрмэлзэх угсал харц зүрхийг нь хүлхэх шиг болоход аа гэж алмайраадаагатай архиа нэгмөсөн хөнтрөөд хоолой зурах аагийг торгоох гэсэн мэт хэсэг амаа таглажтонгойн суухдаа нүднийхээ булангаар Цоомоог ахин ажив. Бүсгүй галбир торгонд ороолттой ч Өнөөдөр тэвэг тоглож, би сайн хожлоо. Мөнгөтэй болсон. Өнөөдөр би одтой, чи амны хишигтэй байна шүү” гэв. Тооны даалгавараа хийгээгүй ч би хорхойссон баавгай шиг дуртай зөвшөөрлөө. Би сумын дэлгүүр орж очвол Баяраа өврөөсөө задгайдуу арваад төгрөг гаргаад, над руу инээж харсанаа харснаа “Тооны шалгалтан дээр хуулулаарай. Намайг чи даана шүү” гээд- Хоёр кило алим аъяа гээд худалдагчид мөнгөө сарвайв. Би “Өнөөдөр ч алимыг пологттол идэх нь. Багшийн нүдийг хариулж, тооны хичээл дээр яасхийж хуулуулдаг юм билээ” гэж бодон зогсож байтал, Баяраа

- За, явъя. Сэлэнгээ гээд түрүүлж гарав. Мөлчгөр хальсан дээр уулан судал нэвт туяарсан алим даан ч амттай харагдана. Гарын алган дээр ямар гоё харагдах бол. Нэн шүүслэг энэ жимсний цул бөөрөнхий хэлбэр яасан зохино вэ. Энэ алим.., Энэ алим уу..

Би “Хэзээ надад өгөх юм бол” гэж горьдож явсаар байлаа. Бид явсаар дээд ангийн Сараагийн хашааны үүдэнд иртэл Баяраа:

- Цаадахыгаа хурдан дуудчих, тэгээд чамд алим өгнө

- Одоо өг л дөө, түрүүнээс хойш зөндөө хүлээлээ.

- За, май гээд нэг алим өгөв.

Ашгүй Сараа гэртээ ганцаараа байв. Би Сараад “ Чамайг Баяраа дуудаж байна. Хурдан гараад ир” гэхэд Сараа алим идэж зогсох намайг ихэд тоож байгаа шинжтэй горьдож харах мөртөө

“Би юм угааж байна” гэж цаараглах янз үзүүлэв.

- Алим идэхгүй юм уу. Гадаа хоёр кг алимтай Баяраа бид хоёрыг хүлээж байгааг мэдэхгүй байна уу

- “Охин” Баяраа юу?

- Үгүй тэр чинь “Алим” Баяраа болсон.

- Надад алим өгөх болов уу. Охидууд алим жимс идвэл хөөрхөн болдог гэсэн.

- Хэн тэгж чамд хэлээв.

- Алма –атад сурдаг захиан дээрээ бичсэн байна лээ.

- Алим идэж хөөрхөн болооч гэж хөөрөлдөөд гарч ирэхэд, Баяраа урд хашааны ар талд элсэн дээр ууттай алимаа тавьчихсан, өөрөө том байшингийн суурь сандайлчихсан их додигор сууж байлаа. Гартаа барьсан алимнаасаа том том хазлаад, идэхгүй харин газар луу нулимах аж.

Гайхсан би:

- Хайран алим элс ямар идэх биш.

- Энэ элс горьдоод болохгүй байна тэгэхээр нь дээжнээс нь өгч байгаа юм. Газар эхдээ өөрөө яалтай билээ гэснээ

- Сэлэнгээ! Май чи энийг аваад харьж бай. Би удахгүй очно гээд тэр надад нэмж хоёр алим өгөв.

Харин Сараад юу ч өгөхгүй, юу ч ярихгүй байгаад байв. Нүдэнд нь хорхой ассан Сараа

“Охин”Баяраа луу, над руу нэг харснаа гэртээ гүйгээд орчихлоо. Би ч хоёр алимаа халааслаад гэрээдээ гүйлээ. Гэртээ орсон Сараад Баяраагийн амнаас том томоор унах алим харагдаад болдоггүй. Сэмхэн гэрээс гарч хашааны завсараар харвал “Охин” Баяраа урдын янзаар, алимнаас хазаад ч газар луу нулимах аж. Хашааны хаалга аяархан дуугарахыг сонссон горьдоогч этгээд толгойгоо өндийлгөөд их л өгөөмөрөөр

- Сараа ! Алим идэхгүй юм уу? Хэзээ дургүй болчихоов? Нааш ир.

- Нээрээ чи өгөх юм уу?

- Өгнө өө өгнө. Нааш ир.

Сараа “Охин” Баяраагийн хажууд иртэл ууттай алимны бараг тал хагас нь газар хэвтэнэ. Нэг өглөг шиншилж ирэхэд, Баяраа эс ойртуулах тул тэр сүүдэр бараадлаа.

- Яаж байгаа юм? гэж Сараа шүлсээ залгин шороотой алим руу харамсан харсаар суув.

- Би цадчихаад, чамд өгье гэтэл чи гэртээ орчихсон шүү дээ. Гөлгөнд алим би аваагүй.

Чамтай хувааж идье гэж бодсон.

- За надаа л даа. Гараад ирчихсэн байна шүү дээ.

- Нэг тэгүүлчих. Тэгвэл бүгдийг нь өгнө шүү. Царай нь улайсан Сараа гэрээдээ гүйх гэтэл

Баяраа

- За худлаа даа, тоглосон юм гээд урьдын хэвээр алимаас хазан газар луу нулимсаар байх аж. Сараагийн тэсвэр алдагдаж

- Өгөхгүй юм уу? Би орлоо.

- Өгөх гэж байхад, чи яараад байхийм.

- Тэгээд өгөөч дээ гээд гараа сунгав.

- Хажууд суу л даа. Босоогоор алим идвэл амтгүй. Хоол боловсруулах эрхтэнд муу ш дээ.

Жаахан худлаа ярья. Сараа горьдсон шүлсээ цааш залгин:

- Ах одоохон ирнэ, би орлоо.

- Байз л даа, хажууд суугаач

- Өгөх юм уу, үгүй юм уу

- Өгнөө. Хамт суугаач дээ.Хорхойтохын эрхэнд Сараа хажууд нь цомцойн суухад, Баяраа нэг алим өгөх зуураа

- Нээрээ нэг тэгүүлчих, чамайг голио Гонгор тэгсэн гэсэн, бас нөгөө хэн ..,” гээд гараа татав. Сараа учиргүй ичиж, алим идэх манатай нүд нь жижгэрч, хуруу чичрээд босоход , Баяраа

“Чамайг “Банзал” гэж сургуулиар нэг тарааж, амьтны шившиг болгоно доо” гээд өгөх алимаа өөрөө идсээр бослоо. Санасандаа хүрээгүй “Охин” Баяраа хажуудаа байгаа нохойг өшиглөж орхив. Соргог чихтэй нохойд ч бараг дуулдахгүйгээр Сараа

- Нээрээ алимнаас өгөх юм уу? гэж шивнэв.

- Батаа бат, яг найдвартай өгнө гээд санасандаа хүрсэн эр хүний ёсоор алимнаас нэгийг авч Сараа руу сарвайлаа. Хэнд ч хэлэхгүй биз.

- Хэнд ч хэлэхгүй. Голио Гонгорт ч ганц үг цухуйлгахгүй. Батлая. Саванд ердөө дөрөв тавхан алим үлдсэн байв. Энэ намар Сараа долоод, “Охин” Баяраа зургаад орсон жил юм. Хожим сумандаа амралтаар очиход “Охин”Баяраа маань “Хүүхэн” Баяраа болж сайхан морины

нуруун дээр нарыг үдэж, оддыг угтдаг ханхалзуур нэгэн болжээ. Тэвэгний оронд шагай харвахын донд автаж, ойр хавийн сум аймагт шагайч болсон байв. Бас бооцоотой. Тоглоомноос бооцоог салгавал амтгүй болно. Хойтон намар нь найрнаас харьж яваад мориноос осолдож анги ханагар минь өнгөрсөн гэж дуулдав. Богино настайгаа мэдсэн юм болов уу Баяраа минь их эрт эр хүн болж охидын амтанд шимтсэн дээ. Хүүхний тэнгэртэй аавын цээж авирыг нь авах их далд овоглогдох хэдэн хүүхэд нь дуурайх болов уу, яах бол.

ЧУЛУУН БАЙЛДААН

Их хувьсгалч Мао-Зедуны үеийн Хятад манай улсын хамгийн ойрын аюулт дайсан байсан цаг.

Жанжин Чойрыг тойрсон орос цэргийн анги дивиз гэж учир тоймгүй. Дуунаас хурдан онгоц, нисдэг тэрэг, танк, нөгөө алдарт катюша, их буу тэргүүтэн харин Чойрын хүүхдүүдэд нүд хужирлах тийм сонин этгээд ердөө биш байсан. Гагцхүү дэлгүүрээс архи авахаар ирэх орос цэргүүдээс тэмдэ авах явдал гавьяат ажил байв. “Кампаан! Тэмдэг есть?” гээд л ёслоход, усан цэнхэр нүдэнд гайхахын зэрэглээ сүүмэлзэж, улаан таван хошууг заахаар сая нэг ойлгодогсон.

“Оросоор яриад байхад ойлгохгүй хачин юм. Хармалсандаа тэр байх” гэж хирэндээ сайн муу санацгаана. Аргагүй шүү дээ, гол үгээ оросоор хэлдэггүй байж. Тэгэхээр арга байж. Бас байлдаж тоглох хөвүүдийн ганц зугаа. Улаан таван хошуутай нь манайх, тэмдэггүй нь шууд дайсан.

Тэгэхээр орос цэргүүдээс тэмдэг гуйх юу ч биш. “Нохойтой дөрвөн танкчин”, “Километр бүрт”, “Баригдашгүй өшөө авагч” гээд үзсэн ихэвчлэн гарч байдаг байлдаантай кино бүхэн бидэндээ багш гэсэн үг. Мод, төмрөөр “АКА” буу дуурайлган зорж, амаараа их дуу гаргаж учир начиргүй шүрших зэргээр нэгнийгээ зээр шиг намнаж гарах нь тэр. “Чи үхсэн, би шархадсан” гээд маргалдаж өгнө. Заримдаа шар хор нь хөөрсөн хэрүүл хаврын түймэр шиг авалцаж жинхэнэ байлдаан болох жишээтэй. Зодоон цохион үүсэх явдлаар даамжирч, шийр зааж, сарын өс санах үйлдэл байдаг л юм. Намалдагаа нээх, нүд хөхрөх бүр энүүхэнд. Хоёр хэсэгт хуваагдсаар хүрээ тэлж хүч нэмэгдсээр Дэнж, Давхарынханаар талцаж чулуун байлдаан үүсгэдэг. Бас ч үгүй “өстэй бол өстэй, цустай бол цустай” үзэлцэнэ. Хэн нэг нь толгойгоо хага яруулбал, сая тэр тал нь ялагдсанд тооцно. Манай Дэнжийн мэргэн бууч зантгар Хүрлээ. Толгойн талбай том тул дайсан онох магадлал ихтэй. Гэсэн ч чулуун байлдаанд ганц ч удаа толгойгоо хагалуулаагүй юм. Бултаж зайлахдаа хярс шиг годгонуур, хараа сайн. Гэм нь нусаа татахдаа маш удаан. Байлдааны үед өөрийн сүлд дуутай гэж байгаа.

Орой дээрээс зулай хагалам том чулуу

Ойртон ирэхэд нь бултаж орхисон чинь

Олон хүмүүс намайг хараад

Овоо сэргэлэн бацаан байна гэлээ, гэж дуулаад давших нь цаанаа урамтай. Давхарын мэргэн цэрэг нь манай ангийн солгой Энхээ. Нарны цагаан малгай хазгай тавьж хэрзгэр урт гар нь уурга шиг суналзаж харагдана. Солгой гараар савж чулуу шидэх нь толгой дээгүүр шүнгэнэх дуунаас хурдан онгоц шиг агаар зүсээд хол тусгалтай. Тэр нэгэн хаврын оройн чулуун байлдаан би нэн баатарлаг эр Алаг морьт Дандар баатарыг сэтгэлдээ зурж бас өөртөө итгэж, айсуй сумнаасүнэгний сүүлэн хууралт шиг зайлж, манайхан Хүрлээг биш намайг бахдаж байгааг чихэндээ бусзүрхэндээ сонсон байлдаж гарваа. Нүд алгасаж түлхэх шатрын ноёны урд хүү шиг би бусдаасаацойлжээ. Миний сум дуусч, шидэх чулуу харцаар хайх нэг шинэ ажил нэмэгдэв. Давшилт сатаарч,ухрах гарцаагүй боллоо. Санаандаа хүрээгүй тул урамгүй л

байлаа. Нэг ёсондоо би ангийнхаасолгой Энхээд ялагдаж байгаа юм. Бид хоёрын хэн түрүүлж дайсныхаа толгойг хага ононо тэр ньангийн атаман болох ёстой. Охид охидоос тэргүүн хөөрхөн Сэндэрийн хажууд суух эрхтэй болжөдөр бүр эмээгий нь өгдөг чихрийг хуваалцаж идэх нь дажгүй хэрэг байлаа. Ашгүй Хүрлээ минийдэргэд ирж надад хэдэн чулуу өгч дэм болох зуур- Ухаръя, баригдаж магадгүй гэж хэлээд айсуй чулуунаас бултана.- За, за буцъя гэж би зөвшөөрлөө. Жаргах нарны сүмбэн шар цацрагны дагуу гулсангэрэл нүдэнд солонгорлоо ч айсуй чулуунд оногдолгүй холдож амжив. Дахиж дайралт хийхийгби хүснэ. Гэтэл нардүүлж шидсэн нисдэг таваг шиг эргэлдэх чулуу гулсах мэт ирж зайлж бултажүнэхээр амжсангүй. Тас гэх дууг чих минь сонсож, нулимс нүдээр дүүрч хоёр гараар толгойгоодаран хагас суухдаа солгой Энхээ гараа өргөн гүйж

- Миний шидсэн чулуу Мандаагийн толгойг мэргэн онолоо.

Энэ бол миний ялалт гэж нарны малгайгаа эргүүлэн хашгирахыг сонсов. Асгарахад бэлэн нулимс миний хор шаранд ууршлаа. Намайг оносон цустай чулууг Хүрлээ ирж надад өгөв. Цусаа үзэхээр ямар хайран байдаг юм. Өш, шар хоёроор толгойгоо боож ашгүй цус ч тогтлоо. Хамар сарталзаад, нүд эргэлдээд, хөмхийгээ зууна. Хонзон санахгүй байхын аргагүй аж. Гэвч дараагийн байлдаан хүлээхээс замгүй болов. Солгойгийн толгойг заавал хагалахгүй бол би одоо хэн ч биш. Дайсны толгойг яаж хага буудахыг мэргэн бууч Хүрлээ заахаар болов.

- Чи яаж сайн онодог болсон юм бэ?

- Урт сүүлтэй шар оготоныг шидсээр байгаад овоо баримжаатай болсон юм.

Энхээгийн толгойг хагалахын тулд жаахан сургуулилах хэрэгтэй гэв.

- Тэгье.Маленкийг авч гурвуулаа сургууль хийе.

- Маргааш эхлэнэ шүү. Энэ чулуугаар нь чиний толгойг хагална даа гэж би шүд зуусаар байв.

Маргааш нь гурван поошигны таг олж Хүрлээ өөрийнхөө толгой хэмжээтэй адил хүний толгойгшохойгоор зураад дараагийн таг дээр минийхийг сүүлчийн хавтгай дээр бор Маленкийгийн толгойгдүрсэлж цагаан шохойгоор нилд нь будлаа. Манай хашаанаас өлгөж гучаад алхамын зайнаас чулуунүүлгэж гарав. Гэвч хажуу айлын эмгэнд загнуулж буурь сэлгэхээс аргагүйд хүрлээ. Хашааны арынхунгарласан элсэн байгаа суулгаж, онохын төлөө бид чулуу нүүлгэсээр, тэр хоёр залхаж байгаабололтойдог. Хүрлээг оноход эзэн нь хөөрч урамшуулна. Миний дүрсэнд тусахад шарх хөндүүрлэхшиг болох нь хачин. Маленкийг онохоор ярвайчихсан зогсоно. Мэргэн тусах чулуу бүр цагааншохойн тэмдэгтэй. Хэдэн чулуу шидэхэд хэн хэд оносон тоо гарч болмоор.

- Одоо хөдөлгөөнтэй бай оноцгооё гэж Хүрлээ санал гаргалаа.

- Тэгээд яах гэж Маленкийг асуухад

- Хогийн хонхор явцгаая гэсэн Хүрлээгийн санал урам сэргээсэн шийдэл байв. Тэнд урт сүүлтэй шар шар оготонууд хаа л бол шир шур хийнэ шүү дээ. Ёстой зөв гэсэн харцаар би

найзыгаа харлаа.Бид гурав зам зууртаа сав хийвэл шидэж болох бүхнийг чулуугаар нүүлгэсээр солгой

“Энхээгийн толгойг” цөм цөм онож, бах таваа хангана. Миний толгойн өвчин эдгэрсэн мэт сэргэлэн.

Сэтгэлийн ёроолд хор шар түймэр шиг асаатай.

- Одоо байна шүү дээ, арга чаргатай шидэцгээнэ шүү

- Яаж? гэж намайг асуувал

- Тэр амархан. Нэг гэхэд чи хоёр гэж амандаа хэлээд, гурав гэхээр Маленкий, дөрөв мөн амандаа, тав гэхээр би шиднэ.

- Яагаад тав гэхэд чи гэж?

- Би чинь “Онц мэргэн буудагч” биз дээ?

- Заавал би Солгойг онох ёстой шүү!

- Тэгээрээ, чиний тэнгэр мэдэх хэрэг. Дасгал сургуулилт ерөнхийдөө дажгүй. Бид гурвын хавсайдах арга барил боломжийн санагдаж байлаа. Хичээлд явах цаг ойртох тусам Энхээгийн шонтгор хамар миний нүдэнд харагдаад болдоггүй. Нүүр тулахаар надаас жаахан сүрддэгийг нь манай ангийнхан тэр тусмаа Сэндэрийг мэддэг гэж бодоход миний зориг ундарна. Чи ч надаас шангаа хүртэнэ дээ гэж бодсоор омог төгөлдөр ангийн хаалга татвал “Энхээ хичээлдээ ирээгүй” гэгцгээв. Тэр надаас айжээ гэсэн сэтгэгдэл төрлөө. Хуучин зангаар Сэндэрийн хажууд суувал, над руу гярхай ажиж

- Чи миний хажууд суухаар болоо юу гэхэд, Солгой миний толгойг хагалсанг хэлж дээ гэж би бодсон ч

- Тиймээ гэж гудийхгүй тууж орхив.

Хичээлийн хонх дуугарч багш ч орж ирлээ. Миний хариулт Сэндэрийн таамаг үнэнд үл нийцнэ.

Хичээл эхлээд тав, арван минут өнгөрсөн ч нөгөө дамшиг байдаггүй шүү. Энхээг хүлээх тусам толгой янгинана. “Өнөөдөр бүр хичээл пялахаар шийдсэн юм болов уу” гээд Сэндэр лүү хартал надад чихэр өгөөд сэмээрхэн асуух нь:

- Хэний толгой хагарсан юм бэ?

- Хэнийх ч биш

- Чинийх үү?



Боржигон Дарханахүүд овогт Төмөрийн БОЛДБААТАР

1960 оны 09-р сарын 17 нд Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр суманд төрсөн. 1978 онд сумандаа 10 жилийн дунд сургууль, 1983 онд МУИС-ийн ХБФ-ийг монгол хэл, утга зохиолын багш судлаач мэргэжлээр, 1995 онд ТЗУХИ-ийн төрийн удирдлагын үндсэн ангийг тус, тус дүүргэсэн. Идэвхтэн бичигчээс сэтгүүлчийн замаар 30 дахь жилдээ ажиллаж байгаагийн хувьд МСЭ-ийн IX, МСНЭ-ийн III их хуралд төлөөлөгчөөр оролцож, “Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан”, “Ган үзэгтэн”, МСЭ-ийн 60 жил, МУ-д үндэсний сэтгүүлзүй үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүндэт тэмдгээр шагнуулсан. “АЛАГ ЗАЯА” номоо хэвлүүлжээ.

ХҮҮГЭЭ Л ГЭСЭЭР ҮРЭГДЭХ ХҮНИЙ ЛАА БУРХАН-ИЖИЙ МИНЬ

Үгүй ээ, ухаант найрагчийн дэндүү үнэн хоёр мөртийг биччихээд жоол суужээ байтал аль багад минь сонссон домог мэт яриа санаанд зурсхийв.

Ач буянтайгаараа хурц нартай, хөхөлбөр сартай хөрст энэ орчлонд ная гартлаа амьдарч асан Дэлдгээгийн минь аяга зөөг цай уух зуураа ярьсан яриа л даа. Ганц хүү нь бие дордож олон хоногоор хэвтэрт орж насан өндөр эх асарч тойлж арга чаргаа барж ягтаа тулчихаад “Харж хаацайлж явах эрдэнийг минь ингэж өвчин шаналан ээрэх ч гэж дээ. Юу ч үзээгүй цэл залуугаараа амьтныг тарчлааж байхаар оронд нь хэзээ мөдгүй болсон намайг аваад яваач,эрлэг номун хаан минь” гэж цаг үргэлж үглэж залбирах.Цагийн үзүүр наашилж ханш нээсэн үеэр өтөг бууцны чийг бамтай өвөлжөөнөөсөө зөөж бууж завдаагүй байсан нэгэн өдөр дунд хэрд. Зузаахан хувцас мөр дарсан, бүхий бие нозоором бас ялаархуу юм гарчихсан цаг санж. Хөөврийг нь маажсан болоод нэгдлийн ногдол даалгаварт өгчихсөн нэмнээний ормоор үлдсэн жоолоо өөрсдөө улаан арьсаа гартал юу ч үгүй долоочихсон хэдэн боолтрогнууд хашаа хороо гэр бараа дайрчих нь халаг, оодогноод сүйд майд, Аль намрын дунд сарын хуучдаар нэгмөсөн давхарлаад барьчихсан гэрт салхи савир орог гээд үүдээ нээчихээд хүүдээ аягахан шөлний юм оочуулаад ажилдаа түүртсэн хөгшин эхийн нүдэнд ад зэтгэрийн амьтан шиг юм үзэгдэж, ухаан тавин айхдаа “Хүүе гэм тэр эрлэгт очих хүн чинь би биш Тэр тээр баруун орон дээр хэвтэж байна, гэж уулга алдан босож иржээ.Байж ядаж,батгана сүүлдэхдээ

нээлттэй хаалга руу амь тэмцэн ухаан малгайгүй дайрахдаа гэрийн хаяанд байсан үнсний хөнгөрцгийг нь эвэртээ өлгөн эзнээ бараадсан алаг

- Үгүй ээ, минийх биш гэж шивнэхэд толгойд хөндүүр нэмэгдэнэ.

Багш бидэн рүү харцаар чимээгүйг анхааруулахад амаа хамхилаа. Толгойн өвчин замхарч, өрөөсөн гараа атгаж Энхээг хүлээж хичээл завсарлахыг яарна. Жижүүр багш ирж ирц автал миний гол дайсан өвчтөний тоонд орлоо. “Зальтай муу нохой чинь ингэхдээ хүрч дээ” гэж би бодоод авав.

Ангийн хаалга дуугармагч хамгийн түрүүн хаалга руу харц шидлээ. Гэтэл манай хоёр шагайж байх нь тэр. Намайг өндөлзтөл “Азны юм. Хонх, хонх..” Би нөгөө хоёртоо дөхөж очтол:

- Чи мэдсэн үү? Цаадах чинь эмнэлэгт хэвтсэн гэнэ.

- Юун эмнэлэг..,

- Үүрээр Солгой түргэний тэргээр эмнэлэгт хүргэгдээд орос цэргийн эмнэлэгт олгойгоо авахуулсан гэнэ.

- Хэн тэгж хэлж байна аа?

- Тэдний байрны Боорой гэж Маленький дуржигнуулав.

- Хичээлдээ ирээгүй нь тийм учиртай байжээ.

- Яагаад заавал орос эмнэлэгт хэвтсэн гэж?

- Олгой нь дотроо хагарсан учраас тэр. Хүнд болохоор манай эмч нар оросуудыг гуйсан юм байх аа гэхэд:

- Чамаас айгаад Солгойгийн олгой нь гэдсэндээ хагарчээ гэж Хүрлээ хөхрөв.

- Надаас биш ээ, их онгирсондоо тэр биз дээ гэж намайг хариулахад:

- Аль нь ч биш. Ноднин зун би тэнд хэвтэж долоо хоноход “Маленький” гэдэг энэ нэрийг надад орос эмч өгөөгүй юу. Хоол нь ёстой жаатай даа гээд алаг нүд нь асаад ирлээ.

Солгойг өрөвдсөндөө миний дотор буцалж байсан хор шар ууршиж эхлэхэд толгойн лугшилт намжих шиг болно. Намайг оносон цустай чулууг гаргаж, цонхоор хаяхын өмнө:

- Тэртээ тэргүй гэдсээ хагалуулсан юм чинь би өш санахаа байлаа гэв.

- Солгойгийн олгой оёотой, чиний толгой онгорхой шүү дээ.

- Би дажгүй зүгээр болчихно. Найрамдаж бүгдээр сайдъя гээд саллаа.

Хичээлийн хонх бүгдийн чихэнд жингэнэнэ. Бид анги ангийн зүг явцгаалаа. Намайг Сэндэр нэг л зэмлэнгүй ширтэхийг ажиглав.

- Манай ангийнхан сонсоорой. Энхээ олгойгоо авахуулаад орос цэргийн эмнэлэгт хэвтсэн гэнэ. Бүгдээр очиж эргэнэ шүү гэж намайг уриалахад

- Тэгье, хүүхдүүдээ гэж Сэндэр дэмжиж билээ.

Урьдын юм ул болдогийг хэлэх мэт урд хөрш “дайсан” биш болж орос цэргүүд Чойроос минь нутаг бүр мөсөн буцаад хүүхдүүд ч чулуугаар байлдахаа ор тас мартжээ. Би ч бас байлдаанд оролцоод, шархдаж үзсэн толгой. Хирэндээ таарсан “ахмад дайчин” биш гэж үү. Манай үеийнхэн бас л орчлонгийн жамаар цөөрч байна даа.

х х х

Айл амьтаны бараа хүн харын нэмэр хамжаа бодсон Норовынх оройн сэрүүнд ачаалаад зунызунд айлсаж зусдаг Сэрж гуайн гадаа үдшийн одтой хамт хотлон буулаа. Настай хүн, нялх хүүхэдхоёрын явдал суудал таарах нь аяга ам хоёр шиг. Тэгээд ч үр садан өргөж тээх хүнгүй шахам хэл,ул болсоор айлсаж санаа нь амарч авч. Сэрж эмээ Норовын ууган хүүг “Эмээгийн амны алчуур”гэж өхөөрдөх. “”Бид хоёрын бэлчээр, ижил, сэтгэл хоргүй. Ирж яваа, талийж одох цагийн уулзварамьтад” гэж хөөрөх дуртай. Эгээ л элэг өрцнөөс унасан үрээс ялгаагүй ухаанаа тавих. Хөгшинуулаасаа ясан шүд яралзаж байсны оргүй эдгэсэн улаан махан буйлаараа маймчиж, маймчижөөрийнхөө хүнснээс хүүд хувь хүртээх. Их нь үзэж өнгөрүүлснээ нэхэн дурсаж юуханд ч боловчимээгүйхэн мэлмэрчээ суухад бага нь үзээгүйгээ үзэх бариагүйгээ барих гэсэн шиг хүрч,хүрэлцэхгүй юмгүй адтай нь аргагүй цовоо дуугаар ход ход инээх Хүний амьдаралын урганмандах уусан ажргах наран орчлонгийн тунгалаг өглөө бүүдгэр үдэш ер хэзээ л бол хэзээ зайгааолж байраа эзлэх нь жам ёсны ажээ. Их таван ханатын үүдэн хоймор хоёр, хот айлын хөгшинхөрвө хоёр билээ л Сэрж хөгшин Тулга хүү эднүүс минь. Элээн сүүдэр дайрчихвий эндэл осолболчихвий гэхээс бурхан тахилдаа буян заяаг минь даатгаж, алд биеийн алжаалыг юман чинээбодолгүй үрийнхээ төлөө өөрийн биеэ зольсон өрлөг сайхан ээжий-Ижий бурхан мину зээ

ХУЛ НАМАР

Төв, суурин газрын байшин, саравчны ээвэр нөмөр бараадуулан тарьсан бургас, улиас модод бие бүрэх юмгүй нүцгэрч муруй тахир, эгц гоолиг, өндөр, нам байгаа чигээрээ нүдний өмнө. Зун, намаржингаа шимт ургамал завьжаа ногоортол дүүргэн, дүүргэн чихэн зажилж бас хивсэн хонь, ямаа, үхэр сүрэг бэлчээртээ ч, хотондоо ч тарайн хэвтэх нь тарга тэвээрэг хангалттай авсных. Уул, толгод, гуу жалга, судаа ирж, буцаж байгаа цагийн аясаар хүрэн улаан, багир ногоон зарим газраараа хулсан цулхир шаргал сөл талаар нэг ийш ч, тийш ч халиурна. Аяс аясхан “аргагүй амраг” шиг аргадах сэвшээ салхинд бүжингийн, арагны чинээ бас хоточ банхарын дайтай хамхуул уруугаа буцаад өөд сөөргөө хөлгүй гүйх. Өчигдөр өдөр оройхон шугамын засвар хийхдээ ухаж гаргасан нойтон шороо өглөө товоршон дарайж бүр цагаан хяруу уначихсан хөлийн дор тор, тор хийх нь хөхүүрийн ам цаашилсныг хэлүүлэлтгүй дохио зангаа өгөх шиг. Өнөө жил их замуудын зүүн тал руу арай ч дээ гэмээр шивээлсэн. Бага машины дугуй далдран алдан ургасан өтгөн шивээн дотор олон, олон цагаан зээрийн хондлой үл ялгарах, өдрөөр тэдэнд аюул харьцангуй хол. Аргач үгүй хул шаргал намрын хулсан шивээ, өнгө ижил зээрийн сүрэг. Хараа сайтай залуу анчинд ч үл ялгагдах бас үл ажиглагдах тэд эс анзаарах. Шивээлсэн газрын бага малын хоолой багалзуур гар хүрэхийн аргагүй бүүр бэлчээрлэж чадахгүй болтлоо баглуулсан нь ч байдаг. Гэлээ ч намрын анхны цас олигтойхон ороодохвол шивээн зүүн толгой дэвтэж дорхноо хөрсөнд буудаг гэлцдэг. Хүчтэй нь хүчгүйгээ дийлэх байгалийн жам ийм л. Байгаль эхийн өөрийгөө урлан бүтээсэн уран зураг энэ.

бяруу байсныг хөөрхий эх эрлэгийн элч байна гэж будилсан нь энэ.Ээжийнхээ ийнхүү мунгинажамнаасаа буцаж самгардахыг харж хэвтсэн хүү нь тэсгэлгүй тэсрэх мэт инээд алдтал бүх биень хөнгөрөөд явчих шиг болж.Хожим учрыг олоход хоолойд нь буглачихсан том идээт үрэвсэлгэнэтийн хүчтэй инээдээр дотогшоо хагарч илааршсан гэдэг. Домог ч биш юмаа. Харин домоглугаа үнэн Энүүхэн Даланжаргалан сумын Цацаг Нэрэн гэдэг хүнд тохиолдсон явдал гэсэн шүүта минь Ээжийн гэгээн сэтгэл , сүүн мөр биш гэж үү?

х х х

Зуны таатай сайхан өдрийн жин үдийн наран хойморлосон пүн халуунаар ганц хүнд элбэг ахдахбог малаа усалж тоогоо алдтал тонголзох ховоо татсан залуу эх гэртээ ирэнгүүт,хаяа хатавчаасөхөөд дээл хувцасаа нимгэлж борц үйсэн, сүү болсон сайхан цай чанах юм болов. Энэ зууруяандаа баахан түүртсэн бяцхан хүүгээ өрөвдөөд өвөр дээрээ авч өөр зүйрлэх юмгүй ариуханүнэртэх нялххан багынх нь сэвлэгийг үнэрлэн үнэрлэн суулаа. Хүү нь хоргол нүдээрээ орчныгсая харах мэт сониучирхаад нь дөлөөрөө тоглогдоо гэсэндээ үнсэж үнсэж тавилаа.Шируун галдээр төдөлгүй буцалсан цайгаа хийцлэх борц нүдэх гаднаас дотор өөх,сэмж оруулах данх домбооарчиж зүлгэх гээд нэг хэсэгтээ л анзаарсан юмгүй. Хэдүй нь босго, хатавчтай хамжин элгээрээмөлхөж байгаад түүртэн гарч харагдсан хүүгээ сая санаж нэрээр нь дуудлаа.

Ийн уун шулганахнь томоохон хомолон чинээ бойтгонд нь уясан хос хонхон хэл сонсогдохгүй аг чиг. Нөмгөлөнсуусан дээлээ ч бүслэх сөхөөгүй нэг дуу тэнгэрт нэг дуун газарт, хадаан шургачин гүйх ээжбүсгүй саахалтынхаа хонин дээр явсан хүүгэс асуусан ч харж үзсэн юмгүй,

бара сураггүй.Толгойн саатаы алчуураа гээж бүүрхэн гутлынхаа хошууг халцлан хоолойдоо түй гэх шүлсгүйболтлоо гүйхдээ удалгүй нүүхэр гангийн шинжтэй хорхойссон сэрвэгнүүр салхи залгилаад хаабайсан Гүйлст хүртэл салхидаж одсон ачлаганы хэдэн тэмээндээ явж , эрлээ олоод ирж яваанөхөртэйгөө халз тулгарав. Нөхөр Норов нь ер ажиггүй харин ч Дэрсэнэ бууц, Тост амны голыгөгсөн уруудан хашгичин гуагчиж гүйсэндээ хөлс, нулимс нь ялгарахгүй урсах гэргийгээ баахансонжиж, тохуурхсан маягтай инээмсэглэв. Халуунд нозоорохдоо сугалдаргалчихсан дээлийнхээөврөөр нэг юм түнтийлгэчихэж. Агентаар орж холдож нүүхээсээ өмнө жоол зугаа юм авсан л биз гэж бодсон бүсгүй “Одоо яаж ам ангайя даа байз Юу гэж ойлгуулья даа. Хүү минь хаанаангаж цангатлаа орилж, чарлаж яваа бол. Ядахдаа халууны байгаа царайг Наршчихаж байх вийХээр гадаа унтаж хэрээ шувуу оролдчихавзай” гэж зовнин бодож таг дуугүй зогссоор Байдлыгтэртэй тэргүй гадарласан нөхөр нь сая ам нээж “Миний сайн эр ч үнэхээр хөлд орж хөрстийгтамгалах нь ээ Мядааг зовох юмгүй ээ хө Миний хүү Цахилдаг толгойн баруун гууд дэгдээхэйгээдагуулсан хоёр тогоруутай л наадаж явна” гэхдээ тайван гээч нь инээмсэглэж эхийн сэтгэлийннарыг мандуулав. Мориноосоо буугаад гүйж гүйж хөл нь бохирсон түүнийгээ морины нуруундээр хүүхэд шиг өргөн мордуулахад Мядагийн нүд нулимс дүүрээд ирэв Харин хэргийн эзэн ,хэнгэрэгийн дохиур мантгар хүү нь юу ч болсон шинжгүй аавынхаа өвөрт унтаж байлаа. Зэлнийхавиар эргэлдэж үхрийн баасанд шавах том алаг хорхойг түүж иддэг өнөө хоёр тогоруу л хүүгнь байгальтай танилцуулснаас гараа гэж үү ? Тэр юу вэ? Энэ юу вэ? Гэж асууж өдөөх шиг ойройрхон байгаа хадан хошууг ороож голын дэрсийг булбарай нүүрээ шалбалж, нүдээ чичэлгүйхэнтүүчихсан байдаг. Нялх амьтаны заяа,үрт амьтаны нөмөр энэбуюу. Иим л аугаа билээ. Хүүхдэдуяа өлзийтэй гэсэн үгтэй.

ГАНЦ МАЙХАН ДЭРВЭЛЗЭНЭ, ТУУВАР СҮҮЛЧИЛЖЭЭ

/Эрдэмтэн, зохиолч МУИС-д суралцаж ахуйд анги даасан багш минь байсан Сэндэнжавын Дуламын шүлгээс/

Эсээ

Жалга, сархиагий нь нэгжиж мөлжөөд гар хадуураар хадчихсан, газрын өгсүүр Улаантолгойн хоёр бөөрөөр орж ирсэн уужуу хөндийн тээр дор хуучин хийцийн ганц майхан үлээсэнолгой шиг бөмбөлзөн дэрвэлзэнэ. Жилийн жилд ерхөг, цахилдаг, дааган сүүл сугсалзаж байдагДөрвөлжийн хэдэн хоолойн дунд хэрд байх дээхэн цагийн том амтай, чулуун хашлагатай, бөхбат модон тагтай худгийн тархин дээр байх энэ майхны хавь орчны өвс ногоо, хүн малын хөлдгишгэгдээгүй соргог босоо, намар оройн ааг үнэр хамар цоргих нь оторчны нүүдэл ирээд тунч удаагүйг гэрчилнэ. Энэ майхан аймгийн хошой аврага малчин миний аавынх. Намар цаг иймурт сунагар, ийм уйтай бас хул шаргал торго дурдам шиг намилзсан гундуу шар байдгийг еранзаарсангүй ээ, хонгорхон хорин насандаа. Энэ, тэр тодорхой шалтгаангүй байтлаа сургуульдааявах тултал аав хот яваад ирэхдээ “Хүүдээ намрын ажлаас чинь чөлөө авчихлаа. Арван сарынаравдаар очиход болох нь” гэсээр ирэв. Үс, хөөвөр нь бүрзийгээд таргалсан ч юм шиг. Эсвэлтагтай төстэй тэг дөрвөлжлөөд жижигхэн болчихсон юм шиг харагдах намар цагийн хөл чангатаймориор салхи татуулан ширүүхэн эргүүлээд өнгөрсөн ч хавийн хуурай бор хөрс пургин хөдлөх,юуханд ч тоос, шороо татах хачин жигтэй цаг улирлаа гэж. Худгийн амрсан онгоцны хавиармалын хөлөөр шальж байсан асгар өглөө, оройд хариугүй нимгэхэн ч гэлээ зайрмагтаж, зунжингааил задгай хангал явсан арьс хөрсийг чимчигнүүлж, үзүүр нь сэрүү оргиж, хүйт даасан жиндүүсалхи хаа тааралдсан газраа хайр найргүй атлаа элбэх. Майхны зүүн талын баадан түшүүлсэнбаахан холхиндог янданг шивнээ ярианд ч исгэрсэний дайтай сүрхийн хөдлөх хөл хөнгөн салхинхангинуулж, ёнгинуулах. Уруугаа хараад, хйод хоёр борвин завсараар нь шингэн сүүл нь салхитатуулан ямар нэгэн хөг гарган хүүгэж нойрмоглоон зогсох бүгээн зүсний хөгшин морь лугаанамар цагаа гэж, ийм л байдагсанж. Аав “Очирынх нэг адуу унагах гэнэ. Хүүдээ чанаж идэх юмавчирч өгье байз. Умсанд дуртайг чинь Мандал гуай нь мэдэх хойно.” гээд л мордсон. Өнөө их үдхүртэл бараагүй.

Бодвол эрийн цээнд хүрсэн их сургуулийн оюутан хүү, хэдэн хоньд, майхан энэ,тэрдээ санаа зовсонгүй бололтой. Хоёр өвгөн Мандал гуайн ая эвийг олж байж Ганц, хоёр тогоотавиулаа байхаа даа. Гэтэл ... гэтэл өнөөх сүрхий хүү нь шөнөжингөө нойр алдан хөрвөөж, майханхөвхөс хийхэд ч хөнжилдөө шургаж бие нь чичрүүдэс хийж юун хонь малаа харах, эргэж тойрох байхав. Гүйдэлтэй, ёдортой хонхорт хоносноос өөрцгүй дэв дав хийж арайтай сэтгэцийн эмгэголчихолгүйхэн шиг хонолоо. Байгаль дэлхийн аль л шимтэй, шүлттэйг хөл цуцаан гүйж, ам мэдэнидэшлэсэн намар цагийн тарга тэвээрэг авсан. Хонин олон сүрэг маань хаа нэг янцаглан салхиндээд талаас халуу дүүгүүлэн, таана, хүмүүл үнэртүүлэн тааваар налайн хэвтэхийг чагнаарханбайсан нь ааваас ч илүү хань болж байв. Харин, овоо хэдэн хавчигнасан годрон босон харайсангүйбас алаг даага тарган малын ам хамар ухах гэж тавьтаргүйтэн гүйсэнгүй бололтой. Ойрын юмныдүрс ялгагдахтай болж, дөнгөж гэгээ оров уу? үгүй юу л босон харайж цай чанаж уулаа. Аяганыхийцийн ааруул, хурууд, боорцог, еэвэн сүрхий хатуурч залуу нохой ч даахааргүй болж. Гэлээч угааны үнэр суусан хээрийн цайнд

үйж байгаад ядах юмгүй хүртэж орхих оо мэдэлгүйдээ,ер. Их үд нэлээд өнгөрсөн хойно Очир гуай, аав хоёр зэгсэн улаан зээрд болчихсон ирлээ. Гархоосон, ганзага сул. Би юу гэж тэднээс яав, ийв гэж болохсон билээ. “Очир гуайнх нь зээрдтэй хэдолдсонгүй. Үүгээр орж ирээгүй биз. Миний хүү ч адууг эрх биш ялгахаас цаашгүй, айж зугтахгүйбол их юм болох хүн. Бараг анзаарахгүй байхаа ядахгүй дээ. Очир ах нь одоо л нэг юм олж харихбиз. Тэгэхлээр нь л...” гэж дутуу, хагас юм яриад аав маань хүржигнэтэл хурхирч гарлаа. Очиргуай тэп, тап хийгээд сул хөрсний хамарын тамхи шиг шороог томоо гэгч монгол гутлаараапур, пур хийлгэн нэг л их ажирсан юмгүй хар, цагаан дуугүй мордоод явчихав. Оторчны хүүби хойд энгэрлүү хурд мэдэн уралдах хэдэн хониныхоо араас мордлоо. Улаан толгойн энгэрлүү асаж байсан хэдэн ямаа толгойлсон хоньдоо буцаажхаад шивээн толгой баахныг багцалж аваад “Бөх барилдуулж” гарав. Сүрэг маань ч ийш тийш гүйлдсэнгүй тэгэс гээд нөмөр газартогтуухан идээшлэх ч өөрийгөө жоол зугаацуулснаа төдхөн сонь буурч гараа дэрлэн хэвтгэлзүүрмэглэхнээ, янз нь. Тэнгэрийн байдал нэг л ёзгүй. Аль нь хаашаа нүүгээд байгаа нь мэдэгдэхялгах юмгүй зонхигүй өнгөтэй өтгөн, өтгөн үүлс зөрөн, ярган нүүгээд. Бараг л толгой эргүүлэхнь ээ. Заримаас нь ширхэг бүдүүн хэд, гурван дусал хаяж ч байх шиг. Олон хоногоор эмнэлэгсахисан эмгэгтэй амьтан шиг туниа муутай нарны хэлтэрхий зай завсаргүй зөрөлдөх үүлнийбулан, тохойгоос ёлтон, ёлтон хийх нь амь тавин тэмцэлдэж, ач тач үзэлцээд ч байх шиг. Шөнө хоногтоо үгүйдээ л маргаашнаас тэнгэр бурхан эвгүйцэх бололтой. Майхан тийш дурандвал мууаав минь худгаас унд хоолны ус аваад харьж яваа харагдлаа. “Хөөрхий дөө, Зарим хүний гар,хүрсэн болоод зүглүүлчих юмыг заавал ч үгүй өөрийнхөө санаа ханатал хийсэн хойноо болжбайдаг. Их махруу, хэтэрхий ажилсаг хүн. Ах бид хоёрт өвөлсөн юм юу ч алга. Нас нь явчихлаа.Сайндаа ч биш эзгүй зэлүүд газар ганцаархнаа сүүтийж байхаас гэхдээ намайг хань татсан чюмсан уу. Нэгэн суурийн хэрээс давсан нэг наст мал хичнээн ч жил маллав. Бузгай нь л аймгийн хошоо аврага юм биз. Үйлдвэрчний их хуралд төлөөлөгчөөр оролцоо юм биз. “Хөдөлмөрийнхүндэт медаль” аваа юм биз дээ. Би хаа гэж авах юмгүй. Малын өвчин гэж хэдэн мөчийг нь хэрэх шаналгасан айхавтар юм тусчихсан. Эдгэх гэж үгүй. Айл саахалтын, үе насны хүн амьтантайганц лонх юм султгах гэж талд нь хэдэн ч удаа унаж байгаа юм бэ? дээ. Ингэж, ингэж л нэг мөсөнөнгөрөөд өгөх. Ах, бидний асар ч, тойлох, арчилж тордох ч дээ. Ёстой л нохойн жогорхой. Нэг ньоюутан хүн билээ гээд ном шагайж, ширээ тохойлдсон болж бэлэн зэлэн хоол шөл нэхээд нөгөөхнь фермийн тоо бүртгэгч билээ гэж хойгуур урдуур нь хонуут, өнжүүтээр давхих. Миний аав шиг хөдөлмөрч, ажилсаг шоргоолжорхуу хүнийг манай энэ хонхороос хүний урманд олохгүй”.Аавтай өнгөрүүлсэн, оюутны ажилд явалгүй өнжсөн урт шаргал намрын тухай сэтгэлд миньиймэрхүү дүр зураг, дурсамж хоцорч. Одоо нэхэж бодоход аав минь амьдралдаа анх удаа арынхаалга, авилга хоёрыг давхар хэрэглэсэн юм байх аа даа. Деканд нутгийн цагаан идээ, “Янгир”нэртэй хавтгай шилтэй дарстай атгуулчихсан гэж надаас далд Мөөмд хэлэхийг нь чих дэлссэндэг. Яагаад ч юм бэ? Хүүгээрээ хань татаж , цугтаа өнгөрөөсөн тэр л намар хэзээ ч санаанаасгардаггүй билээ. Чухамдаа отор, туувар сүүлчилсэн малчны намраа гэж. Намар цагийн онгожгандсан ганц майхных нь төдөлгүй өвөлжөө, бууцаа, гэр орноо бараадсан билээ л...Аавтайгаа хамт үдсэн тэр намараа, ай хөө Намар, намараас сайхан намараа...

СЭТГЭЛИЙН МЭЛМИЙ

/холбоос эссе/

Нэг. Алтан говийн унага хуурч багш Чоён Банзрагч агсандНарны түмэн цацралаар ээлгэж эхийнхээ сүүнд цадсан унага наадан тонгочиж зэлнээс зэлэндхурдлах нь хуурын эгшигийг хөглөм яруу агаад чамин тансаг ажээ. Хуучцуулын хайр татажхуурын сайхан эгшигийг хөг ортол янцгаах нь их говийн эрдэнэ эгэл хүмүүсийн шүтээн болж,хүмүүний зүрхэнд сэтгэлийн түрлэг нэмнэ. Агуу их Равжаагаас эхлээд алтан говийнхон удамтхурдан толгойтой молор эрдэнэ хуураа тахин шүтэж, таалалд нь нийцүүлэн ая дуугаа аргаданөргөдөг билээ.Их гэгээнтэн Равжаа хутагтын эрдэм билгийн их баяраар хурдны магнайг дэндүүолон хурдтай Дэлгэрэх нутгийнхан авсан нь гайхахааргүй. Үнэхээр алтан говийн унага, Дэлгэрэхнутагт дээдэсээс удамтай хурдан эхээс босоогоороо бууж, дэмбэрэл ерөөлөөр мялаалган хурднымагнай хуурын цацал болсон түүхтэй гэдэг. Алтан говийн унага, Алтан говийн унага төдийгүйаялгуу найргийн хүлэг ая дууны хүсэл болон жигүүр дэлгэж, Ар халх, алс хол хилийн чинададая дуугаа, агтны сайхан янцгаалтаа уян торгон мэдрэмжээ, урлаж баршгүй нугалаагаа уутлажбаршгүй, зан заншлаа гайхуулан мэдрүүлж, өөрийн оронд байтугай өрнө, дорно, харийн хүмүүсийнсэтгэлийн цэнгэл эдлүүлж, халигуулан галигуулан, тэлгүүлэн тэмүүлэнхэн татаж байсан нь үнэхээрговийнхны үүрдийн бахархал гэлтэй. Хүлгэнд хайртай хүн шүлгэнд дуртай байдаг. Хурданд хайртайхүн хуурчдад хайртай байдаг..Гэвч алтан говийн хүлгийн эзэн, агсааж уясан хүлгээ унахгүй, авдрандээр тахигдсан хуураа татахгүй.Ая дуугаа түмэндээ татлахгүй. Ард олондоо дахин үзэгдэхгүйачлалт шавь нартаа ахиж сургаал хэлэхгүй. Үнэнч ханийнхаа уянгалан дуулахыг сонсохгүй. Үрхүүхдийнхээ ач буяныг бодохгүй. Хуурын эгшиг нэгээр шингэрч, хуурч хүмүүс нэгээр дутахадАлтан говийн унага, агсаж байгаа хуурыг амь ортол янцгаалаа. Хурдан удамд хөглөгдсөн хуурынаянд хөглөгдсөн багш минь тэгэхэд байгаа л дүрээрээ ирж мэнд мэдээд Мандухай цэцэн кинонынайрын хуурчийн мөч шиг агшин зуур үзэгдэж мяралзан сүүмэлзэх зэрэглээнд хүлгээ унан уусанодлоо. Ая дууны дээж Алтан говийн борлог унага минь аялгуут хуурын дээд алтан говийн бурханхуурч минь ахин давхих хүлэг дүүлэн дүүлэн цойлсоо, араас нь торойх шавь нар нь дуулан хуурданцоорсоор Алтан говийн хүлэг нар шилгээн янцгаана. Аялгуут хуурын татлага зүрхэнд онгод хөглөнө.

Хуураа тат хуурчид минь

Хурдаа мэд хүлэг минь

Гурий гурий гурий

Хоёр. ТАХИЛЧ

/эссе/

Эмэг эхтэйгээ өнгөрүүлсэн цаг мөч, миний амьдралд мартагдашгүй ул мөр үлдээжээ. Буурай

ээж минь орой болгон бурхандаа мөргөж оройн дээд Очирвааньдаа залбирч итгэлийнхээ гэгээн санааг сэтгэлийнхээ зултай хамт мандааж тахил өргөн барьдаг билээ. Үнэхээр эмгэн буурал ээж минь эрихээрээ түм бум дүнчүүр маань уншиж орсон гарсан хүн болгонд ерөөл айлдаж танин мэдэхүйн оюуныг минь номоор нээсэн тахилч байжээ гэж хожим нь би боддог болсон. Өсөх наснаасаа өмөг түшиг буурал эмээгийнхээ дэргэд байж бурхны номноос нь цээжлэн унших, буяных нь өглөгөөс хамт хуваалцаж, эрдмийн аянд дөрөөлөн их хүмүүсийн оюуны чадлаас хүртэхдээ Тахилч хүний ач гавьяаг юутай ихийг одоо ч би бишрэн ухаардаг билээ. Тахилч байгаад одсон буурлынхаа буяныг бодон дөлгөөн харц шингэсэн даруухан хөргийг нь хадагаар дээдлэн орой болгон орчлонгийн хүмүүсийн сэтгэл шингээсэн судраа баринтаглан тахил дэлгэж номоо уншин мөнхийн зул мандаан Итгэл, Алтангэрэлийн дүйз, эзэн Чингис, Их Равжаа тэргүүтний алтан сургаалийг чадах чинээгээр айлдан тахилынхаа цөгцөнд идээний дээжийг өргөдөг эгэл бяцхан тахилч гэж би өөрийгөө бодно. 1980 оны сүүлчээр Хамрын хийдийн зүүн урагш хадан нөмөрт суурьшсан тохитой хэдэн өвгөчүүлийн нэг Лувсандорж гуай:

-Ээ Түдэв шиг тахилч, тахилч дотроос Түдэв шиг уужим сэтгэж ухаалаг боддог хүн ч од шиг гэж хэлсэн нь одоо ч миний сэтгэлд одонгоо зүүгээгүй танил өвгөд шиг дотно. Түдэв гуай тахилч гэдэг алдрыг илээр биш ч эчнээ залган авч, Их Равжаадаа эгэл говийнхондоо эрдэм билэгт ард түмэндээ эрдэнэ нууцалсан эх орондоо их өвийг үлдээж хадгалж иржээ. Орой болгон оройн дээд бурхан, оргилын дээд Равжаадаа мөргөн залбирч, зул өргөн, зузаан баринтагт судраасаа адис аван найман тахилаа сэргээж, нандин идээгээр тахин шүтдэг байсан буй заа. Энэ нь харин ил биш нууц байлаа. Ороо бусгаа цагт орчлонд ганцхан л үнэнч санаа өвөрлөн Равжаагийнхаа сан хөмрөг, аравнайлуулж амилуулсан бурхан, бичиг сэлт, бийр янтай, эх бичиг, элдэв судар, уран зураг уянга дууг илүү гэр энд тэндхийн овоо товцог толгод, гуу жалга эрдэнэ нуугддаг эхгазар, хавцал цохио хадан агуйд хаа л бол цагаан сэтгэлээр цаана наана нь далдлан нууж, алтан амиараа дэнчин тавьж, асарч тэтгэж ирсэн нь үнэхээр Түдэв гуайн үүрдийн гавьяа энэ бөлгөө.

Шүтдэг бурхан нь далд, шүлэг найраг нь далд Их Равжаа ч далд эд агуурс цөм нууц байлаа.

Хэрэв тэр үед хэн бугай ч түүнийг сурвалжилсан бол бүх юм далдын далд байх байсан. Цагийн салхи эргэж, цагаан зам татуулж, далд юм ил гарч, дарагдсан юм ил гарсан энэ үед Түдэв гуай л харин алга. Түүний алдар нь түүхийн хуудсанд дурайж байна. Ард түмэн нь Равжааг хайрладаг агуу ухаанаараа Түдэв гуайг шүтэн биширнэ. Соёлын гавьяат зүтгэлтэн цол нэхэн шагнах юмсан гэсэн нутгийн зохиолчийн үг ч түмний хайр, түүний гавьяаг давтан илтгэх мэт. Алдараараа мөнхөлсөн тахилчийгаа 3.Алтангэрэл хүү ёс төртэй залгажээ. Их хутагтын үзмэрт орж эгэл сүмд нь сүсэглэн суухдаа аялгуу найргаа тахил болгон өргөн ариун журамт тахилчиддаа хүндэтгэн адис авдаг билээ.

Ом сайн амгалан болтугай

ӨВӨӨ МИНЬ

/бодрол эссе/

Ачлал ерөөл буян төгс өвөөгийнхөө хөргөөс адис авлаа...

Өвөө минь залуу зандан насандаа агтны дөрөөнд дарцаглан давхиж ардаг догшин агтаа номхруулдаг айл айлын хүмүүст хүндлэгдсэн ачлалт хүмүүсийн нэг байлаа. Өвөөгөөс минь шимийн архи монгол ухаан хоёр ханхална. Орох гарах болгондоо суралцаж орсон гарсан бүхнийг цай хоол их ухаанаараа дайлна. Өвөөгийн харцыг би аль багаасаа уншиж сурсан. Нүд нь гялалзаж сүр ихтэй хөдөлгөөнтэй байвал ширүүн байгаагийн шинж. Харин нүд нь тогтуун зөөлөн уян, хат суусан сэтгэл нь тавиун байвал тайван байгаагийн илрэл. Өвөө минь далай түмэнтэйгээ бужигнаж инээж баясч уярч, уурлаж, хөөрч хөгжиж, гуныж гутарч, дэвэрч дэгжиж явсаар далан гурван насыг зооглож билээ. Нэг өдөр өвөө минь биднийгээ орхин бурхны оронд сайн төрөл олохоор одсон. Өвөөг тэнгэрт хальсан тэр өдөр нартай байсан ч бүрэнхий харанхуй маань хэлж, мянган зул асаасан ч сэтгэлд харанхуй. Харанхуйн дотроос ганцхан гэрэлтэй юм өвөөгийн минь татуулсан гэгээн дүр байлаа. Өвөө минь баруун өвдөгнөөс чинь адис аван үе залгамжилсан ач чинь таныхаа гавьяа хөрөг хоёрт сөгдөн мөргөө. Өвөө та бидэндээ амьдаас амьд Хүү С. Лхамхүү уран уншиж олны хүртээл болгосон

НУТАГ СЭТГЭЛ

Бидний хэдэн хүмүүс Хөвсгөл нутгаасаа ирсэн хүмүүсийг үдэж өгөхөөр Тээврийн товчоон дээр уулзав. Нутгийн өнгө үнэртэй хүмүүс үнэхээр цоглог. Хамрын хийд ороод, илч аваад явж байгаа болохоор бүр ч цовоо. Нутаг түшин ирсэн машинтай, явган хүмүүс бүгд цугларсан байлаа. Биднийг баяртай гээд хөдлөн явах зуур хойноос ирнэ үү гэж урилаа. Бензин бага ч сэтгэлээ хөглөж, тэднийг дагаж 22-товчоо өнгөрөөн тэнд дахин уулзлаа. Хориод жил очоогүй нутгаа нүдээрээ халиаж, хүмүүстэй нь сэтгэлээрээ дахин учирлаа. Яг энэ үед Урд, Хойт хуурай, Тэмээн хүзүүвч, Жаргалантын бууз зэрэг төрсөн нутаг минь нүдний минь өмнө жирэлзэн тусч тунгалаг сайхан Нүхтийн голын дөлгөөн урсгал уярлын нулимсыг минь урсгалаараа угаах шиг санагдлаа. Аль алиндаа соронзон шиг татагдсан алтан нутгийнхан сэтгэлээ дэвсэж, сайхан сэтгэл, гэгээн итгэлээр нутаг гэсэн том алдрын дор түр саатан нутгийн дуу шүлгэнд уяран уусан хөгжилдлөө. Буцах замдаа нутгаараа бахархсан бидний сэтгэл өндөр, машин хөнгөн, нутагтаа очоод буцаж буй шиг баярлацгааж явлаа.

Нутаг сэтгэл ээ гэж.

НУЛИМСАН ДЭЭР ДЭЛБЭЭЛЭЭГҮЙ ЦЭЦЭГ

Нэгэн газрын нягтлан бодогч Даш сургууль төгсөөд нутагтаа ирснээс хойш таньдаг бүхэн нь “За гэрлэх гэж байна уу” гэж асуудаг байлаа. Харин Даш энэ жилээс хөл хөдөлгөөн нь нэмэгдээд нэг л биш. Дашийг хүмүүсийн ихэнх нь сайн залуу, ажилсаг, нөхөрсөг гэх бөгөөд хааяа зарим нь зөрүүд, гэжүүд, их зантай, бүр муу хэлвэл нэг нь биеэ тоосон гэдэг байлаа. Дашийн ажлын газрынхан түүнд мэргэжилдээ чадварлаг хүнд тустай шийдэмгий гээд ам сайтай. Мань хүн эхнэр авахын талаар бодовч нэг л сэтгэлд таарахаар аятайхан бүсгүй олдохгүй байлаа. Дашийн ажилынхан Эмнэлэгийнхэнтэй хамтарч үдэшлэг зохион байгуулах болов. Үдэшлэг зохиох гэж хоёр газрын аль авьяастай залуучууд нэг орой цугларлаа. Тэр дунд үдэшлэг хөтлөхөөр бэлтгэж байгаа туранхайвтар гялалзсан хөдөлгөөнтэй голдуу тод өнгийн хувцас өмсөж явдаг Оюун гэгч бүсгүй их л сэргэлэн цовоо, ухаалаг харагдана. Үдэшлэг явагдаж дуусах орой Даш зориглон:

-Би чамайг дөхүүлж өгөхүү гэвэл

-Тэгвэл хамт явъя гэж уриалгахан хэллээ.

Энэ өдрөөс хойш дахиад уулзахгүй юм шиг нэг л эвгүй санагдаж гэрийнх нь гадаэ нилээн зогсож ярилцав. Оюун:

-Чи хэрэг гарвал эмнэлэг дээгүүр очоорой л доо. Би шүдний кабинетэд ажилдаг юм оройны үдэшлэгийг би ямар хөтлөв?

Даш:

-Хөтлөгч гэдэг чинь үдэшлэгийг өөд нь татдаг ганц хүн шүү дээ. Үдэшлэг маш сайхан боллоо

Оюун эх эцэг 2 дүүтэйгээ амьдардаг. Ах эгч нар нь хотод байдаг. Өөрөө эмчийн ажил хийдэг гэдгийг мэдэв.

Даш өөрийгөө танилцуулж нилээн яриад буцах замдаа нэг л азтай сэтгэл хөөрүү харилаа. Үүнээс хойш тэр хоёр үерхсээр байвч амьдралын тухай ярихгүй л байлаа.

Нэгэн өдөр Оюун өндөр залуутай сугадалцан өөрийнх нь урд явж байлаа. Даш сэмхэн дагав. Оюун нөгөө залуутай нэг л их дотно ярилцаад л явсаар тэдний гэрт ороод явчихлаа. Нилээд хүлээсэн боловч гарч ирсэнгүй. Шөнө аль хэдийн болж хаврын тэнгэрийн олон ааш хөдлөх шинжтэй болсон тул аргагүй буцав. Дашийн хармын сэтгэл буцалж өөрийгөө зүхэн буруутган аль хэдийн л амьдрах тухайгаа хэлэхгүй яавдаа гэж бодож үзсэнээ, ер нь гарч ирэхгүй байгаа юм чинь энэ нөхөр нь болчихсон юмуу гэж өөрийгөө зовооно. “Тоглоомоор нөхөр чинь надтай явахаар хардах биз” гэхэд Оюун тас тас хийтэл инээж хайртай хүнтэй бол хардуулахсан гэж байсан юмдаа. Одоогийн айхавтар хүүхнүүдийн нэг юм боловуу гэж бодлоо.

Ажлынхаа газрын Доржийнд маргааш орой нь нь очиж уулзлла

-Нөгөөх чинь нэг залуутай их дотно явж байгаад гэртээ ороод шөнө болтол гарч ирсэнгүй

Дорж:

-Хэн бэ? Тэр хамт явж байсан хүн нь Даш:

-Мэдэхгүй манай энд үзэгдзггүй залуу нөгөө Оюун чинь бүр сугадчихсан лут явна лээ.

Дорж:

-Оюун ч жаахан хурц зантай боловч ухаантай хүүхэн харагдсан даа. Би маргааш уулзах уу?

Даш:

-Үгүй үгүй Би түүнд чинь хайртай гэж хэлж чадаагүй л яваа шүү дээ Дож:

-Өдий болтол та хоёр чинь уулзаж учраад л байсан юугаа хийж байсан юм бэ?

Даш:

-Би жаахан хаширлаад л байсан юм тэгэж байж л алдчихваа даа.

Гэтэл томилолтоор хөдөө явах ажил гарч хэд хоног яваад ирлээ. Ирсэнийхээ орой тэдний гадуур эргэлдсэн боловч уулзаж чадсангүй. Маргааш нь эмнэлэг орж шүдээ эмчилүүлэхээр ажил дээрээсээ чөлөө авч явлаа. Эмнэлэг цөөхөн хүнтэй байлаа. Үнэн худлын хооронд шүдээ дарсаар шагайвал Оюун сууж байв.

Оюун:

-За сайн байна уу? Шүд чинь өвдөө юу?

-Сайн гэж хэлсэнээ гараа хацарнаасаа авлаа Оюун:

-Алив суу шүдийг чинь үзье гэв.

Суудал дээр гэдрэг харууланүзэж шүдийг нь ломбодох зуур Оюун:

-Танайхан сайн уу? Чи бүр үзэгдэхээ байчихсан байсан шүд чинь л нэг нааш нь авчираа шивдээ гэх мэтээр ярихад. Даш “ Энэ намайг сэмхэн харуулддаг байхнээ” гэж бодон баярлах сэтгэл төрсөн боловч Даш:

-Таныг найз залуутайгаа байхад цочоочих байлгүй гэж бодоод гэхэд

-Юун найз залуу? гэж Оюун нүдээ том болгов

Даш:

-Яагаав түрүүчийн пүрэв гаригт чи нэг өндөр танихгүй залуутай хамт явсаар гэртээ ороод л гарч ирэхгүй. Би гадаа чинь зогссоор өглөө болгосон гэж дэгсдүүлбэл Оюун:

-Аа тэр чинь миний дээд талын ах. Хотоос ирсэн байхгүй юу гэхэд Даш шүдний багажтай гарыг нь хуу татаад –Ёох яасан их шаналваа гэхэд Оюун:

-Юу? Юунд шаналаа вэ гэв Даш:

-Тэгэлгүй яах вэ дээ. Би чамд маш их хайртай юм чинь чамайг өөр хүнтэй явахаар шаналахгүй юу гэж пал хийтэл хичнээн хоног хэлж чадаагүй зүйлээ хэлэв.

Оюун юм хэлэлгүй нүүр нь улайчихаад багажаа авч шүдийг гүйцээж эмчилж дуусгав.

Тэгсэнээ Оюун:

-За боллоо 2 цаг юм идэхгүй шүү гэв. -Энэ үгийг бараг бүтэн жил хүлээлээ шүү дээ гэлээ. Даш оргилсон их хайраа дарж ядан өрөөнөөс гарав. Тэр өдөр ажил маш урагштай байв. Орой нь

Доржийнд очиж баяртай мэдээ дуулгаад харив. Тэр жилийн намар тийш Даш Оюун хоёр гэрлэж Оюуны ээж аавтай цуг амьдардаг боллоо. Хойтон хавар нь хүү төрлөө, хүүдээ Гал-Бадрах гэж нэр өглөө. Оюунтай нэг гэрт амьдарч эхэлснээс хойш Дашийн сэтгэлд нэгэн зүйл эвгүй байв.

Найз нөхөдтэйгөө хамт явах, гэртээ авчирах зэрэгт Оюун дургүйцэж тэр хоёр бүр хэд хэдэн удаа муудалцлаа. Даш унаган багаас үерхдэгхааяа нэг шил юм мулталдаг найз нартаа мөн л чамгүй хайрдай тэдний хүчээр л би өдий зэрэгт яваа гэж боддог. Тэднийхэнд очиход өөрийг нь дайлж цайлж гаргадаг байлаа. Хадмындаа найз нөхдөө авчирахад Оюун муухай харан дуу шуу муутай болдог ба найзууд нь бараг үүднээс шахуу буцацгаана

Х -Х -Х

Нэг удаа томилолтоор нэг суманд очвол тэндхийн ерөнхий нягтлан бодогч Гэрлээтэй сайхантанилцлаа. Гэрэлээ нөхөрсөг эелдэг зантай тэднийд томилолтоор явсан бүх хүмүүст цай хоолууж идэж бужигнахад дургүйцсэн янзгүй тэдэнтэй бужигнана. Тэнд санхүүгийн баримт шалгахад Гэрэлээ ажилдаа хичнээн нямбай чадвартай нь тод байлаа. Ажлаа дуусган Гэрлээтэй амьдралынзовлон жаргалаа ярив. Гэрэлээ Оюун хоёрыг харьцуулж бодоход Оюун хурц муухай ааштай, нөхөрсөг биш, хартай, харамч юм шиг харин Гэрэлээ бол дөлгөөн тайван, ажилсаг, нөхөрсөгхарагдаж байв. Гэрлээгийн ухаалагзанд хэд хоног татагдаж өөрийн амьдралаа эргэцүүлж сэтгэлийндогдлолтой буцлаа. Очсоноос хойш олон захидал бичиж олон захидал хүлээн авав. Нэгэн өдөргэртээ ирвэл: Оюун хүүхдээ хараад гэртээ байдаг хүн, хүүхдээ орхиод хаашаа явдаг байна гэж бараг бүгд гайхаж гадуур сураглавал Гэрлээгийн байдаг сумын онгоцонд сууж байсан гэж сонсоод буцаж ирлээ. Оюунд Даш нэг л хөндий хүйтэн, яриа хөөрөөгүй, бодлогоширонгуй болсон нь мэдэгдээд байв. Оюун гайхавч учирьг ололгүй байсаар ажлын газрынх нь нэгэн хүүхэнтэй уулзвал Дашид захидал ирсэн чамд өгчихье гэв. Захидлыг задалбал Гэрэлээ гэдэг хүүхний захидал байлаа. Оюун угийн хурц хүн

тул шууд нисэх онгоцны буудал руу яван онгоцонд суув. Уурлах харамлах зэрэгцэвч учирьг нь олохыг хичээж байв. Онгоц газардлаа. Оюун онгоцноос бууж захиргааны нягтлан бодох Гэрэлийг асуувал тэр их цэвэрлэгээ хийж байгаа хүмүүсийн дунд байв.

Оюун:

-Сайн байна уу? Таныг Гэрэлээ гэдэг үү гэвэл Гэрэлээ:

-Сайн. Сайн байна уу? Та юу гэв гэвэл Оюун:

-Би Оюун байна. Дашийн эхнэр гэлээ Гэрэлээ:

-Аа та сайн явж ирэв үү. Та хүлээж байгаарай гэсээр дарга байрын нэг хүнд юм хэлчихээд тайвуухан алхаж ирээд

-За хоёулаа манайд очиж тухтай ярилцъя гэлээ.

Гэрт нь ирвэл орчин цагтаа тохирсон тов хийсэн айл байлаа. Өөр гадны хүнгүй тул Оюун яриагаа эхлэмээр байвч Гэрэлээгийн дөлгөөн тайвуу байдал дууны аялгууны өнгө нэг л мэдэхэд тайвшруулаад байлаа.

Шаргал цай аягалж мах чанаад Гэрэлээ

-Хүүгээ орхиод хүрээд ирсэн юмуу гэлээ.

Оюун:

-Орхиод ирсэн гэв.

Цай хоол идсэний дараа Гэрэлээ:

-За яриад байгаарай Оюун:

-Чи манай нөхөртэй явдаг болсныг чинь энэ захидлаас мэдээд онгоцонд шууд суугаад ирсэн. Ер нь гэр бүлтэй хүнийг үймүүлж байгаа чинь тусгүй л байна.

Та хоёр миний муу хүүг бодмоордоо гэж хэлээд багаран уйлахад.

Гэрэлээ:

-Танай нөхөртэй сайхан танилцсан. Та хоёрын амьдралыг би бусниулах бодолгүй байгаа. Манай суманд ирэхэд нь жаргал зовлонгоо ярилцсан юм. Оюун минь чи хүүхдийнхээ эцгийн явуулахгүй хүүхдээ өнчрүүлэхгүй л гэж бодож байгаа бол ааш араншингаа татах хэрэгтэй. Найз нөхөдтэй нь найрсаг хандаж ундтай устай эвлэг зөөлөн хандахгүй бол нэг л өдөр Даш онгоцоор нисээд ирэх байх шүү. Би Дашид хайртай ч хүний хүүхдийн нулимсан дээр цэцэг дэлбээлүүлье гэж бодоогүй. Дашаас олон захидал ирсэн.

“Ухаантай хүнээс хүн эмээдэг

Ууртай догшин хүнээс хүн эмээж хүндэлдэггүй юм”.

Чамайг дутагдлаа засаад хань ижилтэйгээ явбал би чиний хүүхдийг өнчилөхгүй.

Харин энэ хэвээр байвал би суухад бэлэн байна гэлээ. Оюун нэг зүйлийг бодож баахан уйлаад тайвширлаа. Гэрэлээ түүнд гарын бэлэг жаахан цагаан идээ боож өгөөд нэгдлийн даргын машинд дайгдуулад өдөрт нь буцаав.

Х -Х -Х

Оюун нөгөө машинаар гэрийн гадаа буугаад хөх нь чинэрсэн тул яаран гэртээ орж хүүхдээ хөхүүлэв. Эх нь ихэд үглэж Дашийн зөрүүд хөдлөн буруу харан хэвтэв.

Оюун өөрийн нууцыг мэдсэн тул өөрийнхөөрөө тэр чигтээ зөрөхөөр шийдлээ.

Гэвч Оюун шал өөр болчихоод иржээ. Өвөрт нь ормогц тэвэрч аваад уyllлаа.

Мөн өөрийнхөө бурууг хэлж уучлахыг гуйв. Даш:

-Үгүй, би Гэрэлээтэй сууна. Чи нэгэнт мэдсэн юм бол одоо бүр явахад амар боллоо гэж хэлээд унтаад өгсөн юм шмг хэвтэв.Нэг мэдэхэд өглөө боллоо. Тэр хоёр эвлэрсэнгүй харин Даш аавыгаа дуудаж авчираад Оюунаас салах болсноо хэлэв. Аав нь:

-Өөрмйнхөө амьдралыг өөрөө шийдэж сур гэж хэлчихээд яваад өгөв. Даш чемоданд хувцасаа хийж бариад гарахаар үүд чиглэв. Баруун орон дээр хадам ээж хүүг нь тэврэн сууж байлаа.

Хүүгээ үнсэхээр тонгойлоо хүү тэмүүлэн хүзүүдэн тэвэрч авав. Даш өөрийн эрхгүй хоёр нүднээсээ нулимас дуслуулан тэврэн авахад, чемоданаа газар алдсан байлаа. Гэрт байсан хүмүүс сэмхэн гарч тэр гурав үлдэв. Оюун нэг хацрын нулимсыг хүү нь нөгөө хацрын нулимсыг арчих мэт байв. Энэ л үед хүүдээ хичнээн хайртайг Оюун тэр хоёр ямар нягт холбогдсоныг мэдэрлээ.

Тэр цагаас хойш Оюун дутагдлаа засаж дөрвөн хүүтэй өнөр өтгөн аз жаргалтай айл болон арван таван жил ханиллаа. Дөрвөн хүүхдүүд өсөж том болжээ.

xxx

Оюун амралтанд амрахаар явлаа. Байгалийн үзэсгэлэн жигдэрсэн энэ амралтанд ирсэн хүнбүрийн сэтгэл татагдана. Холын амрагсдаас нэгэн хөрслөг бор 40 орчим насны хүн Оюунд нэг лдотно хандаж байгааг мэдэгдсээр байлаа. Оюунд ч бас аятайхан байлаа. Хамт тоглоно, зугаална,баяр тэмдэглэнэ, амралтын хоног хэдхэн юм шиг байсаар хоёр хоногийн дараа буцна гэж байхад байрандаа ганцаараа байвал Цэрэн орж ирээд хамт баахан сууж ярилцаж байсаар Оюуныг үнсээд авлаа. Оюун ч нөгөөдөр явах болчихоод бас ярианд нь болсон юмуу дургүйцсэнгүй.Тэд үнсэлдэнүнсэлдсээр байв. Оюун Даштай сууснаас хойш ер нь өөр хүнтэй танилцах зав байгаагүй бизээ. Сонин содон байлаа. Тэр хоёр тэр өдөр уул

дамжин арван наймт шиг л эрхлэн тоглож эрүүлчийрэг бие шүргэлцэн хэн хэнээ хүсэн мөрөөдаж хошин шог яриа мэдрэмжид нөлөөлж эрхэнтоглосоор орой байранд ирэхэд хамт байралсан бүсгүй бүжгэнд явсан байлаа. Эр хүний зоримогбодол Оюуныг энэ хорвоод ер нь ховорхон мөч боловуу гэмээр энэхэн агшин тэр хоёрыг ихэддогдлууллаа. Цэрэнгийн эвлэгхэн хөдөлгөөн хөхийг шүргэн зөөлхөн эвтэйхэн хүрэхэд өөрийнэрхгүй огцом татаж чичигнэв. Уруулыг үнсэж хүзүү мөрийг мөөмийг үнсэн доошилсоор байхавай. Хувцаснууд нэг л мэдэхэд мултарсаар хуял тачаал газар овон түрсээр хундан цагаан биехөнжил дотор хөлбөрсөөр хурмастын хур аянга шиг асгаран буух мөч хүлээн догдлоход Цэрэнбие сул тавин удах тусмаа гоё шүү дээ гэв.Цэрэн:

-Би чамд дасчихлаа. Би чамруу очно шүү гэж хэлээд хурууны үзүүрээр гижиг ирвэгнүүлэн хүсэлт агшиныг хүлээн байна нэг л агшинд жаргал мансуурав.

Амралтаар ирэгсэд буцахын урд орой Цэрэн Оюун хоёр салж чадахгүй шахам байлаа. Балын амт авсан зөгий дахин дахин эргэлдэх шиг Цэрэн Оюуныг даган даган эргэлдэв. Оюун Цэрэнг

Даштай зэрэгцүүлэн бодож эхэллээ. Цэрэн Даш шиг зөрүүд биш, тунимхай биш эмэгтэй хүнд үнэн сэтгэлээсээ ханддаг, соёлч боловсон, нарийн нандин харьцаатай, ухаалаг яриатай, ажилсаг байрын энэ хүнд Оюун өөрийн эрхгүй татагдаж байлаа. Цэрэнгийн сэтгэлд Оюун татагдаж байвч өнө багаас ханилсан ханиас илүү гарахгүй л байлаа. Хүний хань гэдэг өвдөх зовох хорвоогийн хамгийн хэцүү үед түшиг болон үлддэг, хүний хос жигүүрийн нэгэн гэдгийг мэддэг. Мөн 3 хүүхдийг минь төрүүлж өгсөн, хорвоод өөрийг нь мөнхлөн үлдээсэн өрх гэрийн наран ээжийг гомдоох сэтгэл байсангүй. Оюун Цэрэн хоёр Улаанбаатарт ирсэн хойноо ч уулзаж байлаа. Оюун нутаг буцлаа. Цэрэн хоёрч удаа томилолт, чөлөө аван очлоо. Оюуныг амралтанд яваад ирснээс хойш Дашид хэн ч хэлээгүй боловч нэгэн мэдрэмж бууж байв. Оюун өөрийгөө их гоёод дуу аялаад гэр орондоо тогтохоо больсон бөгөөд хааяа архи үнэртүүлэн ирж байх шиг хоёр ч шөнө гэртээ ирж хоносонгүй байтал Даш мэргэжил дээшлүүлэн курсэд Улаанбаатар явав. Даш сэтгэлдээ маш их зовиуртай явсан боловч Оюунд юу ч хэлсэнгүй. Юуч гэж хэлэхээ мэдэхгүй байлаа.

Цэрэнг хоёр ч удаа ирсэнийг мэдсэн Даш Улаанбаатарт ирээд Баянгол зочид буудалд байрлажээ.

Буудлын нил хивс дэвссэн гудамгаар 12 давхарт буудаллаж маш тохилог байв. Ирсээр хэдэн долоо хоног өнгөрсөн ч бүтэн хагас сайн өдрөөр явахгүй байлаа. Нэгэн амралтын өдөр нэг бүсгүйтэй танилцсаныг Бурмаа гэх бөгөөд тэр холын аймгаас мөн курсэд ирсэн байж. Тэр хоёр амралтынхаа өдрийг хамт өнгөрөөхдөө их зүйлийг ярилаа. Тэр бүсгүй ухаалаг, амьдралын наад захыг мэддэг хүн байлаа. Хоёр биендээ амьдралаа ярив.

Бурмаа:

-Хүн хорвоод нэг л удаа амьдарна. Амьдрахдаа чамаас илүү сайн хүнтэй уулзсан ч байж мэднэ.

Оюуны цааш тэмүүлдэг нь зөвөө, чиний зөрүүд гэжүүд тунимхай зан л түүнийг цааш түлхэж

хүний энгэр өнгийхөөр болгосон байна. Чи чинь дөрвөн хүүхдийн эцэг энэ үед чи уурлаж, агсан согтуу тавих юмуу, зөрөөд буруу хараад хэвтээд байвал чи улам л муухай харагдана шүү дээ.

Харин хамгийн энхрий ялдам зан гаргаж түүний алдааг ойлгуулах хэрэгтэй. Бүсгүй хүн чинь уяхан шүү дээ гэх зэргээр Дашид олон зүйл ярьсан нь Дашын нүдийг нээжээ. Даш курсээ төгсөөд гэртээ ирэв.

Цэрэн хэд хэдэн удаа ирснийг найз Дорж нь хэлээд асуудлыг уураар биш ухаанаар зохицуулахыг зөвлөв. Ирсэний орой Оюун бууз хийж, цай чанаад нэг л аргачилангүй байхыг хараад би ч гэсэн алдах үедээ алдсан шүү дээ гэдэг бодол буувч мөн л буруу харан газраар тусдаа хэвтэв. Энэ нь

Оюунд хүнд байв.

Цэрэн хэлэхдээ

-Би чамд хичнээн хайртай ч гурван хүүхдийн минь эх, насны ханиа яалтай билээ. Тавь, жар хүрэхээр үүнээс болоод л юу ч үзээгүй шүү гэж чи минь надад гомдож харамсах вий дээ гэж хэлсэн хүн миний хорин жилийн цаадахыг харан хайрлаж байхад би түүнийг хаяад чамтай сууна гэж хэлэх зүрх надад алга гэж хэлсэнийг Оюун тод санаж байлаа. Дашид тэр Цэрэнгийн амьдрах ухаан хорвоогоос заяасангүй дээ гэж бодсоор орондоо ороход хүйтэн хөнжил бие хайрав.

Даш буруу харан хэвтэхэд Бурмаа бүсгүйн хэлсэн олон зүйл чихэнд нь хангинах шиг болж байлаа.

Бурмаа ухаантай л хүүхэн байсан даа.

-Паа яанаа би лав өвгөнөөрөө л аргадуулдаг. Чи ямар муухай зөрүүд амьтан бэ гэж тас тас инээсэн нь бодогдмогц босоод Оюуны өвөрт орвол Оюун цааш болон дуртайн аргагүй хэвтлээ.

Оюун:

-Энийг ингэж зөрөөд л байвал аргадахгүй салвал сална л биз гэж бодож байлаа гэтэл Даш:

-Чи бид хоёр эх эцэг, эхнэр нөхөр болсоор хориод жил боллоо. Чи надад дөрвөн сайхан хүү хайрлалаа. Чи надаас нэг л хөндий болжээ. Уйдаад байгаа юмуу, би хөгширөөд чамд гологдоод байгаа юмуу? Эсвэл чи минь хөнгөмсөг болсон юмуу. Чамайг тэр Улаанбаатарын залуутай яваад байгааг би мэдэж л байгаа гэхдээ миний найз бид хоёр үр хүүхдээ бодох ёстой. Тээр жил би чамаас уучлал гуйх ёстой байсан боловч одоо бол би чамайг уучиллаа. Би ер нь чамд хичнээн хайртайгаа чамдаа хэлж амждаггүй л юм байна лээ. Олон жил үерхсэн үерхлээч бодсон, алаг үрээ ч бодсон ч би чамайг уучилах ёстой гэж хэлээд, хайрын халуун илч төөнөн энхрийлэхэд

Оюун:

-Уучлах эсэхээ өөрөө л мэддээ миний нөхөрлөсөн хүн муу хүн бишээ гэхдээ чамайг зөрүүд муйхар зантай болохоор миний хийсэн буруу зүйлийг уучилна гэж би зүүдэлсэнгүй зөвхөн надаас салах байх л гэж бодож байсан. Чи намайг уучилбал би сална гэхгүй сайн муу ч миний хүүхдүүдийн эцэг, энэ айлын ноён нуруу гэж ярив.

Энэ шөнө тэр хоёрт харавсан сум шиг өнөөдөр суусан арван наймт шиг л өнгөржээ.

Өглөөгүүр Оюун :

-Чамд энэ бүхнийг хэн зааж өгсөн бэ? гэж асуув Даш:

-Намайг өөрийн гэсэн толгойгүй хүн гэж бодож байжээ гэж бодоод инээд нь хүрэвч Бурмаагийн тухай ярив.

-Ухаалаг бүсгүйтэй учиржээ гэж санаа алдав.

Бурмаа Дашийн сэтгэлээс гарахгүй л байв. Нүдийг минь нээж өгсөн бүсгүйг баярлуулмаар байлаа.

Танилцаж эхэлсэн хэдхэн хоногт түүний хэлсэн үг бүр ямар ухаантай юм бэ гэж бодогдсоор.

Хааяа утсаар ярьдаг боловч очихоор шийдэв. Оюунд үнэнээ хэллээ Оюун тор дүүрэн хүнс цуглуулж бэлдэж өглөө.

Улаанбаатар явж Бурмаатай уулзаж Оюуны өгүүлсэн юмыг өгөөд хүсэл мөрөөдөл шүтэн биширж бүхнээ ярихад Бурмаа

-Та хоёр л эвтэй найртай байвал боллоо. Чамайг эргэж ирнэ гэж бодоогүй шүү гэснээ би бал сайн хань ижилтэй хүн: Хүн хүндээ сайн санаж явах шиг сайхан зүйл хаана байх билээ гэв.

Сайнтай нөхөрлөвөл сарны гэрэл

Муутай нөхөрлөвөл могойн хорлол

Урам хайрлах үг

Ухаан нэмэх үг

Ухаарч амьдардаг хорвоо

Уужим өнгөрдөг нас

УРВАГЧ

Хан улсын их жанжин барын шүдэт Тянь Шунийн үнэнч цэрэг У-ди Хүннү цэргийн зургаан эвэрт жанжин вангийн гэр тэргийг эзэлж эмс янжинг нь олзлох шуналдаа улайран замд таарах дайчдыг тариа хадах адил тасчин цавчиж давшина. Энэ үед хүннүгийн дорд гаралт хөвгүүн

Гоудан тарианы вааран сав хураасаны дунд амь хорогдон нуугдаж, Хан улсын шаламгай цэрэг хэрхэн хүннү цэргүүдийг цавчин буйг харан чичрэн зогсоно. Сав саальны завсраар харагдах тулаан заримдаа халхлагдан далд орох үед вааран дээрх хөөцөлдүүр хээ нүдэнд нь тулна.

Тэгснээ цэргүүдийн тулаан хөөцөлдүүр хээнүүд залгагдан нэгэн хүчирхэг хээ угалз болон эрчлэн хуйларч айдас нь арилж цус нь хөөрөөд ирлээ. Гэвч угийн хашир болгоомжтой зангаар огцом төрсөн омог зоригоо дарж арга ухаан сүвэгчлэн бодохуйд нүдэнд нь бүдүүн сураар холбосон хүнд төмөр дөрөө харагдахуйд багаас сурсан дүүгүүрийн эрдмээ гаргах сайхан санаа төрж тулааны зүг хараачиллахуйд хан улсын цэрэг У-ди цааш харан алхаж тэргэн гэрт ойрхон очисоныг мөн хамгаалах хүннү цэрэг байхгүй болж Хан цэрэг У-ди тайванаар гэр өөд алхаж буйг ажин тэрхүү агшинд дөрөөг шүүрэн авч дүүгүүрдлээ. Дүүгүүр У-дигийг яг ар дагзанд нь тусч гэнэгүй алхаж байсан тэрбээр гэдрэг саван унаж ухаан балартлаа. У-ди нүдээ нээхүйд уйлаан майлаан болсон хүн малын дуу, утаа май болсон бүрэнхий үдшийн тэнгэр зэргээр ухаан балартаад хэр удаан хэвтсэнээ баримжаалах гэж оролдоно. Өндийх төдийд дагзнаас нь янгинах өвчнөө үл тоон ухасхийн босч илдээ шүүрэн авлаа. Гэвч би чинь аль талын цэрэг билээ гэсэн эргэлзээнд хүлэгдэн зог туслаа.

Зургаан эвэрт вангын гэрийг хамгаалж байлуу, олзолж байлуу гэж бодон зогстол нэгэн хан цэрэг өөдөөс нь тэргэн гэр өөд яаран гүйж ирэхэд сандарсандаа цавчиж орхилоо. Гэтэл цаанас нь өдий төдий хан цэргүүд нэмэгдэн ирж тулалдаж бараг арваад цэргийг цааш харуулан ч шархадсан гар хөл нь өөрийн мэдэлгүй тэрэг түшүүлэн суун тусууллаа. Харин мөнөөх тэргэн гэрийг хар халзан морьтой хүннү цэргүүд хашаалан хамгаалсаар алсалж байгаа нь харагдаад урвагч У-ди г барь гэх нь бүдэг бадаг сонсогдоод харанхуйллаа. У-ди гийн ухаан сэргэвч нүдээ нээх гэж яарсангүй. Тэр хүннүүгээс олзолсон тэргэн дээр нэгэнт хүлээтэй яваа бололтой хус модны хяхтнаан сонсогдож үхрийн баас ханхална. Одоо яарах зүйлгүй тул бодол санаагаа сэргээн өөрийгөө хэн болох тухай эрэлд аялана. У-ди миний эцэг Хан улсын Лянь уулын шар замын худалдаачин байж билээ. Тариа тарих, худалдаа хийх бүхий ажилд нь тусалж чадахуйц болсон хойно минь Хүннү хүмүүстэй худалдаа хийсэн гэж муу аавын минь цаазалж олон ч найз нар нь хамт хэлмэгдсэн дээ. Тэгтэл бас тэнгэр ууланд ан гөрөөс хөөцөлдөн ах нарыгаа даган нум сум агсан алаг үрээ зайдлан давхиж явсан нь санаанд тодоос тод дурайна. .. ужиг хүний сүнс шингээгүй байгаа даа энэ чинь Хүннүү аав минь тэнгэр ууланд хил хариуцсан “Оуто” байсан хүн Чэши жанжинд хороогдсон гэж ярьцгаадагсан. Олзлогдсон хүннүүчүүд зөөлөн шивнэлдэж Хан цэргүүд хашихчан ярилцаж хөсөг зогслоо. Нилээд удсан хойнонүүрэн дээр нь хүйтэн усаар цочмог цацахад өөрийн мэдэлгүй нүдээ нээж тэнгэрийн ширтлээ. Түүний дээрээс төмөр дуулга нь нарны гэрэлд гялалзсан барын шүдэт жанжин заналтайгаар ширтэн Урвагч У-ди дайны талбарт дайсанд

урваж, дайсны толгойлогчдыг зугтаалган өөрийн талын олон зуун цэргийн амийг хөнөөж, өөрийн талыг ялагдалд дуудсан урьд өмнө байгаагүй хүнд гэмт хэрэг үйлдсэн тул цаазаар авсугай гэхэд жанжны дуулганы оронд урт илдний ир гялбалзан харагдлаа. Яг энэ үед хүн амьтад дунд шуугиан болж дайснууд дайрч байгаа бололтой уухай сонсогдоно.

...У-ди би Хан улсын цэрэг байжээ. Харин Хүннүгийн амьдрал минь урьд нас уу, хойд нас уу хэмээн гэгээнээр бодохуйд нүднээ зүйрлэшгүй их гэгээ татлаа.

ТӨСӨЛ

Бөглүү тосгоны хуучин муу модон саравчинд гурван хөвгүүн нэгэн охины тухай ярилцана. Тэдний яриагаар тэр охин үг хэл муутай учир битүүлэг бөгөөд сонирхол татахуйц нэгэн увидастай гэнэ. Харин ямар нууц чанар байгааг өөрсдөө хэлж тодорхойлж чадахгүй учир зүгээр л үзсэн харсан тохиолдлуудаа ярилцана. Тэр охин гажиг биетэй царай муутай, муухай ааштай, сургуульд явдаггүй хэнтэй ч найзалдаггүй гэртээ хэдүүлээ байдгийг нь хэн ч мэддэггүй гэнэ. Ойн захын нэгэн хашаанд буй жижигхэн байшинд ороод явчихдаг бөгөөд дагаж орьё гэвэл маш хэрцгий догшин хоёр нохойд уруулах хэрэгтэй болно. Үлгэрт гардаг охин ч юм шиг нэг л нууцлаг. Гэхдээ тэр худгаас ус авна дэлгүүрээс хүнс аваад явах нь бас харагдана. Гэвч тэр охиныйг яагаад ч юм тэднээс өөр хэн ч үл анзаарахгүй байсан тэр үед ийм явдал болсон юм. Нэг удаа олны дунд явж байхад нь хөвгүүдийн нэг нь хараад мэл гайхлаа. Тэр давхар биетэй болсон байх төдийгүй нилээд том гэдэстэй хэзээ хэзээгүй төрөх дөхсөн шинжтэй гэсэн ч бас л гайхал төрүүлсэн зүйл нь харц дээгүүр ичиж нэрэлхэх зүйлгүйгээр алхахдаа хоёр гуравхан хоногийн өмнө зүгээр л нэг охин байгаагүй юм шиг явж байгаад л байлаа. Хүү нөгөө хоёртоо дуулгахаар яаран гүйлээ. Үүнээс хэд хоногийн дараа тосгон даяар сонирхолтой зүйлсээр дүүрч эхэллээ. Сонирхолтой нь нөгөө охин хүүтэй болсон бөгөөд тэр хүүхэд нь ёстой жинхэнэ үлгэрийн гэмээр хүүхэд гэнэ. Төрөхдөө маш жижигхэн төрсөн ч маш хурдан өсч ердөө долоо хоногт л ярьж явж чаддаг болсон байлаа. Ингээд энэ тосгонд гадна дотны маш олон сэтгүүлч сурвалжлагч, эрдэмтэн мэргэд цуглан тэднийг даган маш олон шинэ үйлчилгээ, үйл ажиллагаа нэмэгдэж хэдхэн хоногын дотор өнөөх жижиг тосгон чинь нэгэн шинэ хот болон хөгжиж эхэллээ. Тосгоныхон энэ сонирхолтой өөрчлөлтийг харан ямар нэгэн илбэ шидийн хүчэнд автагдсан мэт алмайран гайхацгааж байлаа. Зурагт, радио сонин сэтгүүл болгон дээр энэ тосгон болон сонирхолтой хүүгийн тухай материалууд хөврөнө. Янз бүрийн түвшинд янз бүрийн мэргэжлийн хүмүүсийн таамаг ярилцлага, цаг тутум өсөх хүүгийн шинэ шинэ эрдэмүүд, биеийнх нь жин, өндөрийн хэмжээ, хэлсэн үгийг нь нийтлэнэ. Хүү нэг сарын дараа гэхэд 16 настай хүүхдийн хэмжээний бие хаа, оюун ухааны гайхалтай дээд түвшинд хөгжсөн нь янз бүрийн таамгийг тайлсан дүгнэлтүүд гарч ирэх цагт тулж ирсэнийг мэдэгдэж байлаа. Ийнхүү бүх шатны холбогдох байгууллагуудын томоохон эрх баригчид дуу нэгтэйгээр хүн төрөлхтнийг шүүхээр ирсэн бурхны элч гэдгийг баталцгаана. Бурхны элч өнгөрсөн олон мянган жилд тахиолдсон нүгэл хилэнц гай барцдыг он сар алдалгүй тоочин дэнсэлж эхэллээ. Мөн хүмүүсийн дунд сайн мэдэхгүй түүхэн баримтуудыг сөхөн сургаалаа айлдан тэдгээр баримтууд, сургаалыг цэгцлэх шинэ албадууд үүсч Шинэ бурханы маш том сан дэлхий даяар тархаж Хүмүүнлэг буяны байгууллагууд үйл ажиллагаагаа шинэ бурханы сургаалыг номлон зохион байгуулж эхэллээ. Шинэ бурхан хэзээ хэрхэн буцах тухай он, сар, өдөр, цаг минуттай нь хэлж хүмүүсийг гэм нүгэлээ наминчлах боломжыг аль болох ихээр олгож байлаа. Шинэ бурханы сургаалууд дэлхий даяар олон боть ном болон хэвлэгдэж түүний сургаалийг дагагсад дэлхийн хүн төрөлхтний ихэнх хувийг эзэлж Бүхий л шашны төлөөллүүд өөрсдийн эзэн бурханы эргэн ирсэн дүр гэж баталцгааж байгаа нь сургаалийг нь дагах үндэс болж байлаа. Шинэ бурхан товолсон хугацаандаа буцаж хүн төрөлхтөн ирээдүйнхээ тухай шинэ төсөөлөлтэй үлдлээ. Энэ үед “Шинэ бурхан-1” төсөлийн багийнхан төрөл бүрийн салбарын эрдэмтдээ цуглуулан тайлан хурлаа маш нууц байдалд эхэлж байлаа.

ХУЛГАЙЧ

Жижиг хулгайч вагоноос нь

Том хулгайч вагоноор нь ...

Тэртээ 1990 оны цагаан морин жилийн ардчилсан хувьсгалын үр дүнд гарсан өөрчлөлт Монголчууд бидэнд их зүйлийг авчирсан гэж магтан дуулах хүн цөөнгүй. Тэдгээр олон зүйлс их

үнээр олдсон. Монгол Улсын Их Хурлын гишүүн, хуульч Хишигдэмбэрэлийн Тэмүүжиний “ҮГС...” хэмээх бүтээлд “Монголчууд бидний хувьд 1990 оноос ардчилал руу тэмүүлэн, хуучинулс төрийн тогтолцоо, түүний сэтгэлгээний хэв маягийг өөрчлөх гэж тэмцэхдээ бид өнөөгийнхшиг өөрсдийгөө дархалчихсан, эрх дархтнуудын шинэ ангийг бий болгох ийм зорилго тавиагүй” хэмээн харуусан бичсэнийг уншиж суугаад өөрийн амьдрал руу эргэн нэг өнгийлөө. Зах зээлийн эдийн засагтай ардчилсан нийгэмд шилжихээр зорилт тавьсан монголын амьдралтүшмэд нь сэлгүүцэж, төр нь эзгүйрсэн, эрээн рүү тэмүүлж, өдөр өнгөрөөж, амиа аргацаасанард олон, өмнөх замаа харахааргүй мананд төөрсөн аав нар архинд живж, хэтийдсэн ачаатайэхчүүд зовлонд төөрч, энэ цагаа андуурч мэндэлсэн хүүхдүүд нь гудамжинд гарч байсныг табид мартах учиргүй. Монголын төр ачаагаа үүрч чадахаа болж, бүхий л зүйлсийг хувь заяанд ньдаатгаж байхад би 10 настай вагонд тэнэж явлаа. Нүүрс хулгайлж, нүдээ дэлсүүлж, байцаагчидчичлүүлж, цагдаад зодуулж, үйлчлэгчид хөөгдөж, хоол зарж, гахай үүрч, тарвага бөөндөжнийгэмдээ гадуурхагдаж ч байх шиг.

Өлсөнө. Ядарна. Даарна. Ичнэ. Иймдээ ч би сурлага муутай болж байлаа. Өөрийнхөө нэрнээс залхдаг ч юм билээ.

Энэ үед тэнэмэл хүүхдүүд, вагоны хүүхдүүд гэсэн үг сонсогдож эхэлсэн. Энэ томъёоллоос өөрийгөө зайлуулавч эргээд харахад би тэдний нэг байжээ. Харин энэ үед гарч ирсэн нэг үг одоо санаанд орж байна.

Юу вэ гэвэл ? “Жижиг хулгайч вагоноос нь, том хулгайч вагоноор нь ..” гэсэн үг юм. Тэр үед би хулгайч вагоноос юм хулгайлахыг ойлгож байсан. Харин вагоноор нь яаж хулгайлдагийг үнэндээ ойлгож байсангүй. Би эргэцүүлж боддог байсан. Тэгээд ч ойлгоогүй. Ёстой л анаашны онигоо шиг байна уу.? Үгүй юу..? Айн.

Хожим нь олон жилийн хойно би Чингис хааны нэрэмжит “Их засаг” их сургуулийн хууль зүйн сургуулийн 3 дугаар дамжаанд суралцаж байхдаа Монгол улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал асан Доктор С.Нарангэрэлийн нээлттэй лекцэнд суух аз завшаан тохиосон юм.Тэр лекцэнд Хууль зүйн ухааны доктор С.Нарангэрэл гуай танхимд байсан хүмүүсээс “энэ танхимд өнгөрсөн амьдралдаа худлаа ярьж үзсэн хүн байвал гараа өргө” гэлээ. Ер нь цөөхөн хэдэн хүн гараа өргөлөө. Би ч тэдгээрийн дотор орж байгаа юм. Өөрөө ч өргөж байна. Дараа нь “энэ танхимд өнгөрсөн амьдралдаа “хулгай” хийж үзсэн хүн байвал

гараа өргө” гэлээ. Би ч гараа өргөөдөхлөө. С.Нарангэрэл гуай өөрөө ч өргөж байна. Хамт цөөхөн хэдэн хүн бас гараа өргөж байна шүү. Үүний дараагаар тэрээр “өнгөрсөн амьдралдаа худлаа ярьж, хулгай хийгээгүй хүн гэж нэгээхэн ч байхгүй, хамгийн наад зах нь би хүүхэд байхдаа ээж аавынхаа халааснаас задгай мөнгийг нь хаяа нэг туучихдаг л байлаа” гэж билээ.

Одоо би вагоноор нь туучихдаг нөхдийг ойлгодог болоод байгаа. Тэд нар нь эрх мэдэлтнүүдийг хэлж байж л дээ. Би Х.Тэмүүжин багшийн өгүүлсэнтэй санал нэг байна. Тэд сонгуулийн саналыг минь хулгайлж, зөвшөөрөөгүй байтал эрх мэдлийг бий болгож, түүнийгээ үе залгамжлан өөрийн юм шиг эзэмшиж, “дансны аргаар иднэ” гэдэг шиг зорчигчийг ачаа, товартай нь, чингэлэгийг зорчигч, үйлчлэгтэй нь “хулгайсан” үйлдлээ “хуулийн дагуу” нэрээр зөвтгөнө.

Би амьдрахын эрхээр нүүрс хулгайлж байсан. Түүгээрээ би хэний эрхэнд халдсан бэ? Вагоноос нь хулгайлсан нэгнийг 2-20 жил яллаж, хорвоо багтаахаа больж байхад вагоноор нь хулгайлсан нэгнийг 2-20 жил амар суулгаж, жаргааж байх юм. Энэ зөв гэж үү? Хорвоо минь...

Хүн гэдэг өмчиндөө харам байдагсан. Гэтэл бид ч гэж өөрсдийнх нь юмнаас харуулж нэг аваад, хулгайлж нэг аваад байхад “тэнэгийн дотор уужуу” гэгчээр юу ч болоогүй мэт суух. “Өөрөө өгч өгчихөөд өр нэхнэ” гэдэг шиг аль болгонд нь чимээгүй суучихаад “улс нь хөгжихгүй юм, ухаан ч суухгүй юм, муусайн хамуурсан толгойтнууд” гэх нь бас хэр зүйд нийцэх бол.?

“Хулгай хийх боломж л хулгайчийг төрүүлдэг” гэж нэг ухаант ард түмэн бас хэлээд амжчихжээ.

Нээрээ ч цоожгүй авдранд мөнгө орхичихоод наадахаа сайн хамгаалж байгаарай гээд хамаг юмаа найдаж, үлдээгээд, явж, явж ирсэн чинь нөгөө манаачаас хоосон авдар хүлээж авах нь тийм ч ойлгомжгүй зүйл биш байлтай. Ингэлээ гээд өнөөх манаачид уурлаж бухимдан, гоморхоод байх нь та бидний арчаагүйнх болж таарав уу.? Эрхэм зорчигчид оо... “Монголчууд аа”...

МОНГОЛЫН ХУУЛЬ ГУРАВ ХОНОГ

Хүмүүс хуулийг нийгмийн хууль, байгалийн хууль техникийн хууль, зах зээлийн хууль гэх мэт холбоо үгийн нэгдмэл утга, бүхий нэршлээр ангилан тодорхойлж, янз бүрээр ойлгодог.

Гэвч би энэ удаад нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй бичигдмэл болоод бичигдээгүй хуулийн талаар ярьмаар байна.

Хүн төрөлхтөн анх үүсэн бий болсон тэр цагаас хойш, өөрсдийн хоорондын харилцаан дахь олон арван асуудлыг ихэнхи тохиолдолд хамтын зарчмаар шийдвэрлэж ирсэн түүхтэй.

Хүй нэгдлийн нийгмийн үед хүмүүсийн өөр хоорондоо тэмцэлдэх тэмцэл нь ямар нэг утгат бус энгийн зүйл болон хувирав. Үүнийг дагаад аллага худал хуурмаг, муу, муухай, зүйл гаарч, хүчтэй нь хүчгүйгээ гэсэн амьдралын сөрөг зарчим үйлчилж, эмх замбараагзй байдал улам бүр хүрээгээ тэлэв. Энэ үед бурхан гэх зүйлийг хүмүүсийн ухамсарт суулгаснаар шашны номлол нийгмийн харилцааг зохицуулагч нэгэн төрлийн хууль болон төлөвшив.

Хүн төрөлхтөн хөгжиж тэрхүү хөгжиж буй нийгмийн харилцааг бүрдүүлэгч философи, соёл урлаг, улс төр, эдийн засаг шинжлэх ухаан гэх мэт салбарууд өөр хоорондоо харилцан нөхцөлдөн зэрэгцэн оршино. Гэвч дахиад л хүн төрлөхтөн энэхүү хийж, бүтээж бий болгосон гайхамшигт зүйлсийнхээ үнэлэмжийг багасгах сөрөг ухамсарыг бий болгосоор л байв. Харин энэ үед шишны номлол нийгмийн харилцааг зохицуулж чадахуйц хууль байхаа болив.

Гагцхүү тэдгээр хүн төрөлхтний бий болгосон гайхамшигт зүйлсийн үндэс нь оюун ухаан гэх сэтгэх чадварт нь байлаа. Иймд тэдний оюун санаа агуа учир нийгмийн харилцааг зохицуулагч ёс зүй хэмээх шинэ хуулийг бий болгов.

Ёс зүйн хэм хэмжээ нь хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулахдаа хэтэрхий хатуу, хэрэглэсэн тохиолдолд зөрчигдсөн эрх ашгийг сэргээх боломжгүй, тухайлбал: хэн нэгнийг гомдоосон тохиолдолд уучлалт гуйлаа ч гомдоосон үйлдэл нь арилаагүй байдаг бөгөөд гомдоох ёсгүй байсан гэсэн утга санааг илэрхийлэх ажээ. Энэ учир өнөөгийн нийгмийн харилцааг зохицуулжчадахуйц эрх зүйн хэм хэмжээг өөртөө агуулсан сонгодог хууль төлөвшин тогтох шаардлага үүсэнбий болжээ. Сонгодог гэсний учир нь хүн төрөлхтөн өнөөгийн байдлаар нийгмийн хагрилцаагтүүнээс илүү зохицуулж чадахуйц хуулийг хараахан олж амжаагүй байна.Нэгэн цагт “тэнгэрийн доор төрж, хуулийн дор амьдрана” хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Тэр үгийгтайлбарлавал хууль, хувь заяа хоёр нэгэн цэгт утгаа олж буйг өгүүлээ биз.Учир юу хэмээвээс тэртээ 13-р зуунд Чингис хаан өөрийн билэг айлдвараа бичиглэн дэвтэрлэж,улс орон, ард иргэддээ хуульчлан зарлигдваас түмэн газрыг туулсан алс хязгаар нутагт ч гуравханхоногийн дотор хүрч, бүх нийтээрээ дээдлэн хүндэтгэн дагадаг байжээ. Эндээс “Монголынхууль гурав хоног” гэсэн хэлц үүссэн бөгөөд бидний ойлгодог “Монголын хууль гурав хоноодхэрэгжихээ больдог” утга санаа биш ажээ. Энэ учир “одтой тэнгэр орчиж, олон улс байлдаж,орондоо унтах завгүй, олзлон булаалдаж байсан олон аймаг нэгдэж, оройн дээд эзнээ хүлээнзөвшөөрсний илэрхийлэл билээ. Иймдээ тэдний дэлхий дахинаа байгуулсан гавьяа түүхийналсаас тодорон үзэгдэх ул мөрөө үлдээгээ бизээ.

Их засаг хуулийн 6-р зүйлд: “Ноёд жил бүр хоёр удаа хааны ордонд цугларч, ажлаа тайлагнаж, хааны сургааль зарлигийг сонсож, буцаж хариад биеэр үлгэрлэн гүйцэтгэж, ард олноо сайтарудирдаж чадвал хамаг үйлс эерэг бүтнэ. Миний зарлагыг аман даараа дагаж, алс далд зөрчиж, уснаа унасан чулуу, өвснөө гэсэн зүү мэт хөсөрдүүлбэл нийтийг захирч үл чдна” гэж заасан нь өнөөгийн Монгол улсын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 1.2 –т заасан “Хууль дээдлэх нь төийн үйлажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасантай утга нэг юм. Гэтэл өнөөгийн нийгэмд төрийнүйл ажиллагаанд оролцогч идэвхитэй хэсэг буюу төрийн албан хаагчдын ёс зүйн болоод хуульдээдлэх ухамсрын түвшин маш доогуур байна.

Их засаг хуулийн 2-р зүйлд: “Тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг эргэлзээгүй” гэсэн бөгөөд мөн хуулийн 1-р зүйлд “Мөнх тэнгэрийн хүчин дор их монгол улсын далай хааны зарлиг ил болгониргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай” хэмээн заасан нь монгол улсын Үндсэн хуулийн 17-р зүйлийн 1.1-д “Монгол улсын иргэн шудрага хүнлэг ёсыг эрхэмлэн үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх үндсэн үүрэгтэй” болохыг тодорхойлсонтой адил юм. Энэ бүгдээс үзэхэд бид нэгэнт батлагдан гарсан хууль тогтоомжоо дээдлэн хүндэтгэхийн хамт сахин биелүүлэх ариун үүргийг хүлээсэн иргээ гэдгээ ухамсарлах ёстойг илэрхийлж байна.

Гэтэл бид даяршиж буй мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа атал хуулиа мэдэхгүй, сонсоогүй, уншаагүй гэх бөгөөд тийнхүү бардамнан хуулийг санаатайгаар зөрчин хууль мэдэхгүйгээрээ далимдуулан өөрсдийгөө өмөөрөх нь даанч хөөрхийлөлтэй.

Дээрхийг үндэслэн өөрийн зүгээс бяцхан дүгнэлт хийвэл хууль дээдлэх сэтгэлгээгээ хөгжүүлж, өөртөө хариуцлагыг хүлээх ухамсрыг төлөвшүүлж эс чадваас Монголчууд бид хүн төрөлхтөний хөгжиж буй өндөрлөгт хүрэх цаг даанч хол байна даа. Учир нь бид ядуу амьдарлынхаа шалтгааныг нийгэм рүү чихдэг, сул дорой яваагийнхаа шалтгааныг хувь тавьлан руугаа чихдэг, гэмт үйл буруу явдлаасаа болоод хууль хэрэгжихгүй байгаагийн шалтгааныг хууль руугаа чихдэг нь харамсалтай.

Иймд хүн төрөлхтний нэгээхэн хэсэг бид хэзээ ч “буруугүйн” учир аз жаргалтай өөдрөг амьдралд хүрэхгүй л болов уу хэмээн эмээнэ. Алдаагаа өөрөөсөө хайж, олж сурвал тэр л аз жаргал буюу.

БОРЖИГИНЫ ЗАРИМ ОНЦЛОГ ЗҮЙЛҮҮДИЙГ СУДЛАХУЙД

А. Боржигин гэж...

Б. Чойр гэдгийг тодруулбал...

В. Орон нутгийн түүхэн газар зүйн асуудалд...

Агуулга.

Боржигин гэж...

Ерээд оноос хойш Боржигин овог, Боржигины хошуу, Боржигины онцлогууд гэж их бичиж ярьдаг болов.Боржигин гэдэг нэртэй төрийн болон, олон нийтийн байгууллага , аж ахуйн нэгжүүд олширлоо.

Боржигин гэж дөрвөн янзаар бичиж байна

1. Боржигин

2. Боржигон

3. Боржгин

4. Боржгон

5. Уул нь Монголын нэгэн гол овог , алтан урагтны овгийн нэр гэж түүхэн сурвалжуудад дурджээ. Ер нь овог бол “Ясан төрлийн удам угсаа бүхий хүмүүсийн өвөг дээдсээс үе уламжлагдсан нэр, ярианы хэлэнд омог ч гэдэг” хэмээн монгол хэлний тайлбар толиудад \2.466,3.89,6.1135\ тодорхойлсон ажгуу. Дээрх дөрвөн хувилбарын аль нь зөв гэдгийг хэрхэн сонгох вэ? Бид 1995 онд “Говьсүмбэр аймгийн танилцуулга” хэмээх товхимолд \ ред Н. Насан- Очир\А хувилбарыг сонгосон. Учир нь:

1. Шаргуудай овогт Шанжмятавыг Гаадамба абухайн худам бичгээс ийн галигласан.\13.?\

2. Өмнө өгүүлсэн толиудын зөвхөн нэгд нь л БОРЖИГИН \2.89\ гэж бичсэн. Бусдад нь огт байхгүй.

3. Монгол бичгээр бичсэнийг кириллээр буулгахад ингэж бичигдэнэ.

4. Нэг л овогт нэг л хошууг зааж байгаа учир нэг мөр болгох нь ач холбогдлоор илүү гэдэгт үндэслэв.

Боржигин овогт хаанаас эхэлж байгаа талаар нэгдмэл судалгаа хараахан гүйцэд гараагүй

хэвээр байна.Гэвч Академич Далантайн Цэрэнсодном, Галдан туслагчийн “ Эрдэнийн эрхи” зохиолд дурдсан тайлбарыг үндсэнд нь баталсан байдаг. Боржигин овог хэмээсний учир болбоос

Бури – харчу эх БУРИ-ЧИ-ХИАН= БОРЖИГИН

Чи – Тэнгэр эцэг

Хиан – тэр хоёрын хувгүүн болой.\12.184\ гэж тайлбарласан нь Бүртэ –Чиноос ХИАН овогтон үүссэн гэдэг утгыг агуулжээ.

Боржигин-Боржигид \ олон тоо\

Хиан – Хиад \ олон тоо\

Түүхэн сурвалж бичиг, зохиолуудад хамаг Монгол улсын хаан Хабул хаанаас буй болсон хүмүүсийг Хиадборжигин гэдэг болсныг тэмдэглэдэг билээ.\8.8-9\

Боржигин овогтон нарын дээд өвөг нь Бодончар мөн боловч чухам “ БОРЖИГИН” хэмээх үгийг гарал үүслийн хувьд эргэлзээтэй болгож байгаа юм.\13.?\

Бугу Хатаги – Хатгин Бодончар- Боржигин

Бугут Салжи – Салжууд Боржигидай- Боржигин- Бөртэй чоно

Иймээс Боржигин нэрийг Харчугийн хүү Боржигидай мэргэн цаашилбал Бөрт чоно гэсэн үгтэй гаралын хувьд холбож үзсэн байдаг.

Бөртэ- Чонын урд хөлний хар бидэр

\ Якут\ \Пекарский 1917,525\

Бөрту – Буурал, цоохор , эрээн сэвхэт холимог\ Элдэнтэй, Ардаажав- Өвөрмонгол\

Бөри , Бөрү – Урд савартаа бидэртэй чонын тусгай нэр \ Түрэг хэлний зарим аялгуунд\

Бөртэ чоно – Эртний монголчуудын овог аймгийн онгон шүтээний\ тотем\ нэр

Жич тэмдэглэхэд Боржигин гэдгийг Бор нүдтэй , бор өнгө , Бор хүрэн гэж тайлбарласан нь олон байдаг. Тэр бүү хэл Буржигир \ улаан\ үст , цэнхэр нүдтэй гэсэн нь үнэмшил багатай.\9.16-18\

Доктор Дашзэвэгийн Түмэнгийн Антропологийн судалгааны бүтээлүүдэд энэ талаар баталгаа баримт байдаггүй болой.\19.85-92\

Боржигин гэдэг нэрийн тухайд товч өгүүлбэл ийм буюу.

Чойр гэдгийг тодруулбал: “ Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан Монгол үгийн дээж” хэмээх эрхэм тансаг нэртэй монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь бичиг”-т Чойр гэдэг нэрийн ийн тайлбарласаныг та бүхний анхааралд толилуулъя.\7.1004.\|

Чойр = Байгал , нийгмийн хөгжлийн бодит зүй тогтлыг амьдралд нэгтгэн дүгнэсэн логик онол хэмээжүхэй. Чойрын таван ухаан.\ Чой- 5 боть 10.46-47\

Чойрын дацан , Чойрын дамжаа, Чойрын хийд гэхээс гадна “ Жанжин Чойр”, “ Чойрын Богд” гэсэн хэллэг ч байдаг. Эл бүгдийг эс тоочин дараах тайлбарыг хийлээ. Халхын Сэцэн хан аймгийн Боржигин жанжин бээлийн хошуунд 1754 онд Баруун Чойр, Гандан равжайлин 1912 оноос

Жанчивдэчилин \ Бодь их амгалант сүм\ ,1778 онд Зүүн Чойр \ Балдандаш гоманлин\ 1875 оноос Лочинлин гэж нэрлэх болсон\ -ын хийд байгуулагдсан түүхтэй. Жанжин бээлийн хошууны хоёр

Чойр гэдэг нэр он цагийн уртад дөхөмчлөгдөн дуудагдсаар халх даяар “ Жанжин Чойр “ хэмээн алдаршсан байна. Харин Их хүрээнд 1756 онд чойрын Дашчоймпэл дацан , 1809 онд мөн Чойрын “Гунгаачойлин” дацан байгуулагджээ.\ 10.45\

Зүүн Чойрын хийд Боржигин хошууны гол хийд – Шашин номын төв төдийгүй гар урлал худалдаа, Да хүрээ, Чуулалт хаалганы их замын дайран өнгөрөх томоохон төв байв. Хийдийн ойролцоох Оцол уулыг Чойрын богд хэмээн нэрийдэх болсон ажгуу. Энэ талаар хойно тодруулна. Эдгээрээс гадна Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошуунд Бага газрын чулууны Дэлгэрийн уулын энгэрт 1911 онд төвхнөн суурьшсан “ Дашчойжилин” буюу “ Өлзийт номын учралт төв” гэдэг нэртэй Дэлгэрийн чойрын хийд байсан баримт байдаг.\4.77\ Эдгээр хийдүүд 1937-38 онд хаагдсан байна. Ингээд Боржигин нутагт хоёр Чойрын хийдийн туурь “Жанжин Чойр” гэдэг хэллэг үлдэж, Чойр Богд уулын нэр ч Оцол сансар гэдгээр солигджээ. Харин 1950 – иад оны эхээр төмөр зам тавигдахад “Чойр” нэртэй зангилаа \өртөө\ үүсчээ. Энд шинэ Чойр \ Новый Чойран\ нэртэй хороо захиргааг 1956 онд байгуулсныг 1959 оны 8-р сард БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 129-р зарлигаар сум болгон өргөтгөн Дундговь аймагт харъяалуулахдаа зэргэлдээх Цагаандэлгэр сумын зүүн талынхыг \ “ Гэрэлт зам “нэгдэлд\ таслан нийлүүлжээ. УБТЗ-ын нэг өртөөн хоёр аймгийн хоёр сум зэрэгцэн төвлөрч байв.1964 онд Дундговийн Чойр сумыг татан буулгаж Дорноговь аймгийн Сүмбэр сум эндээ суурьшин үлдсэн болой. Цагаандэлгэр сумаас таслагдан очсон хэсгийг Дундговь аймагт эргүүлэн өгч Шинэн Чойрын \ УБТЗ-ын\ хороо захиргааг Сүмбэр суманд харъяалуулсан түүхтэй. Үнэн түүх ийм л байгаа юм. 1970-д оноос Зөвлөлтийн цэргүүд ирэхэд Чойр-1, Чойр- 2, Чойр -3 гэж цэргийн анги нэгтгэлийг нэрлэж байгаад 1992 оноос Чойр хот байгуулагдсан. 1994 оноос Говьсүмбэр аймаг болов.

ОРОН НУТГИЙН ТҮҮХЭН ГАЗАРЗҮЙН АСУУДАЛД

Ер нь Монгол улсын хүн амын дийлэнх олонхи нь халхчууд бөгөөд өөрсдийгөө “ Боржигин халх”, “ Элжигэн халх” , “ Хатагин халх”, “ Олхонууд халх” гэх мэтээр нэрлэдэг билээ. “ Халх” гэдэг үгийн утгыг тайлбар толь болон ном судраас шүүн үзвэл гурван үндсэн утгатай байна.\7.562\ 19 -20 –р зууны зааг үеээр алтан ургийн Гэрсэнзийн удмын засаг ноёдын үе залгамжлан захирч байсан 4 аймгийн 86 засаг хошуу, шавь тавыг багтаасан монгол орны нэг хэсгийг “Халх “ монгол гэж нэрлэж байв. Эдгээр хошуудын дотор Боржигины хошуу ноён Нэрэнгийн Гомбосүрэнд үе улиран цэцэн цол, чин вангийн зэрэг шагнаснаар Боржигин цэцэн \сэцэ\ вангийн хошуу гэгдэх болсон юм. Энд л ялгаа харагддаг.\17.10-11\

Нягтлан үзвэл эртний толь бичгүүдэд хүний мэргэн цэцнийг сэцэн , буу зэрэг юмын цэцэнийг цэцэн гэж ялгаж бичиж байсан нь ажиглагдав.\7.970\

Боржигин сэцэн вангийн хошууны нутгийн эргэн тойрны хэмжээ 1399 газар, 7 хувь ,9 алд хэмээн тэмдэглэгдэн үлджээ.

$$1399 \text{ газар} * 576\text{м} = 805.834$$

$$7 \text{ хувь} * 57,6 \text{ м} = 403.2$$

$$9 \text{ алд} , 1.6 = 1464 \text{ Z} = 806\text{км} \text{ } 251.6 \text{ м орчим}$$

Хойд цэг - Өлзийт хушууны гэзэг, Бөгтөр Хар – Усны овоо

Өмнөд этгээд – Сайн усны баруун цагаан гуагийн овоо Эрлсэн \ хо-урагш\= 360* газар буюу 135км * 360м

Зүүн этгээд Цагаан өндрийн овооноос баруун этгээд Их газрын чулууны оргил Баян – Улааны баруун өмнө Балингийн суварга хэмээх өндөр улаан хадны дундах овоо хүртэл эрслэн 433 газар буюу 294км 408м болох юм. Боржигин сэцэн вангийн хошууны нутгийн зураг , хошууны газар нутгийн хилийн 120 овоог тодорхойлсон цэсийг Олноо өргөгдсөний 11-р он \1921он\д үйлджээ.

$$X \text{ } 135.360 \text{ Хойд} = 79$$

$$\text{Урд} = 23$$

$$\text{Баруун} = 49$$

$$\text{Зүүн} = 105$$

$$\text{Б } 3$$

$$294.408$$

Монгол улсад байгаа Боржигин халх хэмээх нь хуучнаар Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн вангийн хошуу одоогийн Говьсүмбэр аймаг , Төв аймгийн Баянжаргалан\ нялга\, Дундговь аймгийн Цагаандэлгэр , Говь-Угтаал, Баянжаргалан, Дорноговь аймгийн Даланжаргалан , Айраг, Иххэт сумд бүхлээрээ, Дундговийн Өндөр шил, Дорноговийн Алтанширээ , Төв аймгийн Баян , Баянцагаан сумдын нутгийн зарим хэсэг хамрагддаг нутагт оршин сууж байна. Хүн амын зонхилох хэсгийг эзэлнэ. Хошууны төв нутаг нь яах аргагүй Говьсүмбэр аймаг. Хошууны гол хийд Зүүн Чойр , хошуу тамга, , ноёны өргөө чухам энд л байж. Иймээс Говьсүмбэрийн газар зүйн асуудалд хандах нь зүйтэй болов уу?

Нутгийн хойд захын цэг: Хэрлэн голын Хөмүүлтийн гүүр 46*59”54*

Урд зах нь Цагаан дөрвөлж :\ 1224.3м\45*52”48*,108*24”08*

Баруун захын цэг: Төмөр замын 14-р зөрлөг 46*51”37*,108*47”26*

Зүүн захын цэг нь Цагаан толгой \1211.9 м\ 46*51”54*,109*07”08*

Нутаг дэвсгэрийн хэмжээ нь 5540 хавтгай дөрвөлжин км. 2009оны жилийн эцсийн хүм ам, мал тооллогын дүнгээр 4144 өрхийн 14,135 хүн,168.723 толгой мал тоологджээ. Засаг захиргааны хувьд 3 сум , 9 багаас бүрддэг. Тус аймаг нь хойд талаараа Төв аймгийн Баянцагаан , Баян, Баянжаргалан сумдтай, Зүүн хойд хэсгээрээ Хэрлэнгийн Хөмүүлтийн гүүрнээс Зараа булан хүртэл Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Зараа булан\46*58”04*:\ 108*57”50*\ -аас Цайдам нуурын хойд булан Хэнтийн Дархан, Цайдам нуурын хойд булангаас \46*20”20*,109*01”17*\ Урсахын өндөр ухаа \1180.0\ хүртэл зүүн өмнөд талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан сумтай хаяа нийлэн савлаж хиллэдэг. Харин өмнөд , баруун өмнөд талаараа Дундговийн Баянжаргалан\ Хамарцагаан жаргалан гэж настайчууд нэрлэдэг байсан\ сумтай Урсахын өндөр ухаа \45*56”40*,108*34”09*- 1206.9 тоот буюу Улаан - Өндөр хүртэлх 45км газраар хиллэнэ. Улаан - Өндөрөөс \46*04”37*,108*08”39*\ төмөр замын 14-р зөрлөг хүртэл 109км газраар Дундговь аймгийн Цагаандэлгэр сумтай хиллэдэг. Хамгийн өндөр цэг нь Оцол уул 1695м\хойд\,урд уул1682м , Сүмбэр уул 1585 м өндөр гэж тэмдэглэгджээ.Од сал буюу Тодорхой гэрэлт гэсэн төвд нэрнээс үүсэлтэй Оцол уулыг Чойр уул , Чойрын богд гэх мэтээр нэрлэх нь буруу юм. Зүүн чойрын хийдийн туурь байгаа газар бол Марзны хоолойн эх Мандалын таван хад гэдэг нэртэй болно. Малахын тал бол эртнээс адууны отрын нутаг бөгөөд Их малах, Бага Малах, Голын Малах гэдэг газрын нэрийг Малх гэж бичээд зогсохгүй Их уул, Бага уул гэж ярьж бичдэг болов.Уул үгийн гарал нь МАНА-МАЛЛАХ гэсэн үгнээс үүдэлтэй монгол хэлний авиа сэлгэх зарчмаар Н,Л авиа сэлгэгдсэн эсвэл зэрэгцсэн ижил гийгүүлэгч орхигдсон хэрэг шүү дээ. Баянтал сумын нэрийг сонгох гэж хөглөв. Лүн хотхон гэсэн чинь Лүнгийн улаан овоо. Сүмбэр сумын нутгийн заагт байгаа учир Билгүүн гэж солив.Тэр нь дээр үеийн хүн тавьдаг\ оршуулгын\ газрын нэр учир аргагүйдэн сольсон билээ.Шивээговь сумын төвлөсөн газар байгаа бол Сэвхүүлийн говь. Халх , ойрад\өөлд\-ын дайны үетэй холбоотой Боржигины таван шивээгийн нэр юм. Шивээ гэдэг нь хуучирсан утгатай бэхлэлт, цайз гэсэн\7.1058\үг ажээ . Мод чулуу мэтээр босгосон хашаа хороо мэт юм. \3.843\гэж ч тайлбарлаж болдог. Мөнх Шивээ \ Мөнхийн хар толгой гэлцэх болж\ Баруун Чойрын шивээ,Аргийн шивээ гэх мэт буй. Сэвхүүлийн говийн нэр Сэгхүүрийн,Зуумай гэдэг

нь Зуун умай гэдэг үгнээс гаралтай гэх. Халх, Өөлдийн дайны үеийн \ 17-р зууны \ гаралтай домог үе дамжин хэлэлцэгдсээр иржээ. Одоогийн Сүмбэр сум УБТЗ-ын Чойр зангилааны орчим нь Төгрөгийн зүүн баруун “ Аяганы тойром” гэдэг байв. Хонхор гээд байгаа газрыг “Хуурай хүр” хэмээнэ. Урд талд нь байгаа өндөрлөгийг \ Оросын локатор гэлцэх\ Хуурай хүрийн толгой гэж газрын зурагт тэмдэглэсэн байдаг. Хүр гэдэг нь ус нь ширгэж хатсан голын гольдрол , нуурын хуурай тойромм \2.889\ Ганга гуу жалга \3.747\ гэж толь бичигт дурджээ. Төмөр замын гарамнаас баруун урагш Нефть баазаас цааш 1992 онд анхны Боржигин наадам хийсэн газрыг “ Цагаан дух” гэдэг. Хүрийн ногоон нуурыг Хүрийн ногоо , Хүүрийн ногоо гэх мэт эндүү ташаа бичиж , ярьж, үндэслэлгүй худал домог хүртэл зохиох хүмүүс байна. Хуурай хүрийн дэнж гэхийг Хуурай хүрэн дэнж гэж мэдэмхийрэгч хүртэл гарсан нь харамсалтай.Үүнээс санал болгоход газар усны нэрийг зөв бичих, өсвөр залуу үеийнхэн болон шинээр шилжин ирэгсэдэд зөв ойлголт өгөх цаг болжээ.

Үүнд сум, аймгийн ИТХ-аар нухацтай хэлэлцэн шийдвэр гаргах нь зүйтэй.Түүхээс үзвэл одоогийн Улаанбаатарт 1950 –аад он хүртэл Гандангийн хүр, Дүнжингаравын хүр гэж байсныг эрдэмтэн О.Пүрэв, С, Идшинноров нар бүтээлдээ дурдсан байв.”Хүрийн хотхон”, эсвэл “ Боржигин хороолол” , гэх мэтээр нэрлэхэд болохгүй зүйлгүй санагдана. “Шинэ чойр” хотхон гэж ч болмоор.

Эл бүгдийг нуршин өгүүлэхийн учир нь он цагийн манан дундуур гэрэл гэгээ татуулан эрхэм та бүгдийн оюуны мэлмийд солонгын өнгөөр туяарч , Монгол хүний сэтгэлийн наранд амьдралын үнэн , ахуй ертөнцийн бодит байдлын мэдрэмжийг өөрийнхөөрөө сэтгэж гаргасан нь энэ буюу. Саруул ухаан дэлгэрэх болтугай.

СЭТГЭЛИЙН ТАЯГ

“Санахын огторгуй” наадмын Дэд байрны шагналт Багын явдал гэдэг санаанаас үл гарах. Сургуульд орох намар юмсан даг. Их үдийн өмнөхөн миний багын найз Батаанаа бид хоёр гудамныхаа айлуудын эгнээ хашаагаар дүүлэлдэн авирч тоглоод, нохой, тахиа шуугиулан, эмээ, өвөө нарын тав тух алдуулан дүрсгүйтэн явтал хамгийн хойдгудамнаа саяхан нүүж ирсэн, хамгийн баруун айлын хашаанд гал дүрэлзэн оволзох харагдаж, улс амьтан хашгиралдан уймах сонсогдон бид ч юундаа хоцрох вий гэсэн шиг тэр зүг хөл мэдэнжирийлгэлээ. Гэрийн эзэн нь тээврийн жолооч тэр айлын их гэр бамбар тавьсан шиг ноцож, хаяалан буусан жижигхэн бор гэрийн эмээ, залуу хүн мэт хашаагаар гүйн ирсэн хүмүүст шатажбуй гэрт балчир хүүхэд байгааг учирлан эхэр татан уйлаад, өөрөө л бараг дүрэлзэх гал руу орчихмэт цовхчин сандрах нь өрөвдмөөр. Тэр дороо л хувинтай ус, шороо, хүрз, лоом болсон хүмүүсцугларан шатаж буй гэрийг унтраахыг чармайн эрвийх дэрвийхээрээ зүтгэн ус, шороо цацлавчнамрын цоног наранд аагьталаа хатсан мод, бүрээстэй гэр гэдэг унтрах бүү хэл өширхөх мэтулам дөллөнө. Шатаж байгаа гэрт буй нялхад санаа зовсон хүмүүс хий л самгардан бахиралдана. Энэ жил цэргээс ирсэн манай хавьдаа л “овгор” гэдэг өндөр Тулгаа ах тэдний дунд байхыг хараадбид хоёр хоорондоо “За, манай овгор ах ч эр зоригоо одоо л үзүүлж, хүүхдийг гэрээс аврана даа” хэмээн хөөрөлдөж зогсохуй, мань хүн харин ч галаас айсан мэт ойртох байтугай авгайчуул тайхувин булаацалдах нь бидэнд инээдтэй сонин санагдав. Гэтэл гудамны баруун дороос гэр ньхаана байдаг, бүтэн нэрийг нь бид мэдэхгүй, баруун хөл нь татуу хазгар болохоор нь Батаанаабид хоёр хирэндээ явдалаар нь шоолж, хоорондоо “Төгрөг тавь” гэж нэрлэдэг, гандуу хүрэндээл, хар дугуй малгайтай, айл хунар хэсэж, мод, нүүрс хийх, мал төхөөрөхөд нь ямагт байлцажявдаг, биднийг харахаараа “Аа дүрсгүй моншнуудын гэдсийг нь гаргана даа” хэмээн үнхэлцэггартал айлгадаг хар царайтай Сүхээ гэдэг хархүн эрүүл хөлтэй мэт гүйхээрээ ирэх нь харагдав. “Төгрөг тавь” ах гүймэгхэн дундаа олны ярианаас гэрт хүүхэд байгааг мэдүүт, юм ч хэлсэнгүйхувинтай ус цалгиан, өгзөг нь тонтогонуон, хөлс нь бурзайн шогших алаг эрээн гэрийн халаадтайнэгэн бондгор бор авгайн гараас хувинтай усыг нь шувт татан авч өөр дээрээ хөмрөн асгаадулаан гүйхээрээ шатаж буй гэр лүү орж явчуут, дуу шуугиан улам хүчтэй тэнгэр хагарах мэтцаргиж тэр хавь дайвалзах шиг болов. “Төгрөг тавь” ахыг ороод удаа ч үгүй байтал гэрийн тооно цөмрөн унахад, цөм дуу алдаж хөөрхийлөлдөн, бор гэрийн эмээ ухаан алдан унахтай зэрэгцэн, суурингийн эмнэлэгийн тусламж, гал унтраах “сэсчээр” машин хоёр зэрэг шахам дохио хангинуулан сүртэйхэн ирэв. Удалгүй гал унтарч, эмнэлэгийн дамнуурган дээр пөөнийсөн хар нүүрс шиг болсон “Төгрөг тавь” ахыг дамнан түргэн тусламжийн машинд оруулахтай зэрэгцэн, хүмүүс бас л шуугиад явчихав. Бид ч гайхаад хартал, нарны гэрэлд цагаан халааднаа чагнуур нь гоёмсогоор толилон гялалзах, манай тэндхийн ганц “бурхан” эмч ах маань, өмцөө, цөмцөө цоо алаг түлэгдсэн баривчтай нялхад үзлэг хийгээд өвөртөө тэврэн босохдоо, “Ашгүй хүү түлэгдээгүй, угаартсан байж, саяын хүн амжиж хүүхдийг олж тэврээд, гарч амжилгүй дороо хийж унажээ, хүү одоо амьсалж байна аа” гэж хэлсэнийг нь бид сонсоогүй аж. “Төгрөг тавь” ахыг хөдөөлүүлэх ёслолдманай суурингийнхан бараг тэр чигээрээ явсан шиг санагддаг юм. Батаанаа бид хоёр ч тоглохдоохэрэглэдэг унинд уясан дайчин улаан тугаа бөхийлгөн, тэр цувааг харж, аавгүй үлдсэн гурван бор хүүхдийг нь

өрөвдөн, нүдэндээ нулимас цийлэлзүүлэн зогсоцгоож билээ. Хөөрхий тэр ах хөл нь хазгар ч, сэтгэл нь хазгай байгаагүй ээ.

МӨӨГӨН ХҮРЭЭ

Зуны дунд сарын нар хур тэгширсэн өглөө, ойрын хоногуудад говь нутгийн ховорхон заяадаг борообагагүй орж хоёр гурав хоногоос хурц нар ээсэн болохоор чийглэг тааламжтай байлаа. Жижигжодгороо хураангаа нүдэн тогоо, аяга сав мэтээ эмхлэх зуур өвгөн оточ Гончигзав гуай мандах нарны туяан доогуур ойрхон саахалтын тэртээгээс чөдөртэй хоёр морио хөтлөн айсуу арав гаруйнасны шавиа саравчлан харж “бас ч гэж хүн л болж байна даа” хэмээн хэрэндээ баяртай суух зуур өөрийнхөө зургаан насанд аавтайгаа дөрөө харшуулан Ихгазрын чулууны урд биед оршихнутгаасаа Дэлгэрийн Чойрын хийдэд маарамба багшийнхаа шавь болохоор очиж байснаа санах. Шавь нь хоёр морио тушаад өөрийнхөө жижиг модон тагшаар нэг хүйтэн цийдэм уугаад багшийгаа ямар учиртай хоёр шээзгий /том дөрвөлжин араг/авсан болохыг сонирхон асуувал- Багш нь: Би чамд нэгэн сонин зүйл ярьж өгье хэмээн шал өөр зүйлийг өгүүлэх мэт болов. Одоо хоёулаа хойшоо хол саахалтын хэртэй яваад Ихгазрын чулууныхаа урд биед орших ухаа зоогийн наран талын энгэрт очно оо гээд дараахи зүйлийг өгүүлэв.

- Тэр баруунтаахи Баянбулагаас ус уугаад өвсний сорыг даган идээшилсэн цагаан зээрийн сүрэг орой болоход чи бид хоёрын зорьж яваа ухаа зоогийн урд очиж хоноглодог юм. Зээрийн сүрэг хоноглохдоо их учиртай, нялх гэнэн мөн нойр ихтэй сонор соргог биш янзагануудаа голдоо оруулаад түүний гадуур янзаганы эх шарагчингууд болон бусад зээр хэвтээд хамгийн гадуур сүргийн тэргүүн болон хамгаалагчид болох оононууд хүрээ үүсгэн хэвтдэг. Өглөө болоход бие биеийн үсэнд унасан хярууг долоогоод өглөөний ундаан уучих нь тэр. Үүний дараа эхэлж оононууд босон биеэ хөнгөлөөд /шээгээд/ алсын бараа ширтэж тэнгэрийн байдлыг шинжих мэт болоод тухайн өдөр аль зүгт хандан идээшилэхийг шийднэ. Заавал биеэ хөнгөлж байж бэлчдэг учир хуучны үгэнд зээр шээхгүй болявж чадахгүй гэж хэлцдэг байжээ. Ийнхүү зээр удаа дараа хоноглон удаа дараа шээсэн газар гэрийн малын бууц мэт хомог хөрзөн тогтдог. Анчин хүн ан хийхийн тулд ийм газрыг мэдэж авахыг хичээдэг бол олны тусын тулд эмэнд ордог өвс ургамал түүж явдаг оточ хүн ийм газрыг мэддэг байх нь өөр учиртай гээдинээмсэглэв.

- Шавьнь ихэд сонирхон аа мэдлээ тэр шээстэй шороонь эмэнд ордог юмуу гэхэд барагтай инээж уурладаггүй багш нь ихэд хөхөрч

- Чи байз гэм гээд цааш өгүүлсэн нь Ирэхзун нь бороо хур тэгширсэн дэлгэр сайхан цагт энэ хомог хөрзөн тогтсон газарт цагаан мөөг дугуйран ургадагийг манай ард түмэн мөөгөн хүрээ хэмээн нэрлэдэг. Маарамба багш маань надад ингэж зээрийн хомог хөрзөн дээр ургасан хүрээ мөөг их эмийн чадалтай, бас бороо орсон дараахан шинэдээр нь түүж авбал олонд тустай хэмээн айлддаг байсан юмдаа гэв.

Багшаа цагаан мөөг ямар эмэнд ордог юм бэ? гэж шавь нь асуувал багш өгүүллрүүн

- Эмийн сударт цагаан мөөг шим тэжээлээр тун арвин тул “ургамалмах” гэж нэрлэсэн байдаг. Мөн мөөгийг идвэл элэг, ходоодонд шингэж, түргэн туулуулан хорыг тайлж, ходоодыг сайжруулна, шинэ мөөгөөр шөл гаргаж идвэл халууныг дарж, цэрийг ховхлоно гэсэн

байдаг.Бас мөөгийг халуун тогоонд хууран хэрэглэж болно гэсэн ч бий. Харин шээзгий авдагнь шинэ мөөг эмзэг амархан гэмтдэг учир түүж авмагц давстай усанд дүрээд шээзгийнд тараан гадуурнь нарнаас халхлан бүтээгээд гэртээ аваачсаны дараа утсанд хэлхэн хатаадаг учиртай гээд ямар ч чадалтай эмийн ургамалыг буруу цагт буруу түүх, буруу хатааж хадгалахнь эм үл болох учир олон түмэнд эм болохгүй муу үр дагавартай учир буян бус нүгэл болно шүү дээ гээд босож явахаар мориныхоо зүг алхсан нь энэ удаагийн яриа дууссаны тэмдэг ажээ.

Жодгор – жижиг майхан

Нүдэнтотоо – маш жижиг тогоо

Шээзгий – том дөрвөлжин араг

СУУСАН ТЭНЭГ

Ажлын цаг дуусчээ. Бүтэн өдрийн турш “хийх ёстой” гэсэн үгээр өөрийгөө саатуулан байж сандал дээрээ тогтож суусан над мэтийн хүнд ажил хийнэ гэдэг хамгийн аймшигтай зүйл. Өглөө гэрээсээ гарахдаа л би яаж өнөөдрийг өнгөрөөнө дөө гэсэн бодлоор бүх зүйлийг үзэн ядаж эхэлдэг. Яахав зарим өглөөг бол цайны цагаар хоол олж иднэ гэсэн өөдрөг үзлээр угтана. Миний хамгийн сайхан өглөө ийм бодлоор л эхэлдэг. Би та нарын бодож байгаа шиг төрөлхийн азгүй амьтан бол биш шүү. Арван жилдээ тэргүүний сурагч, тооны аварга, шилдэг бүжигчин гээд тоолж барамгүй олон гуншинтай сэхүүн жаал байсан юм. Оюутан байх даа ч адилхан шилдэг, тэргүүний, онц сурлагатан байсан. Та нар намайг яг хаана алдаа гаргаж ийм амьдралтай болсныг гайхаж байгаа бол хонгор минь өөрөөсөө ч бас “би жаргалтай байна уу?” гээд асуугаад үз. Энэ байдлаас минь нээх дээрдэхгүй л бол уу. Миний алдаж эхэлсэн цаг хугацаа өнгөрсөнд ч, одоо ч, бас өөрчилж чадахгүй ирээдүйгээс минь ч тодрон харагддаг. Би өнгөрсөндөө өөрчилж чадах байсан. Би одоо ч өөрчлөх боломжтой. Би маргаашийг ч өөрчилж чадна. Харамсалтай нь би чадахгүй. Сар бүр хоолны минь хэдэн төгрөгийг аргалдаг энэ ажлаас гарах санаа толгойг минь хэдэн мянган удаа эзэмдэж байсан ч эцсийн бүлэгт ялагдал хүлээсэн. Тэгээд ч ажлаасаа гарлаа гээд юу өөрчлөгдөх вэ дээ. Би амьдралд хариуцлага хүлээхээсээ айдаг. Алдаа гаргахаасаа бүүр ч их айдаг. Хэдийгээр хараал идсэн энэ ажлаа хаяад нисмээр байгаа ч над шиг хүнд бурхан үнэгүй далавч өгөх нь юу л бол. Нэг бодлын би тэнэг хүн. Бас гэнэн, аймхай, азгүй бас овжин зальтай, бусдын арга эвийг олчихдог нэгэн. За тэгээд ер нь дэлхий дээр олон арван хүн хүсэл мөрөөдлөө золиослон амьдарсаар л байгаа шүү дээ. Би ч гэсэн тэдний нэг болоод амьдрахад буруу нь юу байх вэ? Угаасаа намайг мөрөөдлөө биелүүлэх гэсээр байтал дэлхий суйрнэ. Сүйрдэггүй юм аа гэхэд ядаж л байгалийн гамшиг болж замд минь саад болно. Тэгээд удаан хөдөлмөрлөсөн цаг хугацаа минь хий хоосон болчих вий дээ гэхээс би үхтэлээ айж байна. Одооноос эхлэн ЯВСАН УХААНТНУУДААС СУУСАН ТЭНЭГ НЬ ДЭЭР гэсэн үгийг урдаа барин сандалнаасаа зуурсаар байх болно. Ураа! Цайны цаг\Хэнээс мөнгө зээлэх вэ? \. Гэхдээ нэг асуулт одоо ч толгойг минь зовоогоод байна. би хэр удаан амьдрах вэ, бас хэдэн удаа хүн болж төрөх вэ? Энэ эцсийн боломж байвал яах уу? Үхэх үедээ би харамсвал яах вэ? Өөрийгөө тэсэлгүй ихээр үзэн ядах тэр үед юу намайг тайтгаруулах вэ? Одоо ч миний цаг хугацаа хий хоосон өнгөрч байна. Суугаад алдах уу яваад алдах уу? Алив түмэн олон минь хэлээд өгөөч.

ДАХИН ЭНЭ ЗАМААР АЛХАХГҮЙ

Яг 24:00 хаалганы дэргэд аяархан сөхөрлөө. Чихээ хананд наан орцонд хэн нэгний алхах чимээ гарахыг тэсэн ядан хүлээнэ. Хананаас шалруу унахусны шол хийсэн чимээчихэнд цуурайтна. Өөрийн эрхгүй элэг зүрх хамаг л эд эсийг минь зурсаар нулимс урсана. Зүрхний хэмнэлийг дагах гэж байн байн дуслах борооны ус яг л миний нулимс шиг. Тэр л үед чи хаалга тогшиж намайг тэвэрсэн бол. Би ухаангүй амьтан шиг энгэрт чинь шигдэж нулимсаараа цээжийг чинь нэвт норгох байсан. Чи бид хоёрын гунигт түүх тэр үдэш л нүдэнд минь бүтэн харагдаж билээ. Удалгүй би галзуурсан мэт хар хурдаараа босож харайн чиний хувцас, сахлын хутга, сойз, гутал гээд нүдэнд торж чамайг илтгэх бүхнийг гэрээсээ гаргаж хаясан. Тиймээ тэр өдөр би чамайг өөрөөсөө түлхэж гаргасан. Миний нэг хэсэг гэж өдөр бүр хэлдэг байсан тэр үгтэй чинь хамт хаясан. Хэзээ ч би чиний нэг хэсэг байгаагүйг миний тархи тэнэг зүрхэнд минь тэр мөчид л ойлгуулж чадсан юм. Гэхдээ чамайг өөрөөсөө гаргах гэж оролдох бүрт дотор минь өндөлзөх айдас, харамлах сэтгэл “Дахиад нэг л уучил” гэж байн байн шивнэж байсан. Тиймээ тэр үед чи ирсэн бол би чамайг дахиад л уучлах байсан. Магадгүй чи сайн залуу. Гэхдээ хайртай хүндээ л сайхан загнаж чаддаг байх. Би бол эмэгтэй хүн. Би ямар ч зовлонг тэсч чадна бас ямар ч жаргалыг дааж чадна. Гэхдээ миний хүч дуусч байна. Нүдэнд минь асдаг байсан оч нулимсан бороонд унтарч, зүрх минь бус зөвхөн уруул минь инээдэг болсныг чи мэдээгүй. Мэдсэн ч анзаараагүй. Учир нь хайрлан байж урсагадаг нулимс минь борооны дараа тогтдог шалбааг шиг л чамд үнэ цэнэгүй. Тэр шалбааг хөрсөнд чинь шингэж цэцэг ургуулдагийг чи бас л мэдэхгүй. Чиний амьдралд цэцэг ургуулсаар залхаж байна. Өөрийнхөө хатаж үхсэн хөрсийг арчилж шинэ хөрсөнд шинэ үр тарихыг би хүсч байна. Одоо чамайг өнгөрсөн хэмээх хуучин цүнхэнд хийгээд амьдралын зам дээр үлдээлээ. Дахин энэ замаар алхахгүй байхын тулд би урагшаа л тэмүүлэх болно. Хэзээ нэгэн цагт энэ өдрийг эргэн дурсахад амьдралаа аварсан өөрөөрөө би бахархана. Эхнэртэй залуугийн энгэрийг дэрлэж хэвтсэн гунигт өдрүүдээ шоолж инээнэ. Хэдийгээр хурц үзүүртэй хадаас амьдралын минь хананд зоогдсон ч үлдэх нүх нь насан туршид минь сургамж болно. Хайр дурлал минь нүгэлт шунал минь хаалгаа хаагаад нулимсаараа чамайг үдье.

ЖҮЖГИЙН ЗОХИОЛУУД

Дуутан Ширчингийн БАТНАСАН

МОГОЙ ГАЗРЫНХАА ӨНГӨӨРӨӨ...

/ 3 БҮЛЭГ 5 ҮЗЭГДЭЛТ ДРАМЫН ЖҮЖИГ /

1. Амгалан – нас 50 гаруй, лам
2. Хайдав- нас 40 орчим, лам / хожим нь бөө, чекист болж хувирна/
3. Аюушмаа- нас 30 гаруй Хайдавын санч / нууц гэргий/
4. Гамин офицер
5. Жамбалдорж – нас 40 орчим лам / хожим нь хувьсгалч, чекист болж хувирна/

Мөн далдаас хөтлөгч оролцоно

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Эхлэл.

Дэншиг 3 удаа дуугарна. Хөтлөг / далдаас/ - Бодончар боржигин овогтой бөлгөө. Бодончарын удмаа

Тэмүүжин мэндэлсэн болой. Тийнхүү түүний удмын бүх хаад ноёд уг гарлаа хиюүд яст боржигин

овогт хэмээн хөтлөх болжээ. Хөгжим /Боржигины уртын дуу “Эртний сайхан” эгшиглэнэ. Түүний

фонон дээр хөтлөгч :- Батмөнх даянх хааны удмын хун тайж Дамбадашийн хүү Цэвдэн Боржигин

хошууг үүсгэн байгуулсан түүхтэй. Боржигин хошууны сүүлчийн арав дахь ноён нь Нэрэнгийн

Гомбосүрэн байлаа. Уртын дуу алсарч хөшиг нээгдэнэ

НЭГДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ

Тайз: Зүүн Чойр хийд хурал хурж буй уншлага тод дуулдана.

Хөтлөгч: Цагаан бичин жилийн өвлийн сүүл сар аргын тооллын 1920 оны зүүн Чойр хийд

/ уншлага намсаж хийдийн гол хаалгаар хар хилэн хиазтай шар торгон дээл өмсөж, улаан зулагт Чойр хийцийн гутал өшиглөсөн Хайдав, Амгалан нар шанам малгай сагсалзуулсаар ярилцсаар гарч ирнэ.

Хайдав- Цаг төр үймэхийн хирээр бурхан шашны хэрэгт ч цөвтэй болж ирэх нь дээ давуу минь.

Амгалан- Бурханы авралаар харин ч бид буруу номтнууд хаяанд маань ирж буучихаад байхад өнөө хир дэг ёсоо хадгалсаар, бурхан шашныг өрнүүлэгч Балдан дашгомлин хийдийн маань хурал ном буяны үйл хэвийн явсаар байгаа бус уу?

Хайдав- Цаг цагаараа байдаггүй гэдгийг та бид болгоож байвал зүгээрсэн цаана чинь нийслэл хүрээнд цагаан ноён ирж суучихаад байдаг. Өшөө бас улаан намынханы тухай үнэн худал нь үл мэдэгдэх цуу их дуулдаж байна.

Амгалан- Тэр ч тийм. Улаан оросын нөлөөнд автсан Сүхбаатар, Чойбалсан, Данзан ч гэх шиг. Тэр ч бүү хэл манай эндэхийн зарим нэг бүтэл муутай хүмүүсийн нэрс ч дуулдах боллоо. Ер нь энэ тал дээр та ямаршуухан бодолтой байна вэ?

Хайдав- За бүү мэддээ, юу болсон харзная. Могой газрынхаа өнгөөр гэдэгсэн. / бүрэн зэвсэгтэй нүдний шилтэй гамингийн офицер гарч ирнэ / Хайдав, Амгалан мэхийн ёсолж-Эрхэмсэг ноён жанжны амгаланг айлтгая.

Гамин дарга / ихэмсэгээр, толгой дохиж худал инээж/

- Оо элхэмсэг гэгээнтануудын амлыг элье аа.

- Мэндээ / Хайдав мэхэлзэн дөхөж/ Амгалан явна.

Хайдав- Танай их цэргийн өмгөөлөл дор өчүүхэн хуврагууд бид хамаг амьтны тусын тулд сэтгэл оюунаа чилээж сууна.

Гамин дарга – Хай тэл яаха ба? Танай манай хоёл хэзээнээс нэгэн гэлийн аха дүү шүү. Халин ойлгохгүй үхэл шига улс иха байнаа.

Хайдав- Жа /мэхэлзэнэ. Гамин цагаа хяламхийн харсанаа/

- Тиймаа үхэлүүдтай тулалдахад л та нал билэнда туславаа хэлэгтэй / явах гэнэ. Хайдав араас нь дагаж зальжнаар/

Хайдав- Эрхэм жанжин түр тогтоож хайрла. Орой та завтайсан бол өчүүхэн хувраг миний гэрт гийгүүлэн очвол ихэд баярлах байна.

Гамин дарга –Ай тэл болохгүй яахаа болнааваа.

Хайдав- Гялайлаа, ноён жанжин. Би таныг нохой цагт хүлээж байя.

Гамин дарга- Ноху цаг ямал цага, чи энэ дээл зааваа / цагаа гаргана/

Хайдав – Энэ дээр ноёнтон

— Мэндээ /Хайдав мэхэлзэн дөхөж /Амгалан явна.

Хайдав: — Танай их цэргийн өмгөөлөл дор өчуухэн хуврагууд бид хамаг амьтны тусын тулд сэтгэл оюунаа чилээж сууна.

Офицер :—Хай тэл яаха ба? Танай манай хоёл хэзээнээс нэгэн гэлийн аха дүү шүү. Халин ойлгохгүй ухэл шига улс иха байнаа.

Хайдав:— Жа /мэхэлзэнэ. Гамин цагаа хяламхийн харснаа/:

— Тиймаа ухэлуудтай тулалдахад л та нал билэнда туслваа хэлэгтэй!/явах гэнэ. Хайдав араас нь дагаж зальжнаар /

Хайдав:— Эрхэм Жанжин тур тогтож хайрла. Орой та завгайсан бол өчүүхэн хувраг миний гэрт гийгүүлэн очвол ихэд баярлах байна.

Офицер : — Ай тэл болохгүй яахаа болнааваа.

Хайдав: — Гялайлаа, ноён Жанжин . Би таныг нохой цагт хулээж байя.

Офицер — Ноху цага ямал цага, чи энэ дээл зааваа / цагаа гаргана /

Хайдав— Энэ дээр ноёнтоон

Офицер — Жа ойлговаа ойлгаа/ гамин явж Хайдав үлдэнэ /

Хайдав— За энэ ч нэг хэрэг /хамрын тамхи татаж бодолхийлнэ /

Ер нь ингэхэд энэ Чойрын хийдэд над шиг түвд орж Далай ламд бараалхан номын дамжаа барьж, баруун зууд явьж ном хаялцан дийлж аранжамба болж ирсэн нь хэдсэн билээ. Ингээд бодохоор би уг нь эндхийн хамба байх ёстой биш билүү ... Энэ Лигшид хамба надаас юугаараа илүүтэй юм бэ ? . / гэнэт уурсан хөмхий зууж /

“Богд гэгээнд нэрийг минь хамба ламд өргөн толилуулчихаад байхад өмнүүр минь хэн хөндөлссөнийг олох гэж би мөнч олон удаа бодож энэ муу толгойг гашилгасан даа . . . Гэвч би олсоон .Одоо тооцоо бодох л үлдэж.., Гэхдээ чамтай би өөрөө үзэлцэхгүй ..Чамайг чи байтугай чиний тэр сохор тангадаас чинь илүү хүчтэнтэй тулалдуулна. Тэгэхдээ харин яаж../ нүдээ аньж эрхээ эргуулж бодолхийлнэ. /

Тэгснээ гэнэт хөхөрч — Аам хаа ёстой зөв, ёстой зөв. Арга бол магтаал ха..ха.., ха магтаал

Аюушмаа /гарч ирнэ айсан байдалтай /

—Хайдаав, чи чинь.., / Хайдав огло үсрэн цочино /

Аюушмаа : Чи чинь яачихаа вэ? Ойрд нэг л санаа зовингуй байсан сан , Өнөөдөр гэнэт юундаа ганцаараа хөхөрч зогсдог билээ

Хайдав — / зальжинаар/ За тэр яахав дэмий юм бодож байтал багын явдал санаанд ороод л.., /маасганаж / — Бас ч чамайгаа хүрээд ирэх боловуу гэж хүлээгээд л .. .

Аюушмаа: За яршиг даа хүлээгээд байхаар хүрээд л очино биз / аальгүйтэн хөхрөнө/

Хайдав - Тэр ч яаж болох вэ. Би бас ч гэж мяндаг тушаалтай хувраг хүн шүү.

Аюушмаа —/хувьсийн / Үгүй ер дөө өнөөдөр л хуврагаа мэдэж гэнэ.

Тэртэй тэргүй л намайг чиний санч гэдгийг хүрээний хэдэн асман баньд нар байтугай нь ноход нь хүртэл хуцах байлгүй / явна /

Хайдав— / сандарч / Хүүе чи байз л даа тоглож байхад. Орой ч болчихлоо хоёулаа манайд очьё.

Аюушмаа /гүйнэ /

/ Гэрэл унтраад асахад. Хайдавын гэр Бурхан тахил, явган ширээ, ширээн дээр домботой цай идээ айрагтай агаруу хувин байна/

Хайдав — Аюуш минь чи өнөөдөртөө миний захиснаар л байхыг хичээдэг юм шүү . Тэгвэл чиний өвөрт удахгүй Чойрын хамба лам өөрийн биеэр залрах болно ха...,ха...,ха..,

Аюушмаа — / эрхлэнгүй / За яршиг даа би хэзээ л чиний үгнээс нэг их зөрөөд байлаа. Чи л дараа нь олон юм яриад байхгүй бол..,

Хайдав — Үгүй үгүй яалаа гэж харин чи минь л хичээж үзээрэй

Аюушмаа- Харин тэр луухаан чинь үнсэж үлгэх гээд байвал яанаа

Хайдав — Аюуш минь могой газрынхаа өнгөөр гэдэг юм.Ганц хоёр үнсүүлэх ч юу ч биш. Харин бусдыг нь би даая

Аюушмаа—/тунирхаж / Чи ч цагаа болвол намайг худалдаж ч магадгүй нь ээ

Хайдав—/ аргадангуй / За хаанаас даа Би чинь муу ч сайн бурханы шавь хүн, тийм нүгэл юу гэж үйлдэх вэ ? /үнсэнэ / Харин чи миний нөгөө төмөр утасны хорооны орос Кузеницовоос авч өгсөн даашинзыг өмсөнө шүү.

Аюушмаа /дурамжхан /- Тэгэхээс дээ

Хайдав — За яамай даа. Чи минь хурдалж уз / Аюушмаа нөгөө өрөөнд орно. Хайдав

хувцасаа өмсөж байтал гамин офицер орж ирнэ / Хайдав—/ мэхэлзэж / Эрхэм ноёныг гадаа угтаж чадалгүй ёсыг алдлаа, Өршөөж хайрла.

Офицер- Оо ламтан та юу айлд наа тэл хамаагүй ваа. Бида нэгэн гэлийн улса шүү.

Хайдав — Жа ноёнтон дээшээ морил

Офицер— Зүгээл.зүгээл /худал инээж нахилзсаар малгайгаа авч сууна.

Хайдав — Ноёнтон манз зоогло

Офицер — Манзуу гэжа юу байнаа.

Хайдав — Ай харла гэж . . . Цай уу идээ ид

Офицер- Зүгээл, зүгээл баялаа. /ихэмсэгээр амсснаа тавина /

Хайдав — Ноён даргын миний өчүүхэн гэрт гийгүүлэн ирсэнд ихэд бэлгэшээж байна.

Офицер — Зүгээл зүгээл тэл яахаа халин би жаахаа төөлсөөн шүү. Танай байшаа тэл тэнда байсаан Мунаа энда байнаа.

Хайдав—Уучлаарай эрхэм ноён манай Чойр хийцийн байшингууд чинь дуртай цагтаа гэр шигээ буулгаад нууж болдог юм л даа. Та айраг уу? / том хуланд хийж өгнө /

Офицер / толгой сэгсэрч / —Оо их баялаа ваа халин би ийма жаахан гэдсуутэй ваа. Танай аягаа мину толгойгоос тома байнаа шүү / амссанаа ярвайж тавина. Аюуш хувцасаа сольж халуун бууз авчирч тавина. Гамингийн нүд сэргэж босно /

Офицер — Оо сайн байна Аюушмаа— Сайн та сайн байна уу?

Офицер — Танай нэл хээн ?

Аюушмаа — Аюуш

Офицер — Оюуша, Оюуша

Хайдав — Жа тиймээ Аюуш, ноёнтон сууж цав зоогло.

Офицер — Чав гэжа юу байнаа / Аюушмаа нөгөө өрөө руу орно /

Хайдав — Хоол ид, хоол ид Офицер — Зүгээл,зүгээл, Оюуша хайчсаан

Хайдав— Одоо ирнэ. Та архи уу

Офицер — Хай, танай бас ууваа

Хайдав — Өршөө ноёнтон минь би лам хүн болохоор архи ууж болохгүй л дээ.

Офицер— / нүднийхээ шилэн дээгүүр сэжиглэнгүй харж / — Чи ямал сануутай өөлөө уухгүй байнаа Оюуша хайчсаан, Алхи бас холтой юу / буун дээрээ гараа тавина /

Хайдав / сандарч /— Үгүй, үгүй Аюуш одоо ирнэ.

Офицер — Чи эхлээд ууваа.

Хайдав- Жа /салгалж өөр нэг аяганд хийн хөнтөрснөө учиргүй хахаж цацан орхимжоороо амаа таглана.

Офицер —/Хо ... хо . . хо. . . //шудрага барьсаар Аюуш орж ирнэ /

Аюуш / айсан байдалтай / - Хүүе яанаа .Яасан бэ?

Офицер —Зүгээл, зүгээл лама алхиа уусан ваа хо хо хо / Аюуш руу муухай харж / - Чи хайчсаан

Аюушмаа — Ноёнтоон би ...би шудрага авчирсан.

Офицер — Шудлаа, шудлаа гэж юу байнаа

Аюушмаа— Энэ байна / хөгжмөө барьсаар ойртоно /

Офицер — Хай. Би мэдсээн шуу. Оюуша наашаа сууваа.Манай тоглосон баа. / Хайдав тайвширсан.

болтой 2 мөнгөн аяганд архи дүүргэж, офицерт 1-ийг нь өгнө / хоёулаа тулгана.

Аюушмаа— Ноёнтон би уудагуй

Офицер — Тэгвэл лама ууваа

Хайдав /сандарч / — Наана чинь шимийн архи хийсэн чи хурдан уу? би согтох нь / дуржигнуулна /

Офицер — Хай чи бас юу гэсээн

Аюушмаа /худал инээж / Аа энэ намайг эрхэм ноён таны төлөө хурдан уу гэнээ.

Офицер — Хай елөөлөөл болваа /ууцгаана /

Офицер — / Ихэд мэдэмхийрч/—Танай манай и ха дээл үеэс аха дүүс шүү.

Танай монгол Дундад уласын тасалхай болахоол биди хамгаалахаа л ирсээн баа. Гэтэл уунааг ойлгохгүй үхэл шига хүмүүс олоон байнаа шүү.

Хайдав — Жа тиймээ. /архи барина /

Офицер — Хэлваа та нал энэ талаал мэдвэл над хэлваа Аюушмаа — Ноёнтон хоол ид, Алив та наадхиа уучих /офицер ууна /

Хайдав/Хэл нь ээдрээтэн / Жа... Одоогоор бид тодорхой сайн мэдсэн зүйлгүй / Зальжинаар / Харин та энэ талаар хошуу ноён цэцэн чин ван Гомбосүрэнд айлтгавал яана.

Офицер / Ихэд ярвайж / Гомбасулэнд уу?

Хайдав — Жа тиймээ, Тэр чинь манжийн төрийг унагахад идэвхтэй оролцож гавьяа байгуулсан,

Богд гэгээний ойрын шадар хун, Тэгээд өөрөө тиймэрхүү ажилд оролцож байсан болохоор танд тус болж мэдэх туршлагатай хүн дээ.

Офицер / Ихэд дургуйлхэж / — Хай тэл хэлэггүй ваа, Гомбосулэн нада айлтгахаас, би түүнд айлтгахгүй шүү. /муухай харж / Гомбосулэн байтугай, танай Богда манай Да жунтаны хөлгөнд мөлгөсөөн шүү.

Хайдав: / халамцуу байдлаар / — Манай Гомбосүрэн ноён Богдоос ч илүү ухаалаг том хүн дээ.

Одоо хүртэл их хаан Тогоонтөмөрийн гэрийн буйрны ойролцоо өргөөгөө босгочихсон ихээ алсын хараатай суугаа эр дээ. Нэг л өглөө таны өргөөний үүдэнд сэлмээ сугалчихсан зогсож байж мэдэх л бий /Аюушмаа чимхэж Хайдав амаа барина /

Офицер / тамхи татан чагнаж сууснаа уурлан / — Хай танай бас тэгнаа ваа / буу руугаа гар нь явж босож ирнэ /

Аюушмаа / сандарч урдуур нь орж /—Ноёнтоон өршөөж хайрла, Энэ их согтож. Та бид нэг гэрийн ах дүүс гэж та айлдсан ш дээ. Энэ дэмий яриагаар яахав.Одоо хэдүүл жаал наргия./ Архи аягалж барина. Офицер амсаад тавина /

Офицер—Тэгваа тэгваа Оюуша энда сууван /хажуудаа суулгаж нална. Хайдав / сэргэсэн бололтой

/ Ноёнтон болгоож хайрла. Би таньд сайн санаж явдагтаа л анхааруулсан ухаантай юм. Би ч их согтож дээ...,Алив Аюушмаа ноёнтонд нэг ая бариач.

Аюушмаа-Тэгье, тэгье. Алив та наадахаа бариач / аягатай архийг нь авч өгөөд өөрөө шударга авч дуулна.

Мэлхий, мэлхий нэг л амтай яа

Хоёр хөлтэй дөрвөн нүдтэй дээ

Дэвхрэн цовхорн жүнзэнд орчихоороо

Жүнзүүтэй архийг хэн маань уух вэ хө

Офицер- Хай чи уухаагүй яахам. Ямал сайхайн дуу ваа / ширээн дээрээс архтай аяга вач бөхөлзөн өгнө/

Аюушмаа /аальгүйтэн/ Үгүй ээ.., ноёнтон та уу?

Офицер- Ай тэгбал хубаа ваа.

Аюушмаа-Тэгье, тэгье, та харин нэг ая бариач.., /архитай аягыг нь барьж уулгана/

Офицер -/Нилээд согтуу байдалтай/

Үйтэн хуалийн хэа чинаа элэгдэнаа ваа аа

Үнэнчаа нөхүүла нь хэлга болноаа Оюушаа хо / гэж дуулснааа гэнэт суудал дээрээ дэрлэн ойчно/

Аюушмаа /сандарч/ -Ноёнтоон, хүүе ноёнтоон /мөрнөөс нь татна/

Хайдав –Ноёнтоон /офицер үл дуугарна/

Аюушмаа –Одоо яана аа

Хайдав -/Мөрнөөс нь татаж / Ноёнтоон гэснээ ноёнтонг хоёулаа орон дээр унтуулъя гээд өргөтөл

Офицер – Хо.., хо.., хо / буун дээрээ гараа тавьсаар босч ирнэ/ Аюушмаа, Хайдав нар цочин ухрана.

Офицер- Хо.., хо..,хо Зүгээл зүгээл би согтоогүй лаа тоглоосон баа хо.., хо.., / гэснээ чимээгүй болж/ Халин танай тэл Гомбосүлэнг би Чэндууд, бальж хүлгүүлнаа шүү. Өөл ч танай муусайн ламын нал дотол олон дайсаан бий ваа шүү. Баялтай /ёслоод гарч одно. Гадаа нохой хуцаж буу тасхийн гасалснаа чимээгүй болно. Аюушмаа уулга алдаж Хайдав наминчлана. / Гэрэл зөвхөн Хайдав дээр тусна/

Хайдав- Ёстой нэг гамин ноёны загатнасан газар нь маажив биш үү. Одоо ч цэцэн чин ван

Гомбосүрэн чамайг миний өмнүүр хөндөлсөхийг харах юмсан. /Гэнэт бөмбөр цан дуугарч Гомбосүрэн ноёны хөрөг тайзны голд бууж ирнэ./ Хайдав бондгосхийн цочно.

Хайдав –Гэхдээ Гомбосүрэн ч уурга урттай, аюултай этгээд, ам хэлээ мэдээтэй байж тааламжтай цагийг хүлээх минь /Баян хүн таван хаанд нүүртэй гэгчээр..,/ Гэрэл зөвхөн Гомбосүрэн ноёны хөргөн дээр тусна. Хөгжим түүний фонон дээр хөтлөгч: Олноо өргөгдсөний тэргүүн он буюу 1911 онд Богд Жавзандамба хутагт тулгар төр байгуулах үйлсэд хүчин хавсран зүтгэсэн, Засаг төрийн бэйл Гомбосүрэнд цэцэн цол, чин вангийн зэрэг төрийн жүн ван хүрэн жолоо шагнаж дотоод яамны дэд сайд, чуулган даргаар тохоон

томилжээ. Үүнээс хойш Боржигин жанжин бэйлийн гэгдэж байсан хошууг цэцэн вангийн хошуу гэж нэрийдэх болсон ажгуу.

Боржигин цэцэн вангийн хошуу нь: 1 хондого 7 сум 44 отогтой байжээ.

Нэгдүгээр үзэгдэл төгсөв.

ХОЁРДУГААР ҮЗЭГДЭЛ.

Амгалангийн гэр

Амгалан дээлээ нөмөрч мөнгөн аяганд цай ууж сууна. Гэнэт хөл нүцгэн нөмгөн хөвөнтэй дээлтэй даарч чичэрсэн Жамбалдорж гүйн орж ирэхэд Амгалан цочин босон харайж аягатай цайгаа алдана.

Амгалан— Ээ Чойрын богд минь...

Үгүй чи чинь ...

Жамбалдорж — Цаана чинь сүйд боллоо давуу минь ... тий.. тий... тий... / дагжина /

Амгалан — Чи чинь Жамбалдорж шивдээ чи минь яахаараа ийм орой болсон хойно нөмгөн нүцгэн гүйж явдаг билээ.

Жамбалдорж — Чойр, чойр шатсан ганцхан Дүйнхор дацан л үлдлээ /тий, тий, тий /

Амгалан — Лам гурван эрдэнэ минь Би ч саяхан л мэдлээ, Хээ наад хөл чинь /сандарч ус хийн ирж

хөлийг нь дүрнэ /За за тайвшир, Халуун цай уу? Тэгээд юу болсныг тодорхой яриатах Жамбалдорж /Цай оочилж/

— Та ямар азаар өнөөдөр тийшээ зүглэсэнгүй вэ ?

Амгалан — Би баруун Чойрын гол сумд бурхан бүтээлцэх ажилд оролцоод очиж амжаагүй л дээ.

Жамбалдорж — Бид өглөө хурал номондоо цуглаж байтал толгой дээгуур хоёр гурван ч удаа нэг их хүчтэй юм пин пан гээд л нисч өнгөрлөө.

Амгалан — За уухайс даа / Суугаагаараа дөхнө /

Жамбалдорж — Эхлээд ч учрыг олоогуй байж байтал гамингууд буу шийдэм болсоор ороод ирлээ.

Амгалан — Тэгнээ тэр. Баруун Чойрт ч бас бүдэг бадаг пис пас гэсэн чимээ сонсогдсон юм.

Жамбалдорж—Тэгсэн чинь юу болсон гэж санана. /Хөмхий зууна /

Амгалан — Яасан гэж ..

Жамбалдорж — Хошуу ноён Гомбосүрэн, хамба лам Лэгшид , Чойр дацангийн гэсгүй Дамбаяринпил нарыг туусаар хүрч ирээд биднийг цуглууллаа.

Амгалан — Ээ сахиус минь ... Цөвүүн цаг ч эхэллээ дээ. Урьд шөнө даанч шөнөжин шар шувуу

инээж хоносон юм. / Санаа алдаж эрхээ эргүүлнэ /

Жамбалдорж—Тэгтэл гамин ноён Цахар Самдангаар хэлмэрчлүүлэн

— Танай лам нараас цагаантнуудтай сүлбэлдэж манай цэрэг руу буудлаа гэж баахан загнаж байснаа, засаг ноён хамба лам, гэсгүй гурвыг Бээжин хүргэнэ, Урвасан хулгай нарын уур болсон танай хийдийг хаалаа. Одоохон гэр гэртээ харьцгаа гээд дээш нь хий буудтал лам нар ч тал тал тийшээ бут усэрлээ.

Амгалан — Муусайн хар турлиахнууд холоос ирээд хот минийх гэдэг шиг юм болжээ.

Жамбалдорж — Би ч бараг өөрийн мэдэлгүй л, Дүйнхор дацангийн ойролцоох Чойр дацангийн уринх руу гуйж орчихоод харж байтал гамингууд учир зүггүй хий буудацгааж байснаа гал тавьцгааж эхэллээ.

Амгалан — Муухай хар гайхлууд..,

Жамбалдорж — Данангуудад толгой хорогдсон лам нар гал утаанд хахаж цацан гарч гүйхэд толгой дараалан буудаж унагаж байгаа нь харагдаж байлаа.

Амгалан — Болдогсон бол өөрсдийг нь ...

Жамбалдорж — Гал утаа юу юугуй ихсээд ирэхийн үед гэнэт чармай нүцгэлээд гүйвэл чөтгөр гэж бодоод буудахгүй өнгөрч амь хэлтэрч юу магад гэж бодоод л аз үзсэн чинь өмнө минь байсан хэдэн гамин эргээд зугтаалаа. Замдаа дүрвэсэн айлын босгон дээрээс энэ дээлийг олж нөмөрсөн юм. Би ч тэднээс айж тэд ч надаас айх шив дээ.

Амгалан — Сэргэлэн ч дамшиг бол за чи хэвтэж амар би хоол унд хийж өгөв /хэвтүүлж хучиж өгнө /

Амгалан / ганцаар / — Дүйнхор дацангаас бусдыг нь шатаана гэдэг чинь бараг 20- иод сум дуган хайлуулсан байх нь. Гайгүй дээ та нар ... орсон бороо арилж ирсэн гийчин буцдагсан ... / бодолхийлнэ / Чойрын хийдийн 5 дахь хамба лам, лам эрдэнэ Гочигдамбэл чойрыг дайн дажнаас болж мичин жил шатна гэж айлдаж байсан нь үнэн болж байх шив. Мөн түүнээс хойш 20-иод жил болоод тарна гэсэн нь ч ортой болж мэдэх нь ... /залбирч амандаа ном уншина //Гэрэл унтарч буун дуу ширүүсч, тэсрэлтийн чимээ дууддаж энэ тэнд гэрэл гялалзана. Аажмаар намсаж гэрэл асахад Амгалан бурханыхаа өмнө залбирч ном

уншиж сууна. Шар торгон дээлтэй нэгэн хувраг орж ирнэ /

Хувраг — Багшганы амгалан айлтгая Амгалан — Мэндээ, та дээшээ суу / гэснээ гайхсан байдалтай / чи чинь ..

Аюушмаа юу даа энэ их үймээн самууны үеэр хувраг хувцастай газрын хаанаас гараад ирэв.

Аюушмаа — Тиймээ би байна / Малгайгаа авна / Ядуу бид ч яахав дээ, Шатсан Чойр луу юм олох санаатай явж байж гамин руу довтолсон цагаантны талынханд баригдаад хүрээ орж тэндээс оргоод хар бор ажил хийж байтал ардын намынхан хүрээг чөлөөлөөд Дугар мээрэнгийн цэргүүд наашаа хөдлөхөөр нь цуг наашаа ирлээ. Юмыг яаж мэдэхэв гэж хувраг дээл олж өмссөн юм.

Амгалан — Тэр Дугар мээрэнгийн цэргүүд гэдэг чинь хаанахын цэрэг байна вэ ?

Аюушмаа — Муусайн гамингууд ч уул хадаар л нэг бутарсан байх.

Амгалан — Ээ энэ цөвүүн цагт чинь сэтгэл санаа ч уймраад мартамхай болох шинжтэй . Хувцасаа хөнгөлж цай уу идээ ид / Амгалан цай аягалж тавагтай идээ дөхүүлж тавина. Аюушмаа дээлээ тайлна/ — Урд шөнө даанч адтай буудалцаад байсан юм. Тийм учиртай байж... /инээмсэглэж /

Чамайг чинь би өдийд Хайдав аранжамбатай лхамт Оцол ууланд морилж яваа юм бодлоо.

Аюушмаа — Яалаа гэж дээ . Тэр чинь баруун зууд явж ном хаялцан дийлж, түвд орж Далай ламтай учирч явсан лут эр. Тэгээд ч бурхан бүтээж яваа бол над шиг эмээр ч яах вэ дээ

Амгалан — За,за тоглосон юм. Харин ардын журамт цэргийнхэн гэдэг чинь ямаршуу янзын гайхлууд байна.

Аюушмаа — Их л энгийн улс билээ монгол дээл, гуталтайгаа, өндөр шовгор малгайтай түүн дээрээ том улаан таван хошуу тэмдэгтэй .Харин дайсандаа бол өршөөлгүй

Амгалан — Мөөн ... / чих тавин сонсож эрхээ имрэнэ./

Аюушмаа — Зуумай хонхорт зуун гамина яах ийхийн зуургуй л цавчиж орхино билээ. / Буугаа гартаа барьсан гамин офицер ядарч туйлдсан бололтой гуйвсаар орж ирнэ /

— Яанаа. Яадаг билээ /Аюушмаа Амгалангийн араар гүйж орно

Амгалан — Ээ Чойрын Богд минь ... / амандаа ном уншина /

Офицер —Чш чимээгүй / буугаа чиглүүлэн ойртоно / — тайбишал ...тайбишал ваа ОО ... Оюуш чи наадыга таньхаагүй байнаа... тайбишал ваа ... / буугаа буулган хөлсөө арчина /

Офицер — / буугаараа зангаж / Чш ... аялхан аяалхан / эргэж харан хэсэг чимээ чагнаснаа буугаа хуйлж сууна /

Амгалан — / Цай хийж идээ өгнө /

— Ноёнтон зоогло./ Офицер хурдан авч асгаж цутгалан идэж ууна.

/ — Хөөрхийдөө хэний ч үр ялгаа юу байхав их өлсөж дээ, /Тараг хийж өгнө, Офицер идсэнээ ойчих янз үзүүлснээ үүрэглэж эхлэнэ.Аюушмаа айсан байдалтай харсаар зогсоно. /

Аюушмаа /шивнэж/—Чойрын хийдийг шатаалгадаг даамал чинь энэ шүү дээ . / Офицер буун дээрх гараа унжуулж хурхирч эхлэнэ /

Амгалан / зэвүүцэнгүй /— Тийм бий ... Бурхан шашныг өрнүүлэгч Балдандашгомилон хийдийг минь хайлуулчихаад энэ муу илжиг ямар нүүрээрээ манайд орж ирдэг байнаа

Гамин давхийн өндийж ийш тийш харснаа үүрэглэж ширээ дэрлэн хурхирч эхлэнэ.

Аюушмаа — Буруутны бурхан таалдаггүй гэдэгүйсэн биш билүү ламтан минь Амгалан / тэд хоорондоо дохилцоно/—Тэр үнэн /орхимжоо барьж гаминруу дөхнө / Нүгэлтийг гэсгээх нь буян болдог ч тал бий / Аюушмаа ширээн дээрээс зэс домбо авч далайна. Гэрэл унтарч гамин орилох дуу тасхийн цохих чимээ 2 удаа гарч чимээгүй болно./

1-Р БҮЛЭГ 2-Р ҮЗЭГДЭЛ ТӨГСӨВ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

3-Р ҮЗЭГДЭЛ. Хайдавын гэр Хайдав бурхан зурж сууна.

Далдаас: Бүхий олон багачуудаа

Бүрхсэн улаан цэцэрлэгтээ

Бүр шинээр үүссэн

Бүжиг наадмаар наадацгаая аа Бэлхэн ээ. /гэж дуулан алхаж ойртон ирнэ. Хайдав зурахаа больж чих тавин чагнана. /

Хайдав — Энэ улаан хувьсгалын зулбасганууд чинь мөд буу бариад ороод ирэх нь шив. / Эгдүүцсэн байдалтай чагнана /

Далдаас: Нэг хоёр, зогс, эргээд, алхаад марш / бүрээ бөмбөр дуугарч алсрана/

Хайдав — Ороод ирэх нь үү гэтэл арай л үгүй бололтой /Гаднаас орхимжгүй лам дээлтэй, дээлнийхээ энгэрт юм залган битүүлсэн Жамбалдорж орж ирнэ. Хайдав цочисхийнэ. /

Жамбалдорж— Аранжамбатны амгаланг айлтгая !

Хайдав — Сайн л байна. Энэ чинь яасан сонин хүн явж байх юм дээшээ морил. / Юмаа хураангаа /

Ойрд уулзаагүйг хэлэх үү...,Наад дээл хувцас чинь ... лам ч биш хар ч биш болчихоо юу даа.

Жалбалдорж /эвгүйрхсэн байдалтай/ — Хм ...Миний энэ ч манж захтай дээл л дээ ... Цаг төр үймэхээр мань мэтийн улс ч өнөө маргаашаа л бодох юм байна шүү дээ. Хайдав минь.

Хайдав /худлаа хөхөрч / Тоглосон юм. Жа ламтан юу гээчийг хийгээд байна даа /Цай хийж өгнө ... хөөргөөр тамхилна.

Жамбалдорж / суудал дээрээ займчин /—Ламаа ч алддаа... Өөрийг чинь Оцол ууланд бясалгал хийж явахад чинь би ч хар болоод зогсоогүй, тэнхимд ажиллаж байгаа шүү дээ ... харин та нөгөө бурханаа дууссан уу. Хэзээ ирэв дээ.

Хайдав — Би ч яахав. Уулын жаргал шиг тэнэж тэнэж иртэл төр эргэчихэж, чамаас авахуулаад яриа ч таарахааргүй болж байгаа юм шив дээ ... Харин Их зуу бурханаа дуусгаад Чойр дацангийн дуганд залсан ухаантай.

Жамбапдорж — Яамай даа.

Хайдав—Танай тэнхимийн хүүхдүүд чинь дуулаад ч байх шиг хэг хоёр, хэг хоёр гээд тоолоод алхаад ч байх шиг, заримдаа ганлин, хэнгэрэг маягийн юм дуугараад ч байх шиг юм аа.

Жамбалдорж — Тэд чинь үндсэндээ бас нэг шинэ маягийн шашин юм байна шүү.Би тэдний тогоо шанагыг нь барьдаг юм. Манай Чойрын лам нар уншлагатай, сахиус чойготой, цан хэнгэрэгтэй бол

тэнхимийн хүүхдүүд чинь тангарагтай , зангиа, тэмдэгтэй, тэгээд бас дуутай бүрээ бөмбөртэй гээд бод л доо.

Хайдав — Нээрээ тийм ч юм уу тэгээд тэр тэнхим гээчийг чинь хаанаас удирддаг хэрэг вэ?

Жамбалдорж — Хан хэнтийуулын аймгийн Оцол сансар уулын хошууны тэнхим гэдэг болохоор хошуу тамгын газар л мэдэж таарна . . / Хайдав чимээгүй толгой тохиж сууна /

— Ээ дээ давуу минь одоо ч Чойрын хийд хэдий удаан оршин тогдох бол доо , Бурхангүйчүүдийн эвлэл гээд бас нэг юм гараад ирсэн.

Хайдав: — Чи чинь бүр байсаар улааныхны номыг надад сурталдах нь уу даа.

Жамбалдорж — Чи юу л гэж бодвол бод. Хурдхан бараан дүр залсан чинь онох бий вий ... Харин нөгөө Гомбосүрэн ноён Бээжингээс эргээд ирсэн байна билээ шуу.

Хайдав / эгдүүцэх янзтай/ Мөөн ... нөгөө хамба лам, гэсгүй хоёр нь яасан юм бол ?

Жамбалдорж — Мэдээж диваажинд залраа байлгүй. За даа үг олдож, үхэр холдлоо би ч явъя даа. / гарна /

Хайдав : / ганцаараа бухимдангуй / — Үгүй ерөө, энэ муу Жамбалдорж саяхан цавын

будаа горьдсон

Дүйнхор дацангийн доожоогүй шавь явсансан. Одоо харин надад сургамж хайрлах санаатай.., их эд байх нь. / хамрын тамхи татаж бодолхийлнэ / За гайгүй ээ ...Би ч бас цагийн аясыг дагаад хөвж чадахгүй гэж уу ... Могой газрынхаа өнгөөр гэдэгсэн / Аюушмаа эхнэр мөртэй торгон дээл өмсөж урт үсэндээ сувдан даруулга зүүж их л баясгалантай орж ирнэ /

Аюушмаа / инээд алдсаар /—За миний хамба ламтан яагаад барайчихаа вэ? Хайдав/хэгжүүн /

Харин чи юундаа нэг их гоёж гоодож, баясаа вэ? улаан гэрт очих гээ юу ?

Аюушмаа— Хэг ёг гээд л чи уурлаад байгаа юм уу.., Энэ дээлийг хараач Цогдарь ахайтан надад өгсөн юм ямар байна вэ? зохиж байгаа биз дээ / эргэлдэнэ. Хайдав үл дуугарна/ Гомбосүрэн ноёнг феодал энэ тэр гээд баривчлаад явсан гэнэ.

Хайдав — За тэр дээ /хашгирч босч ирнэ Аюушмаа цочин гайхаж зогсоно/ Цогдарь тэгж дээлээ хунд зүгээр өгөх тэнэг амьтан биш.Могой газрынхаа өнгөөр гэгчээр хумсаа нуусан муур шиг ядуу зүдүү хүн болох гэж юмаа тарааж байхад чи...чи муу?Мал....

А юушмаа /уурлаж / — Би яачихаа вэ?

Хайдав — Би яачихаа вэ? гэнээ... Үгээгүйчүүдийн засаг бий болчихоод байхад баригдсан ноёны хатны дээл өмсчихөөд ... миний толгойг цусдахаас сийхгүй өдрөөр наашаа гүйнэ гэнээ /уухилна/

Аюушмаа /хэдэрлэж /—Тэр засаг чинь та бид хоёрт ямар хамаатай юм бэ?

Хайдав — Хамаатай /хашгирч барьж авна / Чи яасан ганган, баян хүүхэн бэ? /дарж унаган өрөөсөн мөрийг нь / дээлнийх нь /тас хяргана /

Аюушмаа/уйлж Хайдавыг алгадна/—Чи чинь солиороо юу? Тавиач ээ...

Хайдав/амьсгаадан /Аа чи бүр зодож байна уу? Чи...чи ямар гоё сувдан даруулгатай авхай вэ / үсийг нь тас хяргана/

Аюушмаа /уйлж/—Ээ Чойрын богд минь... Энэ чинь бүр галзуурчихаж...

Хайдав — Тиймээ би галзуурч байна. Тэгэхдээ чам шиг харалган биш.., Сохрын газар сохроор гэдгийг санаж явахгүй бол амиа ч алдаж мэднэ шүү чи ... зайл / хашгирч үүд рүүгээ заана /

Аюушмаа хяргуулсан гэзгээ тэвэрч уйлсаар гүйн одно.

Хайдав — Одоо цаг улам бүр цөвүүн болж байхад ийм тэнэг эмтэй зууралдахгүй байсан минь дээр / бодол хийлнэ /

— Ер нь энэ хэдэн бурхан тахилаа түр хугацаагаар хураах минь. Улааныхан нэг л өдөр

хэлтгий захтай болгоныг хүйс тэмтрэхийг үгүй гэх газаргүй...юуч болсон цагийн аясаар хөдлөх гээд улье.../ Гэрэл унтарч, Тэнгэр дуугаран цахилгаан цахиж бороо орно. Гэрэл асахад энгийн даруу хувцасласан Аюушмаа Амгалангийнхэнд орж ирнэ/

Аюушмаа — Ламтны амгаланг айлтгая

Амгалан — Мэндээ. Энэ их усан бороо дундуур яаж яваа чинь энэ вэ?

Аюуишаа — Амьтны нүд хариулж таныг л зориуд зорьж ирлээ.

Амгалан — Цай уу идээ ид.

Аюушмаа / цай амсаад өврөө уудалж баранзад хадагтай, жижиг гуутай зураг гаргаж/—Мичин жил гамингууд Чойрыг шатаахад Лам- эрдэнийн өргөө хамт шатсаныг та мэдэж байгаа... Хожим Должин санг шатсан өргөөнийх нь үнс чандрыг цэвэрлэж байгаад энэ зургийг олж тахиж байснаа надад өгсөн юм.

Амгалан /уулга алдаж /— Ээ лам гурван эрдэнэ минь...Наад зураг чинь миний мэдэхийн 2 дахь удаагаа шаталгүй үлдэж дээ, Лам - эрдэнийн эхний өргөө зулнаасаа болж хайлахад буйран дээр нь зүгээр үлдсэн гэдэг шүү дээ / залбирна /

Аюушмаа — Би энэ хөрөгийг тахиж байсан боловч одоо нэгэнтээ Чойрын хийд маань сүсэгтэн, олны буянаар дахин сэргэж, Лам- эрдэнийн маань 3 дахь өргөө дахин боссон тул үүнийг залж өгөхийг хусэж багш таньд өргөн барья аа.

Амгалан /Хадагтай зургийг авч адис аваад бурхныхаа хажууд тавина/

— За би ойлголоо. Должин та хоёр их буянтай үйлс бүтээлээ... Харин чи энэ зургийг наашаа барьж явахаар аранжамбтанд өгөхгүй яагаав.

Аюушмаа — Багш минь цаг төр үймэхийн хирээр хүн хүн л янз бур хувирч байх шиг байна. / Санаа алдана /Хайдав ч бурхан тахилаа хурааж, лам дээлээ сольчихоод, ойрноос Очир бөөг л дагаж харайлгаад байгаа

Амгалан — Мөн ч сонин юм даа. Хайдав ч ном эрдэм, гарын ураар манай хийд дээ л том ламын нэгсэн ... нөгөө Жамбалдорж ламтан бараан дүр залснаасаа хойш ер уулзалдсангүй. Чи дайралдаагүй биз.

Аюушмаа — Жамбалдорж гуай ч эхлээд тэнхимд тогооч хийж байснаа хошуу тамгын газарт ажилладаг болсон бололтой, суран бус савхин малгай гуталтай , бараг суганаасаа газар шүргэх шахам алтан шармал сэлэм зууж явдаг болсон байна билээ.

Амгалан — Мөөн мөн, Бурхан минь үнэн байх нь. Чойр дацангийн Данжин сахиусны шүтээний бурханы Жансагийн сэлэмийг хурааж аваад явлаа гэсэн. Өөрөө зүүж л дээ. / Ярвайж зүрхээ дарна /

Аюушмаа — Яав аа таны бие чинь зүгээр үү.

Амгалан — Гэмбэлийн бугийг даралцсанаас хойш нэг л базаадагуй. Үе үе лагшин чилээрхэх боллоо.

Аюушмаа — Тэр бугийн чинь баруун Чойрын Жамъян зоч ирж « Сэрээдарж устгалаа гээгүйсэн биш билүү »

Амгалан — Тийм нь ч тийм. Тэгэхдээ хоёр гамин чөтгөрийг нь алдчихлаа, Бусдыг нь дарлаа гэж өөрөө айлдсан юм. Харин тэр чөтгөрүүдийн нэгнийх нь барьж байсан юншихайтыг Жамъян зоч над хадгалуулсан юм. Энэ байна. / гаргаж үзүүлнэ/

Аюушмаа / айсан гайхсан байдалтай /—Өө тийм үү / юн шихайтыг үзэж / буцаан өгнө.

Амгалан — Үнэхээр ч Гэмбэл сүүлдээ солиорч шахам нас барсан . Баруун Чойрын ловон / лам хувилгаанаас Агваанданзанняямаас / асуулгасан чинь « Жамъянгийн хэлдэг үнэн байна» гээд

Балданчойдог ламтанг ирүүлж ном уншихад нь намайг туслалцуулсан, юм.

Аюушмаа — Тэгээд яасан бэ дарж чадсан уу?

Амгалан — Чадах ч чадсан харин майхны гол нуруунд бэхэлсэн хэнгэрэг унаж Балданчойдог ламтны толгойг шалбалж намайг унатар цохисон ч номоо таслалгүй уншиж байтал Жамъян зочийн хэлснээр яг 2 хятад майхны үүдэнд узэгдээд алга болсон Нэг нь чи бид хоёрын тэр жил цааш харуулдаг даамалтай тун төстэй байсан шүү.

Аюушмаа — Бурхан минь...Ямар аймаар юм бэ ?

Амгалан — Чи Хайдавт дуулгана биз би биеэ нэг үзүүлмээр л байна.

Аюушмаа — За,за бороо ч намжих нь би явья даа/гарна/ гэрэл

3-р үзэгдэл төгсөв.

4-Р ҮЗЭГДЭЛ.

Амгалангийн гэр. Хайдав, Амгалан нар гаднаас ярилцсаар орж ирнэ. Хайдав шувууны 3 өд хатгасан малгайрхуу юм өмсөж духан дээрээ гуулин толь байрлуулж нүүр рүүгээ хар утсан тунараа унжуулж, захгүй ногоон цамц, гуя нь харагдсан богино өмд өмсөж бүсэлхийгээрээ олон өнгийн тууз ороон жижиг хонхнууд дүүжилж, том махир сэлэм зүүж, хүзүүнээсээ жижиг мөнгөн гадас гинжилсэн харагдана. Мөн хэц хэнгэрэг үүрсэн харагдана.

Амгалан — Чамайг чинь Очир бөө л гэж бодлоо шүү. Цагийн аясаар та нар маань хувьсаж байгаа нь тоогүй, Чи уг нь намайг бодвол ном эрдэмд нэвтэрхий ингэж явхааргүй хуврагсан.

Хайдав — Давуу минь, Бурхан шашныг өрнүүлэгч ариун догшин « Балдандашгомлин » хийд маань харин одооноос элдэв шахалт хавчилтанд удаа дараа өртөж бараг байсан байгаагүй адил болоод байна шүү дээ... Тэгэхээр могой газрынхаа өнгөөр гэгчээр ингэж

явахаас өөр яахав.

Амгалан — Гэхдээ л ардын засаг хийдийг маань юу юугүй хаачихаагүй байна. Харин доод гаралтай нилээд лам нарын оюун санаанд нөлөөлж тэд бараан дур залсан нь үнэнтэй.

Хайдав— Одооходоо энэ хувьсгалчид чинь ноёд түшмэдтэйгээ үзэлцээд байгаа бололтой. Чи дуулаа биз. Гомбосүрэн ноёнг феодал гээд бариад явлаа гэсэн ... Дараахан нь хөрөнгийг нь хурааж, түүнээс болоод Цогдаръ хатан галзуурч Оцол уулын оргил өөд гүйж гараад олдоогүй байгаа сурагтай

Амгалан— Чойрын богд минь... Бүсгүй хүн бэлээс нь өөд өгсдөггүй уулын тэргүүн дээгүүр галзуу ч гэсэн эм хүн гишгэлсэн нь сайны ер биш ... Ум базар ваань хум пад.

Хайдав — Дэмий ч биш дээ. Өврөөс боссон чоно аюултай гэгчээр нөгөө Жамбалдорж час улаан хувьсгалч болчихсон, Манба дацангийн хэдэн маарамбыг ард олны эмчлэх нэрээр толгойг нь эргүүллээ. Төр шашныг тусгаарласан хуулийн дагуу «та нарыг буудчихсан ч чадна» гэж занаж явна гэнэ лээ.

Амгалан—Дуулсаан. Өвгөн дэмч Ламбуу гуайг эсэргүү хэмээн баривчилж хошуу тамгын газар хүргүүлсэн боловч олон шавьтай гэхээс өөр гавьтай хэрэг гэх юмгүй болохоор нь буцаасан гэсэн.

Хайдав — За тэр дээ, чи ч гэсэн одооноос бараан дүр залсан дээргүй юу?

Амгалан — Үгүй дээ, Хайдав минь, Цаг ямраар ч эргэсэн энэ яваа насаа хамаг олны тусын тулд зориулсаар л дуусъя.

Хайдав / ёжтой /—Ариухан ч хувраг бол доо. Аюушмаа та хоёр чинь тэр жил гамин ноён нухаж нүгэл уйлдсэн юм биш үү.

Амгалан / сандарч / — Бурхан гончигсум минь. Тэр ч арга буюу хийсэн нүгэл. Нас ахихаар нүгэл ихэсдэг гэдэг үнэн бололтой.

Хайдав — За тэр ч яахав. Чамайг Гимбэлийн бугийг даралцахад оролцож бузартснаас бие чинь тааруу гэдгийг сонсоод ирлээ шүү дээ.

Амгалан — Үгүй ээ Хайдав минь чи тэгээд номын хувцастай ирэхгүй дээ. Бурханы шашины номонд бөөгийн ёс зохицдоггүйг чи мэдэх хойно доо

Хайдав / үл тоомсорлон / Хн... Тэртээ тэргүй шарын номоор дийлэхгүй байгаа буг чөтгөрийн үлдэгдлийг харын номоор дийлэхийг хэн байг гэхэв.Гимбэлийн бугаас чамд шингэснээс зайлаа гэж уу.

Амгалан — Харин л дээ зув зүгээр байж байгаад заримдаа нүдэнд элдэв юм үзэгдээд муужрах шахах юм.

Хайдав—Тэр шүү. Олон юм бодоод байлгүй энэ сэлэмийг галдаа хийчихээд энд дээлээ

нөмөрөөд хэвт. Би нэг аргалахыг бодъё.

Амгалан / тээнгэлзээсхийн сэлмийг галдаа хийнэ /—Базарваанъ хум пад

Хайдав — За,за хэвт хэвт /Хэвтүүлж хучсанаа хэнгэргээ дэлдэн гуагалж эхэлснээ тургилна.
Гэрэл бүдгэрнэ. Амандаа шившиж байснаа:

Хан тэнгэрт залбирсан

Оцол ууланд тахилгатай

Хатан дэлхийгээр тэнүүчилсэн

Өвгөдийн сүнс сонсож бай

Нүдэнд үл харагдах

Чөтгөр шулмасыг даралцаж хайрла

Нүгэлт нэгэн хуврагийн

Амийг өршөөж хайрла

Хүний мах хэрэгтэй бол

Надаас нэгэн үмхийг ав

Хүрэн цус хэрэгтэй бол

Надаас нэгэн балгыг ав.

Тургилж хэнгэргээ улам хучтэй балбаснаа тэмээ шиг буйлж, хэрээ шиг гуагалж байснаа хэц хэнгэргээ шидчихээд үсэрч сэлмээ суга татан авчирч Амгалангийн дээрээс ишинд нь тултал шаана.

Өөрөө найган ойчно.

Гэрэл хөгжим

Морин төвөргөөн сонсогдсоор гэрэл асахад Амгалан гэртээ ном уншиж сууна. Монгол дээл савхин, малгай гуталтай, бичгийн ширэн цунх, газар шүргэм урт сэлэмтэй Жамбалдорж орж ирнэ.

Амгалан — Сайн явж байна уу? ямар сонин хун бэ?

Жамбалдорж /дурамжхан /За,за сайн Хн: — Хөдөөний хөгшчүүл хүртэл гэгээрч үс гэзгээ тайруулж бурхангүйчүүдийн эвлэлд элсэж, бурхан тахилаа хураачихаад байхад чи яг хэвээрээ учрыг нь олохгүй байж нөгөө л бурханы номоо шагайсаар шив.

Амгалан /Номоо баринтаглангаа/—За давуу минь хаа хүрээд явж байна даа?

Жамбалдорж —Давуу гэнэ шүү / дуу нь чангарч /— Чи ер нь яасан гэгээрдэггүй нөхөр вэ? Наана чинь Хан хэнтий аймгийн Оцолсансар уулын хошууны тамгын газрын төлөөлөгч, улаан хувьсгалч нөхөр Жамбалдорж зогсож байна. Чиний тэр хуучны давуу биш яасан хоцрогдсон этгээд вэ чи.

Амгалан — За чи битгий нохойтоод бай

Жамбалдорж / Улам уурлан сэлэмнийхээ бариулаас атгаж / — Дуу чи муу шар хувалз, Байтлаа надтай зиндаархах санаа байна уу?

Амгалан/Урам хугарсан байдалтай/—Төлөөлөгч гуай сууж, манз зоогло.

Жамбалдорж — Манз гэнэ шүү. Цай гээч чи / цай хэд ойчилсноо / Хөдөөгүүр явсаар бүр ядарч гүйцлээ. Ядаж чийчаан маань танайхаас нилээд зайтай унтарчихаад...

Амгалан — Тэр ч ёжбоо шожбоо хоёр нь холилдчихоо л биз.

Жамбалдорж / цухалдангуй / — Чи чинь бас юуныхаа ёжбоо шожбоо гэж хоцрогдсон юм яриад эхлэв.

Амгалан— Тос ус хоёр нь холилдсон юм биш үү гэж байна.

Жамбалдорж /эвшээлгэж ядарсан байдалтай хувцасаа тайлна /

— Тэр бас боддог бодол / гутлаа тайлан / юу ч болсон жаахан хэвтэж амрангаа би чамд шинэ эргэлтийн бодлогоор лекц уншина / Цунхээ уудалж ном гарган хэвтэнэ/ Чи энэ хоёр гутлыг хатавчиндаа нааш нь харуулаад зэрэгцуулж цэргийн дүрэм ёсоор тавьчих ../хөгжим, Жамбалдорж уншиж байснаа үүрэглэж улмаар хурхирч эхлэнэ/

Амгалан — Мөнч сайн лекцилж байх шив, за даа гарч хийж байсан тэргээ дуусгая / гарна /

Жамбалдорж/ гэнэт цочин сэрнэ / — Хөөе чи хаана байна.Хүн лекц уншиж байхад гараад явчихдаг ямар янзын нөхөр вэ?

Амгалан /орж ирнэ/—Аа би морь хараад ирлээ. Та ямар сайхан уншдаг юм бэ ?

Жамбалдорж / босож нэрэлхэнгүй / — За нэг тамхилцгаачихуу / хайрцагтай тамхи гаргана./

Амгалан — Иш ... Жамбалдорж минь.Би бурхан тахилынхаа дэргэд тамхилж сураагүй хүн шүү.

Жамбалдорж—Өө тийм үү.../ёжтой инээмсэглэн тамхиа асааж хэд сорсноо аман дахь утаагаа бурхан руу нь үлээж хувцасаа өмсөнгөө /

— За ингээд бурхан чинь шинэ цагийн тамхиар тамхилчихлаа... харин чи битгий маяглаад байгаарай Далай ламын чинь зургийг хураалаа харин энэ бурханд мөргөж явбал өлзийтэй байх шүү / Лениний зураг гаргаж бурхных нь өмнө тавина / Дараа тухтай уулзнаа гайгүй.

Гэрэл, хөгжим.

2-рБҮЛЭГ 4-р ҮЗЭГДЭЛ ТӨГСӨВ.

3-Р БҮЛЭГ 5-Р ҮЗЭГДЭЛ.

1-р үзэгдлийн тайз. Сумийн гол хаалгаар Амгалан гарч ирнэ. Аюушмаа таарна/

Аюушмаа — Багшганы амгаланг айлтгая

Амгалан — Мэндээ. Ойрд харагдахгүй яагаав.

Аюушмаа — Хошуу тамгын газар зарлага хийж байгаа болохоор зав муутай л байна.

Амгалан — Мөөн. Тэгээд алба тавлаг уу ?

Аюушмаа — Хөл хөдөлгөөн ихтэй л байна. Урд шөнө дотоодыг хамгаалахын төлөөлөгч Хайдав аранжамбатан 4 цэрэгтэй ирсэн.

Амгалан /гайхаж/—Манай Хайдав уу?

Аюушмаа — Харин тиймээ ... Манай ч гэждээ. Хайдав цэргийн дарга хувцас өмсөж, үг яриа нь хуртэл их боловсорчихоод ирсэн байна лээ.

Амгалан — Уг нь цаадах чинь өнгөрсөн жил нийслэл хурээ рүү агромын дамжаа барихаар яваагүйсэн биш бил уу?

Аюушмаа—Тэгэхдээ л одоо чекист гээч юм болоод ирсэн юм байхаа ... Би хэдэн лам нарт зар хүргэх учиртай жаахан яарч явна .../явна/

Амгалан / ганцаараа / — Энэ олив Хайдав ч ёстой могой газрынхаа өнгөөр гэгчээр хувирч байх шив / Бодолхийлэн /

— Шинэ эргэлтийн бодлогоор төр шашныг тусгаарласан ч шашныг хуулиар хориглоогүй. Гэхдээ л залуу лам нараас цэргийн. татвар жасуудаас 100 бод тутмаас 25 бодын татвар авдаг нь ихээхэн дарамт болж байна даа ядаж манай Чойр, Дүйнхор, Жүд, Манба дацангууд овоо хэдэн малтайг хэлэх үү.. . 1930 оны баривчлагаар мөн ч олон сайн эрдэмтэй лам нар, оточ, зурхайч, үзмэрч хуврагууд эрсдсэн дээ. Одоо ч бас л цаг ээдрээтэй болж эхэллээ. Олив

Хайдав гэнэт чекист болоод ирдэг / Олби / яавч сайны ёр биш /явна /

Нөгөө талаас дотоодыг хамгаалахын хувцастай ташаандаа буутай Хайдав,Жамбалдорж нар

гарч ирнэ.

Хайдав— Тэр цаашаа явж байгаа чинь Амгалан уу даа?

Жамбалдорж — Тийм л байна. Гэгээрдэггүй муу шар хувалз даа. Ганц энэ ч биш. Чойрын хийдийн хэдэн лам өнөө хир сум дугандаа шигдсээр л байна.

Хайдав / ихэмсэгээр /—Маргааш өглөө Ламжамаа төлөөлөгч ирнэ. Тэрнээс өмнө амжаад өнөөдөртөө багтааж Жүд, Дүйнхор дацангийн цамын бурхадын хувцас чимэг багийг Улаанбаатар руу ачуул Ганжуур Данжуурын 108, 228 ботийг олшруулж байсан мод чулуун барыг ч мөн адил, эсэргүүцэх хүн гарвал дор нь баривчлах буюу бууд.

Жамбалдорж — Жа, Мэдлээ.

Хайдав — Та нарын дээр хурааж явуулсан Дамдин Чойжоо бурхны багных нь өрөөсөн эвэр дутуу очсон шуу. Дахиж тйм алдаа гаргавал уу...

Жамбалдорж — Жа, Мэдлээ.

Хайдав — Харин хар өнгийн цаасан дээр алт зооглуулж есөн эрдэнээр зүмбэрлэж урласан Ганжуур,

Данжуурын хөлгөн судрууд тоо ёсоороо очсон,

Мартсанаас Лам-Эрдэнэ Гочигдамбэлийн шарилыг ухаж үз гэж төвөөс даалгасан шүү.

Жамбалдорж — Тэр чинь ардын засаг байтугай нь одоогоос 100- гаад жилийн өмнө таалал төгссөн шүү дээ.

Хайдав /уцаарлангүй / Тэр хамаагүй ээ түүний эсэргүү нөлөө одоо ч асар их байна. Зураг нь шатдаггүй, цогцосыг нь хайлуулахад гавлынх нь яс шатаагүй дотроо маанийн үсэгтэй ч гэх шиг.

Түүний улаан халзтай өргөөг ч хурааж ачуул.

Жамбалдорж — Жа, Мэдлээ.

Хайдав — Би энэ хийдийн ихэнх эсэргүү лам нарыг өнөө шөнө тогтсон цагт ачиж явна. Замдаа хагасынх нь бодийг хөтлөнө... Ламжамаа төлөөлөгч маршалын тушаалаар хоёр машин цэрэгтэй наашаа хөдөлсөн маргааш өглөө цэргүүдээ ууланд орхичихоод өөрөө жолоочийн хамт энд ирнэ.

Төлөөлөгчийн аюулгүй байдлыг чи хариуцна шуу. Энэ бол онцгой даалгавар.

Жамбалдорж — Жа, Мэдлээ.

Хайдав — Зүүн Чойр ч тэгэсгээд нүвлэх биз. Юмыг яаж мэдэхэв. Лам нар зэвсэглэн

хөдөлбөл юуны түрүүнд төлөөлөгчийн амийг аварч, ууланд бүтсэн цэргүүдэд хэл хүргэ

Жамбалдорж — Жа, Мэдлээ ...

Хайдав — За ийшээ миний хойноос ...орцгоох шив дээ/Хийд руу орцгооно /

Гэрэл унтарч гуниглуун хөгжмийн фоно: Хөтлөгч: 1919 оны гамин , бароны довтолгооноос эхлэн хэлмэгдэж эхэлсэн Боржигин цэцэн вангийн. хошууны зуун Чойрын хийд аргын тооллын 1938 он билгийн тооллын 16-ржарны шар бар жилийн зун хэлмэгдэлтэйгээр нүвэлэн таржээ. Гэрэл асахад

Амгалангийн гэр, Цэрэг хувцастай Хайдав орж ирнэ. Амгалан уншиж байсан номоо хойш тавин угтан босч.

Амгалан — За амархан сайн морилж явна уу? / Золгох гэнэ /

Хайдав/ Их л хөндий/ — Дараасчий / өрөөсөн гараа сунгана /

Амгалан / инээмсэглэн /—Бушдуу/гарыг нь хоёр гараараа атгана.

Хайдав/гараа суга татан авч хялалзан / — Чи бас хятадуудыг мартаагүй л байна уу ?

Амгалан—Хаанаас даа, давуу минь өөдөө сууж манз, цав зоогло.

Хайдав / Цай дуртай дургуй оочих болсноо /— Чи, танай хийдийн хэдэн лам нар хэзээ ухаан суух улс вэ? Халхын олон хүрээ хийдууд хурал номоо орхиж, дуган сүмээ хаачихаад мал маллах нь маллаж, цэрэгт явах нь явж, үйлдвэр хоршоонд ажиллах нь ажиллаж байхад та нар л хуучин янзаараа учир мэдэхгүй түвд номтойгоо зууралдаж суудаг.

Амгалан — Тийм ч биш шүү Хайдав минь. Манай Чойрын хийдийнхэн чинь сайн цагийн мянган бурханыг бүтээгчид төдийгүй, хурал номын мөр хөөсөн хэн бүхэн урлахуйн ухаанд давхар суралцаж ухаант мэргэдийнхээ сайн сайхан бүхнийг өвлөн авч хамаг амьтны тусын тулд буян үйлдэгч томоохон төв гэдгийг чи мэдэж байгаа

Хайдав / ёжтой / — Урьдын юм ул болж шинэ юм зул болж байгааг ойлгооч чи ! Баригдаад явсан лам нар чинь буцаж ирэхээсээ өнгөрсөн. Эсэргүүнүүд хувьсгалын улаан лантуунд няцлагдсан...

Амгалан— Эй... Чойрын Богд минь /амандаа ном уншина.

Хайдав — Би ч бас эсэргүүний зарим үлдэгдлийг цэвэрлэхээр ирээд байна.

Санжуураг Санжаажамц, Яшил Түвдэнгийн хоёр чинь ойролцоо байдаг байхаа.

Амгалан / хэгжүүн /— Өөрийн чинь хүрээ рүү Агромбын ламжаанд явсан хойгуур Санжуураг маань дөрвөн мааньт руу яваад эргэж ирээгүй шүү дээ. Хадан гэрт нь л очвол уулзаж магадгүй дээ.

Хайдав / цочин чимээ чагнаснаа / — Дуу чи яасан доогтой муу эсэргүү вэ чи. Оронд нь тэгвэл чамайг авч явна даа / шазруун / дулаан хувцасаа бэлдээрэй.

Амгалан / тайвнаар / Өөрөө л мэддээ Чойрын хийдийн лам нар дотоодыг хамгаалахын төлөөлөгч таны бүтээсэн Их зуу бурханы чинь зул хүжийг өдий болтол таслаагүй л байх.

Хайдав — Дуу чи / буугаа суга татан босон харайж Амгаланг заамдан авна/ — Чи яасан их хуцдаг нохой вэ? Дахиад дэмий юм чалчвал дор чинь буудчихна шүү/ Чимээ чагнан ийш тийш харснаа/—

Бос чи ..Амгаланг тууж одно. /Гэрэл хөгжим/

5-р ҮЗЭГДЭЛ ТӨСӨВ.

ТӨГСГӨЛ ХЭСЭГ

Цагаан Дарь-Эх бурханы өмнө нөмгөн ядарч туйлдсан Амгаланг Хайдав туусаар гарч ирнэ.

Хайдав/буугаараа занган /—За чи энэ чулууны тухай юу юу гэж дэмий донгосоод байдаг билээ.

Тэрнийгээ нэг яриадах.

Амгалан. / амьсгаадан. /—Тэр бол ариун бөгөөд үнэн юм чинь. Чи мартсан бол тогтоож ав... Зуу гаруй жилийн өмнө. Чойрын хийдэд гай дайрахад ганц хүүтэй Дарьмаа бусгүй аврал айлтгуулж сэтгэлтэй байсан бурханч ламаараа урт наслахын ерөөлт энэ Цагаан Дарь- Эх бурханыг бүтээлгэсэн нь бүгдийг аварсан юм.

Хайдав /ёжтойгоор /— Чамайг ч одоо бас аврах юм биш биз дээ Чи амьд гарья л гэж бодож байвал зул хүж хадаг мандалыг нь хурааж миний нүдний өмнө газар бул.

Амгалан — Тэгж буяндаа бузар оруулснаас чамайг эрлэгийн хаалган дээр угтсан минь дээр ...түй /нулимна /

Хайдав — Одоо яая гэхэв.Тахилч ламынх нь араас оч доо / буудна / Амгалан аажуухан сөхөрч ойчно.Гэнэт цахилгаан цохиж Догшин дүрт Дагва Сундэл бурхан бууж ирнэ. Түүний нүүрэн дээр гэрэл тусаж Боржигин зүүн Чойрын Хайдав чи бурхан номноосоо тэрсэлж цагийн аясаар тэрсүүдийн дотоодыг хамгаалахад шургалан ???

Хайдав / цочин сандарч буугаа унаган толгойгоо барьж /—Би чинь солирч байнауу даа. Амгалангийн сүнс ийм амархан намайг авахаар ирлээ гэж үү...

Давгасүндэл— Үгүй ээ чи солиороогүй буруутныг бурхан таалдаггүй юм...

Хайдав — Ээ Чойрын Богд минь өршөө / сөхөрч унан залбирч / Нээрээн энэ чинь Цагаан Дарь-

Эхийг бүтээсэн бурханчийг өөд болоход Цагаан Дарийн эх дүр болсон Дарьмаа бүсгүй түүнд зориулан хүүгээрээ Давгасүндэл бурханыг бүтээлгэсэн гэдэг

Давгасүндэл—Тиймээ ... Чи могой газрынхаа өнгөөр гэж хичнээн хувирсан ч эрхээр бурхан олон шавь нар диваажинд заларсан ч жар далан жилийн дараа бурхан шашин дахин дэлгэрч амьд үлдсэн нь алтан аяганаас рашаан хүртэн жаргахын цагт тэднийг санан дурсацгаах болно. Харин бурхан шашин руугаа буу барин өнгийсөн чамд Малахын талд багтах газаргүй нь / Тэнгэр дуугарч цахилгаан цахина /

Хайдав — Ээ ... Чойрын Богд минь өршөө / сунаж мөргөн уйлна. Гэрэл унтарч буун дуу тас хийнэ /Гэрэл марш эгшиглэнэ.

Хөтлөгч : — 1990 оны Цагаан морин жилийн ардчилсан хувьсгалын үр дүнд монгол оронд бурхан шашнаа дээдлэх ариун ёс дахин дэлгэрч 1998 -7-8 нд Говьсүмбэр аймгийн төвд хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан хөшөө босголоо.

Жанчин Чойрын хийдийн шавь нараас нам төрийн зүтгэлтэн Д.Моломжамц, Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн зохиолч, сэтгүүлч Н.Ишгавхай зэрэг алдар цуутнууд төрөн гарсан билээ.

Чойрын Богд өршөөж түмэн олон амгалан энх орших болтугай « Энх мэндийн баяр » уртын дуу эгшиглэнэ.

БЯМБАДОРЖИЙН МӨНХ-ӨЛЗИЙ

ХЯРУУДАЙН АЯЛАЛ

4 үзэгдэлт хүүхдийн дуулалт жүжиг

/сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн бага насныханд /

Дүрүүд

Хяруудай-Намар төрсөн туулайн бүжин

Цагаадай- Өвөл төрсөн туулайн бүжин

Ногоодой- Зун төрсөн туулайн бүжин

Хаданхүү- Бяцхан хад

Модонхүү-ойн моддын төлөөлөл ургаа мод

Бүжигчид

Цасан ширхэгүүд

Дэрснүүд

Усны бүжигчид

Цэцэгсийн бүжиг

Эрвээхэйнүүд

1-р үзэгдэл

Тайз: Цагаан хяруу унасан байдалтай гялалзсан ойн цоорхойд чулуу болон дэрснүүд байна.

Хөшиг нээгдэхэд ойн цоорхойд гэрэлт саран бууж ирнэ. Саран дотор унтаж байгаа туулайн бүжин нойрмоглон бууж саран буцаж явна.

Бүжин нүдээ нухлан : би хэн бэ? /хүүхдүүдэд хандан /та нар хэн бэ? , Би хаана ирчихээд байна гэсээр ийш тийш гайхан гүйнэ.

Энэ үед салхи шуугин бүжин үсчин тайзны булан тийш үсрэн нуугдана.

Дэрснүүд амь орон найган хөдлөнө.

Дэрснүүдийн дуу: Бүжинхэн минь

Туулайхан минь

Бүү ай бүү ай

Турьхан найз минь

Хяруу унахад

Төрсөн чамайг

Хяруудай хяруудай

Гэж нэрлэе дээ.

Дэрс дэрс

Найзууд чинь бид

Дэргэд чинь

Нөмөрлөх болно.

Хяруудай хяруудай

Хярж нуугдайрай

Дэлдэн чихээ нуугаад

Дэрсэн дундаа тоглоорой

Хяруудай сэргэлэн цовоо болж:

Би хяруудай

Би хяруудай

Бие минь нялхаараа

Нас минь бага ч

Дэрс дэрс найзуудтай

Дэгдэж харайх нутагтай

Хярж нуугдах газар минь

Хяруудай миний найзууд

Би хяруудай

Би хяруудай

Хяруу унахад төрсөн

Хяруудай би байна гэсээр дэрсэн дундуур сүлжин тоглож дуулна.

Дахин илүү хүчтэй салхи салхилж модод сүржигнэж найган хөдлөхөд Хяруудай дэрсэн дунд хярж нуугдна.

Модонхүү: Сайн найзын чинь нэг

Модонхүү би байна.

Сахинаас чамайг

Хамгаалах болно

Нас минь хамгаас ах

Бие минь бусдаас том ч

Ойн бяцхан амьтдын

Онц сайн найз нь билээ

Анд найз чинь

Модонхүү би байна

Араатнаас чамайг

Хаацайлах болно.

Томоогүй олон найзууд минь

Том биений минь ард

Араатан дайснаас нуугдан

Амь биеэ авардаг юм. Ха ха гэхэд

Хяруудай: Нэг ойртон нэг холдон болгоомжтойгоор

Сайн найз Модонхүү минь

Саглагар том толгой чинь

Санаанд оромгүй арзгар юм

Салхинд сүртэй дуугарах юм

Аврага том мөчир чинь

Аюултай биш юм шиг байна

Анд найз болсон юм чинь

Айхгүй байж болно биз дээ.

Модонхүү: Саглагар том мөчир минь

Салхи шорооноос хамгаална

Навчис минь дэлгэрэх цагт

Нарнаас бас халхалж өгнө

Аварга том мөчир минь

Аюултай бишээ Хяруудай минь

Ангаж өлсөх цагт чинь

Амин ундаа ч болох болно.

Дэрс , мод, хяруудай хамтаар дуулна

Анд найзууд бүгдээрээ

Хамт сайхан амьдрана даа

Ойн амьтад бүгдээрээ

Онц сайхан нөхөрлөнө дөө

Модны нөмөрт хяруудай эвшээн суниасаар унтана

Харанхуйлал

2-р үзэгдэл /цастай өвөл/

Тайз: Тайзан дээр цасан ширхэгээр хувцсалсан бүжигчид байралсан байна.

Хяруудай сэрнэ. Хүүе би хаана ирчихвээ энэ юу вэ?

Модонхүү: Хяруудай минь бүү ай /цасан ширхэгүүд бүжиглэж эхэлнэ/

Хяруудай сандран ийш тийш гүйнэ.

Дэрснүүд: Бүжинхэн минь

Туулайхан минь

Бүү ай бүү ай

Турьхан найз минь

Дэрс дэрсхэн

Найзууд бид чинь

Дэргэд чинь

Нөмөрлөх болно.

Цалин цагаан

Угалз гоёлтой

Цасхан найзууд

Айлчлан ирлээ.

Хяруудай: Сайн байцгаана уу

Цасхан найзуудаа

Санамсаргүй танилцсан

Цагаахан гүнжүүдээ

Би хяруудай байна

Бие минь жижигхэн

Олон найзуудтай

Ойн цоорхойн бүжин байна

Хяруу унах цагаар

Төрсөн болохор

Хяруудай нэртэй болсон

Би хяруудай байна

Цаснууд бүжиглэхээ зогсоож хариу мэхийн ёсолцгооно.

Цаснууд: Ойн цоорхойн эзэн

Одтой хөөрхөн хяруудай минь

Олон сайхан найзуудтайгаа

Онц сайхан амарч байна уу

Хан тэнгэрийн тэртээгээс

Хангай дэлхийгээ чимэглээд

Хөвчийн дуугаа аялаад

Хөнгөн зөөлөн бүжсээр бид ирлээ.

Нарны илч суларсан

Намуун өвлийг чимхээр

Жил бүрийн өвлөөр

Жингүүдсээр бид ирдэг юм.

Хяруудай : ямар сайхан юм бэ гэсээр цасан ширхэгүүдтэй бүжиглэнэ.

Гэтэл хүчтэй салхи салхилан цасан ширхэнүүд бужигнан улам хурц хөдөлгөөнтэйгээр бүжиглэнэ /цасан шуурга/ хяруудай садрана.

Далдаас Салхи дуулна: Хяруудай минь хяруудай минь

Нялх томоогүй байна даа

Хярж нуугдах нөхөд байлаа ч

Хянамгай явахгүй бол болохгүй ээ

Цасан дээр тоглох мөрөөр чинь

Цаана чинь атаатнууд мөшгиж байна

Ачлалт найз олон байлаа ч

Араатнууд аюултай шүү

Үлээх салхи би чинь

Үдшийн цастай нийлээд

Аюул үлдээсэн мөрийг чинь

Арилган хийсгэж үлээе дээ

Энэ үед Хаданхүү амь орон дуулна: Хангайн цас хайлтал

Хаданхүү намайг бадаад даа.

Урин хавар иртэл

Ургаа биенд минь нуугд даа.

Жавар халхалсан энгэрт минь

Жаахан биеэ халхал даа

Араатан дайсан өнгөртөл

Авралт нөмөрт минь нуугд даа

Хяруудай: Салхин эгчдээ баяраллаа

Сайхан санаанд чинь талархлаа

Хаданхүү найздаа ч баярлалаа

Хамгаас сайн андууд минь ээ.

Хадны нөмөрт хярна.

Харанхуйлал

3-р үзэгдэл

Өглөө хадны энгэрээс сэрээд хэдхэн алхтал өөдөөс нь бас нэгэн бүжин гарч ирлээ. Хяруудай ихэд цочин хадний араар орон нуугдана Цагаадай ч мөн ялгаагүй цочин нуугдах боловч бие биенийг эргэж харан буцаж нуугдсаар ойртон ирж бие биенээ үнэрлэн уулзана. Хоёр бүжингийн харилцаа дуу:

Хяруудай: Ойн цоорхойн бүжин би

Олон сайхан найзуудтай

Харин чамайг танихгүй байх чинь

Хаанаас гараад ирэв ээ чи чинь

Цагаадай: Цагаан цасан орох үеэр

Туулай ээжээс төрсөн болохоор

Цагаадай гэдэг намайг

Таныг харин хэн гэдэг вэ

Хяруудай: Би хяруудай

Би хяруудай

Бие минь нялхаараа

Нас минь бага ч

Дэрс дэрс найзуудтай

Дэгдэж харайх нутагтай

Хярж нуугдах газар минь

Хяруудай миний найзууд

Би хяруудай

Би хяруудай

Хяруу унахад төрсөн

Хяруудай би байна

Цагаадай: Ачлалт ээж минь захихдаа

Ах нарыгаа олж уулзаарай гэсэн

Хяруу унахад төрсөн

Хяруудай ахыгаа оллоо

Хяруудай:Бид хоёр бие биетэйгээ их адилхан юм. Дүү минь мөн байна Дэргэд минь хамт амьдар даа. Энэ үед хөгжилтэй ая эгшиглэж туулайн бүжингүүд хамтран бүжиглэж хажуугаар нь ус урсан гарч ирэх бүжиг үргэлжлэнэ.

Усан дунд цасан ширхэгүүд гараа даллан хөвж явна.

Ус цасны дуу: Ганган өвөл буцаж

Гайхам хавар ирлээ

Дараа жил уулзъя

Баяртай баяртай

Хяруудай цагаадай хоёр: Өвөл болтол баяртай

Өнгө цагаан цасхан минь

Өндөр тэнгэрээс ирэх

Өдрийг чинь хүлээж байя \

Баяртай баяртай

Цаснууд: Удахгүй уулзах хүртлээ

Усан дунд бид нуугдлаа

Хажууд чинь шуугин урсаад

Харж байх болно оо та нарыгаа

4-р үзэгдэл

Тайз зуны байдалтай

Ногоодой: Хавар болтол дүү нарыгаа хайлаа

Харсан хүүхдүүд байна уу

Нэг дүүг минь Хяруудай гэдэг

Нөгөөх дүүг минь Цагаадай гэдэг юм

Харин би халуун зунаар

Ноёлог уулс цэцгээр гоёод

Номхон мөрөн цэнхэртэн урссан

Ногоон зунаар төрсөн болохоор

Ногоодой гэдэг нэртэй болсон юм.

Ногоодой гэдэг нэртэй болсон юм.

Гэсээр дээшээ харан хэвтэнэ. /Цэцгэсийн бүжиг/ Ногоодой босч цэцгэстэй бүжиглэхэд

Хяруудай, Цагаадай нар хөөр баяр болон гарч ирнэ хэсэг бүжиглэсний дараа Ногоодойг харж

Цагаадай,Хяруудай хоёр зог тусан буцаж гүйн дэрс, хадны араар нуугдна.

Тэд бие биенийгээ хайх нуугдах аль нь мэдэгдэхгүй дэрс хадний араар ил далд орон хөөцөлдөн хүүхдүүдээс асууж сураглана.

Дэрснүүд дуулна.:

Ах дүү бүжингүүд

Амар мэнд уулзлаа даа

Анд олон найзуудтайгаа

Аятай сайхан наадна даа

Эрх чөлөөт нутагтаа

Энх мэнд өслөө дөө

Хангайн дэлхийн найзуудтайгаа

Хамгаас сайхан нөхөрлөж

Жавартай өвлийг давж

Хавартай учиран золгож

Дэлгэр зуныг угтаж

Дэлдэн бүжингүүд уулзлаа даа

Туулайн бүжингүүд уулзан бие биенээ танин хамтдаа бүжиглэн тоглоно. Энэ үед эрвээхэйнүүд нисэн гарч ирнэ. Эрвээхэйнүүдийн араас хөөцөлдөн тоглох

Гурван бүжин дуулна:

Ах дүү бүжин бид

Амар мэнд уулзлаа даа

Ойн олон найзуудтайгаа

Олуулаа бүжэн дуулцгаая

Бүгдээрээ: Ойн олон найзуудтайгаа

Олуулаа бүжэн дуулцгаая

Ногоодой: Ноёлог уулс цэцгээр гоёод

Номхон мөрөн цэнхэртэн урссан

Ногоон зунаар төрсөн болохоор

Ногоодой гэдэг нэртэй болсон юм

Ногоодой би байна

Хяруудай: Дэрс дэрс найзуудтай

Дэгдэж харайх нутагтай

Хярж нуугдах газар минь

Хяруудай миний найзууд

Би хяруудай

Би хяруудай

Хяруу унахад төрсөн

Хяруудай би байна

Цагаадай: Цагаан цасан орох үеэр

Туулай ээжээс төрсөн болохоор

Цагаадай гэдэг намайг

Цагаадай би байна.

Гурван бүжин дуулна:

Ах дүү бүжин бид

Амар мэнд уулзлаа даа

Ойн олон найзуудтайгаа

Олуулаа бүжэн дуулцгаая

Бүгдээрээ: Ойн олон найзуудтайгаа

Олуулаа бүжэн дуулцгаая

ТӨГСӨВ

БААТАРЫН ЭНХТӨР

Сэтгэлийг тоолж үл болно

Үйлийг хувааж үл болно . Д.Равжаа

ГАЛ ЭЛС

сэтгэлгээний дуулалт жүжиг 3-н бүлэг 5-н үзэгдэлт

ЭХЛЭЛ

1-р үзэгдэл

Хөшиг нээгдэнэ.

Тайзны байдал: Хүний цээжний хөндийн ясны хэлбэрээр засагдсан байх бөгөөд лугшиж буй том хүрэн улаан зүрх байна. Зүрхний хоёр талд хар сэтгэл, цагаан сэтгэл болох хар нөмрөг хувцастай цагаан нөмрөг хувцастай хоёр жүжигчин сууна. Уушиг байх хэсэгт том толин сар өлгөөтэй байна. Хар сэтгэлийн монолог өрнөх тусам зүрхний өнгө бүүдийнэ. Цагаан сэтгэлийн монолог өрнөхөд зүрхний өнгө тодсоно.

Хөгжим намуухан эгшиглэх нь хүмүүн яраглан хурхирах чимээтэй холилдох бөгөөд энэ нь

“Шулам авай”* хатан унтаж буйг илтгэх юм.

Цагаан сэтгэлийн монолог-1

Зүрх минь зүрх минь

Равжаа минь Равжаа

Харсан даруйдаа таныгаа

Халих зөнгөөрөө хайрласан билээ

Хатан царайндаа эрэмшин байж

Халгих сэтгэлээ илчилсэн билээ

Урьтаж төрсөн үйлийн үртэй ч

Ухааны чагт минь алдарсан билээ

Учир өрсөн зүйлийн явдлыг

Уйлан байж сөрсөн билээ

Зүүд минь зүүд минь

Равжаа минь Равжаа минь

Эр сэтгэлийн хүсэл соронзолсон

Эрдэнийн тунамал биетэй би

Эрх аалийн үүсэл бурамласан

Энгэр цоргиосон илчтэй би

Хуйсган хорвоогийн алаг бөөрөнд

Худалд өсөрхсөн ааштай би

Уйсган цагийн тарлан талд

Урвуулж загнасан адайр би

Гал минь гал минь

Равжаа минь Равжаа минь

Хөгшин ноёны чимэг зүүлт шиг

Хөөрхөн насаан үдсэн билэ

Хөнтөрсөн тогоо шиг энэ л орчлондоо

Хүслээн шатааж уугьсан билээ

Амьтан бүхний ад болж

Арилсан дотортой гэгдсэн билээ

Авсан нөхөртөө эд болж

Арилжсан санаа үржсэн билээ

Үнэн минь үнэн минь

Равжаа минь Равжаа минь

Ааваас хайрласан энхэр нэрээ

“Шулам” хочоор сольсон билээ

Ээжээс өвөлсөн өрөвч сэтгэлээ

Шунал гоочоор зольсон билээ

Өсөрхсөл буцалсан хор болж

Өрвөлзсөн бүхэн лүү цацсан билээ

Өвчүүн чинад зүрх минь

Өвөл шиг хөлдөж царцсан билээ

Заяа минь заяа минь

Равжаа минь Равжаа минь

Нартын дор нар болж ирсэн

Нандин учрал та минь юмаа

Эрээд олоогүй сэтгэлээ олсон

Эрдэнийн туяа та минь юм аа

Сувд шиг биеэ тандаа бариагүй ч

Суварга хайр минь мөнхийн юм аа

Шүүрэн шанаган шиг хорвоогийн урсгалд

Шүр шиг хайр минь үнэн юм аа

Хайр минь хайр минь

Равжаа минь Равжаа минь

Дэлхийд багтахгүй биш

Дэргэд чинь би баймаар байна

Хүсэл ахдахгүй биш

Хүүхэн чинь болж очмоор байна

Жаргал дуусахгүй биш

Жаргаж унтартлаа

дулаацуулмаар байна

Зовлон барагдахгүй биш

Зорьж тандаа очмоор байна

Хутагт минь хутагт минь

Равжаа минь Равжаа минь

Зүүд мөнх биш

Зүрхээ жаргааж үзмээрсэн

Амьдрал мөнх биш

Агшин ч атугай таных байхсан

Хувраг ариун сэтгэлийн чинь

Хирээр би угаахгүй ээ

Хэврэг байдаг итгэлийг

Хороор би буртаглахгүй ээ

Зүрх минь зүрх минь

Равжаа минь Равжаа минь

Хар сэтгэлийн монолог-1

Говь, Хангайгүй биширдэг

Гэгээрсэн номын хутагт гэвүү чи Равжаа

Гол усаараа шүтдэг

Гэрэл цацарсан нар гэвүү чи Равжаа

Хүүхэн заяат хүсдэг

Хөнжил доторхи зүүд гэвүү чи

Хүрэн зүрх дүрэлзүүдэг

Хайрын шидтэй уул гэв үү чи

Догшин улаан сахиустай гэв үү чи

Дагшин говиороо сахиулдаг гэв үү чи

Усыг сархад болгодог гэв үү чи

Үйлийг жүжиг болгодог гэв үү чи

Хатан миний нодогтой харцыг

Харалгүй чи өнгөрөөгүй дээ

Харцсын өмнө нохой шиг загнаж

Хамаагүй намайг шившиглэсэн дээ

Бурмаар урьсан ужид хүслийг минь

Буу шиг чи үгээр намнав уу

Бурхантай учирах хажид үүслийг минь

Буруутгаж чи өсөөр даллав уу

Эрийн галыг өнгөөрөө дуудсан

Эрхэм бие минь хөгшрөөгүй байна

Ирийн хатыг өвөртөө нуусан

Илбийн санаа минь бөхөөгүй байна

Амьд бурхан гэв үү чи

Албин чөтгөр болгоод өгье

Амьдрал мөнх гэв үү чи

Адын там руу илгээгээд өгье

Таалалд минь оршоогүй нас чинь

Тавин лангийн үнэтэй байна лээ

Тамтагтаа тулаагүй хатан миний

Тавилан чамаас урт билээ

Дарвих дуртай дарсны чинь

Даруулга нь миний хор байна аа

Ха ха ха

Дарь шиг ууртай үгний чинь

Хариулга нь миний хор байна аа

Хи хи хи

Үгүй болсны чинь дараа

Үнсэн дээр чинь бүжиглэнэ ээ

Ха ха ха

Үхээрт хувилсан чи

Үүдээр минь дахиж харагдахгүй

Хи хи хи

Харамлаад байсан толгой чинь

Хохимой болно

Ха ха ха

Өмчлөөд байсан бүсгүйчүүлийн

Өвөр нь хатна

Хи хи хи

Хунз Лувсан* чи

Хурдал хурдал

Хар буур минь

Жонжуул жонжуул

Хутагт минь хутагт минь гээд

Хортой архиа бариарай

Аргалж тойглож суугаад

Архиа хундагалан уулгаарай

Хатан миний шившсэн хортой

Нажид могой ч дэргэд нь хүчгүй

Шулам миний шивнэсэн хараалтай

Шунал тамталсан гахай ч дүйцэхгүй

Тарчилж яаж үхсэнийг нь

Товчилж болохгүй яриарай

Хар буур минь

Хурдал хурдал

Хунз Лувсан чи

Бушуул бушуул

Цагаан сэтгэлийн монолог-2

Өвчүүн чинад совин татаад байна

Өр зүрх минь зүйргүй өвдөнө

Өс хурсан сэтгэл шиг

Мэс хурц үгүй шүү дээ

Гэгээн хутагт минь болгоомжлоорой

Гэр үүдээ мануулаарай

Зүүдний анирт зөн ирээд байна

Зүгээр ч биш сэтгэл өмрөнө

Хар нуусан санаа шиг

Хор хаана ч үгүй шүү дээ

Хайртай Равжаа минь болгоомжлоорой

Хатавч босгоо сахиулаарай

Ариун хүслийг буртагладаг

Адын хорвоо хуучраагүй байгаа шүү

Аваагүй бүхнээ бузарладаг

Атаачийн нүүр хувираагүй байгаа шүү

Зовлонгоор цадаж инээдэг

Замлингийн урсгал татраагүй байгаа шүү

Бусдын жаргалд өсөрхдөг

Булайн балчиг хатаагүй байгаа шүү

Үлдсэн насны тоотой хоногуудаа

Үүдийг чинь сахиж өнгөрөөхсөн

Үдийн нар шиг мандмал таныхаа

Өврийг дэрлээд өнгөрөхсөн

Нар сар шиг уралдсаар

Насыг бид өнгөрөөх юм уу

Уул уул шиг ширтэлцсээр

Урсах жамаа үдэх юм уу

Нэг амьдралын ганц талд

Гарын ар өвөр шиг явах

Нийцэж болдоггүй хүсэл гэж

Гарагийн явдалд байдаг юм уу

Хатан зүрхний итгэл минь

Хад болсон ч хувирахгүй ээ

Үнэн хайрын сэтгэл минь

Үүлэн мэт сарнихгүй ээ

Говийн тэнгэрт манан байна

Газар эргүүлсэн үер буух вий

Горийн энгэрт шаналан байна

Гэнэгүй та минь эндэх вий

Хайрын зүрхээ аянга болгож илгээе

Хар үүлсийг бутартал ниргэе

Халуун амиа ерөндөг болгож уулгая

Хор үүслийг танаасаа холдуулъя

Маргаашийн нарыг л та минь хүлээгээр

Гэрлийн хурдаар би очино оо

Мандах гундах хожмын үйл ээ

Гэрийн чинь тулганд ашид даатганаа

Зүүн зовхи минь юундаа татна

Зүүрмэг дорно юутай харлана

Хар сэтгэлийн монолог-2

Хунз Лувсан чи

Худлаа хэлж ирвэл

Хэлийг сугалж

Хөлийг чинь тайрна даа

Нүдийг чинь ухаж

Нүцгэн талд хаяна даа

Шуналд ороогдсон би

Авч үзээгүй эдгүй шүү

Шуламын сувдаг зүрхэнд минь

Авралын зай эзгүй шүү

Чамайг хэргээ бүтээвэл

Чаргай биеэ өгнө

Самуун магнагийн буданд

Сархданд чамайг жаргаана

Нүүр хувирамтгай хорвоод

Нүгэл гэж байдаггүй юм аа

Зүс хууламтгай орчлонд

Үхэхээс бусад нь худал юм аа

Эзэрхсэн ноёноос оргуулна гэсэн

Өндгөн сүйний эзэн минь хуурахад

Эдлэгдэх бие, өнгөний сайхнаар

Өргөст хорвоо эргэдэг жамтайг

Харсан бүхнээ эдэлж цадах

Хатны жаргалыг би ухаарсан

Санасан бүхнээ гүйцээж амрах

Садарын хуялд бурантаглуулсан

Хунз Лувсан чи

Хурд...

/Энэ үед тайзнаа дигваранз гарч хар сэтгэл рүү дөхнө/

Аа энэ чинь юу вэ?!

Равжаагийн сахиус уу?

Амжаа юу Лувсан минь

Ашгүй дээ албин минь

Аймаар юм аа

Аймаар юм аа

Наашаа битгий дөхөөд бай

Надад буруу байхгүй

Өргөсөө цаашаа болгооч

Өөрт минь буруу байхгүй

Аймаар юм аа

Аймаар юм аа

Равжааг би егүүтгэчих вүү

Аль эсвэл өөрийгөө юу

Аааа ааа...

хэмээн хар сэтгэл чарлахад сар харангалан

хагарч зүрх лугшихаа болино. Энэ үед хөгжим

маш өрнөлттэй аймшигийн хөгөөр өрнөнө.

Хөшиг хаагдана.

ӨРНӨЛ

2-р үзэгдэл

Хөшиг нээгдэнэ.

Тайзны байдал:Хар буур унасан, ямаан дахтай хунз Лувсан тайзнаа гарч ирэх бөгөөд нутгийн зүг яаран тэмцэж яваа нь илт. Хөгжим догдлонгуй өрнөлтэй байна. Хилийн дээсэн овооны энгэрт амрахаар түр суугаад өврөөсөө тавин лангийн алтан ембүү гарган гар дээрээ дэнслэхүй монолог өрнөнө.

Лувсангийн монолог

Ёох ёох ёох

Амьд байна уу би чинь?

Алт минь өвөрт байна уу?

Ашгүй ашгүй

Аврал ...,

Ээ бүү үзэгд

Эрдэм гэдэг хүчтэй юм аа

Эд гэдэг үнэтэй юм аа

Худал гэдэг идтэй юм аа

Хуурмаг нулимс шидтэй юм аа

Хутагт хүртэл хуурагддаг байна

Хувраг итгэл алдуурдаг байна

Гэхдээ гэхдээ

Гэгээрсэн тэр хүн

Хундаганд мэлзэлзэх хорзонд

Хор ёроолд нь буцлахыг

Хаанаас тэгж мэддэг байна аа

Хачин юм аа хачин юм

Тавин лангийн ембүү

Таалал өргөж авсаныг минь

Хатнаас бусад нь мэдэхгүй атал

Харсан шиг хэлдэг байна аа

“Тарва товлосоноороо би уух уу?

Тавин лан хүртсэнээрээ чи уух уу?”*гэхэд

Алаг нүүрэн дундуур минь

Алхаар дэлсэх шиг болсон шүү

Чичирч байсан зүрхийг минь

Чивчиртэл сугалах шиг болсон шүү

Айхын эрхэнд шуумганд минь

Аадар шинхэг цутгасан шүү

Амиа алдана гэхээс

Айсаан айсан

Равжаа таныг бодсондоо биш

Амиа л бодсон би

Битгий та уу гэж

Бохирч өвдөглөөд хэлсэн

Санааг минь та унших шиг л

Сэмэртэл намайг харж байсан

Гэхдээ гэхдээ

Гэгээрсэн тэр хүн

Хатны шившэлсэн хорыг

Харсаар байтал уусан

Аминдаа хайртай баймаар

Амьдрах дуртай баймаар

Мэдэхгүй ээ мэдэхгүй

Мэргэдийн явдал надад хамаагүй

Хаадын явдал харцад падгүй

Хатны жөтөөрхөл байдсанд зайгүй

Зусараар өссөн надад

Өнгө мөнгө л хэрэгтэй

Зуйргаар амьдрах надад

Өөрийн минь амь үнэтэй

Хунз Лувсан ингээд

Хураасан хөрөнгөтэй болов оо

Ланз торгонд хөлбөрч

Хатадтай жаргах болов оо

/ Энэ үед завилан сууж буй Лувсангийн доод биенээс эхлэн алтжиж эхэлнэ/

Ханз халуун газар очиж

Панз наймаа үсэргэнээ хө

Хуучин авгайгаа сольж

Хөлтэй амьдарч үзнэ ээ хө

Ар халхад цуутай

Арилжаа өрнөөхийг байг гэхгүй

Авдар авдараар дүүргэсэн

Алттай болохыг үгүйсгэхгүй

Алт Алт Алт

Аяа ямар сайхан билээ

Миний л мэдэхийн

Хүний хорвоо

Алтны төлөө уралцсаар ирсэн

Миний л мэдэхийн

Өнгөний хорвоо

Алтаар бүхнийг арилжсаар ирсэн

Ээжийнхээ хуруунд

байсан бэлзэгийг

Дүүгээсээ урьтаж би авсан

Эцгийнхээ үлдээсэн сүрэг малыг

Бусдаасаа урьтаж алтаар арилжсан

Хунз цайгаар би

Хошуугаа худалдаж явсан

Алт өгсөн хүнд би

Авгайгаа ч өгнө

Алтны төлөө би

Амиараа ч төлнө

Авсанд орсон хойноо ч

Алт зүүдэлсээр байх болно

/Энэ үед Лувсангийн хүзүү хүртэл алт болж хувирсан байна/

Ёох ёох ёох

Ёдор бие чинь хүндрээд байх чинь

Алт бодоход сайхаан сайхан

Барихад баян юм аа

Байхад өег юм аа

Алт олоход ичгүүргүй

Алдахад амь юм аа

“Шулам авай” хэрийн хүнд

Тавин лан өгөхгүй шүү

Ай яа ай яа ай яа

Айхтар тэр чаралба

Хорын баларт шимнуус

Харын балчигт зулбадас

Араандаа зуусаар байгаад

Равжааг хорлож дөнгөсөн

Ашидаа намайг ч дөнгөлнө

Чөтгөрийн шид шүглэсэн

Чөргөр тэр авгай

Ноёнд ховлож байгаад л

Нохой мэт хөнөөлгөнө

Ямарч байсан очиж

Янагийн эрдмийг нь үзье байз

Янгиагаа нэг тохоё байз

Явдал яриаг нь сонсьё байз

Алгы нь тэнийлгэтэл

Равжааг хөнөөсөнөө ярья

Аз байвал ахиад

Зуун ланг хүртье

Өнөө муу “Шулам” чинь

Өрсөж егүүтгэж магадгүй

Өргөн дэлхий уужим хойно

Өөр газар хулжъя байз

/Энэ үед Лувсангийн бүх бие том алтан ембүү болж хувирна/

Хачин юм аа

Хамаг юм

Харанхуйлаад

Ёр зэдээд байна уу

Явья явья түргэн

Алт минь алт минь

Харагдахгүй байх юм

Алт минь алт минь...,хэмээн хашгирах энэ үед алтан ембүү хад болон хагаран бутрах бөгөөд хөгжим тэмээ цамнан буйлах чимээгээр солигдож хар буур цамнан туйлсаар суларч одно. Хөшиг хаагдана.

3-р үзэгдэл

Хөшиг нээгдэнэ.

Тайзны байдал: Гэртээ үйл мэтгэн уйтгарлан суух Дадишуари босож бурхныхаа өмнө дөллөх зулаа сэргээгээд шанзаа авч шудран тоглож эхлэнэ. Хөгжим зөвхөн шанзаар эгшиглэнэ.

Дадишуари дуулна

“Анх л багын учрал минь”

Алслах тусмаа гэрэлтээд хө хө

Арвисах цагийн хүрдэнд

Амрагийн итгэлийг

бөхлөх юм аа хө хө

Янзаган насны хайр минь

Явдлын аянд тодсоод хө хө

Явуу замлингийн үүдэнд

Янагийн сэтгэлийг

хөгжөөх юм аа хө хө

Зүрхэн чинад хутагт минь

Зүүдлэх бүрийд солонгороод хө хө

Зүг нь өөрчлөгдөх хорвоод

Зүс нь солигдохгүй гэрэлтэх юм аа хө хө

/хэмээн дуулаад хэсэг мэгшинэ/

Дадишуаригийн монолог

Алмад хорвоогоос дураараа зугтсан

Равжаа хутагт минь хаана явна даа

Ашид дурсах диваажин үлдээсэн

Амраг тавилан минь хаана явна даа

Үхлийн цаана давж уулздаггүй

Үнэнийг би яалтай ч билээ

Үзэгдэх цагт бие чинь байхгүй

Үйлийг тэгээд яах ч билээ

Дотогшоо иртэй жад шиг санаатай

Доройхон зарим увайгүй харчуулын

Доромж дээрэмжийг биеэрээ этэлж

Дорнын говьдоо уйлж явна аа

Танаас минь өөр зай оршихгүй

Тангарагт сэтгэлээсээ зүрх минь урвахгүй

Тавилант зургийн хөврөөг гэтэлж

Тал нутагтаа гуньж явна аа

“Нууц зогсоол”*-ын шүүдэрт цэцэрлэгт

Нугын эрвээхэй шиг цэнгэлтэй ниссэн

Энхэр хормуудыг элгэндээ үгүйлж

Элгээ уусган гашилж байна аа

Эргүй гэргийн зовлонг туулж
Элдэвт заримын хүчинд авгаж
Эгшин бачуурч таныгаа дуудаж
Эзгүй харанхуйд балмагдаж сууна аа
Ганьхан хорвоогийн сүүдэр хөдөлгөхдөө
Ганцхан таныхаа хойчийг бодож
Гаравч оровч тэнгэр ширтээд
Галаа бөхөөлгүй хүлээж байна аа
Бэлэвсэн сэтгэлийнхээ нулимсыг ууж
Бэтгэрсэн зүрхнийхээ цусыг шавхаж
Өглөөн нарнаар цайгаан дээжлэн
Өдөр шөнийг элээж байна аа
Үүрдгүй учралын аалинд хууртаж
Үр мөнхийг аргамжааг бөхлөөгүй
Зүслэх үргүйн хувь дутсан даа
Зүрхээн үгтээн бахирч байна аа
Бадмын цоморлиг минь гандлаа
Балаар дутсаар хатлаа
Үзмэн уруул минь хагсарлаа
Өөрийг чинь дуулсаар хагдарлаа
Орчлонг хуваалцаж жаргасан мөртлөө
Орхихдоо юунд ганцаар явав даа
Хор буцалсан шулмын хорзыг
Хоёулаа ууж болсонгүй юу

Зүрхэндээ уусдаг алтан анирын

Үлгэр зохиож чадсан мөртлөө

Зүүдээ хувааж санадаг хайрандаа

Үхлээн таллаж чадсангүй юу

Янагийн увдисаар сэтгэлээ сүлж

Янигийн уянгаар хосолсон атлаа

Нартаас та буцах болох доо

Надгүй явж чадсан юм уу

Найрын ширээ шиг залуу насандаа

Найргаар хамт бадарсан мөртлөө

Нандин сэтгэлийн ариун орныг минь

Наргүй хиртээж болоо юм уу

/ Энэхэн зуур нэгэн хун шувуу тэнгэрээр дүүрэн ганганан гэрийн дээгүүр нисэхүй еэ сэтгэл нь догдолсон Дадишуари баярласандаа гүйн гарна. Хун шувуу ганганасаар Хамрын хийдийн зүг нисэн алсарна/

Дадишуаригийн монолог үргэлжилнэ

Ай сахиус минь

Асури тэнгэр минь

Равжаа минь сонсчээ

Улаан сахиус нь өршөөж

Хун шувуугаа илгээжээ

Та минь намайгаа харж байх нь

Та минь намайгаа санаж байх нь

Та минь наддаа нэгэн цагт ирэх нь

Та минь надтай заавал учрах нь

Та минь ...

Та минь ..., гэсээр Дадишуара гэртээн ороод шанзаа авч дуулна

Дадишуари дуулна

Гэгээн оюунт Хутагт минь

Гэрэлт тунгалаг ухаантай яа хө хө

Гэнэн орчлонгийн үйлийг

Гэгээрч таньсан билэгтэй еэ хө хө

Мөнхийн амьд Хутагт минь

Мэлмий тунамал хараатай яа хө хө

Мянган чинадын учрыг

Мэдэж таньсан тайлалтай яа хө хө

Эрдэм төгс Хутагт минь

Эрхэм увдист сэтгэлтэй еэ хө хө

Эргэх цагийн утгыг

Эгэлгүй мэдсэн

бишрэлтэй еэ хө хө

хэмээн дуулах төгсөгхүй хөшиг хаагдана.

4-р үзэгдэл

Хөшиг нээгдэнэ.

Тайзны байдал: Тас харанхуй байх бөгөөд зулын мэт нэгэн сүүмгэр шар гэрэл тайзнаа хөдлөн явах бөгөөд хөгжим намуухан эгшиглэнэ. Монолог өрнөх бүр тайзны гэгээ нэмэгдэж монологны үйл явцаар тайзнаа орших хад, хайлаас гэх мэт юмсад шар гэрлэн сүнс тухайн өрнөж буй үйлийн эд юмсад шингэж гэрэлтэнэ.

Гэрлэн ухамсар буюу

Равжаагийн сүнсний монолог-1

Зүдэр бие минь хөрс боллоо

Зөөлөн сэтгэлийнхээ буйдыг оллоо

Махан бие минь шороо боллоо

Манзушир сэтгэлийнхээ үүрдийг оллоо

Шулмас сувдагийн хорыг танилаа

Шагшаабадын учигыг тайллаа

Ягчис ужидын харыг харлаа

Ямандаг чанарын шидийг ухаарлаа

“Шулам авай” одоо сонс!

Шуналыг чинь би уусан юм

Хорсол нисванисыг чинь нигүүсэлж

Хайрыг чинь өрөвдөөд энэрсэн юм

Ганцаар бүхнийг өвөрлөх гэсэн

Гайгаа одоо мэдэв үү?

Хүмүний сэтгэлийг өмчилж болдоггүй

Хэлгүй үнэнийг танив уу?

Сүнс чинь намайг эрж яваа

Би мэдэж байна

Сүүдэргүй чи уйлж байгаа

Бас мэдэрч байна

Арван төрөлдөө чи намайг олохгүй

Араас минь дуудсаар эрэх болно

Аръяабалын мандалд ортлоо

Арвин замлинг туулах болно

“Эрүүл” хүмүүс та нарын дунд

Согтуу явсаны минь нүүр тэр ээ

Энэрэлгүй сувдагийн үүрэн дунд

Солиотой гэгдсэний минь үр тэр ээ

Хуурамч орчлонг үнэн болгох гэж

Хайртай Дадишуаригаа хагацалд орхиод

Хоосон чанарын царайг харуулахаар

Хорвоогоос зугтсан учир энэ ээ

Бодь хутагийн мөн чанарыг

Бурхадын сургаалаас таниг гэж

Бод биеэ салхинд хувиргаж

Буданд хувираад ирсэн минь энэ ээ

Би одоо самадид хувирсан

Биегүй сэтгэл минь хаа ч нэвтэрнэ

...,гэхүй тайзнаа орших боржин хаданд гэрлэн ухамсар нэвчиж тэндээс гэрэлтэнэ.

Гэрлэн ухамсар буюу

Равжаагийн сүнсний монолог-2

Хадыг хатуу гэв үү

Үлэмж зөөлөн

Хадыг хайруу гэв үү

Үлэмж дулаан

Хадыг амьгүй гэв үү

Үлэмж ухамсартай

Хадыг даардаггүй гэв үү

Үлэмж нимгэн

Хадыг хайргүй гэв үү

Үлэмж энэрэнгүй

Хадыг ярьдаггүй гэв үү

Үлэмж цуурайлаг

Хадыг хардаггүй гэв үү

Үлэмж ажигч

Хадыг сонсголгүй гэв үү

Үлэмж сонор

Хадыг уйлдаггүй гэв үү

Үлэмж уян

Хадыг үхдэггүй гэв үү

Үлэмж эмзэг

Хадыг урвадаг гэв үү

Үлэмж үнэнч

Хадыг атаач гэв үү

Үлэмж худал

Хадыг ганц гэв үү

Үлэмж ертөнц

Хадыг хуурмаг гэв үү

Үлэмж эндүү

Хадыг хагацадаггүй гэв үү

Үерлэх нулимастай

Газрын цус судсаар нь гүйж

Галавын цагийг бүтээж байдаг

Атираат буурал хар хаданд

Амгалан чанар мөнх оршдог

Үггүй алсын үнэнийг

Үүнээс цааш мэдэх үү

Үндсээрээ газраас зуурсан

Өвгөн хайлаасны үгийг сонсох уу., гэхүй гэрлэн ухамсар хаднаас шилжиж тайзнаа байх ганц өвгөн хайлаасанд шингэнэ. Энэ үе гэрэл тэнд төвлөрөх бөгөөд хад харагдахуйц гэрэлтэй үлдэнэ.

Өвгөн хайлаасны хэлэх монолог

Гундах навчсын ширхэгээр

Сэтгэл минь бууралтнам

Гурван хорвоогийн хэрчлээсээр

Зүс минь урагднам

Ургах унахын аашаар

Орчлон өөрчлөгднөм

Учрах хагацахын заагаар

Зүрх минь өвднөм

Жаргалын диваажинг

ертөнцөөс хайж

Жаран жил зун болж ургалаа

Жаргахгүй хавар шиг

хүслийг минь

Жамын салхи намар бүр хяргалаа

Жаргалыг хүсэх тусмаа

Зовлонгоо арвижуулж өгөршлөө

Мөчир дээр минь инээлдэн эрхлэх

Мянган навчсыг өрөвдөх бүр

Үндсээрээ шимсэн усаа өгсөөр

Өтөлж тахийгаад эрхгүй өвгөрлөө

Одоо яахав орчлонгийн зам

Ойчиход минь тосох хөрст байгаа

Ахин хүмүн төрлийг ологсдод

Амжиж хэлэх нь өтгөсийн үүрэг

Буман живаа төрлөөс

Хүмүн төрөл эрхэм

Түмэн цэнгэлийн төөрлөөс

Эрдэм ном эрхэм

Тамтаггүй атгаг сэтгэлээс

Түвшин санаа эрхэм

Төрөл садан бүхнээс

Ижий аав эрхэм

Түших энэрэлд сургаваас

Үр хүүхэд эрхэм

Атаач ужгийг жигшиж

Авирыг зөөллөх эрхэм

Анд андын дотроос

Амраг заяа эрхэм

Амьдархуйн гэгээ учраас

Яруу уянга эрхэм

Ашид амьдрахгүйн үнэнээр

Амь хамгийн эрхэм

Амьдралын үргэлжлэл учраас

Сайн үйлс эрхэм

Энэ байгаа төрхөндөө

Эргэж хэзээ ч төрдөгүй

Эцсийн тайлшгүйн чандмань

Эсэрваагийн оронд оршном

Ээжээсээ хоёр төрдөггүй

Эрхэм үүдийн нууц

Эргэх замиланг зохиосон

Бурхны хутагт оршном

Үйлээ хүлээсэн хэн ч

Үхэхийг юундаа хүсэх ..ийн хэлэхийн зуур Дадишуаригийн дуулах сонсогдож гэрлэн ухамсар тэнгэрт нисэх хун шувуу болон ниснэ.

Хун шувуу буюу

Равжаагийн сүнсний монолог-3

Саатаж буусан хүмүүн хорвоод

Санахын учиг Дадишуари минь

Худалгүй сэтгэлээр ханьцаж учирсан

Хүмүний ариун Дадишуари минь

Янагийн гэрэлт дагинасын дундаас

Янжинлхам лугаа Дадишуари минь

Эргэн мөрөөдөх хүслийн туйл

Эрдэнийн цоморлиг Дадишуари минь

Бираавадийн орны нандин цэцэг

Бадамын лянхуа Дадишуари минь

Үзэсгэлэн бүхний зэндмэнэ цогцолсон

Уянгын лавай Дадишуари минь

Шамбал мөнхийг ашид оршоосон

Шанзны аялгуу Дадишуари минь

Солонгын өнгөөр мэлмий булаасан

Сондорын чимэг Дадишуари минь

Сүлд Улаан сахиусанд минь

Сүслэж хүлээгээрэй

Би очино

Сүүлд учиг тайлагдах

Сунтаг Жамсран хүртээнэ

Би оршино

Үүрд чамайгаан гэх

Үнэн минь амьдарсаар байгаа

Би очино

Насад чамайгаан гэх

Найраг минь уянгалсаар ахуйд

Би оршино

Хайраас илүү хайргүйг

Хагацалаар хүмүн мэдэг гэж

Би орхисон

Учирсанаас сайн амраг

Уудам орчлонд үгүйг

Би ойлгосон

Ялгуун цагийн буудалд

Яруу уянгаар эгшиглэнээ

Хоёулаа

Ядам бурхны тааллаар

Янжинлхам чамтайгаа учирнаа

Хожимдоо

Цаггүй орчлонгийн уудамд

Цалгисан хайранда

Авидад жарганаа хоёулаа .., ийн хэлэх зуур тэнгэрийн заадаснаас гэгээ түгж үүлэн дунд завилсан Равжаа хутагтын дүр бүдгэвтэр гарч ирэх бөгөөд хөгжим энэ үед маш яруусангуй болно.

Гэрлэн ухамсар буюу

Равжаагийн сүнсний монолог-4

Цагаасаа өмнө хорвоод ирсэн

Цадиг догшин түүх минийхээ

Чинад билгийн хутагийг нээсэн

Цаглашгүй дагшин оюун минийхээ

Үйлийн үртэй замлинг туулахдаа

Үнэний тухай дуулж өгсийм аа

Наснаасаа эрт орчлонгоос буцсан

Намтар шуугиант мөр минийхээ

Наран мэт мандан түгэх

Найргийн галт онгод минийхээ

Зүйлийн алагтай нажидыг этлэхдээ

Зүрхээрээ нигүүсэлж

бадамласийм аа

Үе эртээсээ түрүүлж мэндэлсэн

Үнэний туйлтай заяа минийхээ

Үүрд оршихуйн очир зангидсан

Үлдээсэн суварга үйлс минийхээ

Туйлийн оньсот мандалыгт нээн

Тусыг оршоон тайлж барьсийм аа

Эрдэнэт ухааны бумба дэлгэрэх

Ирээдүй айсуй Майдар алсаас

Энэ цагийн мунхагийг шатаах

Элсэнд ноцсон гал дүрэлзэнэ

Гал элс Дэмчилээс түгэн

Галав юүлж оюуныг цацраана ...,гэхүй

монолог төгсгөлд тайз дүүрэн гэгээ цацрах

бөгөөд үүлнээ суусан Равжаа хутагтын гэгээн

дүр машид тодрон гэрэлтээд замхархуй хөгжим

маш яруухан уясалтай болж хөшиг хаагдана.

ТӨГСГӨЛ

5-р үзэгдэл

Хөшиг нээгдэнэ.

Тайзны байдал: Говийн байгаль харуулсан байх бөгөөд зээрийн сүрэг бэлчиж байна. Сүрэгт нэгэн сайхан ооно байх бөгөөд энэ нь “Шулав авай”-н сүнс бөлгөө.

Ооно буюу “Шулам авай”н сүнсний монолог

Хойд сүнсэн төрөлдөө

Хонгор говьдоо төрсөн минь

Хувь заяаны гааж уу

Худал хорвоогийн гооч уу

Хутагтыг хөнөөсөн нүгэлдээ

Хөөрхий зүрх минь тэсээгүй ээ

Хурмаст тэнгэрийн шийтгэл тэр ээ

Хувилгааны Улаан сахиусны ниргэлээ

Алаг зүрхний минь хайрыг ойлгосон

Авир сэтгэлийн минь чивэлийг харсан

Архад хувилгаан хутагт минь харин

Аваръя хэмээн бодсон билээ

Гэгээн билэгийг таньсан хүмүүнд

Гэсгээл атаа байдаггүй юм билээ

Бодь мөрийг таньсан Равжаад

Баширыг сэтгэх зайгүй билээ

Оюунтай Та хаана явна вэ?

Ооно болсон надтай учираач

Орчлонгийн явдлыг хожуу ухаарсан

Оройтсон гэмшилээ хүлцэж тайлья

Чандмань Хутагт минь хаана явна вэ?

Зээр болсон надад харагдаач

Чөтгөрийн мунхагаа таньсан сэтгэлээ

Хээр буйдад тандаа дэлгэе

Шаргал говийнхоо сөөгт манханд

Шалдан сүнс минь хоргодсоор төржээ

Эрдэнэт таныгаа зүрх минь хайсаар

Элсэн толгоддоо зээр болж иржээ

Ай хөөрхий сэтгэл гэдэг

Амирлахын цаана ч амардаггүй байнам

Ай хорвоо итгэл гэдэг

Амьддаа төгсөж жаргадаггүй байнам.., энэ

үед Говь мэргэн вангийн дунд хүү бараа

бологсодтойгоо ан гөрөөлж явах бөгөөд

зээрийн сүргийг харуут намнахаар уулгалан

нум эвшээж сум тавьцгаана. Хүүгээ таньсан

“Шулам авайн” сүнсний монолог өрнөнө.

Ооно буюу “Шулам авай”н

сүнсний монолог

Элэгнээс минь тасарсан

Эрдэнийн ганц үр минь үү дээ

Энгэрт минь нэвчсэн

Энхэр үнэрийн дүр үү дээ

Халихдаа хоргодсон

Хайрын шалтгаан үр минь дээ

Холдохдоо зовсон

Хайлан сэтгэл хүү минь дээ

Амирлахдаа амжиж үнсээгүй

Алаг тормон хүү минь дээ

Аминдаа нуусан

Ашид энэрэх үр минь дээ

Уул шиг сүрлэг

Удамт эр болжээ

Хангай шиг тэнэгэр

Ханхар эр өсжээ

Үхэл эрсэн зэвтэй сум

Үйлсийн тэнгэрийг чинь

харлуулна даа

Утга тэрлэх бэхтэй сүм

Ухааны цэнгэлийг авчирна даа

Шунал шившсэн байнд чинь

Шаргачин оононы нэг нь үрэгдэнэ

Сувдаг идсэн над шиг явснаас

Судар бүтээсэн мэргэн яв даа

Исгэрэх сумны улиан

Эрдэнэт нэгэн амийг хороохоос хойш

Ээж нь., гээд цоройн харайхуй хүүгий

нь тавьсан сум ирж оонын зүрхийг сүлбэн

унагахад анчид ангаа ганзгалахаар үтэр ирэхүй

“Шулам авай”н хүү бусдаас түрүүнд шаламлан

гүйж эцсийн амьслаа аван тийчлэх оонон

дээр очихуй залуугийн нүдэнд зүрхэндээ нэвт

харвуулсан ооно ээж нь хэвтэж харагдахуйд

тэрбээр машид цочирдон уйлаад дуулна.

Зүйвэр.

“Шулам авай” хатан буюу Говь мэргэн вангийн

2-р хатан байсан эмэгтэй

хунз Лувсан* Говьмэргэн вангийн албат хунз

Лувсандорж

гэгч бөгөөд хатны зараалаар Д.Равжаа

хутагтад хор өгч егүүтгэжээ.

Нууц зогсоол*-Д.Равжаагийн “Хүмүүн заяаны

судар” буюу “Нууц зогсоол” хэмээх 108 цуврал

зураг бүхий үүлэн сарны явдал үүсгэх тухай

зураглал судар юм.

*хунз Лувсандоржийг хортой архи авчирахыг урьдчилан мэдэж байсан Ноён хутагт архианаас нэг аяганд хийж ийнхүү хэлсэн нь түүхэн үнэн ажгуу. Тарва товлосоноороо гэдэг нь тонилгохыг олсоноороо гэсэн үг буюу.

Д.Равжаа хутагтын зохиол

Төрж өсгөсөн гөрөөс ижий

Төрж өсгөсөн гөрөөс ээж минь

Төөрөлдсөн янзага намайгаа өршөө

Төрөл бүхэнд ачтай сүүгээрээ

Тэтгэн тэтгэн бойжуулж соёрх

Үдэд дайраад өнгөрөх үүл ч бол

Үтэрхэн зуур сэрүүцүүлэх байтал

Өнөд ханилсан үеийн нөхөд минь

Өдийд суугаад юундаа хууралцана

Унаж сурвал эмнэг даага ч бол

Уран гол шиг жороо болох байтал

Ултай сэтгэлээр ханилсан амраг нөхөд минь

Урамгүй юундаа хууралцана

Матаж сүлжвэл чилгэр сухай ч бол

Малгайны гэр хийж болох байтал

Махарж ханилсан амраг нөхөд минь

Маниас даанч юундаа уйдна

Зүрхгүй сансрын иймийг мэдлээ

Зүйгүй нөхдийн худалчийг мэдлээ

Зүгээр суугаад элдвийг үзлээ

Зүдэг орчлонгоос тонилох болтугай ..., хэмээн

дуулж дуусахуй хөгжим яруусангүй өрнөж

хөшиг хаагдана.

ТӨГСӨВ

РАГЧААГИЙН БАТЖАРГАЛ

ХОШУУ ДОМОГ

Боржигин хошууны түүхийг үлэмжлэх гурван бүлэгт долоон үзэгдэлт дуулалт жүжгийн цомнол

Наадагчид

- 1. Бүри бөх Жүрхэний хүчит бөх
 - 2. Хув Нагварал Хатан бүүвэйн хүү
 - 3. Содном Хув Нагваралын эх
 - 4. Содномын аав
 - 5. Шивэгчин
 - 6. Хэрсүү Цэвэг Боржигин нутгийн хүн
 - 7. Цэрэнсандив ноён
 - 8. Юндэндорж хүүхэд ноён
 - 9. Гомбосүрэн ноён
 - 10. Хиа бичээч тэргүүтэн хүмүүс сүнсүүд болон бүжигчид найрчид Ядаг ноёныхон зэрэг
- нижгээд хүмүүс оролцоно

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Эхлэл

Тайз Ер бус совинлог орчин

Есөн цагаан сүнс сууна

Урд нь хоёр хүн

Ууц нь хугарсан Бүри бөхийн түшнэ

Үхлүүт хэвтэх түүний

Үг нь дуулдана

Бүри бөхийн монолог

Эрхийдээ эрчимтэй

Элгэндээ шүүстэй

Уушгиндаа ууртай

Уруулдаа хилэнтэй

Эрдэмт эрсийн нэгэнсэн

Энэ Жүрхэний баатарсан

Унахыг ер үзээгүй

Улсын бөх Бүри бөхсөн

Асар цацарт өргөөнийхөө

Алтан босгыг сахьдагсан

Өндөр дээд өргөөнийхөө

Өргөн үүдийг өргөдөгсөн

Хабул хааны үр юмсан

Хатан зоригт эр юмсан

Хар Жүрхэний тэрс юмсан

Халирах айдасгүй баатар юмсан

Яавч би Бэлгүтэйд

Ялагдах учиргүй

Өрөөсөн гараараа

Өргөчих байсан

Торох төдий эгзэгт

Товшчих байсан

Торгон зодогийг сэмлэн

Тонгорчих байсан

Ээ халаг гэж

Эзнээс айгаад ийм болов

(Өндийх гэж зүтгээд

Өвдсөндөө болж зүднэ)

Яавч би Бэлгүтэйд

Ялагдах учиргүй

Гарын доор түүнд

Гартах учиргүй

Эзний хөмхийгөөс урьтаж

Эргэх байсан юм

Базах Бэлгүтэйгээс өрсөж

Барилдах байсан юм

Эзэн Чингэсийг аргадаад

Энэ бие минь мөхлөө

Хаан Чингэсийг аргадаад

Хар толгой минь өнхөрлөө

Ууц минь хугарлаа

Ураг минь доройтлоо

Сүнсийг минь дорд үзэв

Сүлдийг минь доромжилж үлдээв

Тэнгэрт халив

Хөдлөл Энэ зуур сүнсүүд

Эргэж харах бөгөөд

Сүнсүүд хар нүүртэй

Сүг сүүдэр мэт харагдана

Бүри бөхийн сүнс гагцаар

Бүтэн хүн нүүртэй үзэгдэнэ

Харанхуйлал

1-Р ҮЗЭГДЭЛ

Тайз Цааш харж суугаа

Цагаан нөмрөгтэй сүнсүүдийн наана

Хашир өвгөн охинтойгоо

Харааны алсыг саравчилна

Төдөлгүй төвөргөөн наашилж

Төрхгүй арван эр ирнэ

Тэд баатарлаг эрхэмсэг

Тэгээд дутаагаа болов уу гэхээр

Галтай бүжиг бүжиж

Газар доргитол наадна

Өөдөсхөн охиноо нөмөрлөөд

Өвгөн гайхаж алмайрна

Нэг нь

Гэр нэвт гэгээтэй юм

Гэргий болох насандаа юм

Гэээг үс урттай юм

Гэнэн хонгор зүстэй юм

Эзэнтэн та таал таал

Эхнэр болгоод ав ав (Бүжиг гангараад

Бүгд нэгийн зүг сөгдөнө)

Бас нэг нь

Эзэнтэн та таал таал

Эхнэр болгоод ав ав

Нөгөө нь

Туурга нэвт туяатай юм

Тунгалаг хар нүдтэй юм

Турьхан зөөлөн аальтай юм

Тунчиг гоё бүсгүй юм

Хаан та таал таал

Хатан заяанд богтол богтол

(Бүжиг гангараад

Бүгд нэгийн зүг сөгдөнө)

Бас нөгөө нь

Хаан та таал таал

Хатан заяанд богтол богтол

Бас нэг нь

Жирийн биш үзэсгэлэнтэй юм

Жирэвгэр хар хөмсөгтэй юм

Жимсэн улаан хацартай юм

Жигтэйхэн гоё харцтай юм

Эзэн минь та таал таал

Эхнэрээ болгоод ав ав

(Бүжиг гангараад

Бүгд нэгийн зүг сөгдөнө)

Нэг нь

Эзэнтэн та таал таал

Эхнэр болгоод ав ав

Бас нөгөө нь

Цаснаас цагаан царайтай юм

Цалгиа хонгор аальтай юм

Цангинам шингэн дуутай юм

Цайлган хайлган зантай юм

Хаан минь та таал таал

Хатан заяанд богтол богтол

(Бүжиг гангараад

Бүгд нэгийн зүг сөгдөнө)

Нөгөө нь

Хаан та таал таал

Хатан заяанд богтол богтол

Хөдлөл Албан хүчээр охиныг дугтчиж

Ахлагчийн дэргэд зэрэгцүүлж суулгаад

Буурал өвгөн суусан газартаа

Бурхны авралд залбирч сөгдөнө

Өвгөн (цөхөрсөн аясаар)

Хатан бүүвэйд өгнө гэж

Хан тэнгэрт амалсан юмсан

Ам тангарагсаа гажвал

Азай би яахсан билээ

Тэд Дуу зандарна

Өвгөн

Бүүвэй баатарт өгнө гэж

Өндөр тэнгэрт өчсөн юмсан

Бүрэн үгээсээ няцвал

Өтөл би яахсан билээ

Тэд Дуу зандарна

Өвгөн

Торолзохоос

Тал нутагтаа өссөн бид

Тогтохоос

Таана мангирханаар өллөдөг бид

Тойгтоос

Тос нүнжиг горьддог бид

Тойвловоос

Тоост замд үлддэг бид

Тэд Ха ха ха инээнэ

Өвгөн

Билэгт хүний үрс юм та нар

Биднийг үлдээж хайрла

Ямба эрхэмсэг хүмүүс юм та нар

Ядуу биднийгээ явуулж өршөө

Нэг нь

Элээ шувуу боловч

Эргэж Халхдаа зүглэх биз

Хун галууг ялгая гэлээ

Хурмаст тэнгэрт өргөө гэлээ

Нөгөө нь

Тэнгэр мэдтүгэй

Алавч амь нь хүнд

Арандаг гэдгийг мэдээрэй

Өрлөвч өс нь бузар

Өртлөөс гэдгийг санаарай

Бас нэг нь

Харцага шувуу боловч

Халх нутагтаа зүглэх биз

Ятуу хөтүүг ялгая гэлээ

Ял асууж өрлөө гэлээ

Нөгөө нь

Тэнгэр мэдтүгэй

Аманд орсон олзыг

Хэлээр хэн түлхэх

Арга нь олдохгүй үүнийг (Өвгөнийг заана)

Хэзээ ч яаж болох

Нэг нь

Тас шувуунд

Тарааж өгье

Нөгөө нь

Бүргэдийн саварт

Бүтнээр нь хаяя

Бүгд

Тэнгэр мэдтүгэй

Охин

Ааваа ааваа эд нар

Аюух үг хэллээ

Азай буурал таны

Аминд хүрэхээр хэлэлцлээ

Өвгөн

Цуутай дуутай орчлонд

Цуглаж ирдэг ёстой ч

Цууртай хууртай найраас

Цувж явдаг жамтай юм

Бие ямар мөнх биш дээ

Билэг ерөөлөөр болог

Үйлийн хэлхээ тасравч

Үр минь миний үргэлжлэл юм

Орчлонг орхих үнэнтэй ч

Охин миний үргэлжлэл юм

Амьдрал ямар мөнх биш дээ

Ашдын ерөөлөөр болог

Охин

Зүс танихгүй хүмүүс

Зүтгүй мууг ярилаа

Зүйргүй ачтай таныг минь

Биед халдахаар хэлэлцлээ

Өвгөн

Одтой сартай орчлонд

Олуулаа ирдэг үнэнтэй ч

Овилго гуцуу орчлонг

Орхиод явдаг жамтай юм

Ертөнц ямар мөнх биш дээ

Ерөөл билгээр болог

Цөлд ганцаар мөлхөлтэй биш

Цөхөрч зовж үхэлтэй биш

Цөөхөн хоногийн үйл юмсан

Цөвт амьдын үнэн юмсан

Хутаг бодовч мөрхрөх биш дээ

Хувь ерөөлөөр болог

Хөдлөл Ядсан өвгөнийг босоход

Ярсхийтэл цэгцэрч

Өст бүжиг хөллөж

Өвгөнийг өрлөж үзэгдэнэ

2-Р ҮЗЭГДЭЛ

Тайз Ядаг ноёны өргөөнөө

Ядуу бүсгүй хатан болж

Өлгийтэй хүүхдээ тэврээд

Өөрөөсөө ч ширвээдэж сууна

Бүүвэйлэх нь

Зээрэн чихтэй цавьдар чинь

Зэгс болно хулс болно

Зэсэн чихтэй борлог чинь

Дэрс болно хулс болно

Ээ бүүвэй ээ бүүвэй бүүвэй

Бүдүүн нарийн адилдаа

Цавьдар морин чинэгтэй

Бүтэл зэхий годилдоо

Бор морин чимэгтэй

Ээ бүүвэй ээ бүүвэй бүүвэй

Өдөр өдөртөө балархай

Шөнө шөнөдөө тодорхой

Их хар бага цавч

Эвий хонгор үр минь

Ээ бүүвэй ээ бүүвэй бүүвэй

Салхин зөв буруу чиг

Сар ялгадаг гэж мэддээ

Адаг эцсийг амсвал

Арван таван гэж боддоо

Ээ бүүвэй ээ бүүвэй бүүвэй

ХАА НЭГТЭЙГЭЭС ИХ ДУУН ГАРЧ ӨГҮҮЛЭХ НЬ

Эрмэг гүү сайн ч гэлээ

Эр моринд үл хүрмуй

Эдний нутаг холч гэлээ

Эртийн явдал сэдрэх бусуу

Удамт гүү сайн ч гэлээ

Унаган хүлэгт үл гүйцмуй

Уртхан зам алс ч гэлээ

Урьдын явдал сөдрөх бусуу

Хөдлөл Харсаар байтал нялх биетэй

Хатны адил толгойгоо боосон

Харц шивэгчдийн нэг

Хаалга сөхөн орж ирнэ

Шивэгчин

Эрхэмсэг хатан ээж минь

Эсэн мэнд амаржив уу

Эрдэнэ болсон хүү чинь

Энх тунх ажаам уу

Хатан

Буянаар ирсэн хүү минь

Бусдаас өөрцгүй мэндэллээ

Бурмаар тэжээхээс урьтаж

Урмаар гэдэг дээ баярлалаа

Шивэгчин

Харсаар байтал та

Хайр гэрэлтэж явдагсан

Хархан нүд чинь гунигтай

Хялгасан сүүдэр юуных вэ

Хатан

Уйлахыг бүү асуу

Инээхийг асуу гэдэг дээ

Ухилах охилох нулимсгүй ч

Уйлж л явна даа эгч нь

Шивэгчин

Үзсээр байтал та

Үзэсгэлэн төгөлдөр гунхдагсан

Үе үехэн сэрмэлзэж

Үргэсэн цочир юуных вэ

Хатан

Хар зөн ээдээд байна

Харьтан дайсан үзэгдээд байна

Хайртай үр минь балчирдаад байна

Хаан эзнээ ч хардаад байна

Элдэв зөн ээдээд байна

Эрээн бараан үзэгдээд байна

Эрэвгэр үр минь балчирдаад байна

Эзэн ноёноо ч хардаад байна

Шивэгчин

Таарсан энэ хувь заяа

Ташир бодох муу шивэгчинд

Татлаа түлхлээ байх биш

Та хүүгээ сольчих уу

Эвийг олоод өсвөл

Эр бие чангарна биз

Эхийг солиод өсгөчихвөл

Эд хардаад нэмэргүй биз

Хатан

Өрнөөс унасан өр юм даа

Өхөөр тээсэн үр юм даа

Өдрөөс өдөрт өсөх юм даа

Өлзий учралын бах юм даа

Шивэгчин

Тохоосон энэ хувь заяа

Тохь алдсан муу шивэгчинд

Тоомжир нэгэн байх биш

Тоодгор хүүгээ сольчих уу

Нууц нууцхан өсгөвөл

Нуган үр чангарна биз

Нутаг усаа зорьтол

Нухацтай хардлагаас өрсөнө биз

Хатан

Бодол минь богшоод байна

Болжморийн зүрхтэй юм уу би

Боломж бүхнийг эрэгцээх бүр

Бор зүрх минь чичрээд байна

Санаа минь саринаад байна

Салхины зүгтэй юм уу би

Сайхан ерөөлийг санах бүр

Сар жилийг хардаад байна

(ХөдлөлТүрэмгий эрчүүд орж ирж Түрүүчийн шивэгчин хөөгдөн гарна)

Тэд нийтээр

Буга намнаач төрсөн юмуу

Булга зүйгээч ирсэн юмуу

Буруу зөрүүг санах хэрэггүй

Бурхан биднийг явуулсан юм

Зэрлэг булга зүйгээч юм уу

Зэвт сумны наагаач юм уу

Нодог буруу санах хэрэггүй

Ноёнтон биднийг явуулсан юм

Эгнээ булга зүйгээч юм уу

Эрээн нум эвшээлгэгч юмуу

Элдэв буруу санах хэрэггүй

Эзэнтэн биднийг явуулсан юм

Нэг нь

Ахайтны амрыг эрье

Алив хүүг чинь үзье

Хатан

Хар л даа та нар

Хан хөвгүүний нүд нь

Хаан аавтайгаа адил юм

Хас тунгалаг гэрэлтэй юм

Нийтээр дуулах

Эм гарвал асар гэдэгсэн

Гэр нэвт гэрэлт бусуу

Эр гарвал цусал гэдэгсэн

Гэм зэмийн өст бусуу

Хүүхэн гарвал асар гэдэгсэн

Хүсэл цайлах гэгээт бусуу

Хүү гарвал цөсөл гэдэгсэн

Хүсэл дайлах өст бусуу

Охин гарвал асар гэдэгсэн

Ураг шингэлэх гэгээт бусуу

Хөвүүн төрвөл цаазал гэдэгсэн

Тураг зэврэх өст бусуу

Нөгөө нь

Хатны амрыг эрье

Хан хүүг чинь үзье

Хатан

Үз л дээ та нар үз

Үр минь эцэгтэйгээ ижилхэн юм

Эзэн ноёнтон адилхан юм

Эрдэнийн тунгалаг гэрэлтэй юм

Хөдлөл Хүүгийн өлгийг дэлгээд

Хүдэр эрчүүд шуналтай харна

Нэг нь

Эр хүн байна

Эрдэнийн шүрэн хөөрөгтэй юм

Алив тамхилъя

Ах чишш

Нөгөө нь

Хан хүү байна

Халтар манан хөөрөгтэй юм

Алив тамхилъя

Ах чишш

Хөдлөл

Тэнгэр нүргэлэх шиг хөгжим өндөрсөж

Тэнд айдас хургахад

Хатан хүүгээ шүүрэн авч

Халуун элгэндээ тэвэрнэ

Нэг нь

Харахад ханцуйн чинээ юм

Халхын харуудын адил биз

Хувь заяаг бууржилж

Хув Нагварал гэж нэрлэе

Нөгөө нь

Өлгийдөө өөдөсхөн чинээ юм

Өөлдийг сөнөөх гэж төрөө биз

Өсөх заяаг бууржилж

Хув Нагварал гэж нэрлэе

Хөшиг

3-Р ҮЗЭГДЭЛ

Тайз Их гэрт хатан морилоод

Ирэх явахад зовж суухад

Хув Нагварал саадаг агсаад

Хурганы хүүхэд шиг дэгдэж ирнэ

Хүү

Ээжээ ээжээ ээжээ

Эрхийвч минь халлаа

Эр хар нөж хурлаа

Эрчис билэг шингэв бололтой

Эх

Алив хүүгээ үнсэе

Аргалын өргөс тороо биз (үнсэнэ)

Хүү

Ээжээ ээжээ ээжээ

Эгших цээж минь галшлаа

Эрхбиш нэгийг бодлоо

Эр бие өсөв бололтой

Эх

Эрхийн чинээ үр минь

Энгэрийн цөс оргио биз

Хүү

Асралт эх минь сонс доо

Аавын тухай агтын дэлэнд

Алтан зөн босов биш үү

Амар амгаланд дуудав биш үү

Эх

Амраг үр минь сонс доо

Айгуус мануус харагдаа болов уу

Хүү

Энэрэлт ээж минь сонс доо

Эцгийн тухай морин төвөргөөнд

Эрчис зөн босов биш үү

Эрххэн хүслээр дуудав биш үү

Эх

Алдрай багахан үр минь

Ай чи юу хэлнэм

Аавын захиасыг дуулж өгье

Аман билгийн ерөөл айлдая

Эрэвгэр нүдэн үр минь

Эрххэн хүү минь юу хэлнэм

Эцгийн захиаг дуулж өгье

Эрдэнэ болсон ерөөл айлдая

Бүүвэй баатарын үр юмсан

Бүтэн заяаны эв юмсан

Аман захиасыг дуудаж өгье

Аавын чинь үгийг хэлж өгье

БҮҮВЭЙН ДУУ

Зээрэн чихтэй цавьдар чинь

Зэгс болно хулс болно

Зэсэн чихтэй борлог чинь

Дэрс болно хулс болно

Ээ бүүвэй ээ бүүвэй бүүвэй

Бүдүүн нарийн адилдаа

Цавьдар морин чинэгтэй

Бүтэл зэхий годилдоо

Бор морин чимэгтэй

Ээ бүүвэй ээ бүүвэй бүүвэй

Өдөр нь өдөртөө балархай

Шөнө нь шөнөдөө тодорхой

Их хар бага цавч

Эвий хонгор үр минь

Ээ бүүвэй ээ бүүвэй бүүвэй

Салхин зөв буруу чиг

Сар ялгадаг гэж мэддээ

Адаг эцсийг ажвал

Арван таван гэж боддоо

Ээ бүүвэй ээ бүүвэй бүүвэй

Хүү

Ай сайхан зарлиг вэ

Азтай энэ өдөр

Амар амгалан амьдралын

Алтан үүдэн сүлдлэв үү

Мунхаг харанхуй гэрэлтэж

Муугийн сүүл шувтарлаа

Сайны эх ойртсныг

Сайхан ээж минь мэдэв үү

Ээж

Ачит хонгор үр минь дээ

Аавын зарлиг бат болог

Хүү

Ёсоор ёсоор

Зарлиг бат

Хүү

Өвгөө өрлүүлсний

Өс болж торинов би

Өвчүүгээ хадуулсны

Өрөндөг болж өсөв би

Санах цагийн зарлиг

Сайхан аавын захиас

Сайн цаг ойртсныг

Сайхан ээж минь мэдэв үү

Ээж

Эвий хонгор үр минь дээ

Эцгийн зарлиг бат болог

Хүү

Үгэнд учир суманд гичир

Үнэндээ ээж минь утга тодорхой

Яасан сайхан зарлиг вэ

Ямар гайхам зорилго вэ

Ээж

Юу хэлэв үр минь

Зарлиг бат болог

Хүү

Гайхаад яах вэ ээж минь

Гадаах чимээг отъё

Ганилсэн сэтгэлийг нимгэлж

Гандсан үгсийг тайлья

Ээж

За тэгдээ хүү минь

Зарлиг бат болог

Хүү

Ёсоор ёсоор

Хүү

Айгаад яах вэ ээж минь

Алив чимээг отьё

Амар амгалангийн эхэнд

Аман зарлигийг тайлья

Ээж

За тэгдээ үр минь

Зарлиг бат болог

Хүү

Ёсоор ёсоор

Хүү

Дэрс хулс гэдэг

Дэндүү сайн хагсаа гэжээ

Бүдүүн нарийн гэдэг

Бүхнийг төгс тааруул гэжээ

Өөрөө цавьдрыг ээждээ борыг гэжээ

Өдрөөр бүгж шөнөөр замна гэжээ

Эх

Өршөөлт эцгийн чинь үг

Өөгүй үнэнтэй ч гэлээ

Өөдөсхөн хүү минь боддоо

Өшлөх зүрхэн гэнэн шүү

Хүү

Их хар бага цавч

Итгэлээ эвлэтэл сэргэг гэжээ

Салхин зэвгэй ирт сумаа

Саадагтаа хийгээд агс гэжээ

Адаг эцсийн болзол хугацаа

Арван таван насандаа гэжээ

Ээж

Эхийн санаа үрд

Үрийн санаа ууланд

Энэ ямар үнэн бэ

Үйлийн үрийг нимгэлье

Хүний газар эгзэгтэй

Хүлэг морин эндэлтэй

Хүсэл сэтгэлийг цэгцлэвч

Хүү минь ахин бодолтой

Хүү

Эр морь

Эс харайсандаа хүрвэл

Дөрвөн туруундаа шар устай гэлээ

Дөмөгхөн үг биш билүү

Эх

Энтэй газар эгзэгтэй

Эмээлт морин эндэлтэй

Эр бие өсөвч

Эвий үр минь бодолтой

Хүү

Эр хүн

Эс зорьсондоо хүрвэл

Эрхий хуруундаа шар устай

Эндүүрэлгүй хэлсэн үг биш үү

Гэрэл унтарна

Хөдлөл Морин төвөргөөн зугтах бүжиг

Монгол аялгуу бахархах хөгжим

Алслан холдох бүдэг чимээ

Асах гэрэл алсын харгуй

ХУВ НАГВАРАЛЫН ДУУ

Сайхан цавьдар мориндоо

Сайн эр дөрөөллөө

Саран зэвтэй сумыг

Сарвайтал татлаа

Санаа муутай та нарт

Сарвайх чадал байна уу даа

Хүлэг сайн мориндоо

Хүний хүү мордлоо

Хүчит хүрэн нумыг

Хүчлэн байж татлаа

Хүйтэн санаат та нарт

Хүрэх чадал байна уу даа

Өрлөгдсний өшийг авахаар

Өнчирсөн эхийг бахлахаар

Эцгийн харгуйг тайлахаар

Эр бие хөдөллөө

Халхын хүү харилаа

Хар санаатан хаягдлаа

Харанхуйлал

Хөдлөл Төдөж удалгүй

Төвөргөөн холдоно

ХОЁРДУГААР БҮЛЭГ

4-Р ҮЗЭГДЭЛ

Тайз Халхын хэрсүү Цэвэг

Ханхар эр бодолт хүмүүн

Галзуу улаан дүнсээ нэрж

Ганц нэг шившинэ

Хүлгийн төвөргөөн дөрөөн чимээ

Хүү эх хоёр ирнэ

Хөдлөл Биест мэхийн хүндэтгэл үзүүлж

Билэгт үгийг хэлэлцэнэ

Цэвэг

Нүүрэндээ галтай

Нүдэндээ цогтой

Шилэндээ махтай

Шилбэндээ чөмөгтэй

Жаахан хүү хаа хүрч явна

Хэрэг зориг хэнд вэ

Хэт нутаг хаана вэ

Яваа зориг хэнд вэ

Ямба ёс хаа вэ

Хүү

Хэрэг зориг хэюүд ястанд

Хэт нутаг энүүхэн баруугаар

Яваа зориг тост боржигинд

Ямба ёс байдаггүй

Цэвэг

Хэдэн үгийн зөрөөгүй

Хэлний ээдрээ тайлалгүй

Хэрэг зоригийг асуухад

Хэт нутгаар хэдэрлээд

Юуны туханд хүрэлгүй

Нутаг усыг сонжоод

Юу хэлэх гээд чи

Юу хэлэв гээд

Хөдлөл Зүггүйхэн хүүд илдээ сугалж

Зүрх юунд нь тааруулна

Эх нь

Үр минь балчир юм өршөө

Үг нь холчир юм өршөө

Цус нь шингэн юм өршөө

Цуур алдаргүй нимгэн юм өршөө

(сөгдөнө)

Хөдлөл Хатан болд сэлмээ

Хархийтэл хуйлав

Хүү

Ай ах минь та өршөө

Аян сунаад бие чилжээ

Аргай даргай үгийг

Адаръя гэж алдсангүй

Ухаант ах минь өршөө

Урт замд бие чилжээ

Ужиг балархай үгийн

Утгыг тайлах гэж яарлаа

ЦААШ ӨГҮҮЛЭХ НЬ

Хүү

Батмөнх даян хааны

Баттай аравдах хөвгүүн

Жалайр хун тайж Гэрсэнзийн

Жаргалтай үрсийн удамсан

Аминдураал ноёны

Алаг үрсийн хэлхээ

Сэцэн хан Шолойн

Сэргэлэн үрсийн хойчсон

Далай хун тайж Бадамдашийн

Дараагийн удам Дамбадашсан

Эрхэт бээл Цэвдэн

Эрдэнэ Бүүвэйн хүүсэн

Алвал алтугай

Ачилбал авартугай (сөгдөнө)

Цэвэг

Мөрөөдөлт бяцхан хүү минь

Мөр замыг чинь мэдлээ

Зорьж гарсан омог

Зориг хүчийг чинь үнэллээ

Алдрай хонгор хүүгийн

Алдар нэр хэн бэ

Хүү

Өөлдөөс өөрт хайрласан нэр

Өөдөсхөн хув Нагварал

Өстнөөс өөчилж өгсөн алдар

Өнөөх л хув Нагварал

Өвгөө өрлүүлсний

Өс болж торинов би

Эцгээ эвдүүлсний

Эрлэг болж өсөв би

Цэвэг

Ай ноёнтон минь өршөө

Андуу ташааг хүлцэж хайрла

Амны алдааг хүлээзнэж соёрх

Амар амгалан морилж явна уу та

Хөдлөл Сөхөрч суугаад Цэвэг

Сөгдөж мөргөхөд хүү гайхна)

Ээж

Эвий үр минь бурхны өршөөл

Эсрэн тэнгэр буяны язгуур

Эрххэн үр чи нутагтаа иржээ

Эцэг шигээ хүнийг түшиж босгоо

Хөдлөл Хүндлэл эрхмийг ёсчлон

Хүү Цэвэгийг түшиж босгоно

Цэвэг

Хурсан олон чинь хүлээж буй

Хувилгаан тэнгэрийн зарлиг өчье

Хувь заяаг гутааж өгсөн

Хув Нагварал нэрийг орхиё

Гүн ухаант танд

Гүнзгий сэтгэлт чамд

Бэрхийг туулсан Ваанжил

Бээл хэргэм өргөө

Тэнгэр ухаант танд

Тэсвэр тэвчээртэй чамд

Түмний ноён Ванжил

Түшээ хэргэм өргөө

Хөдлөл Хаадын ёслолын бүжиг

Хас их цэнгэл

Өргөн их хүндлэл

Өргөлийн дуу цууриатна

ӨРГӨЛИЙН ДУУ

Хан тэнгэр эцэг минь билээ

Хараа ихтэй тугаа тахья

Хавт их боржигид минь билээ

Хатан болд зоригоо зэхье

Хатан болд зоригоо зэхэе

Мөнх тэнгэр эзэн минь билээ

Мөнгөн бүрдэл ёсоо сахья

Мөрөөдөл ихт боржигид минь билээ

Мөнхрөх замд алдраа сийлье

Мөнхрөх замд алдраа сийлье

Алтан ураг эцэг минь билээ

Асрал ихт сүлдээ тахья

Амин шүтээн боржигид минь билээ

Асах мөнхийн голомтоо сахья

Асах мөнхийн голомтоо сахья

Хөдлөл Их баяр болж буй

Ирмүүн бүжиг өрнөнө

ГУРАВДУГААР БҮЛЭГ

5-Р ҮЗЭГДЭЛ

Тайз Гэрэл алгуурхан асахад

Гэгээ аясхан өгөхөд

Есөн сүнс эргэж харахуй

Ес дэх нь Гомбосүрэн байх

Голд нь Цэрэнсандив сууж

Гоо бүсгүйчүүл бүжиг асаана

Эрхэмсэг тэр бүжгийн хэлээр

Энгүй их хүндлэл илэрхийлнэ

Цэрэнсандив ноён сууж

Цэнхэр боржигинд найр эхэлнэ

“Хөг нийллээ” гэхүй

Хөлтэй найр жигдэрч

Хуур лимбэ эгшиглэж

“Авралын дээд” цууриатна

Зээ Авралын дээд багш ламдаа

Өлмийн лянхуа бат

Эрдэнийн жанжин төр

Элдэв сайнаар бадартугай зэ

түрнэ

Зээ Хуур магнайн эгшгэнд

Хурсан бүгд даяараа

Ая түрлэгээ өргөн

Амар жаргалтай найрлая зэ Гэхүй

Хөдлөл Хурсан олны түрлэг

Хуурын цар доргитол өндөрсөөд

Амгалангаа орших найрчид жаргалтай

Ая дуу цааш зөөлөн эгшиглэхүй

ӨГҮҮЛЭГЧ

Гүүнийхээ сүүгээр найрладаг

Гүнцэг арвин зооглодог

Хусрангийн сүүгээр найрладаг

Хувь хишгээ түгээдэг

Найрыг нэг нь даргалдаг

Наадмыг нэг нь ахалдаг

Дугараа бүрээр дуугардаг

Дуу хуураар эрэмбэлдэг

Морьт боржигдын цэнгэл

Монгол цэргийнх мөн өө

Баруун талыг ханалах

Баатар зоригт хөвгүүд

Бардам дүүрэн зантай

Барсын омогт эрчүүд

Зүүн талаар эгнэх

Зүс гоо бүсгүйчүүл

Зүүдний тайлал шиг үзэсгэлэнтэй

Зүйлийн цэцгэс шиг өнгөтэй

Морьт боржигидын цэнгэл

Монгол цэргийнх мөн өө

Бошго ухаарлаар суухдаа ч

Босно гэдгийг санадаг

Босгон талын өвдгөө

Босоо чигээр нь түшдэг

Машид гүн сэрэмжээр

Малгайтай сууж дуулдаг

Эмээлт хүлгэдээ бэлэн

Энгэрээ товчилж уудаг

Морьт боржигдын цэнгэл

Монгол цэргийнх мөн өө

Харанхуйлал Найрчид түрнэ

Хөдлөл Гэрэл өгөхөд түгшүүрт аялгуу

Гэндсэн ноён аглагт ганцаар

Хөлсөө шударч хөлөө сольбиж

Хөдөө хээрт буутай алхана

Дуулах нь

Төрийн бээл Ванчинзавын

Төрлийн хэлхээ удам юмсан

Хун тайж Дагдандоржийн

Хувь заяаны хэлхээс юмсан

Жанжин бээл Намжилдоржийн

Жаргалтай үрсийн нэгэн юмсан

Үйзэн мэргэн Гончигжавын

Үр удмын үзүүр юмсан

Далай бээл Гунгаадоржийн

Дараа төрсөн чин ван юмсан

Ноён заяа газардаж

Нохойн замаар жорооллоо

Өнөөдөр яасан өдөр вэ

Өргөн талд явгарлаа

(Ая хурдасана

Айзам өндөрсөнө)

Хорголжин сум минь

Зээрэнд тусахгүй

Холдооч ойрдоо ч

Зэргийн оньчгүй

Тугалган сум минь

Туулай ч шалбалахгүй

Тураг биед

Тусгал оньчгүй

Өнөөдөр яасан өдөр вэ

Өлбөрөх шахлаа би яах вэ

Эмээлт хүлэг минь

Эзнээ орхилоо

Эрэвгэр хярын

Шилээр давлаа

Сайн хүлэг минь

Эзнээ явгаллаа

Санхюу гөлмөө

Дэрвүүлж одлоо

Явдал бүтэлгүй ямар өдөр вэ

Явгарч үлдлээ би яах вэ

Хөдлөл Хэсэг амарч суугаад

Хий саравчлан босохдоо

Толгодын сугад

Торолзоод байгаа

Товцог төдий

Тэр юү вэ

Холын зэрэглээнд

Холбироод байгаа

Хомоол төдий

Тэр юу вэ

Бутны хооронд

Бумбайгаад байгаа

Буурцаг төдий

Тэр юу вэ

Цэцгэсийн дунд

Бөргийгөөд байгаа

Цэгийн төдий

Тэр юү вэ

Ай ямар бүтэлгүй өдөр вэ

Айлын бараа биш биз дээ

(Хэсэг саравчилж харна)

Алс тэртээ дайдад

Айлын бараа харлаа

Гэрэл гэгээ цацарлаа

Гэрийн бараа үзэгдлээ

Ангасан бие тавирч

Амсхийх цаг боллоо

Цангасан сэтгэл дэвэрч

Цаашдаа алзахгүй боллоо

(Гүйх алхах зуур яаран одно)

Хөдлөл Хөшиг нээхэд Цэрэнсандив

Хөөргөн онгиргон долоон залуу

Хэрж бүжиглэнэ хэдэрч бүжиглэнэ

Хэрэг зоригийг асууж бүжиглэнэ

Хэл амаа олохгүй бүжиглэнэ

Хээхэлзэж хэсэг ээрч бүжиглэнэ

Зугтах бултах халаг сандарч

Зуур замдаа ноён гарч явна

(Танхай залуус бүжиг өндөрлөөд

Тараад явах гэтэл)

Эх

Хүлээж бай та нар

Хүн үзээгүй ороолонгууд уу

(Хөвгүүд эргэлзэнэ)

Эх

Зогсож бай та нар

Зочин үзээгүй араатанууд уу

(Хөвгүүд зээглээд зогсоно)

Эх

Томоогүй үрс минь

Тойроод сууцгаа

Хэн хүний үр

Хэрэг болгож манайд хонов

(Хүүхдүүд нэг нэгээр суух зуур

Хүн бүр ам амандаа)

Хүү

Явуулын нэг анчин биз

Явдлын нэгэн гөрөөчин биз

Нөгөө хүү

Цангаж ундаассан аянчин биз

Цагаа горьдсон гуйрамч биз

Бас нэг нь

Зээр гөрөөс авлаачин биз

Хээр хөдөө хэрээчин биз

Эх

Үгүй дээ үгүй Тийм биш

Үрс минь юун томоогүй

Пауз

Хан хүний үр бололтой

Хатавчин дээр буугаа тавихад

Хана туурга хавгалзаж байсан шүү

Хар гэр минь шажигнаж байсан шүү

Хүү нь

Үнэг туулайн авчаач биз

Үүр шөнийн овлооч биз

Нөгөө хүү

Чоно нохойн ангууч биз

Чогчого зурамны гөрөөч биз

Бас нэг нь

Тарвага зурам тогшооч биз

Танхай нэгэн хэсүүлч биз

Ээж

Үгүй дээ үгүй Тийм биш

Үрс минь юун гэнэнхэн

Пауз

Яавч тэр эгэл биш

Явдал аяны хүн биш

Дотоод хормой нь ярсхийхдээ

Дориун булга цухасхийсэн шүү

Хүүхдүүд

Үгүй байлгүй дээ

(зэрэг хэлээд босоцгоож бүжиг үргэлжилнэ)

Хөшиг

6-Р ҮЗЭГДЭЛ

Тайз Бодол болсон ноён өргөөндөө

“Боржигины намар” дуу уянгална

ДУУЛАХ НЬ

Хуурын эгшигт уулс урганаа

Хувьхан заяаны үйлс өргөнөө

Хултай айрганд тэнгэр эрхлэнээ

Хутаг бодсон итгэл тэгширнээ

Боржигины намраа

Бороотой намраа

Бодолд эрхлэх

Боржигины намраа

Таанын айраг тагнай цоргиноо

Талын эндээ жаргал эрхэлнээ

Тансаг уяхан шуранхай цойлноо

Таны амрыг эрэн дууднаа

Дахилт

Цэцгийн шимээр үндэс охилноо

Цэнхэр боржигинд жаргал эрхэлнээ

Цэцэн ээлийн магнай тэнийнээ

Эзэн заяаны манлай тэнгэрээ

Дахилт

Гурван дугараа түрлэг өргөнөө

Гурван хайрхан уулсаа сүсэлнээ

Гувай хатад зүсээ гайхуулнаа

Гучин усны цаадтай гэрэлтнээ

Дахилт

Хөдлөл Өндөрлөх дуунаар

Цэрэнсандив ноён

Өндийж нэгийг бодох зуур

Гаднаас нэг хиа орж ирж

Гарцаагүй бялдуучхан эрх дуугаар

Хиа

Мушгиагийн хонхорт байдаг

Муу хүмүүсийг авчирлаа

Ноён таныг танилгүй

Нойргүй хонуулсанд

Ял тогтооно уу

Ноён

Галгүй гэрт боловч

Гайгүй дулаан хонуулсан юм

Тавиад явуулчих

Хиа

Хэдэн зэрлэг залуусаас

Хэрэг толгойлсон этгээд

Тэр чавганцын ганц хүүг

Тэнгэр яаж таалах бол

Ял тогтооно уу

Ноён

Айлын ганц юм билээ

Аргагүй ядуу юм билээ

Тавиад явуулчих

Хиа

Танхай тэр залуус

Танай сүргийн гүүг идчихээд

Ноён таныг доромжиллоо

Ногдох ялыг сонсоё

Ял тогтооно уу

Ноён

Арддаа танигдаагүй ноёны

Арчаагүй нь тэр биз

Тавиад явуулчих

Хиа

Хошуу ноёноо таньдаггүй

Хойд урдахаа мэддэггүй

Итгэл эвдсэн зэрлэгүүдээр

Идүүлсэн гүүгээ яаж төлүүлэх вэ

Ял тогтооно уу

Ноён

Чи тэр залуугийн

Чихийг авах гээ юү

Тавиад явуулчих гээд

Хөдлөл Аядуухан дээш харснаа

Алга хавсарч бичээчээ дуудаад

Энэ миний зарлигийг

Эмээлийн дуунд ав

ЗАРЛИГ БОЛГОХ НЬ

Нэгэн зүйл

Боломж бололцоо бүхнээ шавхаж

Боржигин айл бүр таван ханаттай байг

Нэгэн зүйл

Хурсан олны цэнгээнд бодож

Хуур лимбийг гэртээ байлга

Нэгэн зүйл

Зориг хэргийг асууж шалгалгүй

Зочин бүхэнд олбог тавь

Нэгэн зүйл

Хол ойрын ялгаа үгүй

Хоноцыг хоолтой дулаан унтуул

Нэгэн зүйл

Ирэх хүнд нохой хорь

Их өргөөнийхөө үүдийг сөх

Нэгэн зүйл

Нялхас бүрийг энэрч яв

Настныг асран хүндэлж бай

Энэ миний зарлигийг

Эмээлийн дуунд ав хэмээв

7-Р ҮЗЭГДЭЛ

Тайз Цагаан нөмрөгт сүнсүүд

Цааш харж сууна

Эргэж харсан ганц нь

Эрхэм Юндэндорж ноён байна

Хүүхэд ноён Юндэндорж

Хүн дүрсдээ орж

Цагаан нөмрөгөө ус шиг урсгаж

Цааш өчил шүлгээ хэлнэ

ӨЧИЛ

Мөнх тэнгэр шүтээнт

Эзэн Чингэс минь өршөө

Мөнхөрлийг олоогүй хорвоод

Эндэл гундал элбэг юм

Мөрөөдөл хүслийн элбэгт

Эрх сэтгэл минь өршөө

Мөнгөн сарны доор

Эр бие минь ганц юм

Тэнгэрээс гэрэл атгасан

Тэмүүжин эцгийн удамсан

Тэмцлээс гэнэ агссан

Тэр цагийн тэмдэгсэн

Цэцэн чин вангийн төлөөс юмсан

Цэрэн сандивын үр юмсан

Жүн вангийн зэрэгт бээл юмсан

Жүрхэний Бүри Бөхийн тээл юмсан

Үе залгамжлах гэгээн үйлсэд

Нэр залгамжилсан ноёхой юмсан

Үе үеийн ухаант түмэндээ

Нэхэл цөхлийн үнэнийг өчсү

Хоёрхон жилийн хомсхоныг яана

Хорвоог орхино гэж санасангүй

Хонгорхон насны гэнэхнийг яана

Хожимдсон гэмшил даанч үнэгүй

Ноёдын удмыг удаалах

Алтан ураг тасарлаа

Номхон ардын дундаас

Хошууны ноён тодорлоо

Бүри бэхийг бүрэлгэсэн

Хилэнц нүгэл нүүрлэлээ

Бүтэн заяаг өшилсөн

Хишиг буян дундарлаа

Жүрхэн овгийг зүдрээсэн

Зүүдний тайлал хөвөрлөө

Хутагт Монхорыг мохоосон

Хувь заяа минь алдарлаа

Бархагийн зоригт хөвгүүдийг

Баалсан минь башир боллоо

Бүри бэхийн ууцыг хугалж

Бүрэлгэсэн минь балар боллоо

Өсөхүйеэ бэрх цаг юм яалтай

Өтлөхүйеэ хэрх үе юм юутай

Өндөр дээд тэнгэртээ мөргөө

Өтгөс өвөг удамдаа сөгдөө

Нэрэн хун тайжийн хүү

Нэгэнтээ ноёноор тодорлоо

Хохь тайж Нэрэнгийн хүү

Хошуу олныг түшлээ

Мөнх тэнгэр мэдтүгэй

Хөдлөл Нөмрөгөө нөмрөөд Юндэндорж

Нөгөө сүнсүүдийн адагт сууна.

Харанхуйлал

Хөдлөл Гэрэлд сүнсүүд эргэж харна

Голд нь Гомбосүрэн ноён сууна

Гагцаар хүн нүүртэй байна

Гайхамшигт бүжиг гангарна

Тэр бүжгийн утга нь

Тэнгэрийн аястай баяр байна

ӨГҮҮЛЭХ НЬ

Илдийн ирэн дээр бөмбөрсөн

Галт сүнсгий оргилсон

Ижлийн сэтгэл дээр бөлбөрсөн

Гарьдын жигүүрт омогсон

Ихэсийн зиндаанд өртөлзсөн

Хүн сүнсний хэдэрсэн

Ид хаваар сөртөлзсөн

Хүслийн цагаахан хэлхээсэн

Төөрсөн сүнсний буян юмсан уу

Төгөлдөр заяа баян юмсан уу

Төсөрч гундахгүй итгэл юмсан уу

Төвөгт төөрөхгүй сэтгэл юмсан уу

Өндөр дээд өвгийн минь буян

Хэргэм мяндаг зэргэллээ

Өвт их овгийн минь баян

Хэтийн үйлсэд зориглолоо

Хөгжим өндөрсөнө

Хөдлөл Эрийн гурван наадам

Эрхий мэргэн харваач

Хурсан олны цэнгэл

Хурц хурдан морьд

Хүдэр чийрэг эрчүүд

Хүчит бөхийн барилдаан

Бүжгийн хэлээр оргилж

Бүхний цэнгэл даргилна

Өгүүлэх нь

Бартан баатрын удам дамжсан

Баруун замын дундад хошуу

Энэ цагийн хоймор эзэлж

Эрхт ардын хийморь түшив

Бүри бөхийн сүнс сүлдэр

Бүтэн зургаан зууны турш

Амь мэт тэмцэлд хатуужиж

Амар амгалангийн замыг тэгшлэв

Жахрай ханыг арлан жаргаж

Жалман ханыг өвөрлөн өтгөрч

Боржигин түмний сүлдийг өргөж

Босоо цагаан хийморь дэрвэв

Жаргалтай түмний өлгий нутаг

Жанжин Чойрын өлмий бат

Эгэл ардын омог цоргиж

Энэ зууны домог оршив

Хөдлөл Ая дуу цээлшиж

Амар амгалангийн гэгээ цэлсхийж

“Цэцэн вангийн нутаг” гэдэг

Цээлхэн дуу уянгална

Банзрагчийн ая Цэцэн вангийн нутаг

ХӨШИГ

ДУУНЫ ШҮЛГҮҮД
БОРЖИГИН БИЛГИЙН АЯЛГУУ

Шүлгийг Рагчаагийн Батжаргал

Аялгууг Г.Эрдэнэчулуун

ГОВЬСҮМБЭР

/хүндэтгэлийн дуу/

Цэцэн вангийн цэнхэр уулс минь

Цээжинд уяатай боржигин нутаг минь

Өвгөдийн даллагатай итгэлийн хэлхээ

Өтгөсийн зартай сэтгэлийн учгаа

Амьдрал тэмцлийн эрхэм зүмбэрээ

Амин хэлхээ элгэн сүмбэрээ

Азын босготой говийн сүмбэрээ

Алтан нутаг Говьсүмбэр ээ

Тост боржигины торгон тал минь

Тольт зүрхний уяат нутаг минь

Ухаант түмний эвийн хэлхээ

Улаан залаат өвгөдийн нутгаа

Үлгэрийн зартай уулан сүмбэрээ

Үүдэн сүлдтэй унаган сүмбэрээ

Ашид орших эрдэнийн сүмбэрээ

Алтан нутаг Говьсүмбэр ээ

Хиад боржигины хонгор толгод минь

Хишиг буяны өлзийт нутаг минь

Андгай нэгтэй хаадын удмаа

Алтан ургийн амин нутгаа

Галын даллагатай уурхайн сүмбэрээ

Ган замтай хөгжлийн сүмбэрээ

Ахуй баян эрчмийн сүмбэрээ

Алтан нутаг Говьсүмбэр ээ

Шүлгийг Жалбуугийн Дансранжав

ТАЛ НУТГИЙН ДУУ

/Дорноговь аймгийн сүлд болсон/

/ Аялгууг Жагдал /

Санан санан бодоход

Саравчлан саравчлан хармаар

Нүдний хараа сунгасан

Миний нутаг уудам даа

Уурга барьсан адуучин

Уртын дуу аялаад

Даамай сайн мориороо

Давхин явдаг орондоо

Нуур шиг зэрэглээн дунд

Нутгийн айлууд тодроод

Түмэн сүрэг налайсан

Миний нутаг баян даа

Харьд яваад ирэхэд

Хараад зогсмоор санагддаг

Хаа ч явсан миний

Хайрлан дуулдаг орон доо

1957 он

Шүлгийг Жалбуугийн Дансранжав

ЭХ ОРНООН МАГТАН ДУУЛЪЯ

/ аяыг Б.Түвшинжаргал /

Цовоо сэргэлэн дуу минь

Гадаа гэртгүй цуурайтсан

Цогтой ариун хөдөлмөр

Газар сайгүй өрнөсөн

Эх орноон магтан дуулья

Энэ дууг цөмөөрөө өргөөрэй

Нэгдлийн үржилт сүрэг минь

Цэлгэр талыг чимсэн

Нийгэм журамт уралдаа

Дэлгэр хөгжлийг нь ундруулсан

Эх орноон магтан дуулья

Энэ дууг цөмөөрөө өргөөрэй

Хорвоогийг түмэн ардтай

Хувиршгүй бат холбоотой

Хотол даянаа жолоодсон

Хошууч баатар намтай

Эх орноон магтан дуулья

Энэ дууг цөмөөрөө өргөөрэй

Шүлгийг Рагчаагийн Батжаргал

ЦЭЦЭН ВАНГИЙН НУТАГ

(Аяыг МУСТА Б. Банзрагч)

Ингэн цагаан гунганаа

Шингэн хөөмий аястай

Ижий аавын нутаг

Ирэх явахын уяатай

Цэцэн вангийн нутаг

Цэцэг зулсан хөндий

Цээжинд үргэлж уяатай

Цэнхэр боржигины өлгий

Аяс аясхан сэвшээ

Алтан лимбийн эгшигтэй

Аав ээжин нутаг

Амин голын уяатай

Дахилт

Төрж өссөн нутаг минь

Төөрөг заяаны холбоотой

Төгөлдөр их аялгуу

Төгс уянгаар цалгиастай

Дахилт

Шүлгийг Рагчаагийн Батжаргал

ИЖИЙ МИНЬ ЗҮРХНИЙХ ЮМ ДАА

Налгар намар алтаар урсавч

Навчсын сондор гандаа шүү дээ

Насны хишигтэй ижий минь дээ

Намайгаа гэсээр гундаа шүү дээ

Ижий та минь зүрхнийх юм даа

Энэхэн хорвоод зүүднийх юм даа

Үйлийн эрхийг харцаар ээрэвч

Үнэсээд угтахгүй ижий минь дээ

Үнэний хорвоод мөнх биш дээ

Үгүйлээд ханашгүй эрдэнэ минь дээ

Дахилт

Энгэр нэвчтэл нулимсаар дэвтэвч

Эргээд заяахгүй ижий минь дээ

Эрххэн үр чинь үгүйлээд байна даа

Эмзэг сэтгэл урагдах юм даа

Дахилт

Шүлгийг Рагчаагийн Батжаргал

АРВААЛЖ

(Аяыг МУСТА Батдэлгэр)

Зандан зандангийн үнэр гэлээ

Загтай хонгор шугуй юу даа

Замилан замилангийн жам гэлээ

Загийн шар арваалж уу даа

Арваалж арваалж арваалж

Амь эрсэн арваалж

Хилэнц нүглийг хурааж гэлээ

Голомт тойрсон амьдарал уу даа

Хэтдээ нэг л орчилд гэлээ

Говийн шар арваалж уу даа

Дахилт

Яшлын хаттай шугуй гэлээ

Яагаад ч юм бэ дээ дуусаа юу даа

Ярдаг ааштай аалз гэлээ

Яалтгүй бид нар айлсаа юу даа

Дахилт

Шүлгийг Рагчаагийн Батжаргал

УХААРАЛ

(Айыг МУСТАГанболд)

Ээжий аав хоёрыгоо

Элэхгүй юм шиг саналаа даа

Элбэрэл ихтэй хайры нь

Эцасгүй юм шиг бодлоо доо

Гэрийн хойморт төөрч явна даа

Гэнэн цалгар ухаарал минь дээ

Гэмгүй атлаа гэмшиж явна даа

Гэгээн хоёр бурхан минь дээ

Буянтай хоёр буурлыгаа

Буцахгүй юм шиг саналаадаа

Бурхан ээлтэй хайры нь

Буурахгүй юм шиг бодлоо доо

Дахилт

Аав л ээж хоёрыгоо

Алдахгүй юм шиг саналаа даа

Амин эетэй хайры нь

Ажрахгүй юм шиг бодлоодоо

Дахилт

Шүлгийг Рагчаагийн Батжаргал

ШАГАЙ ХАРВААЧДЫН ДУУ

(Аяыг А.Доржпалам)

Гүгэл зандан хашлага нь хө

Арван цэнгийн сумтайдаа

Гүндүү андуугүй сэтгэл минь хө

Алтан юмбүүнээс үнэтэйдээ

Зэ хэ хэ хэ

Зэ хэ хэ хэ

Зэ хэ хэ хэ

Ууухай уухай уухай

Бөгтөр суман зурхайдаа хө

Ханан хасаа өнгөтэйдөө

Бөртөн төдий дүүжиндээ хө

Харвах тоолон оноотойдоо

Дахилт

Хожил дундлах эрэмбээрээ хө

Зэ хурайн эетэйдээ хө

Хорин хасаа шимэхдээ хө

Найн уухай түрлэгтэйдээ

Дахилт

Цэцэн түргэн сум нь хө

Эгнээ хасаандаа ончтойдоо

Цэц мэргэн харваачид нь хө

Эвийн халуун ерөөлтэйдөө

Дахилт

Шүлгийг Лувсаншаравын Содномдорж

УХААРЛЫН ДУУ

Тэнгэр заяатай аавынхаа

Ачийг хариулж чадлуудаа

Тэнүүн сэтгэлт ээжийнхээ

Ачлалыг хариулж барлуудаа

Дахилт:

Уужим орчлон эргэхүй

Ухаан санаа ариусна

Ухаан бодол ариусах

Ухаарч эгээрч амьдарна

Сүүн замтай ханийгаа

Сэтгэл бүтэн байлгалуудаа

Сүжрэн дээдлэх үрсийнхээ

Итгэлийг нь бүлээн явууллуудаа

Алагтай эрээнтэй хорвоод

Алдаатай оноотой явж дээ

Угтан тосох жилүүдэд

Ухаарч эгээрч амьдрая даа

Шүлгийг Л.Содномдорж

Аяыг МУСТА,Б. Ганболд

ХАЙРЫН ЦАГААН ШӨНӨ

Тэнгэрт үүлгүй цагаан шөнө

Тэнгэрлэг дурлалын баланд бялуурч

Халуун сэтгэлийнхээ гэгээн хүслээр

Хайрын цагаан шөнөө мялаана

Дахилт: Үнэн хайртай чамтайгаа байхаар

Үүлс сэмрэн тэнгэр цэлмэнэ

Харамгүй гэгээн сэтгэлийг нь санахлаар

Хайрын цагаан шөнө богинодоно

Сайхан чамайгаа налан тэврээд

Сарны туяа наадан ирнэ

Ариухан сэтгэлээс илч авч

Агаарт цацагдан гэрлээр сүлнэ

Дахилт:

Сайхан чамайгаа налан тэврээд

Оддын гэрэлд сэмхэн үнсэлцэж

Олдошгүй дурлалаа улам бадраалаа

Үнэнч хайр нь дотроос гэрэлтэж

Үүрийн цолмонг тоосонгүй угтлаа

Шүлгийг Ширчингийн .Батнасан

Аялгууг МУСТА Ц.Ганхуяг

ХҮҮГЭЭ ӨРШӨӨ

Аавын үгэнд эрхэлж нялхарсан

Алдуул морь шиг сураггүй одсон

Амьдралд алгадуулж ухаан суусан

Алдаж оносон хүүгээ өршөө

Аавдаа золгохоор хүү чинь ирлээ

Алдаж оносон хүүгээ өршөө

Ээжийн үгэнд эрхэлж нялхарсан

Эзэнгүй морь шиг сураггүй одсон

Эндэж гэнэдэж ухаан суусан

Эндүү явсан хүүгээ өршөө

Ээждээ золгохоор хүү чинь ирлээ

Эндүү явсан хүүгээ өршөө

Буурлуудын үгэнд эрхэлж нялхарсан

Бусгаа морь шиг сураггүй одсон

Буруудаж зөвдөж ухаан суусан

Будлиу явсан хүүгээ өршөө

Буурлууддаа золгохоор хүү чинь ирлээ

Будлиу явсан хүүгээ өршөө

Буурлууддаа золгохоор хүү чинь ирлээ

Буянтай сайхан сургаалиа хайрла даа

Шүлгийг Ширчингийн .Батнасан

Аялгууг М.Бэгзэд

БАГШТАЙГАА ДУУЛЪЯ

Арван намрын мөнгөн хонхоор

Ариун номын өргөөг зорьсон

Ачтай багшийн ухаан өвлөсөн

Арван жилийн алтан үе минь

Дахилт:

Багштайгаа би бүжиглэнэ / ээ/

Багштайгаа би дуулна /аа/

Багшаа би хайрлана /аа/

Багшаа би хүндэлнэ /ээ/

Аргадуулж зэмлүүлж ухаарч өссөн

Ангаахай насны гэгээн дурсамж

Аав, ээж шиг дотно дассан

Ангийн багшаа бид мартахгүй

Дахилт:

Арван хаврын шувууд шиг чуулсан

Ахиад олдохгүй цэцэгхэн нас

Амьдралын өнгийг

наддаа таниулсан

Арван жилийн ачтай мэргэд

Дахилт:

Үгийг Ц.Дуламжав Ая: МУСТА Эрхэмбаатар

ХАЙРЫН САЛХИ

Хавар цагийн хонгор салхи

Хойгуур урдуур сэржигнэнэ дээ хө

Хайртай хонгор чи минь

Хүрээд ирэх болоогүй юу

Аа аа аа Хүрээд ирэх болоогүй юу

Зун цагийн сэвшээ салхи

Зулай дээгүүр сэвэлзэнэ дээ хө

Зүрхний хайртай чи минь

Зүүдэн дунд минь учирна даа

Аа аа аа Зүүдэн дунд минь учирна даа

Намар цагийн намуухан салхи

Намайг чамайг илбэнэ дээ хө

Насаараа хайрлах чи минь

Нойрон дунд минь уулздаг даа

Аа аа аа нойрон дунд минь уулздаг даа

Өвөл цагийн өнөтэй салхи

Өглөө үдэшгүй жавартай даа

Өр зүрхний амраг чи минь

Өдөр шөнөгүй бодогдоно доо

Аа аа аа өдөр шөнөгүй бодогдоно доо

Аа аа аа өдөр шөнөгүй бодогдоно доо

СҮМБЭР НУТГИЙН ДУУ

Нар тоссон Боржигины тос даасан хоймор

/оо/

Наран тогоруудын дуутай мөнх хөх тэнгэр

/ээ/

Нартын зуунуудыг элээсэн монголын алтан

тал /аа/

Намхан бор толгодтой Малхын ууда

хөндий

Сүлдэлж тахьсан арслан уул

Чойрын богддоо мөргөө

Сүүгээ өргөж идээшсэн

Сүмбэр нутгаа магтан дуулья

Хүннү –Түрэгийн туульсаас

хүн чулууд нь нулимстай

Гал хурайлсан амьдралаас нь

гавьяат цолтнууд тодроостой

Төрийн наадмын дэвжээнд

түрүү айргийн хурдтай

Даяар монголын даншигт

даамай хүчит бөхчүүдтэй

Сүлдэлж тахьсан арслан уул

Чойрын богддоо мөргөө

Сүүгээ өргөж идээшсэн

Сүмбэр нутгаа магтан дуулья

Тэнгэр заяат өвгөдийн

буян хурсан хоймор /оо/

Тэмцэл тулаандт жилүүдийг

домог хэлхсэн энгэр /ээ/

Түүхий нь бидний бичилцсэн

Боржигины буурал тал /аа/

Төвшин жаргахын ерөөл дуутай хууртай

Сүмбэр /ээ/

Сүлдэлж тахьсан арслан уул

Чойрын богддоо мөргөө

Сүүгээ өргөж идээшсэн

Сүмбэр нутгаа магтан дуулья

Шүлгийг

Хишигийн. Чулуунбаатар

Аялгуу СТА С.Батболд

СҮМБЭР НУТАГ МИНЬ

Замбуулин тивд нэрээ дуурсгасан

Залуу Тэмүүжиний тэмцлийн нутаг

Заяа буянт хийдийн туурь

Жанжин Чойр бидний нутаг

Дахилт:

Олон ястныг урин дуудсан
Оцол Сансар хайрхан уулаа
Омог бардам хаадын өлгий
Омголон сүрлэг Сүмбэр хайрхан
Хиад Боржигины уугуул нутаг
Хэрлэн Цоорхойн рашаан устай
Хүчит арслан төрсөн нутаг
Хөх Монголын нэгэн сумаа
Мандах нараа угтан мэндэлсэн
Малх Цайдамын уудам талаа
Малчин түмний сэтгэл шингэсэн
Мөнх дээшлэх Сүмбэр нутагаа

Шүлгийг Баатарын Аасүрэн

АМРАГТАА

Халиахан халиахан бодогдоно доо хө
Халуухан чиний минь сэтгэл үүдээ хө
Хараад л баймаар харцыг болдоо хө
Хайрлахгүй орхиж хэн чадам бэ
Намайгаа намайгаа зүглээд ирэхэд хө
Насаан бодолгүй угтсан л юмаа
Налж суугаад бодлоо дундлахад
Наргиж хэн дуу аялах вэ
Зөөлөн зөөлөн шиврэх дусал нь
Зөндөөн санасаныг хугаслаа болвуу

Зөнгөөр зөнгөөр хүний аалинд

Зөрж хэн чадах билээ дээ

Санан санан дуулнадаа хө

Сайхан л явсаны шинжүү дээ хө

Сонсоод л баймаар хоолойг нь хө

Сонжихгүй өнгөрч хэн чадам бэ.

Шүлгийг Хишигийн Чулуунбаатар

Аягууг

АХМАД ЦЭРГҮҮД ХАЛАГДАХ БОЛООГҮЙ

Хотлоор жаргах монгол хүн

Ядуу байна уу? чадуу байна уу?

Хотлоор бялхах мал сүрэг

Дутуу байна уу? дүүрэн байна уу?

Хабул хааны цэргүүд тэгвэл

Халагдах болоогүй

Чингис хааны цэргийн чимээ

Тасрах болоогүй

Алтаар гулигах монгол хүн

Амьдарч байна уу? үхэж байна уу?

Алаг бяцхан үрс маань

Газартай байна уу? цагаач байна уу?

Амарсанаа вангийн цэргүүд тэгвэл

Халагдах болоогүй

Чингис хааны цэргийн чимээ

Тасрах болоогүй

Цог жавхлант монгол түмэн

Сэрүүн байна уу? унтаа байна уу?

Зоригт дайчин эрс маань

Хурц байна уу? мохоо байна уу?

Цогт тайжийн цэргүүд тэгвэл

Халагдах болоогүй

Чингис хааны цэргийн чимээ

Тасрах болоогүй

Хатан тунгалаг гол булаг

Хатаж байна уу? ундарч байна уу?

Хамаг монголын заяа буян

Босоо байна уу? хэвтээ байна уу?

Хатанбаатар вангийн цэргүүд тэгвэл

Халагдах болоогүй

Чингис хааны цэргийн чимээ тасрах болоогүй

Сүрлэг онгон уулс маань

Бүтэн байна уу? тал байна уу?

Сүртэй олон хилийн баганууд

Эзэнтэй байна уу? эзгүй байна уу?

Сүхбаатар жанжны цэргүүд тэгвэл

Халагдах болоогүй

Чингис хааны цэргийн чимээн

Тасрах болоогүй

Уран байгаль эрдэнэт баялаг

Ундраад байна уу? дундраад байна уу?

Урвагч ноёд газраа худалдаад

Яагаад байгааг та на мэднэ

Ухаант генералын цэргүүд тэгвэл

Халагдах болоогүй

Чингис хааны цэргийн чимээ

Тасрах болоогүй

Шүлгийг Баатарын Аасүрэн

НАРНЫ ДУУ

Асарлан цэлийх өлгийн хоймор

Аньсага норгох ээжийн нутгаа

Дүүрэн дүүрэн газрын чулуу

Дүүлэн очмоор ерөөлт өргөө

Нарны зүг алхаж амьдарна

Насны энгээр дуулж сүсэлнэ

Энхжүү амгалан сарны гэгээ

Эндээс ургадаг сайхан туяа

Нарнаас асгардаг газрын солонго

Намайг бүтээдэг ганц диваажин

Нарны зүг мөргөж тайтгарна

Насны энгээр мөнхөд залбирна

Говийн энтээ бүдэгхэн чимээ

Гол урсах нь содон анир

Гоо энхийхэн охидын шивнээ

Гоёж л явмаар торгон зүлэг

Нарны нутаг яг мөндөө

Намайг авчирсан сар мөндөө

Шүлгийг Баатарын Аасүрэн

ААВДАА

Хан өндрийн тэргүүнийг ширтээд

Хайртай аавыгаа хайлан саналаа

Бодолд норсон салхи хүртэл

Бугуйнаас түшин тулж зогслоо.

Хөх униартай галбын говь юмсандаа

Хүний дээд ганцхан аав минь юмсан

Хайрхан уулын хормойд сөгдөөд

Хайртай аавыгаа ахиад л бодлоо

Халуун энгэрийнх нь илчийг санаад

Хамаг ухаанаа тайлж дэвслээ

Хөх униартай галбын говь юмсандаа

Хүний дээд ганцхан аав минь юмсан

Хөхрөх уулсын алсаас ширтээд

Хөөрхий аавыгаа энхрийлэн дурсав

Хөглөрсөн бодол тэмээ шиг торолзоод

Хөмсөг дундуур торойгоод далдрав

Хөх униартай галбын говь юмсандаа

Хүний дээд ганцхан аав минь юмсан

МИНИЙ МЭРГЭЖИЛ САЙХАН

Бөмбөрцөг дэлхийд цэцэг болон түгж

Бүхэнд ачлал тус хайрласан

Буман гэрлийн түлхүүрийг атгасан

Бусдаас илүү бид азтан

Алсад одох хүчдэлийн шугам

Амьдрал тэтгэх хөгжлийн алхаа

Алдарт хүргэх сайхан ажил

Аяа бидний ховорхон мэргэжил

Хүчит техникийн зүрхийг амилуулж

Хүн бүхэнд ажлын амт мэдрүүлсэн

Хүчдэл энэрийн ухааныг олсон

Хэнээс ч илүү бид азтан

Алсад одох хүчдэлийн шугам

Амьдрал тэтгэх хөгжлийн алхаа

Алдарт хүргэх сайхан ажил

Аяа бидний ховорхон мэргэжил

Айл болгонд дээдлэгдэн залагдсан

Амьтай бүхэнд хүч хайрласан

Илч гэрлийн эмч бид

Эгэлгүй их авьяастан залуус

Алсад одох хүчдэлийн шугам

Амьдрал тэтгэх хөгжлийн алхаа

Алдарт хүргэх сайхан ажил

Аяа бидний ховорхон мэргэжил

Үг. Аяыг Сүрэнгийн Отгончимэд

ДЭЛГЭРЭХ НУТАГ

/ эрэгтэйн дуу/

Дөрөө шүргэх дэрс нь ээ хө

Төгөлийн дайтай шуугина даа хө

Дөлөөд байгаа бүсгүй минь дээ чи

Төдий л холоос санагдана даа хө

Урсаад байгаа горхи нь ээ хө

Уянгын донжтой шуугина даа хө

Уулзаж өгдөггүй бүсгүй минь дээ хө

Уриад ч байх шиг инээмсэглэнэ дээ хө

Бор борхон толгодууд нь хө

Ботгоны буйлаагаар уярна даа хө

Бодлоос салдаггүй чи минь дээ хө

Борхон зүрхийг догдлуулна даа хө

Намхан намхан гүвээд нь хө

Намрын аяар шаргалтана даа хө

Надтай уулздаггүй бүсгүй минь дээ хө

Насны л юм шиг санагдана даа хө

Аяны холоос ирэхэд минь хө

Цантын уул нь цавцайна даа хө

Алсын холоос очиход нь хө

Цаанаа л санасан санагдана даа хө

/эмэгтэйн дуу/

Гурван булгийн нутгаар нь

Хур л ороод шаагилаа даа хө хө хө

Гурван булгийг ширтээд

Хонгор сэтгэл минь догдлоно доо хө хө хө

Гурван баянгийн нутгаар нь

Нар нь гараад цэлийлээ дээ хө хө хө

Гурван морь хөтөлсөн залуу

Намайг чиглээд ирлээ дээ хө хө хө

Адууны даллагатай нутаг минь дээ хө хө хө

Хурдаар гайхуулж цэнгэлээ дээ хө хө

Алаг нүдэн чи минь дээ хө хө хө

Хуртай л ирж учирлаа даа хө хө

Отрын нутаг хол доо хө

Олон хоног явна даа хө

Онгон дагшин нутаг минь дээ хө

Орой өглөөгүй намаржлаа даа хө

Цайвартан харагдах Цантын ууланд нь

Чамайгаа л хүлээж өвөлжлөө дөө хө

Цагаан сарыг хүлээгээд

Шаглан шаглан оёлоо доо хөө

Шүлгийг С.Отгончимэд Аяыг Санзай

УУЧЛАХ ХОРВОО

Ганцхан алагтай адуундаа

Нарнаар мордоод явлаа шүү дээ

Ганцаар хорвоог туулахгүйгээс хойш

Гомдож суугаад яах вэ дээ

Буруу дэлтэй буурал морио

Бугуйлаар бариад уналаа шүү дээ

Булга минжээр гоёогүй ч гэлээ

Бурууг нь сургаад үдсэн дээ

Гурван шаргатай адуунаас

Уургын хээрээ уналаа шүү дээ

Гунхсан залуу нас ч гэлээ

Уучилж л хорвоод амьдрана үү дээ

Шүлгийг ийг С.Отгончимэд Аяыг Батдэлгэр

БУТТАЙ ТАВАН ТОЛГОЙ

Буттай таван толгой нь

Бусдын нутгаас содон доо

Булиглаад байдаг зүрх нь

Будраад л нэг сонин доо

Дахилт:

Айх хөө

Бусдын нутгаас торолзох

Буттай таван толгой минь

Зэ хөө

Алсын нутгаас торолзох

Атар гол уул минь хө

Хадтай таван толгой нь

Халтиргаатай ч гэсэн сүрлэг дээ

Ханилаад суух тэр минь

Хальтарсан ч түшээд амьдрана даа

Дахилт:

Дэрстэй таван толгой нь

Дэндүү холоос харагдана даа хө

Дэнслээд байгаа сэтгэл нь

Дэрвээд л нэг сонин доо

Дахилт:

Цэцэгтэй таван толгой нь

Цэлгэр талаас бүртэлзэнэ

Цэнгэж жаргасанаа бодохоос

Цэлэлзэх гээд байгаа нь сонин доо

Дахилт:

Шүлгийг С.Булган

Аялгууг Д.Амарбаяр

ЭЭЖ МИНЬ

Аараг борхон толгодынхоо хөндийд

Аргал түүн, цэцэгс баясгаж

Айлын бараа, нутгийн дээсийг

Анирлаж, саравчлан аядуухан алхдагсан.

Ээж минь.

Дахилт:

Таанын аагтай цэнхэр талдаа

Таныгаа санан дуулж явна аа. Үр чинь.

Таван өнгийн аягтай хорвоодоо

Танаараа дутан уйлж явна аа. Үр чинь.

Цайны дээжээ бишрэлтэйгээ өргөж

Цагаан Дарь эхэд сүслэн мөргөж

Цагийн салхи, түүхийн улбааг

Цайруулж, аргадаж амандаа шившдэгсэн.

Ээж минь

Ганган талаасаа тэнгэрт одоход тань

Гантиг түшин уйлж суусан хүү нь

Ган хаттай, гүн бодолтой эр өсөж

Галаа бадрааж, удмаа ургуулж явна аа.

Ээж минь.

Эрин дамжин өртөөлсөн

өвгөн салхин амсхийнэ

Эрт цагийн домог шивнэн

өвсөн толгой намсхийнэ

Зуун зууныг элээсэн

өөвөн уулс налайна

Зуны дурсамж, хэнзхэн цэцэгс

өглөөн шүүдэрт жиндэнэ

Хааяа нэгхэн зүсрэх

зөөлөн бороо дулаахан

Харгуй дагуулж ширтэх

зөнч бодол дулаахан

Зүрхэнд гуниг унагалаа ч

энэ л намар амгалан

Зүүдэн жаргал шиг орчлонгийн

энэ л үе нь амар амгалан.

Шүлгийг Төмөртогоогийн Эрдэнэбаатар

Аялгууг Н.Бат-Өлзий

САНАЖ ИРЭЭГҮЙ ХАЙР

Бодолд өнжсөн алаг нүдэн

Бороо хүлээсэн солонго байж дээ чи

Будан чуулсан хүний хорвоод

Бурхад атаархсан хайр минь

Чамдаа би дурласан болохоор

Чинийхээ сэтгэлийг чагнамаар байх юм

Сар жилийн төгөлд төөрсөн

Санаж ирээгүй хайр минь

Шүүдэр туучсан алаг нүдэн

Сүүдрээсээ эмээсэн бүжин байж дээ чи

Сувдан аалитай хүний хорвоод

Сэтгэлд нуугдсан хайр минь

Дахилт

Зэрэглээ хөтөлсөн алаг нүдэн

Зөн дагуулсан эрвээхэй байж дээ чи

Зөрүү хээтэй хүний хорвоод

Зүүдэндээ аргадсан хайр минь

Дахилт

Шүлгийг Г.Зоригт Аялгууг Ш.Бат-Амгалан

СУРГУУЛИА МАРТАНА ГЭЖҮҮ ДЭЭ

Шижиртэн туяарах домгийн талдаа

Шивээговь тосгон байдаг юм

Шивээговийн тэр л тосгонд

Шинжлэх эрдмийн сургууль минь байдаг юм

Дахилт:

Шивээ говийн тэр сургуульд

Сэргэлэн бага балчир нас минь бий

Эрдмийн саруул тэр л сургуульд

Энхрий бага хүүхэд нас минь бий

Эртний буурал домгийн талдаа

Илчит уурхайн тосгон байдаг юм

Илчит уурхайн тэр л тосгонд

Эрдмийн саруул сургууль минь байдаг юм

Сэвхүүлийн хөндийд өссөн болохоороо

Шивээговио мартана гэж үү дээ

Шижир эрдмийг сурсан болохоороо

Шилтгээн сургуулиа мартана гэж үү дээ

Шүлгийг Баатарын Энхтөр

ХАЙР ДҮҮРЭН ХАНЬ

Заяа заяагаа түшээд

Замлингийн тавиланг бүтээнэ дээ

Зүрх зүрхэндээ эрхлээд

Зүйлийн хорвоог туулна даа

дахилт:

Ханьсах амьдралын наран гэгээ

Хайр дүүрэн хань минь дээ

Сэтгэл сэтгэлдээ уусаад

Хүмүүн насыг элээнэ дээ

Итгэл итгэлдээ жаргаад

Хүслийн өглөөг мандаана даа

Үрсийнхээ зулайг үнсээд

Үнэний жамыг тайлна даа

Үүрд нэгнээ үгүйлээд

Үйлийн орчлонд дурсана даа

Шүлгийг Мулцангийн Уянсүх

Аялгууг Б.Энхтөр

ЗҮРХЭНДЭЭ ХАДГАЛНАМ

Салхийг чам руу нисгэж хацарт чинь хүрнэ

Сарнайг чамаар орлуулж үнэрт чинь согтно

Үгээр чамайг гоёж зүрхэндээ хадгална

Үхлээс чамайг булааж... цээжиндээ тэвэрнэ

Дахилт:

Үгээр чамайг гоёж зүрхэндээ хадгална

Үхлээс чамайг булааж цээжиндээ тэвэрнэм

Өө өө өө ..., зүрхэндээ хадгалнам

Харгуйг чамаас наашлуулж болзоо мэт

тосно

Хайраа чамд өгч гал шиг дүрэлзэнэ

Гэрлээр чамайг сүлж харанхуйг сөнөөнө

Гэргий мэт чамтай хамт он цагаас нуугднам

Дахилт:

Гэрлээр чамайг сүлж харанхуйг сөнөөнөм

Гэргий мэт чамтай хамт он цагаас нуугднам

Өө өө өө...,зүрхэндээ хадгална

Шүлгийг Бямбадоржийн Бат- Өлзий

Аялгууг Б. Энхтөр

ГОВИОН БИ САНАЧИХЖЭЭ

Ингэ буйлах шиг

Уужимхан дуу сонсмоор оо

Ижий минь уярах шиг

Дуулмаар, дагаад дуулмаар

дахилт:

Голд салхи хүүгээд л

Говион би санана даа

Талаас гүн нүдтэй

Нялх ботго болчихмоор оо

Тэнгэрээс том санагдах

Ганцхан нулимс унагамаар

дахилт:

Үүдэндээ харуулдах ижийгээ

Зүүдэндээ ч болов хармаар аа

Үнсүүлж байсан хацраа

Дахиад дахиад өгмөөр

дахилт:

Адууныхаа захад зогсмоор

Аавыгаа дагаад алхмаар аа

Нэг л их санаа алдмаар

Нэлэнхүй талыг саравчилмаар

дахилт:

МУСТА Лхамсүрэнгийн Чулуунбат

ЧОЙРЫН БОГД

ерөөл

Аавын минь төрсөн нутаг

Ажнай хүлгийн шандас сорьсон

Алтан шаргал талтай

Алсын барааг тольдуулсан

Сүмбэр хайрхан уулс мину зээ

Өвөг дээдсийн онгон шүтээн

Өнөд мөнхийн Чойрын богд минь

Уул талын үзэсгэлэн

Уурхай баялагийн ордтой

Чойрын богд та мину зээ

Сүүн цацлаа өргөөд

Сүмбэр хайрханаар овоглосон

Газрын холоос гялалзсан

Говьсүмбэр аймаг мину зээ

Мал сүрэг налайсан

Малхын уудам их талтай

Ган замын хос шугам

Газрын холоос зурайсан

Говьсүмбэр мину зээ

Бодол зүрхийг минь уяраасан

Боржигин дууны

шуранхай хальсан

Буурал өвгөдийн минь өлгий

Оцол сансар хайрхан мину

Оцол сансар хайрхан мину зээ

Рашаан булгийн тунгалаг ус нь

Анагаах увидасыг шингээсэн

Амгалан амьдрах ерөөлтэй

Ашид мөнхийн боржигин нутаг

Боржигин нутаг та мину зээ

ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН УРАН БҮТЭЭЛЭЭС

Төмөртөгоогийн ЭРДЭНЭБААТАР

ДЭВТЭР

Хичээж бичсэн

Хичээлийн дэвтэрт

Дөрвөлжин гурвалжин

Дүн тавина

Тавьж өгдөггүй

Таван хошууг

Талыг нь зураад

Дэвтэрээ гоёлоо

ТАЙРДАС

Аавынхаа хагалсан

Түлээний тайрдасыг

Амрах завгүй

Хагалсан гэж

Урдуур хойгуур

Өнгөрсөн амьтад

Урьж харуулан

Магтаал хүссэн

Айлгах аавтай

Арслангийн зулзага

ЗАРАА

Зарааны хөөрхөн зулзагад

Захиалж хувцас хийлгэн

Хурдан гэрт нь очоод

Хувцсаа өмсүүлэн хартал

Энэ тэндээс өргөс нь

Ээлжилж гараад болдоггүй

Өргөс гарахгүй хувцсыг

Өөрөө би хийхээс дээ

ИЛЖИГ

Зөрүүд илжгийг явуулах гэж

Зөндөө арга хэрэглээд

Цаггүй өвс өгөн

Цамаан занг хөдөлгөв

Айлын хүүхдүүд харахад

Арагшаа урагшаа харан

Ав адилхан хоёулаа

Амарч байгаа үзэгдлээ

УЙЛАНХАЙ БАТАА

Баавгай ичдэг нь

Байгалийн жам

Батаагийн нойр нь

Аавынх нь зан

Уйланхай зантай

Унтамхай Батаа

Ном сурахаа

Нойрондоо даатгав

Сүрэнгийн ОТГОНЧИМЭД

ДҮҮТЭЙ БОЛСОН СОНОР

Ээжээс дүү гарсан чинь

Эхлээд мээмийг минь булаачихлаа

Ээжийг минь бас булаачихлаа

Ээж аав хоёртойгоо хамт унтдаг орыг минь булаачихлаа

Миний дургүй хүрээд

дүүгээ нэг цохиод авлаа

Ээж харин дүүг өмөөрөөд намайг нэг түлхээд авлаа

Ээж надад хайргүй болчихсон юм уу

Эмээдээ л би очихоос доо

Айлын хүүхэд биш миний дүү болохоор

Аяархан алхсаар очоод үнсчихлээ

Аав харин харчихаад

аавын ухаантай охин гэж магтлаа

Аав дээрээ ч очдог юм бил үү

Дүү минь хоол идэж чадахгүй болохоор

Дүүдээ мөөмөө өгөхөөс биш дээ

Дүүг жоохон болохоор ээж тэврээд байх шиг

Дүүгээ би зодохоо болихоос биш дээ

Рагчаагийн БАТЖАРГАЛ

БОРОО

Үлгэх үндэс дэвтээсэн

Үрэл сувдан дуслууд

Үес үес шаагин

Үүлнээс сэмэрсэн мяндас

Энгэрийн цэцэг таалсан

Тэнгэрийн мөнгөн хөшиг

Цайран хөллөн бороо

Цаг дэлгэрсний дохио

ШАМАРГА

Бужигнасан буурал бөмбөлөг

Бууж дэгдэхдээ хайлна

Бутарсан цагаан буурцаг

Бужигнаж хуйлрахдаа урсана

Хуйсганах салхины үзүүрээс

Хурын үнэр ханхална

Үрлэн цагаан шамарганаас

Үүлний үнэр сэнгэнэнэ

ИНГЭН ТУЙЛААДАС

Ингэн ингэн тэмээдийн

Шингэн буйлаан урссан

Их их говийн

Ихэр толгодоор бударсан

Ингэн туйлаадас

Ингэн туйлаадас

Гунжин дөнжин тэмээдийн

Гунганах буйлаан шингэсэн

Арвин цэнхэр говийн

Аараг толгодоор бударсан

Ингэн туйлаадас

Ингэн туйлаадас

НЭРЛЭХҮҮ

Онгиороо бамбарууш

Ойн цоорхойд

Анчинтай таараад

Айхгүй сүрхий

Зоригтон болохоор

Зогсож үзэв

Өөдөөс нь дөхөж

Өдөж үзэв

Тохьтой анчин

Томоотой өвөө

Том баавгай биш

Тонтогор бамбарууш гээд

Буудаж айлгалгүй

Буцаад явчихав

ИЧИМХИЙ

Түнтийлгэж шивсэн

Түмэн зүү

Бумбайлгаж хатгасан

Буман зүү

Өшиглөж болохгүй

Өргөсөн бөмбөг

Харилцаж болохгүй

Хатгах бөмбөг

Нүдээ харуулдаггүй

Нугдаахай

Нүүрээ үзүүлдэггүй

Нуугдаахай

Бөөдий өөрөө

Ичимхий дэндүү

Бүхний замд

Итгэхгүй хэтрүү

Баатарын ЭНХТӨР

ЦАСХАН ЦААСХАН

Өргөн тал нутагт минь

Өвөл айлчлан ирлээ

Өдөн цагаан цасхан

Өвлийн өвөө маань бэлэглэлээ

Цаас шиг цагаан цас

Намайг тоглоё гэж дуудлаа

Эвлэг цасаар найзуудтайгаа

Элдвийн зүйл бүтээж тоглолоо

Бөмбөг, бамбарууш хийлээ

Байшин, машин барьлаа

Зуны нарыг зурлаа

Цасан дээр цэцэг ургалаа

Гулсуур, овоохой босголоо

Гулгаж наадаж тоглолоо

Харин бүүр хэтрээд

Хацраа хайрчихсан байлаа

Хамаагүй хүйтэнд тогловол

Хамаргүй ч болж мэдэх нь шүү

МИНИЙ ГЭР- ДЭЛХИЙ

Тооно нь нар

Унь нь цацраг

Хана нь уулс

Хаяа нь тал

Миний өргөө – Дэлхий

Ижий, аав, дүүтэйгээ

Энэ гэртээ би амьдардаг

ТАНИХ УУ?

Хамар дээрээ эвэртэй

Хачин амьтаныг мэдэх үү?

Хуяг өмссөн баатар шиг

Хүчирхэг амьтаныг таних уу?

Усанд байх дуртай

Унтаахай түүний нэрийг

Хирс гэдэг дууддаг юм

Хичээн тогтоож аваарай

АРСЛАН

Амьтны хаан арсланг

Алгандаа мөөмтэй гэнэ

Хөөрхөн гүегээ гишгэчихгүй

Хөлөө өргөж хөхүүлдэг гэнэ

Нуугих халуунд нозоором

Ноостой бөөнцөг зогдорыг нь

Үсчин эгчийг уриад

Үнэгүй засч өгүүлэхсэн

ЗАГАС УНТДАГ УУ?

Зав гаргаж энэ орой

Загасны унтахыг харахаар

Тэнгэрт одод түгтэл

Тэвчээр заан ширтлээ

Шилэн цөөрмөгний өмнө

Ширээгээ дэрлээд би

Нар мандтал унтчихжээ

Найман цаг болчихжээ

Загаснууд маань унтаагүй

Загалмай, сүүлээ хаялан сэлнэ

Яагаад амардаггүй учрыг нь

Яаж мэдэх вэ? хүүхдүүд ээ

БОЛЖМОР ЧАМД

Өвлийн улирал болохоор

Өмнийг зорьдог шувууд шиг биш

Жаврын хүйтнээс айдаггүй

Жаахан болжморуудыг хүндэлдэг би

Өвлийн өвөөг ирэхээр хэлж

Өөрсдөд тань бэлэг өгүүлнэ дээ

НАЙЗ БОЛОХ УУ?

Цамц хувцас таарахгүй

Царай муутай зараа

Өхөөрдөж илэх гэхээр

Өргөсөөрөө айлгаж сөрвийнө

Бүрэг ичимхий зантай юм уу?

Бөмбөг шиг болоод нуугдчих юм

Чихэр авчирч өгвөл

Чи надтай найзлах уу?

ГУРВАН НАРТАЙ ДЭЛХИЙ

Гурван настай Адъяа хүү

Гурван нартай дэлхий зурлаа

Нисдэг хонь

Жигүүртэй морь

Цонхтой гэр

Сэнстэй уул

Ногоон гол

Чихэртэй цүнх

Ярьдаг ном

Хөлтэй бөмбөг

Дээлтэй мод

Өнгийн бороо

Гараасаа хөтлөлцсөн хүмүүс

Гадаа тоглох хүүхдүүд

Адъяа хүү өөрийнхөөрөө

Амьдралын өнгийг зурлаа

БУГЫН НУУЦЫГ МЭДЭХСЭН

Олон салаа эвэртэй буга

Ойн дундуур давхихдаа

Орооцолдон тээглэж

Ойчдоггүйн байх даа

Эврээн эвхэж нуудаг

Ид шидтэй юм уу?

НОМЫН САН

Дурсгалт эртний түүх, судар

Дуртай үлгэр, нэвтэрхий толь

Ирээдүйн сонирхолтой уран зөгнөл

Элдэв янзийн учигт амьдрал

Утга зохиолын уудам сансар

Урьж биднийг даллан дууддаг

Номын сангийн эгэл тавиурт

Ертөнцийн бүхэн нээлттэй байдаг

Номын санчид хүүхдүүдэд

Номоо уншуулахдаа баярладаг

Эрдэнэт номын гэрэлт мөрүүдэд

Эрхэм ухааны дээж байдаг юм

Эндээс хир мэдэж ойлгосоноор

Эрдэм оюунаа тэлж чаддаг юм

Номын сангийн саруул танхим

Ертөнцийн хамгийн баян байдаг

Номын санд уншигч хүүхдүүд

Ерөөс дундрашгүй эрдэмтэй болдог

Гардаж авсан номоо

Гамтай уншиж байгаарай

Ганцхан хуудас дутахад

Гомдож ном уйлдаг юм

Үрэгдэж дутсан хуудастай ном

Үзэж дуусаагүй

кино шиг харамсуулдаг

Үүний учир хүүхдүүдээ

Үргэлж номыг хайрлаж байгаарай

Номын сангийн эрдэнийн тавиурт

Ертөнцийн үүд нээлттэй билээ

Насан үүрд чамтай нөхөрлөх

Найзын түшиг ном билээ

ЦИРК

Хөгжилтэй марзан алиалагч

Хүмүүс бүхнийг баясгана

Хүрэн бүдүүн баавгай

Хөгмийн аянд бүжиглэнэ

Цирк цирк сайхан шүү

Цөмөөрөө ирж үзээрэй

Илбэчин ах бидэнд

Ид шидийг үзүүлнэ

Уран нугараач эгч нар

Үегүй гэмээр нугарна

Цирк цирк сайхан шүү

Цөмөөрөө ирж үзээрэй

Араатны хаан арслан

Алаг эрээн тахь

Агаарт нисдэг хүмүүс

Алив бүгд бий шүү

Цирк цирк сайхан шүү

Цөмөөрөө ирж үзээрэй

ХӨГЖИЛТЭЙ ҮЕРХЭЛ

Цэцэрлэгээсээ найзалсан

Сургуульд хамт орсон

Ширээнд зэрэгцэж суусан

Соёлоотойгоо би найз

Найман жил найзалчихаад

Надаас тэр зугтдаг болчихсон

Охидуудтайгаа нийлээд

Ондоо тоглоом тоглодог болсон

Эрдэнээ найзаасаа асуутал

Эрэгтэй хүүхдүүдтэй тоглохоос

Ичиж байгаа юм гэсэн

Намайг ичээгүй байхад

Найзлахаасаа тэр ичдэг

Охидууд гэдэг тэгэхээр

Ондоо л зантай байх нь дээ

Ширчингийн БАТНАСАН

ТОГОС ОО

Тогосоо Тогосоо тольдох дуртай

Тун чиг дэгжин гоёх дуртай

Тоос шороог нь арчих дургүй

Толь нь харин гомдвол яана /аа/

Тогосоо Тогосоо амттанд дуртай

Таваг халбагаа долоох дуртай

Тогосоо харин угаах дургүй

Таваг халбага нь гомдвол яана аа

Тогосоо нээрээн мартдаг байлгүй

Толио арчихыг сануулдаг юм бил үү

Тогосоо нээрэн засрах байлгүй

Таваг халбагаа угаах байлгүй

ГОЛИО

Хүрэн голио зс...,зс...,

Хөмсөг сормуусгүй нүдтэй дээ

Хүзүү сээргүй нь сонин доо

Хоёр утсан сахалтай даа

Хойноо уртаа сүүлтэй дээ

Өвс ногоогоор хооллодог доо

Өөдөө дээшээ авирдаг даа

Зургаан саравгар хөлтэй дээ

Зурсан ч би чадна даа

ХҮҮХДИЙН ДУУ

ТОМ АЛИМ

Шүлгийг Р.Батжаргал

Аяыг МУСТА Б.Ганболд

Тавагтай алим тавилаа

Таатай сайхан харагдлаа

Олон олон алимнаас нэг нь

Онцгой том харагдлаа

Хараад баймаар байлаа

Хамгийн том үзэгдлээ

Харин тэгтэл түүнийг

Аваад надад өглөө

Баярлалаа гээд эргэтэл

Батынх том санагдлаа

Цэгнэж жигнэж үзвэл

Цэцэгийнх давуу бодогдлоо

Ахиад цаашаа харлаа

Алимууд бөндийж байлаа

Дээр нь дэнхийх алим

Дэндүү том санагдлаа

Үлдсэн алим бүгдээрээ

Үнэхээр том үзэгдлээ

Харин миний алим

Халаасанд багтахгүй байлаа

ЭРХ ЦЭНХЭР

Шүлгийг Р.Батжаргал

Аяыг МУСТА Б.Ганболд

Эрх цэнхэр ишиг

Бараан дээр гарлаа

Эргээд тэндээс үсэрч

Ховоон дээр буулаа

Буцаад тэр үсэрч

Бараан дээр гарлаа

Буухдаа харин андуурч

Банхар дээр уналаа

Хав гээд банхар

Хазах гэснээ болилоо

Манай банхар ухаантай

Мал гэж танилаа

ЯНЗАГА

Шүлгийг Р.Батжаргал

Аяыг МУСТА Б.Ганболд

Цэцгэнд ихэрлэх

Цоохор янзага

Цэнхэр хангайдаа

Цолмон гэрэлтэй

Хөөрхөн янзага

Хөгжилтэй янзага

Өөдөсхөн янзага

Өхөөрдөм янзага

Униарт эрхлэх

Туяхан янзага

Уулс хангайдаа

Туурайн цахилтай

Хөөрхөн янзага

Хөгжилтэй янзага

Өөдөсхөн янзага

Өхөөрдөм янзага

МИНИЙ ДҮҮ

Шүлэг, аяыг Б. Энхтөр

Алиа цовоохон аашгай

Алдрай бяцхан дүү минь

Аз жаргал бэлэглэн

Манайд гийсэн наран

Дахилт:

Миний хөөрхөн дүүгийн минь

Мишээн инээх нь наран адил

Миний хөөрхөн дүүгийн минь

Хөөрөх , баясах нь наран адил

Алдрайхан өөжин дүү минь

Эгдүү эрх аашгай

Энхрий бяцхан дүү минь

Хүсэл хайрын бэлэг болж

Манайд гийсэн наран

Дахилт:

Миний хөөрхөн дүүгийн минь

Мишээн инээх нь наран адил

Миний бяцхан дүүгийн минь

Хөөрөх , баясах нь наран адил

Өхөөрхөн , балчирхан дүү минь

МУУДЛАА САЙДЛАА

Шүлгийг Р.Батжаргал

Аяыг МУСТА Б. Ганболд

Чихрүү үлээгээд

Чимхэж шоглоод

Чигчий хуруугаар

Чичиж зангалаа

Муудлаа муудлаа

Муудлаа муудлаа

Эвийлж хайрлаад

Элэгсэж найзлаад

Эвийн эрхэм

Эрхийгээр дохилоо

Сайдлаа сайдлаа

Сайдлаа сайдлаа

Гэдэлзэж годолзоод

Гэээгдэж шоглоод

Чигчий хуруугаар

Чичлээ зангалаа

Муудлаа муудлаа

Муудлаа муудлаа

Алимаа таллаад

Амталж хуваагаад

Эвийн эрхэм

Эрхийгээр дохилоо

Сайдлаа сайдлаа

Сайдлаа сайдлаа

Муудлаа муудлаа

Үгүй шүү дээ

Сайдлаа сайдлаа

Үнэн шүү дээ

Сайдлаа сайдлаа

Сайдлаа сайдлаа

ЗОХИОЛЧДЫН ЕГӨӨ, ХОШИГНОЛ

НАМСРАЙН БАТТӨМӨР

“Эмнэлгээс илгээсэн дуут шуудан \ мессеж\”

Хүүхэд биш чихрээр яахав

Хүүхэн биш “набор” оор яахав

Өлдсөн биш боовоор яахав

Өлссөн биш хоолоор яахав

Өгье гэж санаж байвал

Өндөр шилтэй “юм” ганцыг

“Өгөөж” хيام, өөхтэй “сало”

Өргөст хэмхэн даруулгатай аваад

Өөрийн биеэр түргэн ирээч!

Ардын Армийн бэлтгэл хурандаа Ганборжигин овогт Нацагийн Дөш Москвагийн Фрунзегийн нэрэмжитцэргийн Академид суралцаж байх үе.

Мань хүний нэрийг гадаадынхан буруу дууддаг байж. Учир нь “Ө” байхгүй болохоор Душш үршүүр , Тушь- нэгэн төрлийн бэх гэж ойлгогдмоор. Дөш сэргэлэнтэж нэрээ Наковальня -\ Дөш\ гэж орчуулав. Харин курсын дарга нь подполковник Топоровский \ Сүхжав\, захирал нь генералмайор Кувалда \ Лантуу\ гэж байв. Төхиолдол үүгээр дууссангүй , дотнын орос бүсгүй найз нь Надя \ Надежда\ Молоткова\Алххан\ гэж байлаа шүү хэмээн өөрөө ярьсан удаатай.

АЙРГИЙН ТАТАЛБАНУУД - 2007-06-23

Лувсаншаравын Содномдоржид

Айрагийн төв дээр гул азарга

Найргийн наадамд сул азарга

Дүр төрх нь шарга азарга

Дүрэмдэж хөтлөх нь дарга

Азарга!

“Эмэгтэй найрагчид хэнсэн билээ”

Анандын Байгалмаа Радиодоо – “Босс” юм аа

Айрагийн Энхтуяа шүлгэндээ – “Касс” юм аа

Рагчаасүрэн бүсгүй гангараагаараа- “Мисс” юм аа

Аймгаасаа хамт ирсэн Отгончимэд маань – “Масс” юм аа

“ХЭРХЭН УНШИВ АА”

Шандын найрагч Энхбаяр

Шатаж уншив, тэсэрч уншив

Шаавай ганган Далангийн Боржигон

Шартаж уншив, тасарч уншив

Шавилхан биетэй Ганзул

Хагсарч уншив

Шагналт зохиолч Чулуун

Агсарч уншив

Хутагт Равжаагаа дээдэлсэн

“Хурмаст тэнгэр”ийн Баатар сөхөрч гуйв

Хотоос ирсэн Батцэнгэл

Холын зай туулах шиг цөхөрч гуйв

Гээгэндээ сургүй Будзана бөө

Гэдэлзэж , бөхөлзөж уншив

Говь- Угтаалын унаган Батзориг

Гэгэлзүүлж, дэгэлзүүлж уншив

Довон дээрээ Содномдорж

Догшин дүртэй хашгирч уншив

Хорь буриадын Сонинбаяр

Ховордсон амьтан\ хотил, мөндөл\ шиг

Хошгирч уншив

Найрагч дөрвөн бүсгүй

Аргадаж учирлаж уншив

Намбалаг гурван шүүгч

Аргалж, чаргалж шүүв

Наадмын “хобби”той Эрдэнэбат

Зайгаа цэнэглэж уншив

Намсрайн Баттөмөр би

Заримыг нь элэглэж уншив.

2007-06-23.

Б.Энхтөр

ЦАГААН САР БА ХОДООДНЫ “НАРГИА”

хошин

Цүлхэр бид нэг хонхорт өссөн хоёр. Тэр багын хоолонцор. Түнгэрцэглэсэн гүзээт, том хүний хэмжээний лийрэн дээр бүрх малгай тавьсан шиг хүмүүн харагдвал тэр Цүлхэр мөн. Аашийг нь тодорхойлоход ядах юмгүй. Ялангуяа хэн нэгэнтэй айлд ороод дайлуулж, цайлуулахдаа ёстой нэг тавгийг нь ёроолдоно гэгч болно. Энэ зангий нь мэдэхгүй хөөрхийс зайлуул монгол ёсоороо аль чанасан тарган мах, буузаараа гийчдээ дайлах гээд Цүлхэрийн ходоодонд алдана. Байшинтай айлд ороод гал зууханд нь тухлах дуртай. Гэрт орвол эрэгнэг хавьцаа тогоо шанаганд ойрхон сууна. Эзэгтэй нь ч юм уу, эсвэл гэрийн эзэн цаад өрөөнд орох хооронд урдахь аягатай нь / тавагтай нь ч байж магадгүй/ бага санагдаж хөргөгч, шүүгээг нь заавал онгойлгож долгомцоно. Хэн нэгэн танилынд нь хөдөө, гадаанаас зочин ирвэл мань хүн хэдийн үнэр авчихсан тавьж хүрнэ. Тэгээд ярих идэх хоёрыг ч үзүүлж өгнө дөө. Нэг хэсэг шунагхан хүртдэг байсан арзнаасаа холдсон. Даахгүйгээ мэдээд больсон нь зөв болсон. Харин гэртээ бол мань эр тун хариг. Ирсэн зочинд хаа нэгхэн тавагтай чихэр авч өгвөл их юм. Хүнд аяганы амсар зуулгахгүй. Хоолон дээр нь санамсаргүй орчихвол хэдийгээр ёсыг бодож “Ид, ид” гэх боловч нүднийх харц хорт могойных шиг сүлбэнэ. Ийм харцны доор хэн ч юугаа идэхэв. Миний нэг таньдаг хүний хэлсэнчлэн “Гэртээ хавар шиг, айлд

намар шиг” тийм л хүн. Мань хүн нэгэн удаа байгууллагынхаа хүлээн авалтан дээр өөрийнхөө хувийг идчихээд хажуудаа суух хүүхнийг бүжиглэх зуур тавган дээрээс нь дутуу идсэн шарсан тахианы гуяыг нь сэмхэн хулуулж үмхэх гэж байгаад яарсандаа ястай нь тас хазаж хиймэл шүдээ хугалж гэнэдсэн. Энэ явдлаас хойш тэр үргэлж “нөөц” хиймэл шүд нусны алчууранд нямбайлан боож, энгэрийнхээ дотоод хармаанд авч явах болж. Цагаан сар бол түүний хувьд хамгийн хүсүүштэй баяр. Битүүний орой битүүртлээ чихэж аваад маргааш орох айлуудаа тооцоолон “ тэдний бууз ноднин арай жижгэрсэн байсан, тэдний ууц тарган байсан гэхчлэн” түмэн амттан бодож бараг нойргүй хононо. Шинийн нэгэнд гэрийнхэнтэйгээ золгомор аядсанаа “хөгшчүүлтэй золгоно, баяр урт, орж ирсэн хүмүүсийг хамаагүй битгий дайлаад байгаарай” гэмээн лүндэн буулгачихаад эртхэн гараад нар тонгойсон үед орж ирнэ. Энэ Цагаан сараар Цүлхэр бид хоёр Шархаданд байх манай нутгийн буурай эмгэнийд таарсан юм. Бид Томоо гэж авгайлах эмээгийн дэвсгэрт маань үр хүүхэд, ач гуч нь бүжигнаад сар шинээ хөлтэйхэн, элбэг дэлбэг угтаж байв . Авгай хүүхэдтэйгээ ирсэн Цүлхэр самбай хадаг гарган Томоотой золгомор аядсанаа ширээний ард хурдхан нугдасхийн тухалж авав.

Мориных шиг нүд нь гөлөгнөөд тун ч их баяртай байгаа бололтой. Жигнэсэн буузны уур савссан амтлаг үнэр байшин дүүрэн ханхийн таваглахад Цүлхэр ч “ажил”даа орлоо доо. Ойр зуурын хэдэн ойн медаль, байгууллагын тэмдэг санжигнасан хүрэн үйтэнхуар дээлийнхээ энгэрт тос дуслуулан үмхэлнэ. Дээл цэвэрлэх бол авгайн ажил. Авгай хүүхдүүд нь өмнөхөө бараагүй байхад Цүлхэр хоёр таваг бууз идэв. Төдөлгүй мань хүн “Эхнээр, гэрт хүмүүс ирж байгаадаа, чи хүүхдүүдтэйгээ одоо яв яв” хэмээн шавдуулав. Цүлхэрийн үгнээс гарч үзээгүй эхнэр нь хүүхдүүдээ дагуулан гарлаа. “

Овоодоо, гэртээ бас хүн ирэхийг мэддэг байх нь” гэсэн миний цагаахан бодол авгай, хүүхдүүдэд нь аягалсан тавагтай буузнуудын үлдэгдэлийг хамж идэх Цүлхэрийн аманд хамт зажлагдлаа. Ахиад жигнүүр бууз гарахыг хүлээх зуур мань эр Архангайгаас ирсэн тостой айраг гулгуулан хоолой, ходоодоо тослож дэвэн дэлхийг хаман бурж суув. Шинийн хоёронд золголт хийсэн арван гурав дахь айл нь байж таарсан Томоо эмээгийнхээс Цүлхэр тун маадгархан гарлаа. Дээлийнхээ энгэрт түнтийтлээ бэлэг чихсэн Цүлхэр “Шар хад”ны эцсээс шугамын “микро”нд суув. Мань эр буцах замаа хүртэл битүүнд тооцоолсон нь энэ. Шугамын эцсээс ямарч байсан суудалтай явна. Тосолсон сүүл шиг нүүрээ байн байн илэн малийтал инээд алдан пар нар хийх сайхан зантай хүн энэ өдөр лав Цүлхэрээс өөр байгаагүй байх. Хоёр буудлын дараах зогсоол дээр оюутан бололтой гурван охин орж ирэн өөдөөс нь харан суув. Залуу хүмүүс хоорондоо шивнэлдэн инээлдэх нь Цүлхэрт өөрийг нь шоолох мэт санагдахад тэр дотроо дүрэлзэн уурлалаа. Тэр хоолонцороос гадна битүү өөнтөгч зантайг нь хэлэхээ мартчихаж. Өөрийг нь шоолоод инээлдээд байна даа гэсэн бодолдоо хатуу итгэсэн Цүлхэр хөмхийгөө шамшийтал зуулаа. Зангий нь мэдэх хүнд Цүлхэр буйлан хөмхийгөө нэг зуувал тун хэцүү. Одоо гурван буудал явчихвал тэр бууна. Сүхбаатар дүүргийн эмнэлэгийн урд буудалд Цүлхэр буух ёстой. Ходоод нь хүржигнэн, гэдэс нь базлахад Цүлхэр инээд алдав.

Сөөсийсөн жулдрай охидоос өшөө авах санаагаа олоод маасайж байгаа нь тэр. Буух буудалд нь ирээд “Микро” хаалга дэлгэхэд Цүлхэр дээлийнхээ хормойг сөхөж байгаад машины заадал салмаар “хий” тавьчихаад үсрэн буулаа. Үлдсэн зорчигчид “ Паах ямар заваан

амьтан бэ? Ичдэггүй ямар сонин хүн бэ? Согтуу юм уу хаашаа юм. Ямар муухай өмхий юм бэ? хаалгаа нээгээчээ”гэх дуун ард нь хадаж, мань хүн эс тоосон шинжтэй цаашаа маадгархан алхав. Маг наг хийн нударгаараа амаа дартал бөгсөн бие нь халуу дүүгэн төөнөж, нялцгай оргихыг Цүлхэр мэдэрлээ. Хоёр гудамны цаана байх гэртээ өмд дүүрэн “цэвэрлэгээ”тэй Цүлхэр яаж харьсаныг би мэдэхгүй.

2012.02.28

БААДУУ

Ба багш шүлгэндээ баадуу

Баттөмөр багш инээлгэхдээ баадуу

Батбаясгалан маань мээмдэхдээ баадуу

Баярцэнгэл сэтгүүлч мэдээндээ баадуу

Дөш хурандаа халамцахаараа баадуу

Дөмөг Батнасан тайзан дээр баадуу

Дуламжав найрагч дуулахаараа баадуу

Дуугүйхэн Билэгбаяр үйлэндээ баадуу

Да Мөнхбат мааниндаа баадуу

Дарга Батмэнд ажилдаа баадуу

Хас Чука хэрэглэгчдийн баадуу

Харин Баярмаа хотдоо баадуу

Ханхар Мөнх-Өлзий харвахдаа баадуу

/Наадам алгасалгүй харвадаг жил бүр хүүхэд бүтээдэг/

Аасүрэн шилрэхдээ баадуу

Айргийн Со гавьяат ходоодондоо баадуу

Бат-Өлзий эмч багачуулдаа баадуу

Батцоож багш Дундговьдоо баадуу

Боржигин Ганхуяг чөмөгтэй баадуу

Бондгор Майнбаяр бултахдаа баадуу

Хоршооллын Мөнхзаяа хотондоо баадуу

Хөөрхөн Болорсувд өндөглөхдөө баадуу

/ Боржигидай нэг болоход Болорсувд хоёр жирэмсэлдэг/

Отгончимэд эгч зурхайндаа баадуу

Отгон Наранхүү хуулиндаа баадуу

Эрдэнэбаатар интернетдээ баадуу

Энхтөр би эднийхээ төлөө баадуу

Боржигин найрагчид авьяас түлхүүрдсэн баадуу

“Болор цом”-ыг ч тоохгүй Говьсүмбэртээ аархуу

2013.12.18.

ХИЧЭЭЛ

/сатир – рондо/

Хэтэрлээ ш дээ

Гадуур нь тавилаа

Хүүшээ

Зогсооч дээ

Тэнэг юм уу?

Одоо болно

Хөдөл хөдөл

Огцом хөдөлвөл

Хэтэрнэ шүү

Сайн хараарай

Аажуухан аажуухан

Ашгүй ашгүй боллоо

Амрая жаахан, одоо

Амжлаа шүү цагтаа, ухрах хичээл

Шинэ жолооч минь ээ

Р.Батжаргал

ХАНДАА

Хүн дөрвөн хөлтэй байх нь хоёр хөлтэйгөөсөө долоон дор юм билээ. Өглөө бостол ууц нуруугаар хатгаад юун баруун хашааны Хандааг бодохтой мантай боохой дайралдвал босож зугтахаар бороохой тулж автобусны зогсоол чиглэв. Тэнд автобус хүлээж энгэрийн товчоо хулжтал зүтгэхэд бэлэн байгаа олныг харахаас яаж орно доо гэж яс хавталзаж зүрх алдан, зайдуу дүүргийн унаа цөөнд сэтгэл давчидна. Өглөө болгон буудлын түмний дундаас Хандаагийн хөгжим шиг сонсдох сайхан дууг чагнан тас тас буух инээдэнд нь бүүвэйлүүлж энэ тэрийг ярилцан харц тулгарахнаа зүрх зүггүйтэн оволзож байдгаа санахаас их л алсын дуртгал шиг бодогдоно. Ашгүй автобус ирэхэд олны дэмээр би уулс цочтол дуун алдаад далавчгүй нисээд орчихов. Барим бүдүүн таягаа туяртал дуун алдахад дүүрэн хүнтэй автобусны галирахгүй ган арал хотолзон газар шүргэж алдаад өндөсхийв. Хөлтөйд гэрлийн хурдаар цахилж, арван морины хүчээр довтолж, олныг оволзуулан түмнийг түжигнүүлж ороод Хандаад суудал авчихсан ханхалзаж байдагсан. Даанч тэр хөг өнгөрчээ. Ядахнаа босоод суудал тавиад өгчихмөөр үеийн хүн суудалд харагдахгүйд гансран алаг нүд шалаар өнхрүүлж, сандлаар бөмбөрүүлж эцэст нь таазаар хүртэл галигуулаад аргаа барахдаа хүнд ачаатай галт тэрэгний дуут дохио шиг хүнгэнүүлэн аюулхайгаа хагстал санаа алдахад зөөлөн суудалд тухалж амжаагүй өвөө босож, зөрүү харж шилбэлзсэн шавилхан эмээтэй өвдөг зэрэгцэв. Хясахад өнөөдөр Хандаа дайралдсангүй Газар дээр ганц харахын заяатай төрсөн хонгор минь тааралдсан бол сугадаж оруулаад суудалд тухлуулаад эгээ л эрх хүүхэд шиг бөөцийлнө дөө гэсэн уярлын нулимс ухархай хэлбэж ширүүн борооны дусал шиг том том үрэл сормуусанд цэцгийн дохиур шиг бөнжигнөн өвдөгт онож ёслолын буудлага шиг бутарна. Хажууд суусан эмээ эмзэглэх тоолонд ондгосхийж цонх өөд тэлүүлнэ. Хөөрхий минь ясанд янгинах миний энэ өчүүхэн зовиурыг яс махаараа мэдэрч бас хуваалцаж байгаа нь энэ биз гэж санагдана. Тэрээр өрөвчхөн эмээ олдошгүй нэгийг осолдож хар зам дээр гээчихээ юу гэмээр цонхонд духаа хавтгайртал тулгаж цардмалд нүд унагаж явснаа алжаав бололтой насны хэм урсах он цагийн саалтанд яаж тэсэж вэ гэмээр будгаар шилэмдэж бамбарласан хүүхэлдэйнх шиг өтгөн сормуус залбируулж урд шөнө алдаа болов уу гэмээр их нойроос чимхэлж эхлэх нь нүдний буланд зэрвэсхэн агаад барагтайд үл анзаарагдана. Автобусны зөөлөн доргионд бүүвэйлүүлж үе үе үүлс үймтэл дуун алдсаар хүрэх газрын бараа харвал хамт зорчигчид хайр өрөвдөл дэлгэн түшиж тулж буулгалаа. Хүн хүнээ түшиж тулж явах гэдэг нэг ёсны жаргал болоод цээжнээс өчүүхэн бачимдал хийсч хурын дараах тэнгэр шиг цэлмэн аясхан баясал түрэлхийлэв. Хажууд суусан эмээ надтай нэгэн буудалд дөрөө мулталсанд өөрийг мартаж, өчүүхэн зовиурыг гэвч яс махаараа хуваалцагчаа өрөвдөх сэтгэл дэлгэж харвал... Санах юм биш Харж баяслаар ундлан бодож бодлоор баян явдаг

Хандаа минь

-Та байсан юм уу түрүү хэлэхгүй яасан юм гээд ширэв татан ширүүн салхины түрүүч шиг сүрхийн одоход гараас таяг алдран, хад нурж хавцал доргих шиг нурууны яс нужигнан улаан гол тасартал дуун алдуулавч өнөө сайхан дуу нь хөгжим шиг сонсдож байлаа. Байнга бодол доргиосон хамар хашааны Хандаа минь чи сэтгэл илбэдэж, бодол нялхруулах даанч мартаж болохгүй ганцхан сайхан дуутай төрсөн бүсгүй юм даа

ХОНЗОН

Дэндэв арван долоон цаг болоход секундын зүүтэй уралдан хурд хэтрүүлж гурван буудал алхсандаа амьсгаадан хашааныхаа хаалганаас бараг хэтэрчих дөхөн тогтоод өлзий утаст дааман хаалганаасаа эхлэн арван алдын цэнхэр хашаагаа зөөлөн харцаар харж босго алхуут гэрийг зүглэлгүй хашааныхаа баруунаас зүүнийг хүртэл зүүнээс барууныг хэтэртэл хэдэнтээ эргүүлэн харж сажилтал өлмийд торсон чулуунд таварцаглаж сэхээ авах завгүй газрын чийг үзчихэв. Хашааны сүүдэрт тоглож байсан хүүхдүүд нь аавыгаа түүдэг шиг бөндгөсхийгээд унахад айж балмагдан үргэсэн туулай шиг сортосхийснээ ийм тийм болсонгүй давгүй босоод ирэхэд нь баясалдан аймсалт түгшүүр нь аль хэдийн хийсэн одож инээцгээв. Угийн нэрэлхүү зангаасаа ч юм уу эсвэл хүүхдүүдийнхээ инээснээс болов уу эргэж ч харсангүй өчүүхэн чулууг үзэн ядах өшөө хонзон нь хурган тогоонд буцлан амсраа халих хар цай шиг даргилж нэгийг бодон хоёрыг санан шурдхийж гэртээ оров. Дэндэв энэ мөчөөс эхлэн их ажилд бэлдэж эхэллээ. Нэгдүгээрт тэр чулууг огли татахад зориулан түрдэг трактор эрэвч эс олдох тул өөрийн юм өргүй хэдэн хүүхдээрээ хүч нэмэрлүүлэхэд хэрэг болно гэж хорин алд олс, хүч тэнхээндээ тохируулж алд илүү хөх төмөр царил базаав. Хоёрдугаарт аз таарч тэр чулууг ховхолж чаддаг юм бол балчир хүүхдийн чавханд хийх ширхэггүй болтол бутална гэж хүнд лантуунд галирахгүй ган иш гагнуулав. Гуравдугаарт хүчир ажлын үед алга холгож хүүхдүүдийнхээ баяраар барьдаг алаг бөмбөлөг шиг цэврүү гарт үсрэхээс болгоомжилж ажлын бээлий таван хосыг цуглуулав. Дөрөвдүгээрт ганц амралтын өдрөө энэ их ажилд зориулна гэхээс өдөртөө долоо шаардаж, найм сануулан байж нарны малгай эхнэрээрээ нэгийг оёулав.

Бэлтгэл ханасан орой сэтгэл хөдөлснийх юм уу нойр хулжиж элдвийг бодон эргэж хөрвөсөөр асар том хадан хясаа буулгаж өш хонзонгоо авлаа гэж зүүдлэн урсах усан хөлсөндөө нэвчиж сэрвэл үүр дөнгөж хаяарч байсанд олзуурхан оглохарайв. Үүр тэмдгэрч байсан боловч ургахын улаан нарнаас урьтаж нарны малгайгаа духдуулаад бээлийтэй гарт багтаж ядсан царилаа чирээд хүнд лантуу дөхүүлж нөгөө чулуугаа эрээд эрээд олсонгүй. Заавал олно доо гэхээс унасан талын яс янгинаж урхаг хууч сэдрэх шиг болж хүйтэн хөлс нь хөлгүй үер шиг асгаран, уур улалзаж ухаан балартав Энд эс ч тэнд байна уу гэж горьдон нааш цааш сүлжсээр байтал чирсэн царилынх нь үзүүр элэгдэж, өртсөн газрын хөрс уринш хагалсан талбай шиг үелээтэж хөгшид эмгэд бол хөл алдахаар болжээ. Ааваа юу эрээд байгаа юм бэ гэсэн хүүхдийн шингэн дуунд цочин сэхээ авч, мөлхөж гулсах эрлээс толгой өндийвөл нар аль хэдийн бага үд хэвийж долоон настай хүү нь анивчин зогсов. Уржигдар зардалгүйгээр газрын чийг үзэхэд хүүгийнхээ час час инээж байсныг дурсаж чөтгөрийн бага нь адтай гэж энэ мэдэж юуны магад хэмээн нарийн ухаан сийлэн хүүгээ дуудаж

-Аавынх нь таварцаглаж унасан чулуу хаа байна гэж шивнэвэл

-Өө тэрүү энд бий Би гадаа чулуудчихсан гээд хаалгаар годхийв. Бор хүүгийнх нь би чулуудчихсан гэсэн үг хаздаг бахь шиг часхийлгэхэд ай хөөрхий өшөө хонзон гэдэг чулуунд боловч халтай юм даа гэхээс өнгөрсөн гунигт дуртгал бүхэн дотор сэтгэлий нь азарган хуурай шиг үрчив.

Шүлгийг Л.СОДНОМДОРЖ

МОНГОЛ ХОДООД

хошин дуу

Ай хөө Зээ хөө

Монгол ходоод мину зээ

Тав хоногийн өл даадаг

Тарган хонины ууц шингээдэг

Тэглээ гээд тэсэрдэггүй ходоод

Тээр болж зовоодоггүй ходоод

Нанчид архийг сордог ходоод

Найруулсан спиртийг хусдаг ходоод

Ингэлээ гээд шархалдаггүй ходоод

Эндээ л гэхэд чонын ходоод

Ходоод минь ходоод минь

Монгол ходоод мину зээ

Түмпэнтэй махыг дор нь пялдаг

Тарваганы боодгийгусаар даруулдаг

Тааралдсан бүхнээ залгин залгисаар

Тас үсэрч талийдаг ходоод

Найрын магнайд найгадаг ходоод

Намрын айргийг цөлдөг ходоод

Гаднын нөлөөг тоодоггүй ходоод

Гарын ая даадаг ходоод

Ходоод минь ходоод минь

Монгол ходоод мину зээ

Дэлхийд ховорхон монгол ходоод

Тив дэлхийд цуутай ходоод

Үнэхээр бидний буяны сав

Үлгэрийн юм шиг

Монгол ходоодоо

Ай хөө Зээ хөө

Монгол ходоод мину зээ

ДУРСАМЖ

ЗҮЙДЭЛ ЭХТЭЙ ГЭГЭЭН ДУРСАМЖ

Одод тохиосон хөх сүмбэр оргил алдар нь халх долоон хошуу шавь тавд сүслийн мэлмийн гэрэл

тунатал түгсэн Чойрын богд уулыг түшсэн цагаас манай Утга зохиолын нэгдэл өдгөө 20 оныг үдэж бүтээхийн их жаргалд бүгд 20 жил умбаж ирлээ. Энэ утга зохиолын нэгдлийг Бөгтөр цант

Дулдуйтын хар овооны эзэн савдаг байхаар гүн бодлогоширолт Жалбуугийн Дансранжав гэж шавилхан биетэй ч давилуухан шүлэгтэй

“Цовоо сэргэлэн дуу минь

Гадаа гэртгүй цуриатсан

Цогтой ариун хөдөлмөр

Газар сайгүй өрнөсөн

Эх орноо магтан дуулъя” хэмээн хашгирагч хийгээд түүний “Тал нутгийн хүний дуу”-г Дорноговийнхон сүлдлэн тахьж сүүрс алдан нулимстай зүрхэндээ нутгархан дуулж хайлж яваа эрхэм болон “Суварга хайрхан”-ы сул цагаан сүлд мэт их цагаан үсийг хөглөрүүлэгч суу алдрын талбарт “ Талын нар “ “Талын од “ номоороо цахиур хагалж сэтгэлийнхээ ганжирт наран мэт баяр бахадлаа дүрэлзтэл асаасан

“Бүүвэйн шингэн дуу чинь

Чихэнд дандаа сонсдох шиг

Бүлээн цагаан сүү тань

Тагнайд дандаа амтагдах шиг

Ижий минь ижий минь

Энэ ертөнцийн сайхан хүн” гэж уулга алдсан Гүндсамбуугийн Төмөр нарын хамт Их Дэрэнгийнхээ уул мэт дүнжгэрхэн ухаарлыг үгийн урд зангидаж ертөнцийн гайхамшгийг уран үгийн бүлд идээшүүлсэн ест шүлгээрээ ертөнцөд өөрийнхөө овоохойг босгосон гэж онгирох МЗЭ-ийн шагналт яруу найрагч Рагчаагийн Батжаргалын санаж сэдсэнээр тулгын чулуугаа тулж тусгаар голомтоо асаасан Говьсүмбэр аймгийн утга зохиолын нэгдэл тэр үеийнхний заншил ёсоор аймгийн “Болор цом” найргийн наадам зохион байгуулахад

“Наранбулаг” ХХК арван мянган төгрөгөөр ивээн тэтгэж санхүүгийн асуудлыг бүрэн шийдээд наадамд “Хутаг уул” “Цагаан овоо”- ны галтай цогтой шүлэгч хөвүүн М.Батбаясгалан түрүүлснээр их ажлын нуруу нугалсан мэт баясацгаан М.Батбаясгаландаа Болор цом улсын наадамд оролцох эрх шийтгээд Утгазохиолын дээд сургуульд суралцах Эрхийн бичиг олгож байлаа.

Энэ үед Ж.Дансранжавд зориулан ийн галзуурав

“Цоожны цаана цонх байна

Цонхны цаана лонх байна

Цочоод харсан чинь Данаа байна

Ширээн дээр жүнз байна

Шилэн жүнзэнд гал байна

Шимж суугаа нь Данаа байна

Цаасан дээр үзэг байна

Цалгиж халгисан найраг байна

Цагаахан онгод Данаа байна” гэхэд мушилзаж суусансан.

Тэгээд утга зохиолын нэгдэл хэл хөлд орсны тэмдэг болгож “Найргийн ажнай” гэх бүтээлийн түүврийг эмхэтгэн хэвлүүлсэн нь хождын олон найрагчдыг дагуулах түрүү магнай болсондоо анхны их өргөөний цэнгээнд айраг түрүүний цулбуур атгах ажнай энэ бүлээс лавтайяа төрөх холын итгэл мөнх галын дөл мэт дүрэлзэн буйг тунсаг яруу эгшгийн өглөгөөс мэдсэндээ бидний ном найргийн ажнай гэж тунхагласан юм.

“Ар булгийн зандан уснаа

Адуугаа усалж зогсохуйяа

Арван тавны саран мэт

Алтан тогос хул морь

Газар чимсэн адууны минь захад ирж зогслоо

Галтай онги тамгатай гүйж яваа морь байна даа” гэж дэвэрч омгорхож дэвцэж цовхчиж ирсэн гозгор хөх хүү Мөрдоржийн Батбаясгалан өнөөдөр МЗЭ-ийн гишүүн яруу найрагч болтлоо өсөж уран бүтээлч нөхдийн дунд яруу найрагч гэж дуудуулах эрхийг олж авсан бөгөөд энэ зуур Утга зохиолын нэгдлийн жолоог чанга атгаж чадварлаг залалцаж явсан түүхтэй. Түүний алба хашиж байх зуур “Боржигины эгшиглэн”, “Боржигин билгийн судар” гэж

нэгдлийн гишүүдийн бүтээлээр боссон их номон суварга цогцолсон юм. Ямар боловч өөрийн гэсэн бодолтой амьдралын эгзэг бүхнийг дүгнэх тунгаамал санаа тэгширсэн аз эзийн орчлонд алхам тутамдаа бусдад тус болох орчлонгийн гоо сайхныг мэдэрсэн түүнийг нээж бусдын болон өөрийн билгийн нүдийг нээх эс боловч зөвөөр тунгаах сэтгэлийн хайланд ямхын төдий боловч ухаарал цутгах гэгээн дагшин бодлоор цалгиж явах сайн санааны үүдлийг бий болгож бүтээхийн урмыг нөхөддөө өгчээ гэж санааны үзүүрт баяр тунаам. Дундговь нутгийн үүл асарлах амирлан Их газрын чулууны үзэсгэлэн дунд торнисон Хур харцага хэмээх алдарт бөх Сэцэн вангийн наадамд түрүүлээд хошуу ноёноо хэлсэн амандаа хүрсэнгүй гэж зодгоороо газар савав гэгчээр Батбаясгалан маань биднийгээ үгэндээ хүрсэнгүй гээ юм уу Утга зохиолын нэгдлийнхээ тамгаар газар савах дөхсөнийг үгүйлэхгүй байхын аргагүй, Уран бүтээлч хүний уяхан энхрий сэтгэлээр тунгаахад сэмрэхгүй байхын аргагүй нэгэн цагийн эндэл тэмтэчнэ. Бид номын ухаантай явж нойрмог орчлонгийн гоо сэрлийг өдөөнөм. Бид хүний ухаантай явж бирдийн тойрогт ертөнцийн адал балмадыг сөрнөм.

Эс тэгвээс адрал бүхэн цөвт сэтгэлийг элээн нас цагийг хороох тул амжиж хэлэх үг утга хомсдох болноо. Гэгээлэг ахуй бясалгал хоёроос гоо сайхны сэрэл сэтэмж үндэслэж ухааны ур тэгшрэхэд бүтэл болж цогцолдог болов уу гэж мунхагланам. Гэнэ сэрэггүй үгийн бөлөөр нэнж асралыг тойлон хүсэл хяслын их цалгар дор мэхийн ёслох ахул үйл лайг зайчлах төгөлдөрт цулбуур өргөх торгон агшинг торгооном. Иймд үгийн урлаг гэгч сэтгэхүйн тов тодорхой адармаат үйл бөгөөд үйлсийг түших цэнгэлийн манлай цэц ир ханасан яруу дуун ажаам. Түүний үгс энэ дайтай болсныг бахархаж сэтгэлийн цацал өргөм үү

“Ижийнхээ хөхийг тэмтрэвч

Сүүл хөхөн шимсэн

Исгэл багын араншин

Сүүнд угжуулсан дурсамж

Зөөлөн цагаан мэлмий

Омгорхол дэврүүн нулимс

Зөвхөн Пунаагийнх гэх

Онгод шүлгийн дуулал” гэж гаажтай үгээр галзуурсан, газрын хаан агсарлаар тэнгэрт тэлүүлсэн, Эрхтий хайрханы эр хар чулуу эмзэг сэтгэлээр уйлж ч чадах дуулж ч чадах яруу найрагч Лувсандавгын Пунцагсүрэн Нялга Баянжаргалангийн шар талд төрж өсөөд, Малахын тал шигээ цагаахан шүлэгтэй аяны урт амьдралын уужмыг туулж явсан автын жолооч манай Утга зохиолын нэгдлийн ам бүлд багтаж багтарч үхтлээ яруу найрагт дурлан, хал үзэж халуун чулуу долоохдоо хийж бүээхийн их хүсэл нь буцалж, авьяасынхаа галд шажигнатал даргилаад сэтгэлгээний шүлэг рүү морины нүүдэл хийсэн эрхэм найрагч билээ. Говьсүмбэр аймгийн утга зохиолын нэгдэл анх үүсгэн байгуулагдахад дээр дээр алхан босгоор нь хөндлөндүүхэн давж орсноос эхлэн ухраагүй, уйдаагүй, урваагүй нэгэн үзүүрт сэтгэлээр яруу найрагчийн

зовлон жаргалыг хамт эдэлж хаа боловч тав тухыг эрэлгүй гудманд хүртэл суун тусаж шүлэг тэрлэдэг ухаарал сөвөгчтэй найрагч байлаа. Зул боловч шанддагийн адилаар ертөнцийн гоо сайхнаас эрт зуларчихсан нөхрийг, найргийн сөн түшин найдвар итгэлээ сэтгэлийн минь орон зайд цуглуулсан найзыгаа дурсаж сууна. Түүний “Миний араншин” “Хээтэй араншин” “Хуур дагасан аялгуу” “Ташуу араншин” номуудыг уншиж суухад энэ хорин жилийг эндэл сандалгүй туулсан бол мөн ч ихийг бүтээх байсандаа гэх халуун бодол зүрх жигнэж, сэрлийн үзүүрт гунигийн манан гогцооровч, чамлахаас чанга атга гэдэг ардын үг гайхамшигт гаргалгааг хөөршөөн түүний туурвилын гэгээнд сууж ахуйдаа баярлаж бахаднам. Билэг танхай энэ найрагч манай нэгдлийн гишүүн байсан юмаа гэж ам бардам хашгирах зүрх зоригийг хөвчилнөм

ПУНАА-даа

Найраг асарлах тэнгэрийн харьяат

Нарны сүлдэнд энгэрийн харьяат

Найз минь хөндлөн хөх Пунаа

Шүлгийн морин эмээлтэй цовхочиход

Шүүдэрт талдаа ганзага цацалсан

Шүншигтэй бурхдын нэгэн Пунаа

Хөлгөн асралт дэлхийг цочоож

Хөдөөх агсарлын магнайд цоллуулсан

Хөндлөн дөө хөндлөн хөх өвгөн Пунаа

Түүний учирт нөхрийн хувиар үг хэлэхгүй байх аргагүй түмэн он мянган жил улиравч өөрийн гэх хөшөө дурсгалаа шүлгээрээ босгосон эрхэм гэж сэтгэлийн цочил нимгэлнэм.

Тэмээ түлхэж тэрэг дайрчихам өсгөлүүн төрсөн өндөр шар бүсгүй хааяахан мөөмөнд нь сүү орсон юм шиг магтаал аястай шүлгээ өндөр дуугаар зандарч манайхан гэж нэгдлийнхнээ архи сэтгэл хоёроор дайлж жаахан дайвуулчихдаг байсан нь “Чоносон” хэмээх архины үйлдвэрийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Сүрэнгийн Отгончимэд бөгөөд нэгдлийн анхны түүвэр “Найргийн ажнай”-г Чоносон компанийнхаа нэрийн өмнөөс ивээн тэтгэж хэвлүүлсэн анхны номын буянтан билээ. Өөрөө болохоор “Дэлгэрэхийн чулуу” гэж дэвэрч омгорхоно.

Хөвсгөл далайн цалгиадас гэж авьяасаар аргиж тургивч тэр их далайн хувьд өчүүхэн хөх сувд юм шиг гялтайж дэвхцэх цалгиадас биш ядахнаа давалгаа байсан болоосой гэмээр гэнэ оныг хэлхэн сүлжих шавилах эрийг Ширчингийн Батнасан гэх. Уйлган голын гурван аваргатай ус нутаг нэг гэж нугарах дөхөж нумрах шахаж арай л ах дүү нь гэх холгүй агсамнах аядаад Угтаал хайрхны унаган хүү Баттөмөрт томроод омогоо нуга даруулж толгойныхоо оройг цөм

унасан нэгэн бөхийн алдрыг дуулбал

“Ааш бааштай орчлонгийн алтан дагнаасыг дагаагүйдээ

Амьдрал чиний оргил дээр өөрийн бодлоор тэмүүлсэндээ

Дөрвөн зүгтэй орчлонгийн дөрвөлжин хэвэнд хашигдаж

Дөрөөн дээрээ ухаажсан дөрвөлжин чулуу боллоо” хэмээн өөрийгөө “Өвгөн чулуу” гэх дуучин агаад “ Найргийн зургаан татлага” номондоо цатгалдаад үгийн ур ухааныхаа царааг хямгадсаар өнөөдөр бидэндээ өвөөгийн сургаал айлдмаар тулх тохийг эзэлжээ

Алаг нүдэн Ц.Дуламжав гэж аманцар бүсгүй од ойчтол гунхан, намжир гоо цагийг уйлуулж бас дуулуулна Тиймдээ

“Дуулах уйлах ч хүсэл хясал

Дурлах өших ч хүсэл хясал

Ерөөх хараах ч хүсэл хясал

Ертөнц өөрөө хүсэл хясал” гэж дуун алдсан бизээ. Өөрөө сайхан дуулна

Дансранжавын “Тал нутгийн хүний дуу”-г бол дарс даргиж сархад сагатаал, архи асгарч бурхад амилтал аялна Тиймдээ ч “Соёлын тэргүүний ажилтан” гэдэг алдар хүндийг тэврэн монгол түмэндээ эрхэлж суугаа бизээ. Нацагийн Дөш гэж дүрэм ярьж журам сахьсан дүүрэн цагаан эр Бүрдэнэ булаг Эрдэнэ нутгийн эрхэм, бүлээхэн үгийн саамаар чинэрэгч нэгэн Манай утга зохиолын нэгдлийн “Мөнгөн хараацай” Ардчилалын бол “Алтан хараацай” даль жигүүрхэндээ шатаж бас шартагч, ардын армийн алтан мөрдөст хурандаа авьяасын тэнгэрт мацаж майцарч явах нь хамаагүй сэтгэл байвал жаргал байдгийн үлгэрээр үгийн урныг эвлүүлж ядан үглэх шүлгээ хэвлүүлж чадамгүйхэн 20 жилийг үдэхдээ “ Тэнгэрийн цомирлон “ номоо баринтаглаж магнайгаа хагартал баярлан малгайгаа унатал малилзаж инээж зорилготой явахын улаан тугийг мандуулаад зогсолтгүй зүтгэж улсын сүрийг бадруулаад хувирч нэг хувьсаж нэг хувь ерөөлөө өлгийдөж явна Тэрээр

“Эр хүний дотор

Эмээл хазаартай морь багтдаг юм

Эр цэргийн цээжинд

Эх орон бүхлээрээ багтдаг юм” гэж тангарагтаа үнэнчээ татал үгүй тавил үгүй

үглэжээ Д.Батчулуун гэж

“Оршихуй орчихуй хоёр

Солигдож байдаг хорвоод

Огоорохуй эгээрэхүй хоёр

Эрэгцэж байдаг ёс байх юм” хэмээн он цагийн хэлхээ хөвөн, хийц уран хэл үг уян хэсэг бусаг уянгуудаар тургиж явсан нэгэн. Манай нэгдлийн нэр нүүр хоёр дээр шүлгээрээ тамга дарсан эрхэм хааяа хааяа биднийхээ дунд ирж шүлгээрээ бүжиг эргэдэг байлаа .Шагдаржавын Мижиддорж гэж миний үеийн энэ шагхийсэн шавилхан хар хүү ханцуй дотроо шившиж ханийнхаа зүрхэнд шивнэсэн зөөлөн аяст зөв чигт шүлгүүдээ нэгэн удаа уншчихаад алга болсон ч манай нэгдлийн анхны гишүүн гэдгээрээ бидний зүрх сэтгэлд үлдэж дээ Б.Батпүрэв гэж данхар эр Баянталаас хөсөг хөдөлгөсөн юм шиг хөглөрч ирээд ноомой нь дэндүүдээ гэрэвшингүй зогссоор олонд хүргэх гэсэн онч мэргэн санаагаа багцалж осолдохгүй л шүлэг уншиж байсан нь санаанд илхэн он цагийг элээжээ. Буурал Далантай гэж бурхны шуумал шиг тагдгар эр Зүүнбаянгийн зүггүй жолооч нарын оройн дээд, ярих хэлэхдээ буцалж ядаж байх шиг зөөлөн дуутай атлаа тайзан дээр гарахаараа гэнэт нөөшний лааз ханзалж байх шиг шингэн дуугаар цочсон юм шиг цангинуулан шүлэг уншчихаад уншсан шүлгээ хүн авчих вий үзчихвий гэсэн шиг баахан цаасан дунд хавчуулан баадагнаад далд хийчихэж билээ.

Ц.Галбадрах гэж шингэн дуутай ширвээ сахалтай цэргийн дарга орос хром шажигнуулан тайз эзлээд

“Оройн дээд эрдэнэ төрийн сүлдээ огоороогүй

Ороо бусгаа амьдралд ноён нуруу нь хотойгоогүй

Орчлонгийн эрээн бараанд сэтгэл алдран гонсойгоогүй

Орчилт энэ хорвоод ганцхан заяах буурлууд минь” гэж “Өвгөд минь” шүлгээрээ бөөлөөд жаахан ичингүйрэх аядан хөшигний цаагуур зүтгэж байж билээ. Анхны гишүүдийн тухай алтан дурсамж хөвбөл ийм байна. Говьсүмбэр аймгийн утга зохиолын нэгдэл энэ хэдэн хүн цугласнаар ам бүл тэгширсэнгүй өдрөөс өдөрт сараас сард жилээс жилд ам бүл нэмж өсөж өтгөрсөөр байлаа Энэ зам зуурыг нэхэн дурсвал. Дэвээд байгаа сормуусандаа гал зангидсан дэврээд байгаа авьяасаараа бал цуглуулсан тунгалаг шүлэгтэй Баасанхүүгийн Дэлгэрмандал гэж дэгдээхэй шиг жаахан зэрэмгэр охиныг баахан шүлэг уншуулж баалаад нийтээрээ ярсхийтэл гараа өргөөд нэгдэлдээ элсүүлж билээ. Түүнийг

“Хан бүүдийх хөх уулсын тэртээд үүлс хуйрганах

Хаана хураа илгээх вэ гэж тэд шивнэлдэх

Хавирган сарны гэрэлд бүрэлзэх

Хан богд уулыг хараач

Би аавыгаа гэж андуурмаараа

Хан богдын сүр дулаахан болоод түшигтэйе ээ” гэхэд бүхний сэтгэлийн утас

донхийгээ бизээ. Дараа өдөр нь хөндлөн Пунаа дөрөв нугалсан хөх дэвтрээ угзарч нэг дугтарч нэг нээгээд уянгаар асгарч урмаар галзуурч эхэлтэл хэн нэгэн гярхай нь Дэлгэрмандалын мөр шүлэг уг зүсээрээ утга санаагаараа цохьж явна гэж нууцыг илрүүлээд агсам шүлэгчийн омгыг нуга дарсныг бодоход манай нэгдлийнхэнд маш амархан нөлөөлж чадах авьяасаараа аван хайлах, охин бидний эгнээнд нэгдсэнийг илтгэх ганцхан адал тэр бөлгөө Дундговь аймгийн Өлзийт сумаас ирсэн гэх хаан ч байж болохоор заан ч байж болохоор лагс ланжгар шар залуу Тунгаа минь Тунгаа минь гэж дуу алдан тунгалагхан үгийн бөлөөр зодсон уртавтар шүлгүүд уншсаар орж ирсэн нь Дамчаагийн Баясгалан хэмээх данхгар шар эр байлаа. Тэрээр манай энэ нутагт багахан саатаад буцаж нутаг руугаа морин сэтгэлээр гүйж одсон юмаа Уран бүтээл нь өдийд ир цэц ханасан бизээ. Говьсүмбэр аймгийн Утгазохиолын нэгдэл МЗЭ-ийн Говьсүмбэр аймаг дахь “Боржигдай сэцэн” салбар болж өргөжсөнөөр бидний ам бүл бүр өссөн юм

Эрчмийн нурууны эгэл хүн Хөвсгөл аймгийн Галт сумынх гэж хөөрлөвч алтан говь Айраг сум Сайншандаас хөл хөндийрч хөсөг хөдөлгөж бараг үзээгүй МЗЭ-ийн гишүүн “Ард түмний гавьяат” “Утга зохиолын төлөө” хүндэт шагналт Лувсаншаравын Содномдорж алд алдын тунгалаг шүлгээрээ агсам тавьж авьяасын тэнгэрт аянга цахилгаан мэт нүргэлж, залууст сургаал айлдаж, хөгшдөд суртал үлгэрлэж, уран бүтээлийнхээ үйлс заяаг бидэнтэй холбож ирлээ. Ийнхүү адал сүлжиж, амь нэгсээд алдаагүй гэж бодном. Тэрээ манай нэгдлийн анхны “Хишиг өдөр” МЗЭ-ийн байранд “Удвал ахайтны танхим”-д болоход “Утгазохиолын төлөө” гэдэг хүндэт шагналыг гардаж авсан болно. Содномдорж маань буй биеээрээ ч тэр, бурхад аргадсан уран шүлгээрээ ч тэр бидний дундаа сарлагийн бух шиг бараа сүртэй оволзож явна. Нэгдэл салбарынхан дундаа “Багахангай” гэж эерүү үгээр нэршсэн эрэвгэр алаг нүдтэй эвчхэн хөөрхөн шүлэгтэй Төмөртоогоогийн Эрдэнэбаатар гэдэг залуу уран бүтээлээ гэж шатаж шартахдаа урт замыг туулж, уудам талыг гэтэлж, Багахангайгаас нааш соронзлогдож, удирдах зөвлөлийн гишүүний үүргээ нэр төртэй биелүүлж, өөрийн болон бусдын төлөө өдөр шөнөгүй интернет сахьж, өөдөсхөн биднийгээ дэлхий даяхнаар сурталчилж, түмний шөргөн харцад үйчихээд тэр баяртаа өөрөө багтран суудгыг талархахгүй хүлээн авах арга алга даа. Тэрээр “Айлгах аавтай арслангийн зулзага”-уудаа хөтөлж ирээд “Хадан ой” гэдэг яруу найргийн чамбай нямбай ном хэвлүүлж цаг хугацааны хайланд цахиур хагалав

“Малахын их тал

Адуугаар дүүрч хийморлоно

Манай нутгийн адуучид

Тэнд нэг жаргаж хойморлоно” гэж ахуйн гоо сайхныг зүрхнээсээ асгасан найрагч бол миний багш Дамбын Батцоож бөгөөд манай салбарын ахмад гишүүдийн хамгийн хамгийн билээ. Бямбадоржийн Мөнх-Өлзий, Бямбадоржийн Бат-Өлзий гэж ах дүү хоёр. Дүү Б.Мөнх-Өлзий нь урч, уран зураач хүн болохоор угалзан хээтэй уран шүлгээ эмхэтгэж “Гүнж өнгө”-ийг бүтээгээд Гомбын Сэр-Одын нэрэмжит шагналаар энгэрээ мялаах зуур ах Бат-Өлзий нь багтай бүр багтай бажгархан ухаарлын ном бүтээхээр баримтагтай шүлгээ зөөж нэг үзэж зөв буруугий нь сонжиж, нээж нэг үзэж нэг хоёрыг нь нэмж хасаж явна.

Загдсүрэнгийн Билэгбаяр гэж эрвээхэй шиг жаахан цагаан охин алаг нүдээр шилбүүрдээд

адтай шүлгээр илбүүрдээд “Зүрхээ би чамд” гэж зүггүйтээд зүүдтэй бүхнийг үймүүлж дэггүйтээд нэгдлийн маань нэр сүрийг авч явах нэгэн найрагчийн дүрийг тодотгов. Тэгээд

Дэн бараадаж эрвээхэй шатна

Дэр уйдаж нойр алсална

Дэлхий унтаж оддоо асаана

Дэвтэрт минь шинэ шүлэг зүүдэлнэ гэж омгорхжээ

Баатарын Аасүрэнг “Хүрэл тулга”-ын хүүхэд гэтэл “Бусдаас өөр чамд” гэж томроод сэрэхүйн татлаганаас угзчиж сэтгэлгээ мэдрэмжийн шүлэг хэлхээд эр өсөх хорвоод эмэгтэй найрагч байж болно гэж тунхаглав. Түүнд нэгэн шүлэг хэлэв

Ашид мөнхийг үлгэн цочир гэнэхэнд уусаж

Аасүрэнгийн шүлгийг уншаад босож сууж жаргахад

Адайр мөнхийн орчлонд амь тэмцэж тэснэ

Зүрхнээс зүрхэнд юүлэх зүггүй түүний үгс

Зүс гоог шилэхгүй үнэнээс үмхэлж зулгаана

Зүүд нойрыг сандааж үхлээс үхлийг булаана

Арвис гэгээн гэрэлт хутаг өлзий бүрдэхэд

Амьнаас амь бүтээх адалт цагийг ноолж

Аасүрэнгийн шүлгийг уншин адайр цэгийг тоолно

Их Угтаалын дүнгэр хүү Намсрайн Баттөмөр гэж инээд нь нүдээрээ гоожсон шооч эрхэм шог үгэндээ живж харах тоолон гижиг нь хүрээд байгаа юм шиг инээд ивж моосойгоод хажиглах төдийд эрвэсхийтэл ширэв татна. Эгэлхэндээ чөдрийн морь шиг бараа тасрахгүй Ааяа минь гэж дуу алдаж явдаг аргил эр Гончигийн Ганхуяг хоёр “Чөлөөт зохиолчдын холбоо”-ны гишүүн болж

Утга зохиолын нэгдлийн хүрээ хашааг тэлэв.

“Өргөстэй цасаар дуншиж үг алдсан Уяатын Баярмаа нэгдэл салбарын нэн идэвхтэй гишүүний нэг бөгөөд бэрс гарах найдвартай захын хүү, бэр болох насандаа залуухан бүсгүй Улаанбаатарт ужиг хол суувч уг угшлаа дагаж учир нэгийг зангидаж үг үйлсээрээ нааш тэмүүлэн найргаар асгарч явна. Арга ч үгүй биз дээ манай “Боржигдай сэцэн” яруу найргийн наадамд тэргүүлж, тэнгэрийн сахиус зүүсэн шиг онгирч байсан хатагтай даа.

Мөнхбаярын Хүрэлбаатар гэх эгэлхэн шүлэгчийн “Жаргалтай нутгийн наадам” мэт эгэл бус зөөлөн аяст шүлгүүдийг хүлхэж гоо тэнгэрийн тарнийг идээшүүлэн сэтгэлийн цэнгэл эдэлж, манай утгазохиолын салбартай мөнх заяагаа холбосон найрагч Маамын Мөнхзаяа, Батаагийн Баттулга, боржигин нутгийнхаа босоо цагаан хийморийг дуулж яваа Хишигийн Чулуунбаатар, цөөн үгээр үнэнийг өгүүлэгч Магнай трейдийн Майнбаяр, Баян сумын буянт шүлэгч Ганбатын Болорсүвд. Сэтгүүлч Батцоожийн Баярцэнгэл, лам Дашдондовын Мөнхбат нарын манайх минийх гэсэн халуун сэтгэлийг хүндэлж явнам. Тэдний уран бүтээл тэнгэрийн асрал олж бурхны үгээр буцлах болтугай.

Дээрх хугацаанд хамт олондоо үг хэлэхгүй явж чадсангүй зүггүйрхэж зүгээргүй хэдэн мөрөөр шоолж шоглоод авлаа

НЭГ

- Батжаргал би ест шүлэгтэй
- Батбаясгалан найрагч ёст шүлэгтэй
- Баатарын Аасүрэн адайр шүлэгтэй
- Батмэнд дарга өнгөлөг шүлэгтэй
- Баярмаа бүсгүй өргөстэй шүлэгтэй
- Бат-Өлзий эмч өргөл шүлэгтэй
- Отгончимэд зурхайч мөргөл шүлэгтэй
- Оодгор Батнасан мөргөм шүлэгтэй
- Овгор Баттөмөр мөргүүр шүлэгтэй
- Маргаад яах Мөнх-Өлзий зормол шүлэгтэй
- Манай Энхтөр зоргол шүлэгтэй
- Магтаад суумаар маягтай гоё шүлгүүдтэй

ХОЁР

- Гэгээнтэн Мөнхбат цалгим шүлэгтэй
- Гэдэнтэй Дөш цагаан шүлэгтэй
- Гээзэгтэй Баярмөнх ягаан шүлэгтэй
- Мадаггүйдээ Баттулга урсгал шүлэгтэй

Маамаа Дуламжав дурсгал шүлэгтэй

Майнбаяр хүүхэн дуншмал шүлэгтэй

Өхөөрдөм Билэгбаяр дөл шүлэгтэй

Өвгөн Рэнжин зэл шүлэгтэй

Өндөр Ганхуяг бал шүлэгтэй

Амарбат найрагч залбирал шүлэгтэй

Аархуу Баярцэнгэл золбирол шүлэгтэй

Алтанчимэг бүсгүй золигрол шүлэгтэй

Маргаад яах Хүрэлбаатар элэглэл шүлэгтэй

Магад тэр Булган нууц шүлэгтэй

Манай нэгдлийнхэн цөм уншмаар шүлэгтэй

Утга зохиолын нэгдэл салбарыг уртай цэцтэй ухаантай цэгцтэй уран үгсийн дархчууд удирдан жолоодож явсныг дурдавал Ш.Батнасан, Б.Бат-Өлзий, Ду.Батмэнд, М.Батбаясгалан Б.Энхтөр гээд урсгаад байхын зэрэгцээгээр нэг л өдөр дуугүйхэн орж ирээд нэгдлийн даргын албыг хашиж эхэлсэн одоо Говьсүмбэр аймаг дахь МЗЭ-н “Боржигдай сэцэн” салбарын удирдах зөвлөлийн дарга Ду.Батмэндийг дурдахгүй байхын арга алга Тэрээр “Бурхад завгүй” “Сүүтэй итгэлд бийрээ дүрж...” хэмээн хүчтэйгээр дуун алдсан бөгөөд тэр нь бурхны үг мэт сонсдож өөрийн хувьд сэтгэлгээний зүг нэгэн алхам хийсний гэрч билээ. Одоо тэр МЗЭ-ийн гишүүн яруу найрагч хэмээх алдрыг уран бүтээлээрээ өргөлцөж явна. Тэрээр анх хадаг мэт урт шүлэгтэй хааяа хааяхан морилж ирдэг байснаа шүлэг нь богиносож ухаан нь уртсаж сэтгэлгээ талруугаа хальтарч чамбайраад сэтгэмжийн сэжүүрийг гоо үгийн бүлд зангидаж цээжний гүнд буцалган уран бүтээлээ туурьваж явна. Хайрхан Зорголын хүү Баатарын Энхтөр бидний эгнээнд орж ирснээр “Өөр өнцгийн нүд”-ээр өнө хожмыг харах боломж нээгдэж, өв их соёлыг түгээн нийгэм түүхийн манарсан их нүргээнд нуруу бөгтийгсдийг сэргээж М.С.Горбачев дээвэр хөвсөлзөж дэлхий цочтол хашгирсан шиг Утга зохиолын нэгдлийн хувьд өөрчлөлт шинэчлэлтийн салхи сэвэлзэн зөв эрчилж эхлэв.

Утгазохиолын нэгдэл маань МЗЭ-ийн салбар болтлоо өргөжиж Энхтөр найрагч маань МЗЭ-ийн гишүүн болтлоо өвгөрч гүйцэд нэг бүтээхийн төлөө гэсэн сэтгэлээр гүйцэтгэх захирлын албыг хашиж олныг амжуулж оройлон зүтгэж байна даа

ШҮЛЭГЧ НӨХӨДДӨӨ

Уран Батмэндийн угалзан хээтэй эрхээ

Ухаарлын цөмд галт цэцэг шиг бадамлахад

Уй баярын ширэлдээ онч харьж хэлгийрдэг

Цагаандэлгэрийн толгод дунд Батбаясгалантай

Цахиур мэт галтайдаа газарт биш тэнгэрт ууж

Цавчрах оддын тоогоор шүлэг бичиж жаргадаг

Хайрхан Зорголын шүлэгч Энхтөртэй

Хааяа хааяа уулзахад найраг шиг гэрэлтээд

Хар нүдэн бүсгүйн халуун болзоог мартчихдаг.

Хэмээхүй дор уран бүтээлчдийн ойж буусан омголон зан, асаж даргилсан ааг омог, цаг цагийн хэлхээг хөвж сувьж явахад амьдрал хэмээх их аяны жолоо булаалдах аяг зан алийг тэр гэх вэ хааяа хааяа зарим өдөр өөтэй өнгөрөх явдал өмнөөс тулж араас зулгааж байлаа. Тэгээд намайг өөтэй өнгөрсөн өдрүүд гэж сүүрс алдахад хүргэсэн нь бий

ӨӨТЭЙ ӨНГӨРСӨН ӨДРҮҮД

Сахилтай шүлэгч Мөнхбат ламаа хөөгөөд дашийншог

Сахилгатай дарга Батмэнд намаа хөөгөөд дашийншог

Сайхан шүлэгтэй Батбаясгалан замаа самраад дашийншог

Өргөстэй цасны Баярмаа загалмайд дурлаад дашийншог

Өөр өнцгийн Энхтөр Баясаад чирэгдээд дашийншог

Өндөр гоолиг Мөнх-Өлзий шагай шигшээд дашийншог

Магнай трейдийн Майнбаяр даргад шаварлаад дашийншог

Магтаалд цатгалан Аасүрэн надад жаварлаад дашийншог

Магад энэ хэд хоног маапаантай өөтөй өнгөрлөө

Гэхүйд сэтгэл сэнсэрч бодол огшивч бидний замд саад болох савсаг савдаг чөтгөрүүд таарсангүй салбарын ажил тэнгэр мэт тэнүүн, далай мэт гүн, асралыг тээж, уран бүтээлийн урт замд жолоо сунган түмний эхийн хурдаар бариа зүглэж, түүхт хорин жилийг хоромхоноо ардаа орхиж мянга мянган жилийг замнаж, бүтээхийн их аяныг авьяасаараа түшиж, хийморь сүлдээ өргөн туурвиж явцгаана даа Ом сайн амгалан болтугай

Утга зохиолын нэгдлийг санаачлан байгуулагч МЗЭ-ийн шагналт яруу найрагч Р.Батжаргал

МИНИЙ ДУРСАМЖ

Говьсүмбэр аймаг байгуулагдаад жил ч болоогүй 1994 оны 10-р сард манай цэргийг штабын офицер хошууч Ц.Галбадрах надад “Манай аймагт МЗЭ-ийн гишүүн ахмад зохиолч, яруу найрагчид байдаг юм. Бид мөдхөн утга зохиолын нэгдэл байгуулахаар ярилцаж байгаа гэхэд нь “Байгуулагдах үед надад хэлээрэй би оролцоно шүү” гэсэн юм. 1994.11.09-нд Сүмбэр сумын 1-р 10 жилийн сургуулийн нэг танхимд МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Р.Батжаргал, Ж.Дансранжав, Гүн. Төмөр нарын санаачлагаар Говьсүмбэрийн Утга зохиолын нэгдэл нэртэй анх байгуулагдаж дүрмээ батлаж даргаараа Р.Батжаргалыг сонгон батлаж, анхны 13 хүн зургаа татуулсан нь бидэнд түүх болон үлджээ. Анхны 14 хүний нэр, тухайн үед эрхлэж байсан ажил нь

1. Р.Батжаргал – Сүмбэр сумын 1-р сургуулийн хичээлийн эрхлэгч
2. Ж.Дансранжав – Сүмбэр сумын 2-р сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
3. Г.Төмөр – Шивээговь сумын төвд амьдардаг өндөр настан
4. Ш.Батнасан- Аймгийн Боловсрол соёлын газрын арга зүйч
5. Н.Дөш – Сүмбэр сумын Засаг дарга бөгөөд аймгийн цэргийн штабын дарга хурандаа цолтой.
6. Ц.Галбадрах – Аймгийн Цэргийн штабын иргэний хамгаалалтын офицер хошууч цолтой
7. С.Отгончимэд –Аймгийн эрүүл ахуй, хяналтын газрын дарга. Их эмч.
8. Д.Батчулуун –Аймгийн нэгдсэн эмнэлэгийн их эмч
9. М.Батбаясгалан –оюутан
10. Л.Пунцагсүрэн- Автотээврийн 32-р баазын жолооч
11. Ц.Дуламжав – ажилгүй
12. Д.Баясгалан –ажилгүй
13. Ш. Мижиддорж –ажилгүй
14. Ч.Батпүрэв –

Утга зохиолын нэгдэл маань үүдээ нээж, өрхөө татсанаас хойш нэгэн жилийн дараа анхны хамтын бүтээл “НАЙРГИЙН АЖНАЙ” номоо өлгийдөж авч М.Батбаясгалангийнхаа хуриманд хамт олноороо уригдан оролцож баяр жаргалаа хуваалцдаг эвсэг хамт олон бүрдэж, 1995 онд аймгийн анхны засаг дарга манай хамт олныг хүлээн авч уузаж байсан гэгээлэг дурсамжууд үргэлжилж 2010 оноос “Боржигидай мэргэн” салбар болж хамтын уран бүтээлийн 2-дахь ном “БОРЖИГИНЫ ЭГШИГЛЭН” хэвлэгдэж олон түмэн хүрч

“БОРЖИГИДАЙ МЭРГЭН” яруу найргийн наадам маань хүрээгээ тэлж Монгол орны өнцөг булан бүрээс нэртэй яруу найрагчид ирж оролцдог уран бүтээлийн томоохон баяр болтлоо хөгжиж байна. Анх Говьсүмбэрчүүдийн утга зохиолын салбарын тулгын чулууг тавилцсан бидний нөхөд яруу тунгалаг үгсийн ундарга байнга манай нутгаас оргилж биднийг амжилт бүтээлийн оргил руу зөв чиглүүлж, манлайлан удирдаж яваа салбарын Удирдах зөвлөлийн дарга МЗЭ-ийн гишүүн яруу найрагч Ду.Батмэнд, гүйцэтгэх захирал Б.Энхтөр нарынхаа уйгагүй хөдөлмөр зүтгэлийг өндөр үнэлэж баярлаж бахдаж яваагаа дурсамжиндаа шигтгэе. Энэх бүхнийг эргэн дурсахуйд таатай байна.

Дурсамж бичсэн:

Говьсүмбэр аймгийн Утга зохиолын нэгдлийн анх байгуулалцсан ахмад гишүүн Ганборжигин овогт Нацагийн Дөш. 2014.07.31.

ХӨНДЛӨН БОСОО БҮЮУ ҮРГЭЛЖ ДУРСАХ “ХУУР ДАГАСАН АЯЛГУУ”

Бид их мартамхай улс юм. Жил ирэх тусам л хэн нэгнийг, ямар нэгэн зүйлийг мартаж, гэж байдаг.

Гэхдээ мартаж чадахгүй, мартагдах учиргүй эрдэнэт хүмүүний үр байдаг байна. Тэр эрхэм бол

Төв аймгийн Баянжаргалан сумын уугуул Баян Эрхтий хайрхан шүтээнтэй, цайлган эр хонгор сэтгэл, бөн бөн бөмбөрөх нулимст, өмөг түшигтэй “Миний араншин”, “Хуур дагасан аялгуу”, “Ташуу араншин” зэрэг яруу найргийн бие даасан ном бүтээсэн Боржигины билигт найрагч Л.Пунцагсүрэн билээ. Түүний шүлгүүдийг миний ард түмэн амьсгаа даран сонсдог байсан.

Ялангуяа ус нутаг, эжий сэтгэл ерөөсөн шүлгүүдээс нь Монголын гүн цэнхэр тэнгэр, хаяа хязгаар нь үл харагдах уудам талын сайхныг мэдэрдэг билээ. Насаараа тээврийн тэрэгний жолоо мушгиж, аяны алтан шар замдаа ер хаа сайгүй л шүлгээ бодож явах.., Хааяа гэрээр нь хөдөөнөөс морилоход “Бурхадын сархад” сэржимдэж бөөн утаан дунд шүлгээ билүүдэж суудагсан. Шүлгийнх нь ир улам чангарч, сэдэв цар хүрээ нь өргөжсөөр оны шилдэг шүлэг шалгаруулах уламжлалт “Боржигидай сэцэн” наадамд тэргүүлж, хэд хэд аман хүзүүдсэн дээ.Төрийн шагналт яруу найрагч Р.Чойномын нэрэмжит “ОЮУХАЙ” наадамд онгодтой, омголон оролцоод ирж байлаа. Анхаарлын төвд “Хөндлөн босоо” ах минь байлаа. Уншсан шүлгий нь хотын залуус сонсоод гайхан биширч “Залуу хүн үү” гэж шуугилдан өөрийг нь хараад уулга алдаж байсан гэдэг. Тэрээр нэгэн удаа надад “Би ер нь хаанахын ч бай хүн зонд шүлгээ зориулж явахдаа жаргалтай байдаг. Яруу найраг ард олныхоо хайр ивээлийг өдөр тутам хүртэж явна. Тэр дундаа та нарынхаа шүлэг дууг сонсохдоо нэгэн ер бусын гайхамшигт ертөнцөд нисэн хүрэх мэт болж, үлэмж жаргал эдэлдэг юм даа” хэмээн дахин эс олдох эгэлгүй авьяас заяасан түмний сэтгэлийн зул болсон найрагч ах минь бахдалтайяаа өгүүлж билээ. Тэр хаврын бүүдгэр өдөр өнөөдөр мэт санагдана. Үнэндээ түүний шүлгүүдийг сонсохоор талын хаяанаас дүүрэн тэргэл наран алгуурхан мандан өндөрт хөөрөх, анир авсан хулангийн сүрэг ээрэм говийн хаяанаа цаашлан шингэн уусах шиг мэдрэмж төрдөг. Ер нь түүний утга уянгын, айраг шиг чимчигнүүлсэн уламжлал, шинэчлэл, сэтгэлгээний

шүлгүүдийг сонсоод уярдаггүй хүмүүн бий гэж үү., Уяхан замбуутивийн наран мэт сэтгэлд мандах “Хуур дагасан аялгуу” өдгөө ч уужим дэлхийг гийгүүлэн гэрэлтүүлж, цаг мөнхөд уянгалсаар байх билээ.

Тэс хөндлөн найрагч шүлгээ уншихад

Тэнгэр дуугарах шиг болдог байсан юм

Чойрын богдын салхитай ергөсөн

Галын хүрэн морь байсан юм

Чойномын шүлэг шиг асгарсан

Дорнын цагаан сар байсан юм

Сүлдтэй найрагч од шиг харваж

Сүүгээ өргөж хоцорсон ч

Ариун хүнлэг сэтгэл нь өрөмтсөн юм

Ардын дуу шиг шүлэг нь үлдсэн юм

Утга зохиолын нэгдлийн анхны гишүүн,

МЗЭ-ийн гишүүн яруу найрагч М.Батбаясгалан

САЛБАРЫН ТУХАЙ

МЗЭ-ИЙН ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УТГА ЗОХИОЛЫН САЛБАРЫН ЗОХИОЛЧДЫН 1994--2014 ОНД ХЭВЛҮҮЛСЭН УТГА ЗОХИОЛЫН БҮТЭЭЛҮҮД

- “Найргийн ажнай” /хамтын бүтээл/ 1994
- “Шүлгэн эрих” Р.Батжаргал 1995
- “Миний араншин” Л. Пунцагсүрэн 1996
- “Нас дагасан найраг” Ж.Дансранжав 1996
- “Наран ордын эзэд” Г. Төмөр 1997
- “Алаг заяа” Т. Болдбаатар 1998
- “Найргийн зургаан татлага” Ш.Батнасан 1999
- “Араншингийн салхи” Р. Батжаргал 2003
- “Чанад совин” Р. Батжаргал 2003
- “Нар аргамжсан нутаг” Б. Баттулга 2003
- “Хуур дагасан аялгуу” Л.Пунцагсүрэн 2004
- “Гоё амраг” Р. Батжаргал 2004
- “Тэнгэрийн санаа” Р. Батжаргал 2005
- “Ташуу араншин” Л. Пунцагсүрэн 2005
- “Боржигины уянга” Л. Содномдорж 2006
- “Хэлд орж хөл дээрээ тогтсон нутаг” Д. Батцоож 2006
- “Дэлгэрэхийн чулуу” С. Отгончимэд 2008
- “Алаг дэвтэр” Р. Батжаргал 2008
- “Миний шүлгүүд” Р.Батжаргал 2009
- “Бусдаас өөр чамд” Б. Аасүрэн 2009
- “Айлгах аавгай арслангийн зулзага” 1,2 Т. Эрдэнэбаатар 2009

“Алаг дэвтэр-2” Р.Батжаргал 2009

“Бурхад завгүй” Ду. Батмэнд 2010

“Бурхад уулзах цаг” Р. Батжаргал 2010

“Морьт Сүмбэр аялгуу” М. Батбаясгалан 2010

“Боржигины эгшиглэн” / хамтын бүтээл/ 2010

“Амраг шүлгүүд” Р. Батжаргал 2010

“Өөр өнцгийн нүд” Б. Энхтөр 2010

“Морьд үнэртсэн бороо” М.Батбаясгалан 2010

“Амьд цаас” Б. Энхтөр 2010

“Сарны сүнс” Р. Батжаргал 2010

“Гүнж өнгө” Б. Мөнх-Өлзий 2010

“Билгийн чанад” Р. Батжаргал 2011

“Аравнайн эгшиг” Л. Содномдорж 2011

“Оршихуйн дорно.., Равжаа” Б. Энхтөр 2011

“Сүүдэр тод” Р. Батжаргал 2011

“Хадан ой” Т.Эрдэнэбаатар 2011

“Боржигин билгийн судар” /хамтын бүтээл/ 2011

“Эрх нас” Б.Энхтөр 2011

“Тийм биз” Р. Батжаргал 2012

“Энхжин зүрхний ерөөлтэй нутаг” М.Батбаясгалан 2012

“Мөнх цэнхэрлэх Сүмбэр нутаг ” Б.Энхтөр 2012

“Уруул шүрэн жүнз” Б.Энхтөр 2012

“Цаг хугацаанаас ангид.., диваажинд учиртал” Б.Энхтөр 2012

“Зүрхээн би чамд..,” З.Билэгбаяр 2012

“Стихи роса сердца..,

Шүлэг зүрхний шүүдэр” Б.Энхтөр 2012

“Хий бод бие ба мэлмийн зурхай” С.Отгончимэд 2014

“Үнэн нүцгэрэх цагт” Б.Батгэрэл 2014

“ Чам шиг хавар..,” С.Булган 2014

“Сүүтэй итгэлд бийрээ дүрж..,” Ду.Батмэнд 2014

“Орон зайн гишгэгдэл” Б.Энхтөр 2014

“Тэнгэрийн цоморлин” Н.Дөш 2014

“Жанжин Чойрын замаар” Б.Мөнх-Өлзий 2014

“Боржигин билгийн судар 2” хамтын бүтээл 2014

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УТГА ЗОХИОЛЫН НЭГДЛИЙН АНХНЫ ГИШҮҮД

1. Рагчаагийн БАТЖАРГАЛ

2..Жалбуугийн ДАНСРАНЖАВ

3. Гүндсамбуугийн ТӨМӨР

4. Лувсандагвын ПУНЦАГСҮРЭН

5. Нацагийн ДӨШ

6. Цэвэлийн ДУЛАМЖАВ

7. Цэвэгдоогийн ГАЛБАДРАХ

8. Сүрэнгийн ОТГОНЧИМЭД

9. Ширчингийн БАТНАСАН

10. Дамдины БАТЧУЛУУН

11. Ч. БАТПҮРЭВ

12. Шагдаржавын МИЖИДДОРЖ

13. Дамчаагийн БАЯСГАЛАН

14. Мөрдоржийн БАТБАЯСГАЛАН

МЗЭ-ИЙН ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ УТГА ЗОХИОЛЫН САЛБАРЫН ҮЕ ҮЕИЙН УДИРДЛАГУУД

1. Рагчаагийн БАТЖАРГАЛ 1994-1999 онд Утга зохиолын нэгдлийн тэргүүн
2. Ширчингийн БАТНАСАН 1999-2000 онд Утга зохиолын нэгдлийн тэргүүн
3. Бямбадоржийн БАТ-ӨЛЗИЙ 2000-2004 онд Утга зохиолын нэгдлийн тэргүүн
4. Дуламсүрэнгийн БАТМЭНД 2004-2010 онд Утга зохиолын нэгдийн тэргүүн
5. Баатарын ЭНХТӨР 2010-2011 онд Утга зохиолын салбарын Удирдах зөвлөлийн дарга
6. Мөрдоржийн БАТБАЯСГАЛАН 2010-2011 онд Утга зохиолын салбарын гүйцэтгэх захирал
7. Дуламсүрэнгийн БАТМЭНД 2012-оноос Утга зохиолын салбарын Удирдах зөвлөлийн дарга
8. Баатарын ЭНХТӨР 2012- оноос Утга зохиолын салбарын гүйцэтгэх захирал

“БОРЖИГИДАЙ СЭЦЭН” ЯРУУ НАЙРГИЙН НААДМЫН ТЭРГҮҮН ХИШИГТ НАЙРАГЧИД

1. Мөрдоржийн БАТБАЯСГАЛАН /Аргамжаа/ 1994 он
2. Мөрдоржийн БАТБАЯСГАЛАН / Өхөөрдлийн шүлэг/ 1997 он
3. Ширчингийн БАТНАСАН / Монгол зурхайн татлага/ 1999 он
4. Мөрдоржийн БАТБАЯСГАЛАН / Өнө мөнхийн заяа / 2002 он
5. Лувсандагвын ПУНЦАГСҮРЭН /Би тэс хөндлөн хөх эр/ 2003 он
6. Мөрдоржийн БАТБАЯСГАЛАН / Дутахын шүлэг/ 2005 он
7. Мөрдоржийн БАТБАЯСГАЛАН / Уянгын тэнгэр/ 2006 он
8. Дашдондовын МӨНХБАТ / Их цагаан гэгээ / 2009 он
9. Уяатын БАЯРМАА / Өргөстэй цас/ 2010 он
10. Рагчаагийн БАТЖАРГАЛ / Цэцгэн энхрэл / 2011 он
11. Нямсайханы МИНЖИНСАЙХАН / Хэзээ / 2012 он

12. Базарсадын БАТТУЛГА /Талын тухай шүлэг / 2013 он

Table of Contents

[НОМ МЯЛААХ СУҮТЭЙ ХАДАГ](#)
[СУДАРТ ӨРГӨХ ҮГ...](#)
[ЯРУУ НАЙРАГ](#)

[Рагчаагийн БАТЖАРГАЛ](#)
[Жалбуугийн ДАНСРАНЖАВ](#)
[Гүндсамбуугийн ТӨМӨР](#)
[Лувсандагвын ПУНЦАГСҮРЭН](#)
[Нацагийн ДӨШ](#)
[Цэвэлийн ДУЛАМЖАВ](#)
[Цэвэгдоогийн ГАЛДБАДРАХ](#)
[Сүрэнгийн ОТГОНЧИМЭД](#)
[Ширчингийн БАТНАСАН](#)
[Дамдины БАТЧУЛУУН](#)
[Мөрдоржийн БАТБАЯСГАЛАН](#)
[Дамбын БАТЦООЖ](#)
[Намсрайн БАТТӨМӨР](#)
[Бямбадоржийн БАТ-ӨЛЗИЙ](#)
[Батаагийн БАТТУЛГА](#)
[Батцоожийн БАЯРЦЭНГЭЛ](#)
[Дуламсүрэнгийн БАТМЭНД](#)
[Сосорын АМАРБАТ](#)
[Балдангийн ТУУЛ](#)
[Лувсаншаравын СОДНОМДОРЖ](#)
[Уяатын БАЯРМАА](#)
[Маамын МӨНХЗАЯА](#)
[Баатарын ААСҮРЭН](#)
[Дашдондовын МӨНХБАТ](#)
[Бямбасүрэнгийн МАЙНБАЯР](#)
[Мөнхбаярын ХҮРЭЛБААТАР](#)
[Батнасангийн ШҮРЭНЧИМЭГ](#)
[Баатарын ЭНХТӨР](#)
[Загдсүрэнгийн БИЛЭГБАЯР](#)
[Гэнийдоогийн АЛТАНЧИМЭГ](#)
[Банзрагчийн БАЯРМӨНХ](#)
[Ганбатын БОЛОРСУВД](#)
[Бямбадоржийн МӨНХ-ӨЛЗИЙ](#)
[Төмөртоогогийн ЭРДЭНЭБААТАР](#)
[Хишигийн ЧУЛУУНБААТАР](#)
[Даваадоржийн РЕНЖИН](#)
[Гончигийн ГАНХУЯГ](#)
[Пүрэвийн БӨХБАТ](#)

Пүрэвдоржийн НАРАНХҮҮ
Эрдэнэсүрэнгийн БЯМБАСҮРЭН
Сахьяагийн БУЛГАН
Баттулгын БАТГЭРЭЛ
Цэвэгмидийн ОЮУНЦЭЦЭГ
Гэндэняримпэлийн МАЙХАНТ
Цэдэнхүүгийн ЦОГБАДРАА
Ганбаатарын БАТБАЯР

ҮРГЭЛЖИЛСЭН ҮГИЙН БҮТЭЭЛ

Гунгаанамжилын Зоригт
СҮНСНИЙ ТАРЧЛААН
СҮҮДРИЙН ЗОРГОДОС
АЛИМ ИДЭХҮЙ
ЧУЛУУН БАЙЛДААН
ХҮҮГЭЭ Л ГЭСЭЭР ҮРЭГДЭХ ХҮНИЙ ЛАА БУРХАН-ИЖИЙ МИНЬ
ХУЛ НАМАР
ГАНЦ МАЙХАН ДЭРВЭЛЗЭНЭ, ТУУВАР СҮҮЛЧИЛЖЭЭ
СЭТГЭЛИЙН МЭЛМИЙ
НУЛИМСАН ДЭЭР ДЭЛБЭЭЛЭЭГҮЙ ЦЭЦЭГ
УРВАГЧ
ТӨСӨЛ
ХУЛГАЙЧ
МОНГОЛЫН ХУУЛЬ ГУРАВ ХОНОГ
БОРЖИГИНЫ ЗАРИМ ОНЦЛОГ ЗҮЙЛҮҮДИЙГ СУДЛАХУЙД
ОРОН НУТГИЙН ТҮҮХЭН ГАЗАРЗҮЙН АСУУДАЛД
СЭТГЭЛИЙН ТАЯГ
МӨӨГӨН ХҮРЭЭ
СУУСАН ТЭНЭГ
ДАХИН ЭНЭ ЗАМААР АЛХАХГҮЙ
ЖҮҮЖГИЙН ЗОХИОЛУУД
МОГОЙ ГАЗРЫНХАА ӨНГӨӨРӨӨ...
ХЯРУУДАЙН АЯЛАЛ
ГАЛ ЭЛС
ХОШУУ ДОМОГ
ДУУНЫ ШҮЛГҮҮД
ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН УРАН БҮТЭЭЛЭЭС
ХҮҮХДИЙН ДУУ
ЗОХИОЛЧДЫН ЕГӨӨ, ХОШИГНОЛ
ДУРСАМЖ
САЛБАРЫН ТУХАЙ